МОНГОЛ УЛС
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА

Наадамчдын зам 1200, Арцатын ам,
23 дугаар хороо, Хан-Уул дүүрэг,
Улаанбаатар хот, 17100
Утас: (976-11) 32 39 77, 32 71 99
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2026.01.23 № 01/421

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГА А.БАЯР ТАНАА

Тогтоолын төсөл өргөн
мэдүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсгийг үндэслэн "Нийслэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх тухай" Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төслийг боловсруулан үүгээр өргөн мэдүүлж байна.

Тогтоолын төслийг зохих журмын дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлж өгнө үү.

Хавсралт .... хуудастай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Х.НЯМБААТАР

C:\Users\DELL\2026 он\Засаг дарга\ЗД А4.docx

1726110147

Улаанбаатар хот, Сүхбаатарын дүүрэг, 1-р хороо, Монгол Улс, 14200
Утас: 70 11 70 00 · 99 93 - 66 - 99 : Факс
Цахим хуудас : www.ulaanbaatar.mn

Улаанбаатар хот дахь Засаг захирагчийн Захиргаа

Улаанбаатар хотын Засаг дарга Х.Уянга

Дугаар _____ Огноо _____ 20 оны _____ сарын _____ өдөр

Хотын Засаг дарга Х.Уянгын захирамж

Нийслэлийн Засаг захиргааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийг баримтлан, Нийслэлийн Засаг захиргаа, Газрын харилцаа, барилгын газрын Барилгын хяналтын алба, Нийслэлийн Засаг захиргаа, Газрын харилцаа, барилгын газрын Барилгын хяналтын газрын Барилгын хяналтын 1 дүгээр хэлтсийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 03/03 тоот хүсэлтийг хянан үзсэн нь:

Нийслэлийн Засаг захиргаа, Газрын харилцаа, барилгын газрын Барилгын хяналтын газрын Барилгын хяналтын 1 дүгээр хэлтсийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 03/03 тоот хүсэлтийг хянан үзсэн нь: Нийслэлийн Засаг захиргаа, Газрын харилцаа, барилгын газрын Барилгын хяналтын газрын Барилгын хяналтын 1 дүгээр хэлтсийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 03/03 тоот хүсэлтийг хянан үзсэн нь: Нийслэлийн Засаг захиргаа, Газрын харилцаа, барилгын газрын Барилгын хяналтын газрын Барилгын хяналтын 1 дүгээр хэлтсийн 2023 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 03/03 тоот хүсэлтийг хянан үзсэн нь:

ХЯНАЛТЫН ДАГАЛДАХ ХУУДАС
/Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн
хурлын тогтоолын төсөл/

Олгосон:

2026 оны 01 дүгээр сарын 20 Дугаар 134

Төслийн нэр: ***Нийслэлийн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг дүгнэх тухай***
Боловсруулсан байгууллага, ажилтны албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал: **Хяналт-Шинжилгээ, үнэлгээний газрын дарга Б.Мөнхбаяр**

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Засгийн газрын гишүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилт, үр дүнд хийх хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн Б.Цогзолцэрмаа

№	Санал өгөх газар, хэлтэс	Сонирхлын зөрчилтэй эсэх	Санал*	Гарын үсэг	Он, сар, өдөр	
					Хүлээн авсан	Хүлээлгэж өгсөн
1	Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай	Үгүй	—		2/22	I/22
2	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Т.Оюунчимэг	Үгүй	—			I/21
3	Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Хадбаатар	Үгүй	—		I/20	I/20.
4	Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ү.Ганболд	Үгүй	Харилцах субъект гаа Зарим заалтын дахин хэлэх			I/20
5	Хууль тогтоомж, гэрээ эрх зүйн газрын дарга М.Үнэнбат	Үгүй	—			I/20

Тайлбар: Сонирхлын зөрчилтэй эсэх гэсэн хэсэгт "Тийм" гэсэн тэмдэглэгээ хийсэн албан тушаалтан захирамжийн төсөлд санал өгөх үүргээ гүйцэтгэхээс татгалзана.

Хэрэв аливаа сонирхлын зөрчилтэйгөө мэдүүлээгүй, эсхүл Засаг даргыг шийдвэр гаргахад нь хуульд нийцсэн, бодит баримт нотолгоонд тулгуурласан, үндэслэл бүхий үнэн зөв мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөөгөөр хангаж ажиллаагүй бол Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

Хяналтын дагалдах хуудас нь захиргааны актын төслийн хамт хүчинтэй.

Санамж: Төсөл боловсруулагч нь "Захирамжлалын баримт бичиг гаргах ажиллагааны журам"-ын 4.11-д заасны дагуу саналыг эрх бүхий албан тушаалтнуудаас ажлын 10 хоногт багтаан авч дуусгана. Эрх бүхий албан тушаалтан бүр журмын 4.8-д заасан хугацааг баримтлан баримт бичгийн төсөлд санал өгнө.

ТӨСӨЛ

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны ... дүгээр сарын .... Дугаар Улаанбаатар хот

Нийслэлийн бодлогын баримт бичгийн
хэрэгжилтийг дүгнэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.5 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.1, 6.4, 6.5-д заасныг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилтийг "Үр дүнтэй" гэж, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтийг "Үр дүнтэй гарсан" гэж, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг "Үр дүнтэй гарсан" гэж тус тус дүгнэсүгэй.

2.Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг тус тус хангаж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын ажлын албаны дарга (М.Халтар)-д даалгасугай.

ДАРГА А.БАЯР

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР
9077243 СТА6163
2026.01.23

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 01 сарын 23 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 01 дүгээр хурлын тэмдэглэлд:

"1.ХЭЛЭЛЦСЭН нь: "Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2025 оны хэрэгжилт, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар"

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 5.8-д "Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийсэн тайланг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд нэгдсэн системд тайлагнаж, баталгаажуулна" гэж заасны дагуу Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай танилцуулав.

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

"Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2025 оны төлөвлөгөө, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээний дүнг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн гишүүдийн саналыг тусган, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлж, хэлэлцүүлэхийг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Т.Даваадалай)-д үүрэг болгов." гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ТТБ №2105

1726270003

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

“НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР”-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 01 дүгээр сарын 23 Улаанбаатар хот

Нэг.Хяналт-шинжилгээний ажлын зорилго

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт хэрхэн хангагдаж байгаад хяналт-шинжилгээ хийж, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг бодит мэдээллээр хангах, цаашид хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр.Хяналт-шинжилгээний ажлын үндэслэл, арга зүй

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/08 дугаар тогтоол, 2025 оны 25/111 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1480 дугаар захирамжаар баталсан “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т тусгагдсан 5 бүлэг, 25 тэргүүлэх зорилт, 211 зорилтын 539 арга хэмжээний 2025 оны хэрэгжилтийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газар, нийслэлийн нутгийн захиргааны 74 байгууллагаас авч, нэгтгэн ирүүлсэн тайланд Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.5-д заасны дагуу хяналт-шинжилгээ хийлээ.

Тайланг судлах, холбогдох мэргэжилтнүүдтэй ярилцах, тодруулга, нотолгоо баримт авах зэрэг арга хэлбэрээр хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэв.

Гурав.Хяналт-шинжилгээний ажлын үр дүн

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т туссан зорилтуудыг хэрэгжүүлэх нийт арга хэмжээнүүдийг он, оноор нь харуулбал:

Д/д	Хугацаа	Арга хэмжээний тоо	Эзлэх хувь
1	2025 он	542	80.8%
2	2026 оноос эхлэх	106	15.8%
3	2027 оноос эхлэх	19	2.8%
4	2028 оноос эхлэх	4	0.6%
Нийт		671	100%

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 бодлого (бүлэг), 25 тэргүүлэх зорилго, 211 зорилт (дэд бүлэг), 539 арга хэмжээний 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаарх хэрэгжилт 88.21 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэгдсэн.

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг эзлэх хувийн жингээр нь харуулбал:

№	Бодлого	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Эзлэх хувь
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	69	153	28.3%
2	Хүний хөгжлийн бодлого	40	164	30.4%
3	Эдийн засгийн бодлого	36	96	17.8%
4	Ногоон хөгжлийн бодлого	23	60	11.1%
5	Засаглалын бодлого	43	66	12.4%
Нийт		211	539	100%

Хяналт-шинжилгээний чанарын үзүүлэлт:

№	Арга хэмжээний хэрэгжилт	Арга хэмжээ
1	Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш "үр дүнтэй"	355
2	Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 60-84 хувь буюу "үр дүн хүлээгдэж байгаа"	101
3	Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй"	53
4	Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь буюу "үр дүн гараагүй"	15
5	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	15
Нийт арга хэмжээ		539

Арга хэмжээний хэрэгжилтийн хяналт-шинжилгээг бүлэг, салбар тус бүрээр авч үзвэл:

№	Бүлэг, салбар тус бүрээр	Арга хэмжээний тоо	Хувь
НЭГ.БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО		153	81.9
	• Улаанбаатар "20 минутын хот"	13	71.08
	• Олон төвт хот	43	87.33
	• Инженерийн дэд бүтэц	55	83.9
	• Авто зам	27	83

	• Нийтийн тээвэр	15	84
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО		164	94.1
	• Эрүүл мэнд, биеийн тамир	77	95
	• Боловсрол	32	98
	• Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт	9	98.3
	• Соёл урлаг	37	97
	• Гэр бүл, хүүхэд, залуучууд	9	82
ГУРАВ.ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО		96	88.7
	• Санхүү, хөрөнгө оруулалтын бодлого	6	90.3
	• Төсвийн санхүүжилтийн шинэ эх үүсвэр	6	92.7
	• Үйлдвэрлэл, инновац	35	72.7
	• Аялал жуучлал	24	97.4
	• Хүнс, хөдөө аж ахуй	25	90.3
ДӨРӨВ.НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО		60	87.3
	• Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт	22	91
	• Агаар, дуу чимээний бохирдол	16	82
	• Хөрсний бохирдол	6	90.8
	• Хог хаягдлын менежмент	4	85.5
	• Ногоон байгууламж, тохижилт	12	87
ТАВ.ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО		66	89.04
	• Засаглалын шинэчлэлт	17	86.5
	• Цахим шилжилт	17	84.8
	• Батлан хамгаалах үйл ажиллагаа	6	88.8
	• Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа	6	94
	• Олон нийтийн аюулгүй байдлыг хангах	20	91.1
Нийт хяналт-шинжилгээний дундаж		539	88.21%

Хэрэгжилтийн явц зорилтот түвшний 0-29 хувь буюу "үр дүн гараагүй" 15 арга хэмжээ:

1. 1.2.17.1."Дэд бүтцийн төв" төслийг барьж байгуулна. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
2. 1.3.6.5.Толгойт дэд төв 42.5 мВт-ийн дулааны эх үүсвэр барьж, ашиглалтад оруулна. (Энэхүү ажил нь УБГХХХОДХ төслийн санхүүжилтийн хэлэлцээрийн хүрээнд багтаагүй ажил бөгөөд төлөвлөлтийн дагуу Толгойт дэд төвийг 37.6 Гкал/цаг хүчин чадалтай төвлөрсөн дулаанд холбохоор төлөвлөсөн.)
3. 1.3.7.8.Шархад дэд төв 144 мВт-ын дулааны станцыг барьж ашиглалтад оруулна. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)

4. 1.3.10.8.Чингэлтэй дүүргийн 117-р сургууль, Сүхбаатар дүүргийн 17-р хороо орчим үерийн хамгаалалтын сувгийг барьж ашиглалтад оруулна. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
5. 1.3.17.3.Цэвэр, бохир усны Ф15-400 мм голчтой тоолуур шалгах, баталгаажуулах лабораторийг барьж байгуулна. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
6. 2.1.4.3.Тав хүртлэх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр тусламж, үйлчилгээг чанаржуулна. (1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл суурь түвшин 15.7 байснаас 2025 оны зорилтот түвшин нь 14.9-өөр төлөвлөгдсөн боловч 17.1 байна.)
7. 3.3.1.19.Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркийн цахилгаан хангамжийн 35/10 кВ-ын 2х8 мВА чадалтай дэд станцыг барина. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
8. 3.3.1.27.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө, Техник технологийн түвшний үнэлгээ, Байгаль орчны үнэлгээ боловсруулна. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
9. 3.3.1.28.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн цэвэрлэх байгууламжийг барина. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
10. 3.3.1.29.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дулаан хангамжийн шугам сүлжээ барина. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
11. 3.3.1.38.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн гадна цахилгаан хангамжийн зураг төсвийг боловсруулна. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
12. 3.3.1.39.Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн бөөний болон жижиглэн худалдааны төвийн төлөвлөлтийг (ХЕТ) боловсруулна. (Хэрэгжилт зорилтот түвшинд хүрээгүй.)
13. 3.3.6.2.Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан бүтээгчдийн талбарыг бий болгож, бойжуулан хөгжүүлнэ. (Хэрэгжилт зорилтот түвшинд хүрээгүй.)
14. 3.3.8.1."Улаанбаатар хотын Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ" санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (Санхүүжилт шийдвэрлэгдээгүй.)
15. 5.1.2.1.Нийслэлийн дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулахад мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн оролцоог хангаж, саналыг тусгана. (Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгах саналыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас авч, боловсруулсан. -Хэрэгжилт зорилтот түвшинд хүрээгүй.)

Дөрөв.Дүгнэлт

“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 бодлого (бүлэг), 25 тэргүүлэх зорилго, 211 зорилт (дэд бүлэг), 539 арга хэмжээний 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаарх хэрэгжилт 88.21 хувь буюу “Үр дүнтэй” гэж дүгнэгдсэн.

Тав.Санал, зөвлөмж

1.Төлөвлөлтийн шатанд 3 арга хэмжээг давхардуулан тусгасан, түүнчлэн шалгуур үзүүлэлт болон зорилтот түвшинг бодит боломж, нөхцөл байдалд нийцгүйгээр тогтоосон нь анхаарал татаж байна. Эдгээр алдаа нь хэрэгжилтийн явцад арга хэмжээнүүдийн үр ашиг буурах, явцын үнэлгээ бодитой хийгдэх боломж хязгаарлагдах, улмаар эцсийн үр дүнд сөргөөр нөлөөлөх нөхцөлийг бүрдүүлж байна.

Давхардуулан баталсан 3 арга хэмжээ:

1. 2.1.8.31.Монголын тулааны шилдэг тамирчдын холбоо "Khangarid Cup"-ын тэмцээнийг зохион байгуулна.
2. 2.1.8.32.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн нэрэмжит бие хамгаалах тамирчдын аваргуудын аварга-2025 тэмцээнийг зохион байгуулна.
3. 2.4.5.17.“Улаанбаатар” олон улсын кино наадам, Сонгодог урлагийн гала фестивалийг зохион байгуулна.

2.Тайлагналтыг шалгуур үзүүлэлтийн дагуу үр дүн болон үр нөлөөг тусгаж тайлагнах шаардлагатай байна.

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАЯР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ХИЙСЭН МЭРГЭЖИЛТЭН: Б.ЦОГЗОЛЦЭРМАА

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

НИЙСЛЭЛИЙГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ 5 ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 01 дүгээр сарын 23 Улаанбаатар хот

Нэг.Хяналт-шинжилгээний ажлын зорилго

Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн, үр дүнг хэмжих, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг бодит, үнэн зөв мэдээллээр хангах, цаашид төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр.Хяналт-шинжилгээний үндэслэл, арга зүй

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02/09 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл" дунд хугацааны бодлогын баримт бичгийн 2025 оны хэрэгжилтийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийслэлийн нутгийн Захиргааны 59 байгууллагаас хүлээн авч Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газар хариуцан нэгтгэж, хэрэгжилтэд нь Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Хяналт-шинжилгээний журам"-ын дагуу хяналт-шинжилгээ хийлээ.

Гурав.Хяналт-шинжилгээний ажлын үр дүн

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-д 9 бүлэг, 186 арга хэмжээ, 352 шалгуур үзүүлэлт тусгагдсан бөгөөд түүний хэрэгжилтийн дундаж дүн 91.6 хувь буюу "Үр дүн гарсан" дүгнэгдсэн байна.

Арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээг бүлэг, салбар тус бүрээр нь авч үзвэл:

№	Бүлэг, салбар тус бүрээр	Арга хэмжээ	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	5	93.0
2	Хүний хөгжил	33	89.7
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	14	98.1
4	Эдийн засаг	21	96.0
5	Засаглал	12	94.1
6	Ногоон хөгжил	19	92.6
7	Амар тайван, аюулгүй нийгэм	9	91.0
8	Бүс орон нутгийн хөгжил	8	94.3
9	Улаанбаатар ба Дагуул хот	65	88.9
Дүн		**186**	**91.6**

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-д 352 шалгуур үзүүлэлт, 186 арга хэмжээний хэрэгжилтийг тооцож, зорилт арга хэмжээний дундаж үнэлгээгээр хэрэгжилтийг ангилсан. Нийт 186 арга хэмжээнээс 85.5 хувь буюу 159 арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшний 85 хувиас дээш буюу "үр дүн гарсан", 14.5 хувь нь буюу 27 арга хэмжээний хэрэгжилт зорилтот түвшин 85 хувьд хүрээгүй "үр дүнгүй" үнэлэгдсэн.

№	Арга хэмжээний хэрэгжилт	Арга хэмжээ	Үндсэн чиглэлийн хэрэгжилтэд эзлэх хувь
1	2	3	4
1	Зорилтот түвшин **85** хувиас дээш **"Үр дүн гарсан"**	159	85.5%
2	Зорилтот түвшин **85** хувьд хүрээгүй **"Үр дүнгүй"**	27	14.5%
Нийт арга хэмжээний тоо		186	100%

Үр дүнгүй үнэлэгдсэн 27 арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийж үзэхэд шалгуур үзүүлэлтийн зорилтод хүрээгүй арга хэмжээ, санхүүжилтээс шалтгаалан удааширсан, гадаад хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжээгүй арга хэмжээ байна.

Шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээ:

1. 1.1.3. Нийслэлийн нутаг дэвсгэрт байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалуудыг QR кодоор танилцуулах аппликэйшн бүтээж, хэрэглээнд нэвтрүүлсэн байна,
2. 2.3.1. Ерөнхий боловсролын сургуулийн барилга, байгууламжийг үе шаттай нэмэгдүүлж, бүлэг дүүргэлтийг стандарт түвшинд хүргэсэн байна,
3. 2.7.1. Дүүрэг бүрд "Нийгмийн эрүүл мэндийн төв"-ийг байгуулсан байна.
4. 2.8.1. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулна,
5. 2.13.1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулсан байна.
6. 2.14.2. Хүүхэд ажиллуулахыг хориглосон ажлын байранд хүүхэд ажиллуулахыг таслан зогсооно,
7. 2.14.3. Эцэг, эхийн хараа хяналт сул, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг эрт илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний хяналтыг сайжруулсан байна.
8. 4.1.1. Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлсэн байна,
9. 4.5.2. Дагуул, хаяа хот, тосгодод хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлсэн байна,
10. 5.4.1. Бүх нийтийн оролцоог хангасан, үр нөлөөтэй, хариуцлагатай, чадварлаг, институцийг бүх шатанд бий болгож, иргэдийг аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлөөр хангана,
11. 6.2.1. Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулсан байна,
12. 6.2.3.Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулж тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологийг нэвтрүүлж, дахин боловсруулах

үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулна,

13. 6.2.5. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нөөлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ,
14. 7.3.2. Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглал /Griemmap, Compstat/-ыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, Улаанбаатар хотын хэмжээнд ашиглагдаж буй хяналтын камерыг "Камерын удирдлагын нэгдсэн төв"-тэй холбож, гудамж, зам талбайн хяналт, гэмт хэрэг илрүүлэлт сайжруулж, гэмт хэргийн гаралт бууруулсан байна,
15. 9.8.5. Ашиглалтын хугацаа дуусан шугамыг шинэчилж, ус, дулаан дамжуулах төвүүдийг нэгдсэн теле хяналтын системд холбох болон зэв шүүх төхөөрөмж суурилуулан ашиглалтын зардлыг бууруулсан байна,
16. 9.9.1. 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг хийж дуусан байна,
17. 9.12.1.Дулааны станцын хүчин чадал, гол магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадвар нэмэгдсэн байна,
18. 9.15.2.Туул усан цогцолборын техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн дуусгаж, барилга угсралтын ажлын зураг төслийг боловсруулсан байна,
19. 9.15.3.Ундны усны эх үүсвэрийн гүний худаг, тоолуургүй айл өрхийг тоолууржуулж усны бодит хэрэглээг тооцож, усны лабораторийн хүчин чадлыг өргөтгөн шинэчилсэн байна,
20. 9.16.2.Одоо байгаа ус хангамжийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн, шинэчилсэн байна,
21. 9.17.1.Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон лаг хатаах байгууламжийг ашиглалтад оруулсан байна,
22. 9.23.1.Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна,

Гадаад хүчин зүйлээс шалтгаалан зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээ:

23. 9.1.3.Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлсэн байна,
24. 9.2.1."Яармаг" хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөө /Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулагдаж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлсэн байна,
25. 9.3.2.Улсын кадастрын мэдээллийн нэгдсэн системд холбогдож, хэрэглээнд нэвтрүүлэн, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчлэн, хэрэглээнд нэвтрүүлсэн байна,

Санхүүжилт шийдвэрлэгдээгүйгээс шалтгаалан хэрэгжээгүй арга хэмжээ:

26. 9.6.3. Захын бүсийн алслагдмал гэр хорооллын бүсэд бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий технологийг нэвтрүүлсэн байна,
27. 9.7.3. Шинэ суурьшлын бүсэд инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий орон сууцны хорооллын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлсэн байна.

Үр дүнгүй арга хэмжээний дийлэнх нь буюу 27 арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй буюу нийслэлийн хэмжээнд тулгамдаж буй асуудлууд байна. Тухайлбал: хог хаягдлын менежмент дутмаг байдал, гэмт хэргийн гаралт өсөн нэмэгдсэн зэргээс шалтгаалж байна.

Санхүүжилтээс шалтгаалан хэрэгжээгүй 3 арга хэмжээ, гадаад хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжээгүй арга хэмжээ 2 байна.

Мөн Хот бүс нутгийн төлөвлөлтөөс шалтгаалан удаан хугацаанд хэрэгжихүйц дэд бүтэц, бүтээн байгуулалтын томоохон арга хэмжээнүүдийн шалгуур үзүүлэлтийг эцсийн үр дүнгээр тодорхойлсноос шалтгаалан үнэлгээ мөн буурч байна.

Дөрөв.Дүгнэлт

"Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл"-ийн 352 шалгуур үзүүлэлт, 186 арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн тайланд хийсэн хяналт-шинжилгээний дундаж дүн 91.6 хувийн хэрэгжилттэй буюу "Үр дүн гарсан" дүгнэгдсэн.

Тав.Санал, зөвлөмж

Төлөвлөлтийн хувьд судалгаанд үндэслэн бодитой шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, ур хугацаанд хэрэгжихүйц ажлын шалгуур үзүүлэлтийг гарцаар тооцохгүй байх, бодлогын баримт бичигт байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааны шинжтэй арга хэмжээг тусгахгүй байх, тайлагналтын хувьд үр дүн, үр нөлөөг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах шаардлагатай байна.

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.МӨНХБАЯР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН Б.ИЧИННОРОВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

“НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ”-НИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2026 оны 01 дүгээр сарын 23 Улаанбаатар хот

Нэг.Хяналт-шинжилгээний ажлын зорилго

Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийн, үр дүнг хэмжих, дүгнэлт, зөвлөмж гаргах, удирдлагыг бодит, үнэн зөв мэдээллээр хангах, цаашид төлөвлөлт, гүйцэтгэлийг сайжруулахад дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хоёр.Хяналт-шинжилгээний үндэслэл, арга зүй

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 24-ны өдрийн 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө” богино хугацааны бодлогын баримт бичгийн 2025 оны хэрэгжилтийн тайланг 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар нийслэлийн нутгийн Захиргааны 59 байгууллагаас хүлээн авч Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийслэлийн бодлого, төлөвлөлтийн газар хариуцан нэгтгэж, хэрэгжилтэд нь Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээний журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийлээ.

Гурав.Хяналт-шинжилгээний ажлын үр дүн

“Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 5 бүлэг 386 арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хэрэгжилт 86.0 хувь буюу “Үр дүн гарсан” дүгнэгдсэн байна.

Арга хэмжээний хэрэгжилтийг бүлэг тус бүрээр нь авч үзвэл:

№	Бүлгийн нэр	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4
1	Бүсчилсэн хөгжлийн бодлого	111	78.0
2	Хүний хөгжлийн бодлого	108	89.0
3	Эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлого	53	90.0
4	Ногоон хөгжлийн бодлого	51	81.0
5	Засаглалын бодлого	63	93.0
Арга хэмжээний хэрэгжилтийн дундаж хувь		386	86.0

“Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан 386 арга хэмжээний хэрэгжилтийг тооцож, зорилт арга хэмжээний үнэлгээг харуулбал:

№	Арга хэмжээний хэрэгжилт	Арга хэмжээний тоо	Төлөвлөгөөнд эзлэх (хувь)
1	2	3	4
1	Зорилтот түвшин **85** хувиас дээш **"Үр дүн гарсан"**	320	83.0
2	Зорилтот түвшин **85** хувьд хүрээгүй **"Үр дүнгүй"**	66	17.0
Нийт арга хэмжээний тоо		386	100%

Салбарын үзүүлэлтээр харуулвал:

№	Бүлэг, салбар	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4
1	*Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд*	**111**	**78.0**
	• Улаанбаатар "20 минутын хот" стандарт	17	82.6
	• Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт	11	86.4
	• Дэд бүтэц	40	71.6
	• Олон төрөлт нийтийн тээвэр, логистик	43	78.8
2	*Хүний хөгжлийн бодлогын хүрээнд*	**108**	**89.0**
	• Нийгмийн эрүүл мэнд	22	98.8
	• Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	19	71.1
	• Эрүүл амьдралын хэв маяг	10	90.0
	• Тэгш хүртээмжтэй чанартай боловсрол	25	92.1
	• Гэр бүл, хувь хүний хөгжил	11	82.7
	• Соёлын бүтээлч үйлдвэрлэл	16	99.0
	• Хөдөлмөр эрхлэлт	5	80.0
3	*Эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд*	**53**	**90.0**
	• Санхүү, төсвийн зохицуулалт	9	97.0
	• Үйлдвэрлэл технологийн парк	5	87.6
	• Үйлдвэрлэл инновац	8	91.9
	• Дөрвөн улирлын аялал жуулчлал	15	85.0
	• Хүнс, хөдөө аж ахуй	8	95.0
	• Мал аж ахуй	7	87.7
	• Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ	1	100
4	*Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд*	**51**	**81.0**
	• Ногоон хот	10	81.5
	• Агаар, орчны бохирдол	20	78.7
	• Байгаль орчин	21	83.8
5	*Засаглалын бодлогын хүрээнд*	**63**	**93.0**
	• Цахим засаглал	3	92.3
	• Орон нутгийн засаглалын бие даасан байдал	37	90.1
	• Ил тод байдал, хяналт	4	100.0
	• Амар тайван аюулгүй нийгэм	19	98.5
Нийт арга хэмжээний дундаж хэрэгжилт		**386**	**86.0**

Үр дүнгүй 66 арга хэмжээнд хяналт-шинжилгээ хийж үзэхэд санхүүжилтийн асуудлаас шалтгаалсан, гадаад хүчин зүйлсээс шалтгаалсан (гэрээний үүргээ биелүүлээгүй, газрын асуудал шийдэгдээгүй г.м), зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээнүүд байна. Тухайлбал:

Санхүүжилтээс шалтгаалан хэрэгжээгүй арга хэмжээ:

1. Шинэ суурьшлын бүсийн орон сууцны хорооллын төслийн хүрээнд 28 мВт хүчин чадалтай уурын зуух шинээр барих /Морингийн даваа/,
2. Арцат, Нүхт, Морь барьдгийн ам, уяачдын хотхоны үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх,
3. Үерийн хамгаалалтын барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах,
4. "Туул усан цогцолбор"-ын ТЭЗҮ шинэчлэх, техник, ажлын зураг төслийг боловсруулах ажлыг эхлүүлэх,
5. Налайх дүүргийн усан сан, насос станц, дамжуулах гол шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлын зураг төсөл боловсруулах,
6. "Толгойт", "Их наран" орчим барьж буй усан сан, шугам сүлжээний угсралтын ажлыг үргэлжлүүлэх,
7. Урьдчилсан цэвэрлэгээ хийх шаардлага хангасан юүлэх станцын ажлыг үргэлжлүүлэх,
8. Дэнжийн 1000 дулаан хангамжийн хийн технологийн 93МВт-ын эх үүсвэрийг барих,
9. Их наран орчимд баригдах 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40 мВА чадал бүхий дэд станцыг барьж, ашиглалтад оруулах,
10. Баянхошуу орчимд баригдах 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40МВА чадал бүхий дэд станцыг барьж, ашиглалтад оруулах,
11. Улаанбаатар хотын 2 байршилд мэдээлэл холбооны үндсэн сүлжээг нэмэгдүүлэх
12. Баруун хэсэгт логистикийн төв байгуулах зураг төслийн ажлыг эхлүүлэх,
13. Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн салбар амбулаторийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх,
14. Эмнэлгийн барилга худалдан авах (Баянзүрх дүүрэг, 32 дугаар хороо),
15. Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн барилгын зураг, төсөв боловсруулах
16. Хүүхдийн сэргээн засах Бяцхан тэмүүлэл төвийн сувиллын барилгын зураг төсөв боловсруулах,
17. Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр олон улсын туршлагыг судлах, экспертийг урьж төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах,
18. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лаборатори шинээр байгуулах бэлтгэл хангах,
19. Төвлөрсөн хогийн цэгүүдийг хашаажуулах,
20. Хот нийтийн аж ахуйн нөөцийн агуулах барих,
21. Улаанбаатар хотын газар доорх усны органик бохирдлын зөөгдлийн загварын судалгаа хийх,

22. Геологи, уул уурхай, авто замын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон, орхигдсон газруудын судалгаа хийх, хохирлыг тогтоох,
23. Орон сууцны хороолол дахь ногоон байгууламж хотын стандартын төсөл боловсруулж, батлуулах,
24. Нийслэлийн хот байгуулалтын салбарын тулгамдсан асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх төлөвлөлтийн шийдлийг мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулах,

Шалгуур үзүүлэлт зорилтот түвшинд хүрээгүй арга хэмжээ:
25. Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх,
26. Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх,
27. Орлогод нийцсэн орон сууцны төслийг үргэлжлүүлэх (Баянголын ам),
28. Ариутгах татуургын "Толгойт" коллекторын 2 дугаар ээлжийг ашиглалтад оруулах,
29. Сэлбэ дулааны станц, Дамбадаржаа дулааны станц, Дэнжийн мянга дулааны станцыг холбосон цагариг сүлжээний дулааны шугамын ажлыг эхлүүлэх,
30. Одоо байгаа 110/10 кВ-ын дэд станцыг өргөтгөх. 2*25МВА чадалтай дэд станцыг 2*40МВА болгож өргөтгөх /Гео дэд станц/,
31. "Хүүхдийн замын хөдөлгөөний сургалтын төв"-ийн ТЭЗҮ, эскиз зураг, ажлын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэх,
32. Зогсоолын эрэлт ихтэй бүсэд 2-оос доошгүй байршилд өөр өөр төрлийн зориулалт бүхий ил зогсоол байгуулж, ухаалаг авто зогсоолын менежментийн системд холбох
33. Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд станц барих бэлтгэл хангах,
34. Такси үйлчилгээнд үйлчилж буй шаардлага хангасан таксины парк шинэчлэлт хийх
35. Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох,
36. Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх,
37. Тэгш хамруулах боловсролын төсөл хэрэгжсэн цэцэрлэг, сургуулийг ментор цэцэрлэг, сургууль болгон зөвлөн туслах, хүний нөөцийг чадавхжуулах, эцэг эх олон нийтэд эерэг ойлголт өгөх нөлөөллийн ажлыг зохион байгуулах,
38. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн сургагч багш" бэлтгэх,
39. Дагуул хот, дэд төвүүд, паркуудад шинээр ажлын байр бий болохыг дэмжиж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан шаардлагатай мэргэжлээр суралцах боломжийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах,
40. Ургамлын үр тариалж, нутагшуулах судалгааны ажил хийх,
41. Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлэх ,
42. "Зочид буудал, дэн буудал, амралтын газар тавигдах ерөнхий шаардлага (MNS 4588:2008, MNS 6043:2019, MNS 6043:2019) стандартын үзлэг зохион байгуулах,
43. Өвлийн хүлэмжийн аж ахуйг хөгжүүлэх, газар олгох, хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэг үзүүлэх,

44. Эрчимжсэн сүүний үхрийн аж ахуйд үржүүлж буй цэвэр үүлдрийн (хар тарлан) үхрийн тоог нэмэгдүүлэх,
45. Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нэвтэрсэн малыг хашаалах газрын асуудлыг шийдвэрлэх,
46. Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам шинэчлэх,
47. Нийслэлийн нийтийн эзэмшлийн ногоон байгууламжийн тооллого явуулах,
48. Хөрсний бохирдлыг газрын нэгдсэн мэдээллийн системд бүртгэж, нийслэлийн хөрсний бохирдол, доройтлыг нээлттэй болгох,
49. Улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх,
50. Онлайн бизнес төвийн үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системийг хөгжүүлэх,
51. Багануур дүүрэгт архивын барилга шинээр барих зураг төсөв боловсруулах,

Хот бүс нутаг төлөвлөлттэй холбоотой удаан хугацаанд хэрэгжихүйц арга хэмжээ:

52. Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг батлуулах,
53. Агро сити эдийн засгийн тусгай бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах,
54. Иргэд оршин суух газраасаа "20 минутын зайд" алхаж хүрэх ногоон байгууламж бүхий соёл, амралтын хүрээлэн байгуулах,
55. Зүүн хэсэгт логистикийн төв байгуулах ажлыг эхлүүлэх,
56. Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх,
57. Монголын Хүүхдийн ордны өргөтгөл "Спорт цогцолбор"-ын барилгыг шинээр барих,
58. Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн барилгын бүрэн хүчитгэл болон Их танхимын засварын ажлыг гүйцэтгэх.

Гадаад хүчин зүйлээс шалтгаалан хэрэгжээгүй арга хэмжээ:

59. Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах
60. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн системийн оргил ачаалалд ажиллах тархмал дулааны эх үүсвэрийг 5 байршилд барих ажлыг эхлүүлэх
61. Улаанбаатар хот, СБД 17 хороо Долоон буудал, Дамбадаржаа орчимд баригдах 2 хэлхээ 110 кВ-ын ЦДАШ, 110/35/10 кВ-ын 2*40 мВА чадал бүхий дэд станцыг барьж, ашиглалтад оруулах
62. Ерөнхий төлөвлөгөөний дагуу холбогдох мастер төлөвлөгөө боловсруулж батлуулах
63. Спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах
64. Багахангай дүүргийн соёлын ордны барилгыг ашиглалтад оруулах
65. “Бүс нуур” цэцэрлэгт хүрээлэнг тохижуулах /УБ, Налайх дүүрэг, 5 дугаар хороо/
66. Архивын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх

Дөрөв.Дүгнэлт

“Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-нд туссан 386 арга хэмжээний 2025 оны жилийн эцсийн тайланд хийсэн хяналт-шинжилгээний дундаж дүн 86.0 хувийн хэрэгжилттэй буюу “Үр дүн гарсан” дүгнэгдсэн.

Тав.Санал, зөвлөмж

Төлөвлөлтийн хувьд судалгаанд үндэслэн бодитой шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээг төлөвлөхгүй байх, тайлагналтын хувьд үр дүн, үр нөлөөг шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнах шаардлагатай байна.

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
ДАРГА Б.МӨНХБАЯР

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ГАЗРЫН
МЭРГЭЖИЛТЭН Б.ИЧИННОРОВ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 01-НИЙ БАЙДЛААРХ ХЭРЭГЖИЛТ

2026 оны 01 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО																				
Салбарын үр дүн: Улаанбаатар "20 минутын хот" буюу нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого, төлөвлөлтийг боловсруулж, төвлөрлийг задлан шинээр байгуулагдах 14 хот, 42 нэгж хороолыг хөгжүүлж иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.																				
Зорилтын үр дүн: 1.1. Улаанбаатар "20 минутын хот" үзэл баримтлалын дагуу иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.																				
1	1.1.1.Хот байгуулалт болон холбогдох салбарын хууль, журам, норм, дүрэм, стандартын хэрэгжилтэд нэгдсэн дүн шинжилгээ хийж, эрх зүйн орчныг сайжруулна.	"Улаанбаатар 20 минутын хот" концепцийн хэрэгжилт хангагдана.	1	20 минутын хот концепцийн хүрээнд Улаанбаатар хотын Хот байгуулалтын бүсчлэлийн дүрэм боловсруулж батлуулна.	2025-2026	-	920.0	-	-	-	-	920.0	Бүсчлэлийн дүрэм боловсруулах ажлын явц, хувь	-	-		ХБХСГ	"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг Улсын Их Хурлаар батлагдсаны дараа боловсруулна. (Тус төсөл, арга хэмжээ 2026 оноос хэрэгжих бөгөөд хугацаа болоогүй.)	ХБ	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсны дараа хийгдэнэ.
2			2	Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн хуулийг дагаж мөрдөхтэй холбоотой бусад хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Санал боловсруулах ажлын явц, хувь	-	10		НЗДТГ-ХТГЭЗГ ХШГ: ХАМТРАН	НЗДТГ-ХТГЭЗГ: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн өөрчлөлтөөр Монгол Улсын нийслэл нь нийт 14 хотод хуваагдаж байгаа ба Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлтэд нийцүүлж, 2025 онд шинэчилсэн хуулийн найруулгад нэмэлт өөрчлөлт оруулсан. Тус хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллахад 20 минутын хот Үндэсний хороо болон Нийслэлийн Засаг даргын тамгын газар хэрхэн хамтран ажиллахад анхаарах асуудлын талаар санал солилцсон. ХШГ: Нийслэлийн Засаг даргын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/1459 дүгээр захирамжаар хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах санал зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус Ажлын хэсгийн хүрээнд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Хяналтын улсын байцаагчийн эрх олгох, цуцлах журам зэрэг нийт 6 хууль тогтоомжийн 24 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулж, танилцуулгын хамт 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 01/186 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн.	84	
3			3	Барилга, авто зам, нийтийн тээвэр, ногоон байгууламж, орон сууцны салбарын холбогдох норм, дүрэм, журам, стандартад нэмэлт өөрчлөлт оруулах саналыг боловсруулж эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Санал боловсруулах ажлын явц, хувь	-	10		УБЗАА, ХБХСГ, НБТГ ХШГ: ХАМТРАН	ХБХСГ: Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийг шинэчлэн найруулах ажлын хүрээнд: -Засгийн газрын тохируулагч агентлаг Стандарт хэмжил зүйн газар, Шадар сайдын ажлын албатай 2025 оны 02 дугаар сарын 10-ны өдөр хамтарсан уулзалтад оролцон хотын стандартын эрх, зүйн орчинг сайжруулах, Захиргааны ерөнхий хуультай уялдуулах талаар саналаа өгсөн. Үүнд: 101 дүгээр зүйл. Хотын стандарт. 101.1.Хотын удирдлагаас иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиг үүргийнхээ хүрээнд стандарт батлан хэрэгжүүлж болно. 101.2.Хотын стандарт нь үндэсний стандарт, техникийн зохицуулалтын үзүүлэлт, шаардлагад нийцсэн байна. -Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Стандарт, хэмжил зүйн газраас 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Барилгын салбарын стандартын өнөөгийн байдалд тулгамдаж буй асуудал" нээлттэй хэлэлцүүлгийг Төрийн ордонд зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Газрын дарга хотын стандартын хэрэгжилт, тулгамдаж буй асуудал сэдвийн хүрээнд танилцуулга, илтгэл тавьж оролцсон. 2025 оны 02 дугаар сарын 21-ний өдөр тус хэлэлцүүлгийн үр дүнг хэлэлцсэн. -Хууль тогтоомж, стандартын төсөлд санал өгөх ажлын хүрээнд 7 хууль, 4 журам, 1 дүрмийн төсөлд саналаа өгч, холбогдох газарт хүргүүлэв. НТБГ: Зам, тээврийн хөгжлийн яамны "Автотээврийн бодлого зохицуулалтын газар"-т 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 01/07/1417 дугаар албан бичгийн хавсралтаар Авто тээврийн салбарын эрх зүйн баримт бичгүүдийг боловсронгуй болгох, шинэчлэх хүрээнд боловсруулсан "Зорчигч тээвэрлэлт. Ангилал ба Ерөнхий шаардлага" MNS 5012:2025 стандартын төсөлд тусгуулах саналыг нэгтгэн хүргүүлсэн. "Стандартчиллын 2026-2027 оны төлөвлөгөөнд тусгуулах стандартын саналаа "Шинэ ажлын сэдвийн санал" маягтын дагуу холбогдох хууль тогтоомж, бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж, 2025 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 01/01/2406 дугаартай албан бичгээр Нийслэлийн засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. ХШГ: Барилга, авто зам, нийтийн тээвэр, ногоон байгууламж, орон сууцны салбарын холбогдох норм, дүрэм, журам, стандартын нэмэлт, өөрчлөлт оруулах хүрээнд нийт 3 хууль, 2 журам, 1 норм ба дүрэм, 4 хотын стандартын төсөлд тус тус санал боловсруулж, холбогдох байгууллагуудад хүргүүлэв. Үүнд: Зөрчлийн тухай хууль-7 санал, Барилгын тухай хууль (шинэчилсэн найруулга)-14 санал, Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн менежментийн тухай хууль-3 санал, Хяналт шалгалтын нийтлэг журам-47 санал, "Ногоон хөгжлийг дэмжих сангийн хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах, ногоон оноо олгох шалгуур, хэмжээг тодорхойлох журам"-1 санал, "Барилгын материал, бүтээгдэхүүний аюулгүй байдлын техникийн зохицуулалт" /БНБД/-д 4 санал, "Орон сууцны барилгын дулаалга, гадна фасадад тавигдах шаардлага" хотын стандартын төсөл-2 санал, "Авто угаалгын газрын гадна орчинд тавигдах шаардлага" хотын стандартын төсөл-1 санал, "Авто засварын газрын гадна орчинд тавигдах шаардлага" хотын стандартын төсөл-1 санал, "Хоёрдогч түүхий эд авах цэгт тавигдах шаардлага" хотын стандартын төсөл-1.	100	
4			5	Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын хугацаанд нийгмийн суурь үйлчилгээ үзүүлэхэд чиглэсэн байгууллагуудын бүтэц зохион байгуулалт хийнэ.	2025-2026	-	-	-	-	-	-	-	Бүтэц зохион байгуулалт хийгдсэн байгууллага, тоо	-	15		НЗДТГ-ТЗҮГ	20 минутын хот Үндэсний хорооны 2024 оны 06 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын гишүүн Ж.Алдаржавхлангаар ахлуулсан "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн бэлтгэл ажил, 20 минутын хот стандартыг хангуулах" чиг үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн 04 дүгээр хуралдаан 2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан. Хуралдааналаар Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1309 дүгээр захирамжаар байгуулагдсан (14 хот, 3 дагуул хот, 42 хороолыг байгуулах шилжилтийн үйл ажиллагаат нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах чиг үүрэг бүхий) Ажлын хэсэгт Нийслэлийн агентлагуудаас 14 хот, 3 дагуул хот, 42 хороолын төлөвлөлттэй уялдуулан бүтэц орон тоо, чиг үүргийн хуваарилалт, төсвийн урьдчилсан тооцооллыг гаргуулж, танилцуулах үүрэг өгөгдсөний дагуу бүтэц, орон тооны саналыг дараах байдлаар боловсруулав. Бүтэц, орон тооны судалгаат аль болох орон тоо нэмэгдүүлэхгүй, одоо байгаа бүтэц, орон тоогоо оновчтой хуваарилах зарчимд суурилсан. Одоо байгаа бүтэц, орон тоо-16,892, нэмэгдүүлэх орон тоо-3728,14 хот, 3 дагуул хот, 42 хороололтой уялдуулан төлөвлөсөн орон тоо-20,620.	59	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
5			6	Улаанбаатар хот, 14 хотын хөгжлийн индексийн суурь анхдагч мэдээллийн боловсруулалтыг сайжруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	2024-2028	-	-	-	-	-	-	-	Индекс шинэчлэх ажлын явц, хувь	50	60		БСШТ	Хотуудын хөгжлийн чиг хандлага, үндсэн чиглэлийг гаргах, төлөвлөх ажлуудыг гүйцэтгэж, орон нутгийн зэрэглэлтэй 14 хотыг байгуулахад шаардлагатай орон зайн зураглалыг гаргасан. Үүнд: Ерөнхий боловсролын сургуулийн хүртээмжийн зураглалд үндэслэн 14 хотод шаардлагатай 26 бага сургуулийн тооцоолол, ерхийн эрүүл мэндийн төвийг 14 хоттой уялдуулсан орон зайн зураглалыг гарган ашиглалтын шаардлага хангахгүй ерхийн эрүүл мэндийн төвийг нэгтгэх замаар чанар, хүртээмжийг сайжруулах тооцооллуудыг хийсэн. Нийт 1.2 сая гаруй иргэнд буюу хүн амын 82 хувь нь шаардлагатай төрийн үйлчилгээг цаг тухайд нь авч чадахгүй байна гэсэн судалгаа гаргасан ба үүнээс шалтгаалан 14 хот дахь төрийн үйлчилгээг чанаржуулахад анхаарах дүгнэлт гарсан. Үүний үр дүнд хотын иргэдийн эрх зүйн болон нийгмийн оролцоонд шууд сөргөөр нөлөөлөх хүчин зүйлийн орон зайн зураглалыг гаргасан. 14 хотын хэмжээнд: - 1-р шатлалын эмнэлэг – 159 - 2-р шатлалын эмнэлэг – 14 - 3-р шатлалын эмнэлэг – 16 - Эмийн сан – 1,057 - Сургуулийн өмнөх боловсрол – 342 - Ерөнхий боловсролын сургууль – 317 - Их сургууль – 39 - Эрчим хүч дулаан хангамж – 224 - Худалдаа, үйлчилгээ, томоохон хүнсний захууд – 65 - Нийтийн тээврийн үйлчилгээний хангамж – 4,097 - Цагдаагийн хэлтэс – 15 - Ногоон байгууламж - 916.8 га - Онцгой байдлын хэлтэс – 8 - Спорт заал, бялдаржуулах тев – 369 Үзвэр үйлчилгээний газрууд /кино театр,музей/ - 83 зэрэг дата өгөгдлийг ArcGIS программд оруулж, боловсруулалт хийсэн. Харьяа байгуллагаас шаардлагатай тоон мэдээллийг цуглуулан, дата мэдээллийг цэцлэх, ArcGIS программ хангамжид оруулах, үр дүнгийн зураглал гаргах зэрэг боловсруулалтыг хийсэн. Хотын хөгжлийн индекс тооцох суурь өгөгдлийг харьяа байгуллагуудаас шинэчлэн, өгөгдөлд дүн шинжилгээ хийн зураглалыг гаргасан. Үүний үр дүнд нийслэлийн хэмжээнд боловсролын салбарт 77 сургууль, цэцэрлэгийг нэмэхээр төлөвлөсөн. Хотын хөгжлийн гол зорилго нь иргэд өөрийн оршин суух газраасаа 20 минутын дотор нийгмийн суурь үйлчилгээг хүртэх боломжийг бүрдүүлэхэд оршдог. Энэ зарчмын хүрээнд орон зайн дүн шинжилгээний аргаар боловсролын үйлчилгээний хүртээмжийг үнэлсэн. Нийслэлийн хэмжээн дэх сургуулиудыг 500, 1500, 3000 метрээр тооцон хүртээмжийн зураглалыг гаргасан. Нийт 317 сургуулийн сурагчдын гэрээс сургууль руу зорчих хөдөлгөөний “Суралцагч болон багшийн зорчилт”-ын зураглал, мөн дүүргүүд хоорондын зорчилтын урсгалын зураглалыг гаргасан. Үүний үр дүнд боловсролын үйлчилгээний хүртээмж, орон зайн хамаарал, төвлөрөл болон алслагдсан асуудлыг илүү нарийвчлалтайгаар тодорхойлох боломж. бүрдсэн. Сонгинохайрхан, Баянхошуу, Дарь-Эх, Баянзүрх, Амгалан, Яармаг зэрэг захын хорооллуудад хүртээмж хангалттүй байна. Судалгааны ажлыг нийслэлийн Боловсролын газар болон Үндэсний статистикийн хороотой хамтран гүйцэтгэсэн бөгөөд Улаанбаатар хотын 370,950 сурагчийн оршин суугаа хаяг болон сургуультай холбогдох мэдээллийг цуглуулан боловсруулсан. Энэхүү мэдээллийг ArcGIS программ хангамжид оруулж, үр дүнгийн таталцлын бүюу зорчилтын орон зайн зураглал боловсруулсан. Үр дүнд Нийслэлийн хэмжээнд авто замын түгжрэлийг бууруулахын тулд Нийслэлийн тээврийн цагдаагийн албаас ирүүлсэн дата мэдээлэлд үндэслэн төрийн өмчийн 156 сургуулийн 314,806 суралцагчийн зорчилт хөдөлгөөний судалгаг хийн ажилласан. Үүний үр дүнд тээврийн хэрэгслийн зорчилт хөдөлгөөний ачаалал сургууль амарсан үед 54.7%-иар буурдаг байна. Улаанбаатар хотыг 14 орон нутгийн зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх бодлогын хүрээнд хүн ам, нийгмийн үйлчилгээ, дэд бүтэц болон эдийн засгийн чиг үүргийн хуваарилалтыг математик загварчлалын үндсэн дээр тооцоолон судалж, хүн амын өсөлт, насны бүтцийн өөрчлөлт, үйлчилгээний ачааллын прогнозыг 2040 он хүртэл тооцооллоо. Математик загварчлалын үр дүнгээс харвал Сонгинохайрхан хот хүн амын тоо харьцангуй бага ч өсөлтийн хурд 1.45 гэсэн динамиктай байгаагаар хамгийн хурдацтай тэлэх хотуудын нэг болохоор байна. Харин Дарь-Эх хот нийт 224.6 мянган хүнтэй болж, өсөлтийн тогтвортой чиг хандлагатай (1.08) бүс болохоор байна. Ийнхүү өсөлтийн ялгаатай динамик нь хотуудын хөгжлийн чиглэлийг зөв оношлох, үйлчилгээний хүчин чадал, дэд бүтцийн хөрөнгө оруулалтын эрэмбэ дараалыг оновчтой тодорхойлох боломжийг бүрдүүлж байна.	100	
6	1.1.2."Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө", "Хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулж батлуулна.	Улаанбаатар хотыг хөгжлийн урт хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн дагуу хөгжүүлэх боломж бүрдэнэ.	1	"Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлж батлуулна.	2025	-	-	-	-	-	-	Бодлогын баримт бичиг боловсруулж батлуулах ажлын явц, хувь	90	100		ХБХСГ	Засгийн газрын 2024 оны 33 дугаар хуралдааны тэмдэглэлд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-ний төслийг Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн шинэчлэлд нийцүүлэн боловсруулах үүрэг өгөгдсөн. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1189 дүгээр захирамжийн хүрээнд “Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө” хот байгуулалтын баримт бичгийг боловсруулж, Засгийн газраас 2025 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай” тогтоолын төслийг Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн. 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" төслийг хэлэлцэх нь дэмжигдсэн. Улсын Их Хурлын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 65 дугаар захирамжаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	95	
7			2	"Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	2025	-	-	-	-	-	-	-	Төлөвлөгөө боловсруулж батлуулах ажлын явц, хувь	-	100		ХБХСГ	“Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг Улсын Их Хурлаар батлагдсаны дараа боловсруулагдана.	ХБ	
8		Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу хот байгуулалтын	1	Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу 14 хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө батлуулж, хот байгуулалтын үйл ажиллагаг эхлүүлнэ.	2025-2028	-	56,088.1	-	-	-	-	56,088.1	Батлагдсан баримт бичгийн тоо	-	11	15,220.4	ХБХСГ	Улсын Их Хурлын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн "Хот байгуулах тухай" 72 дугаар тогтоолоор Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт улсын зэрэглэлтэй 2 хот, орон нутгийн зэрэглэлтэй 14 хот, дагуул 3 хотуудыг байгуулсан. Тус тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Сайдын 2025 оны 176 дугаар тушаалаар байгуулагдсан "Улс, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын эдэлбэр газрын хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг тодорхойлох" үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсгээс гаргсан үүрэг даалгаврын дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1 дэх хэсэгт заасны дагуу улс, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын эдэлбэр газрын хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг тогтоох тухай Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолын төслийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 18 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлээд байна. Улс, орон нутгийн зэрэглэлтэй болон дагуул хотуудын эдэлбэр газрын хил заагийн эргэлтийн цэгүүдийн солбицол, талбайн хэмжээг Улсын Их Хурлаар эцэслэн тогтоосны дараа хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	55	
					2025-2028	-	-	-	-	-	-	-	Бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын явц, хувь	-	10	-	ХБХСГ			

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
	1.1.3."Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний дагуух хот байгуулалтын бусад баримт бичиг, салбаруудын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлнэ.	2	Багахангай, Шарга морьт, Аргалант-Эмээлт дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлуулж, хот байгуулалтын үйл ажиллагааг эхлүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын явц, хувь	-	10	-	ХБХСГ	Багахангай: Багахангай хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний үзэл баримтлалыг Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хүрээлэн хариуцаж байгаа болно. Шаргаморьт: "Шаргаморьт" дагуул хотын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахад шаардлагатай хөрөнгө (1,065,800,000)-ийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2025 оны төсөвт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 2025 оны 24/50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дагуул хотыг хөгжүүлэх хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" багц төсөл, арга хэмжээний багцаас санхүүжүүлэхээр тусгагдсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний Захиалагчийн хяналт хийхэд эрх шилжүүлэх захирамжийн төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 01/517 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Захирамж албажиг гарсны дараа Ерөнхий төлөвлөгөөний ажлын даалгаврыг батлуулж, тендер шалгаруулалтыг зохион байгуулан ажиллана. Аргалант-Эмээлтийн суурьшлыг дагуул хот болгон хөгжүүлэх судалгаог хийж, Улаанбаатар хотын 2040 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд Аргалант-Эмээлт хотыг дагуул хотын статустай байх тухай, дагуул хотын нэршлийг нэг томьёоллоор тусгах тухай саналыг "Хот төлөвлөлт судалгааны институт" ОНӨААТҮГ-т 2025 оны 01/245 дугаартай албан бичгээр хүргүүлэн тусгуулсан.	57	2024 оны Хот байгуулах тухай 72 дугаар тогтоолтой холбоотой асуудалтай холбоотой үе шатны ажил удааширсан.
10		Салбаруудын хүртээмжтэй хөгжлийг хангах нөхцөл бүрдэнэ.	3	"Улаанбаатар 20 минутын хот" хот байгуулалтын бүсчлэлийн дүрмийн хүрээнд Авто зам, Нийтийн тээвэр, Эрчим хүч, Ус хангамж ариутгах татуурга, Байгаль, агаар орчин, Орон сууц нийтийн аж ахуйн салбаруудын мастер төлөвлөгөөг шинээр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Баримт бичиг боловсруулж батлуулах ажлын явц, хувь	-	15	-	УБЗАА, ХБХСГ, НТБГ, НЗХГ, НАОБТГ, НБОГ	УБЗАА: НЗДТГ, УБЗАА-аас Япон улсын олон улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагад хотын ус хангамж ариутгах татуурга, Орон сууц нийтийн аж ахуйн салбарын мастер төлөвлөгөө боловсруулах хөрөнгийн шийдвэрлэх хүсэлтийг тавьсан. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын "Зардал нөхөх төлөвлөгөө" -г Хот суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хороотой хамтран 2020 оны 11 дүгээр сарын 19 -ний өдөр НЗДТГазрын даргаар батлуулсан. 2024 онд цэвэр усны үйлчилгээний үнэ тарифыг хамгийн багадаа 15%, бохир 30%, 2025 онд цэвэр 3% иар нэмэгдүүлнэ гэж заасан байдаг. 2025 онд Сангийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Нийслэлийн Засаг дарга хамтран Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын 209.0 тэрбум төгрөгийн өрийг балансад нь буцаж шилжүүлэхгүй байх, шаардлагатай тариф, татаасыг тодорхойлж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна. 30% ХБХСГ "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг Улсын Их Хурлаар батлагдсаны дараа боловсруулагдана. НЗХГ: "Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ухаалаг, дижитал хотын тээвэрийн мастер төлөвлөгөө боловсруулах" төслийн хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр сургалт зохион байгуулагдсан. Тус ажлыг Бүгд Найрамдах Солонгос улсын газар, дэд бүтэц, тээврийн яамны Хөгжлийн албан ёсны тусламжийн хүрээнд (ODA) олгож буй буцалтгүй тусламжаар 2025 оны 06 дугаар сараас 2027 оны 05 дугаар сар хүртэл хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. НТБГ: Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээг Тогтвортой авто зам тээвэр төслийн нэгж хариуцан боловсруулж байна. Нийтийн тээврийн мастер төлөвлөгөө боловсруулах бэлтгэл ажлын хүрээнд зөвлөх багаас ирүүлсэн "Нийтийн тээврийн стратеги"-ийн тайлантай танилцаж, тайланд тусгах 9 саналыг нэгтгэн 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/02/102 дугаар албан бичгээр, "Нийтийн тээврийн дүн шинжилгээ"-ний тайланг ирүүлсэнтэй танилцаж, нэмэлтээр тусгах 6 саналыг нэгтгэн 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 01/02/355 дугаар албан бичгээр тус тус төслийн нэгжид хүргүүлсэн. Уг зөвлөх үйлчилгээний STRA-C3 дугаартай гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахтай холбогдуулан гэрээний хугацаа сунгах, санхүүжилтийн эх үүсвэрийг өөрчлөх, түншлэл хасах, холбогдох голлох мэргэжилтнүүдийг солих нэмэлт өөрчлөлтийн саналыг боловсруулж, холбогдох хянатлыг хийж ажилласан ба гэрээний сунгалт НЗДТГ-аар 5 дугаар сарын 19-ний өдөр баталгаажсан. Зөвлөх багтай хамтран 2025 оны 06 дугаар сарын 24, 27-ны өдрүүдэд "Улаанбаатар хотын нийтийн тээврийн стратеги ба стратегийн төлөвлөлт, Их багтаамжтай нийтийн тээврийн систем ба нийтийн тээвэрт суурилсан хөгжил" сэдвээр төслийн оролцогч талуудтай уулзалт зохион байгуулсан. Нийтийн тээврийн стратеги төлөвлөгөөний эцсийн тайланд 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 01/02/2216 дугаартай албан бичгээр нэмэлтээр тусгах шаардлагатай 36 саналыг нэгтгэж Тогтвортой авто зам тээвэр төслийн нэгжид хүргүүлсэн. Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратегийн эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлснээр дараагийн шатны Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яаманд өргөн мэдүүлэхээр бэлтгэл ажлыг хангаад байна.	59	
11		Улаанбаатар хотын төвлөрлийг саарулах, амьдрах орчны чанарыг дээшлүүлэх нөхцөл бүрдэнэ.	4	Иргэд оршин суух газраасаа "20 минутын зайд" алхаж хүрэх ногоон байгууламж бүхий соёл, амралтын хүрээлэн, спортын болон авто зам, нийтийн тээвэр, явган хүний зам, дугуйн зам, явган хүний зам бүхий нэгдсэн цогц төлөвлөлтийг хийж, эрүүл мэнд, боловсрол, худалдаа, үзвэр үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Тохижилт, бүтээн байгуулалтын ажлын явц, хувь	-	15	-	ХБХСГ	"Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг Улсын Их Хурлаар батлагдсаны дараа боловсруулагдана.	ХБ	
12	1.1.3."Нийслэл Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний дагуух хот байгуулалтын бусад баримт бичиг	Дагуул хот,	5	Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж буй ХУД-ийн 20-р хорооны суурьшлын бүсийн арьс шир, завод, ноосны анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг /28 нэгж үйлдвэр, 3 нэгж ноосны үйлдвэр болоод 10 дагалдах үйлдвэр/ нүүлгэн шилжүүлэх тухай хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Эмээлт эко үйлдвэрийн паркт зохион байгуулсан. Үүний хүрээнд 4 арьс шир, 1 ноолуур боловсруулах үйлдвэртэй "Паркийн нэгжийн гэрээ" болон "Паркт газар ашиглуулах гэрээ"-г байгуулсан. Мөн Нийслэлийн Ерөнхий Архитекторын санаачлаагаар Хот байгуулалт, хотын стандартын газар болон Эмээлт эко аж үйлдвэрийн парк ХК хамтран "ХУД-ийн 20-р хорооны үйлдвэрийн бүсийн хөрс, усны бохирдлыг саармагжуулах, нөхөн сэргээх нь" сэдэвт хаалттай хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн үр дүнд оролцогч талууд ХУД-ийн 20-р хорооны үйлдвэрийн бүсийн байгаль орчныг нөхөн сэргээх аргачлал, төлөвлөгөө боловсруулж хамтран ажиллахаар болов. 2.Хотын түгжрэл болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж буй зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мега төслүүд, зам тээвэр, логистикийн сүлжээ, өнөөгийн байдлын суурь судалгаанд үндэслэн хот төлөвлөлтийн үндсэн 4 хүчин зүйлсийг харгалзан судалж төвлөрөл, түгжрэл, агаар орчны бохирдолд хамгийн их нөлөөлж буй томоохон 9 зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх төсөл боловсруулсан. Дээрх зах худалдааны төвүүдийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэхэд шаардагдах төсөв санхүүг тооцоолж, үе шат дараатай нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр НЗД-ын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайд танилцуулсан. Зах худалдааны төвүүдийн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал болон НИТХ-д танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Нүүн шилжсэн арьс шир, ноос боловсруулах үйлдвэр, аж ахуйн нэгж	-	-	-	ХБХСГ		55	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
13	бичин, салбарудын мастер төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	эдийн засгийн тусгай бүс кластераар хөгжих боломж бүрдэнэ.	6	Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулна.	2025	-	210.0	-	-	-	-	210.0	Төлөвлөлт боловсруулах ажлын явц, хувь	-	100	210.0	ХБХСГ	Засгийн газрын шуурхай штабын 2025 оны 4 дүгээр хурлаар өгсөн үүрэг даалгаврын дагуу Улаанбаатар хотын томоохон зах, худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мега төслүүд, зам тээвэр, логистикийн сүлжээтэй уялдуулан өнөөгийн байдлын суурь судалгаанд үндэслэн зах, худалдааны төвүүдийг нүүлгэн хот төлөвлөлтийн 4 хүчин зүйлсийг /хот төлөвлөлтийн уялдаа, тээвэр логистикийн сүлжээ, эдийн засгийн хүчин зүйл, замын хөдөлгөөний ачаалал/ харгалзан судалж төлөрөл, тугжрэл, агаар орчны бохирдолд хамгийн их нөлөөлж буй томоохон 9 зах, худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх урьдчилсан төлөвлөгөө боловсруулж иргэд, олон нийтээс санал авах цахим холбоосыг бэлтгэв. Нүүлгэн шилжүүлэх захуудын жагсаалт: 1. Нарантуул зах; 2. 100 айл; 3. Барс худалдааны төв; 4. Да-Хүрээ зах; 5. Өгөөмөр; 6. Хангай зах; 7. Хүчитшонхор; 8. Гурвалжин; 9. Цайз. Дээрх зах, худалдааны төвүүдийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэхэд шаардагдах төсөв санхүүг тооцоолж, үе шат дараатай нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай даргад танилцуулсан. 2025 оны төсөвт санал өгсөн боловч төсөвт суугдаагүй.	84	
14		Их, дээд сургуулийг дагасан хүн амын төвлөрөл саарна.	7	Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн салбар чиглэлээр төрөлжүүлж дагуул хотуудад нүүлгэн шилжүүлэх ажлыг эхлүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Нүүлгэн шилжүүлэх ажлын явц, хувь	-	5	-	ХБХСГ	Улаанбаатар хотын хамгийн их оюутантай МУИС, ШУТИС, ХААИС, МҮБИС зэрэг 4 их сургуульд 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/309, 01/306, 01/308, 01/307 дугаартай албан бичиг хүргүүлж, сүүлийн 10 жилийн оюутны тоон мэдээлэл (шинээр элсэгч, төгсөгч, хөдөлмөр эрхлэлтийн мөшгөх судалгаа) ирүүлэх хүсэлт тавьсан. Хариу мэдээллийг 2025 оны 04 дүгээр сарын 07-30-ны өдрийн хооронд ирүүлсэн. Энэхүү судалгаанд үндэслэн их сургуулиудыг салбар чиглэлээр төрөлжүүлэн дагуул хотуд руу үе шаттайгаар нүүлгэн шилжүүлэх төсөл боловсруулахаар ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/996 дугаар захирамжаар Монгол-Солонгос хөөр улс хамтран хэрэгжүүлэхээр зорьж байгаа "Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол Улсад бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл"-ийн хүрээнд хотын төвлөрлийг задалж, олон төвт хотын тогтолцоог бий болгох, судалгааг олон улсын жишиг нийцүүлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэстийн хүрээнд төсөл хэрэгжүүлэгч КОІСА олон улсын байгууллагын судлаачидтай уулзалт зохион байгуулж, уулзалтаар Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр Хүнну хот байгуулах чиглэлийн судалгаа хийж эвлэх уйтчилгээ үзүүлэхээр шийдсэн. Тухайлбал: Хүнну хотын Оюутны хотхон эрдэм шинжилгээний бүсэд их, дээд сургуулиудыг шат дараатай нүүлгэн шилжүүлэх судалгаа боловсруулахаар тохиролцож 2025.09.03-2025.09.04-ний өдрүүдэд Хүнну хотын төлөвлөлтийн байршилд ажилласан. Монгол Улсын Боловсролын яам болон холбогдох яам, агентлагуудтай КОІСА судалгааны баг уулзалт хийж эхний элэжид нүүлгэн шилжүүлэх их сургуулийн санал авч ажиллаж байна. Цаашид үе шат дараатай судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх бөгөөд тус төсөл нь 2027 он хүртэл үргэлжлэн хийгдэнэ.	52	
15	1.1.4.Нийслэл Улаанбаатар хотыг хөгжүүлэхэд чиглэсэн сангуудыг байгуулж, хөрөнгө оруулалт татах замаар сангуудын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэн хөгжлийн төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлнэ.	Дэд бүтцийн санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журмыг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавина.	1	"Дэд бүтцийн санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам" батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Журмын хэрэгжилтийн явц, хувь	-	10	-	УБЗАА	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/152 дугаар захирамжаар "Дэд бүтцийн санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам"-ын төсөл боловсруулах Ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. Ажлын хэсгээс журмын төслийг боловсруулан 2025 оны 04, 05 дугаар сард Засгийн газрын тохируулагч агентлагууд болон орон нутгийн засат захиргааны байгууллагаас саналыг авч нэгтгэсэн. Журмын төслийг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар 2025 онд багтаж хэлэлцүүлэхээр хүлээгдэж байна.	59	
16			2	"Ногоон хөгжлийн санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журам" батлуулж, хэрэгжилтийг хангуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Журмын хэрэгжилтийн явц, хувь	-	10	-	УБЗАА	Нийслэл хотын хөгжилд хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ногоон оноогоор урамшуулах үйл ажиллагаар зохицуулах "Ногоон хөгжлийг дэмжих санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах болон ногоон оноог олгох шалгуур үзүүлэлт, хэмжээ, түүнийг мөнгөн хэлбэрт шилжүүлэх, санхүүжүүлэх, оноо зарцуулах журам гэсэн хэсэгт хуваагдаж санал боловсруулагдаж байна. "Журам"-ын төсөл боловсруулах Ажлын хэсэгт орсон харьяа байгууллагуудаас санал авахаар Ажлын хэсгийн ахлагч 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 02-02/3786 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Журмын төсөл нь 5 бүлэг 27 зүйл, 2 хавсралттай боловсруулагдан санал авч байна. Ажлын хэсгийн хурал 2025 оны 12 дугаар сард хуралдахаар санал авч нэгтгэн ажиллаж байна.	65	
Зорилтын үр дүн: 1.2. Хот, суурин газрыг дахин төлөвлөн хөгжүүлж, төвлөрлийг сааруулах замаар иргэдийн амьдрах орчныг сайжруулна																				
17	1.2.1.Нийслэл Улаанбаатар хотод шинээр байгуулах орон нутгийн зэрэглэлтэй Хан-уул, Яармаг, Буянт-Ухаа, Сонгинохайрхан, Толгойт, Баянхошуу, Өнөр, Баянгол, Чингэлтэй, Сэлбэ, Сүхбаатар, Дарь-Эх, Баянзүрх, Амгалан хотуудын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу 42 нэгж хорооллыг хөгжүүлэх ажлыг эхлүүлж, "Нэг төвт хотоос олон төвт хот"-ын тогтолцоог бүрдүүлнэ.	"Нэг төвт хотоос олон төвт хот"-ыг хөгжүүлнэ.	1	Шинээр байгуулах 14 хотын хөгжлийн бодлогын судалгаанд математик загварчлал боловсруулж, дүн шинжилгээ хийнэ.	2024-2027	-	-	-	-	-	-	-	Дүн шинжилгээ хийх ажлын явц, хувь	-	25		ХБХСГ, БСШТ	ХБХСГ: "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг Улсын Их Хурлаар батлагдсаны дараа боловсруулагдана. БСШТ: Дэд төвүүдийг 14 хот болгон хөгжүүлэх нь нийслэлийн төвлөрсөн бүтцийг аажмаар задлан, олон төвт хөгжлийн загвар руу шилжих боломжийг бий болгоно. Энэ нь тус бүрд бие даасан дэд бүтэц, ажлын байр, нийгмийн үйлчилгээ, амьдрах орчин бүрэлдэн, нийслэлийн төв рүү чиглэсэн хөдөлгөөнийг бууруулж, замын түгжрэл болон агаарын бохирдлыг бууруулах чухал нөхцөл болно. Энэхүү судалгааны ажил нь хот тус бүрийн хөгжлийн логик уялдаа, нийгэм-эдийн засгийн тооцоо, загварчлалын үр дүнг нэгтгэн том зургаар харж, 2040 он хүртэлх төлөвлөлт, бодлого боловсруулахад чухал суурь баримт, шийдвэр гаргалтын үндэслэл болж байна. Уг ажлын хүрээнд 14 хотын тухай танилцуулгыг бэлтгэн, холбогдох удирдлагуудад танилцуулав.	58	
18			2	Шинээр байгуулах 14 хот 42 нэгж хороололд орон зайн дүн шинжилгээ хийнэ.	2024-2028	-	-	-	-	-	-	-	Орон зайн дүн шинжилгээ хийх ажлын явц, хувь	-	25		ХБХСГ, БСШТ	БСШТ : "20 минутын хот" үзэл баримтлалын хүрээнд орон зайн дата өгөгдөл цуглуулан нэгтгэж, боловсруулалт, дүн шинжилгээ хийсэн. Хотын суурьшлын бүсийн тэлэлтийг 1990-2024 оны 5-8 дугаар сарын Landsat хиймэл дагуулын мэдээ боловсруулан дүн шинжилгээ хийхэд 1990-1995 оны хооронд 1,061.8 га, 1995-2000 онд 2,723.0 га, 2000-2005 онд 2,672.0 га, 2005-2010 онд 2,567.5 га, 2010-2015 онд 1,753.7 га, 2015-2020 онд 4,412.0 га, 2020-2023 онд 5,981.4 га–аар тус тус өссөн үзүүлэлттэй байна. Эрүүл мэнд, боловсрол, нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний хүртээмжийн судалгааны орон зайн дүн шинжилгээг торлолын (grid-based) аргыг ашиглан тодорхойллоо. Суурьшлын бүсийн хил нь 800x800 метрийн 655 торлолоос бүрдэнэ. Нийт 655 торлолын эмийн сангийн хүртээмж 185 торлол, өрхийн эмнэлгийн хүртээмж 113 торлол, II шатлалын эмнэлгийн хүртээмж 11 торлол, III шатлалын эмнэлгийн хүртээмж 14 торлол байгаа нь нийслэлийн хэмжээнд эрүүл мэндийн хүртээмж хангалттүй гэсэн дүгнэлтэд хүрч байна. Улаанбаатар хот, 14 хот тус бүрээр эмнэлгүүдийг төрөлжөн эмнэлэг, хувийн эмнэлэг, эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг гэсэн 4 төрлийн ангиллаар байршлын зургийг гаргасан. Нийслэлийн ерөнхий боловсролын 317 сургуулийн мэдээллийг нэгтгэн орон зайн мэдээнд хөрвүүлэн ашигласан. Нэг багшид ноогдох хүүхдийн тоо, сургуулиудын бүлэг дүүргэлтийн тоо, сургуулиудын хүчин чадлын хэмжээг нийслэлийн хэмжээнд анализ хийсэн. Дэд бүтцийн салбаруудын хүртээмжийн зураглал гаргасан. Үүний үр дүнд дулааны хангамжийн хүртээмж нь 117 байршилд хангамж хүрч байгаа нь энэ салбарын хүртээмж харьцангүй сул байна. Авто замын хүртээмжийн зураглал, худалдаа үйлчилгээ, томоохон хүнсний захуудын хүртээмж, шатахуун түгээх станцын хүртээмжийн тооцооллыг хийсэн. 14 хотын эдийн засаг, өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан 14 тэргүүлэх чиглэлийн санал боловсруулсан. Шинээр төлөвлөж буй 14 хот, 42 нэгж хорооллын орон зайн дүн шинжилгээгээр Баянзүрх, Сүхбаатар, Амгалан зэрэг хотууд эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж өндөртэй, нийслэлийн хэмжээнд анхан болон дунд шатлалын эмнэлгийн төвлөрөл бүхий тэргүүлэх эрүүл мэндийн бүс болох боломжтой нь орон зайн дүн шинжилгээгээр тодорхойлогдсон.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
19	1.2.2.Багануур дүүргийг үул уурхай, хүнд, хөнгөн үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий аж үйлдвэрийн, Налайх дүүргийг хүнс, хөнгөн үйлдвэрлэл, барилгын материалын үйлдвэрлэл, үйлчилгээ, ачаа тээврийн логистик төв бүхий аж үйлдвэрийн улсын зэрэглэлтэй хот болгон хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Улсын зэрэглэлтэй хотуудын үйл ажиллагааг эхлүүлнэ.	1	Багануур, Багахангай, Налайх хотуудыг хөгжүүлэх ТЭЗҮ, үзэл баримтлал, ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батлуулна.	2025-2026	2,000.0	-	-	-	-	-	2,000.0	Суурь баримт бичиг боловсруулах ажлын явц, хувь	-	100	2,000.0	ХБХСГ	Багануур, Налайх, Багахангай хотуудын ТЭЗҮ, үзэл баримтлал, ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлын хөрөнгө Улсын төсөв-Шадар сайдын багцад тавигдсан тул ХББОСЯ-наас уг ажлыг зохион байгуулна.	ХБ	
20			2	Багануур, Багахангай, Налайх хотуудыг хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Бүтээн байгуулалтын бэлтгэл ажлын явц, хувь	-	10		ХБХСГ	Хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх ажлыг зохион байгуулна.	ХБ	
21	1.2.3."Налуу-Ухаа" барилгын материал, хүнд хөнгөн үйлдвэрлэл, тээвэр логистикийн, "Агросити" хүнсний нарийн ногоо, хүлэмжийн аж ахуйн кластер бүхий эдийн засгийн тусгай бүс болгон хөгжүүлэх ажлыг эхлүүлнэ.	Аж ахуйн кластер бүхий эдийн засгийн тусгай бусийн үйл ажиллагааг эхлүүлнэ.	1	Агросити дагуул хотын ТЭЗҮ, хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталж, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.	2025	-	2,332.7	-	-	-	-	2,332.7	Суурь баримт бичиг боловсруулах ажлын явц, хувь	-	100	2,332.7	ХБХСГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжих тухай" А/107 дугаар захирамжаар Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг ХБХСГ-т үүрэг болгосон. Үүрэг даалгаврын хэрэгжилтийг хангуулан дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын даалгаврыг боловсруулж, 2025 оны 2025/01 дугаартай даалгаврыг Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Т.Даваадалай)-оор батлуулсан. Батлагдсан ажлын даалгаврыг НХААГ-т 2025 оны 01/217 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Худалдан авах ажиллагааг НХААГ-аас 3 удаа нээлтэй тендер сонгон шалгаруулалтын аргаар зарласан. 3-р сонгон шалгаруулалтаар 2 гүйцэтгэгч материалаа ирүүлж, 2025.06.16-ны өдөр худалдан авах ажиллагааны Үнэлгээний хороо хуралдаж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж Гоби Травел ХХК болон Интеллекттауэр ХХК-ийн түншлэлтэй "Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын НХААГ/20250103049 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын эхлэлийн тайланг 2025 оны 2025/01 дугаартай ажил хүлээлцэх актаар хүлээн авч, Нийслэлийн нутаг дэвсгэрт хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 44 дүгээр хурлаар хэлэлцэн дэмжигдсэн болов Сангийн яам нийслэлийн төсвийн хөрөнгийн дансыг хаасан шалтгаанаар санхүүжилт удааширч, шийдвэрлэгдээгүй. Гүйцэтгэгч тал болох Гоби Травел ХХК нь ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэн дундын тайланг боловсруулж байгаа болов санхүүжилт саатсанаас шалтгаалан зарим гэрээт ажлууд, лабораторийн дүгнэлтүүдийг товлосон хугацаанд гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүссэн тухай 2025 оны 161/25 тоот албан бичгээр гэрээ сунгах хүсэлт ирүүлснийг судлан үзэж, хугацаа сунгалтын гэрээг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр НХААГ/20250103049-2 дугаартай байгуулав.	84	
22			2	Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бусийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг баталж, инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.	2025-2026	700.0	-	-	-	-	-	700.0	Суурь баримт бичиг боловсруулах ажлын явц, хувь	10	50	700.0	ХБХСГ, НҮЭЗТБЗАА	ХБХСГ: Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бусийг хөгжүүлэх ТЭЗҮ, үзэл баримтлал ерөнхий төлөвлөгөө боловсруулах 700.0 сая төгрөгийг Улсын төсвийн хөрөнгөөр Шадар сайдын багц мөнгөн дүнд тусгагдаж, "Бусчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын тендер шалгаруулалт 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн МУШС/20250103002 дугаартайгаар нээлттэй тендер зарлагдсан. Тендер 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр нээгдсэн боловч гүйцэтгэгч байгууллага тавигдах шаардлагад нийцэхгүйн улмаас тендер амжилтгүй болж төсөв татагдсан. (*Захиалагчийн хяналтыг "Бусчилсэн хөгжлийн Үндэсний хүрээлэн" УТҮГ хариуцан ажиллаж байна.)* НҮЭЗТБЗАА: 2025 оны батлагдсан төслийн хүрээнд Монгол Улсын Шадар Сайдын багцаас Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бусийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулахад 700,000,000 төгрөг төсөвлөж 2 удаагийн тендер зарлаж амжилттүй болсон. Нийслэлийн хот байгуулалт, хотын стандартын газар 2026 оны төсвийн саналдаа дээрх ажилд зориулан 3.1 тэрбум төгрөг байхаар төсөвлөн Монгол Улсын Сангийн яамд хүргүүлээд байна. Захиргчийн ажлын алба нь ерөнхий төлөвлөгөө, техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах бэлтгэл ажлыг хангах үүднээс суурь судалгаа, орчны шинжилгээ хийх ажлыг 100 хувь гүйцэтгээд байна.	ХБ	
23	1.2.4."Хүннү" хотыг Нийслэл хотын тусгай чиг үүргийг гүйцэтгэх хүрээнд төрийн захиргаа, их дээд сургууль, тээвэр логистик, аялал жуулчлал, санхүүгийн төрөлжсөн дагуул хот болгон хөгжүүлнэ.	"Хүннү" хотын инженерийн дэд бүтцийг барих "Хүннү хотын дэд бүтэц" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.	1	"Нүүрс төрөгч ялгаруулдаггүй, сэргээгдэх эрчим хүчээр хангасан байгаль орчинд ээлтэй ухаалаг тогтвортой хот" байгуулах үзэл баримтлал боловсруулна.	2025	-	-	-	-	-	-	-	Уралдаант шалгаруулалтын явц, хувь	-	100		ХХЗАА	Олон улсын хот төлөвлөлтийн жишгийн дагуу "Хүннү ногоон хотын төлөвлөлтийн үзэл баримтлал буюу хотын дүр төрх, дизайныг боловсруулах" олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын мэдээллийг дэлхийн хот төлөвлөлт, архитектур, дизайны чиглэлээр нийтлэл бичдэг, бүтээлүүдийг оруулдаг нэр хүнд бүхий веб сайтуудад байршуулан сурталчилснаар 24 улсын 34.1 сая иргэнд мэдээлэл хүрч 21 улсын 43 баг бүртгэлээ баталгаажуулсан. 2025.11.11-14-ны өдрүүдэд "Хүннү ногоон хотын төлөвлөлтийн үзэл баримтлал буюу хотын дүр төрх, дизайныг боловсруулах" олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтын уралдаан, хот төлөвлөлтийн үзэсгэлэнг зохион байгуулж, хөрдүгаар шатанд шалгарсан 24 шилдэг багийн бүтээлүүдээс 5 шилдэг бүтээлийг мэргэжлийн 9 шүүгчийн онооноос гадна олон нийтийн саналын оноогоор шалгаруулсан. Шилдэг бүтээлүүдийг шалгаруулах ёслолын арга хэмжээг 2025.11.14-ний өдөр зохион байгуулж, эхний 5 байр ээлсэн багийн шагналыг гардууллаа.	100	
24			2	Эхний ээлжийн салбар шугам сүлжээний зураг төсөл боловсруулна.	2025-2028	-	4,200.0	-	-	-	-	4,200.0	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	-	100	4,200.0	ХХЗАА	Нийслэлийн төсвийн 4,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Хүннү хотын бүтээн байгуулалтыг хангах эхний ээлжийн дэд бүтцийн инженерийн шугам сүлжээний (дулаан, ус хангамж, ариутгах татуурга, цахилгаан хангамж, холбоо дохиолол, инженерийн бэлтгэл арга хэмжээ) салбар шугамын зураг төсөв боловсруулах ажил 40%-тай хийгдэж байна. Үүнд: багц-1 Хүннү (Шинэ зуунмод) хотын "Хотын төв, засаг захиргааны бүс"-ийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв болон мэдээлэл холбооны нэгдсэн төв, хотын хяналт удирдлагын төвийн барилгын загвар зураг-40%, багц-2 Хүннү (Шинэ зуунмод) хотын "Эдийн засгийн чөлөөт бүс"-ийн гадна инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв -40%, багц-3 Хүннү (Шинэ зуунмод) хотын Тээвэр логистик, үйлдвэрлэлийн бүс болон Их дээд сургууль, оюутны хотхоны гадна цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв-40%-тай үргэлжилж байна.	75	
25			4	Шинээр авто зам барих зураг төсөл боловсруулна.	2025	-	5,800.0	-	-	-	-	5,800.0	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	70	100	5,800.0	ХХЗАА	Нийслэлийн төсвийн 5,8 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар "Хүннү" хотын эхний ээлжийн 127.4 км авто замын ажлын зураг төслийн гүйцэтгэгчээр "ХЗТ авто зам" ХХК шалгарч, ажлын гүйцэтгэл 50%-тай явагдаж байна. Авто замын ажлын зураг төслийг Хүннү хотын 1. ЭЗЧБүс 2. Олон нийтийн бүс 3. Хотын төв, засаг захиргааны бүс 4. СЭШУЦогцолбор 5. Тээвэр логистикийн нэгдсэн төв зэрэг 5 байршилд гүйцэтгэж байна. Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн 102км төмөр замын бүтээн байгуулалтыг "МТЗ" ТӨХК гүйцэтгэж буйтай холбоотой тээвэр логистикийн нэгдсэн төвийн байршил өөрчлөх болн Боловсролын яамны захиалгаар СЭШУЦогцолборт Шинжлэх Ухаан, Технологийн Их сургуулийн Механик, тээврийн сургуулийг Хөшигийн хөндий руу нүүлгэхтэй холбоотой зураг төсөв /Хөшигийн хөндий/ боловсруулах явцад байршлыг зөвшилцөхтэй холбогдуулан ажлын даалгавар өөрчлөгдөх нөхцөл үүссэн тул тооцоолол судалгаа хийгдэж байна.	83	
26			6	Хүннү хотын Эрчим хүчийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр хангана.	2025-2029	-	-	-	-	1,608,300.0	1,608,300.0	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	-	30	482,490.00	ХХЗАА	Төр хувийн хэвшлийн түншлэлээр "Хүннү" хотыг сэргээгдэх эрчим хүчээр хангах бодлогын хүрээнд "Улаанбаатар түншлэл төв" ХХК нь 360 мВт/ц-ийн багтаамжтай 90 мВт-ын эрчим хүчний хуримтлуур, 100 мВт-ын нарны станцын ТЭЗҮ-ийг боловсруулж, Эрчим хүчний яамны дэргэдэх ШУТҮЗөвлөлийн хурлаар хэлэлцүүлсэн. ШТҮЗөвлөлийн 2025 оны 09 хуралдааны 42 дугаар тэмдэглэлээр ТЭЗҮ-ийг дэмжиж, батлагаажуулсан. "Хүннү хотын өөрийн үүсвэрээс цэнэглэх 90МВт батарей хуримтлуур төсөл"-ийг НИТХ-ын 2025 оны 25/01 дүгээр тогтоолоор төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Тус төслийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээ, эрсдэлийн үнэлгээнүүдийг "Улаанбаатар түншлэл төв" дээр хийгдсэн бөгөөд төслийг зарлах эрх авахаар НИТХ-д ергөн мэдүүлсэн. НИТХ-аар 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр тус төслийг зарлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхээр хүлээгдэж байна.	65	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулагa	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
27			7	Логистикийн нэгдсэн төв байгуулах ажлыг эхлүүлнэ.	2022-2032	-	-	-	-	-	-	-	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	5	10		ХХЗАА	Хүннү хотын төмөр замын нэгдсэн логистик төвийн гадна цахилгаан хангамжийн ОН2512001707002003 дугаартай "Хүннү хотын Тээвэр логистик, үйлдвэрлэлийн бүс болон Их дээд сургууль, оюутны хотхоны гадна цахилгаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл, төсөв" боловсруулах ажлын хүрээнд 110 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамудын трасс гаргах, дэд станцын байршил, түүний инженер геологийн судалгаа хийх, зарчмын схем боловсруулах ажил хийгдэж, 110/35/10 кВ-ын "Логистик" дэд станц, 10 кВ-ын кабель шугам, хуваарилах байгууламжийн төсвийн тооцоолол хийгдсэн. Багахангай-Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын ачилтын талбайн төлөвлөлтийн байршил нь "Монголын төмөр зам" ТӨХК-ийн хүсэлт, техникийн шаардлагын дагуу өөрчлөгдөх нөхцөл шаардлага үүссэн тул Хүннү хотын захирагчийн ажлын алба, "Хүннү хотын хөгжлийн корпорац" ХХК болон Төмөр замын мэргэжлийн байгууллагатай хамтран тус талбайн төлөвлөлтийг дахин шинээр зөвшилцөх ажил хийгдэж байна.	81	
28			8	Эхний ээлжийн инженерийн дэд бүтцийг барина.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	-	30		ХХЗАА	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 143 дүгээр тогтоолоор Хүннү хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлан 2022-2025 онуудад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Барилга хот байгуулалтын сайд /хуучнаар/, Эрчим хүчний сайдын багц, Нийслэлийн төсвөөс нийт 329.8 тэрбум төгрөгийн бүтээн байгуулалтын ажил хийгдэж байна. Үүнээс 2025 онд ниислэлийн төсвөөс 43.4 тэрбум төгрөг хуваарилж, хотын инженерийн дэд бүтцийн ажлын зураг төсөв, цэвэрлэх байгууламжийн бүтээн байгуулалтын төслүүд хэрэгжиж байна. Ингэснээр Хүннү хотын Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ажлын зураг төслийн дагуу хотын дэд бүтцийн эх үүсвэрийн бүтээн байгуулалтын ажлууд хэрэгжиж, цахилгаан хангамж 86%, ус хангамж 80%, үерийн хамгаалалтын суваг 75%, мэдээлэл холбооны сүлжээ 65%, ариутгах татуурга 10%, дулаан хангамж 10 % -ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Нийт дэд бүтийн бүтээн байгуулалт 30 хувьтай байна.	100	
29	1.2.5.Дамбадаржаа, Дэнжийн мянга, Толгойт, Шархад, Яармаг дэд төвүүдийн инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.	Дэд төвүүдэд байрлах нийт 59.000 өрх инженерийн дэд бүтцэд холбогдоно.	1	Дамбадаржаа дэд төвийн инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг бүрэн дуусгана.	2017-2026	-	48,996.3	-	125,062.7	-	-	174,059.0	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	53	80	139,247.2	УБГХХХОДХ төслийн нэгж	Дамбадаржаа дэд төвийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 297 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 296 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 98%-тай байна. Авто зам инженерийн барилга байгууламжийн ажлын трасст өртсөн 1 өрх эд хөрөнгийн өмчлөлийн маргаантай, шүүхдэж байгаа тул хэлэлцээр эцэслэн хийгдээгүй хүлээгдэж байна. Шүүхийн шийдвэр гарахаар хэлэлцээр хийгдэнэ. Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил бүрэн хэрэгжиж дууссан байна. Худалдан авах ажиллагааны явц 98%-тай байгаа бөгөөд 63МВт-ын дулааны станцын зөвлөх үйлчилгээний 1 багц ажил, 58-р сургууль орчмын орц, гарц, гадна тохижилтын 1 багц ажил болон цэцэрлэгийн тавилга худалдан авах 1 багц ажил үлдсэн байна. Дамбадаржаа дэд төвийн барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: • 2.8 км авто замын ажлын явц 100% 63МВт-ын хүчин чадалтай дулааны станцын барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 38%-тай байгаа бөгөөд Эрчим хүчний яамнаас ажил эхлүүлэх зөвшөөрөл 2025 оны 03 сарын 06-нд гарсан. 21МВт-ын 3 зуух болон метал хийц, бусад голлох тоног төхөөрөмжүүдийн гадаад захиалга хийгдээд байна. • 2.15 км дулааны шугам сүлжээний ажлын явц 83%, 4ш ус дулаан дамжуулах төвийн барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 90% 6.6 км цахилгааны шугам сүлжээ, 5.9 км холбооны сувагчлал, 4.8 км шилэн кабель, 1 хуваарилах байгууламж, 2 хаалттай дэд өртөө болон мэдээлэл холбооны сүлжээний нэгдсэн үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлын явц нийт 80% байгаа бөгөөд "Авто зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрөл олгох" ажлын хэлтсийн хурлаар орж зам сэтлэх, сүвлэх зөвшөөрөл авах шаардлагатай хурлын тов хүлээгдэж байна. • 2.24 км цэвэр усны, 3 км ариутгах татуургын шугам сүлжээний ажлын явц 100% • 1.2 км хөрсний ус доошлуулах шугамын угсралтын ажлын явц 100% • 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц 100%-тай байна. Дэд төвийн бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц 87.6%-тай байна.	100	Дамбадаржаа дэд төвийн 63 МВт-ын хүчин чадалтай дулааны станцад 2021 оны 1 дүгээр сарын 25-нд цахилгаан хангамжийн техникийн нөхцөл олгосон бөгөөд гүйцэтгэгчтэй гэрээг 2023 оны 10 дугаар сарын 03-нд байгуулсан. Техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах хүсэлтийг 2023 оны 11 дүгээр сарын 10-нд болон 2024 оны 2 дугаар сарын 8, 9 дүгээр сарын 10, 10 дугаар сарын 01-нд Эрчим хүчний яаманд хүргүүлсэн ч эх үүсвэр, холбох цэгийн хүчин чадал болон нэгдсэн сүлжээний нэвтрүүлэх, шингээх чадвар хүрэлцэхгүй гэсэн үндэслэлээр удаа дараа татгалзсан. Эцэст нь 2025 оны02 дугаар сарын 12-нд техникийн нөхцөлийг сунгаснаар, 03 дугаар сарын 06-нд ажил эхлүүлэх зөвшөөрөл авч, ажлаа эхлүүлэх боломж бүрдсэн нь төслийн хугацаанд саатал үүсгэхэд нөлөөлсөн.
30			2	Толгойт дэд төвийн инженерийн болон нийгмийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг бүрэн дуусгана.	2020-2026	-	29,938.0	-	106,269.4	-	-	136,207.3	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	34	60	53,702.8	УБГХХХОДХ төслийн нэгж	Толгойт дэд төвийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 501 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 472 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 97%-тай байна. Авто зам инженерийн барилга байгууламжийн ажлын трасст өртсөн 1 өрх эд хөрөнгийн өмчлөлийн маргаантай, шүүхдэж байгаа тул хэлэлцээр эцэслэн хийгдээгүй байна. Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 100%-тай хэрэгжиж байна. Худалдан авах ажиллагааны явц 85%-тай байгаа бөгөөд Толгойт дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн 4 багц ажил, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 2 барааны худалдан авалт үлдсэн байна. Толгойт дэд төвийн барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: • 1.8 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 100%-тай байна. • 5.2 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 60%-тай байгаа бөгөөд Д-1, Д-2.1, Д-2.3 үерийн хамгаалалтын сувгийн угсралтын ажил хийгдэж байна. • 2.84 км цэвэр усны шугам сүлжээний ажил болон насос станцын барилга угсралтын ажил 100% дууссан. • 10 кВ-ын хүчдэлийн 13 км урттай 4 хос цахилгааны кабель шугам, 2 хаалттай дэд өртөө болон 1 хуваарлах байгууламжийн ажлыг гүйцэтгэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлаа эхлүүлсэн. Хаалттай дэд өртөө болон хуваарлах байгууламжийн суурийн арматурчлал болон цутгалтын ажил хийгдэж барилга угсралтын ажлын явц 25%-тай байна. • Сургалтын төвийн барилга угсралтын ажлын явц 100% дууссан. • 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлын явц 60%-тай байна. Дэд төвийн бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц 74.16%-тай байна.	100	Ковид-19 цар тахлын улмаас барилгын материалын үнэ болон тарифт цалин өссөнөөр барилгын ажлуудын төсөвт өртөг хүрэлцэхгүй гэдэг шалтгаанаар зарим ажлуудын тендерт оролцогчгүй болсон тул тендер дахин зарлах шаардлага гарч, ажил урагшахад хүндрэл учирсан.

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
31	1.2.6.Шархад, Дамбадаржаа, Толгойт дэд төвүүдийг орон сууцжуулах төслийг эхлүүлнэ.	"Хорин минутын хот" үндсэн үндсэн концепцийг анхлан хэрэгжүүлэх Сэлбэ дэд төвд 10,068 айлын орон сууцны цогцолбор хороолол барих "Сэлбэ хот орон сууцжуулах" төслийг хэрэгжүүлнэ.	1	Сэлбэ дэд төвд төрийн болон нийтмийн бүх үйлчилгээг хуртээмжтэй авах боломжтой орон сууцны цогцолбор хороллыг барьж байгуулна.	2025-2028	-	1,646,200.0	-	-	-	680,800.0	2,327,000.0	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	15	50	912,554.0	НОСБГ, СХМХК ХХК	"Сэлбэ хорин минутын хот" төсөл, арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо болон Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрийг хамарсан 158 га талбайд "Хорин минутын хот" үндсэн концепцийг анхлан хэрэгжүүлэх үүргийг манай байгууллагад даалгасан. Сэлбэ хорин минутын хот бүтээн байгуулалтын ажлын хүрээнд нийт 8565 өрхийн 113 блок орон сууц, 7,1 км авто зам, 39 км явган зам, 23 км дугуйн зам, 3.6 га талбайд тоглоомын талбай, 3780 хүүхдийн 3 сургууль, 1200 хүүхдийн 5 цэцэрлэг, эмнэлэг, спорт байгууламж байгуулахаар төлөвлөсөн бөгөөд нийт талбайн 62,6 га буюу 39 хувьд нь ногоон байгууламж барихаар төлөвлөж байна. Төслийн хүрээнд нийт 158 га талбайн 2206 нэгж талбар чөлөөлөхөөс төрийн байгууллагын чөлөөлөхгүй 107 нэгж талбар, АТД буюу архитектур төлөвлөгөөний даалгавар хүссэн 105 нэгж талбар байгаа бөгөөд 1994 нэгж талбарыг бүрэн чөлөөлөхөөс 1872 нэгж талбарыг чөлөөлж, үлдсэн 122 нэгж талбарыг Нийслэлийн газрын албатай хамтран чөлөөлөх ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар газар чөлөөлөлт 94,1 хувьтай байна. Төслийн барилгажилтын талбайн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд нийт 2206 нэгж талбарт ариутгал халдваргүйжүүлэлт хийхээс 1919 нэгж талбарыг цэвэрлэн ариутгаж 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар ажлын явц 83.0 хувьтай, мөн холбооны худаг буулгалтын ажил 95%, Барилгын төслийн байршилд зөвшөөрөлгүй баригдаж буй барилгын буулгалтын ажил 95% хийгдсэн. Төслийн хэмжээнд, захиалагч, гүйцэтгэгчид бүх нийтээр дагаж мөрдөх Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн чиглэлээр баримтлах үндсэн бодлогын бичиг баримт боловсруулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны дугаар захирамжаар Нийслэлийн үнэт цаасны хөрөнгөөр 2025 онд "Сэлбэ дэд төвийн орон сууцны иж бүрэн цогцолбор хороолол" төслийн хүрээнд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар Багц 1, Багц 2, Багц 3.1, 3.2, 3.3, Багц 4.1, 4.2-ын барилга угсралтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийн худалдан авах ажиллагаат зохион байгуулж, хамгийн сайн тендерээр "Багц 1" төсөлд "Хятадын хөрөнгө оруулагч металлургийн групп" ХХК, "Багц 2" төсөлд "Хятадын барилгын зургаадугаар инженерийн товчоо" ХХК, "Багц 3.2" төсөлд "Морин сувд ХХК, "Юувөкү" ХХК,"Их базар констракшн" ХХК-иудын түншлэл, "Багц 3.3" төсөлд "Нутгийн буян" ХХК, "Багц 4.1" төсөлд "Монкон констракшн" ХХК, "Багц 4.2" төсөлд "Професионалстрой" ХХК, "Шуофан групп" ХХК-иудын түншлэл шалгарч гэрээний хэлэлцээрийг зохион байгуулан барилга угсралтын "ЕРС" гэрээг байгуулж ажилласан. "Багц 1" төслийн "Гадна цахилгаан, холбоо дохиолол, гэрэлтүүлэг, дэд өртөө, РП-ийн барилга угсралтын ажил" -ын гүйцэтгэгч, "Смарт крафт" ХХК, "Багц 2" төслийн "Гадна цахилгаан, холбоо дохиолол, гэрэлтүүлэг, дэд өртөө, РП-ийн барилга угсралтын ажил" -ын гүйцэтгэгч "Эм Эм Эс инженеринг" ХХК төндерт шалгарч тус компаниудтай гэрээ байгуулж ажилласан. 47,25 га талбайн 19 хэсэгт үйлчилгээтэй орон сууцны барилга, олон нийтийн барилга, байгууламж, худалдаа, үзвэр үйлчилгээ, спорт цогцолбор, давхар зогсоол, авто үйлчилгээ зэргийг төлөвлөж байгаа ба төсөл хэрэгжүүлэгчийн сонгон шалгаруулалтын БЭЛТГЭЛ ажил явагдаж байна. Нийт төслийн гүйцэтгэлийн явц: 1.Төслийн ТЭЗҮ, зураг төслийн гүйцэтгэлийн хувь 95%, (Орон сууцны хорооллын барилгын нэг маягийн зураг төсөл 100% магадлагдаж баталгаажсан) 2.Багц 1,2 ГИШС зураг төсөл 100% магадлагдсан, Багц 3,4 ГИШС 98%, магадлуулах ажил хийгдэж байна.) 3.Газар чөлөөлөлт 93%, Цэвэрлэгээ буулгалт 70.4% 4.Сонгон шалгаруулалт, Гүйцэтгэгчтэй гэрээлэх ажил 78.6% 5.Барилга угсралтын гүйцэтгэлийн хувь 7% 6.Багц 1 Бэлтгэл ажил-98.6%, Суурь ухлагын ажил-89.7%, Суурийн ажил-52.6%, Зоорийн давхрын угсралтын ажил-38%, Барилга угсралтын ажил-4.5% 7.Багц 2 Бэлтгэл ажил 98.2%, Суурь ухлагын ажил-91.1%, Суурийн ажил-61.3%, Зоорийн давхрын угсралтын ажил 76.2%, 1-р давхрын угсралтын ажил 37.8%, 2-р давхрын угсралтын ажил-7.3%, Барилга угсралтын ажил-5.6% 8.Багц 3.1 Бэлтгэл ажил-6% 9.Багц 3.2 Бэлтгэл ажил-66%, Суурь ухлагын ажил-80%, Суурийн ажил-30.6%, Барилга угсралтын ажил-2.6% 10.Багц 3.3 Бэлтгэл ажил-54%, Суурь ухлагын ажил-56.8%, Суурийн ажил-33.3%, Зоорийн давхрын угсралтын ажил-34.8%, Барилга угсралтын ажил-2.6% 11.Багц 4.1 Бэлтгэл ажил-55%, Суурь ухлагын ажил-70.3%, Суурийн ажил-46.8%, Зоорийн давхрын угсралтын ажил-43.9%, Барилга угсралтын ажил-3.5 хувьтай төслийн ажил ургэлжилж байна. "Сэлбэ хорин минутын хот" төслийн гүйцэтгэлийн хувь 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 24,5 байна. (Тайлбар: Хугацаа зарцуулалтаар: Суурь түвшин 15% (2025 он 01 сар) Одоогийн түвшин 60% (2025 он 11 сар) ; Санхүүжилтийн хувиар: Суурь түвшин 0.1% (2025 он 01 сар) Одоогийн түвшин 20% (2025 он 11 сар)	95	
32		Дэд төвүүдэд 8.200 өрхийн орон сууцны цогцолбор хороолол барих "Нийслэлийг орон сууцжуулах" төслийг хэрэгжүүлнэ.	2	Баянхошуу хот орон сууцжуулах төслийн хүрээнд 1-р ээлжийн 462 өрхийн ногоон орон сууц бүхий эко хороллыг барьж байгуулна.	2025-2026	-	-	-	70,613.0	-	-	70,613.0	Ашиглалтад орсон орон сууц, өрхийн тоо	-	260	64617.0	УБХОННО СБДЗҮБХ ШС төслийн нэгж	Төслийн хүрээнд тогтвортой хөгжлийн 37 гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) бүхий ногоон орон сууцны барилгын техникийн шаардлагыг хангасан, мөн Олон улсын ногоон барилгын үнэлгээний EDGE системийн шалгуурын дагуу 800 айлын орон сууцны барилга болон ухаалаг удирдлагын СКАДА төвийн барилгын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд болон магадлалаар хянуулан батлуулсан. Баянхошуу дэд төвд баригдаж буй эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны 4 блок барилга угсралтын ажил бүрэн дуусч, 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр үүрэг даалгаврын биелэлттэйгээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисст хүлээлгэн өгсөн ба 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн БА-311/2025 дугаар барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан. Тус дэд төвийн инженерийн шугам сүлжээний барилга байгууламжийн ажлын явц 100 хувийн хэрэгжилттэй, улсын комиссд 2024 оны 12 дугаар сарын 26-нд хүлээлгэн өгсөн. Харин Баянхошуу дэд төвд 2024 оны 07 дугаар сараас эхлүүлсэн 226 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 68 хувьтай хэрэгжиж байна. Баянхошуу дэд төвийн барилгуудыг EDGE стандартын шаардлагыг хангасан байдалд эрх бүхий Sintali" Ltd аудит хийсэн ба 2025 оны 08 дугаар сарын 13-нд B15 талбарын 4 блок барилгууд нь EDGE стандартыг зураг төслийн шатанд хангасан болохыг батлан GP1-MNG-23112910179665-110-P дугаартай EDGE гэрчилгээ олголоо. Аудитын явцад тус төслийн эрчим хүчний хэмнэлт - 34%, Усны хэмнэлт - 20%, Материалд шингэсэн хүлэмжийн хийн хэмнэлт - 21% гэж үнэлэгдсэн болно.	83	
33			3	Баянхошуу хот орон сууцжуулах төслийн хүрээнд 2-р ээлжийн 2354 өрхийн ногоон орон сууц бүхий эко хороллыг барьж байгуулна.	2025-2030	-		-	381,510.0	-	-	381,510.0	Ашиглалтад орсон орон сууц, өрхийн тоо	-	-		УБХОННО СБДЗҮБХ ШС төслийн нэгж	ЭХОНОСС-г Улсын бүртгэлд 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр бүртгүүлсэн. Үүнтэй холбоотойгоор хөгжүүлэгч сонгон шалгаруулах ажил 2026 оны 01 дүгээр улирлаас эхэлж байгаа учир сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа болон төслийн гүйцэтгэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд сонгон шалгаруулалтын шаардлагудыг нарийвчлан тогтоох болон тендер зарлах БЭЛТГЭЛ ажлуудыг дуусаны дараа тендер зарлаж, барилга угсралтын ажлыг 2026 оны 03 дугаар сард эхлүүлэхээр төлөвлөж байна.	ХБ	
34			4	Шархад дэд төвд 1 дугээр ээлжийн 338 өрхийн ногоон орон сууц бүхий эко хороллыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2024-2026	-	-	-	46,013.0	-	-	46,013.0	Ашиглалтад орсон орон сууц, өрхийн тоо	10	186	45,231.0	УБХОННО СБДЗҮБХ ШС төслийн нэгж	Төслийн хүрээнд тогтвортой хөгжлийн 37 гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) бүхий ногоон орон сууцны барилгын техникийн шаардлагыг хангасан, мөн Олон улсын ногоон барилгын үнэлгээний EDGE системийн шалгуурын дагуу 800 айлын орон сууцны барилга болон ухаалаг удирдлагын СКАДА төвийн барилгын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд болон магадлалаар хянуулан батлуулсан. Барилгын эрчим хүчний үр ашиг, Ногоон Барилгын Үнэлгээний Системийг олон нийтэд таниулах, барилгын салбарын мэдлэг, чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор олон Улсын Санхүүгийн Корпорац (ОУСК)-ын "Ногоон барилгын үнэлгээний Excellence in Design for Greater Efficiencies (EDGE) систем"-ийн дотоодын мэргэшсэн эксперт БЭЛТГЭХ сургалтуудыг зохион байгуулаа. Сургалтад төрийн болон төрийн бус байгууллагуд, аж ахуйн нэгжийн төлөөлөл нийт 30 мэргэжилтэнг хамруулав. Шархад дэд төвд баригдаж буй эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны 4 блок барилга угсралтын ажлын хэрэгжилт 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэхүү барилгыг 2025 оны 12 дугаар сард Улсын комисст хүлээлгэн өгнө. Шархад дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын явц 100 хувийн хэрэгжилтэд хүрч, 2025 оны 11 дүгээр сарын 12-нд улсын комисст хүлээлгэн өгсөн. Шархад дэд төвд 2024 оны 07 дугаар сараас эхлүүлсэн 152 айлын орон сууцны барилга угсралт 71 хувь, 2025 оны 03 дугаар сард эхлүүлсэн 76 айлын ногоон орон сууцны барилга угсралт 51.4 хувьтай хэрэгжиж байна. Төслийн барилгуудыг EDGE стандартын шаардлагыг хангасан байдалд эрх бүхий Sintali" Ltd аудит хийсэн ба 2025 оны 05 дугаар сарын 15-нд S27-2 төслийн 6 блок барилгууд нь EDGE стандартыг зураг төслийн шатанд хангасан болохыг батлан GP1-MNG-24101310211650-240-P дугаартай EDGE гэрчилгээ олголоо. Аудитын явцад тус төслийн эрчим хүчний хэмнэлт - 38%, Усны хэмнэлт - 29%, Материалд шингэсэн хүлэмжийн хийн хэмнэлт - 23% гэж үнэлэгдсэн болно.	85	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
161	1.5.3.Цахилгаан автобусны цэнэглэх саравч зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулж, цахилгаан автобусны хэрэглэгч нэмэгдүүлнэ.	Байгальд ээлтэй цахилгаан автобусны хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Цахилгаан тээврийн хэрэгслийг цэнэглэх дэд станц 3 байршилд барина.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Цэнэглэх цэг, тоо	1	-		НТБГ	Цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төслийг боловсруулан, хамтран ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 01/07/33 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд БНСУ-ын Кёнсанбүг мужийн холбогдох албан тушаалтан хүрэлцэн ирж, цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төслийн талаар танилцуулж, санал бодлоо солилцсон. 2025 оны 05 дугаар сарын 21-ний 01/08/1161 дугаартай албан бичгээр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах ажлын хүрээнд холбогдох зураг төсөл, төсвийн задаргааг төсөл хэрэгжүүлэх байгуулагаар гүйцэтгүүлж, холбогдох зардлыг 2026 оны хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тусгуулах талаар хамтран ажиллах санал хүргүүлсэн. Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дүгээр шүүхийн шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжаар 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг хоёр үе шаттай зохион байгуулж, 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-т актаар хүлээлгэн өгсөн.	55	
162	1.5.5.Хотын эүүн, баруун хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн бөөний худалдааны төв байгуулна.	Олон улсын стандартад нийцсэн ачаа тээвэр, логистикийн үйлчилгээ нэвтрүүлнэ.	1	Хотын эүүн хэсэгт ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	612,500.0	612,500.0	Логистикийн төв байгуулах ажлын явц, хувь	-	20	122,500.0	УБХХК ХК	Монгол Улсын Зам тээврийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 01/47 дугаар албан бичгийн дагуу Улаанбаатар хотын эүүн хэсэгт байгуулах ачаа тээврийн логистикийн төвийг Хөшигийн хөндийн логистикийн төвийн төлөвлөлттэй уялдуулахаар заасан. НЗД-ын 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн А/534 дугаар захирамжаар “Хүннү” хотод төлөвлөгдсөн тээвэр логистикийн төвийг ТХХТ-ээр барих, цаашид хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллах тухай санал, зөвлөмж боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Ингэснээр дээрх ажлын хэсэг буюу НЗДТГ уг төслийг хэрэгжүүлж байна.	58	
163			2	Хотын баруун хэсэгт ачаа тээврийн нэгдсэн логистикийн төв байгуулах бэлтгэл ажлыг хангана.	2025-2028	-	-	-	-	-	925.7	925.7	Зураг төсөл боловсруулах ажлын явц, хувь	-	20	185.1	ОУХЛТ ХК	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/33 дугаар "нийслэлийн 2025 оны төсөв"-ийн 110 дахь хэсэгт "Улаанбаатар хотын баруун хэсэгт логистикийн төв байгуулах ажлын зураг төсөв (Улаанбаатар хот)" 960.0 сая төгрөгийн төсөв тусгагдан батлагдсан хэдий ч 2025 оны 25/50 дугаар тогтоолоор батлагдсан нийслэлийн төсвийн тодотголоор уг төсөл арга хэмжээ хасагдсан болно.	50	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО																				
Салбарын үр дүн: Хотын төлөвлөлт, хүн амын өсөлттэй уялдуулан нийгмийн суурь үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.																				
Зорилтын үр дүн: 2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох, иргэдэд эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, зөв дадлыг хэвшүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж болон спортын барилга байгууламжийн хүртээмжийг тус тус нэмэгдүүлнэ.																				
164			1	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын суралцагчдын насны онцлогт тохирсон эрүүл мэндийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	2025-2028	-	200.0	-	-	-	-	200.0	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, тоо	-	200	50.0	НЭМГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн "Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" А/133 дугаар захирамж, НЭМГ-ын даргын 03 дугаар сарын 10-ны өдрийн удирдамжаар "Маскаа зүүцгээе" аян өрнүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллага, өрхийн Эрүүл мэндийн төвүүд цацэрлэгт амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх, орчны эрүүл ахуйг хангах, хувийн ариун цэврийг сахих, олон нийтийн газарт амны хаалт зүүх ба түүний ач холбогдлын талаар нийт 219 удаагийн сургалтыг цэцэрлэгийн орчинд зохион байгуулж нийт 14,339 хүүхдийг хамруулсан. Үг аянтай холбоотой хэвлэл мэдээллийн хэрэгслээр амьсгалын замаар дамжих халдвараас сэргийлэх агуулга бүхий 370 гаруй зөвлөмж бүхий зурагт хуудас, видео боловсруулж, давхардсан тоогоор 1,310,000 гаруй хүнд хүргэсэн.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
165	2.1.1.Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, өсвөр насныхны нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлнэ.	Эрүүл мэндийн боловсролыг үе шаттай олгож, эрүүл дадал хэвшилтэй иргэнийг төлөвшүүлнэ.	2	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдыг насны онцлогт тохирсон эрүүл мэндийн сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна.	2025-2028	-	460.0	-	-	-	-	460.0	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, тоо	860	7000	100.0	НЭМГ	Хүүхдэд бага наснаас нь эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлж, сурагчдын нас хүйсийн онцлогт тохируулан нийт 7006 удаагийн эрүүл мэндийн боловсрол олгох сургалт зохион байгуулж, 154,773 хүүхдийг хамруулж ажиллаа. Үүнд: 1. 2025 оны 4 сард "Өсвөр үеийнхнийг сонсоё, ойлгоё" аяныг өрнүүлж, 9 дүүргийн ЭМТ, 2 нэгдсэн эмнэлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс харьяалах нутаг дэвсгэр дэх цагдаагийн газар, Засаг даргын Тамгын газартай хамтран ерөнхий боловсролын сургуулиуд дээр "Хорт бодис, дэлгэцийн хэрэглээ, вейп ба тамхи, донтолт, эрүүл зохистой хооллолт /таргалалт, шим тэжээлийн хомсдол/, хөдөлгөөний дутагдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн эрүүл ахуй, аюултай бэлгийн харилцаа, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь" сэдвүүдээр нийт 108 ерөнхий боловсролын сургуулийн 10-18 насны 41,193 сурагчдад 972 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгсөн. 2. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж буй 40,753 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас 2025 онд 33,310 хүүхдийг хамруулж, хамтран ажиллаж буй 86 эмнэлгийн эмчлэгч эмч нар урьдчилан сэргийлэх үзлэг болон эмчилгээнд хүүхдээ авчирсан эцэг, эх, асран хамгаалагч нарт шүд үгаах арга техник, шүдээ арчлах, шүдэнд эмтэй хоол хүнс сэдвээр 5,418 удаагийн сургалтыг хийсэн. 3.АШУҮИС-ийн НАСС-ийн хүүхдийн тэнхимтэй хамтарч, тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт амны хөндийн арчилгаа сэдвээр 70 удаагийн ганцаарчилсан сургалтад хүүхдийг эцэг, эхийн хамт хамруулсан. 4."Электрон тамхины хор хөнөөл" сэдэвт сургалтыг 44 ЕБС-ийн ахлах болон дунд ангийн 10,638 сурагчдыг хамруулан зохион байгуулсан. 5."Угаарын хийн хордлогоос сэргийлье" сэдэвт 12 удаагийн сургалтыг нийт 4.283 цэцэрлэгийн багш, сурагчдад зохион байгуулсан. 6. 8 дүүргийн эрүүл мэндийн төв, 1 нэгдсэн эмнэлэг дэх өсвөрийн кабинетуудаас бэлгийн болон нөхөн үржихүйн эрхтний эрүүл мэнд, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах, стресс даван туулах тухай, зөв хооллолт, дасгал хөдөлгөөн, мансууруулах бодис, электрон утаат тамхины хор урших, донтолтоос урьдчилан сэргийлэх чиглэлээр нийт 490 удаагийн сургалт зохион байгуулж, 24600 хүүхдийг хамруулсан.	100	
													Үе тэнгийн зөвлөгч, тоо	305	2500			Эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан сурагчдын дунд 2025 онд 2500 үе тэнгийн зөвлөгч бэлтгэсэн. Тухайлбал: "Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё" сэдэвт сарын аяныг анхан шатны 126, лавлагаа шатлалын 12 эрүүл мэндийн байгууллагаар дамжуулан 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдрийн хооронд зохион байгуулсан. Тус аяны хүрээнд болон дүүргийн эрүүл мэндийн төвүүдээс бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн замын халдвар өвчнөөс сэргийлэх, сэтгэцийн эрүүл мэндээ хамгаалах сэдвээр 2246 үе тэнгийн зөвлөгч бэлтгэсэн. Мөн Нийслэлийн 4 дүүрэгт " Шүд үгаалтын аврага шалгаруулах тэмцээн" -ийг 9-12 насны сурагчдын дунд зохион байгуулж 254 үе тэнгийн сургагч багшийг бэлтгэн 1.077 хүнд "Амны хөндийн эрүүл, зөв дадал" сэдвээр сургалт зохион байгуулсан.	100	
166			3	Эцэг, эх, асран хамгаалагчдад нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн сургалт, нөлөөллийн ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран үе шаттайгаар зохион байгуулна.	2025-2028	-	480.0	-	-	-	-	480.0	Зохион байгуулсан сургалт, арга хэмжээ, тоо	-	200	120.0	НЭМГ	Нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн сургалт, нөлөөллийн ажлыг мэргэжлийн байгууллагуудтай хамтарч эцэг эх, асран хамгаалагч нарт зориулан 204 сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан байна. Үүнд: 2025 онд "Өсвөр үеийнхнийг сонсоё, ойлгоё" аяныг өсвөр насны хүүхдүүдэд, эцэг эх нарт, сургуулийн эмч нийгмийн ажилтан нарт, хэвлэлд мэдээллээр дамжуулан иргэдэд мэдээлэл сурталчилгаа хийх гэсэн 4 чиглэлээр өрнүүлэн зохион байгуулж ажилласан. Эцэг эх нарт зориулсан чиглэлийн хүрээнд харьяа эрүүл мэндийн байгууллагууд "Хорт бодис, дэлгэцийн хэрэглээ, вейп ба тамхи, донтолт, эрүүл зохистой хооллолт /таргалалт, шим тэжээлийн хомсдол/, хөдөлгөөний дутагдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн эрүүл ахуй, аюултай бэлгийн харилцаа, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь, электрон тамхины хор урших" сэдвүүдээр нийслэлийн 108 ерөнхий боловсролын сургуулиуд сургалт, нөлөөлийн үйл ажиллагаа зохион байгуулж 1569 эцэг эхийг хамруулсан. Мөн дүүргийн эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдээс хүүхдийн зөв зохистой хооллолт сэдвээр нийт 96 удаагийн өдөрлөг зохион байгуулж, 5783 эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулан боловсрол олголоо.	100	
167	2.1.2.Нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг үе шаттайгаар байгуулж, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх замаар амьдралын зөв дадал, хэвшлийг бий болгож, урьдчилсан сэргийлэх эрт илрүүлгийн хамрагдалтыг 10 хувиар нэмэгдүүлж, зонхилон тохиолдох халдварт бус өвчлөлийг бууруулна.	Иргэдийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, амьдралын чанарыг сайжруулна.	1	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний шалтгаан, эрсдэлт зан үйлийг бууруулах чиглэлээр нөлөөллийн ажлыг тасралтгүй зохион байгуулна.	2025-2028	-	150.0	-	-	-	-	150.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	8	12	50.0	НЭМГ	Тайлант хугацаанд зонхилон тохиолдох халдварт бус өвчний шалтгаан, эрсдэлт зан үйлийг бууруулах чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: 1. 8 удаагийн нөлөөллийн уулзалт 2. 6 удаагийн арга хэмжээ 3. 4 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан ажилласан байна. Хорт хавдраас урьдчилан сэргийлэх өдөр, Дэлхийн эрүүл мэндийн өдөр, Цусны даралт ихсэлттэй тэмцэх дэлхийн өдөр, Тамхигүй өдөр, Донорын өдөр, Альцхеймэрийн өдөр, Зүрх судасны өвчний өдөр, Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих өдөр, Дэлхийн хараа алдалтаас сэргийлэх өдөр, Чихрийн шижингийн өдөр, Давсны хэрэглээг бууруулах өдөр, Автомашингүй өдөр зэргийг тэмдэглэн постер сурталчилгааны материалыг НЭМГ-ын вэб сайт, олон нийтийн сүлжээнд оруулж иргэдэд сурталчилсан. Дүүргийн эрүүл мэндийн төвүүдээс алслагдсан бүсэд амьдардаг болон хөгжлийн бэрхшээлтэй, эрүүл мэндийн зориптот бүлгийн иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 6 удаагийн 7,518 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан. НЭМГ-ын даргын 2025 оны А/94 дүгээр тушаалаар батлагдсан "Хариуцлагатай сонголт" аяны хүрээнд өсвөр насны хүүхдийн бэлгийн эрүүл мэндийн асуудал, охидын жирэмслэлт, төрөлт, БЗХӨ түүнээс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагаг эрчимжүүлэх зорилгоор дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: 1. Налайх, Сүхбаатар, Баянгол дүүргийн хороодын нийгмийн ажилтан, ерөнхий боловсролын сургууль, их дээд сургуулийн эмч, нийгмийн ажилтнууд болон эх барих, эмэгтэйчүүдийн хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмч, төлөөлөл гэсэд нийт 168 хүнийг 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт хамруулан ажилласан. Хүний папиллома вирусийн халдвар, түүний хор уршиг, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор зориптот бүлгийн өсөвр насны хүүхдүүдийг дархлаажуулах ажлын хүрээнд 8 удаагийн нөлөөллийн уулзалтыг дүүргүүдэд зохион байгуулан 3443 хүнийг хамруулан зохион байгуулсан	100	
168			2	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийг 10 хувиар нэмэгдүүлж, халдварт бус өвчний тохиолдлыг бууруулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Эрт илрүүлэгт хамрагдалтын хувь	40	45		НЭМГ	Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлэг, 4 тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн яамны харьяа эмнэлгүүдээс Улсын гуравдугаар төв эмнэлэг оролцож байна. Нийслэлийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын байдлаар эрт илрүүлэгт 911892 хүн буюу 59.5%-ийг хамруулсан. 2025 онд 37692 иргэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн сайдаас ирүүлсэн албан бичгийн дагуу эрт илрүүлгийг зогсоосон болно.	100	
													Хяналтад авсан өвчтөн, тоо	125441	130000		НЭМГ	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт хамрагдсан иргэдээс эмчилгээ хяналт шаардлагатай 132,457 хүнийг хяналтад авч ажилласан.	100	
													Эрүүгжилтийн хувь	15	18		НЭМГ	Нийслэлийн хэмжээнд хамрагдсан хүн амын дунд хоол боловсруулах замын эмгэг хамгийн түгээмэл тохиолдож, зүрх судасны өвчин, бодисын солилцооны хам шинж зэрэг өвчнүүд удаалж байна. Нийт үзлэгт хамрагдсан иргэдийн 21%-г хяналтад авч эмчилгээнд хамруулж байна.	100	
169			3	Нийгмийн эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар дүүрэг бүрд байгуулна.	2025-2028	12,500.0	-	-	-	-	-	12,500.0	Шинээр байгуулагдс Нийгмийн эрүүл мэндийн төв, тоо	2	2	-	НЭМГ	Багануур, Баянзүрх дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдан ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв буюу эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгыг тус дүүргийн 14 дүгээр хороонд шинээр барьж байна. Барилга угсралтын ажлын гүйцэтгэл 90%-тай байна. 2026 оны I улиралд ашиглалтад орно. Дүүргийн эрүүл мэндийн төвийг нийгмийн эрүүл мэндийн төв, дүүргийн нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөх нийгмийн эрүүл мэндийн төвүүдийг шинээр байгуулахаар төлөвлөгдсөн. Дүүргүүдийн барилга байгууламж, хүний нөөцийн судалгаа болон дүүргүүдэд одоо ашиглаж буй барилга байгуулламжийг ашиглах судалгаат гарган Эрүүл мэндийн яаманд хүргүүлсэн. Эрүүл мэндийн яамнаас "Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах" тушаал, бүтцийн болон ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй хүлээлтийн байдалтай байна.	100	
170			4	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчид,	2025-	23,000.0						23,000.0	Үзлэгт хамрагдсан хүүхдийн түвшин, хувь		78	5,750.0	НЭМГ	Эрүүл мэндийн сайд, Боловсролын сайдын 2024 оны хамтарсан А/413, А/151 дүгээр тушаалын дагуу Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн суралцагчдын нуд, шүд, зүрхний эмгэгийг эрт илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэг хийх арга хэмжээг зохион байгуулж байна. Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж буй 40752 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 36,553 хүүхэд буюу 89.7%-г хамруулсан. Үзлэг дуусан бөгөөд ЭМЯ-ны шийдвэрийн дагуу 2025 оны 9 сараас үзлэг эхлэх байсан ч дэмжигдээгүй тул зогссон.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
170			4	зорилтод бүлгийн 6 настай хүүхдүүдийн эрт илрүүлгийг зохион байгуулж, эрүүлжүүлнэ.	2028	23,000.0	-	-	-	-	-	23,000.0	Эмчилгээнд хамрагдаж, эрүүлжсэн хүүхдийн түвшин, хувь		50	5,750.0	НЭМГ	Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 2025 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн байдлаар 15,724 хүүхдийг бүюу 43.02 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн байна.	89	
171	2.1.3.Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулж, эмчилгээний хамрагдалтыг 98 хувьд хүргэж, товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулна.	Халдварт өвчний илрүүлэг, тандалтыг сайжруулж, эмчилгээний амжилтыг нэмэгдүүлнэ.	1	Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг 98 хувьд хүргэнэ.	2025-2028	200.0	-	-	-	-	-	200.0	Дархлаажуулалтад хамралтын түвшин, хувь	96	96	50.0	НЭМГ	Товлолт дархлаажуулалтын хамралтын мэдээг сар бүр тогтмол гарган ХӨСҮТ-ийн дархлаажуулалтын албанд хүргүүлж байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар Товлолт вакцины 17 тунгийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 394,849 хүүхэд хамрагдахаас 384,794 хүүхэд хамрагдаж хамралтын дундаж 97.5% байна. Үүнд: 1.БЦЖ (1 тун) – 99.5% 2.Гепатит В (1 тун) – 99.3% 3.Саа (4 тун) – 95,0% 4.Тавт (3 тун) – 95.5% 5.УГУ (2 тун) – 97,3% 6.Гепатит А (2 тун) – 95.3% 7.Пневмококк (3 тун) – 95.5% 8.Сахуу-татран (2 тун) – 73,3% байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар Хүний папиллома вирус (1тун) дархлаажуулалтын хамрагдалт - 47.8%-д хүрсэн. Хүний папиллома вирусын эсрэг вакциныг "Дархлаажуулалтын үндэсний товлол"-д шинээр нэвтрүүлсэнтэй холбогдуулан дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг зохион байгуулан ажиллаж байна. Тухайлбал: Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1256 дугаар захирамж, Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын "Хүний папиллома вирусийн эсрэг дархлаажуулалтыг нийслэлд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай" А/168 дугаар тушаал, "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинаар дархлаажуулах тухай" А/179 дүгээр тушаалудыг гарган хэрэгжилтийг хангасан. НЭМГ-ын даргын 2025 оны А/29 дүгээр тушаалаар нийслэлийн ЕБС-иудын дунд "Эрүүл чийрэг өсвөр үе" аян, нийслэлийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын дунд "Зорилтот насны хүүхдийн нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлэх аян"-ыг тус тус зохион байгуулсан. Аяны хүрээнд 6 сургууль, 4 ӨЭМТ шалгарч, 3,084 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч ажилласан байна. Мөн НЭМГ-ын даргын 2025 оны "Хүний папиллома вирусийн халдварын эсрэг дархлаажуулалтыг эрчимжүүлэх тухай" А/321 дүгээр тушаалын дагуу НҮБ-ийн Хүүхдийн сантай хамтран Нийслэлийн төрийн, хувийн өмчийн сургуулиудын 325 эмч, мэргэжилтэнг сургалтад хамруулан чадавхжуулсан.	100	
172			2	Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулж, өвчлөлийг бууруулна.	2025-2028	500.0	-	-	-	-	-	500.0	Эмчилгээний амжилтын түвшин, хувь	76	78.9	100.0	НЭМГ	Нийслэлийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар шинээр илэрсэн сүрьеэгийн 1022 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 6.2 байна. Өмнөх оны мөн үеэтэй харьцуулахад 56 тохиолдлоор бүюу 0.5 промилиор буурсан байна. Нийт тохиолдлын 8.5%-ийг 0-14 насны хүүхэд эзэлж байна. Нийслэлийн харьяа дүүргийн сүрьеэгийн диспансер, кабинет болон идэвхитэй илрүүлгээр нийт 79,946 үзлэг хийснээс 47,968 буюу 60.2% нь урьдчилан сэргийлэх чиглэлээр хийсэн. Үүнээс зорилтот бүлгийн 4800 гаруй хүнээс сүрьеэ өвчний илрүүлэлтийн хувь 21,3% байна. Сүрьеэ, өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулах зорилгоор: - Эрсдэлт бүлгийн идэвхитэй илрүүлэлтийг зохион байгуулж, 2025 оны 03 дугаар сард Багануур дүүрэгт 150 иргэнийг хамруулснаас 1 хүүчин өвчилж байсан ба сүрьеэгийн сэжигтэй 7 хүнээс цэрний шинжилгээ авсан, - 2025 оны 5 дугаар сард СХНЭ, СХД-ийн 26-р хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нартай хамтран зохион байгуулж Улаанчлуутын хогийн цэгт ажиллаж, хог түүдэг 43 иргэнийг хамруулснаас 10 хүн хүүчин сүрьеэгээр өвчилж байсан ба сүрьеэгийн сэжигтэй 3 хүнээс цэрний шинжилгээ авсан. - 2025 оны 3 сарын 27-ны өдөр НЗДТГ-ын 112 албан хаагчийг эрт илрүүлэгт хамруулснаас 2 нь хүүчин өвдөөд эдгэрсэн байсан ба сүрьеэгийн сэжигтэй 5 хүнээс цэрний шинжилгээ тус тус авсан бөгөөд шинэ сүрьеэгийн тохиолдол илрээгүй. НЭМГ-ын даргын баталсан "Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр"-ийг тэмдэглэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу эмч, эрүүл мэндийн ажилтан болон иргэд, төрийн бус байгууллагуудад чиглэсэн 13 төрлийн үйл ажиллагаат зохион байгуулсан. Нийт тохиолдлын 99%-ийг эмчилгээнд хамруулж, эмчилгээний амжилт 79.9% байна.	100	
	2.1.4.Эх, хүүхэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлэх болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна.	Ургийн гажгийг эрт үед нь илрүүлж, тав хүртлэх насны хүүхдийн эндэгдлийн 1000 амьд төрөлтөд 2 промилээр бууруулна.	1	Ургийн гажгийг илрүүлэх хэт авиан тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллага, тоо	2026-2028	1,000.0	1,000.0	-	-	-	-	2,000.0	Ургийн гажгийг илрүүлэх тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллага, тоо	8	2	500.0	НЭМГ	Баянгол, Сонгинохайрхан, Багануур, Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв, Сонгинохайрхан, Сүхбаатар нэгдсэн эмнэлэг, Хүрээ амаржих газар бүюу нийт 8 эрүүл мэндийн байгууллага ургийн гажгийг илрүүлэх 4D хэт авианы тоног төхөөрөмжөөр хангагдсан. 2025 оны 10 сарын байдлаар 4189 жирэмсэн эмэгтэйд ургийн бүтцийн гажгийн илрүүлэг, оношилгоо хийж 12 ургийн гажиг илрүүлсэн. Ургийн хромосомын гажиг илрүүлэх жирэмсний эхний 3 сарын нийлмэл илрүүлэг шинжилгээг хийх бэлтгэл ажлыг хангах чиглэлийг харьяа эрүүл мэндийн байгуулагад 2025 оны 05 сарын 06-ны өдрийн 01/1085 дугаар бичгээр хүргүүлэн арга зүйгээр ханган ажиллаж байна. Жирэмсний эхний 3 сарын хэт авиан шинжилгээ хийх чадамжтай (Fetal Medicine Foundation-ий албан ёсны сертификаттай, программын эрх эзэмшсэн) эмч нийслэлийн 3 амаржих газарт 9, дүүргийн эрүүл мэндийн төвд 7 эмч бэлтгэгдсэн. Хоёрол тестийн шинжилгээг Нийслэлийн Өргөө амаржих газар хийж эхэлсэн.	100	
174			2	Нярайн скрининг шинжилгээг үе шаттай нэмэгдүүлнэ.	2025-2028	700.0	700.0	-	-	-	-	1,400.0	Скрининг шинжилгээнд хамрагдсан нярайн түвшин, хувь	25	30	350.0	НЭМГ	Нийслэлийн хэмжээнд нярайн тусламж, үйлчилгээ үзүүлдэг Өргөө , Хүрээ, Амгалан амаржих газар, Багануур, Налайх дүүргийн эрүүл мэндийн төв нь 2025 оны эхний 10 сарын байдлаар нийт 12513 амьд нярай төрж нярайн скринингд хамруулахаас түнхний хэт авиан шинжилгээ 12346 бүюу 98.6%, нудний үгийн улаан рефлекс илрүүлэгт 9631 бүюу 77%, сонсголын скрининг 5067 бүюу 40.5%, пульсоксиметрийн скрининг 7710 бүюу 61.6%, зулайн хэт авиан шинжилгээнд дутуу нярайг 100%, гуйцэт нярайг 6315 бүюу 50.5% тус тус хамруулж, нярайн скрининг хамралтын дундаж түвшин 65.6% тай байна. Тухайлбал: -Налайх дүүргийн эрүүл мэндийн төв 214 нярай төрснөөс түнхний хэт авиан шинжилгээ, нудний үгийн улаан рефлексийн илрүүлэгт 213 нярайг 99.5%, -Багануур дүүргийн эрүүл мэндийн төв 381 нярай төрснөөс сонсгол, нудний үгийн улаан рефлексийн илрүүлэг, түнхний хэт авиан шинжилгээнд 373 нярайг 98%, -Нийслэлийн Хүрээ амаржих газар 2786 нярай төрснөөс нудний үгийн улаан рефлексийн илрүүлэг-2779 / 99.7%/, зүрхний хэт авиан шинжилгээ-2779 / 99.7%/, түнхний хэт авиан шинжилгээнд 2779 / 99.7%/, зулайн хэт авиа шинжилгээ-123 / 4.4%/, Нийслэлийн Амгалан амаржих газар 4662 нярай төрснөөс нудний үгийн улаан рефлексийн илрүүлэг – 4093 / 87.8%/, пульсоксиметр - 3240/70%/, түнхний хэт авиан шинжилгээ – 4511 / 96.7%/ , сонсгол – 3901/83.6%/, зулайн хэт авиан шинжилгээ – 401/8.6%/, Нийслэлийн Өргөө амаржих газар 4470 нярай төрснөөс нудний үгийн улаан рефлексийн илрүүлэг- 2173 /48.6%/, пульсоксиметрээр хүчилтөрөгчийн ханалт тодорхойлох -4470/100%/, түнхний хэт авиан шинжилгээ-4470/100%/, зулайн хэт авиан шинжилгээнийг 3135/ 70.1%/, сонсголын скрининг -793 /18%/нярайг тус тус хамруулсан байна.	100	
175			3	Тав хүртлэх насны хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах чиглэлээр тусламж, үйлчилгээ чанаржуулна.	2025-2028		100.0	-	-	-	-	100.0	1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	15.7	14.9	20.0	НЭМГ	Нийслэлийн хэмжээнд 2025 оны 10 сарын байдлаар нийт 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 422 бүртгэгдэж 17.1 байна. Үүнээс 269 бүюу 63,7% нь Улаанбаатар хотын хаягтай хүүхдийн эндэгдэл байна. Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 85 хувийг нялхасын эндэгдэл эзэлж байна. Нэг хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн нийт 359 тохиолдлын 43.7 хувь нь 0-6 хоногтойдоо, 18.1 хувь нь 7-28 хоногтойдоо, 38.2 хувь нь 29 хоногоос 1 хүртэлх настайдаа эндсэн байна. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзэхэд 83.9% нь перинаталь үеийн эмгэг, 27.8% нь төрөлхийн гажиг хөгжил, 10.2% нь амьсгалын тогтолцооны өвчний улмаас эндсэн байна. Тиймээс эндэгдлийг бууруулах зорилгоор нийслэлийн 3 амаржих газарт "Эхийн сүүний банк" байгуулж, "Нярайн тархи хөрөөс эмчлгээ", "Дутуу төрсөн нярайн амьсгалыг үргэлжилсэн өндөр давтамжит аппараатаар удирдах эмчлгээ" тус тус шинээр нэвтрүүлсэн. Хүүхэд, нярайн эндэгдлийн хохимдол, шалтгааны талаарх хэлэлцүүлгийг 2025 онд хэд хэдэн удаа зохион байгуулсан. 2025 оны 11 сарын байдлаар 8 дүүргийн эрүүл мэндийн төв, 5 нэгдсэн эмнэлэг, 3 сэргээн засах төвүүдээр дамжуулан 176,523 хүүхдэд давхардсан 568,236 удаагийн өсөлт хөгжлийн хяналт хийж, туранхай 736, тураалтай 578, өсөлтийн хоцрогдолтой 742, цус багадалттай 1,456, сульдаатай 896 хүүхдийг илрүүлж, 100% хяналт, эмчилгээнд хамруулан ажиллаж байна.	0	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
176		Эхийн сэргийлж болох эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг бууруулна.	4	Зорилтод бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн хамрагдалтын хувийг нэмэгдүүлнэ.	2025-2028		160.0	-	-	-	-	160.0	Жирэмсэнээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан эмэгтэйчүүдийн түвшин, хувь	62	65	40.0	НЭМГ	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан эмэгтэйчүүд 41,987 буюу 64.7%-тай байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/11 дугаэр тушаалын дагуу Нийслэлийн харьяа 9 дүүргийн эрүүл мэндийн төвд дүүргийн хэмжээнд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгаг сайжруулах чиглэл өгч шинэчлэн, нийт нөхөн үржихүйн насны 422,442 эмэгтэйчүүд байгаагаас 62,268 зорилтот бүлгийн эмэгтэйчүүд байна. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар жирэмснээс сэргийлэх арга хэрэгсэлээр 41,987 зорилтот бүлгийн эмэгтэй буюу 67,4% хамрагдсан байна.	100	
177			5	Өндөр эрсдэлтэй зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлт, үр хөндөлт, жирэмслэлтээс сэргийлэх нөлөөллийн ажлын тогтмол зохион байгуулна.	2025-2028	100.0	60.0	-	-	-	-	160.0	Зохион байгуулсан арга хэмжээ,тоо	1	2	40.0	НЭМГ	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхийн ач холбогдол, гэр бүл төлөвлөлтийн аргуудыг таниулах, хүсэхгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай" А/770 дугаар захирамжийг боловсруулан батлуулж ажиллалаа. 1.Захирамжийг дагуу жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгслийг таниулах хөтөч дэтгийг боловсруулан 28000 ширхэгийг гарган 9 дүүргийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхийн ач холбогдол, хүсэхгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх тухай мэдээлэл, сургалтыг үйл ажиллагаанд ашиглаж байна. 2.Оюутны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, хүсэхгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор сурталт зохион байгуулахад хамтран ажиллах тухай албан бичгийг Боловсролын Ерөнхий газарт хүргүүлсэн. 11 сарын байдлаар МУБИС, МУИС, ДХИС, ХААИС, ШУТИС, ҮТИС, Оточ манрамба, МУИС, ИЗИС, ТЗИС, ҮБХИС, ҮБЭДС, БТДС, ТТДС, зөрэг 14 их, дээд сургуулийн 14,080 оюутанд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн Налайх, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Тамгын газруудтай хамтарч, 12 удаагийн сургалтад хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан гэзэ нийт 1,369 албан хаагчдыг хамруулсан.	100	
178	2.1.5.Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах боломжийг бүрдүүлж, тусламж үйлчилгээний хүртээмж, нэр төрлийг нэмэгдүүлнэ.	Иргэдэд анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг ойртуулна.	1	Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг авах нөхцөлийг бүрдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	Бодлогын баримт бичгт санал өгч, төлөвлөлт хийх ажлын хэрэгжилт, хувь	-	100		НЭМГ	Баримт бичиг боловсруулах ажлын явц 80-тай байна.Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу "20 минутын хот" концепцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий НЭМГ-ын Ажлын хэсгийн гишүүдийг 2024 оны А/142 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд Нийслэлийн харьяа 28 байгуллагыг 14 хотын газрын зураг дээр байрлуулж, холбогдох саналыг НЗДТГ-т хүргүүлсэн. Тус онд "20 минутын хот" концепцийн Ажлын хэсгийн гишүүд ЭМЯ-ны Ажлын хэсэгтэй хамтарсан нийт 4 удаагийн уулзалт хурлыг зохион байгуулсан. Нийслэлийн эрүүл мэндийн салбарыг бүсчилсэн хөгжлөөр хөгжүүлэх зураглал, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах шатандаа явж байна."20 минутын хот" концепцийг хэрэгжүүлэх асуудлаар 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын Г.Лувсанжамц гишүүнтэй уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Уулзалт хэлэлцүүлгээр Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах бүтэц, зохион байгуулалтын талаар НЭМГ-ын ажлчид, харьяа 28 эрүүл мэндийн байгуллагын удирдлагатай өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөвлөгөөний талаар хэлэлцсэн. Улсын Их хурлаас "20 минутын хот" хороллын хилийн цэсийн заг тодорхой болоогүй, нэг жилээр хойшлуулсан тул хүлээгдлийн байдалтай байна.	83	
													Тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллага, тоо	149	151		НЭМГ	2025 оны эхний 10 сарын байдлаар тус газрын харьяа 151 өрхийн эрүүл мэндийн төв, 29 салбар, 4 тосгоны эрүүл мэндийн төв иргэдэд анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Нийслэлийн 151 өрхийн эрүүл мэндийн төвийг 14 хотын газрын зураг дээр байршуулсан. Мөн нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд, эмийн сангуудыг орон зайн байршлын газрын зурагт байршуулах ажлыг зохион байгуулж байна.	100	
179			2	Нийслэлийн өмчит эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлт хийж үйл ажиллагааны менежментийг сайжруулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Менежмент нэвтрүүлэх ажлын явц, хувь		30		НЭМГ	Нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгуллага, 151 өрхийн эрүүл мэндийн төвийг 14 хотын газрын зураг дээр байрлуулж, холбогдох саналыг 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр НЗДТГ-т хүргүүлсэн."20 минутын хот" концепцийн хүрээнд нийслэлийг 14 хот, 42 хороолол болгох хил хязгаар эцэслэгүй байна. 42 хорооллын хил хязгаар эцэслэсний дараагаар тухайн газар нутгийн хүн амын тоо, эрүүл мэндийн байгуллагын хүчин чадлаас хамааран анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудыг нэгтгэх бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх тул уг ажлын бэлэн байдлыг ханган ажиллаж байна.	ХБ	
180	2.1.6.Эрүүл мэндийн байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтний нийгмийн баталгаат хангах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Эмч, эмнэлгийн мэргэжилтний тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл бүрдэнэ.	1	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр тооцон үнэлж, урамшуулал олгох ажилд дэмжлэг үзүүлнэ.	2025-2028	-	1,600.0	-	-	-	-	1,600.0	Эрүүл мэндийн байгууллага, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, тоо	15, 186	15, 187	400.0	НЭМГ	Нийслэлийн харьяа шилдэг эрүүл мэндийн байгууллага, шилдэг эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, ажилтанг ажлын гүйцэтгэл үр дүнгээр тооцон үнэлж, урамшуулал олгохоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Мөнгөн урамшуулал олгох" А/1600 дугаар захирамжийг гарган 399,715,000 төгрөгийг батлуулсан. Тус захирамжийн хүрээнд шалгуур үзүүлэлтийн даагуу нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллагаас 2-р шатны сонгон шалгаруулалтаас шалгарсан 186 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын ажилтан, 15 эрүүл мэндийн байгууллагыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн урамшуулпыг олгосон.	100	
181			1	Нийслэлийн хүн амын бие бялдар, хөгжил чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг зохион байгуулна.	2025-2028	-	131.0	-	-	-	-	131.0	А, В, С үнэлгээтэй иргэдийн эзлэх түвшин, хувь	68	69	26.0	НБТСГ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигийн дагуу бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорилыг Нийслэл, дүүргийн хэмжээнд зохион байгуулж 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 606 байгууллагын 85,122 иргэн хамрагдсан байна. Сорилд хамрагдсан иргэдийн 26% нь А, 28% нь В, 23% нь С, 15% нь D, 8% нь F үнэлгээ авсан ба нийт 77% нь А, В, С үнэлгээтэй байна.	100	
182			2	Ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалтыг зохион байгуулна.	2025-2028	29.5	-	-	-	-	-	29.5	Оролцогчид, тоо	100	130	6.5	НБТСГ	Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрыг чийрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх багш, арга зүйчдийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор сургалт семинарыг 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс 02 дугаар сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулсан. Сургалтад оролцсон багш нарт Монголын спорт сонирхогч хөгжөөн дэмжигчдийн холбооноос ЕБС-ийн ахлах насны сурагчдын хөгжөөн дэмжигчдийн заавал хийх дасгалыг 2025 онд шинэчлэн зааж хүүхдийн бие бялдрын хүмүүжлийн ажлыг зохион байгуулах заавар зөвлөгөө өгч Нийслэлийн 9 дүүргийн 80 сургуулийн 300 багш нарыг хамруулсан.	100	
183			3	Өсөөрийн шигшээ багийн багш, дасгалжуулагчдын сургалтыг зохион байгуулна.	2025-2028	5.0	-	-	-	-	-	5.0	Оролцогчид, тоо		80	1.0	НБТСГ	Нийслэл, дүүргийн хэмжээнд спортын төрлүүдийг хөгжүүлж, багш, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, хамтын ажиллагааг өргөжүүлэх, өсөөрийн шигшээ багийн дасгалжуулагчдад зориулсан сургалтыг 8 удаа зохион байгуулж 109 багш, дасгалжуулагчид оролцсон.	100	
184			4	"Алхацгаая гүйцгээе" хөдөлгөөнийг өрнүүлнэ.	2025-2028	-	104.0	-	-	-	-	104.0	Оролцогчид, тоо	231,890	243,485.0	19.0	НБТСГ	Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас хөнгөн атлетикийн суурьтай дасгал хөдөлгөөнөөр иргэдэд биеийн тамир, спортын үйлчилгээг хүргэх зорилгоор "Алхацгаая гүйцгээе" хөдөлгөөнийг нийслэлийн хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 15--наас 10 дугаар сарын 15-ныг хүртэлх хугацаанд өрнүүлж, сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Бямба гаригт иргэд нийтийн алхалт, биеийн тамирын дасгал хөдөлгөөнөөр хичээллүүлэх ажлыг зохион байгуулсан. Удирдамжийн хүрээнд Нийслэлийн 9 дүүргүүд ажлын байрны дасгал, шугаман бүжиг, аэробик, хийн дасгал, алхалт, гүйлтийн арга хэмжээг иргэдийн дунд 71 арга хэмжээг зохион байгуулж, жилийн эцсээр нийт 420 байгууллагын 410,000 иргэнийг хамруулсан.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
185	2.1.7.Нийслэлийн иргэдийг биеийн тамир, спортын дасгал хөдөлгөөнөөр тогтмол хичээллэх боломжийг бүрдүүлж, бие бялдрын хөгжил, чийрэгжүүлэлтийн түвшин тогтоох сорилд хамрагдсан иргэдийн бие бялдрын түвшний суурь үзүүлэлтийг 5 хувиар өсгөнө.	Нийслэлийн иргэдийн бие бялдрын түвшний суурь үзүүлэлтийг 5 хувиар өсгөнө.	5	Цэцэрлэгийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	6.0	318.6	-	-	-	-	324.6	Оролцогчид, тоо	2,439	2,500.0	80.3	НБТСГ	Сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор Монголын Гимнастикийн холбоотой хамтран Цэцэрлэгийн хүүхдийн уран хөдөлгөөнт гимнастикийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 01-23-ны өдрүүдэд 2 үе шаттай зохион байгуулсан. Тэмцээнд Нийслэлийн 9 дүүргийн 80 цэцэрлэгийн 2580 хүүхэд оролцсон.	100	
186			6	Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын Спортын хөгжөөн дэмжигчдийн тэмцээн зохион байгуулна.	2025-2028	14.3	343.5	-	-	-	-	357.8	Оролцогчид, тоо	2,938	3,000.0	80.0	НБТСГ	Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын бие бялдрыг гимнастикийн дасгал хөдөлгөөнөөр хөгжүүлэх, тэднийг биеийн тамир, спортын үйл ажиллагаанд татан оролцуулах зорилгоор Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын "Хөгжөөн дэмжигчдийн" тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 01-20-ны өдрүүдэд Монголын спорт сонирхогчдын хөгжөөн дэмжигчдийн холбоотой хамтран 2 үе шаттай зохион байгуулсан. Тэмцээнд нийт Нийслэлийн 9 дүүргийн 48 сургуулийн 3850 сурагчид оролцсон.	100	
187			7	Бүжгийн фестиваль зохион байгуулна.	2025-2028	-	493.3	-	-	-	-	493.3	Оролцогчид, тоо		2,500.0	118.3	НБТСГ	Хип хоп, клоп бүжгийн наадмыг 2025 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байсан боловч ерөнхий боловсролын сургуулийн багш нарын ажил хаялтын улмаас хойшлогдож 2026 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр "Буянт-Ухаа" спортын ордонд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	83	
188			8	Нийтийн гимнастикийн фестиваль зохион байгуулна.	2025-2028	-	505.1	-	-	-	-	505.1	Оролцогчид, тоо		4,200.0	123.1	НБТСГ	Нийтийн гимнастикийн фестиваль тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдөр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байсан боловч ерөнхий боловсролын сургуулийн багш нарын ажил хаялтын улмаас хойшлогдож 2026 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр "Буянт-Ухаа" спортын ордонд зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.	83	
189			9	Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	128.0	-	-	-	-	128.0	Оролцогчид, тоо	480	500.0	30.0	НБТСГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/723 дугаар захирамжийн хүрээнд Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөрт зориулсан биеийн тамир, спортын арга хэмжээнд спортын 3 төрлийн (тэнцвэрт дугуй, "Аав ээж би" хөгжөөнт тэмцээн, хип поп бүжиг) уралдаан тэмцээнийг тухайн спорт холбоодтой нь хамтран зохион байгуулж 890 иргэдийг оролцуулсан.	100	
190			10	"Улаанбаатар марафон" олон улсын гүйлтийн тэмцээн зохион байгуулна.	2025-2028	-	3,223.5	-	-	-	-	3,223.5	Оролцогчид, тоо	30,000	30,000	773.5	НБТСГ	НБТСГ: "Улаанбаатар марафон 2025" олон улсын гүйлтийг 10 дах жилдээ 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Нийслэлийн Засаг даргын А/402 дугаар захирамжаар гүйлт зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогчоор ахлуулсан 44 байгууллагын 44 хүний бүрэлдэхүүнтэй 4 дэд ажлын хэсэгт хуваагдаж бэлтгэл ажлыг бүрэн хангаж ажилласан. "Улаанбаатар Марафон-2025" олон улсын гүйлтийг 42 км 18-аас дээш нас, ХБИ, 21 км-ийн зайг 18-34, 35-54, 55-аас дээш нас, ХБИ, 5 км-ийн зайг 12-17 нас, 18-аас дээш насны эрүүл мэндийн гүйлт, 1,5 км /хараанаы бэрхшээлтэй, тэргэнцэртэй ХБИ, гэр бүл, 500м, 800м тусгай олимпын тамирчид/ гэсэн ангиллаар зохион байгуулж, нийт 27,789 иргэд цахимаар 2211 иргэн ивээн тэтгэгч байгууллагуудыг төлөөлөн бүртгүүлж, нийт 30,000 иргэдийг хамруулсан.	100	
191			11	"Хангарди" иргэдийн спортын наадам зохион байгуулна.	2025-2028	-	820.6	-	-	-	-	820.6	Оролцогчид, тоо	1,500	1,500.0	202.6	НБТСГ	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Бүсчилсэн хөгжлийн Иргэдийн спортын их наадмыг 7 төрлөөр 186 хороодын 6526 иргэдийг хамруулж зохион байгуулсан. Нийслэлийн шатны тэмцээнийг хуваарийн дагуу бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байсан боловч улсын санхүүжилт шийдэгдээгүй тул цуцлагдсан.	80	
192			12	"Улаанбаатар цом" усанд сэлэлтийн арга хэмжээг зохион байгуулна.	2025	-	224.5	-	-	-	-	224.5	Оролцогчид, тоо	-	650.0	54.5	НБТСГ	"Улаанбаатар цом" усанд сэлэлтийн арга хэмжээг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа бүрэн хангасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилтийг нийслэлээс олгоогүй тул цуцлагдсан.	80	
193			13	Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастик тэмцээн зохион байгуулна.	2025-2028	69.2	-	-	-	-	-	69.2	Оролцогчид, тоо	1,850	1,900.0	14.2	НБТСГ	Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын уран хөдөлгөөнт гимнастик тэмцээн зохион байгуулахаар бэлтгэл ажлаа бүрэн хангасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилтийг нийслэлээс олгоогүй тул цуцлагдсан.	80	
194			14	Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдийн спортын анхдугаар наадам зохион байгуулна.	2025-2028	-	695.0	-	-	-	-	695.0	Оролцогчид, тоо	-	500.0	170.0	НБТСГ	Хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт иргэдийн спортын анхдугаар наадам зохион байгуулахаар бэлтгэл ажлаа бүрэн хангасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу санхүүжилтийг нийслэлээс олгоогүй тул цуцлагдсан.	80	
195			15	Өсөрийн хүүхэд залуучуудын дунд багийн спортын тэмцээн, үйл ажиллагааг сурталчлан таниулах спорт хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2025	-	-	-	-	-	-	-	Оролцогчид, тоо	-	1500		НБТСГ	Багийн спортын төрлөөр дамжуулан өсөөр үеийн хүүхэд, багачуудын бие бялдрыг чийрэгжүүлэх, хамтач үзэл санааг төлөвшүүлэх зорилгоор 2025 онд "Улаанбаатар лиг" сагсан бөмбөг, волейболын тэмцээнүүдийг тус бүр 4 үе шаттайгаар 2-3 насны ангиллаар зохион байгуулж, 8728 багийн 157,746 хүүхэд, залуучуудыг оролцууллаа.	100	
196			16	3*3 спорт өдөрлөг (оюутан, сурагч,сонирхогч)-ийг зохион байгуулна.	2025	-	-	-	-	-	-	-	Оролцогчид, тоо	-	2000		НБТСГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн биеийн тамир, спортын газар, Монголын 3х3 сагсан бөмбөгийн холбоо хамтран "Улаанбаатар 2040" 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг 2025 оны 05 дугаар сарын 03-04-ний өдрүүдэд Үндэсний соёл амралтын хүрээлэнгийн 3х3 сагсан бөмбөгийн талбайд зохион байгуулсан. Нийт 32 багийн 128 тамирчид өрсөлдсөн.	100	
197			17	"Дугуйтай Улаанбаатар" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	654.4					654.4	Оролцогчид, тоо	-	1500	144.4	НЗДТГ, НБТСГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Дугуйтай Улаанбаатар-2025" арга хэмжээг зохион байгуулах тухай А/564 дүгээр захирамжийн дагуу Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин ахлуулсан 25 албан хаагчдын бүрэлдэхүүнтэй Ажлын хэсэг байгуулагдан, 82 үйл ажиллагаа бүхий бэлтгэл ажлын төлөвлөгөөг 2025 оны 04 дүгээр сарын 14-нд батлан, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Монголын дугуйн холбоо хамтран "Дугуйтай Улаанбаатар-2025" арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд 5км-ийн дугуйн парад, 13 насны ангиллаар тойрог замын болон тэнцвэр дугуйн уралдааныг зохион байгуулж, 2000 иргэдийг хамруулсан.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
198			18	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний төсөлд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдан хэрэгжүүлэх ажлын танилцуулгыг зохион байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Оролцогчид, тоо	-	1000		НЗДТГ, НБТСГ	Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн төлөвлөгөөний төсөлд биеийн тамир, спортын чиглэлээр тусгагдан хэрэгжүүлэх ажлын танилцуулгыг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа бүрэн хангасан боловч Еренхий сайдын тушаалаар цуцлагдсан.	82	
199			19	Нийслэлийн тэргүүний биеийн тамир, спортын байгууллага, спортын холбоод, Биеийн тамир, спортын хамтлаг, мэргэжилтэн, багш, дасгалжуулагч, тамирчин, арга зүйчдийг шалгаруулах арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	100.5	-	-	-	-	-	100.5	Шагнал авсан хүн, тоо	15	15	15.5	НБТСГ	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн хамт олны хурлаар Нийслэлийн оны шилдэгүүдэд нэр дэвшүүлсэн материалуудыг хэлэлцэн "Оны шилдэг"-үүдийг тодруулсан. 2025 оны үйл ажиллагаагаараа Хоёрдугаар байранд Ц.Сосорбарам даргатай Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хороо, Нэгдүгээр байранд Г.Батбаяр даргатай Баянгол дүүргийн Биеийн тамир, спортын хороо болон Р.Очирпүрэв даргатай Чингэлтэй дүүргийн Биеийн тамир, спортын хороо; "Оны шилдэг дасгалжуулагч"-аар Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны дасгалжуулагч Б.Хаштогтох, "Оны шилдэг тамирчин"-аар Чингэлтэй дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсөөрийн жудо бөхийн шигшээ багийн тамирчин, 117 дугаар сургуулийн сурагч А.Мишээл, "Оны шилдэг арга зүйч"-ээр Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны арга зүйч Б.Бямбахишиг, "Оны шилдэг биеийн тамирын багш"-аар Хан-Уул дүүргийн "Орчлон" сургуулийн биеийн тамирын багш А.Урангоо нарыг шалгаруулж өргөмжлөл, цом гардуулж өгсөн.	100	
200			1	Улаанбаатар хотын аварга шалгаруулах ширээний теннисний тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	55.5	-	-	-	-	-	55.5	Оролцсон тамирчид, тоо	450	500	5.7	НБТСГ	Монголын Ширээний теннисний холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах Ширээний теннисний тэмцээнийг өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн төрлөөр 2025 оны 03 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд Ширээний теннисний Оч клубт зохион байгуулж, 30 байгууллагын 500 тамирчид оролцуулсан.	100	
201			2	Улаанбаатар хотын аварга шалгаруулах бадминтоны тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	36.2	-	-	-	-	-	36.2	Оролцсон тамирчид, тоо	1,750	1,800	3.8	НБТСГ	Улаанбаатар хотын аварга шалгаруулах Бадминтоны тэмцээнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа бүрэн хангасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу улсаас санхүүжилтийг буцааж татсан тул цуцлагдсан.	83	
202			3	Улаанбаатар хотын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	98.1	-	-	-	-	-	98.1	Оролцсон тамирчид, тоо	1,400	1,500	7.3	НБТСГ	Монголын Жудо бөхийн холбоотой хамтран Улаанбаатар хотын аварга шалгаруулах өсвөр үеийн Жудо бөхийн тэмцээнийг 2025 оны 04 дүгээр сарын 07-09-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Биеийн тамир, спортын хорооны спорт цогцолборт зохион байгуулж, 30 байгууллагын 1560 тамирчид оролцсон.	100	
203			4	Уран сайхны гимнастик Бадминтон Улаанбаатар хотын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	67.2	-	-	-	-	-	67.2	Оролцсон тамирчид, тоо	315	350	5.7	НБТСГ	Улаанбаатар хотын аварга шалгаруулах Уран сайханы гимнастикийн тэмцээнийг 2025 оны 10 дугаар сарын 17-19-ний өдрүүдэд Монголын гимнастикийн холбоотой хамтран СХД-ийн Биеийн тамир, спортын хорооны зааланд зохион байгуулсан. Тэмцээнд 15 байгууллагын 365 тамирчин оролцсон.	100	
204			5	Улаанбаатар хотын аварга шалгаруулах Спортын гимнастикийн тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	61.0	-	-	-	-	-	61.0	Оролцсон тамирчид, тоо	155	170	6.3	НБТСГ	Улаанбаатар хотын аварга шалгаруулах өсвөр үеийн Спортын гимнастикийн тэмцээнийг Монголын Гимнастикийн холбоотой хамтран 2025 оны 04 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Монголын гимнастикийн холбооны спорт цогцолборт зохион байгуулж, 10 байгууллагын 170 тамирчид оролцсон.	100	
205			6	Улаанбаатар хотын аварга шалгаруулах Софт теннисийн тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	35.2	-	-	-	-	-	35.2	Оролцсон тамирчид, тоо	200	250	4	НБТСГ	Улаанбаатар хотын аварга шалгаруулах Софт теннисийн тэмцээнийг зохион байгуулахаар бэлтгэл ажлаа бүрэн хангасан боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дагуу улсаас санхүүжилтийг буцааж татсан тул цуцлагдсан.	84	
206	2.1.8.Үндэсний болон орчин үеийн спортын төрлүүдийг хөгжүүлж, нийслэлийн иргэдийн дунд зохион байгуулах уралдаан, тэмцээн наадмын төрлийг нэмж, өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халаа	Үндэсний болон орчин үеийн спортын тэмцээн уралдаанд оролцогчдын тоог 5 хувиар өсгөнө.	7	Улаанбаатар хотын аварга шалгаруулах Дугуйн тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	34.8	-	-	-	-	-	34.8	Оролцсон тамирчид, тоо	120	130	4.2	НБТСГ	Улаанбаатар хотын аварга шалгаруулах засмал замын дугуйн уралдааныг 2025 оны 06 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд Төв аймгийн Алтанбулаг суманд зохион байгуулсан. Тус тэмцээн нь ганцаарчилсан, бөөн гараа гэсэн ангиллаар нийт эмэгтэй, эрэгтэй 135 тамирчдыг оролцсон.	100	
207			8	Улаанбаатар хотын аварга шалгаруулах Шатарын тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	30.8	-	-	-	-	-	30.8	Оролцсон тамирчид, тоо	1,650	1,700	3.2	НБТСГ	Монгол Улсын Үндэсэн хуулийн өдрийг тохиолдуулан Улсын Их Хурлын даргын ивээл дор Шатар сонирхогчдын 14 дах удаагийн дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 12 дугаар сарын 05-18-ны хооронд нийслэлийн 9-н дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Биеийн тамир, спортын хороод хамтран зохион байгуулж, 123 байгууллагын 1258 иргэн өрсөлдөж, эхний 4-н байрт шалгарсан иргэд нийслэл болон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан. Улаанбаатар хотын аварга шалгаруулах Шатрын тэмцээнийг 2025 оны 12 дугаар сарын 09-10-ны өдрүүдэд "Зууны шатар" клубын байранд зохион байгуулж, 10 байгууллагын 60 тамирчин оролцсон.	100	
208			9	Улаанбаатар хотын аварга шалгаруулах 100 буудалт даамын тэмцээнийг зохион байгуулна.	2025-2028	27.2	-	-	-	-	-	27.2	Оролцсон тамирчид, тоо	200	250	2.5	НБТСГ	"Цаглашгүй Монгол ухаан" ТББ хамтран Улаанбаатар хотын 2025 оны аварга шалгаруулах өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн зуун буудалт даамны тэмцээнийг 2025 оны 02 дугаар сарын 15-16-ны өдрүүдэд Чингэлтэй дүүргийн 57 дугаар сургуулийн спорт зааланд зохион байгуулж, 9 байгууллагын 250 тамирчид оролцсон.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
255			1	Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зориллоор "Сайн багш таны дэргэд" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2025-2028	600.0	-	-	-	-	-	600.0	Арга хэмжээний хэрэгжилтийн явц, хувь	-	30		НБГ	НБГ: Нийслэлийн боловсролын салбарын багш, удирдах ажилтны мэргэжлийн чадамж (мэдлэг, чадвар, хандлага)-ийг тасралттүй дээшлүүлж, тэргүүн туршлага, ур чадварыг түгээн дэлгэрүүлэх, тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэх, багшийн хүртээмжийг нэмэгдүүлэх, нийгмийн баталгаат хангах зориллоор “Сайн багш таны дэргэд” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 06 дугаар 18 ны өдрийн А/51 тоот тушаалаар байгуулан, төслийг боловсруулж байна. БЗД: Багшийн хөгжлийг дэмжих чиглэлээр "Багшаа дэмжье" нэгдсэн арга хэмжээг УИХ-ын гишүүн, дүүргийн Засаг даргын дэмжлэгтэйгээр зохион байгуулж, “Шилдэг менежменттэй байгууллага”, "Тэргүүний үйл ажиллагаатай мэргэжлийн багш нарын бүлэг", 10 номинацийн хүрээнд мэргэжлийн чиглэл тус бүрээр шилдгүүдийг тодруулан алдаршуулж батламж гардуулсан. Үйл ажиллагаагаар 2 байгууллага, 5 мэргэжлийн багш нарын бүлэг, 10 номинацийн хүрээнд 20 тэргүүний багш, боловсролын салбарт ажиллаж байгаа 5 гэр бүлд орон сууцны урьдчилгаа өгч нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэргээр нийт 300.0 сая төгрөгийг санхүүжүүлэн зарцуулсан байна.	100	
256	2.2.9.Багшийн гурван тулгуурт бодлогын хүрээнд орон нутгийн онцлогт тулгуурлан "Сайн багшийг таны дэргэд" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	"Сайн багшийг таны дэргэд" арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2	Эрдэм шинжилгээний онол практикийн бага хурлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, шилдэг илтгэл шалгаруулж, эмхэтгэл, гарын авлага боловсруулан, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	2025-2028	400.0	-	-	-	-	-	400.0	Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, хувь	100	100	100.0	НБГ	Эрдэм шинжилгээний онол практикийн бага хурлыг зохион байгуулахаар нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/95 дугаар тушаалаар удирдамж батлагдсан. Дүүргүүдийн Боловсролын хэлтсүүдэд зохион байгуулах чиглэл бүхий 2025 оны 10 дугаар сарын 13 -ны өдрийн 01/1457 дугаар албан бичиг хүргүүлсэн. Удирдамжийн дагуу нэгж байгууллага бүюу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд 2025 оны 11 дүгээр сарын 08-нд, дүүргүүд Боловсролын хэлтсүүд 2025 оны 11 дүгээр сарын 27-нд тус тус зохион байгуулсан. Нийслэлийн түвшний шалгаруулалт 2025 оны 12 дугаар сарын 01-15-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Илтгэлийн уралдаан 23 судлагдахуун тус бүрээр зохион байгуулагдаж байна. I шатны шалгаруулалтад 9 дүүргээс 384 илтгэл ирүүлснээс удирдах ажилтны 90, 16 судлагдахууны 294 илтгэл шалгаран нийслэлийн Боловсролын газарт ирүүлсэн байна.	100	
257			3	Багш нарын мэргэжлийн ур чадварын шилдэг арга зүй, технологийг дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	200.0	-	-	-	-	-	200.0	Түгээн дэлгэрүүлсэн шилдэг арга зүй, тоо	-	19	50.0	НБГ	Багш нарын ур чадварын шилдэг арга зүй, технологийг дэлгэрүүлэх арга хэмжээг зохион байгуулахаар шаардагдах төсвийн тооцоо, зардлыг гаргахаар газрын даргын тушаалын төслийг бэлтгэж бэлэн байдлыг хангасан ч санхүүжилт нь төсвийн хэмнэлтийн горимоос шалтгаалан шийдвэрлэгдэх боломжгүй улмаас арга хэмжээ хойшлогдоод байна.	59	санхүүжилтгүй

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
258	2.2.10.Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээнд хүнс ханган нийлүүлэх нэгдсэн тогтолцоог нэвтрүүлж, хүүхдийн эрүүл баталгаат хоол хүнсээр хангана.	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлнэ.	1	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургуулийн тоог нэмэгдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлсэн ЕБС-ийн түвшин, хувь	62.9	70		НБГ	Засгийн газрын 2021 оны 18 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 164 сургуулиас 110 сургууль "Удийн хоол" хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлэн ажиллаж байна. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг бие даан хэрэгжүүлэх байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилгоор Боловсрол яам, БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (КОЙКА)-тэй хамтран хэрэгжүүлж буй "Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 10 сургуулийн гал тогоог иж бүрэн засварлахаар төсөл хэрэгжиж байгаа бөгөөд 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийслэлийн 9, 40, 48 дугаар сургуулийн гал тогооны засврын ажил бүрэн дууссан. Тэгш боломжийг дэмжих төслийн хүрээнд нийслэлийн 15 ерөнхий боловсролын сургуулийн гал тогоонд 1.5 сая ам долларын өртөг бүхий 61 нэр төрлийн 8142 ш тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Уг төслийн хүрээнд 103, 116, 63 дугаар сургуулийн гал тогоонд нийт 210.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Боловсролын яаманаас нийслэлийн ерөнхий боловсролын 32 сургуульд аяга таваг, угаагч нийлүүлсэн. Үр дүн: 2025-2026 оны хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 326 сургуулийн 53% буюу 173 нь төрийн өмчийн сургууль байна. Үүнээс хоол үйлдвэрлэл үйлчилгээг бие даан хэрэгжүүлэх 162 сургуулиас 110 сургууль буюу 67.9% нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлж байна.	98	
259			2	Ерөнхий боловсролын сургуул, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хүнсний хангамжийг бүсчилсэн хэлбэрээр цогц байдлаар үзүүлэх менежментийг нэвтрүүлнэ.	2025-2026	-	-	-	-	-	-	-	Менежмент нэвтрүүлэх ажлын явц, хувь		50		НБГ	Төрийн худалдан авах ажиллагааны цахим дэлгүүрт 15 аж ахуйн нэгжийн 53 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүн тавигдаж ерөнхий гэрээгээр сургууль, цэцэрлэг хүнс худалдан авалт хийх боломжийг хангаж байна. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан, чанартай хүнсний бараа бүтээгдэхүүнээр тасралтгүй хангах, үйл ажиллагааны бодлого, чиглэлийг боловсруулах, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх Ажлын хэсэг НЗД-ын 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрийн А/1297 дугаар тушаалаар байгуулагдсан. Уг хурлаар нийслэлийн цэцэрлэгийн эрхлэгч, нярав, тогооч нараас нууц, нэргүй нээлттэй санал, асуулга, судалгаар авч цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд шаардагдах хүнсний бараа бүтээгдэхүүний тооцоог урьдчилсан байдлаар Ажлын хэсэгт орсон байгууллагуудын ирүүлсэн саналыг нэгтгэн цаашид хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг танилцуулсан.	100	
260			3	Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах хүрээнд аяга таваг угаагч ариутгалын иж бүрэн системийг цэцэрлэгүүдэд нэвтрүүлнэ.	2025-2027		20,388.0					20,388.0	Тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллагын тоо		100	6,796.0	НБГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжаар гал тогооны аяга таваг угаагч, ариутгагчийн захиалагчийн хяналтыг Нийслэлийн Боловсролын газар хэрэгжүүлж байсныг 2025 оны А/673 дугаар захирамжаар Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ-т шилжүүлсэн болно. Тус төсөл, арга хэмжээний хүрээнд 100 цэцэрлэгт 1043 ширхэг тоног төхөөрөмжийг нийлүүлэх бөгөөд гүйцэтгэгчидтэй гэрээ байгуулах ажил үргэлжилж байна. Тус захирамжийн хүрээнд захиалагчийн хяналт тавих эрхийг Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт шилжүүлсэн тул уг заалтын хэрэгжилтийг Нийслэлийн Боловсролын газраас тайлагнах боломжгүй байна. нхог-с асуух	100	
261			4	Нийслэлийн онцлогт тохирсон хүнсний хангамжийн тогтолцоо, нэгдсэн хангамжийн төв байгуулахад мэргэжлийн чиг үүргийн байгууллагуудтай хамтран ажиллаж эрүүл баталгаат хоол хүнсээр хангахад дэмжлэг үзүүлж зөвлөн тусална.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Зөвлөн тусалсан байгууллага, тоо	54	50		НБГ	Нийслэлийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хоолны хүнсний хангамж, худалдан авалт, ерөнхий гэрээний нийлүүлэгч аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үнийг тогтвортой хангах нөхцлийг судлах цаашид авах арга хэмжээний санал боловсруулах чиглэлээр БЕГ даргын 2025 оны А/73 дугаартай "Ажлын хэсэг байгуулах тухай" тушаалаар ажлын хэсэгт орж ажилласан. Хяналт шалгалтад нийслэлийн ерөнхий боловсролын 6 сургууль, 4 цэцэрлэг, 15 хүнс нийлүүлэгч аж ахуйн нэгжийг хамруулан хийсэн. Хамрагдсан цэцэрлэг, сургууль хоол үйлдвэрлэл, үйлчилгээний хяналтыг хангалтгүй тавьдаг, зохистой дадал хангалтгүй зэрэг зөрчил илэрсэн. Тухайн зөрчилийг арилгах цаашид үйл ажиллагаандаа анхаарч ажиллах талаар мэргэжил арга зүйн зөвлөмж өгч улсын байцаагчийн 50 заалттай 6 зөвлөмж хүргүүлэн ажилласан. Нийслэлийн 38 дугаар цэцэрлэг хүнсний түүхий эд бүтээгдэхүүн хадгалах агуулахдаа хугацаа дууссан 5 нэр төрлийн 32 ширхэг бүтээгдэхүүнийг хадгалж байсан зөрчилд эрх бүхий улсын байцаагч хуулийн дагуу Зөрчлийн хэрэг нээн Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтаар (таван сая) 5000,000 төгрөгийн торгууль ногдуулан, хууль бус орлого (хоёр зуун мянга дөрвөн зуун тавь) 200,450 төгрөгийг тогтоож, зөрчил арилгуулах улсын байцаагчийн албан даалгавар хүргэж ажилласан. • БЕГ-ын даргын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн А/135, А/213 тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд 10 цэцэрлэг, 22 ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамтарсан хяналт шалгалт хийж ажилласан. Тухайн ажлын хүрээнд нийслэлийн 105, 105 дугаар сургуульд ажил сайжруулах, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай" хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар 2025 оны 06 дугаар сарын 06 өдрийн 02/840, 841 дугаартай албан бичгийг хүргэсэн. Үр дүн: Тайлант хугацаанд нийт 57 байгууллагад зөвлөн туслах ажилласан.	100	
262	2.2.11.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын үдийн хоолонд сүү, сүүн бүтээгдэхүүн нэмэлтээр олгож, хүүхдийн ясны бүтэц, өсөлт хөгжлийг дэмжих "Сүү" хөтөлбөрийг хамтын санхүүжилтээр хэрэгжүүлнэ.	"Сүү" зорилтот төсөлд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлнэ.	1	Сүү зорилтот төслийг өргөжүүлж бага насны хүүхдүүдэд өдөр бүр амин дэмтэй сүүг өгч, хүүхдийн өсөлт хөгжлийг дэмжинэ.	2025-2028	19,772.9	19,772.9				19,772.9	59,318.7	Төсөлд хамрагдсан хүүхэд, тоо	18860	156.928	14,829.7	НБГ	"Сүү хөтөлбөр"-ийг нийслэлд дараах 2 чиглэлээр хэрэгжүүлж байна. - "Сүүн дархлаа" зорилтот төслийг 2024 оны 05 дугаар сарын 01 өдрөөс хэрэгжүүлсэн бөгөөд нийслэлийн 2025 оны үйл ажиллагааны төсөвт 784.0 сая төгрөг, орон нутаг буюу БЗД, СБД-үүд 338.0 сая төгрөг батлуулж, эцэг эх асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 13 сургуулийн 19,400 сурагчаг хамрагдаж байна. -Мөн үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 38 сургуулийн 87,400 сурагчаг, өрт хамрагдаж байна. -"Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийн хүрээнд Энэ хичээлийн жилд 51 ерөнхий боловсролын сургуулийн 106,800 хүүхдийг хамруулан 7 хоногийн 2-3 өдөрт сүү өгч байна. Үр дүн: Сүү хөтөлбөрийн хүрээнд нийт 213,600 хүүхдийг хамруулж, өдөр бүр сүү өгч дэмжиж байна.	100	
277			2	Ерөнхий боловсролын сургуулиудад шүдний кабинет байгуулж "Эрүүл шүд хөтөлбөрийг эрчимжүүлнэ.	2025-2028								шинээр нээсэн шүдний кабинет, тоо	2			НБГ	Нийслэлийн ерөнхий боловсролын нийт 135 сургууль шүд угаах цэг байгуулж, шүд угаах цэгийн орчныг анги, хоолны заалны үүдэнд, коридор, ариун цэврийн өрөөнд угаахаар бүрдүүлсэн. Шүд угаах цагийн зохицуулалт хийсэн нийт 40 сургууль байна. 2025 онд шинээр 12 сургууль шүд угаах орчин бүрдүүлсэн. 2025 онд шүдний кабинет шинээр байгуулах төсөв, зорилтот тусгагдаагүй, 2026 оны нийслэлийн төсөвт 200 сая төгрөг тусгасан ингэснээр шүдний кабинет байгуулах боломж бүрдэнэ.	100	
264	2.2.12.Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг урамшуулах, нийгмийн баталгаат хангахад төр хувийн хэвшлийн байгууллагуудтай	Багш, ажилтныг урамшуулах, нийгмийн баталгаат хангахад дэмжлэг үзүүлнэ.	1	Боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтныг урамшуулах үйл ажиллагааг зохион байгуулна.	2025-2028	570.0	-	-	-	-	-	570.0	Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, хувь	100	100	120.0	НБГ	Нийслэлийн боловсролын салбарын шилдэг байгууллага, гэр бүл, удирдах ажилтан, багш, ажилтныг шалгаруулан, шагнаж урамшуулах, тэдний тэргүүн туршлага, ололт амжилтыг олон нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор "НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛ-АМЖИЛТЫН ЭЗЭД" хүндэтгэлийн үйл ажиллагааг зохион байгуулж 8 номинацид 18 байгууллага, 52 багш, ажилтныг шалгаруулж Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/1322 дугаар захирамжаар 103.072 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж, шагнаж урамшуулсан. Үр дүн: Нийт 79 багш ажилтан шилдгээр шалгарсан байна.	100	
265			2	Багш, ажилтныг чадавхжуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор гадаад улс оронд туршлага судлах, сургалтад хамруулна.	2025-2028	-	1,200.0	-	-	-	-	1,200.0	Хамрагдсан багш, ажилтан, тоо	-	50	450.0	НБГ	Гадаад улс оронд багш, ажилтны мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2025 онд АНУ-ын Вашингтон DC хот, БНСУ-ын Сөүл хот, Япон улсын Токио хот, БНХАУ-ын Хөх хот, Тайланд, Польш зэрэг 6 улс оронд 13 удаагийн туршлага судлах сургалт, олон улсын эрдэм шинжилгээний хурал болон бусад арга хэмжээнүүдэд нийслэлийн Боловсролын газрын 21 албан хаагч, нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 124 багш, ажилтнууд хамрагдсан. Үр дүн: Мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх зорилгоор 6 гадаад улс оронд туршлага судлахаар 145 багш ажилтан сургалтад хамрагдсан байна.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
266	хамтран дэмжлэг үзүүлнэ.		3	Багш ажилтны нийгмийн баталгаат хангах зорилгоор багш гэр бүлд түрээслэхэд өмчлүүлэх орон сууц олгох үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Орон сууц олгосон багш гэр бүл, тоо	28	53		НБГ	Боловсролын салбар дахь багш, ажилтан албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тэднийг дэмжих зорилгоор ажлын амжилт, ёс зүй, ур чадварын үзүүлэлтүүдийг харгалзан багш гэр бүлд түрээслэхэд өмчлөх орон сууцны эрхийг 3 дахь жилдээ олгож байна. 2025 онд боловсролын салбарын 11 багш гэр бүлд түрээслэхэд өмчлүүлэх орон сууцыг олгосон. Үр дүн: Орон сууц олгосон багш гэр бүлийн тоо 54-д хүрсэн.	100	
Зорилтын үр дүн: 2.3. Бүсийн хөгжлийн зорилттой уялдуулан зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.																				
267	2.3.1.Ажил эрхэлдэггүй, нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг түр хоноглох үйлчилгээнд хамруулж, амьдралын зөв дадал хэвшилд сургах, ажлын байранд зуучлах үйлчилгээ үзүүлж орлоготой болоход нь дэмжлэг үзүүлнэ.	Зорилтот бүлгийн иргэд бие даасан амьдралд шилжсэн байна	1	Нийгмийн хамгааллын тусгай төвийн техник, тоног төхөөрөмжийг шинэчлнэ.	2025		896.7					896.7	Тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувь		100	896.7	НХТТ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийгмийн хамгааллын тусгай төвийн өргөтгөл "Сургалт хүмүүжлийн цогцолбор төв"-д шаардлагатай тоног төхөөрөмжийн төсөв батлагдаж, тендерийн үйл ажиллагаа Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар хариуцан ажиллаж, "Интерворлд" ХХК, "Чиглэл" ХХК шалгарч цогцолбор төвд тоног төхөөрөмж хүлээн авах, суурьлуулах бэлтгэл ажил хангагдан ажиллаж байна.	100	
268			2	Гэр оронгүй иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулна.	2025-2028	-	4,300.0	-	-	-	-	4,300.0	Нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамрагдсан иргэд, тоо	525	400	1,600.0	НХТТ	2025 онд 783 иргэнийг хүлээн авч, нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулж ажилласан. Эдгээр иргэдээс 9 иргэнийг бичиг баримтжуулж, 9 иргэнийг тэтгэвэр тэтгэмжид хамруулж, 3 иргэнийг ахмадын асарамжид шилжүүлж, 61 удаагийн сургалт зохион байгуулан давхардсан тоогоор 1825 иргэнийг хамруулж, сэтгэл зүйн анхан шатны үнэлгээнд 353 иргэнийг хамруулж, 343 иргэнд ганцаарчилсан зөвлөгөө өгч, 715 иргэнд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлж, нарийн мэргэжлийн эмч нарийн үзлэгт 355 иргэнийг хамруулан, 172 иргэнийг дараагийн шатны эмнэлэгт зуучлан эмчилгээнд хамруулж, 21 иргэнийг ар гэрт нь хүлээлгэн өгч, бие даасан амьдралд шилжүүлж ажилласан байна.	100	
						-	-	-	-	-	-	-	Ажлын байранд зуучлагдсан иргэд, тоо	155	250	-	НХТТ	Тогтвортой ажлын байранд 69, түр ажлын байранд 86, нийт 155 иргэнийг ажлын байранд зуучилсан байна. Хөдөлмөр эрхлэлтийн үр дүнг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд 2025 онд Мэргэшсэн мэргэжил сургалтын төвтэй хамтран ажилласан нь ихээхэн үр дүнтэй байв.	90	
269	2.3.2.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд тэгш, хүртээмжтэй оролцох боломжийг нэмэгдүүлж, барилга байгууламж, явган хүний зам, гэрлэн дохиог олон улсын стандартад нийцүүлэн өөрчилнө.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн барилга байгууламжий г 20 хувиар нэмэгдүүлнэ.	1	Барилга, байгууламжид хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжийн төлөвлөлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийж, тэгш хүртээмжийг нэмэгдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Стандартад нийцүүлсэн барилга байгууламжийн эзлэх түвшин, хувь	-	10	-	ХШГ, ХБХСГ	ХШГ: 1. Хот байгуулалт, барилга орон сууцжуулалтын яамны Салбарын ерөнхий байцаагчийн 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 02-00/06 дугаартай удирдамжийн дагуу орон сууц, олон нийтийн 450, сургууль цэцэрлэгийн 160, нийт 610 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, шаардлагыг хангах зорилгоор барилга байгууламжийн зураг төсөл, угсралт, ашиглалтын чанар, аюулгүй байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг зохион байгууллаа. Шалгалтын үр дүнд Барилгын техникийн хяналтын улсын байцаагчийн 02-13-01/033/48 дугаартай "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн барилга байгууламжид тавигдах шаардлага, аюулгүй байдлыг хангуулах тухай" зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллах үүрэг чиглэл өгөв. 2. 2025 онд нийт 299 барилга, байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах улсын комиссын үйл ажиллагаат зохион байгуулсан. Үүнд сургууль, цэцэрлэгийн 36, аялал жуулчлалын цогцолбор болон тур отоглох байры зориулалттай 48, орон сууцны 116, олон нийтийн 99 барилга. Энэ хүрээнд MNS 6055:2009 "Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин" стандартыг мөрдүүлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийг хангах үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг ханган ажиллав. ХБХСГ: Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Боловсролын яамны 2025 оны 03-00/12, 02-00/28 дугаар удирдамж, Нийслэлийн Хяналт, шалгалтын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 27-ны А/47 дугаар тушаалын хүрээнд "Сургууль, цэцэрлэгийн орчны аюулгүй байдал болон ашиглалтын төлөв байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт" хийх ажлын хэсэгт Нийслэлийн Боловсролын газар, Хяналт, шалгалтын газартай хамтран нийслэлийн 9 дүүргийн нутаг дэвсгэрт байрлах ерөнхий боловсролын 90 сургууль, сургуулийн өмнөх боловсролын байгууллагын 90 байршилд 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрүүдэд ажиллав.	100	
270		Хөгжлийн бэрхшээлтэй хүнд тэгш, хүртээмжтэй орчинг нэмэгдүүлнэ.	2	Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтэц бүлгийн хотын стандартуудыг сонгосон байршлуудад иж бүрэн цогц байдлаар жишиг болгон бүрэн нэвтрүүлнэ.	2025-2028	-	500.0	-	-	-	-	500.0	Стандартын нэвтрүүлэх ажлын явц, хувь	-	50	300.0	ХБХСГ	1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөлийн Ажлын хэсгийн гишүүнээр оролцон ажиллаж байна. Мөн "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл" бүлгийн хотын стандартуудыг мөрдүүлэх ажлын хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газартай 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдөр уулзалт зохион байгуулан ажиллав. 2.Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшинээр батлуулсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй оны шилдэг салбар зөвлөл" шалгаруулах ажлын удирдамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 11 дүгээр сарын 12-ны өдрийн хооронд нийслэлийн 9 дүүргийн ажлын хэсэгт холбогдох албан хаагч ажиллав. Дүүргүүдийн салбар зөвлөлийн 2025 оны төлөвлөгөөт ажилтай танилцаж, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтэц бүлгийн дараах 2 хотын стандартыг мөрдүүлсэн байдал, иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан ажлыг шалгаж дүгнэв. Үүнд: - UCS 1001A:2023 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж; - UCS 1001C:2023 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл болно. Цаашид салбар зөвлөлийн ажлыг уялдуулан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийг нэмэгдүүлэх чиглэлээр батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх, энэ чиглэлээр иргэд, олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх хүрээнд сургалт зохион байгуулах талаар санал, зөвлөмж өгч ажиллав.	100	
271			3	Хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих бүрэн боломжтой явган хүний зам, талбайг иж бүрэн тохижуулна.	2025-2028		1,200.0	500.0				1,700.0	Тохижуулсан явган хүний зам, талбай, м2			1,700.00	НЗХГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/104 дүгээр захирамжаар батлагдсан "Хөгжлийн бэрхшээлтэй хүн зорчих бүрэн боломжтой явган хүний зам, талбайг иж бүрэн тохижуулах" ажлын хүрээнд нийт 150 орчим байршилд талбайн тохижилтын ажлыг бүрэн гүйцэтгэсэн байна. Тухайн ажлын гүйцэтгэлийг баталгаажуулах зорилгоор комисс газар дээр нь ажиллаж, геодезийн хэмжилт хийж, нарийвчилсан тоо хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг гарган ажиллаж байна.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
272	2.3.3.Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээг хөгжүүлж, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжин, хувийн хэвшил, төрийн бус байгуллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлнэ.	Ахмад настны өдөр тутмын амьдралд дэмжлэг үзүүлэн амьдралын чанар сайжирна	1	Ахмад настанд асаргааны хувилбарт үйлчилгээг төрийн болон бус байгуллагатай хамтран үзүүлнэ.	2025-2028	#REF!	-	-	-	-	-	9,600.0	Хувилбарт үйлчилгээнд хамрагдсан ахмад настан, тоо	-	50,000	2,400.0	Дүүргүүд	Багануур дүүрэг: санхүүжилт тусгагдаагүй тул хамаарахгүй. Бзд: Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгуллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, нийгмийн ажилтныг мэргэшүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх Орон нутгийн мэргэжлийн хамтарсан багийг дүүргийн Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн А/462 дугаар захирамжаар 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан бөгөөд 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Ахмад настны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 7.1.2, 7.1.5, 7.1.9, 7.1.10, 7.1.11 -д заасан багц үйлчилгээ буюу "Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төв"-ийн үйлчилгээ үзүүлэх боломжтой иргэн, аж ахуйн нэгж ТББ-ыг сонгон шалгаруулж гэрээлэн гүйцэтгүүлэхээр хамтран ажиллах гэрээ 6 байгуллагатай байгуулан ажиллаж байна. Ахмадын цогц үйлчилгээг 6 багцаар үзүүлэн ажиллаж байгаа бөгөөд нийт 1055 ахмад настан хамруулаад байна. Үүнд: Багц1: Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 512 Багц2: Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 59 Багц3: Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 352 Багц4: Хувилбарт үйлчилгээнд (Гэрээр асрах, өдрөөр асрах) 41 Багц5: Хувилбарт үйлчилгээнд (Гэрээр асрах, өдрөөр асрах) 49 Багц6: Хувилбарт үйлчилгээнд (Түр хугацаагаар асрах, урт хугацаагаар асрах, байнгын асрах) 42 ахмад настныг тус тус хамруулан холбогдох үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээнд 518,000,000 төгрөгийг зарцуулсан болно. хамтран ажиллах гэрээ байгуулсан байгуллагуудтай "Ахмад настны цогц үйлчилгээг хэрхэн хүргэх" болон холбогдох хууль, журмын талаар дэлгэрэнгүй танилцуулж, арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж байгаа болно. БГД: "Улсын төсвийн хөрөнгөөр Ахмад настны цогц үйлчилгээг үзүүлэх аж ахуй нэгж, төрийн бус байгуллагуудыг сонгон шалгаруулах" үнэлгээний хороо байгуулж, тендерийн баримт бичгийг боловсруулан, Төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дамжуулан 4 багц үйлчилгээ дээр нээлттэй сонгон шалгаруулалтыг 2025 онд 2 удаа хуулийн хугацаанд зарласан. Сонгон шалгаруулалтад тэнцсэн 3 аж ахуй нэгж байгуллагатай хамтран ажиллах гэрээг байгуулж ажилласан.Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээнд 800 гаруй ахмад хамрагдаж 4,000 гаруй төрлийн үйлчилгээ авсан байна. Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний мэдээлэл зөвлөгөөг 418 ахмадад өгч, хамрагдах хүсэлт ирүүлсэн 118 иргэний төслийг сонгон шалгаруулах ажлыг 3 үе шаттайгаар зохион байгуулж 47 ахмадад санхүүгийн дэмжлэг үзүүлсэн. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн өндөр ур чадвар, туршлагатай 118 ахмадад ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээний арга хэмжээний талаар сургалт зохион байгуулж зөвлөгөө өгч мэдээллийн санг бүрдүүлэн ажилласан. Зөвлөх үйлчилгээ авах хүсэлттэй 13 аж ахуйн нэгж байгуллагаас хүсэлт ирүүлж, 9 ахмад мэргэжилтнийг ажиллуулан түр ажлын байраар ханган ажилласан. Баянгол дүүрэг дэх Цагдаагийн газрын нэг, хоёрдугаар хэлтэс, Хүүхэд гэр бүлийн хамгааллын хэлтэстэй хамтран хүүхэд хамгаалагч арга хэмжээг зохион байгуулан хороо бүрт хүүхэд хамгаалагчийг ажиллуулж 26 ахмад настныг ажлын байраар ханган ажилласан байна. Үр дүн: Нийт 1418 ахмадыг холбогдох үйлчилгээнд хамруулан ажилласан байна НАЛАЙХ: "Ахмад настны цогц үйлчилгээ" -г үзүүлэх гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулах тендерийг зарлаж "Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ"-ний багцад дүүргийн Ахмадын хороо шалгарсан. Ахмад настанд сэргээн засах үйлчилгээ, өдрийн үйлчилгээ, ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээ зэрэг багцуудад 4 удаагийн төндер зарласан боловч оролцогчгүй байна. Ахмадын хороотой 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдөр гэрээ байгуулсан."Идэвхтэй насжилтыг дэмжих үйлчилгээ"-г эхлүүлж, давхардсан тоогоор 340 ахмад настныг хамруулж 26,833,000 төгрөгийг олгосон. ЧД: Дүүргийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн А/345 дугаар захирамжаар Ахмад настанд цогц тусламж, үйлчилгээ үзүүлэх "Орон нутгийн мэргэжлийн хамтарсан баг"-ийг 5 гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж, Чингэлтэй нэгдсэн эмнэлэг, Ахмадын хороо, Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс, 1-24 дүгээр хороод, Өрхийн эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан ахмад настнуудын бие бялдар, танин мэдэхүй, сэтгэл зүйг үнэлэн цогц тусламж үйлчилгээг үзүүлэх ажлыг эхлүүлэн хэрэгжүүлж байна. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт энэ онд нийт 39 ахмадыг хамруулж 390,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон. Багахангай дүүрэг: Дүүргийн УЗХороо, Ахмадын хороо хамтран тайлангийн хугацаанд 18 хэвтрийн ахмад настанд асаргааны үйлчилгээ үзүүлж 1,2 сая төгрөг зарцуулав. Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэс нь нийгмийн халамжийн сангаас олгодог ахмад настанд үзүүлэх нийгмийн халамжийн үйлчилгээнд нийт 742 ахмад настныг хамруулан 70,1 сая төгрөг, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихээр "Хүүхдийн эрхийг хамгаалахад дэмжлэг үзүүлэх" арга хэмжээнд 1 ахмад настанд 2,0 сая төгрөг, Ахмадын санхүүгийн дэмжлэгт 3 иргэнд 23,0 сая төгрөг, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 4 иргэнд 4,3 сая төгрөгийг тус тус олгоод байна. СХД:Ахмад настны цогц тусламж, үйлчилгээнд хамруулах үйлчилгээ үзүүлэх байгууллагуудыг сонгон шалгаруулах ажлыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн хүрээнд зохион байгуулж, Өнөр болон Төвийн бүс дээр "Дуут баян богд" ХХК, "Ай Эй Пи инсайт" ХХК гэсэн 2 байгуллага шалгарч, ахмад настнуудад идэвхтэй насжилтыг дэмжих төвийн үйлчилгээ буюу Зөвлөгөө өгөх, сэтгэл зүйн зөвлөгөө, хууль эрх зүйн зөвлөгөө мөн зөв хооллолтын сургалт, эрүүл зөв амьдралын хэв маягт сургах дасгал хөдөлгөөн зэрэг үйлчилгээг үзүүлж байна. Асаргааны хувилбарт үйлчилгээ буюу ахмад настны гэрээр орж даралтын хэмжих, анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх, гар хөл, нуруунд бариа хийх, өөрийн байранд хүлээн авч бариа засал, сэргээн засахын үйлчилгээг ерхийн эрүүл мэндийн төвийн эмчийн үнэлгээнд үндэслэн үзүүлж байна. СБД: Батсүмбэр дэх Ахмад настны асрамж хөгжлийн үндэсний төвд 11, 17 дугаар хорооны ганц бие, харж хандах хүнгүй 2 ахмадыг хамрууллаа. Хороодын Ахмадын зөвлөлийн даргаар дамжуулан тулгуур эрхтэний бэрхшээлтэй 50, хэвтрийн өвчтэй 130 ахмадын судалгаг авч нэгтгэн, 12 хорооны 210 ахмадад гэрээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж, эрүүл мэндийн багц олголоо. Ахмад настны асаргааны хувилбарт үйлчилгээний гүйцэтгэгч сонгон шалгаруулах нээлттэй 4 багц 235 сая төгрөгний төсөвтэй тендэрийг 2 удаа зарласан боловч тендерийн ерөнхий шаардлага хангасан оролцогч шалгараагүй тул тус үйлчилгээ хэрэгжиж эхлээгүй. Ахмад настны идэвхтэй насжилтыг дэмжих төвөөр нийт 499 ахмадад үйлчилгээ үзүүлсэн байна.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр: Улс	Эх үүсвэр: Нийслэл	Эх үүсвэр: Дүүрэг	Эх үүсвэр: Гадаад зээл	Эх үүсвэр: Гадаад тусламж	Эх үүсвэр: Төр, хувийн хэвшил	Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он: Зорилтот түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он: Төсөв (сая төгрөг)	Хэрэгжүү-лэх байгуул-лага: Үндсэн	Хэрэгжилт	Хувь	Биелээгүй шалтгаан
273	2.3.4.Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтэд дэмжлэг үзүүлнэ.	Залуучуудын хөдөлмөр эрхлэлт нэмэгдсэн байна.	1	Сургалтыг үе шаттай зохион байгуулж, олон талт эх үүсвэрээс дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Бизнес эрхлэлтийн сургалтад хамрагдсан залуучууд, тоо	6500	6600		Дүүргүүд	Багануур дүүрэг: Шинэ технологи, инноваци бүхий шинэлэг санал санаачлага гаргагч бизнес эрхлэх хүсэлтэй 15-34 залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний бүртгэлийг 09 дүгээр сарын 04- 20-ны өдрийн хооронд google form цахим системээр бүртгэж, Вест Метод ХХК-тай хамтран бизнесийн санааг хөгжүүлэх сургалтыг 10 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулж, 2 дугаар шатны хурдасгуур хөтөлбөрт 11 багийн 21 залуусыг хамруулаад байна. БЗД: Баянзүрх дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсээс арга хэмжээг зохион байгуулах хүсэлтэй эрх бүхий 3 байгууллагын хүсэлтийг хүлээн авсан боловч Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн мөнгө татагдсан байгаа тул арга хэмжээ одоогоор зохион байгуулагдаагүй болно БГД: Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2025 оны 01 дүгээр тогтоолоор аймаг, дүүргийн хэмжээнд шилдэг гарааны залуучуудын багийг өрсөлдөөний зарчмаар зохион байгуулахтай холбоотой бэлтгэл ажлыг бүрэн хангаж, “Хөгжлийн шийдэл” төрийн бус байгууллагатай хамтарч 29 залуучуудыг гарааны бизнес эрхлэх сургалтад хамруулсан. НАЛАЙХ: Шинэ технологи, инновац бүхий шинэлэг санал, санаачилга гаргасан шилдэг “Старт-Ап” залуучуудын багийг шалгаруулах бүртгэлд 11 баг бүртгүүлж, дараагийн шатанд 5 багийг шалгаруулсан. Хоёрдугаар шатанд шалгарсан залуучуудын багийнханд бизнесийн зөвлөхүүдтэй хамтарч 5 долоо хоногийн хурдасгуур хөтөлбөрт хамруулж, бизнес санаагаа зах зээлд нэвтрүүлэхэд чиглэсэн зөвлөгөө, мэдээлллээр хангаж ажилласан. Гуравдугаар шат болох хөрөнгө оруулагч, олон нийтэд төслөө танилцуулах өдөр буюу Demoday арга хэмжээг 11 дүгээр сарын 07-ны өдөр зохион байгуулж, 4 баг оролцсон. Нийт 11 залуучуудыг сургалтад хамруулсан. ЧД: “Шилдэг Стартап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны хүрээнд “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран залуучуудад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж байна. Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг “Монгол Холт” хүүхдийн халамжийн байгууллагатай хамтран залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийг хэрэгжүүлж, 45 залууг амжилттай суралцуулж төгсгөсөн бөгөөд Солонгос хэлний сургалтад нийт 21 залуу хамрагдаж байна. Багахангай дүүрэг: Залуучуудын гарааны бизнесийг дэмжих санхүүгийн дэмжлэг олгох “Старт ап” арга хэмжээний 1 дүгээр шатны “Гарааны бизнесийг хөгжүүлэх” сургалтыг 2025 оны 09-р сарын 27-ны өдрөөс 10-р сарын 27-ны өдрийн хооронд 12 залуучуудад, 2-р шатны сургалтыг 11 залуучуудын 6 багт 10-р сарын 28-ны өдрөөс 11-р сарын 27-ны өдрийн хооронд тус тус зохион байгуулав. Сургалтад хамрагдсан залуучуудаас шалгарсан 2 багт залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний санхүүгийн дэмжлэг болох 30,0 сая төгрөгийг олгоод байна. СХД:“МЭРГЭЖИЛТЭЙ, АЖИЛТАЙ ЗАЛУУС” төслийг 3 дахь жилдээ хэрэгжүүллээ. Нярав, Тогооч мэргэжлээр залуусыг сургаж, Чадамжийн гэрчилгээ гардуулан, байнгын ажлын байранд зуучлах өдөрлөгийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Төгсөгчдөөс сонгон шалгаруулалт хийж “Алтан жолоо” ХХК, “Дүүрэн фүүд” ХХК, "Байгууламж од” ХХК, “Хан богд кашмер” ХХК, АЛТАН ТАРИА, ЭЙ ЭНД ЭМ ТҮВШИН КАТЕРИНГ байгууллагуудад нийт 23 залуусыг байнгын ажлын байранд зуучилсан. Жижиг дунд үйлдвэр үйлчилгээ эрхлэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн сургалтыг зохион байгуулах, хамруулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх ажлын хүрээнд бизнесийн төслийн захиалгат болон туршлага судлах, танилцуулах сургалтуудыг зохих чиглэлийн байгууллагуудтай хамтран 18 чиглэлийн сургалтад нийт 365 үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг хамруулж ажилласан. Жижиг дунд үйлдвэр эрхлэгчдийг тохирох төсөл хөтөлбөр, хөнгөлөлттэй зээл, тусламжид холбон зуучлах ажлын хүрээнд Төрийн банкны Сонгинохайрхан салбар нэгжтэй хамтран үйлдвэр эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжих, хөгжүүлэх зорилготой “Санамж бичиг” байгуулсан. Санамж бичгийн хүрээнд эргэлтийн хөрөнгийн зээл 38, бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн зээл 42, өрхийн бизнесийн зээл 14, гарааны бизнесийн зээл 33, нийт 127 үйлдвэр эрхлэгчдэд 4.8 тэрбум төгрөгийн зээлийг олгоод байна. СБД: Старт-ап санхүүгийн дэмжлэг олгох төслийн талаарх мэдээлэл олгох арга хэмжээг 20 хороог 5 бүс болгон зохион байгуулж, нийт 295 иргэн хамруулсан. Уг төслийн хүрээнд төсөлд хамрагдах сонирхолтой залуучуудад зориулсан зээлийн өмнөх ба дараах сургалтад 13 залуучууд хамруулсан. Сургалт зохион байгуулах эрх бүхий сургалтын байгууллага сонгон шалгаруулах ажлын хэсгийн шийдвэрээр 3 сургалтын байгууллага шалгарч, зээлийн өмнөх аж ахуй эрхлэх төсөл бичих, санхүүгийн анхан шатны мэдлэг олгох сургалтад хувиараа хөдөлмөр эрхлэгч 112 иргэн, зээлийн дараах сургалтад хувиараа хөдөлмөр эрхлэгч 54 иргэн хамрагдсан байна.	100	
						-	-	-	-	-	-	-	Гарааны бизнес эрхлэлтийн дэмжлэг авсан залуучууд, тоо	133	150		Дүүргүүд	Багануур дүүрэг: Шалгаруулалт 11 дүгээр сарын 29-ний өдөр болох бөгөөд нийт 7 багийг шалгаруулж, шилдэг 2 багт хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 50% эргэн төлөгдөх нөхцөлтэй 30,000,000 төгрөгийн санхүүжилт, 5 багт дүүргийн төсвөөс, нийт 25,000,000 төгрөгийн санхүүжилтийг тус тус олгохоор бэлтгэл ажлыг хангаж байна. БЗД: Энэ заалт дээр ирүүлээгүй. БГД: Гарааны бизнес эрхэлж буй 3 багийн 9 залуучуудад 30 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. НАЛАЙХ: Шалгарсан 2 залуутай гарааны дэмжлэг олгох гэрээ байгуулж, тус бүр 15,0 сая төгрөгийг 36 сарын хугацаанд эргэн төлөх нөхцөлтэй олгож, 2 иргэнийг байнгын ажлын байраар хангаж ажилласан. ЧД: Шилдэг Стартап” залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйл ажиллагааны хүрээнд “Хөгжлийн шийдэл” ТББ-тай хамтран залуучуудад чиглэсэн сургалтуудыг зохион байгуулж байна. Чингэлтэй дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг “Монгол Холт” хүүхдийн халамжийн байгууллагатай хамтран залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийг хэрэгжүүлж, 45 залууг амжилттай суралцуулж төгсгөсөн бөгөөд Солонгос хэлний сургалтад нийт 21 залуу хамрагдаж байна. Багахангай дүүрэг: Залуучуудын гарааны бизнесийг дэмжих санхүүгийн дэмжлэг олгох “Старт ап” арга хэмжээний 1 дүгээр шатны “Гарааны бизнесийг хөгжүүлэх” сургалтыг 2025 оны 09-р сарын 27-ны өдрөөс 10-р сарын 27-ны өдрийн хооронд 12 залуучуудад, 2-р шатны сургалтыг 11 залуучуудын 6 багт 10-р сарын 28-ны өдрөөс 11-р сарын 27-ны өдрийн хооронд тус тус зохион байгуулав. Сургалтад хамрагдсан залуучуудаас шалгарсан 2 багт залуучуудын гарааны бизнесийг дэмжих арга хэмжээний санхүүгийн дэмжлэг болох 30,0 сая төгрөгийг олгоод байна. СБД: Дүүргийн залуучуудын шилдэг старт-ап шалгаруулах арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн 2 сарын хугацаанд зохион байгуууллаа. Тус уралдаанд нийт 11 баг төсөл ирүүлснээс 1-р шатны шалгаруулалтаар 5 баг шалгарч, тус багууд нь Стартап Маркетинг Спэйс ментор байгууллагын хурдасгуур хөтөлбөрт 21 хоног хамрагдаж, бизнес санаагаа хөгжүүлсэн. Төслийн сүүлийн шатны шалгаруулалтад 3 баг оролцож, Зохион бүтээгчдийн дугуйлан (Robolab), Машинтай задгай талбайн кино үзвэр (Nabi drive in cinema) зэрэг багууд шалгарч, 36 сарын хугацаанд 50% эргэн төлөх нөхцөлтэй 15 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус авсан.		
274	2.3.5.Оюутан, залуучуудыг цагаар хөдөлмөр эрхлэх боломж		1	Аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран ажиллаж цагийн ажлын	2025-2028	-	-	-	-	-	-	-	Ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж, тоо	539	550		Дүүргүүд	Багануур дүүрэг: Багануур дүүрэгт санхүүжилт тусгагдаагүй тул хамаарахгүй. БЗД: Дүүргийн хэмжээнд 450 шинэ ажлын байрыг хөдөлмөрийн зах зээлийн https://office.ejob.gov.mn/ программд бүртгэсэн. Мөн 50 аж ахуй нэгж байгууллагаас ирүүлсэн сул чөлөөтэй 198 ажлын байрыг программд бүртгэн авч, 43 хорооны мэргэжилтнүүдэд илгээж хороодын мэдээллийн самбар болон цахим хуудаснуудад 10 удаа байршуулан ажилласан. Тайлант хугацаанд нийт 100 гаруй ААНБ-тай хамтран ажилласан болно. БГД: Дүүргийн хэмжээнд 269 иргэн, аж ахуйн нэгжийн 720 ажлын байр шинээр бий болсон. Шинээр бий болсон ажлын байрны 90 хувь нь байнгын ажлын байр байна. НАЛАЙХ: Нийт 194 ажил олгогчийн давхардсан тоогоор 1084 нээлттэй ажлын байрны захиалгыг хүлээн авч, www.office.ejob.gov.mn хөдөлмөр эрхлэлтийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, олон нийтийн сүлжээ болон 8 хорооны мэргэжилтнүүдээр дамжуулан ажил хайгч иргэдэд хүргэсэн. Тайлант хугацаанд нийт 1310 иргэнийг хөдөлмөр зах зээлийн мэдээллийн санд бүртгэсэн. Үүнээс ажлын байр хайх зорилгоор 566 иргэн, ажилгүйдлийн тэтгэмж авах зорилгоор 438 иргэн, хөтөлбөрт төсөлд хамрагдах зорилгоор 306 иргэн тус тус бүртгүүлсэн. Үүнээс 320 иргэнийг байнгын ажлын байранд, ЧД: Оюутан, залуучуудыг цагаар хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд мод ургуулах, арчлах арга хэмжээний хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль болон 33 дугаар цэцэрлэгт ногоон байгууламжийг арчлах, цэвэрлэх, насжилт өндөртэй модыг тайрах, хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, ажил хайгч 46 иргэн, Шинэ иргэншил политехникийн коллежийн 6 оюутан, нийт 52 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан. СХД: ИХ ЗАСАГ ЧИНГИС СООСЭ их сургуультай хамтран хөдөлмөр эрхлэлтийг дэмжих өдөрлөгийг Эрх зүй, Гадаад харилцаа, Аюулгүй байдал, Банк санхүү, Бизнесийн удирдлага, Гааль татварын чиглэлээр суралцан төгсөж байгаа оюутнуудыг хамруулан зохион байгуулсан. Өдөрлөгт Гаалийн ерөнхий газар, Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газар, замын цагдаагийн хэлтэс, “Од” групп, Голомт банк, Грийн групп, “Монос” ХК, Нет капитал ББСБ, Жоб центр, HR Талент, Цэц оюун ухаан групп, "Шинэлэг сууц" ХХК зэрэг ажил олгогч байгууллагууд оролцож төгсөгчидтэй ажлын ярилцлага хийн ажлын байранд сонгон шалгаруулж авлаа. Тус өдөрлөгт 540 гаруй оюутан залуус оролцож ажлын ярилцлагад орж хөдөлмөрийн зах зээлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгч, 12 оюутныг ажлын байранд зуучилсан. СБД: Шинээр бий болж буй ажлын байрны талаарх мэдээ, мэдээллийг иргэдэд хүргэх, ажил олгогч иргэнээс авах сурталчилгаа, зар мэдээг олон нийтэд шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж, нийт 196 шинэ ажлын байрны мэдээллийг батлагдсан маягтын дагуу хөдөлмөр эрхлэлтийн E-JOB цахим системд бүртгэж, мэдээлсэн. Нийт 261 иргэнийг ажлын байранд зуучилсан.	95	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
	нөхцөлийг бүрдүүлнэ.			байрыг нэмэгдүүлнэ.		-	-	-	-	-	-	-	Цагийн ажилд хамрагдсан оюутан, залуучууд, тоо	7629	8000		Дүүргүүд	Багануур дүүрэг: Монголын залуучуудын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан "Нэмэх давлагаа" залуучуудын өдөрлөгт гадна болон дотор үйл ажиллагааны зохион байгуулалтад ажиллах, бүртгэл судалгаа гаргах, арын албанд ажиллуулах зорилгоор 1-4 дүгээр курсын 20 оюутныг нэг өдрийн цалинтай ажиллуулсан. БЗД: Дүүргийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэс болон аж ахуй нэгж байгууллагуудтай хамтран нийт 255 оюутан залуучуудыг түр болон цагийн ажилд зуучлан хөдөлмөр эрхлэх боломж нөхцөлийг бүрдүүлсэн. Менх Сэнтрал Фүүдс ХХК, Стимо ХХК, CU сүлжээ дэлгүүр, Эс И Эс Эл Смарт Солюшн ХХК–тай хамтран ажиллаж нийт 140 оюутан залуучуудыг цагийн ажилд бүртгэж, 85 залуучуудыг ажлын байраар хангаж ажилласан. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгаллын яам, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газраас "АЖИЛТАЙ ӨРХ-АЗ ЖАРГАЛТАЙ ГЭР БҮЛ" өдөрлөг 2025 оны 05 дугаар сарын 15-ны өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгт 17 аж, ахуйн нэгж байгууллагын 160 ажлын байрны сул орон тооны захиалгыг хүлээн авч ирэгдэд хүргэж ажилласан. Баянзүрх дүүргээс идэвхтэй ажил хайч 60 орчим оюутан залуучуудыг урьж оролцуулан, 30 оюутан, залуучууд ажлын шууд ярилцлагад орж ажлын санал хүлээн авсан. БГД: Дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг их дээд сургуулийн 150 гаруй оюутан залуусыг оролцуулсан байгчин болон цагийн ажлын байрыг сурталчлах өдөрлөг арга хэмжээг 9 удаа зохион байгуулж, 182 байгууллагын 675 орчим байгчин, болон түр ажлын байрны нээлттэй зарыг танилцуулж 1,300 гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлсэн. 2025 онд нийт 660 иргэнийг байгчин ажлын байртай болгож, 86 иргэнийг цагийн ажилд зуучилсан байна. НАЛАЙХ: 80 иргэнийг түр (цагийн, улирлын) ажлын байранд, нийт 400 иргэнийг ажлын байранд зуучилсан. Байгчин ажлын байр бий болгосон 14 ААН байна. Ажил олгогчийн шаардлага, иргэдийн хүсэл сонирхолд нийцүүлэн 80 иргэнийг түр (цагийн, улирлын, түр) ажлын байраар хангасан байна. ЧД: Оюутан, залуучуудыг цагаар хөдөлмөр эрхлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд мод ургуулах, арчлах арга хэмжээний хүрээнд дүүргийн Ерөнхий боловсролын 23 дугаар сургууль болон 33 дугаар цэцэрлэгт ногоон байгууламжийг арчлах, цэвэрлэх, насжилт өндөртэй модыг тайрах, хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, ажил хайч 46 иргэн, Шинэ иргэншил политехникийн коллежийн 6 оюутан, нийт 52 иргэнийг түр ажлын байраар хангаж ажилласан. СБД: Их үйлсийн бүтээмж ХХК-тай хамтран Үйлдвэр урлалын политехник коллежийн 85 суралцагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох бүлгийн сургалт зохион байгуулсан. Монгол улсын их сургуулийн оюутан залуучуудад цагийн ажлын байрны танилцуулга хийж, нийт 56 оюутан залуучуудыг цагийн ажлын байранд зуучилсан.		
Зорилтын үр дүн: 2.4.Үндэсний агуулга бүхий соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, хотын соёлыг дэндэлсэн иргэнийг төлөвшүүлнэ.																				
275	2.4.1.Түүх соёлын өвийг бүртгэлжүүлж, түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтад авч, засварлан тохижуулж, соёл, амралт, аялал жуулчлалын бус болгон соёлын аялал жуулчлалыг дэмжинэ.	Нийслэлийн нутаг дэвсгэр дэх түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтад авч, түүх соёлын өвийг бүртгэлжүүлж, соёлын аялал жуулчлалыг дэмжинэ.	1	Соёлын өвийн мэдээллийн сан үүсгэх, соёлын өвийг бүртгэнэ.	2025-2028	-	270.0	-	-	-	-	270.0	Бүртгэсэн соёлын өв, тоо	-	100	50.0	НСУГ	Нийслэлийн хэмжээнд бүртгэлтэй соёлын биет болон биет бус өвийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн сан үүсгэх ажлыг үе шаттай зохион байгуулж, нийслэлийн 9 дүүргийн соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын мэдээллийг 7 ай савын хүрээнд нэгтгэн гаргаж, Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн улсын нэгдсэн бүртгэлийн Ich.mongoluv.mn программд 1014 өвлөн уламжлагчдын мэдээллийг байршуулсан. Соёлын биет өвийн түүхэн дурсгалт газруудыг цахимд шилжүүлэх мэдээллийн сан үүсгэх ажлын хүрээнд Соёлын сайдын 2023 оны А/317, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны А/253 дугаар тушаалаар Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн улсын тооллогыг зохион байгуулж байна. Нийслэлийн өмчийн түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг зохион байгуулах үүрэг бүхий салбар комиссыг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1289 дүгээр захирамжаар байгуулсан. Тус комисс нь Улаанбаатар хотын музей, Багануур, Налайх дүүргийн Соёлын ордны Орон нутаг судлах танхимын хөдлөх дурсгалт зүйлийн тооллогыг зохион байгуулах бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдрөөс Улаанбаатар хотын музейн тооллогын ажлыг эхлүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар тооллогын явц 40%-тай явагдаж байна. Багануур, Налайх дүүргийн Орон нутаг судлах танхимын тооллого 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрөөс эхэлнэ.	100	
276			2	Түүх соёлын дурсгалт газруудыг хамгаалалтад авч, "Кино үйлдвэр" орчмыг хотын киноны гудамж болгон төрөлжүүлэн хөгжүүлнэ.	2025-2028	-	175.0	-	-	-	-	175.0	Хамгаалалтад авсан соёлын дурсгалт газрууд, тоо	-	1	30.0	НСУГ	Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газраас дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсад Үндэсний кино урлаг үүсч хөгжсөний 90 жил,"Монгол хүү" киноны 90 жил, "Цогт тайж кино"-ны 80 жилийн ойг тохиолдуулан "Киночдын гудамж" төслийг эхлүүлэн кино үйлдвэр орчмын зам талбайг засах, цэцэрлэгжүүлэлтийн ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Тус ажлын хүрээнд дүүгийн 5, 41 дүгээр хороо Г.Лувсанцэвээний гудамж Монгол кино нэгтгэлийн орчим 580 м.кв явган хүний зам, 50 ширхэг гэрэлтүүлэг, 959м.кв асфальтан хучилттай зогсоол, 2,916м.кв талбайд зүлэгжүүлэлт, авто зам тусгаарлах 940 метр хайс, ЭТӨЧ дагуух 2390м.кв чулуун явган хүний зам, өргөн чөлөө дагуу амралтын сандал байршуулах ажлыг хийж гүйцэтгэзд байна. Мөн тус төслийн хүрээнд 1990 оноос өмнөх иргэдийн сэтгэлд хоногшсон монгол кинонуудаас "Шилдэг монгол кино"-г шалгаруулах санал асуулгыг Монгол кино нэгтгэлээс зохион байгуулан шилдэг 35 киноны нэрийг сонгож хүндэтгэлийн самбарт байршуулсан.	100	
277			4	Дамбадаржайлан хийдийг сэргээн засварлаж, ашиглалт хамгаалалтыг сайжруулан түүх соёлын өвийг хадгална.	2025-2028	-	736.0	-	-	-	-	736.0	Түүх соёлын өвийг хадгалах ажлын явц, хувь	-	100	736.0	НСУГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1530 дугаар захирамжаар Дамбадаржайлин хийдийг сэргээн засварлаж, уламжлал, шинэчлэлийг хослуулсан, үндэсний түүх дурсгалын цэцэрлэгт хүрээлэн бүхий орчин үеийн соёл, гэгээрлийн төв болгон хөгжүүлэх санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус Ажлын хэсэг 2 удаагийн хурал зохион байгуулж, Дамбадаржайлин хийдийг соёл, гэгээрлийн төв болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.	53	
278	2.4.2.Гандантэгчинлэн хийд орчмыг тохижуулж, "Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар" агуулгаар хөгжүүлж, "Буддын шашны соёлын өвийн цогцолбор" болгоно.	Гандантэгчинлэн хийд орчмыг Үндэсний соёлын өвийн дурсгалт болон Буддын шашны соёлын өвийн цогцолбор газар болгох орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна.	1	Гандантэгчинлэн хийд орчмын тохижилт, бүтээн байгуулалтын ажлыг хийнэ.	2025	-	3,226.1	-	-	-	-	3,226.1	Тохижилт, бүтээн байгуулалтын ажлын явц, хувь	-	100	3,226.10	НСУГ	Гандангийн зүүн талын замын өргөтгөлд нийт 14 нэгж талбар байгаагаас 7 нэгж талбар нь зөвшөөрөлтэй үүнээс 1 нэгж талбартай зөвшилцсөн. Үлдсэн 6 нэгж талбарын үл хөдлөх эд хөрөнгийн гэрчилгээ байхгүй тул нөхөх олговрын зориулалттай хөрөнгийн үнэлгээ хийгдээгүй байна. Зохих зөвшөөрөлгүй газар ашиглаж буй 7 иргэн, хуулийн этгээдэд газар чөлөөлөх мэдэгдэл хүргүүлсэн, 1 иргэнтэй зөвшилцсөн. Баянгол дүүрэг 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт Гандангийн дэнж орчимд Горооны замыг 10 м өргөнтэй байхаар судалгаа хийхэд газар чөлөөлөлтийн ажлын нөлөөлөлд 20 нэгж талбарын 1401м2 газар өртөж 10 тэрбум, 15 м өргөнтэй байхаар судалгаа хийхэд газар чөлөөлөлтийн ажлын нөлөөлөлд 48 нэгж талбарын 3412 м2 газар өртөж 15 тэрбум төгрөгийн нөхөх олговор олгох төсөөллийн үнэлгээ гарсныг Улаанбаатар хотын Ерөнхий менежер болон Захиргачийн ажлын албаны даргаар ахлуулсан Ажлын хэсэгт танилцуулсан. Эдгээр бүтээн байгуулалтын хүрээнд холбогдох чиг үүргийн байгууллагууд 2025-2026 онд гүйцэтгэлээ хангаснаар цогцолбор бүтээн байгуулалтын ажлуд 2027-2028 онуудад хийгдэхээр төлөвлөгдөж байна.	84	
279			2	"Далх, Тасганы дэнжийн Үндэсний соёлын өвийн дурсгалт газар" агуулгаар хөгжүүлэх сэргээн засварлаж тохижуулна.	2025-2028	7,200.0	-	-	-	-	-	7,200.0	Тохижилт, бүтээн байгуулалтын ажлын явц, хувь	-	-		НСУГ		84	
280			3	"Буддын шашны соёлын өвийн цогцолбор" байгуулах бүтээн байгуулалтын ажлыг хийнэ.	2025-2028	6,000.0	-	-	-	-	-	6,000.0	Тохижилт, бүтээн байгуулалтын ажлын явц, хувь	-	-		НСУГ		84	
281	2.4.3.Улаанбаатар хотын музей, Улаанбаатар театр	Улаанбаатар хотын музей, Улаанбаатар театр	1	Улаанбаатар хотын музейг засварлана.	2025-2025	-	130.0	-	-	-	-	130.0	Засвар шинэчлэлтийн ажлын явц, хувь	-	100	130.0	НСУГ	Түүх соёлын дурсгалыг сэргээн засварлах ажлын хүрээнд Улаанбаатар хотын музейн үзүүлэгийн танхимын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Засварын ажлыг дараах байдлаар зохион байгууллаа. Үүнд: 1."Хот төлөвлөлт, судалгааны институт"-тай 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдар ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулж, зураг төслийн ажил бүрэн хийгдэж дууссан. 2.Дээрх зураг төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Яам, Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 34/2025 дугаар барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлт гарч магадлан бүрэн хийгдсэн. 3.Уг төслийг хэрэгжүүлэх 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/256 дугаар захирамж гарч Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдөр НХААГ/20250101603 дугаартай тендер зарлаж "Гурвангис" ХХК шалгаран 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс зураг төслийн дагуу засварын ажлыг эхлүүлээд 07 сарын 30-ний өдөр дуусган, 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн №01 дугаартай "Ажил хүлээлцэх акт" үйлдэн хүлээн авсан.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр: Улс	Эх үүсвэр: Нийслэл	Эх үүсвэр: Дүүрэг	Эх үүсвэр: Гадаад зээл	Эх үүсвэр: Гадаад тусламж	Эх үүсвэр: Төр, хувийн хэвшил	Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он: Зорилтот түвшин	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг) 2025 он: Төсөв (сая төгрөг)	Хэрэгжүүлэх байгууллага: Үндсэн	Хэрэгжилт	Хувь	Биелээгүй шалтгаан
282	театр, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын төв өргөөг засварлан тохижуулж, олон нийтийн тав тухтай үйлчлүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	театр, Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, Соёлын төв өргөөг засварлан тохижуулж, үйлчлүүлж буй иргэдийн тав тухтай орчныг бүрдүүлнэ.	2	Улаанбаатар театрыг засварлана.	2025-2026	-	3,702.1	-	-	-	-	3,702.1	Засвар шинэчлэлтийн ажлын явц, хувь	-	100	3,702.1	НСУГ	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хорооны нутаг дэвсгэрт байрлах “УЛААНБААТАР ТЕАТР” ОНӨТҮГ-ын барилгын их засварын ажлыг “ГОЛОМТ ӨРГӨӨ” ХХК-ий боловсруулсан ГӨ-02/25 шифртэй зураг төслийн дагуу “АТТА ЧР” ХХК нь хийж гүйцэтгэж байгаа ба ажлын баталгаажсан гүйцэтгэл нь 90 хувьтай, гэрээний хугацаа 2025 оын 12 дугаар сарын 25-ны өдөр, гэрээт хугацаанд хийж дуусгахаар төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.	95	
283			3	Улаанбаатар хотын Соёлын төв өргөөг засварлана.	2025-2026	-	7,234.5	-	-	-	-	7,234.5	Засвар шинэчлэлтийн ажлын явц, хувь	10	50	3,634.5	НСУГ	Засвар үйлчилгээний нийт 6 ажлын тендер зарлагдаж, гүйцэтгэгч компаниуд шалгарсан бөгөөд 2025 оны 07 дугаар сараас гүйцэтгэлийн ажил эхэлж, 70 хувьтай явагдаж байна. Түүнчлэн хөгжлийн бэрхшээлтэй иргэд үзвэр үзэх боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх үүднээс байгууллагын инженер, техникийн албан хаагчдын нөөц бололцоонд тулгуурлан тэргэнцэртэй иргэдэд зориулсан налуу замыг “А” байрны төв хаалганы шатны хажууд хийж гүйцэтгэсэн.	100	
284			4	Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн өргөтгөөн шинэчилнэ.	2025-2026	-	-	-	-	17,500.0		17,500.0	Засвар шинэчлэлтийн ажлын явц, хувь	-	30	5,250.0	НСУГ	БНСУ-н Соёл, спорт аялал жуулчлалын яамнаас Хөгжлийн албан ёсны тусалцаа (ODA) төслийн хүрээнд Монгол улсын хүүхэд, өсвөр насны хүүхэд залуучуудад зориулан Номын сангийн өргөтгөлийн барилга барих ажлыг дэмжин хэрэгжүүлж байна. Д. Нацагдоржийн нэрэмжит Улаанбаатар хотын нийтийн төв номын сангийн өргөтгөл барилга нь бүх насны хүмүүст тав тухтай үйлчилгээ үзүүлэхэд оршиж байгаа бөгөөд Үндсэн барилга угсралт, гадна дулаалга, гадна зогсоол бүрэн дууссан. Гадна тохижилт 70%, гадна пасат 70%, гадна цахилгааны шугамын кабель татагдсан, одоогийн байдлаар дулаан болон хэрэглээний ус татах ажлыг ОСНААУГ хийхээр ажиллаж байна. Дотор засал чимэглэлийн тендэр сонгон шалгаруулалт явагдаж нийт 4 компани орсоноос “NICE THINK SERVICE” ХХК 1,991,756,000 төгрөг шалгаран 12 дугаар сараас эхлэн ажиллаж байна.	100	
285	2.4.4.Шинээр байгуулагдах хотуудад соёлын орон зай бүхий соёл, урлагийн олон төрөлт үйлчилгээтэй төвүүдийг бий болгож хүртээмжийг нэмэгдүүлнэ.	Шинэ хотуудад харьяалах соёлын төв, соёлын ордон, соёлын байгууллагуудын үйлчилгээг тэлж, иргэдэд хүргэх соёлын хүртээмжийг нэмэгдүүлнэ.	1	Соёлын үйлчилгээний хүртээмжийг Хотын хөгжлийн индексийн зорилтот түвшинд хүргэж, иргэдийн соёлын боловсролыг дэмжиж, хотын соёлыг бэхжүүлнэ.	2025-2028	-	800.0	-	-	-	-	800.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	65	83	200.0	НСУГ	Нийслэлийн хэмжээнд соёлын хүртээмжийг нэмэгдүүлэх олон улс, улсын хэмжээний томоохон 16 соёл, урлагийн төрөлт тоглолт, үйл ажиллагааг зохион байгуулан 474,829 иргэд, жуулчдад хүргэсэн байна. Түүнчлэн нийслэлийн харьяа 11 байгууллага болон Нийслэлийн Соёл, урлагийн газар 2025 оны байдлаар соёлын байгууллагын бүтээн байгуулалтыг нэмэгдүүлж, засвар үйлчилгээг сайжруулах, соёлын боловсрол олгох, урлагийн олон төрөлт зүйлийг нэмэгдүүлэх, соёлын өвийг дэлгэрүүлэх зэрэг соёл, урлагийн 3977 ажил, үйлчилгээ, үйл ажиллагаа, арга хэмжээг зохион байгуулан давхардсан тоогоор 1,594,379 иргэд жуулчдыг хамруулан, цахимаар 7,404,741 үзэлт, хандалтыг авч соёлын үйлчилгээний хүртээмжийг өмнөх жилтэй харьцуулбал 21,1 хувиар өссөн байна. Тухайлбал, ”Хотын соёл”-ыг төлөвшүүлэх, нийслэлийн иргэдэд соёлын боловсрол түгээх нөлөөллийн арга хэмжээг "Соёл түгээе" уриан дор "Соёлын орон зай бидний орчин" нэртэйгээр бүтээлч аян болгон зарлаж, нийслэлийн 300 гаруй байгууллагууд нэгдэн 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд 221 үйл ажиллагааг зохион байгуулж 58,416 иргэн, залуучуудыг хамруулж, 718 постер, рийлс, контентыг бэлтгэн цахимаар түгээж, 964,720 хандалт, үзэлтийг авсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/727 дугаар захирамжаар ”Монгол хүүхдүүд” Олон улсын хүүхдийн баярын урлагийн тоглолтод “Хотын соёл”-ыг түгээгч хүүхдүүдийн дүрийг бүтээж, “Соёлын түлхүүр”-ээр бяцхан хүүхдүүд нийслэлийн иргэд, ээж аав, ах эгчээ, найзуудаа хотын соёлд уриалсан. Түүнчлэн гэр бүл, хүүхдүүдэд соёлын боловсрол олгохоор байгуулсан 6 хотхонд “Хотын соёл”-ыг сурталчлах соёлын боловсролын хөтөлбөрийг явуулж, давхардсан тоогоор 8250 хүнд хүргэсэн байна. Соёлын үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хүрээнд соёл, урлагийн байгууллагууд засвар тохижилтын ажлыг хийж, иргэдийг тав тухтай үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн. Тухайлбал, Соёлын төв өргөө, Улаанбаатар музей, Улаанбаатар театр засвар тохижилт хийж, Улаанбаатар номын сан өргөтгөлийн барилга барьж байна.	100	
286	2.4.5.Соёл, спорт, аялал жуулчлалын “Улаанбаатар брэнд”-ийг бий болгож, гадаад, дотоодын жуулчдад зориулсан соёл, урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах соёл, спорт, аялал жуулчлалын “Улаанбаатар брэнд” арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.	1	Нийслэлийн хэмжээнд зохион байгуулагдах соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээний нэгдсэн төлөвлөлт гаргаж “Улаанбаатар брэнд”-ийг сурталчлах, хөгжүүлэх, гадаад, дотоодын жуулчдад хүргэнэ.	2025-2028	-	1,200.0	-	-	-	-	1,200.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	1	3	300.0	НСУГ	“Улаанбаатар брэнд”-ийг олон улсад танилцуулах, сурталчлах хүрээнд дараах 3 ажлыг зохион байгуулсан. Үүнд: 1."Улаанбаатар биенналь-2025" дэлхийн хотууд өөрсдийн нэрээр улс орны соёлын үнэлэмж, эрэмбийг олон улсад тогтоодог, Улаанбаатар хотын брэнд үйл ажиллагааг анх удаа зохион байгуулж, ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын сүлжээний 7 төрлийн хүрээнд 19 байршилд 29 улсын 300 гаруй уран бүтээлчдийн 15 үзэсгэлэн, 20 гаруй соёлын нэгдсэн үйл ажиллагааг зохион байгуулж, 60,000 орчим хүнд хүргэсэн. Тус үйл ажиллагааны хүрээнд “Art week” дүрслэх урлагийн 15 үзэсгэлэн гаргаж 2025 оны 06 дугаар сарын 07-20-ны өдрүүдэд үргэлжилж давхардсан тоогоор нийт 16,000 гаруй иргэд, жуулчид үзэсгэлэнгүүдийг үзэж сонирхож, цахимаар 50 гаруй рийлс, фото, ведио контентуудыг нийтлэн 585,900 хандалт авсан байна. 2.“Asian Folk-2025” Азийн хотуудын гар урлал, ардын урлагийн наадам”-ыг Д.Сүхбаатарын талбайд 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулж, тус наадамд нийслэлийн 9 дүүрэг 21 аймгийн 400 гаруй уран бүтээлчид, үндэсний үйлдвэрлэгчид, соёлыг түгээн дэлгэрүүлэгчид Азийн 11 улс орны 170 уран бүтээлчид, гар урлаачид оролцож, уран бүтээлчид оролцсон. Гадаад дотоод уран бүтээлчдийн хамтарсан тоглолт, улс орнуудын үндэсний хувцастай парад, харилцан туршлага солилцох воркшоп зэрэг соёлын олон талт үйл ажиллагаа зохион байгуулагдаж, давхардсан тоогоор талбайн оролцоо 22000 хүнд, цахим мэдээлэл 5 сайт, фэйж хуудсаар 500,000 гаруй хүнд хүрсэн байна. 3.“Улаанбаатар дэйнс 2025” орчин үеийн чөлөөт бүжгийн фестивалийг 2025 оны 06 дугаар сарын 08,14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус тэмцээнд нийт 837 хүүхэд залуучууд бүртгүүлсэн ба үүнээс цахимаар нийт 165, биеэр 672 оролцогч оролцсон.Тэмцээнийг 480 орчим хүүхэд залуучууд хүрэлцэн ирж үзсэн бөгөөд сошиалаар буюу Facebook, Instagram “UB DANCE Festival” өөрсдийн хуудсаар нийт 27,000 үзэгчид үзсэн байна. "Улаанбаатар бренд"-ийг олон улсад танилцуулах хүрээнд 3 арга хэмжээ зохион байгуулж, 700,00 гаруй уран бүтээлчид оролцож, урлаг соёлын эдгээр арга хэмжээг 682480 хүн биечлэн үзсэн бол цахимаар 1,112,900 хүнд хүрсэн.	100	
287		Олон улсын кино наадам, сонгодог урлагийн тоглолтыг жил бүр зохион байгуулж, иргэд, жуулчдыг татах уран бүтээлийн өвөрмөц санг баяжуулна.	2	"Улаанбаатар" олон улсын кино наадам, Сонгодог гала урлагийн тоглолтыг жил бүр зохион байгуулна.	2025-2028	-	1,000.0	-	-	-	-	1,000.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	4	2	250.0	НСУГ	1. 17 дахь удаагийн “Улаанбаатар” олон улсын кино наадам 2025 оны 10 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус наадамд дэлхийн нэр хүндтэй Канн, Берлин, Венец, Торонто, Локарно, Вижн дю Рийл зэрэг наадмуудаас шагнал хүртсэн болон уралдаант хэсэгт сонгогдсон Иран, Франц, Герман, Бразил, Норвег, Хятад, Исланд, Литва, Финланд, Итали, Австрали, Швейцар, Куба, Унгар, Япон зэрэг 17 орны 24 киноны нийт 42 удаагийн үзвэрийг 5,000 орчим гадаад, дотоодын үзэгчдэд 2 театраар дамжуулан толилуулж, үзэгчдийн кино урлагийн талаарх мэдлэг, танин мэдэхүйг дээшлүүлэв. Мөн наадмын шилдгүүдийг шалгаруулж, “Хангарди” монгол уралдааны шилдэг эмэгтэй гол дүрээр О.Дөлгөөн, “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, шилдэг эрэгтэй гол дүрээр Т.Нямдорж, “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, шилдэг зураачаар Н.Болор-Эрдэнэ, “ТАТАР” УСК, шилдэг зураглаачаар Г.Гүенбаатар, “ТАТАР” УСК, шилдэг зохиол: “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, Р.Эрхэмбүрэн, А.Баттүшиг, шилдэг продюсерээр Продюсер Наранбаатар, “B1 ДАВХАР” УСК, шилдэг найруулагчаар Найруулагч Ж.Сэнгэдорж, “ЧИМЭЭГҮЙ ХОТЫН ЖОЛООЧ” УСК, Шилдэг уран сайхны кино: “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, шилдэг баримтат киногоор “Шувуулахуй” кино шалгарсан. Наадмын үеэр хамгийн олон хүнд таалагдсан киног цахим санал хураалтаар тодруулан “Үзэгчдийн нэрэмжит шагнал” олгодог ба энэ жил тус шагналыг найруулагч Батаагийн Энхбаярын 2025 оны “Шувуулахуй" баримтат кино хүртсэн. 2. “Улаанбаатар театр”-ын гоцлол дуучин А.Наранбаатар, А.Отгонболд нарын санаачилсан “DUO TENOR” төслийн хүрээнд дэлхийн сонгодог болон мюзикл бүтээлүүдийг поп оркестртой, Монголын сонгодог дуу болон романс хэлбэрийн бүтээлүүдийг амьд хөгжимтэй хослуулсан цогц илэрхийллийг өөрсдийн дуулах ур чадварт тулгуурлан, орчин цагийн хөгжмийн найруулга, тайз дэлгэцийн шинэлэг шийдэлтэй “DUO TENOR” оператик поп концертыг 2025 оны 11 дүгээр сарын 26,27-ны өдрүүдэд зохион байгуулж 847 хүнд хүргэсэн.	100	
288		Соёлын бүтээлч үйлдвэрлэл	3	"Амар байна уу" сар шинийн баярт зориулсан үзэсгэлэн, соёлын үйл ажиллагааг зохион байгуулна.	2025-2028	-	270.0	-	-	-	-	270.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	1	60.0	НСУГ	“Амар байна уу-2025” сар шинийн баярыг угтсан үзэсгэлэн худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны цогц арга хэмжээг зохион байгуулж, 400 гаруй уран бүтээлч оролцож, 24 удаагийн мэдээ бэлдэж цахимаар 121,494 хүнд түгээсэн. Олны танил 10 уран бүтээлчийн богино хэмжээний видео бичлэг рийлийг цахимаар нийт 920,213 хүн үзсэн байна. “Амар байна уу-2025” үзэсгэлэн худалдаа, хөрөнгө оруулалт, хамтын ажиллагааны цогц арга хэмжээг NTV, Eagle TV, TV5, C1tv гэх мэт 10 телевиз, www.dorgio.mn, www.zaluu.mn, www.sonin.mn, www.unen.mn гэх мэдээ мэдээ мэдээллийн 112 сайт сурвалжлан ажилласан.	100	
289			4	"Их хотын бүсгүйчүүд" хүндэтгэлийн тоглолтын үйл ажиллагааг зохион байгуулна.	2025-2028	-	400.0	-	-	-	-	400.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	1	100.0	НСУГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн А/233 дугаар захирамжийн дагуу нийслэлийн эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй асуудлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн оролцоотой шийдвэрлэх, арга замыг тодорхойлох, тэдний төлөөлөл, дуу хоолой болсон эмэгтэйчүүдийг олон нийтэд таниулах, хүүхэд залуучуудад үлгэр дуурайлал үзүүлэх зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр Нийслэлийн Соёлын төв өргөөний тоглолтын их танхимд “Их хотын бүсгүйчүүд 2025” хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан. Тус хүндэтгэлийн үйл ажиллагаанд нийт 75 уран бүтээлч оролцож, зохион байгуулалтад 62 ажилтан, албан хаагчид ажиллаж, танхимаар 1,300 хүн үзэж сонирхсон бөгөөд NTV телевиз болон Улаанбаатар мэдээ, Zindaa, ASU, 24tsag, Urug, Ergelt мэдээллийн сайтуудар цахимаар шууд дамжуулж 18,000 гаруй хүнд түгээсэн.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
290		эрхлэгчдийг дэмжиж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 төрлийг жигд хөгжүүлнэ.	5	"Улаанбаатар хотын циркийн өдрүүд" үйл ажиллагааг зохион байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	1,418.0	1,418.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	348.0	НСУГ	"Улаанбаатар хотын циркийн өдрүүд 2025" арга хэмжээг Д.Сүхбаатарын талбайд үнэ төлбөргүй зохион байгуулж, 12 хамтлагийн 230 гаруй уран бүтээлчид 7 хоногийн турш 21 удаа тоглосныг нийт 27,900 хүн төв талбайд хүрэлцэн ирж, үзэж сонирхсон.	100	
291			6	"Asian Folk" Азийн хотуудын ардын урлаг, гар урлалын наадмыг болгон зохион байгуулна.	2025-2028	-	1,520.0	-	-	-	-	1,520.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	1	380.0	НСУГ	"Asian Folk-2025" Азийн хотуудын гар урлал, ардын урлагийн наадам"-ыг Д.Сүхбаатарын талбайд 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулж, тус наадамд нийслэлийн 9 дүүрэг 21 аймгийн 400 гаруй уран бүтээлчид, үндэсний үйлдвэрлэгчид, соёлыг түгээн дэлгэрүүлэгчид Азийн 11 улс орны 170 уран бүтээлчид, гар урлаачид оролцсон. Гадаад, дотоод уран бүтээлчдийн хамтарсан тоглолт, улс орнуудын үндэсний хувцастай парад, харилцан туршлага солилцох воркшоп зэрэг соёлын олон талт үйл ажиллагаа зохион байгуулагдаж, давхардсан тоогоор талбайн оролцоо 22000 хүнд, цахим мэдээлэл 5 сайт, фэйж хуудсаар 500,000 гаруй хүнд хүрсэн байна.	100	
292			7	"Улаанбаатар дэйнс" орчин үеийн чөлөөт бүжгийн фестиваль зохион байгуулна.	2025-2028	-	320.0	-	-	-	-	320.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	1	1	80.0	НСУГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/828 дугаар захирамжийн дагуу Соёл, спорт аялал жуулчлалын "Улаанбаатар бренд" арга хэмжээг тогтмолжуулж, гадаад дотоодын жуулчдыг нэмэгдүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4.5, 2.4.6 болон Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 2.6.199, 203-т туссан төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор "Улаанбаатар дэйнс 2025" орчин үеийн чөлөөт бүжгийн фестивалийг 2025 оны 06 дугаар сарын 08,14-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тус тэмцээнд нийт 837 хүүхэд залуучууд бүртгүүлсэн ба үүнээс цахимаар нийт 165, биеэр 672 оролцогч оролцсон. Тэмцээнийг 480 орчим хүүхэд залуучууд хүрэлцэн ирж үзсэн бөгөөд сошиалаар буюу Facebook, Instagram "UB DANCE Festival" өөрсдийн хуудсаар нийт 27,000 үзэгчид үзсэн байна.	100	
293			8	"Ulaanbaatar biennale" Улаанбаатар хотын бренд үйл ажиллагааг зохион байгуулна.	2025-2028	-	1,000.0	-	-	-	-	1,000.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	500.0	НСУГ	"Улаанбаатар биенналь-2025" дэлхийн хотууд өөрсдийн нэрээр улс орны соёлын үнэлэмж, эрэмбийг олон улсад тогтоодог, Улаанбаатар хотын брэнд үйл ажиллагаат анх удаа зохион байгуулж, ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын сүлжээний 7 төрлийн хүрээнд 19 байршилд 29 улсын 300 гаруй уран бүтээлчдийн 15 үзэсгэлэн, 20 гаруй соёлын нэгдсэн үйл ажиллагаат зохион байгуулж, 60,000 орчим хүнд хүргэсэн. Тус үйл ажиллагааны хүрээнд "Art week" дурслах урлагийн 15 үзэсгэлэн гарган, 2025 оны 06 дугаар сарын 07-20-ны өдрүүдэд үргэлжилж, давхардсан тоогоор нийт 16,000 гаруй иргэд, жуулчид үзэсгэлэнгүүдийг үзэж сонирхож, цахимаар 50 гаруй рийлс, фото, видео контентуудыг нийтлэн, 585,900 хандалт авсан байна.	100	
294			9	"Power expo & festival" Монголын автомашин, мотоциклэ, урбан спорт сонирхогчдын нэгдсэн наадамд дэмжлэг үзүүлж, хамтран зохион байгуулна.	2025-2028	-	780.0	-	-	-	-	780.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	1	180.0	НСУГ	"POWER EXPO & FESTIVAL XIII-2025" Авто болон мото спорт сонирхогчдын наадмыг Сонгинохайрхан дүүргийн Авто худалдааны төвд зохион байгуулж, 5 төрлийн 18 ангилалд 7 улсын сонирхогчдын түвшний 289 тамирчин (онцлох 1 хятад тамирчин 7 настай), мэргэжлийн түвшний 73, нийт 362 тамирчид оролцож шилдгүүдээ шалгаруулсан. Тус наадамд 3 өдрийн турш давхардсан тоогоор 50,000 гаруй залуучууд хамрагдсан.	100	
295			10	Юнескогийн бүтээлч хотуудын сүлжээнд элссэн брэндбүүкийн дагуу Улаанбаатар хотын брэнд гарын бэлэг болон 3 төрлийн хөтөлбөрийн загвар төслийг гаргуулна.	2025-2028	-	260.0	-	-	-	-	260.0	Төсөл, загварын тоо	-	1	50.0	НСУГ	Улаанбаатар хот Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол шинжлэх ухаан, соёлын байгууллага (ЮНЕСКО)-ийн "Бүтээлч хотуудын сүлжээ"-нд элссэний дагуу "Бүтээлч Улаанбаатар" сошиал маркетинг, бэлэг дурсгал, самбар сурталчилгаа, хаягжилтын гэх зэрэг 3 төрлийн брэндбүүкийг бий болгож батлуулан үйл ажиллагаандаа ашиглан олон нийтэд фэйсбүүк болон инстаграм хуудсуудыг нээн хөгжүүлж, олон нийтэд хүргэсэн.	100	
296			11	Улаанбаатарын тухай дуу, хөгжмийн бүтээлүүдийг шинэчлэн, иргэд олон нийтэд хүргэнэ.	2025-2028	-	660.0	-	-	-	-	660.0	Бүтээлийн тоо	-	1	150.0	НСУГ	Найрал дууны тайзыг түшиглэн дуурийн урлагаар тогтмол тоглодог ч, ард түмний дунд поп опера буюу U pera урсгалаар хүч түрэн орж ирсэн уран бүтээлч болох Улсын Дуурь Бүжгийн Эрдмийн театрын дуучин А.Анар-Эрдэнэ болон "The Voice of Mongolia" шоуны оролцогч бөгөөд, soul/blues чиглэлээр уран бүтээл туурвидаг уран бүтээлч болох Дуучин Мөнхзул нар хамтран "Улаанбаатарын удэш 2025" тоглолтод оролцож pop, soul/blues чиглэл, жанараар шинэчлэн гаргасан "Улаанбаатар удэш" дуут давхардсан тоогоор 20,000 гаруй үзэгчдэд хүргэж, цахимд шууд дамжуулалтаар 500,000 гаруй хандалтыг авсан байна.	100	
297			12	Үндэсний агуулга шингэсэн уран бүтээлүүдэд дэмжлэг үзүүлнэ.	2025-2028	-	1,520.0	-	-	-	-	1,520.0	Уран бүтээлийн тоо	11	4	380.0	НСУГ	Үндэсний агуулга шингэсэн 2 уран бүтээл, 1 цуврал контентыг дэмжин ажиллаж, үндэсний урлагийг олон улсад сурталчлан ажилласан. Үүнд: - "Хүрээ хөг" шашин, урлагийн дуулал тоглолт, соён гэгээрүүлэх үйл ажиллагаат 2025 оны 04 дүгээр сарын 04-ний "Ханш нээх" өдрийг тохиолдуулан "ACA АРЕНА"-цогцолборт зохион байгуулж, 1,290 иргэд, жуулчид үзэж сонирхсон. - Нийслэлийн Улаанбаатар театртай хамтран "Хархорум" үндэсний агуулга шингэсэн шинэ уран бүтээлийг үзэгчдийн хүртээл болгохоор дэмжин ажиллаж байна. Үндэсний агуулга шингэсэн тус уран бүтээлийн зохиол бичигдсэн бөгөөд хөгжмийн найруулга хийгдэж байна. Тус арга хэмжээний санхүүжилт 2026 оны төсөвт тусгагдсан. - "Хөх дөл" төсөл, "Мөнхөө" баримтат киноны нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж, 1012 хүн оролцсон. "Хөх дөл" нүүдэлчин ахуйн 20 ангит баримтат, реалити цуврал нэвтрүүлэг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Монголын үндэсний олон нийтийн телевизээр олон нийтэд хүрсэн. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд үндэсний соёл, урлагийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Тухайлбал, - Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын захиргааныхаа уламжлал болгон жил бүр зохион байгуулагддаг "Сөүлийн найрамдлын фестиваль" олон улсын арга хэмжээнд Улаанбаатар театрын уран бүтээлчид оролцож, Монгол Улсын үндэсний соёл, урлагийг сурталчилсан. - Монгол Улс, Унгар Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд хөөр орны найрсаг хамтын ажиллагаг хөгжүүлэх, үндэсний соёлын үнэт зүйлсийг сурталчлах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх "Улаанбаатар хотын соёлын өдрүүд"-арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Унгар улс, Будапешт хотод зохион байгуулж, Нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид Монгол түмний бахархал омгошлыг бадраах үндэсний урлагийн тоглолтыг 2 өдрийн турш үнэ төлбөргүй тоглуулсан. Монгол улс, Польш улс хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 75 жилийн ойн хүрээнд нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид Польш улсын нийслэл Варшав хотын удирдлагууд болоод нутгийн иргэд мөн тус улсад ажиллаж, амьдарч буй Монголчуудаа зориулан үндэсний урлагийн тоглолтоо хүргэсэн. - Бүгд Найрамдах Солонгос Улсын соёлын хот болох Гванжу хотод 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Дурсамж-2025" фестивальд Нийслэлийн харьяа Соёл, урлагийн байгууллагуудын 18 уран бүтээлч, албан хаагчид үндэсний урлаг, өв соёлоо таниулан оролцсон. Тус фестивальд жилд дунджаар давхардсан тоогоор 1 сая гаруй иргэд, жуулчид зочлон оролцдог.	100.00	
298			13	"Гэгээн Муза" олон улсын театрын наадмыг зохион байгуулна.	2025-2028	-	250.0	-	-	-	-	250.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	2	1	250.0	НСУГ	"Гэгээн муза 18" олон улсын театрын наадмыг 2 үе шаттайгаар зохион байгуулж, 26 улсаас 300 гаруй уран бүтээлч, 90 гаруй уран бүтээлээр нэр дэвшин өрсөлдөж, шалгаруулалтад 9 улсын 22 бүтээлээр, 89 уран бүтээлч оролцлоо. Тус наадмын шагнал гардуулах ёслолыг шууд дамжуулалтаар иргэдэд хүргэж, танхимаар 1000 гаруй хүн үзэж, цахимаар 49,600 хүнд хүрсэн байна.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
299	2.4.5.Соёл, спорт, аялал жуулчлалын "Улаанбаатар брэнд"-ийг бий болгож, гадаад, дотоодын жуулчдад зориулсан соёл, урлагийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлнэ.	Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 төрлийг жигд хөгжүүлнэ.	14	Ардын урлагийн бүтээлүүдийг шинэчлэн бүтээхэд дэмжлэг үзүүлнэ.	2025-2028	-	620.0	-	-	-	-	620.0	Бүтээлийн тоо	2	1	140.0	НСУГ	Нийслэлийн Соёл, урлагийн газар ардын урлагийн бүтээлийг шинэчилсэн бүтээх ажлын хүрээнд "Хүрээ хөг" шашин урлагийн тоглолтыг санаачлан зохион байгуулж, Улаанбаатар театрын уран бүтээлчид, Зүүн Хүрээ Дашчойлин хийдтэй хамтран ажиллалаа. Тоглолтыг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр "ACA APENA" цогцолборт зохион байгуулж, нийт 1,290 иргэд, жуулчдад хүргэсэн. Тус тоглолт нь үндэсний найрал хөгжим, орчин үеийн болоод сонгодог хөгжим, оркестр буюу симфони найрал хөгжим нь ардын болоод уртын дуутай хэрхэн гайхалтай хоршдогийг сүр жавхлантайгаар үзэгчдэд хүргэснээрээ онцлогтой юм. Жишээлбэл, Монгол ардын уртын дуу "Бор борын бялзуухай" хэмээх домогт уран бүтээлийг шинэчлэн найруулж, СТА Т.Баянжаргал, О.Анхчимэг нар хамтран дуулж, үзэгчдийн хүндэтгэлийг хүлээсэн.	100	
300			15	Бөмбөгөр театрын "Морьтны гайхамшиг" циркчилсэн тоглолтыг зохион байгуулна.	2025-2028	-	3,260.0	-	-	-	-	3,260.0	Зохион байгуулсан тоглолт, тоо	-	1	800.0	НСУГ	LEGEND OF CHINGIS KHAN буюу ЭЗЭН ЧИНГИСИЙН ДУУЛЬ хэмээх Чингис хааны идэр насны нууц түүхийг 60 минутын хугацаатай морьтны гайхамшгийн үзүүлбэр, уран нугаралт зэрэг Монгол үндэсний соёл, ахуй, зан заншлаар чимэглэсэн морьт циркчилсэн тоглолтыг 2025 оны 07дугаар сарын 11-ний өдрөөс 07 дугаар сарын 24-ний өдрүүдэд Хүй долооо худагт байрлах Бөмбөрцөг театрт 45 уран бүтээлчид, баг хамт олны бүрэлдэхүүнтэй 30 гаруй удаа зохион байгуулж гадаад, дотоодын жуулчид үзэгчдэд хүргэсэн байна. Тус тоглолтыг 2025 оны 08 дугаар сарын 09-ний өдрөөс 09 дүгээр сарыг дуустал Цонжин болог- Уухайн дуу camp-д үргэлжлүүлэн зохион байгуулж 3000 жуулчин, 1500 дотоодын үзэгчдэд хүргэсэн.	100	
301			16	"Хар хорум" мюзикл бүтээж иргэд, жуулчдад хүргэхэд дэмжлэг үзүүлнэ.	2025-2028	-	1,660.0	-	-	-	-	1,660.0	Зохион байгуулсан тоглолт, тоо	-	1	400.0	НСУГ	"ХАРХОРУМ" үндэсний агуулга шингэсэн шинэ уран бүтээлийг Нийслэлийн Улаанбаатар театртай хамтран үзэгчдийн хүртээл болгохоор дэмжин ажиллаж байна. Үндэсний агуулга шингэсэн тус уран бүтээлийн зохиол бичигдсэн бөгөөд хөгжмийн найруулга хийгдсэн. Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд 500.0 төгрөгийн төсөв тусгасан болно.	84	
302			17	"Улаанбаатар" олон улсын кино наадам, Сонгодог урлагийн гала фестивалийг зохион байгуулна.	2025-2028	-	1,300.0	-	-	-	-	1,300.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	4	1	250.0	НСУГ	2 дахь арга хэмжээтэй давхардсан.	ХБ	
303			18	Д.Лувсаншаравын нэрэмжит "Хүүхдийн найрал дууны улсын уралдаант наадам" зохион байгуулна.	2025-2028	-	740.0	-	-	-	-	740.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	5	1	200.0	НСУГ	Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдөр Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны 31 дэх удаагийн улсын уралдаант наадам зохион байгуулах тухай удирдамжийг батлсан. Нийслэлийн Соёл, урлагийн газрын 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн 01/20 дугаар "Хамтран ажиллах тухай" албан бичгээр аймгуудын Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газарт уралдааны удирдамжийг, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 03 дугаар сарын 18-ний өдрийн 03/1596 дугаар "Хамтран ажиллах тухай" албан бичгийг Аймгуудын Засаг даргын Тамгын газарт тус тус хүргүүлсэн. Батлагдсан удирдамжийн дагуу 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын Хүүхэлдэйн театрт "Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны 31 дэх удаагийн улсын уралдаант наадмын мастер сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн 116 багш танхимаар оролцож, хөдөө орон нутгаас ерөнхий боловсролын сургуулийн 312 багш цахимаар оролцсон. Мөн 14 аймагт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны 31 дэх удаагийн улсын уралдаант наадмын анхан шатны шалгаруулалтыг зохион байгуулсан. Нийслэл Улаанбаатар хотын өдрийг угтан жил бүрийн 10 дугаар сард зохион байгуулагддаг тус наадам нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 16- ны өдрийн 194 дүгээр тогтоолоор "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдрийг жил бүрийн 6 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Бямба, Ням гараг"-т тэмдэглэх болсонтой холбогдуулан Нийслэлийн Иргэдийн баярыг угтан зохион байгуулах нэгдсэн үйл ажиллагаат 2026 оны хавар зохион байгуулах тухай шийдвэр гарсантай холбогдуулан тус наадмыг 2026 оны хавар зохион байгуулахаар төлөвлөж, нийслэлийн 2026 хөгжлийн төлөвлөгөөнд 350.0 төгрөгөөр тусгагдсан.	95	
304			19	"Хотын соёл" зорилтот нөлөөллийн үйл ажиллагаат зохион байгуулна.	2025-2028	-	800.0	-	-	-	-	800.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	4	200.0	НСУГ	Хотын соёлт иргэнийг төлөвшүүлэх чиглэлээр соёл урлагийн олон талт арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж байна. Үүнд: 1.Нийслэлийн нутаг дэвсгэрт харьяалагдах соёл, урлагийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд 2025 онд 3977 сургалт, багц ажил, урлаг соёлын үзвэр үйлчилгээг 529,073 иргэнд хүргэж ажилласан. 2."Хотын соёл" нэгдсэн үйл ажиллагааны хөтөлбөрийг Нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн арга зүйн дэмжлэгтэйгээр боловсруулж, "Хотын соёл"-ыг төлөвшүүлэх асуудлаар 148 байгууллага, иргэнээс санал авч нэгтгэн, 2025-2028, 2028-2040 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөлт, зардлын тооцоолол, үр дүнгийн зураглал гаргаж Нийслэлийн удирдах ажилтнуудад танилцуулсан. 3."Хотын соёл"-ыг төлөвшүүлэх, нийслэлийн иргэдэд соёлын боловсрол түгээх нөлөөллийн арга хэмжээг "Соёл түгээе" ориан дор "Соёлын орон зай бидний орчин" нэртэйгээр бүтээлч аян болгон зарлаж, нийслэлийн 300 гаруй байгууллагууд нэгдэн 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд 221 үйл ажиллагааг зохион байгуулж 58,416 иргэн, залуучуудыг хамруулж, 718 постер, рийлс, контентыг бэлтгэн цахимаар түгээж, 964,720 хандалт, үзэлтийг авсан. 4.Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/727 дугаар захирамжаар "Монгол хүүхдүүд" Олон улсын хүүхдийн баярын урлагийн тоглолтод "Хотын соёл"-ыг түгээгч хүүхдүүдийн дурийг бүтээж, "Соёлын түлхүүр"-ээр бяцхан хүүхдүүд нийслэлийн иргэд, эөж аав, ах эгчээ, найзуудаа хотын соёлд уриалсан. Үүнчлэн гэр бүл, хүүхдүүдэд соёлын боловсрол олгохоор байгуулсан 6 хотхонд "Хотын соёл"-ыг сурталчлах соёлын боловсролын хөтөлбөрийг явуулж, давхардсан тоогоор 8250 хүнд хүргэсэн байна. Үр дүн: Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдэд хотын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр 2025 онд 3977 арга хэмжээ зохион байгуулж, 529.073 хүнд хүргэсэн. Цахимаар 718 контент түгээж, 964,720 хандалт авсан байна.	100	
305			20	Шинэ жилийн "Улаанбаатарын менгөн шөнө" баярын үйл ажиллагаат зохион байгуулна.	2025-2028	-	1,600.0	-	-	-	-	1,600.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	5	1	400.0	НСУГ	Нийслэлийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баярыг тэмдэглэн өнөрүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн анхдугаар хурал 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулагдсан. "Нийслэлийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баярыг тэмдэглэн өнөрүүлэх ажлыг зохион байгуулах нэгдсэн" төлөвлөгөө"-г боловсруулж, 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдөр Ажлын хэсгийн дарга батлуулсан болно. "УЛААНБААТАРЫН МӨНГӨН ШӨНӨ 2025" шоу тоглолтыг "Бүтээлч хот – шинэ улаанбаатар" ориан дор зохион байгуулж, шинэ оноо угтан нийслэлчүүдийн эв нэгдэл, хамтын хүч, бүтээлч сэтгэлгээг харуулах, монгол бахархлыг сурталчлах мөн "шинэ-улаанбаатар" хотыг дэлхийн жишигт нийцсэн, соёл, урлаг, технологийн өндөр түвшний хот болгон хөгжүүлэх зорилгыг олон нийтэд хүргэхэд оршино.	100	
306			21	Зүүн Азийн залуучуудын чуулга уулзалтыг JCI-тай хамтран зохион байгуулна.	2025	-	500.0	-	-	-	-	500.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	500.0	НСУГ	Ази, Номхон далайн бүсийн "Аспак-2025" чуулга уулзалтыг 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, дэлхийн 70 гаруй улсын 5000 орчим төлөөлөгч оролцсон. Уулзалтын үеэр хэлэлцүүлэг, эвент, соёл урлагийн арга хэмжээнүүд зохион байгуулагдсан.	100	
307			22	Улаанбаатар хотод Гадаад уран бүтээлчдийн шоу тоглолт зохион байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1		НСУГ	"Улаанбаатар Сонос" олон улсын хөгжмийн наадмын тайзнаа 5 улсын 25 артистын тоглолтыг 2025 оны 08 дугаар сарын 02-ны өдөр Төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж, 10,000 гаруй хүнд хүргэсэн.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
308			23	"Авьяаслаг Улаанбаатар уралдаан" зохион байгуулна.	2025-2028	-	1,000.0	-	-	-	-	1,000.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	800.0	НСУГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/444 дүгээр захирамжийн дагуу "Монголын соёлын ижилсэл, ондоошлыг илэрхийлсэн уран бүтээл, уран бүтээлчийг дэмжиж "Авьяаслаг, бүтээлч нийслэлийн иргэнийг төлөвшүүлэх" хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монголын бүжгийн спортын тамирчид, дасгалжуулагчдын ур чадварыг дээшлүүлэх, мэргэжлийн холбоо болон хамтлагуудын өрсөлдөх чадварыг олон улсын түвшинд хүргэх зорилгоор "Улаанбаатар хотын бүжгийн спортын аварга шалгаруулах XXI тэмцээн"-ийг 2025 оны 04 дүгээр сарын 26-нд зохион байгуулагдаж мэргэжлийн бүжгийн спортын холбооны гишүүн клубууд болон өрөнхий боловсролын сургуулиудын бүжгийн хамтлагуудаас бүрдсэн 14 байгуллагын 800 гаруй бүжгийн спорт сонирхогч, хичээллэгчид оролцож, шилдгүүдээ тодруулсан. Түүнчлэн "Хөх дөл" төсөл, Мөнхөө" баримтат киноны нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж, үйл ажиллагаат танхимаар 1012 хүн үзэж, төслийн талаарх 13 видео, танилцуулга мэдээллийг байгуллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар 8,820 хүн, "Аагий Номуун", "Fam Team" фэйсбүүк хуудсаар 785,513 хүн, давхардсан тоогоор нийт 794,333 хүнд дамжуулан хүргэж, мэдээллийгн 40 вебсайт, 3 телевизээр олон нийтэд түгээсэн. Нийслэлийн иргэдэд зориулж, үнэ төлбөргүй хүргэсэн" Улаанбаатар хотын циркийн өдрүүд 2025" үйл ажиллагаат 2025 оны 04 дүгээр сарын 16-22-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд үнэ төлбөргүй зохион байгуулж, циркийн тоглолтод циркийн 12 хамтлагийн 230 гаруй уран бүтээлчид оролцож,7 хоногийн турш 21 удаа тоглосныг нийт 27,900 хүн төв талбайн асарт цуглаж үзсэнээс хүүхэд 13,100, насанд хүрэгчид 16,800, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 600 байсан бөгөөд өсвөр үе хүүхэд багачуудад циркийн урлагийг таниулах, сурталчлах нөлөөллийн үйл ажиллагаа болсноороо онцлог юм.	100	
309		Үндэсний эв нэгдэл, Монгол өв соёлыг сурталчилна.	24	Нүүдэлчин ахуйн цуврал контентуудыг хийж, телевизийн сувгууд болон сошиал хуудсуудаар түгээж, олон нийтэд үндэсний өв соёлоо сурталчилна.	2025-2028	-	1,260.0	-	-	-	-	1,260.0	Контент, цахим хандалтын тоо	-	1	300.0	НСУГ	"Хөх дөл" төсөл, "Мөнхөө" баримтат киноны нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр "Корпорейт конвейншин центр"-ийн концертын их танхимд зохион байгуулагдсан. Үйл ажиллагаат танхимаар 1012 хүн үзэж, төслийн талаарх 13 видео, танилцуулга мэдээллийг байгуллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар 8,820 хүн, "Аагий Номуун", "Fam Team" фэйсбүүк хуудсаар 785,513 хүн, давхардсан тоогоор нийт 794,333 хүнд дамжуулан хүргэж, мэдээллийг 40 вебсайт, 3 телевизээр олон нийтэд түгээсэн. "Хөх Дөл" 20 ангит нүүдэлчин ахуй цуврал контент нь "Өлзий" телевизээр 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрөөс давталтын дугаартайгаа нийт 40 удаа үзэгчдийн хүртээл болсон. Монголын Үндэсний Олон нийтийн суваг, MNB world , MNB гэр бүл сувгуудаар 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн гарсан бөгөөд нийт 3 сувгаар давталтын дугаартай нийт 120 удаа гарсан. UBS телевизээр давталтын дугаартай нийт 40 удаа гарч үзэгчдийн хүртээл болсон.	100	
310			25	"Нүүдэлчин" өвлийн соёлын фестивалийг зохион байгуулна.	2025-2028	-	1,660.0	-	-	-	-	1,660.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	400.0	НСУГ	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд "Монгол нүүдэлчин өвлийн фестиваль"-ийг анх удаа зохион байгуулж, нийслэлийн 43 аж ахуйн нэгж, иргэнтэй хамтран, нийтлэг үйлчилгээ, тээвэр ложистикийн ажлыг 100 хүнд хариуцан гүйцэтгэсэн. Энэ хүрээнд 129 удаагийн ажлын уулзалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 86 албан бичгийг хамтарч ажиллах байгууллагуудад хүргүүлж, 43 байгуллагатай гэрээ байгуулж, санхүүжилтийг шилжүүлж, гүйцэтгэлийг хянаж, ажлын тайланг нэгтгэсэн. Иргэд жуулчдад соёлын өвийг сурталчлан таниулах зориглготой "Цагаан сар" өргөөг хариуцан ажиллаж, 17,662 иргэд, жуулчдад соёлын үйлчилгээ үзүүлж, ардын авьяастнуудын тоглолт цахим орчинд контент хэлбэрээр 22,960 хүнд хүрсэн байна.	100	
311	2.4.6.Дэлхийн Бүтээлч хотуудын сүлжээнд нэгдсэн 350 гаруй хотуудтай хамтран ажиллах "Бүтээлч хот" зорилтот төслийг хэрэгжүүлж, гар урлал, кино урлаг, хөгжим, уран бүтээл, хоол үйлдвэрлэл, дизайн зэрэг бүтээлч салбаруудын эдийн засгийг тэлнэ.	Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 төрлийг жигд хөгжүүлнэ.	1	"Бүтээлч хот" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн нэгдсэн санг хөгжүүлнэ.	2025-2028	-	115.0	-	-	-	-	115.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	1	20.0	НСУГ	Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн суурь судалгааг гаргаж, нэгтгэн, нийт 1787 иргэнийг бүртгэлд хамруулж, Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн 6 модуль, 10 агуулга бүхий цахим болон танхим сургалт, сургалтын контентыг боловсруулан 7100 хүнд, цахимаар 35,500 хүнд, нийт 42,600 хүнд хүрэн ажилласан.	100	
312			2	"Бүтээлч хот" төслийг хэрэгжүүлж, иргэдийн бүтээлч хандлага, сэтгэлгээг хөгжүүлэх, урамшуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	5	5		НСУГ	"Бүтээлч хот" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх 6 чиглэлийг хөгжүүлж, иргэдийн соёлын боловсрол, бүтээлч хандлагыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. 2025 онд дараах үйл ажиллагаат зохион байгуулаа. Үүнд: 1. "Соёлын биет бус өвийн 7 ай сав"-ын хүрээнд соёлын биет бус өв, соёлын боловсролын хөтөлбөрийг таниулан сурталчлах, арьс, эсгий урлал, үндэсний хувцасны ойдол сурталчлан таниулах, хэрэглээний өндөр ач холбогдлыг тайлбарлах, түүгээр дамжуулан язгуур соёлоо өвлүүлэн уламжлуулах зорилгоор Улаанбаатар хотын харьяат шилдэг гар урлачид, уран бүтээлчдийн нийт 16 шавь сургалтыг 2,522 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. 2. Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих зорилгоор нийслэлийн дүүрэг, хороо, соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, амжилтыг олон нийтэд сурталчлан таниулж, урамшуулах зорилгоор "Бүтээлч хот" уралдааныг зохион байгуулсан. 3. Гадаад улс орнуудад зохион байгуулагдах гар урлал, ардын урлагийн уралдаан, наадам, фестиваль, үйл ажиллагаанд Улаанбаатар хотын харьяат урлаачид, уран бүтээлчдийг оролцуулахад 125 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан байна. 4. Нийслэлийн засаг даргын ивээл дор "Asian Folk-2025" Азийн хотуудын гар урлал, ардын урлагийн наадам"-ыг Азийн 11 улс орны 170 уран бүтээлчид, гар урлаачид оролцож, гадаад, дотоодын уран бүтээлчид оролцсон. 5. "Бүтээлч Улаанбаатар" брэндинг, логог мэргэжлийн байгууллагатай хамтран бүтээж, иргэд, олон нийт, гадаад, дотоодын жуулчдад таниулах, сурталчлах 3 контент бүтээж, байгууллагын үйл ажиллагаанд хэрэглэж байна. 6. Соёлын бүтээлч үйлдвэрлэлээс "медиа арт" урлагийг тэргүүлэн хөгжүүлэхэд анхаарч Бүтээлч хотуудын сүлжээнд соёл, урлагийн олон төрлөөр манлайлдаг БНСУ-ын нэр уран бүтээлч И Нам-ын "Тал нутгийн гэрэл" медиа арт үзэсгэлэнг монголын түүх, өв соёл, уламжлалыг харуулсан 3 контентыг ардын урлагийн "Бэртэ" хамтлагийн уран бүтээл, хөгжмийн аялгуутай хамтатган бүтээж, Чингис хаан музейд 14 хоногийн турш гаргаж,7285 хүнд хүргэсэн. Мөн тус чиглэлээр 124 өсвөр насны сурагчдыг сургалтад хамруулсан. 7. "Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт"-ыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Тусгаар тогтнолын ордонд зохион байгуулсан бөгөөд 300 гаруй соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих, эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг асуудлаар саналаа солилцлоо. 8. "Бүтээлч залуу, бүтээлч ирээдүй" залуучууд, өсвөр үеийнхний соён гэгээрүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааны хүрээнд хэлэлцүүлэг, өдөрлөгийг оюутан залуучуудын бүтээлч хандлага, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, цагийн ажил, жижиг бизнес эрхэлэх ажлыг дэмжиж, зохион байгуулсан өдөрлөг арга хэмжээнд 6 их дээд сургуулийн 400 гаруй оюутан залуучууд 28 төрлийн бараа бүтээгдэхүүн 34 чиглэлийн байгууллагын таницуулгыг түгээж, сурталчилсан бөгөөд тус үйл ажиллагаанд нийт 2492 залуус хамрагдсан.	100	
Зорилтын үр дүн: 2.5.Хөгжлөөс хэнийг ч орхигдуулахгүй байх зарчмыг баримтлан хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжиж, идэвхтэй, бүтээлч иргэнийг төлөвшүүлж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангийн "Хүүхдэд ээлтэй хот" санаачилгыг дэмжинэ.																				

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
313	2.5.1.Гэр бүлийн хөгжлийг цогц үйлчилгээний төвийг нутаг дэвсгэрийн нэгж бүрд тер, хувийн хэвшлийн түншлэлээр ажиллуулж, гэр бүлийн боловсрол олгох, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, гэр бүлийн гишүүдийн ёс зүйн хариуцлагыг дээшлүүлж, хөгжих орчин нөхцөлийг бүрдүүлнэ.	Хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжин гэр бүлийн эерэг харилцаат бэхжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлж, хамрагдалтыг өссөн дүнгээр 20 хувиар нэмэгдүүлнэ.	1	Хүүхэд гэр бүлийн хөгжлийг дэмжин гэр бүлийн эерэг харилцаат бэхжүүлэх сургалт, нөлөөллийн ажлыг эрчимжүүлж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Хамрагдсан хүний тоо	229,761	270,000		Дүүргүүд	Багануур дүүрэг: Гэр бүлийн боловсрол олгох 6 модуль сургалтыг 8 удаа зохион байгуулж, 10 байгууллагын 570 албан хаагчийг, “Гэр бүл төлөвлөлт” сэдэвт сургалтыг 10 удаа зохион байгуулж ерөнхий боловсролын 9-12 дугаар ангийн 742 сурагчдыг тус тус хамруулсан. “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сэдэвт цахим хичээлийг bnd.gob.mn вэб сайтад байршуулж 626 хүнд хүргэж ажиллалаа. Мөн “Жаргалтай эзэж” үйл ажиллагаанд 50 иргэн, “Гэр бүл үнэ цэн хариуцлага” үйл ажиллагаанд 150 иргэн, “Эрүүл гэр бүл бидний аз жаргал “Хүүхэд хамгаалалд эцэг эхийн оролцоо”үйл ажиллагаанд-300 иргэн, 4 нөлөөллийн үйл ажиллагаанд 500 иргэнийг хамруулсан. Танхимын 18 сургалт, 1 цахим хичээл, 4 удаагийн нөлөөллийн ажлуудыг үе шаттайгаар зохион байгуулж, нийт 2438 иргэдийг хамруулсан. БЗД: Тайлант хугацаанд Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүд болон хороодоор дамжуулан дүүргийн хэмжээнд нийт 65 удаагийн сургалт, соён гэгээрүүлэх сурталчилгаа, өдөрлөг, нөлөөллийн арга хэмжээнд 15,025 хүнийг хамруулж, цахим хуудаснуудаар дамжуулан 4,805 хүнд мэдээлэл хүргэж ажилласан. Үүнээс: Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдийн үйл ажиллагаагаар дамжуулан гэр бүлийн боловсрол олгох 27 удаагийн сургалтыг хийж, 2640 багш, төрийн албан хаагч, 4953 эцэг, эх, асран хамгаалагчдыг, нийт 7593 хүнийг хамруулсан. Мөн хороодоор дамжуулан “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг 28 хороо нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулахад 1255 хүнийг, Гүүднэйборс Олон Улсын төсөл хэрэгжүүлэгч 5, 19, 22, 24 дүгээр хороод модуль сургалтад 615 хүнийг, хороод бүсчилсэн 6 удаагийн сургалт, өдөрлөгийн арга хэмжээгээр 5562 хүнийг хамруулсан. Мөн Сургууль, цэцэрлэг, цэргийн анги, цагдаагийн байгууллагуудад 23 удаагийн сургалтуудыг зохион байгуулж 5,943 албан хаагч, багш, эцэг эх, асран хамгаалагчдыг хамруулан ажилласан. Дүүргийн Цагдаагийн 1 дүгээр хэлтэс, Даймонд Майнд ТББ, Монголын сайн дурынхны төв ТББ, дүүргийн Улаан загалмай дунд шатны хороо, "Ирээдүй Монгол" ТББ-уудтай тус тус хамтран 17 удаагийн өдөрлөг, соён гэгээрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулан 7,413 иргэдийг хамруулан ажилласан. БГД: Гэр бүлийн боловсрол олгох, соён гэгээрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах чиглэлээр 50 арга хэмжээ зохион байгуулж, 130 зурагт хуудсыг хэлтсийн цахим хуудаст байршуулж, танхимаар 3815 иргэнийг, цахимаар 239,751 иргэнд тус тус хүрч ажиллалаа. Дүүргийн хэмжээнд холбогдох байгууллагуудтай хамтран 36,699 хүүхдийн хөгжлийг дэмжин ажиллаж, дүүргийн нийт хүүхдийн 38,2 хувьд хүрсэн байна. ЧД: Дүүргийн Цагдаагийн газар болон “Даймонд Майнд” ТББ-тай хамтран “Жаргалтай эзэж”, “Гэр бүлийн үнэ цэнэ”, “Хүүхэдтэйгээ суралцдаг эзэж”, “Өөртөө итгэлтэй аз жаргалтай эзэйн үндэс” " сэдэвт нийт 4 сургалтыг зохион байгуулж, 300 иргэнийг хамруулсан. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан “Хайр дүүрэн гэр бүл” эвент, Хайр шингэсэн захидал, “Аз жаргалтай гэр бүл” рийл бичлэгийн уралдаан, Гэр бүлийн өдөрлөг арга хэмжээг тус тус зохион байгуулж, нийт 1500 гаруй иргэнийг хамруулсан.“Зөв дадал” ТББ-тай хамтран хүүхэд, гэр бүлийн хөгжлийг дэмжих, хорт бодис, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Урам” зорилтод төслийг хэрэгжүүлж, 50 гэр бүлийг 12 модуль сургалтад хамруулсан.“Амьдралын луужин” ТББ-тай хамтран дүүргийн Өсвөр насны хүүхдүүдийг суралцах үйлд идэвхитэй оролцоог хангах зорилгоор “Үе тэнгийн туслалцаа” төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ерөнхий боловсролын сургуулийн 7-9 дүгээр ангийн 216 сурагчийг хамруулсан.“Өв уламжилалаа үр хойчдоо уламжлах холбоо” ТББ-тай хамтран “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл” арга хэмжээний хүрээнд сургалт зохион байгуулж, 9 сургуулийн 328 сурагч, эцэг эхийн төлөөллийг хамруулсан. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан "Даймонд майнд академи"-тай хамтран "Хайр дүүрэн гэр бүл" арга хэмжээг зохион байгуулж, 24 гэр бүлийн 72 хүнийг хамруулсан. Багахангай дүүрэг: Хөдөлмөр, нийгмийн хамгаллын сайдын 2019 оны А/122 дугаар тушаалаар батлагдсан Гэр бүлийн боловсрол олгох сургалтын хөтөлбөрийн бүтэц, агуулгын дагуу 20 удаагийн сургалтыг 38 байгуллагад зохион байгуулж давхардсан тоогоор 1250 иргэнийг хамрууллаа. Мөн дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг хувийн хэвшлийн худалдаа, үйлчилгээ, үйлдвэрийн бусийн 9 байгуллагын 280 иргэн, зорилтот 22 өрхийн 47 иргэнийг хамруулан гэр бүлийн боловсрол олгох 8 модул сургалтыг үе шаттай зохион байгуулж 5,1 сая төгрөг зарцуулав. СХД: “Эрүүл, жаргалтай гэр бүл” нөлөөллийн үйл ажиллагааг цуврал байдлаар 2 удаа зохион байгуулж залуу гэр бүлийн төлөөлөл болсон 300 гаруй иргэдийг хамруулсан. “Дайманд Майнд” академь, Гэрлэх ёслолын өргөөтэй хамтран “Жаргалтай эзэж” сэдэвт сургалтыг зохион байгуулж зорилтот бүлгийн 150 гаруй эзэгчүүдэд Сэтгэл зүйн зөвлөгөө, хувь хүний хөгжлийн харилцааны уян хатан чадварыг хөгжүүлэхтэй холбоотой мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх сургалтыг зохион байгуулсан. “Олон улсын гэр бүлийн өдөр”-ийг тохиолдуулан “Нарру art” урлантай хамтран “Гэр бүл - хамгийн сайхан бүтээл” урлагийн сэтгэл заслын хөтөлбөрийг хэрэгжүүлж 50 гаруй төрийн албан хаагчдыг хамруулсан. Дүүргийн гэрлэх ёслолын өргөөнд 8 алтан хурим, 38 залуу хосын нийт 46 ёслолын арга хэмжээг зохион байгуулсан. “ХАЙР ӨВТГӨХ УЧИРГҮЙ”-1 нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж Цагдаагийн газраас давтамжтай дуудлага мэдээлэлтэй 20 өрхийн 50 иргэнийг хамруулж “Хайр дүүрэн гэр бүл” сэдвээр иргэдтэй уулзалт ярилцлага хийж “Нарру art” урлан урлагийн сэтгэл заслын үйлчилгээ үзүүлсэн. "ХАЙР ӨВТГӨХ УЧИРГҮЙ"-2, 3, 4 арга хэмжээг цувралаар хийж 213 иргэнийг хамруулаад байна. СБД: Гэр бүлд зөвлөгөө өгөх төвөөр дамжуулан насанд хүрсэн 42 иргэн, 394 хүүхэд, нийт 436 иргэнд сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлж, Сар бүрийн гэр бүлийн өдрийг тохиолдуулан 820 иргэн, Гэр бүлийн боловсрол олгох сургалтыг танхимаар 1620, цахимаар 6400, нийт 8020 иргэнийг хамруулан ажилласан. Гэр бүлийн олон талт арга хэмжээнд дүүргийн нийт 9712 иргэн хамруулсан. Шүүх шинжилгээний ерөнхий газрын албан хаагчдад 2025 оны 10 дугаар сарын 18-ны өдөр "Гэр бүлийн үнэ цэнэ" сэдэвт сургалт зохион байгуулж, Гэр бүлийн үнэ цэнээ тодорхойлох, Гэр бүлийн харилцаагаа эрүүл байлгах нь сэдэвт сургалтад 50 гаруй албан хаагчийг хамруулсан.	95	
314			2	Хүний хөгжлийг дэмжсэн нийгмийн суурь үйлчилгээг нэг дор цогц байдлаар үзүүлэх "Цогц хөгжлийн төв"-ийг 2 байршилд шинээр байгуулна.	2025-2028		10,000.0					10,000.0	Төв байгуулах ажлын явц, хувь	-	10	500.0	НЗДТГ	Хэрэгжилт ирүүлээгүй.	ХБ	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
315			3	Хүүхдийн тоглоомын талбайн стандартыг хангуулж, арчлалт, үйлчилгээг оршин суугчдын оролцоотойгоор тоглоомын талбайн аюулгүй байдлыг хангана.	2025-2028	-	200.0	-	-	-	-	200.0	Стандартын хэрэгжилтийн хувь	40	45	50.0	Дүүргүүд	Багануур дүүрэг: Орон сууц, гэр хороллын хүүхдийн тоглоомын талбайг сэргээн засварлах ажлыг "Багануур тохижилт" ААТҮГ хариуцан ажилладаг бөгөөд энэ онд Уурхайн нийтийн байр, 1-5 дугаар байр, 10-16 дугаар байрнуудын дундах хүүхдийн тоглоомын талбайн 8 сүүдрэвч, 3 гулсуур, сагсан бөмбөгийн шит-3, сандал 5-ыг шинээр суурилуулж, шат, бялдаржуулах төхөөрөмж, хашаа, хиймэл зүлэг, тоглоомын холбоос боолт зэрэг 14 байршлын хүүхдийн тоглоомын талбайн стандарыг ханган засвар үйлчилгээг хийж гүйцэтгэжд байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/560 дугаар захирамжийн хүрээнд 2 дугаар хорооны хүүхдийн тоглоомын талбай, 3 дугаар хороо Төмөр зам хэсэг, 5 дугаар хороо Бага гүн хэсгийн хүүхдийн тоглоомын талбайн засварлах ажлыг хийж гүйцэтгэжд байна. БГД: "Хичээл эхэллээ" аяны хүрээнд 15 тоглоомын талбайд хяналт шалгалт хийж, хяналтын камер байхгүй, тоглоомын талбайн шал хуулларсан 2 зөрчил илрүүлж холбогдох байгуулагад уламжилж нийт 5 камер шинээр суурилуулан, эвдэрсэн шалыг засварлуулан зөрчлийг арилгуулж стандартын хэрэгжилтийг хангуулсан. НАЛАЙХ: Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/560 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбай дахь хүүхдийн тоглоомын талбайг засварлах, шинэчлэх, аюулгүй байдлыг хангуулах ажлыг зохион байгуулсан. Нийт 26 тоглоомын талбайг засварлан аюулгүй байдлыг хангуулж, шинээр 2 тоглоомын талбай байгуулсан. ЧД: Хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, өсөж хөгжих нөхцөлийг бүрдүүлэх, хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангах, тоглоомын талбай, гадна дотор орчны аюулгүй байдалд хяналт шинжилгээ үнэлгээ хийж зөрчлийг арилгуулах зорилгоор Дүүргийн Засаг даргын 2025 оны А/211 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдаж, 1-24 дүгээр хороодын нутаг дэвсгэр дэх нийтийн эзэмшлийн тоглоомын талбай 98, ерөнхий боловсролын сургуулийн 23, цэцэрлэгийн 47, нийт 168 хүүхдийн тоглоомын талбайд хяналт шалгалт хийж, 22 тоглоомын талбайг засварлуулах шаардлагатай байсан тул илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээг авсан. Багахангай дүүрэг: Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237, дүүргийн Засаг даргын А/47 дугаар захирамжийн хүрээнд дүүргийн 1, 2 дугаар хороонд "Орчны аюулгүй байдлыг хангах" үзлэг, шалгалтыг 4 удаа зохион байгуулав. Хүүхдийн нэгдсэн тоглоомын талбайн аюулгүй байдлыг тогтмол хянах үед нийт 90 зөрчил илэрсэн бөгөөд тэдгээрээс 87 зөрчлийг арилгуулав. СХД: Дүүргийн Засаг даргын А/223 дугаар захирамжаар иргэдийн эрүүл аюулгүй амьдрах орчныг сайжруулах ажлын хүрээнд 2, 8, 10, 11, 12, 13, 22, 27, 32, 34, 35, 41, 42 дугаар хороодын нийтийн эзэмшлийн талбайд 13 хүүхдийн тоглоомын талбайг засварласан. Дүүргийн төсвийн хөрөнгө, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 4, 16, 20, 21, 31, 38, 39 дүгээр хороодын 9 байршилд засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн арчлалт, үйлчилгээг СӨХ, Хороо, Дэд бүтэц хөгжлийн алба ОНӨААТҮГ-т хариуцуулж ээлжүүлсэн. Хүүхдийн тоглоомын талбайн аюулгүй байдалд хяналт шалгалт хийж 13 байршлын 83 төрлийн тоног төхөөрөмжийг актлах шаардлагатай эд хөрөнгийн жагсаалтыг гаргаж хариуцагч байгууллагад хүргүүлсэн. СБД: Дүүргийн 1-20 дугаар хороонд Төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 186 байршлын 123254,34м2 талбайн 153 ширхэг сүүдрэвч 4405м2 хүүхдийн тоглоом, 397 ширхэг чийрэгжүүлэлтийн төхөөрөмж 836 ширхэг сандал, 452 ширхэг хогийн сав, 17106м2 спорт талбайн засвар үйлчилгээг хийлгэхээр Ургамлын далай ХХК гэрээ байгуулан 7 хоногт 3-4 удаагийн давтамжтайгаар цэвэрлэгээ, үйлчилгээг хийлгэн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан.	95	
331	3.2.3.Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлж	Газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл хяналт сайжруулах замаар төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	1	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийг газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн	2025-2028	-	-	-	-	-	-	-	Татварын орлогын тухайн жилийн гүйцэтгэл, хувь	-	100	-	НТаТГ	Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийг газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлж ашиглах байгууллагаа эрхэлж буй татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийг газар зүйн мэдээллийн системд суурилсан газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хөгжүүлэх ажил тусгагдан үүний хүрээнд Нийслэлийн засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 16 өдрийн А/509 дүгээр захирамж, Нийслэлийн Засаг даргын тамгын газрын 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн ажлын удирдамж, Нийслэлийн Татварын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд “Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тоолого” явуулах ажлыг тусган 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 05/394 тоот Чиглэл хүргүүлэх тухай тус тус тусгагдсан байна. Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлын хүрээнд: Нийслэлийн хэмжээнд “Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллого” зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Татварын удирдлагын нэгдсэн системийн Татвар төлөгчийн бүртгэлийн хэсэг, “E-Tub” апп-д өөрчлөлт оруулах бодлогын даалгаврыг ажлын хэсгийн гишүүдээс 2025 оны 02 дугаар сарын 27-ноос 03 дугаар сарын 10-ыг хүртэлх хугацаанд саналыг хүлээн авч боловсруулан нэгтгэж, “Программ хангамж хөгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлэн Татварын удирдлагын нэгдсэн систем болон E-tub аппликэйшныг хөгжүүлж дуусгасан. E-Tub аппликэйшны нэвтрүүлэлтийн явц: 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр нийслэлийн 10 албаны удирдлага болон бүртгэл хариуцсан татварын улсын байцаагчдад сургалтыг зохион байгуулан ажиллаж, Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 202 зах худалдааны төвтэй хамтран ажиллах тухай албан хүсэлт хүргүүлж, татвар төлөгчийн мэдээллийг хүлээн авч ажилласан. E-Tub аппликэйшний нэвтрүүлэлт болон ТУБ-н ашиглалтын хэрэглээний талаар Нийслэлийн 9 дүүргийн татварын хэлтсийн удирдлага болон ТУБ-д хуваарийн дагуу өдөр бүр Цахим зөвлөмж, уулзалтыг зохион байгуулан ажилласан. Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллогын ажлын 2025 оны 11 дүгээр сарын үр дүн: 1.Татвар төлөгчийн бүртгэлийн талаар:Зөвлөн туслах ажлын хүрээнд нийслэлийн хэмжээнд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 464 албан хаагч нийт 43'136 татвар төлөгч үйл ажиллагаа эрхэлж буйгаас 16,225 нь хуулийн этгээд 26,911 иргэнийг ажлын байранд нь газар зүйн байршлаар бүртгэж, татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зөвлөн туслах үйл ажиллагаа үзүүллээ. Үүнд: □ Шинээр бүртгэсэн 38’511 татвар төлөгч; □ Татвар төлөгчийн бүртгэлийн мэдээлэл шинэчилсэн 2’309 татвар төлөгч; □ Татвар төлөгчийн бүртгэлээс хасах 3’067 татвар төлөгч. 2. Төлбөрийн баримт олголтын талаар: Нийслэлийн хэмжээнд төлбөрийн баримт хангалттүй олгож байгаа 361 зах худалдааны төвд үйл ажиллагаа эрхэлж буй нийт 18’705 татвар төлөгчийг тооллогод хамруулан татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, ялангуяа төлбөрийн баримт олгох талаар шаардлага өгч, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Мөн тооллогын явцад нийт төлбөрийн баримт олгох 43’136 татвар төлөгчийн ажлын байранд хяналтын цэг үүсгэснээс тогтмол төлбөрийн баримт олгож буй 11’872 татвар төлөгч, 4’737 татвар төлөгч төлбөрийн баримт олгож буй боловч татварын албанд тайлан ирүүлдэггүй, 6’981 татварын албанд тайлан ирүүлдэг боловч төлбөрийн баримт олгодоггүй зөрчлийг илрүүлж, 2’979 татвар төлөгчийн зөрчилд шаардах хуудас хүргүүлэн хуулийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. 3. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын талаар: Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн мэдээллээр нийслэлийн хэмжээнд 55’754 үл хөдлөх эд хөрөнгө бүртгэлтэй байгаагаас 7’087 – үл хөдлөх эд хөрөнгийг ажлын байрны газар зүйн байршлаар тооллогод хамруулаад байна. Үүнд: □ Үйлчилгээ 5’264	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
	татварын бодлогын тогтвортой байдлыг хангана.			системийг нэвтрүүлнэ.														□ Оффис 495; □ Үйлдвэр 200 □ Зах, Худалдаалах тев 361; □ Агуулах 81; □ Дэд бүтэц 41; □ Авто зогсоол 26; □ Орон сууцанд үйл ажиллагаа эрхэлдэг 1’328; □ Хашаа байшинд үйл ажиллагаа эрхэлдэг 447; 4. Зөвлөн туслах ажлын талаар: Зөвлөн туслах ажлын хүрээнд ТЕХ, НӨАТ, бусад татварын хууль тогтоомж, хуулийг хэрэгжүүлэх зөвлөгөөг 34’861 татвар төлөгчид үзүүлсэн байна. Үүнд: □ ТЕХ, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт хяналт зөвлөгөө өгч, үйлчилгээ үзүүлсэн 23’754; □ Түрээслэгчид татварын бүртгэлийн талаарх зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн 5,015; □ Татварын өр төлөх зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн 1,794; □ Татварын бусад хуулийг хэрэгжүүлэх 1450; □ Татварын тайлангийн талаарх зөвлөгөө үйлчилгээ үзүүлсэн 1116; □ Татварын тооцооллын баталгаажуулалтын мэдээлэл, үйлчилгээ үзүүлсэн 684; 5.Татварын ногдол, төлөлтийн талаар: Тооллогын явцад бүртгэлгүй 486.1 тэрбум төгрөгийн үнэлгээ бүхий 1’546 үл хөдлөх эд хөрөнгийг шинээр бүртгэж, ҮХЭХАТ-аар 3.5 тэрбум төгрөг ногдуулж, тооллогын явцад 1.3 тэрбум төгрөгийн татварыг төлүүлэзд байна.		
332	3.2.4.Төсвийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын орлогыг нэгдсэн системд бүртгэлжүүлж, ил тод байдлыг хангах замаар хяналтыг сайжруулна.	Төсвийн орлогын бүртгэл, хяналтыг сайжруулна.	1	Төсвийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудын орлогыг нэгдсэн системд бүртгэлжүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Нэгдсэн бүртгэлд хамруулах ажлын явц, хувь	-	30	-	НЗДТГ-СХОГ	НЗД-ын 2025 оны А/379 дүгээр захирамжаар "Төсвийн орлогын ногдол, өрийг хураан барагдуулах" үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулан, Ажлын хэсгийн хүрээнд орлого төвлөрүүлэгч байгууллагаас ашиглаж буй систем, програм хангамж, төсвийн орлогын ногдол, өрийн нарийвчилсан судалгаар орлогын нэр төрөл бүрээр нь гаргуулан авч нэгтгэн, төсвийн орлогын ногдол, дутуу төлөлтийг барагдуулахаар төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж, төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлэн ажиллаж байна. Төсвийн орлого төвлөрүүлэгч байгууллагуудыг нэгдсэн системд холбох чиглэлээр Сангийн яам, "Санхүүгийн тооцоолох компани"-уудад асуудлыг тавьж, санал солилцон, холбогдох мэдээллийг гарган өгч, хамтран ажилласан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Технологи, системийн хөгжүүлэлтийн хэлтэстэй хамтран Нийслэл, дүүргийн төсвийн бүрдүүлэлтийн орлогын мэдээлэл, 14 байгуулагын 65 нэгжээс төвлөрүүлж буй татварын болон татварын бус орлогыг нэгтгэн харах, төлөвлөлт ба гүйцэтгэлийг хянах, дүн шинжилгээ хийх нэгдсэн платформыг бий болгохоор ажиллаж байна.	79	
333	3.2.5. Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн өмчийн мэдээллийг нэгтгэн боловсруулах их өгөгдлийн системийг хөгжүүлэн, бүтэц, эдийн засгийн зорилтод түвшинг оновчтой тодорхойлж, орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар үр ашгийг нэмэгдүүлнэ.	Нийслэлийн өмчийн бүртгэл хяналтыг сайжруулж, ашиглалт үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	1	Нийслэлийн өмчийн бүртгэлийн удирдлагын системд нийслэлийн өмчит хуулийн этгээдийн өмчийн мэдээллийг бүртгэнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	Мэдээлэл боловсруулах ажлын явц, хувь	-	100	-	НӨХГ	Нийслэл биеэ даасан мэдээллийн нэгдсэн сантай болох зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1138 дугаар захирамжаар "Цахим Улаанбаатар" төслийн 110 сая төгрөгийн санхүүжилтийн эрх шилжүүлэх ажил батлагдан, НИТХ-ын 15-р тогтоолоор төсөвт өөрчлөлт орон тендер хүчингүй болсон. 2024 оны нийслэлийн төсөвт санхүүжилтийг шийдвэрлэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар захиалагчийн хяналт хийж, гүйцэтгэгчээр “Ухаалаг шийдэл компани” ХХК-ийг шалгаруулан “Нийслэлийн өмчийн бүртгэл, удирдлагын нэгдсэн систем”-ийг хийлгэж хүлээн авсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Амгалан, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Л.Эрдэнэбадрах болон НӨХГ-ын хэлтсийн дарга нар 2025 оны 05 дугаар сарын 08-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Цэнгэл, Бүртгэл ашиглалтын хэлтсийн дарга Б.Нарангэрэл нартай гурвалсан уулзалт хийж “Нийслэлийн өмчийн удирдлагын нэгдсэн систем”-ийг зогсоохоор шийдвэрлэсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас энэхүү программыг дотоод үйл ажиллагаандаа ашиглах талаар судалж байгаа болно.	100	
334			2	Орон нутгийн өмчийг эдийн засгийн эргэлтэд оруулах бодлогыг боловсруулж, хэрэгжүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Эдийн засгийн эргэлтэд оруулах ажлын гүйцэтгэл, хувь	-	20	-	НӨХГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А-1/702 дугаар албан бичгийн дагуу нийслэлийн төсөвөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компанийн засаглалыг сайжруулж зохион байгуулалтын хүрээнд ТӨБЗГ-аас орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой нийт хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, судалгааны тоо баримтыг нэгтгэхэд шаардлагатай тоон мэдээлэл, танилцуулга ирүүлэхийг хүссэн бөгөөд нийт 106 хуулийн этгээдийн 2023, 2024 оны санхүүгийн тайлан, төсөвт төвлөрүүлсэн дүн, аудитын дүгнэлт, Төлөөлөн удирдах зөвлөл, Удирдах зөвлөлтэй холбоотой болон хүний нөөц, хөрөнгө оруулалтын судалгааг гарган НӨХГ-ын даргын 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 1/1698 тоот албан бичгийг тус газарт хүргүүлсэн. Үүнд: 2023өнд 106 хуулийн этгээд: -Нийт хөрөнгө 3,018,9 тэрбум төгрөг, үүнээс эргэлтийн хөрөнгө 870,2 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 2,148.8 тэрбум төгрөг -Эздийн өмч 2,419.1 тэрбум төгрөг, -Нийт өр төлбөр 601,5 тэрбум төгрөг, Үүнээс: -Урт хугацаат өр төлбөр 330,1 тэрбум төгрөг -Богино хугацаат өр төлбөр 271,3 тэрбум төгрөг -Авлага 93,5 тэрбум төгрөг -Тайлант үеийн ашиг алдагдал 6,027.0 сая төгрөг 2024 онд 110 хуулийн этгээд: -Нийт хөрөнгө 3,639,6 тэрбум төгрөг, үүнээс: эргэлтийн хөрөнгө 1,189.5 тэрбум төгрөг -Эргэлтийн бус хөрөнгө 2,450.1 -Эздийн өмч 2,949.1 тэрбум төгрөг, -Нийт өр төлбөр 690,5 тэрбум төгрөг Үүнээс: -Урт хугацаат өр төлбөр 404,9 тэрбум төгрөг -Богино хугацаат өр төлбөр 285,6 тэрбум төгрөг -Авлага 139,9 тэрбум төгрөг -Тайлант үеийн ашиг алдагдал 134,3 тэрбум төгрөг	100	
Зорилтын үр дүн: 3.3.Улаанбаатар хотыг үйлдвэрлэл, инновацын төв болгон төрөлжүүлэн хөгжүүлж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжинэ.																				
335		Малын	1	Паркийн дулааны цахилгаан станцыг барьж байгуулна.	2025-2028	-	134,500.0	-	-	-	-	134,500.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	5	20	27,000.0	ЭЭАҮП ХК	ЭЭАҮПаркийн “Дулааны цахилгаан станц болон Цэвэрлэх байгууламж”-ийг барьж байгуулах ажилд нийт 225 тэрбум төгрөг шаардлагатайгаас 2025 онд эхний санхүүжилт болох 30 тэрбум төгрөгийг Нийслэлийн төсөвт суулгуулсан. Үг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 08 дугаар сарын 26-ны өдөр “Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн Дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх	85	
336			2	Паркийн бохир ус цэвэрлэх байгууламжийг барьж байгуулна.	2025-2028	-	91,000.0	-	-	-	-	91,000.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	5	20	23,000.0	ЭЭАҮП ХК	байгууламжийн ажил гүйцэтгэх (EPC+F) гэрээг байгуулаад байна. Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэгч компаниас 30 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгаат гаргуулсан ба зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.	85	
337			3	Паркийн гадна авто замыг шинээр барина.	2025-2028	101,500.0	-	-	-	-	-	101,500.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	5	10	-	ЭЭАҮП ХК	Эмээлтээс Шувуун фабрик хүртэлх 12.5 км гадна авто замыг барьж байгуулах зураг төсвийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/1249 дугаар захирамжаар шинэчлэн боловсруулж, 2026 оны нийслэлийн төсөвт тусгуулсан.	60	
338			4	Паркийн ахуйн ус хангамжийн системийг байгуулна.	2025-2028	-	12,900.0	-	-	-	-	12,900.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	5	10		ЭЭАҮП ХК	2024 онд НИТХ-аар батлагдсан ЭЭАҮП-ийн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд унд ахуйн усыг Мянганы сорилтын сангийн баруун доод эх үүсвэрээс хангахаар тусгагдсаны дагуу зураг төсөл боловсруулах ажлын тендерийг зарлан, гүйцэтгэгчийг шалгаруулсан. Зураг төслийн явц 90%-ийн гүйцэтгэлтэй байгаа ба бүтээн байгуулалтыг 2026 онд эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна	60	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
339		гаралтай түүхий эдийг боловсруулж бүтээгдэхүүн үйлдвэрлэх чиг үүрэг бүхий эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийг барих "Эмээлт эко аж үйлдвэрийн парк-дэд бүтэц" төслийн бүтээн байгуулалтыг дуусгана.	5	Паркийн технологийн ус хангамжийн системийг байгуулна.	2025-2028	-	16,320.0	-	-	-	-	16,320.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	5	10		ЭЭАҮП ХК	Паркийн технологийн ус хангамжийн ажлын зураг төсвийг 2016 онд гүйцэтгүүлж байсан бөгөөд ажиллах хүчний болон машин механизмын тарифт өөрчлөлт орсон болон материал, тэзвийн зардлыг бодит байдлаар тооцох шаардлагын үүднээс төсвийг шинэчлэхээр төлөвлөсөн. Төсөв шинэчлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгуллага гүйцэтгэж байгаа бөгөөд ажил 80%-тай үргэлжилж байна	45	
340			6	Паркийн үерийн хамгаалалтын далан сувгийн барилга байгууламж барина.	2025-2028	32,739.3		-	-	-	-	32,739.3	Дэд бүтцийн ажлын явц, хувь	5	10		ЭЭАҮП ХК	Үерийн байгууламжийн төсвийг 2025 онд тарифын өөрчлөлтийг тусгаж Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 2094/2025 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан.	45	
341			7	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	5	10		ЭЭАҮП ХК	ЭЭАҮП-ийн зураг төсвийг шинэчлэх ажлуудыг хийхийн зэрэгцээ дараах ажлуудыг гүйцэтгэзд байна. Үүнд: 1.БНСУ-ын хөрөнгө оруулалтаар "Смарт энержи платформ" нэгдэлтэй хамтран "10мВт-ын нарны эрчим хүч үйлдвэрлэх төсөл" хэрэгжүүлэхээр ТЭЗҮ-ийг боловсруулах ажил 2025 оны 07 дугаар сард эхлэзд байна. 2.Гадна тохижилт, ногоон байгууламжийн зураг, төсөв, бүтээн байгуулалтын ажлыг бүрэн дуусган хүлээн авсан. 3.Баруун бүсэд 2*630кВа хаалттай дэд өртөө, гадна цахилгаан хангамж байгуулах ажлыг гүйцэтгүүлэн Комисс ажиллуулах хүсэлтийг Хяналт шалгалтын газар илгээгээд байна. 4. Паркийн баруун бүсийн Хамгаалалтын бүс байгуулах ажлын шугаман суурь болон хашааны шонгийн цутгалтын ажлыг гүйцэтгэж дуусан. Хашааны төмөр хийцийн ажил явагдаж байгаа бөгөөд гүйцэтгэл 90%-тай үргэлжилж байна.	100	
342			8	УБ төмөр замын нэгдсэн сүлжээтэй холбох ТЭЗҮ боловсруулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Бэлтгэл ажлын явц, хувь	-	-		ЭЭАҮП ХК	Паркийн Тээвэр, логистикийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл боловсруулах 05/2025 дугаар бүхий ажлын даалгаврыг боловсруулан, 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Нийслэлийн ерөнхий архитектораар батлуулсан.	100	
343			9	Паркт гаалийн хяналтын бүс болон ачаа тээвэр ачиж, буулгах гаалийн баталгаат агуулах барих зураг төсөл боловсруулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Бэлтгэл ажлын явц, хувь	-	-		ЭЭАҮП ХК		100	
344			10	Паркийн үндсэн цахилгаан хангамжийн 110 Кв-ын 6.76 км шугамын бүтээн байгуулалтыг дуусгана.	2025	-	300.0	-	-	-	-	300.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	90	100	300.0	БнҮТП ХК	Паркийн үндсэн ерөнхий цахилгаан хангамжийн 110кВ-ын 2 хэлхээт 6.76 км цахилгаан дамжуулах агаарын шугамыг барих ажлын хөрөнгө оруулалтыг 2022 онд нийслэлийн Засаг даргын А/170 дугаар захирамжаар шийдвэрлэгдэж бүтээн, байгуулалтын ажил эхэлсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 13-ний өдрийн А/197 дугаартай захирамжаар шугамын бүтээн байгуулалтын үлдэгдэл 300.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж, бүтээн байгуулалтын ажил дуусан. Монгол Улсын Эрчим хүчний сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний А/206 дугаар тушаалын дагуу Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын цахилгааны хэлтсийн дарга Д.Батэоригоор ахлуулсан Улсын комисс 2025 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр ажиллаж шугамыг ашиглалтад хүлээн авах шийдвэр гарч бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусан.	100	
345	3.3.1.Багануур, Багахангай, Налайх, Эмээлт дэх үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.	11	Паркийн ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө, Техник технологийн тушшний үнэлгээ, Байгаль орчны үнэлгээ боловсруулна.	2025	800.0	-	-	-	-	-	800.0	Бэлтгэл ажлын явц, хувь	-	100	800.0	БнҮТП ХК	Нийслэлийн засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/1130 дугаар захирамжаар паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил, Паркийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинэчлэн боловсруулах 80.0 сая.төг-ийг шийдвэрлэсэн. - Паркийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах ажил: Худалдан авах ажиллагааны гаэраас тендерийг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зарлаж, гүйцэтгэчээр Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв шалгарч гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна. - Паркийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шинэчлэн боловсруулах :Худалдан авах ажиллагааны гаэраас тендерийг 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдөр зарласан боловч гүйцэтгэч шаардлага хангаагүй тул тендерийг 2025 оны 11 дүгээр 10-19-ний хооронд дахин зарлаж "Теам смайл" ХХК шалгарсан. Шалгарсан байгуулагуудтай гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.	79	
346			12	Паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг барина.	2025-2026	-	2,454.2	-	-	-	-	2,454.2	Дэд бүтцийн ажлын явц, хувь	-	100	2,454.2	БнҮТП ХК	Технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг худалдан авах 700.0 сая, засвар хийж ашиглалтад оруулах 2,329.0 сая, нийт 3,029.0 сая төгрөгийн төсөвтэй ажил юм. - Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 60% бүюу 1,740.0 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 700.0 сая төгрөг тусгагдсан. - 700.0 сая төгрөгийн санхүүжилтийн асуудлаар нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт 2025.02.06-ны 36 дугаар албан бичгээр хүсэлтээ уламжилсан боловч төсвийн тодотголоор дахин хэлэлцэгдэж хасагдсан тул уг арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон. Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар Паркийн "захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв"-ийн барилгын зураг төслийн 35.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж "Нутаг консалтинг" ХХК нь зураг төслийг гүйцэтгэж 2020 онд хүлээлгэн өгсөн. - Тухайн барилгыг барихад шаардлагатай 2,454.2 сая төгрөгийг нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар бэлтгэж зураг төслийн төсөв шинэчлэх хүсэлтийг 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 135 дугаар албан бичгээр "Нутаг консалтинг" ХХК-д хүргүүлсэн. - "Нутаг консалтинг" ХХК нь 3.0 сая төгрөгөөр төсөв шинэчлэх санал ирүүлсэн тул 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтийн дагуу "Барилга хөгжлийн төв"-ийн 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 2009/2025 дугаартай магадлалын дүгнэлт гаргуулан хүлээлгэн өгсөн. Нийт төсөвт өртөг 6,026,262,161 төгрөг болж шинэчлэгдсэн. Энэхүү төсвийн 50 хувийг Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна.	58	
347			13	Паркийн цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станцыг барина.	2025-2026	-	9,911.5	-	-	-	-	9,911.5	Дэд бүтцийн ажлын явц, хувь	-	50	1,048.9	БнҮТП ХК	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 10 хувийн санхүүжилт болох 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалт шийдвэрлэгдсэн. Гүйцэтгэгчээр "Эм Ай Эс Эс" ХХК нь шалгарч 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр нийслэлийн Засаг даргын Тамгын газартай №ОН2512001438 дугаартай гэрээ байгуулсан. Ажил эхлэх эвшөөрлийг холбогдох байгууллагад хүргүүлэн шийдвэрийг хүлээж байна. Дэд станцын байршил өөрчлөгдсөнтэй холбогдуулан зураг төсөлд нэмэлт өөрчлөлт оруулан мэргэжлийн байгууллагуудтай эвшилцөх ажил үргэлжилж байна. Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд үлдэгдэл 8,8 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр саналууд хүргүүлэн ажиллаж байна.	79	
348		Багахангайн үйлдвэрлэл,	19	Паркийн цахилгаан хангамжийн 35/10 кВ-ын 2х8МВА чадалтай дэд станцыг барина.	2025-2026	-	8,700.0	-	-	-	-	8,700.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	-	50	4,400.0	БхҮТП ХК	Паркийн цахилгаан хангамжийн 35/10 кВ-ын дэд станцын 2 хэлхээт 4,7 км урттай ЦДАШ-ын бүтээн байгуулалтын ажлыг 2025.05.30-ны өдөр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар хүлээн авав. Паркийн Цахилгаан хангамжийн 35/10 кВ-ын 2х8МВА чадалтай дэд станцын нийт төсөв 8.7 (тэрбум төгрөг) бөгөөд 2025 онд 4.3 (тэрбум төгрөг)-ийг төсөвт суулгуулахаар 2025.05.08-ны өдрийн 42 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргад хүсэлт хүргүүлсэн. 2026 оны төсвийн төсөлд санал хүргэв.	29	Төсөв шийдэгдээгүй

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
349		технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.	20	Паркийн ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө, Техник технологийн түвшний үнэлгээ, Байгаль орчны үнэлгээ боловсруулна.	2025-2026	800.0	-	-	-	-	-	800.0	Бэлтгэл ажлын явц, хувь	-	50	400.0	БхҮТП ХК	Паркийн 2025.03.27-ны өдрийн 28 тоот албан бичгээр хүнд үйлдвэрлэлийн бүсийн хөгжлийн төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах 90.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр санал хүргүүлэв. Уг хүсэлтийн дагуу нийслэлийн Засаг даргын 2025 оны А/769 дүгээр захирамжаар санхүүжилт олгогдож, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны албанаас зарласан тендерт "Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв"ТББ шалгарч, гэрээ байгуулав.	80	
350		Налайхын үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтыг дуусгана.	27	Паркийн ТЭЗҮ, Хөгжлийн төлөвлөгөө, Техник технологийн түвшний үнэлгээ, Байгаль орчны үнэлгээ боловсруулна.	2025	800.0	-	-	-	-	-	800.0	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувь	-	100	800.0	НҮТП ХК	Паркийн хөгжлийн төлөвлөгөө /2025-2040/-г боловсруулан хүлээн авч Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулсан. Хөгжлийн төлөвлөгөөг АУЗБЯ-ын мэргэжлийн зөвлөлөөр батлуулж, паркийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахаар бэлтгэл ажил хийгдэж байна. ТЭЗҮ, Техник технологийн түвшний үнэлгээ, байгаль орчны үнэлгээ боловсруулах хөрөнгө оруулалтыг шийдвэрлүүлэхээр эдийн засгийн хөгжлийн яаманд хүргүүлсэн шийдвэрлээгүй байна.	29	санхүүжилтгүй
351			28	Паркийн цэвэрлэх байгууламжийг барина.	2025-2026	-	2,663.0	-	-	-	2,663.0	5,326.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	-	100	5326.0	НҮТП ХК	Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд хоногт 1000мкуб хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, Паркийн 120 га газрын 10.3 км дотор авто зам, 7.06 км гадна авто зам, 26 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц барих, Төв аймгийн Баян зөрлөгөөс паркийг холбох 11,7 км төмөр зам тавих ажлууд тусгуулаад байна. Паркийн дулааны станц барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2026 оны төсөв, МУ-ын 2025-2028 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар саналаа хүргүүлсэн. ХББОС-ын яаманд дэд бүтцийн ажлын хөрөнгө оруулалтыг тусгуулах хүсэлт хүргүүлсэн. Дэд бүтцийн төсвийг шинэчлэх ажлын нэмэлт хөрөнгө болох 60,0 сая төгрөгийг шийдвэрлүүлэх асуудлаар Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдад албан хүсэлт хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын тамгын газрын хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гантулгад дэд бүтцийн барилга байгууламжуудын хөрөнгө оруулалтыг 2026 оны төсөвт тусгуулах албан бичиг хүргүүлсэн.	29	санхүүжилтгүй
352			29	Паркийн дулаан хангамжийн шугам сүлжээ барина.	2025-2026	14,300.0	-	-	-	-	-	14,300.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	-	50	7,150.0	НҮТП ХК			
353			38	Паркийн гадна цахилгаан хангамжийн зураг төсвийг боловсруулна.	2025-2026	-	110.0	-	-	-	-	110.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	-	100	110.0	НҮТП ХК	Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт гадна цахилгаан хангамжийн зураг төсөв боловсруулах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлээгүй байна.	29	санхүүжилтгүй
354			39	Паркийн бөөний болон жижиглэн худалдааны төвийн төлөвлөлтийг /ХЕТ/ боловсруулна.	2025-2026	-	210.0	-	-	-	-	210.0	Дэд бүтцийн ажлын явц, хувь	-	100	210.0	НҮТП ХК	Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн 60 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Хот байгуулалт, Хотын стандартын газрын 2026 оны зураг төсвийн төлөвлөгөөнд тусгуулсан.	29	
355	3.3.2.Багануур, Налайх, Багахангай дүүрэгт хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийг дагалдах бусад үйлдвэрийн хамт байгуулах хувийн хэвшлийг дэмжинэ.	Багануур, Налайх, Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркт үйлдвэр байгуулах хувийн хэвшлийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлнэ.	1	Багануур үйлдвэрлэл, технологийн паркад үйлдвэр, аж ахуйн нэгж байршуулан үйл ажиллагааг дэмжинэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Паркийн нэгжтэй байгуулсан аж ахуйн нэгж, тоо	1	2		БнҮТП ХК	Паркад нэгж үйлдвэр байгуулах ажлын хүрээнд дараах ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: "Натур ларикс вүүд" ХХК, "Мах маркет" ХХК, "Трее Треелинг ойл" ХХК, "Номин сүү" ХХК- тай хамтны ажиллагааны санамж бичиг байгуулан 4 үйлдвэрийн төслийн ТЭЗҮ-ийг боловсруулж холбогдох яамдаар баталгаажуулах ажил хийгдэж байна.	100	
356			2	Налайх үйлдвэрлэл, технологийн паркад үйлдвэр, аж ахуйн нэгж байршуулан үйл ажиллагааг дэмжинэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Паркийн нэгжтэй байгуулсан аж ахуйн нэгж, тоо	3	8		НҮТП ХК	Паркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу одоогийн байдлаар 250 га газар дээр нийт 40 аж ахуй нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байна. 15 аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулах газарт үйлдвэрийн барилга угсралтын ажлаа эхлүүлээд байгаа бөгөөд бүтээн байгуулалт 85 хувьтай явагдаж байна. Дээрх үйлдвэрүүд ашиглалтад орсноор 325 хүнийг байнгын ажлын байраар хангах ба одоогоор 7 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа эхлээд байна.	100	
357			3	Багахангай үйлдвэрлэл, технологийн паркад үйлдвэр, аж ахуйн нэгж байршуулан үйл ажиллагааг дэмжинэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Паркийн нэгжтэй байгуулсан аж ахуйн нэгж, тоо	3	3		БхҮТП ХК	Парк жил бүр нэгжүүдийн үйл ажиллагааг дугнэн ажилладаг бөгөөд гэрээний үүргийг биелүүлсэн 2 аж ахуйн нэгж болох Кокс эрчим хүч үйлдвэрлэх төслийг хэрэгжүүлэгч "Ян сарьдаг оргил" ХХК Барилгын дотоод заслын материалын үйлдвэрийн төслийн "Баян хангайн хүлэг" ХХК-тай хамтран ажиллах болон газар ашиглах гэрээг байгуулсан. Логистикийн нэгдсэн төвийн төслийн "Тен фрейт лайн" ХХК, Вагоны хос дугуй засварлах нэгдсэн төвийн "Эл эс рэйлвэй" ХХК-ууд гэрээний үүргийн дагуу баримт бичгийн бүрдэл дутуу тул гэрээ сунгагдаагүй болно.	95	
358	3.3.3.Эмээлт эко аж үйлдвэрийн паркт арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэж, үйлдвэрүүдийн өрсөлдөх чадварыг дэмжинэ.	Эмээлт эко аж үйлдвэрийн паркт нүүн шилжих үйлдвэрүүдийн үйл ажиллагаа эрхлэх боломжийг бүрдүүлнэ.	1	Арьс шир, ноос боловсруулах үйлдвэрүүдтэй паркийн нэгжийн гэрээ байгуулж, байршуулна.	2025-2027	-	-	-	-	-	-	-	Нэгжтэй байгуулсан гэрээ, тоо	4	10		ЭЭАҮП ХК	Эмээлт эко аж үйлдвэрийн Паркийн нэгжийн гэрээ болон Паркт газар ашиглуулах гэрээг -Аура кашемир ХХК -Болор хээ ХХК -Энх номин орчлон ХХК -Их Асар ХХК -Ужин партнерс ХХК -Фучер холдинг ХХК -Их Эргэлт ХХК -Тунсян Канпюань Биологийн Бүтээгдэхүүн ХХК -Буурал гол ХХК -Ганбүрд ХХК-тай байгуулсан.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
359	3.3.4.Улаанбаатар хотод гарааны бизнес эрхлэгч, инновац, судалгаа хөгжүүлэгчдэд зориулсан хөнгөлөлттэй санхүүжилтийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.	Гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгч, инновацын судалгаа хөгжүүлэгчдэд санхүүжилтийг нэмэгдүүлж, бодлогоор дэмжинэ.	1	Гарааны бизнес эрхлэгчид, инновацын судалгаа хөгжүүлэгчдийг дэмжин хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулахад дэмжлэг үзүүлнэ.	2025-2028	-	200.0	-	-	-	-	200.0	Дэмжлэг үзүүлсэн гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгчид, тоо	-	5	50.0	БИГ	1.Инновацын төвүүдэд 2025 онд сонгон шалгаруулалтаар 16 бойжигчийг шалгаруулан, бойжуулан хөгжүүлж байна. Гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах зорилгоор зээлийн судалгаог бойжигч нараас авч хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг судалж, 1 иргэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 30 сая төгрөгийн зээлийг 36 сарын хугацаатай авч, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх санхүүгийн боломж бүрдсэн байна. 2.ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран "MICS-2024" хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагаг зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр "Ашигласан HEV/EV батарейг дахин ашиглах/дахин боловсруулах технологийг хөгжүүлэх, ноу-хау солилцох" төсөлд Худалдаа хөгжлийн банкнаас 10 сая төгрөгийн дэмжлэг олгосон. 3.Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн удирдлагуудтай уулзалт хийж, тус эмнэлэгийн 100 жилийн ойн 1 сарын аянд СТӨ-ний инкубатор хөтөлберт хамрагдаж буй стартап компани болох "Зохис Аппликейшн" ХХК, "Юникуе повер теч" ХХК/UP Tech компаниудыг бүтээгдэхүүнээ танилцуулах, видео контент хийлгэх ажилд хамтарч ажилласан. Улсын нэгдүгээр төв эмнэлэгийн зүгээс 2 стартап компанид тус бүр 3,3 сая төгрөгийн мөнгөн дэмжлэг үзүүлсэн. 4.Гарааны болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулан бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж, нийт 2364 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. Үр дүн: -Гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгч 4 иргэн, аж ахуйн нэгж дэмжлэг авсан байна. -Гарааны болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулан бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж, нийт 2364 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан байна.	95	
360	3.3.5.Төр, хувийн хэвшил, эрдэм шинжилгээний байгууллагуудын хамтын ажиллагаанд тушиглэсэн инновацын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Нийслэлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх инновацын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	1	Монгол-Японы хамтарсан Ай-Ти Консорциумыг үйл ажиллагааг эхлүүлж, мэдээллийн технологийн чиглэлийн компаниудын хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	2025-2028	-	100.0	-	-	-	-	100.0	Хамтын ажиллагааны хэрэгжилт, хувь	-	25	10.0	БИГ	"Ай Ти Консерциум" байгуулах санамж бичгийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: •Монгол, Япон 2 улсад төлөөлөх ТББ-ыг байгуулагдаж удирдах зөвлөлийн гишүүдээр технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 5 компани ажиллаж байна. •Токио хотод 2 удаагийн эвент арга хэмжээ, зохион байгуулсан бөгөөд нийт 60 гаруй технологийн чиглэлийн компаниудад мэдээлэл хүргэсэн байна. •Япон улсын Токио хотын Шинагава дүүргийн удирдлагууд, цахиурын хөндийн "Готанда валлэй" ТББ-ын гүйцэтгэх захиралтай 3 удаагийн уулзалт хийж хамтран ажиллах талаар санал солилцсон. •Япон улсын технологийн 5 компани айлчилж ICT tour хийхээр болсон бөгөөд тус арга хэмжээг зохион байгуулах бэлтгэлийг хангасан. •"Зууны мэдээ" сонины "Leaderships forum" буланд Ай-Ти консорциумын үйл ажиллагааны талаар мэдээлэл нийтэлж, олон нийтэд хүргэн ажилласан. Үр дүн: Ай ти консерциумын үйл ажиллагааны талаар мэдээлэл хүргэх танилцуулах эвент арга хэмжээг 5 удаа зохион байгуулсан.	90	
361			2	Нийслэлийн тулгамдсан асуудлуудыг иргэдийн оролцоотойгоор шийдвэрлэх Хакатон, тинк танк арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	600.0	-	-	-	-	600.0	Хэрэгжүүлсэн арга хэмжээ, тоо	3	2	150.0	БИГ	Нийслэл хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хотын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд: -Хүнсний эрүүл ахуйн тулгамдсан асуудлуудыг бодит өгөгдөлд суурилан салбарын мэргэшсэн залуусаар шилдэг инновацын шинэлэг шийдлийг гаргах хакатон тэмцээнийг 3 сэдвийн хүрээнд 1 сарын турш 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Тус хакатон тэмцээнд нийт 27 баг бүртгүүлсэн бөгөөд шалгарсан 3 багт тус бүр 3 сая төгрөгийн грант олгосон. -Дэлгэцийн донтолтыг бууруулах инновац" сэдвийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран тэмцээн зохион байгуулсан. Шалгарсан 3 баг Япон улсад болох олон улсын тэмцээнд оролцохоор болсон. -"Нийслэлд нисгэгчгүй нисах техөөрөмж (дрон) технологийг хөгжүүлэх боломж" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээр хотын хөгжлийн бодлого, төлөвлөлтөд дрон технологид суурилсан шийдлүүдийг нэвтрүүлэх чиглэлээр төр-хувийн хэвшлийн хамтын ажиллагааны боломжуудыг хэлэлцэн, санал солилцож, цаашдын хөгжлийн гарц, шийдлийг боловсруулж, нийслэлийн удирдлагуудад танилцуулахаар шийдвэрлэв. Үр дүн: 1 хакатон тэмцээн, 1 тинк танк хэлэлцүүлэг зохион байгуулсан.	100	
362			3	Нийслэлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх инновацын төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2025-2028	-	1,000.0	-	-	-	-	1,000.0	Хэрэгжүүлсэн төсөл, тоо	-	2	250.0	БИГ	Нийслэл хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хотын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор: 1.НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрөөс санхүүжүүлэх "Монголын хүртээмжтэй ногоон хотууд" төслийг нийслэл хотноо таван жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр шийдвэрлэгдэж, төслийг 2026 онд хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Энэхүү ажлын хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөртэй хамтран ажиллах Санамж бичиг байгуулсан. 2.Нийслэлийн гэрлэн дохиогуй гарцуудад явган зорчигчдын аюулгүй байдлыг хангах зорилгоор "Ухаалаг явган хүний гарц" төслийг санаачлан боловсруулж, хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. Төслийн хүрээнд загвар байгуулламжийг Central Tower-ийн урд хэсэгт байршуулан туршилтын суурилуулалтыг амжилттай хийсэн. Мөн төслийн танилцуулга болон холбогдох материалыг БНСУ-ын хамтын ажиллагааны агентлаг КОЙКА-д хүргүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна. 3.Нийслэлийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэх хүрээнд 8 төслийн саналыг боловсруулж дуусгаад байна. 4. Байгууллагын албан хаагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцоог нэмэгдүүлэх зорилготой төслийн уралдаан зохион байгуулж, 3 төслийг шалгаруулсан. Үр дүн: 2 төслийг хэрэгжүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	75	
363	3.3.6.Инновацын төв, бүтээгчдийн талбарыг байгуулж инновацын экосистемийг хөгжүүлнэ.	Инновац, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх инновацын төвүүдийг байгуулна.	1	Инновац, гарааны бизнес, оюуны үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх инновацын төвүүдийг байгуулна.	2025-2028	-	-	-	-	15,470.0	-	15,470.0	Инновацын төв байгуулах ажлын явц, хувь	-	30	1,646.0	БИГ	БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар "Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв" байгуулах асуудлаар хамтран ажиллах, санал солилцох 9 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. -НЗД-ын нэгдүгээр орлогч дарга, НБИГ-ын дарга, БНСУ-аас төслийг хэрэгжүүлэхээр ирсэн төлөөлөгчид, БНСУ-ын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Куаг Хан Сул нарыг хүлээн авч уулзсан. Уулзалтаар БНСУ-аас Монгол Улсад буцалтгүй тусламжийн хүрээнд урт болон дунд хугацаанд нийт 58 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд нэн тэргүүнд "Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв" байгуулах төслийг хэрэгжүүлэхээр болж Нийслэлийн Засаг даргын А/258 дугаар захирамж гарсан. -"Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв" байгуулах төслийг хэрэгжүүлэх зөвшөөрлөө авсан. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулан хүргүүлж, холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна. Үр дүн:БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2026-2028 онд "Инновацын төв" байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	45	
364			2	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан бүтээгчдийн талбарыг бий болгож, бойжуулан хөгжүүлнэ.	2025-2028	-	600.0	-	-	-	-	600.0	Шинээр байгуулсан бүтээгчдийн талбар, тоо	-	1		БИГ	Гарааны бизнес эрхлэгчдэд зориулсан дэмжлэг, орон зай, санхүүжилт, зөвлөгөө, сургалтын хүртээмжийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн өсөлт, ажлын байр, инновацын соёлыг хөгжүүлэх зорилго бүхий Бүтээгчдийн талбар байгуулах саналыг 2026-2030 онд Нийслэлийг хөгжүүлэх үндсэн таван жилийн төсөлд хүргүүлсэн.	28	
365	3.3.7.Олон улсын сайн туршлага, экспортод гаргах нөөц бололцоо, санхүүгийн		1	Нийслэлд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн судалгаат гаргаж, мэдээллийн дата санг бий болгоно.	2024-2028	-	360.0	-	-	-	-	360.0	Судалгаанд хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчид, тоо	3278	5000	90.0	НЖДҮҮДТ	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд 6806 иргэн, аж ахуйн нэгж байгууллага жижиг дунд, үйлдвэр, үйлчилгээ эрхэлж байна.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
366	байгуулламжуудын байгуулагуудын эрэлт хэрэгцээг тодорхойлон, мэдээллийн сан бүрдүүлж, төрөлжсөн сургалт, бизнесийн зөвлөх үйлчилгээний ажлыг зохион байгуулна.	Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулна.	2	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээний салбарт төрөлжсөн сургалт зохион байгуулж, бизнесийн зөвлөх үйлчилгээнд хамруулан олон улсын сайн туршлагыг нэвтрүүлнэ.	2024-2028	-	-	-	-	-	-	-	Сургалт, зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ЖДҮҮ эрхлэгчид, тоо	1500	2000		НЖДҮҮДТ	Нийслэлийн 9 дүүргийн ЖДҮҮД төв болон Герман хамтын ажиллагааны нийгэмлэг (GIZ) эдийн засгийн олон талт өсөлтийг дэмжих төсөлтэй хамтран нийслэл Улаанбаатар хотын бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч иргэн, ААН-үүдэд 5 багц сургалтыг тогтмол явуулж, нийт 2528 иргэн, ААН хамрагдсан байна. Үүнд Улаанбаатар хотын Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ хамаарах юм.	100	
367	3.3.8.Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх зээлийн бүтээгдэхүүнийг боломжит түвшинд нэмэгдүүлж, зорилтот салбаруудад чиглүүлнэ.	Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд чиглэсэн санхүүжилтийн дэмжлэгийг нэмэгдүүлнэ.	1	"Улаанбаатар хотын Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх сургалт, зөвлөх үйлчилгээ" санхүүжилтийн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	2025-2028	-	22,000.0	-	-	-	-	22,000.0	Санхүүгийн дэмжлэгт хамрагдсан үйлдвэрлэл эрхлэгчид, тоо	48	30	3,000.0	НЖДҮҮДТ	Санхүүжилт шийдэгдээгүй.	0	
368	3.3.9.Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг гадаад, дотоодын зах зээлд сурталчлан таниулах ажлуудыг зохион байгуулж, импортыг орлох, экспортын баримжаатай бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ.	Жижиг дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагуудын борлуулалтын бодит орлогыг нэмэгдүүлнэ.	1	Олон улсын үзэсгэлэн худалдаанд Улаанбаатарын брэнд бүтээгдэхүүнийг оролцуулна.	2025-2028	-	4,000.0	-	-	-	-	#REF!	Зохион байгуулсан үзэсгэлэн арга хэмжээ, тоо	3	4	1,000.0	НЖДҮҮДТ	2025 онд нийт 3 гадаадын үзэсгэлэн, арга хэмжээ төлөвлөж, Унгар /Будапешт/, Хятад /Хайпаар/, Хятад /Хөх хот/-уудад 40 гаруй ждү эрхлэгчдийн 2500 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг сурталчилан таниулж, дахвардсан тоогоор 20 мянга гаруй хүн үзэн сонирхсон байна.	95	
369			2	Дотоодын худалдаат зохион байгуулж, дотоодын үйлдвэрлэлийг сурталчлан таниулж, борлуулалтын орлогыг нэмэгдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Зохион байгуулсан үзэсгэлэн арга хэмжээ, тоо	4	11		НЖДҮҮДТ	Дотоодын: Амар байна уу? 2025, Их хотын бүсгүйчүүд, Нарны баяр, Тегсөлтийн аргачлал, Жаргалтай инээмсэглэл, Asia Folk, Данших наадам, Дээлтэй монгол, Үндэсний их баяр наадам, Нүүдэлчин, Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн чуулга уулзалт нийт 11 үзэсгэлэн арга хэмжээ зохион байгуулж, 3000 гаруй иргэдийг хамруулан, давхрадсан тоогоор 1.8 сая иргэдэд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж, 55.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.	100	
370	3.3.10.Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн бүтээгдэхүүний борлуулалтыг бодлогоор дэмжиж, стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн, үйлчилгээг төрийн худалдан авах ажиллагаанд оруулах ажлыг шат дараатайгаар зохион байгуулна.	Төрийн худалдан авалтад дотоодын бараа бүтээгдэхүүний эзлэх түвшинг 10-с дээш хувьд хүргэнэ.	1	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тухайн жилийн худалдан авалтын түвшин, хувь	3	11		НХААГ	Нийслэлийн хэмжээнд 2025 оны 11 дугээр сарын 28-ны өдрийн байдлаар нийт 16,958,854,627,434 (арван зургаан их наяд есөн зуун тавин найман тэрбум найман зуун тавин дөрвөн сая зургаан зуун хорин долоон мянга дөрвөн зуун гучин дөрөв) төгрөгийн баталгдсан төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 5,600,634,362,929 (таван их наяд зургаан зуун тэрбум зургаан зуун гучин дөрвөн сая гурван зуун жаран хоёр мянга есөн зуун хорин ес) төгрөгийн санхүүжих дүнтэй 1748 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 259 төсөл, арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дугээр тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д заасан бараанаас нутгийн захиргааны 25 байгууллага дотоодын үйлдвэрлэгч 51 байгууллагаас бараа бүтээгдэхүүний өрөнхий ангилын 16 нэр төрлийн 93,111,570,510.0 (Ерөн гурван тэрбум нэг зуун арван нэгэн сая таван зуун далан мянга таван зуун арван) төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан байна. Энэ нь 11 хувийг үзэлж зорилтот түвшинд хүрсэн байна.	100	
Зорилтын үр дүн: 3.4.Улаанбаатар хотын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, жуулчдын ая тухтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.																				
371			1	Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.	2025-2028	-	724.0	-	-	-	-	724.0	Шинээр байгуулсан мэдээлэл сурталчилгааны төв, тоо	8	8	194.0	НАЖГ	Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон "Тэрэлж Монгол олле", "Хонхор тосгон Монгол олле", "Сөүлийн гудамж Монгол олле" зэрэг нийт 7 байршилд тогтмол болон улирлын чанартай ажилпуулж байна. Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд жуулчид хамгийн ихээр зорчдог байршлын судалгаар гаргасан. Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр Жуулчны гудамжийг тохижуулах төсөл, арга хэмжээтэй уялдуулан Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр тухайн байршилд байгуулахаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлэн шийдвэрлүүлж, бэлтгэлийг ханган ажиллаж байна.	95.5	
372			2	"Улаанбаатар өвлийн наадам" арга хэмжээг зохион байгуулна	2025-2028	-	627.0	-	-	-	-	627.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	8000	13000	177.0	НАЖГ	Өвлийн болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, өвлийн улиралд Улаанбаатар хотод ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, үндэсний тоглоом наадгай болон орчин үеийн экстрим спортыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор мэргэжлийн холбоодтой хамтран "Улаанбаатарын өвлийн наадам-2025" арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд "Скай резорт" цанын баазад зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Мөсөн сурын олон улсын аварга шалгаруулах тэмцээн, Мөсний шагайн улсын аварга шалгаруулах тэмцээн, Параглайдингийн (уулын шүхэр) хотын аварга шалгаруулах тэмцээн, Цасны Регбигийн хотын аварга шалгаруулах тэмцээн, Снөубоардын хотын аварга шалгаруулах, Улын цанын хотын аварга шалгаруулах тэмцээн, Кёрлингийн хотын аварга шалгаруулах тэмцээн зэрэг 7 төрлийн урлалдаан тэмцээнд ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улс, Бүгд найрамдах Халимаг улс, БНХАУ-ын ӨМӨЗО, Шинжаан Уйгураас нийт 36, Монгол Улсын 21 аймаг болон Улаанбаатар хотоос 1222 нийт 1258 тамирчин оролцлоо. "Улаанбаатарын өвлийн наадам-2025" арга хэмжээг гадаад, дотоодын 13,000 гаруй хүн үзэж сонирхлоо.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулагa	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
373			3	"Улаанбаатар" явган алхалтын фестиваль зохион байгуулна.	2025-2028	-	507.5	-	-	-	-	507.5	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	200	1150	112.5	НАЖГ	1.Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Монголын явган алхалтын холбоо”, “Монгол Олле” нийгэмлэгтэй хамтран “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль-2025” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгууллаа. Фестивальд ОХУ, БНХАУ, БНСУ, Япон улс, БН Казакстан Улс зэрэг 5 улсаас 56 алхагч, “Монголын явган алхалтын холбоо”-ны салбар холбоод, нийслэлийн дүүргүүд, Дорнод, Өмнөговь, Дорноговь, Орхон, Дархан-Уул, Сэлэнгэ, Төв зэрэг 11 явган алхалтын клубүүдийн 600 гаруй алхагчид оролцлоо. 2.Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор “Чингис-21” mountain resort, “Монгол Олла” байгуулагатай хамтран "Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль-2025" арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд Налайх дүүргийн 6 дугаар хороо, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газарт зохион байгууллаа. Фестивальд БНСУ-ын Сөүл, Вонжу, Чэжү хот, ОХУ-ын Горьны Алтай, Эрхүү, Улаан-Үд, Владывосток хот, АНУ, Англи, БНХАУ, БНТажикстан Улс, Филиппин, БНЧех Улс, Тайвань, ХБНГерман Улс, Бутаны хаант улс зэрэг 10 улсын төлөөлөл, Монголын явган алхалтын холбоо, клубүүдийн 500 гаруй явган аялагч, алхагчид оролцсон. Арга хэмжээний өдрүүдэд оролцогчдын дунд үндэсний бөхийн барилдаан, сурын харваа, сээр цохих наадаан, дэмбээ наадаан, шагайн наадгай, морь, тэмээ унах, галын наадам, бий биелгээ, өохор хатирах, од дурандах, задгай кино үзвэрээс гадна Улаанбаатар театрын уран бүтээлчид урлагийн тоглолт, "Хаадын хаан Чингис хаан" морьтны тусгай шоу үзүүлбэр зэрэг олон арга хэмжээг зохион байгууллаа.	100	
374			4	“Бүргэдийн баяр” арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	239.0	-	-	-	-	239.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	6000	12000	59.0	НАЖГ	Казах үндэстэн ястны ёс заншил, өв уламжлал, соёлыг сурталчлан таниулах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилгоор “Бүргэдийн баяр” арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 08,09-ний өдрүүдэд “Чингис хааны хураа” аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа. Арга хэмжээнд Бүгд найрамдах Казакстан Улсаас 2 бүргэдчин, Бүгд найрамдах Киргиз Улсаас 2 бүргэдчин, Баян-Өлгий аймгаас 20 бүргэдчин, Сэлэнгэ, Төв аймгаас тус бүр 1 нийт 26 бүргэдчид оролцлоо. Арга хэмжээний үеэр бүргэдтэй парад, бүргэдүүдийг танилцуулж алдаршуулах арга хэмжээ болон бүргэдчидийн дунд бүргэдээр шырга (хиймэл ан) барилдах тэмцээн, бүргэдээ хэрхэн сайн сургасан байдлыг шалгаруулах тэмцээн, Казак үндэсний тоглоом көкбар (тулам булаалдах) тэмцээн, зоос шүүрэх тэмцээнүүдийг зохион байгууллаа. Мөн “Морьтон баатруудын шоу тоглолт”, “Банхар, тайга, анн нохдын үзүүлбэр”, шухрийн үзүүлбэр болон тойрон бүжиг, цаа буга, тэмээ, морь унах, бүргэд шувуу болон тэмээтэй зураг даруулах болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчийн үзэсгэлэн худалдаа, урлагийн тоглолт зэрэг арга хэмжээг зохион байгуулж гадаад, дотоодын нийт 20,000 гаруй хүн үзэж сонирхлоо.	100	
375			5	"Монгол" өвлийн нүүдэлчин наадмыг зохион байгуулна.	2025-2028	-	120.0	-	-	-	-	120.0	Оролцогчид, тоо	-	100	30.0	НАЖГ	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, соёлын өвөө таниулан сурталчлах зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Засгийн газрын тохируулагч агентлаг Соёл, урлагийн газартай хамтран “Монгол нүүдэлчин өвлийн фестиваль”-ийг 2025 оны 02 дугаар сарын 16-22-ны өдрүүдэд "Үндэсний цацэрлэгт хүрээлэн"-д зохион байгуулсан. Фестивалийн хүрээнд "Монгол үндэстэн угсаатаны жагсаал"-ыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Улсын хүүхэд, залуучуудын театр, дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулж жагсаалд мэргэжлийн урлагийн байгууллагуудын уран бүтээлчид, нийслэлийн 6 дүүргийн нийт 800 гаруй хүн оролцлоо."Монгол үндэстэн угсаатаны жагсаал"-д оролцогчдоос шилдэг дүүрэг, сайхан дээлтэй хос, сайхан дээлтэй эрэгтэй оролцогч, сайхан дээлтэй эмэгтэй оролцогч зэрэг 4 номинациар шилдгүүдийг тодруулав.	100	
376			6	"Наурызын баяр 2025" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	498.0	-	-	-	-	498.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	-	7000	198.0	НАЖГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөлтэй хамтран “Наурызын баяр-2025” арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр Казак түмний уламжлалт гэр үзэсгэлэн, жижиг дунд үйлдвэрлэгчдийн үзэсгэлэн худалдаа, казак бөхийн үзүүлэх барилдаан, Казак үндэсний Алты бахан /савлуур/, күрес бөхийн үзүүлэх барилдаан, Казак үндэсний хоол, Шувуулахуйн үзүүлбэр, Монгол банхарын үзэсгэлэн зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 20,000 гаруй хүн үзэж сонирхсон.	100	
377			7	Суудлын авто машины ангиллын өвлийн мөсөн замын кроссын улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулна.	2025-2028	-	75.0	-	-	-	-	75.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	-	300	15.0	НАЖГ	Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэмэгдүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор Монголын Автомашин Мотоциклын Холбоотой хамтран “Мөсөн замын суудлын авто машины уралдаан-2025” арга хэмжээг 2025 оны 02 дугаар сарын 16, 23-ны өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах “Хун нуур”-т амжилттай зохион байгууллаа. “Мөсөн замын суудлын авто машины уралдаан-2025” арга хэмжээнд мэргэжлийн авто спортын 50 гаруй тамирчид 2 өдрийн турш өрсөлдөж, шилдгүүдээ тодруулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 1500 гаруй хүн үзэж сонирхлоо.	100	
378			8	“UB food" хоолны өдөрлөг арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	2,720.0	-	-	-	-	2,720.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	8,000.0	35000	500.0	НАЖГ	Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хамаарлыг бууруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор “Узбек улсын хоолны өдөрлөг” арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захиргачийн ажлын албатай хамтран 2025 оны 04 дүгээр сарын 08-13-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.Тус арга хэмжээнд Бүгд найрамдах Узбекистан улсаас 10 тогоочоо хүрэлцэн ирж плов, шашлык, казань кебаб, самса зэрэг 4 төрлийн хоолоор үйлчилж, мөн Монголын бүрхан шашинтны төв Гандантэгчинлэн хийдийн лам нар ширмэн тогоонд гурилтай шөлийг уламжлалт аргаар бэлтгэж, монгол хоолны соёлыг түгээн сурталчилсан. Арга хэмжээний үеэр 6 өдрийн турш “Улаанбаатар театр”-ын тоглолт, “Анир” поп оркестрын тоглолт, амьд хөгжмийн тоглолт, хамтлаг, дуучид, уран бүтээлчдийн тоглолт болон Dj үзүүлбэр, Open Mic, циркийн үзүүлбэр, мөн Узбек бараа бүтээгдэхүүний худалдаа, хоол хурдан идэх тэмцээнүүдийг зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 30000 гаруй хүн үзэж сонирхсон.	95.7	
379	3.4.1.Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	9	"Улаанбаатар травел" экспо зохион байгуулна.	2025-2028	-	117.0	-	-	-	-	117.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	3000	25000	27.0	НАЖГ	Аялагчид дотооддоо болон гадаад улс руу мэргэжлийн байгууллагаар дамжуулан аяллаа төлөвлөх, аяллын хөтөлбөр, багцуудтай танилцах, захиалгаа хямдралтай үнээр өгөх болон аялал жуулчлалын байгууллагууд, үйлчилгээ эрхлэгчдийн мэдээллийг нэг дороос хүртээмжтэй байдлаар авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран "Улаанбаатар травэл экспо 2025" аялал жуулчлалын үзэсгэлэнг 11 дэх жилдээ 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд Улаанбаатар зочид буудлын "Их танхимд" зохион байгууллаа. Үзэсгэлэнд БНХАУ-ын Хайнань мужийн "Visit Atlantis Sanya" байгууллага, ӨМӨЗО-ны CITS (China International Travel Service) аялал жуулчлалын тур оператор компани, Монгол Улсаас Өмнөговь, Ховд, Дархан, Дорноговь, Архангай зэрэг 5 аймаг болон 90 гаруй аялал жуулчлалын тур оператор компани, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчид аяллын багцадах хэрэгсэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйл ажиллагаагаа танилцуулан оролцож, үзэсгэлэнг гадаад, дотоодын нийт 25000 гаруй хүн үзэж сонирхсон.	100	
380			10	"Талын салхи" олон улсын мото наадмыг зохион байгуулна.	2025-2028	-	700.0	-	-	-	-	700.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	5000	7000	250.0	НАЖГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын чопперчин ахан дүүс ТББ-тай хамтран “Талын салхи-2025” олон улсын мото наадмыг 10 дахь жилдээ 2024 оны 06 дугаар сарын 07,08-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбай болон “Хүй долоон хутаг”-т зохион байгууллаа. Мото фестивальд оролцогчид Энхтайваны өргөн чөлөө бүюу Сүхбаатарын талбай-Улсын их дэлгүүр- Баруун дөрвөн зам-Таван шар-61-н гарам-Хүй долоон худаг гэсэн маршрутаар 50 км мото парад зохион байгуулж, арга хэмжээнд БНХАУ, ОХУ, БНСУ, АНУ, Малайз, Вьетнам зэрэг улсуудаас 300 гаруй, Монгол Улсаас Улаанбаатар хот болон 21 аймгийн 45 гаруй клубийн 2500 гаруй нийт 2800 гаруй мотоцикл сонирхогчид оролцов. Арга хэмжээний үеэр оролцогчдын дунд гар барилдах, туг сүлжих, мото удаан явах зэрэг тэмцээн уралдаан болон мото тууний дагалдах хэрэгслийн үзэсгэлэн, гэр, майхан кемпийн үйлчилгээ, хоол, ундааны үйлчилгээ болон мото үзүүлбэр, морьтон баатруудын үзүүлбэр, урлаг соёлын арга хэмжээнүүдийг зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 10000 гаруй хүн үзэж сонирхлоо.	100	
381			11	“Даншиг наадам-Иргэдийн баяр” арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	10,300.0	-	-	-	-	10,300.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	-	15000	2,500.0	НАЖГ	Монголчуудын уламжлалт өв соёлыг таниулан сурталчлах, Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Монголын бүрхан шашинтны төв Гандантэгчэнлин хийдтэй хамтран “Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр-Хүрээ цам даншиг наадам” арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд Хүй долоон худгийн “Монгол наадам цогцолбор”-т зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр цам харайх ёслол, “Очирваань” бүрхны тахилга, сор залах ёслол, соёмбот туг залах ёслол үйлдэж, лам нарын дунд ном хэлэлцэх, мэтгэлцэх, балин тосон урлал, хурал номын ая эгшиг унэад голч нарын тэмцээн болон Үндэсний хүчит 256 бөхийн барилдаан, 6 насны хурдан морины уралдаан, жороо морьдын уралдаан, морьт харвааны тэмцээн, сээр шаглах тэмцээн, “Ухай” шагайн харвааны тойром, үндэсний сур харвааны тэмцээн тус тус зохион байгууллаа. Арга хэмжээг гадаад, дотоодын нийт 30,000 гаруй хүн үзэж сонирхсон.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүү-лэх байгуул-лага	Хэрэгжилт	Хувь	Биелээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он					
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)	Үндсэн			
382			12	"Плэйтайм" олон улсын амьд хөгжмийн наадмыг зохион байгуулна.	2025-2028	-	80.0	-	-	-	-	80.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	30000	55000	20.0	НАЖГ	Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, гадаад, дотоодын иргэд, жуулчдын сонирхлыг татах бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, “Амьд хөгжмийн наадам” ТББ хамтран “Плэйтайм-2025” олон улсын хөгжмийн наадмыг 23 дахь жилдээ 2025 оны 07 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр “Тайж хайрхны бэл”-д зохион байгууллаа. Азийн тэргүүлэх хөгжмийн фестиваль болох зорилготой “Плэйтайм-2025” олон улсын хөгжмийн наадамд гадаадын 20 улсын 40 хамтлагийн 150 уран бүтээлчид, Монгол Улсаас 300 гаруй хамтлаг дуучид нийт 450 гаруй хамтлаг, уран бүтээлчид 4 өдрийн турш 12 тайзнаас уран бүтээлээ хүргэж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 94,436 хүн үзэж сонирхсон.	100	
383			13	“Дээлтэй Монгол наадам” арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	400.0	-	-	-	-	400.0	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	10000	12000	100.0	НАЖГ	Тулгар төрийн 2234 жил, Их Монгол Улсын 819 жил, Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 114, Ардын хувьсгалын 104 жилийн ой, Үндэсний их баяр наадмын хөтөлбөрийн хүрээнд Монголчуудын уламжлалт соёл, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Улсын хүүхэд залуучуудын театр, Монголын Аялал жуулчлалын холбоо, “Монгол костюмс” төв хамтран “Дээлтэй Монгол наадам”-ыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа. “Дээлтэй Монгол наадам”-ын баярын жагсаалд БНХАУ-ын ӨМӨЗО-оос 50 гаруй Монгол туургатны төлөөлөл, 21 аймаг, нийслэлийн 6 дүүрэг болон “Бяцхан мисс Олон улсын хүүхдийн байгууллага”, “Андра академи”, "Монголын Үндэсний уламжлалт уран хатгамалчдын холбоо", “Монгол Оршихуйн Ухаан” зэрэг 10 төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдээс 7000 гаруй хүн оролцлоо. Арга хэмжээнд оролцогчдоос шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг дээл урлаач, гадаадын шилдэг эрэгтэй, эмэгтэй оролцогч, хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг 12 номинациар шилдгүүдийг тодруулж, арга хэмжээний үеэр урлагийн тоглолт, үндэсний хувцасны загварын шоу үзүүлбэр, Монгол дээлийн үндсэн загварыг орчин үеийн хэв маягтай хослуулан загварчилсан үзүүлбэр, АХА асуулт хариултын тэмцээн зэрэг арга хэмжээ болон 6 дүүргийн жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч 48 иргэн, аж ахуй нэгж, байгууллага үндэсний дээл хувцас, эд хэрэглэлийн худалдаа үйлчилгээ зохион байгуулж арга хэмжээг гадаад, дотоодын нийт 10000 гаруй хүн үзэж сонирхсон.	83.3	
384			14	"Даншиг наадам-Хүрээ цам" арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	3,330.0	-	-	-	-	#REF!	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	20000	25000	780.0	НАЖГ	Монгол улсыг гадаад улс оронд сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, аялал жуулчлалаас эдийн засагт үзүүлэх үр нөлөөг нэмэгдүүлэх зорилогоор Монгол номадик жуулчны баазтай хамтран “Даншиг бэсрэг наадам” арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 02,03-ны өдрүүдэд зохион байгууллаа. Арга хэмжээний үеэр цагаан идээ боловсруулах, ноос савах, эсгий урлал хийх, үхэр, тэмээн тэргээр нүүдэл хийх болон, Шувуулахуй /Махчин анч шувуудын үзэсгэлэн, үзүүлбэр/, Монгол банхрын хүрээ, үндэсний урлагийн тоглолт, үндэсний бөх, сур харваа, шагайн харваа, морьт харваа, хурдан морины уралдаан, цам харайх үзүүлбэр зохион байгуулж, арга хэмжээг 1000 гаруй аялагч, жуулчид үзэж сонирхов.	75	
385			15	"Хийморь" морьт харвааны олон улсын тэмцээн арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	400.0	-	-	-	-	#REF!	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	5000	7000	80.0	НАЖГ	Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүнийг бий болгох, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Азийн Морьт Харвааны Холбоо”, “Монголын Морьт Харваачдын Холбоо” болон “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолбортой хамтран "Хийморь" азийн аварга шалгаруулах олон улсын морьт харвааны тэмцээнийг 2025 оны 08 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа. Тэмцээнд Монгол, АНУ, Австрали, БНХАУ, БНСУ, БНТУ, Франц, Унгар, Румын, Малайз, Япон, Зимбабве, ӨАБНУ, ОХУ-ын Бүгд Найрамдах Саха Улс (Якут) зэрэг 18 улсын 60 гаруй тамирчид оролцлоо. "Хийморь" азийн аварга шалгаруулах олон улсын морьт харвааны тэмцээнийг "Ази харваа"," Унгар харваа", "Турк харваа", "Бөмбөг намнаа болон багийн гэсэн 5 төрлөөр зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын нийт 8000 гаруй хүн үзэж сонирхсон.	100	
386			16	"Улаанбаатар" олон улсын фото зургийн фестиваль зохион байгуулна.	2025-2028	-	80.0	-	-	-	-	#REF!	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	-	-	-	НАЖГ	"Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр-Хүрээ цам даншиг наадам” 06 дугаар сарын 28, 29-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, арга хэмжээний үеэр “Богдын хүрээ ба Улаанбаатар” түүхэн фото зургийн үзэсгэлэн мөн Нийслэл хотын түүхэн дурсгалт барилгуудын лего үзмэрүүд болон Судлаач, уран бүтээлч С.Чулуунбаатарын түүхэн судалгаанд тулгуурлан VIII Богд Жавзандамбын амьдралтай холбоотой онцгой цуглуулгуудыг тодоор сэргээн баринтагласан 12 ширхэг усан будгийн уран зургийн бүтээлүүдийг олон нийтэд дэлгэн үзүүлж, үзэсгэлэнг 1000 гаруй хүн үзэж сонирхсон.	100	
387			17	"Ай Тм Эм" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг зохион байгуулна.	2025-2028	-	90.0	-	-	-	-	#REF!	Оролцогч, сонирхогч жуулчид, тоо	3000	4000	21.0	НАЖГ	Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “ITM Mongolia-2025” (International Travel Mart) олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг 26 дахь жилдээ "Тогтвортой аялал жуулчлал-Хариуцлагатай аялагч" уриан дор 2025 оны 10 дугаар сарын 24-26-ны өдрүүдэд "Мишээл экспо" төвийн үзэсгэлэнгийн танхимд зохион байгууллаа. Үзэсгэлэнд 19 аймгийн тур оператур компани, амралтын газар, жуулчны бааз, ресторан, зоогийн газар, аяллын хэрэгсэл ханган нийлүүлэгч, аяллын бүтээгдэхүүн үйлчилгээ эрхлэгч болон урлаг, соёлын 300 гаруй аж ахуйн нэгж байгууллага оролцож, үзэсгэлэнг гадаад, дотоодын нийт 8000 гаруй хүн үзэж сонирхсон.	100	
388			18	Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейг сэргээгдэх эрчим хүчээр хангах барилга угсралтын ажлыг гүйцэтгэнэ.	2025-2028	-	3,200.0	-	-	-	-	3,200.0	Барилга, угсралтын ажлын явц, хувь	70	100	200.0	НАЖГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/253 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлж, Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын музейн зураг төсвийн ажил 160,000,000 (нэг зуун жаран сая)-ын худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагаар “Аркосис” ХХК шалгарч зургийг гүйцэтгэж батлуулав. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/717 дугаар захирамжаар Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолборын цахилгааны эх үүсвэр, тохижилтын ажлын 40,000,000 (дөчин сая) худалдан авах ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагаар “Филипс гэрэлтүүлэг” ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж, хүлээн авах Ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ажилласан.	100	
389	3.4.2.Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.		1	Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын улирлын хугацааг уртасгана.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Бүтээгдэхүүн, үйлчилгээ, тоо	15	20		НАЖГ	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “Go Winter - Өвлийн хямдралтай аян”-ыг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 салбарын 82 аж ахуйн нэгж, байгууллага 100 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 10-50 хувь хүртэл хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүллээ.	100	
						-	-	-	-	-	-	-	Хамрагдсан байгууллага, тоо	69	80		НАЖГ	“Go Winter - Өвлийн хямдралтай аян”-ыг 4 салбарын 82 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан.	100	
390	3.4.3.Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллана.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлнэ.	1	Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнд жижиг, дунд бизнес эрхлэгчдийг хамруулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Арга хэмжээнд хамруулсан жижиг, дунд бизнес эрхлэгчид, тоо	488	500		НАЖГ	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан 20 эвент арга хэмжээ, үзэсгэлэнгийн үеэр түр ажлын байр бий болгож 751 жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдааг гаргаж 14,579,681,400 төгрөгийн борлуулт хийсэн. Мөн Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээний хүрээнд жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 21 аж ахуйн нэгж, иргэн 2130 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, үзэсгэлэн худалдаа зохион байгуулав.	84.6	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
391	3.4.4.Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэт технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилна.	Аялал жуулчлалын салбарт инновацыг нэвтрүүлж, гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлж, сурталчилгаа, маркетингийн ажлыг нэмэгдүүлнэ.	1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчилна.	2025-2028	-	580.0	-	-	-	-	580.0	Эй Ар Ви Ар (AR VR) дэвшилтэд технологиор бүтээсэн контент, тоо	-	2	100.0	НАЖГ	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд мета куэст 3S төрлийн 11 ширхэг Ви Ар (VR) тохөөремжийг худалдан авч, 8 арга хэмжээ, 13 үзвэр, үйлчилгээний газар, 6 дурсгалт газар нийт 27 бүтээгдэхүүн үйлчилгээнд VR 360 зураг авалт хийж, Web AR 3D модель контент хийсэн.	100	
392	3.4.5.Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагаг эрчимжүүлнэ.		1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчилна.	2025-2028	-	2,150.0	-	-	-	-	2,150.0	Оролцсон олон улсын үзэсгэлэн, тоо	4	9	400.0	НАЖГ	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, зорилгоор Соёл спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран олон улсын 9 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож, Улаанбаатар хотыг сурталчилсан. Үүнд: ХБНГУ-ын Берлин хотноо 2025 оны 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ITB Berlin” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНХАУ-ын Засаг Захиргааны онцгой бүс болох Хонгконг хотноо 2025 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбооны (WTCF) ээлжит чуулга уулзалт арга хэмжээ, БНХАУ-ын Бээжин хотноо 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “COTTM-2025” (China Outbound Travel & Tourism Market) олон улсын үзэсгэлэн, Улаанбаатар хотноо 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар травэл экспо 2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 06 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “SITF 2025-Seoul International Travel Fair” олон улсын үзэсгэлэн, БНСУ-ын Бусан хотноо 2025 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Дэлхийн Хотуудын Аялал Жуулчлалын дээд хэмжээний уулзалт”, Япон улсын Токио хотноо 2025 оны 09 дүгээр сарын 25-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Tourism Expo Japan -2025” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНСУ-ын Жэжү мужад 2025 оны 11-р сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Жэжү Олле” явган алхалтын фестиваль, БНХАУ-ын Ханиань мужийн Саньяа хотноо 2025 оны 11 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгууладсан Азι, номхон далайн аялал жуулчлалын холбоонооос зохион байгуулсан арга хэмжээ.	100	
393	3.4.6.Гадаад, дотоод хэвлэл мэдээллийн байгуллагууд, дэлхийд алдартай аялагч, нөлөөлөгчдийг урин Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилна.		1	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад цахим орчинд нөлөө бүхий инфлюнсрээр дамжуулан сурталчилна.	2025-2028	-	650.0	-	-	-	-	650.0	Олон улсад Сошиал орчинд нөлөө бүхий инфлюнсэрээр сурталчилсан сурталчилгаа, тоо	2	4	130.0	НАЖГ	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах зорилгоор "Бүргэдийн баяр-2025" арга хэмжээний үеэр Аяллын тойрог нэвтрүүлэг, "УБ фүүд фестиваль-Узбек улсын хоолны өдөрлөг" арга хэмжээний үеэр сошиал орчинд нөлөө бүхий 2 инфлюнсэрээр, Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээг Унгар улсын 5 инфлүнсерээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 2,250,000 хүнд хүргэсэн.	100	
Зорилтын үр дүн: 3.5.Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлж, хүнсний бүтээгдэхүүний бүх үе шатанд эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангуулах хяналтыг сайжруулж, нийслэлийн хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.																				
394	3.5.1."Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний	Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний улирлын хэлбэлзлийг бууруулна.	1	"Алтан намар", "Намрын ногоон өдрүүд" зэрэг төмс хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулна.	2024-2028	-	245.0	-	-	-		245.0	Худалдан борлуулсан төмс, хүнсний ногооны хэмжээ, тонн	14314	15000	60.0	УБЗАА	1.ХХААХҮ Сайдын 2025 оны А/342 дугаар тушаал, ХЕМ-ын 2025 оны А/138 дугаар тушаалаар “Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2025” арга хэмжээг 2025.09.22-28-ны өдрүүдэд Төв цэнгэлдэх хүрээлэнд 21 аймаг болон нийслэлийн 200 гаруй төмс, хүнсний ногооны тариаланчид, ЖДҮ эрхлэгчдийг оролцуулж 3000 орчим нэр төрлийн бүтээгдэхүүний борлуулалтыг дэмжин ажиллаж байна. 2.Нийслэлийн хүн амыг эх орны хөрсөнд ургасан шинэ ургацын төмс, хүнсний ногоогоор хангах, дархлаат дэмжих, нөөцлөх, нөөшлөх боломжийг бий болгох, нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2024 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн "Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдаа зохион байгуулах тухай" А/133 дугаар тушаалаар “Алтан намар” арга хэмжээний хүрээнд Төмс, хүнсний ногооны өргөтгөсөн худалдааг зохион байгуулах 21 байршил болон мөрдөх зааврыг батлуулж дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөл, Нийслэлийн хүнс, хөдөө аж ахуйн, Нийслэлийн Эрүүл мэндийн газарт хүргүүлж, нэгдсэн удирдлагаар ханган ажилласан. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны ХХҮГ нь дүүргүүдийн Засаг даргын Тамгын газрын ХХҮХ-ийг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж, дүүргүүд зохионж байгуулалтыг хийж, нийслэлийн Хүнс, хөдөө, аж ахуйн газар, нийслэлийн Эрүүл мэндийн газрын 15 улсын (ахлах) байцаагч хяналт тавин ажилласан.Арга хэмжээг 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл хугацаанд 9 дүүргийн хэмжээнд 19 байршилд зохион байгуулж, Улаанбаатар хотын болон Сэлэнгэ, Ховд, Өмнөговь, Дархан-Уул, Төв зэрэг 20 орчим аймгийн 218 гаруй тариаланч, ногоочид оролцуулж, 23 нэр төрлийн 5,497 тонн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийг худалдаалж, 2,1 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна.	100	
395			2	Нийслэлийн хүн амын хаврын улирлын махны хангамж, үнийг тогтвортой байлгах зорилгоор мах бэлтгэн нөөцлөх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулна.	2024-2028	-	22,900.0	-	-	-	-	22,900.0	Бэлтгэн нөөцөлсөн махны хэмжээ, тонн	6198	8000	7,900.0	НХХААГ	2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтад 10 аж ахуйн нэгж шалгаран, нийт 8380 тн мах бэлтгэн нөөцөлсөн. Худалдан борлуулалт 85 хувийн гүйцэтгэлтэй буюу 7123 тн мах худалдан борлуулсан. 2026 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бэлтгэх 15 аж ахуйн нэгж сонгон шалгаруулалтад тэнцсэнээс 9 аж ахуйн нэгж 5016,5 тн мах бэлтгэн нийлүүлэхээр "Мах бэлтгэх гэрээ" байгуулан, бэлтгэл ажилдаа орон ажиллаж байна. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ 2025 оны 11 дүгээр сард 26.9 мян.тн байна.	75	
396			3	Нийслэлийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.	2025-2027	-	-	-	-	-	-	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хувь	-	30		НХХААГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/292 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгээс нийслэлийн хүнсний аюулгүй байдлыг сайжруулах үйл ажиллагааны 4 чиглэлийн 13 бүлэг 37 арга хэмжээг 2025 онд 28,476.3 сая төгрөг, 2026 онд 271,164.0 сая төгрөг, 2027 онд 419,502.5 сая төгрөг буюу нийт 719,412.8 сая төгрөгийн санхүүжилт шаардах төлөвлөгөөний төслийг боловсруулсан. Тус төлөвлөгөөний төсөвд мал аж ахуйн үйлдвэрлэлийн чиглэлээр 13, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах чиглэлээр 10, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 10, сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоол тэжээлийн хангамжийн чиглэлээр 4 арга хэмжээг тус тус төлөвлөсөн. Төлөвлөгөөний хэрэгжилт 10 хувьтай байгаа бөгөөд холбогдох нотлох баримтыг хавсаргав.	65	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
397	бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг дэмжиж, иргэдийг хямд, чанартай, эрүүл, аюулгүй дотоодын хүнсний бүтээгдэхүүнээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	Нийслэлийн хүн амын дотоодын хүнсний бүтээгдэхүүний хангамжийг нэмэгдүүлнэ.	4	"Улаанбаатар 4 улирлын хүлэмж" буюу "Хятад Монголын хамтын ажиллагааны хүнсний ногооны технологийн жишиг парк байгуулах" төслийг үе шаттай хэрэгжүүлнэ.	2025-2039	-	-	-	-	42,813.8		42,813.8	Төслийн хэрэгжилтийн явц, хувь	30	70	16,371.4	УБХХК ХК	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн "Улаанбаатар 4 улирлын хүлэмж" төслийг хэрэгжүүлэх хуулийн этгээдийг байгуулах тухай" 25/76 дугаар тогтоолоор орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг БНХАУ-ын "Тяньжин хүнс групп" ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсад байгуулагдсан "Тианжин стэйт фармс агрибизнес монголиан сабсидаири" ХХК-тай хамтран байгуулахыг орон нутгийн өмчит "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК (Ж.Сандагсүрэн)-д зөвшөөрсөн. 2025 оны 05 дугаар сард Улаанбаатар хотын зүгээс бэлтгэл ажлыг бүрэн хангаж гэрээ байгуулах хүсэлтэй байгаагаа Тяньжин хүнс групп ХХК-д мэдэгдсэн. 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас Тяньжин хотын захирагч бөгөөд намын орлогч даргад 01/6755 дугаартай албан бичгээр төслийн ажлыг эрчимжүүлэх хүсэлт хүргүүлсэн.	55	
398			5	Нийслэлийн хүн амын өргөн хэрэглээний хүнсний бүтээгдэхүүн сүү боловсруулах үйлдвэр, нарийн ногооны тариалдаг дотоодын аж ахуйн нэгжид бодит дэмжлэг үзүүлж, дотоодын үйлдвэрлэлээс сүү, нарийн ногооны боломжит төрлөөр 100 хувь бүрэн хангана.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Сүүний дотоодын хэрэгцээний хангалтын дундаж түвшин	99.8	99.8		НХХААГ	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 130-р тогтоолоор батлагдсан "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох" журмын дагуу урамшуулал олгож эхэлснээр сүү боловсруулах үйлдвэрийн өвлийн улирлын түүхий эдийн хангамж нэмэгдэж, импортын хуурай сүүний нийлүүлэлтийг тогтвортой, нэмэгдүүлэхгүй байхад чухал нөлөө үзүүлж байна. Дээрх тогтоолын хүрээнд 2024-2025 онд 2218 фермер эрхлэгч, 6,3 сая литр сүүг бэлтгэн нийлүүлж, 6,3 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон бөгөөд 2025 онд дээрх жүрмын дагуу сонгон шалгаруулалтад 13 аж ахуйн нэгж тэнцэн, 2025 оны 11 дүгээр сарын 01-ээс 2026 оны 03 дугаар сарын 01-ний хугацаанд сүүний урамшуулалд хамрагдах фермер эрхлэгчдээс сүүг хүлээн авхаар ажиллаж байна. Үйлдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүүний хэмжээ нь 2024 оны 10 дугаар сарын байдлаар 47083.8 мян.л байсан бол 2025 оны 10 дугаар сарын байдлаар 49242.14 мян.л байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2158.3 мян.л-ээр буюу 5 %-иар өссөн дүнтэй байна.	100	
399			6	Газар тариалан эрхлэх иргэдийг төсөл хөтөлбөрт хамруулна.	2025-2028	-	-	-	721.8	-		721.8	Төсөлд хамрагдсан иргэд, тоо	-	50	721.8	НХХААГ	Монгол Улсын Засгийн газрын 47 дугаар тогтоолоор Атрын 4 тариалангийн тогтвортой хөгжлийн ХХААХҮСайдын Чиглэл хүргүүлэх тухай 01/1310 албан тоотын дагуу иргэн аж ахуйн нэгж, хоршоодтой "Хяналт тавих гэрээ"-г хийхээр чиглэл ирсний дагуу 3 иргэн, 5 аж ахуйн нэгжтэй 1.6 тэрбум төгрөгийн гэрээ хийж, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллалаа. Итали улсын ASIA олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар Хүнс, Хөдөө аж ахуйн уян хатан, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд тариаланчдыг дэмжих төслийн хүрээнд Баянзүрх дүүргийн 33-р хорооны 19, 21, 22-р гудамж, 34-р хорооны 64-р гудамжны 30 өрх, Сонгинохайрхан дүүргийн 22-р хорооны хилчин 76-р гудамж, 34-р хорооны толгойтын 59-р гудамж, 42-р хорооны Хангай 17,18-р гудамжны 45 өрх, нийт 75 өрх хамрагдсан. Төслийн хүрээнд гудамж бүрд хутаг гаргаж, хүнсний ногооны үр болон гар багаж зэргийг олгож, тариалсан талбайн хэмжээ 0,3 га талбайгаар нэмэгдүүлсэн. Япон улсын ЖАЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас хэрэгжүүлж буй "MON-SHEP" төслийг Хан-Уул дүүргийн 13-р хороонд хэрэгжүүлэхээр төслийн танилцуулга болон суурь судалгаа, зах зээлийн судалгаа хийж төсөлд 13 тариаланч хамрагдаж байна.	100	
400	3.5.2."Агросити" 45,000 тонн хүнсний нарийн ногоо хураах, хүлэмжийн аж ахуйн кластер бүхий эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг эхлүүлнэ.	Агросити эдийн засгийн тусгай бүсийн хот байгуулалтын үйл ажиллагааны баримт бичиг батлагдана.	1	Агросити эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэтийн тооцоог боловсруулна.	2025-2026	-	-	-	-	-	-	-	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувь	-	50		ХБХСГ	ХБХСГ: "Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичиг боловсруулах ажлын НХААГ/20250103049 дугаартай зөвлөх үйлчилгээний гэрээг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын эхлэлийн тайлбар 2025 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн 2025/01 дугаартай ажил хүлээлцэх актаар хүлээн авч, Нийслэлийн Ерөнхий Архитекторын дэргэдэх Нийслэлийн нутаг дэвсгэрт хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 44 дүгээр хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн тул эхлэлийн санхүүжилтийг олгосон. Одоогийн байдлаар дүндын тайлан боловсруулах шатандаа явж байна. (Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа тус төлөвлөгөөний дагуу хэтийн тооцоог боловсруулна.)	100	
401	3.5.3.Хүнс, нарийн ногоо, жимс, жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалалт, борлуулалтын цогцолбор төвүүдэд нийт 50,000 тонн багтаамжтай агуулах байгуулах бэлтгэл ажлыг тер, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдэж, иргэдийг эрүүл, баталгаат хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	Нийслэлийн хүн амыг чанартай, баталгаатай, эрүүл аюулгүй хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Хүнс, нарийн ногоо, жимс, жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалалт борлуулалтын цогцолбор барих бэлтгэл ажлыг хангана.	2025-2028	-	-	-	-	-		-	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	-	30		НХХААГ	Малын зах, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор төвийг хотын зүүн, баруун бүсэд байгуулах бэлтгэл ажлыг хангах чиг үүрэг бүхий Нийслэлийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг тер, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд "МБҮ Трейд" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, баруун хойд талд 15.0га, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Оргил худалдааны төвийн хойд талд 6.26га газрын асуудлыг шийдвэрлэн ТЭЗҮ болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчны үнэлгээ, ажлын зураг төсөл хийгдсэн. Энэ ажлын хүрээнд нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд "Улаанбаатар хотын хөгжлийн корпораци" ХК хариуцаж ажиллахаар тусгагдсан.	78	
402			2	Төмс, хүнсний ногооны зоорь, агуулахын үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, иргэдийн үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлж ажиллана.	2025-2028	-	-	-	-	-		-	Зоорь, агуулахын ашиглалтын түвшин, хувь	84.2	85		НХХААГ	Нийслэлд нийт 6 дүүргийн 102 аж ахуйн нэгж, иргэний 90,4 мянган тонн агуулах зоорь бүртгэлтэй байна. Нийслэлийн хүн амын нийт хэрэгцээнд төмс, хүнсний ногоо 184,6 мянган тонн шаардлагатай байдаг бөгөөд үүнийг хадгалах агуулах зоорины үчүн чадал 30 хувьтай байна. Нийслэлийн 5 дүүргийн 10 байршил буюу Буянт-Ухаа, Яармаг, Сонгинохайрхан, Толгойт, Сэлбэ, Дарь эх, Баянхошуу, Зуратт, Амгалан дэд төвүүдийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд хүнс, нарийн ногоо, жимс, жимсгэнэ, мах, махан бүтээгдэхүүнийг боловсруулах, хадгалалт, борлуулалтын 2000тн багтаамжтай агуулахыг 5 байршилд, 8000тн багтаамжтай агуулахыг 5 байршилд, нийт 50.0 мян.тн багтаамжтай хадгалалт, борлуулалтын цогцолбор төв байгуулах саналыг тусгаж, зоорь агуулахын судалгааг гарган ажиллаж байна. УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд нийт 15 аж ахуйн 42 мянган,тн багтаамжтай агуулах зоорь ашиглалтад орохоос 5800тн зоорь агуулах ашиглалтад орж 6 аж ахуйн нэгжийн 25 мян.тн гаруй агуулах 85 хувийн ажлын гүйцэтгэлтэй явж байна.	100	
403	3.5.4.Нийслэлийн мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэлийг	Малын үүлдэрлэг байдал сайжир цаашр	1	Малын үүлдэрлэг байдал, ашиг шимийг тодорхойлж мэдээллийн санг баяжуулан бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулна.	2025-2028	-	12.6	21.0	-	-	8.4	42.0	Бүртгэлжүүлсэн мал, тоо толгой	150	300	9.0	НХХААГ	Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын даргын "Өндөр ашиг шимт сүүний үхрийн бүртгэлжүүлэлтийн ажлыг зохион байгуулах тухай" 2025 оны 08 сарын 22-ны өдрийн А/29 тоот тушаалаар ажлын хэсэг, удирдамжийг батлан хэрэгжилтийг зохион байгуулан ажилласан. Үүнд Сонгинохайрхан, Баянзүрх, Хан-Уул дүүрэгт бүгд 6 аж ахуйн нэгж, 39 өрхийн өндөр ашиг шимт 2125 үхэрт ялган тэмдэглэгээ хийж малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан мэдээллийг оруулж, энэ онд өндөр ашиг шимтэй үхэрт ялган тэмдэглэгээ хийж гүйцэтгэлээ.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүү-лэх байгуул-лага	Хэрэгжилт	Хувь	Биелээгүй шалтгаан
															2025 он					
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)	Үндсэн			
404	ашиг шимийн чиглэлээр төрөлжүүлэн кластер хэлбэрээр хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.	эрлийз малын тоог нэмэгдүүлнэ.	2	Сүү, сүү махны хосолмол ашиг шимт үхэр сүрэгт малын гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажлыг зохион байгуулна.	2025-2028	192.0	-	-	-	24.0	24.0	240.0	Зохиомол хээлтүүлэгт хамрагдсан үнээ	450	500	60.0	НХХААГ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны харьяа Малын удмын сангийн үндэсний төвд хүсэлт гаргаж, улсын төсвийн хөрөнгөөр сүүний үхрийн эрчимжсэн аж ахуйн бүсэд нийт 890 үнээнд зохиомол хээлтүүлгийн ажлыг зохион байгуулахаар хуваарь гарч тус үйлчилгээг 2 үржлийн нэгжийн 4 мал үржүүлгийн техникчтэй хамтран зохион байгуулан хийж, Сонгинохайрхан, Хан-уул, Баянзүрх, Налайх дүүргүүдэд нийт 870 үнээнд хийгээд байна. Койка ОУБ-ын дэмжлэгтэйгээр хэрэгжиж буй “Хүртээмжтэй мал аж ахуй” төслийн хүрээнд 200 толгой саалийн үнээнд зохиомол хээлтүүлэг хийж, хээлийн шалгалт хийгдэж байна. Малчид, фермер эрхлэгч нарын захиалга хувийн хөрөнгөөр 313 үнээнд зохиомол хээлтүүлэг хийгдсэн. Нийт 135 өрх, фермерийн 1403 үнээнд зохиомол хээлтүүлэг хийж сүүний үхрийн чанар, ашиг шимийг нэмэгдүүлсэн.	100	
405	3.5.5.Эх орны болон импортын хүнсний бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг хангуулж, иргэдийг эрүүл аюулгүй хүнсээр хангагдах нөхцөлийг бүрдүүлнэ.	Хүнсний сүлжээний бүх үе шатанд хяналтыг сайжруулж иргэдийг эрүүл, аюулгүй хүнсээр хангана.	1	Хүнсний сүлжээний бүх шатанд төлөвлөгөөт, урьдчилан сэргийлэх, төлөвлөгөөт бус, гүйцэтгэлийн хяналт шалгалт, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажил хийнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Хяналт шалгалтын ажлын тухайн жилийн гүйцэтгэл, хувь	96.7	100		НХХААГ	2025.11.18-ны байдлаар төлөвлөгөөт шалгалтад 478, төлөвлөгөөт бус шалгалтад 1382, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад 1865 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан байна. Шалгалтын явцад 321 зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 61 зөрчлийн хэрэг нээж, 255 зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж холбогдох хууль тогтоомж, дүрэм журам зөрчсөн 325 аж ахуйн нэгж иргэнд 552,500,000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 491,500,000 төгрөгийн буюу нийт торгуулийн 88,9 хувийг барагдуулсан. Мөн 40 аж ахуйн нэгж иргэний зөрчил үйлдэж олсон хууль бус орлого болох 41,369,298 (дөчин нэгэн сая гурван зуун жаран есөн мянга хоёр зуун ерэн найман мянган) төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 250 аж ахуйн нэгж иргэнд 490 заалттай эрх бүхий албан тушаалтны албан даалгавар хүргүүлж биелэлтийг хангуулж ажилласан байна. Шалгалтаар 365 нэр төрлийн 6154 ширхэг 5638кг 121,182,094 (нэг зуун хорин нэгэн сая нэг зуун наян хоёр мянга ерэн дөрвөн) төгрөгийн хадгалалтын хугацаа дууссан бүтээгдэхүүнийг устгуулахаар, 7 нэр төрлийн 106 ширхэг 613,600 (зургаан зуун арван гурван мянга зургаан зуун) төгрөгийн бүтээгдэхүүнийг улсын орлого болгохоор НЗД-ын дэргэдэх орон тооны бус зөвлөлд шилжүүлсэн ажилласан. Мөн хаяг шошгын зөрчилтэй 258 нэр төрлийн 226 кг 65505 ширхэг 195,980,800 (нэг зуун ерэн таван сая есөн зуун наян мянга найман зуун) төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг буцаан татан авхуулж хаяг шошгын зөрчлийг арилгуулж болзошгүй эрсдэлээс сэргийлэн ажилласан. Хүнсний аюулгүй байдлыг хангах, хууль тогтоомж, стандарт, техникийн зохицуулалт, дүрэм, журмыг мөрдүүлж ажиллах талаар зохион байгуулсан 55 удаагийн сургалтад хүнсний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 1469 аж ахуйн нэгж, 1238 иргэнийг хамруулж хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрд аюулгүй байдлыг хариуцах, хүнсний аюулгүй байдлыг хангаж эрсдэлгүй ажиллах талаар зөвлөгөө зөвлөмж өгч, гарын авлага тараах материал, постер, сэрэмжлүүлэг бэлтгэн хүргүүлж, мэдлэг, мэдээлэл олгосон.	100	
						-	-	-	-	-	-	-	Зөрчил арилгуулалтын түвшин, хувь	73	73.5		НХХААГ	Шалгалтаар 3022 зөрчил илрүүлж 2302 зөрчлийг арилгуулан 340 иргэн, аж ахуйн нэгжид 1794 заалттай албан шаардлага хүргүүлж гүйцэтгэлийн шалгалтаар 266 албан шаардлагын 1338 заалт буюу албан шаардлагын биелэлт 74,5 хувьтай хэрэгжсэн байна.	100	
406	3.5.6.Газар тариалан, хүлэмжийн аж ахуйн тариалалт, хадгалалт, борлуулалт, түгээлтийн сүлжээнд ургамлын эрүүл ахуй, хорио цээрийн шаардлагыг хангуулж хэрэглэгчдэд чанартай бүтээгдэхүүн нийлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	Нийслэлийн иргэд гарал үүсэл тодорхой, эрүүл аюулгүй хүнсний ногоо, жимс жимсгэнээр хангагдана.	1	Хүлэмж, газар тариалан эрхлэгчдийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Хяналт шалгалтад хамрагдсан объект, тоо	249	250		НХХААГ	Тайлангийн хугацаанд ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн тариалагч, хадгалан борлуулагч 219 аж ахуйн нэгж, 183 иргэнийг /нийт 402/ хяналт шалгалтад хамруулан, тэдгээрийн тариалсан болон хадгалж худалдаалж буй ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд газар дээр нь үзлэг хийж, шаардлагатай тохиолдолд дээж авч итгэмжлэгдсэн лабораторид шилжүүлж ажилласан. Шалгалтаар 511 зөрчил илрүүлж 378 буюу 73.9 хувийг арилгуулан, зөрчил бүхий 31 аж ахуйн нэгж, 26 иргэнд Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 87600 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээг 44 хэргийг хялбаршуулсан журмаар, 9 хэргийг зөрчлийн хэрэг нээн шийдвэрлэн ажилласан байна. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хүрээнд 8 иргэн, аж ахуйн нэгжийн 32 нэрийн 985 кг хугацаа дууссан 2474 ширхэг, 35204.8 мянган төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг хураан авч, Нийслэл дэх зөвлөлд шилжүүлж устгуулж ажилласан. Шалгалтын явцад 38 аж ахуйн нэгж, иргэний давхардсан тоогоор 90 гаруй нэр төрлийн жимс, ногоо, хүнсний улаанбуудай, хүнсний ногооны үр, хөрс зэрэг бүтээгдэхүүнээс 548 дээж авч, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид ургамлын хорио цээр, пестицид, бордооны үлдэгдэл, нян судлалын аюулгүй үзүүлэлтээр тус тус шинжлүүлж ажилласан. Шалгалтаар 18 аж ахуйн нэгж, иргэнд 93 заалттай улсын /ахлах/ байцаагчийн хугацаатай албан шаардлага, 48 иргэн, аж ахуйн нэгжид эрх бүхий албан тушаалтны 56 заалттай албан даалгавар тус тус хүргүүлж, биелэлтэд эргэж хяналт тавихад улсын байцаагчийн албан шаардлагын 75 заалт, албан даалгаврын 52 заалт тус тус биелэсэн байна.	100	
						-	-	-	-	-	-	-	Зөрчил арилгуулалтын түвшин, хувь	71	73		НХХААГ	Тайлангийн хугацаанд хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтуудын хүрээнд Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай, Ургамлын эрүүл мэнд, ургамал хамгааллын тухай, Таримал ургамлын үр, сортын тухай, Тариалангийн тухай хуулийн холбогдох зарим заалтыг зөрчсөн 511 зөрчил илрүүлэн 378 зөрчил буюу 73.9 хувийг арилгуулсан нь зорилтыг ханган ажилласан байна.	84.5	
407			2	Ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдалд лабораторийн шинжилгээтэй урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийнэ.	2025-2028	-	250.0	-	-	-	-	250.0	Тариалан эрхлэгчдийн хүнсний сүлжээнд нийлүүлсэн таримлыг шинжилгээнд хамруулсан дээж	570	600	60.0	НХХААГ	Тайлангийн хугацаанд хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт, гомдол мэдээллийн хүрээнд хүлэмж, газар тариалан эрхлэгчид болон тэдгээрийг хадгалж худалдаалж буй 17 иргэн, 21 аж ахуйн нэгжийн ургамал, ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнээс 548 дээж авч, холбогдох шинжилгээг хийлгүүлсэн. Нийт шинжлүүлсэн 548 дээжийн 56 буюу 10.3 хувь нь хаврын тариалалтад тариалах тарих үр, үрийн материал, 489 дээж буюу 89.7 хувь нь ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн байсан бөгөөд 540 дээжийн 130 дээж буюу 24.0 хувийг гомдол мэдээллийн хүрээнд, 410 дээж буюу 76 хувийг төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтуудын хүрээнд авч, шинжлүүлж ажилласан байна. 2025 онд хяналт шалгалтаар 540 дээж авч, 415 дээж буюу 15.2 сая төгрөгийн шинжилгээг үнэ төлбөргүй хийсэн бол гомдол мэдээллийн хүрээнд хийсэн 130 дээжийг иргэн, аж ахуйн нэгжээр барагдуулж ажилласан байна. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд хяналт шалгалтуудын хүрээнд нийслэлийн нутаг дэвсгэрт газар тариалан, хүлэмжийн аж ахуй, агуулах зоорийн аж ахуй эрхлэгчдийн ургамал, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хөндлөнгийн хяналт хийж, лабораторийн шинжилгээтэй хяналт хийх зорилгоор 250.0 сая төгрөг төсөвлөсөн боловч батлагдаагүй улмаас байгууллагын төсвөөс 15.2 сая төгрөгийн шинжилгээтэй хяналтыг хийсэн боловч ХАБҮЛЛ-д шинжилгээний төлбөр төлөгдөөгүй байна.	100	
						-	-	-	-	-	-	-	Лабораторийн шинжилгээгээр шаардлага хангаагүй дээжийн эзлэх түвшин	1.2	1		НХХААГ	Хяналт шалгалтын хүрээнд авсан 548 дээжийг дунджаар 3-10 үзүүлэлтээр шинжлүүлж итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгээр 6 дээж тус бүр 1 үзүүлэлтээр шаардлага хангаагүй нь 1.0 хувийг эзэлж байна. Шаардлага хангаагүй шинжилгээний дүнг үндэслэн 1 аж ахуйн нэгж, 3 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 6.15 дугаар зүйлийн 3.1 дэх, 1 иргэнд 7.8 дугаар зүйлийн 5 дахь заалтаар нийт 5950.0 мянган төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч 103.0 мянган төгрөгийн үнэ бүхий бүтээгдэхүүнийг хураан авч Нийслэлийн Засаг даргын дэргэх зөвлөлд албан бичгээр шилжүүлэн шийдвэрлүүлж, устгуулан ажилласан.		
408	3.5.7.Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, тандалт судалгаанд олон улсын стандартад нийцсэн арга зүйг нэвтрүүлэн, хүнсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээг сайжруулна.	Хүнсний бүтээгдэхүүний чанар аюулгүй байдлыг хангуулна.	1	Хяналт шалгалтын үр дүнд суурилж хүнсний сүлжээний үе шатанд эрсдэлийн шалгуур үнэлгээг сайжруулан, хяналтын хуудсыг боловсронгуй болгоно.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Шалгуур үзүүлэлт сайжруулсан санал, тоо	-	5		НХХААГ	Хяналт шалгалт хийх Хүнсний үйлдвэрлэлийн 8.2.1, 8.2.1.1, 8.11.2 дугаартай 3 хяналтын хуудас, ургамал хамгааллын хяналтын чиглэлийн 8.18, 8.28, 8.41, 8.24 дугаартай 4 хяналтын хуудсанд зарим холбогдох хууль тогтоомж өөрчлөгдсөнтэй холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулах санал, Худалдаалах үйл ажиллагааг шалгах 8.11.1, Согтууруулах ундаа худалдах худалдааны газрын үйл ажиллагааг шалгах 8.11.2, Хоол үйлдвэрлэлийг шалгах 8.10.1, 8.10.2, 8.10.5 кодтой хяналтын хуудсанд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны салбарын хяналтын газарт хүргүүлж, Хүнс, хөдөө аж ахуй,хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2025 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/166 дугаартай тушаалаар өөрчлөлт орж батлагдсан байна.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
409	3.5.8.Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.	Хүнсний сүлжээний бүх шатанд зориулалтын бус савны хэрэглээ буурна.	1	Хяналт шалгалтад үндэслэн зориулалтын бус савны хэрэглээний судалгаа гаргана.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Судалгаанд хамрагдсан объект, тоо	-	300		НХХААГ	ХХААХҮЯ-ны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2025.06.27-ны өдрийн 08-00-02/30 дугаартай удирдамжийн дагуу сав баглаа боодол импортлогч, үйлдвэрлэгч, хүнсний сүлжээнд нийлүүлж худалдаалдаг нийт 107 аж ахуйн нэгж, иргэнийг хамруулан хяналт шалгалт, тандалт судалгаа хийсэн. Мөн "Нарантуул трейд" ХХК-ийн Нарантуул худалдааны төвийн гадна павилионд сав баглаа боодол худалдаалдаг 32 иргэний 52 нэр төрлийн сав баглаа боодлыг Стандарт хэмжил зүйн газрын Нийслэлийн лавлагаа лабораторид шинжлүүлсэн. Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд Хүнсний бүтээгдэхүүний нийлэг сав баглаа боодол. Ерөнхий шаардлага MNS5547:2005 стандартыг шинэчлэх, нэршлийг өөрчлөх, холбогдох хуультай уяялуулах талаар саналыг 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 793 дугаартай албан бичгээр хүргүүлж ажилласан байна.	78	
410			2	Сургалт сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагаагаар дамжуулан зориулалтын бус савны хэрэглээг бууруулна.	2025-2028	-	24.0	-	-	-	-	24.0	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	4	6.0	НХХААГ	Хүнсний аюулгүй байдал, сав, баглаа боодол, шошго, зөв зохистой хэрэглээний талаар Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэн болон холбогдох төрийн бус байгуллага, мэргэжлийн холбоодтой хамтран нийт 35 удаагийн сургалт зохион байгуулсан. Сургалтад хүнсний сүлжээ эрхлэгч 1549 аж ахуйн нэгж, иргэн ,ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдыг хамруулж, хүнсний аюулгүй байдлын шаардлага хангаагүй, хүнсний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй зориулалтын бус хуванцар бав, баглаа боодлыг хүнсний сүлжээнд ашиглахгүй байх талаар сэрэмжлүүлэг мэдээлэл, постер, гарын авлага бэлтгэн хүнсний сүлжээ эрхлэгч 2707 газарт хүргэсэн. Хэрэглагчдэд сэрэмжлүүлэх зорилгоор чанар, стандартын шаардлага хангаагүй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн, зориулалтын бус сав баглаа боодлыг байгуллагын шилэн хоргонд байршуулж, MYOHPT, UBS, Тэнгэр, Ийгл, MN25 телевизээр хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг стандартын шаардлага хангасан хүнсний худалдааны газраас худалдан авах, гарал үүсэл, хаяг шошго, шинжилгээ баталгаажилттай, сав баглаа бодлын бүрэн байдал алдгдаагүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүн худалдан авах талаар сэрэмжлүүлэг мэдээллийг 7 удаа, хүнсний бүтээгдэхүүний сав, баглаа боодол шошгын мэдээлэл, шим тэжээлийн талаар 2 видео шторк, хүнсний нэмэлт, сахар, шошго, зөв зохистой хооллолтын талаар 5 зөвлөмж гаргаж, хяналт шалгалтын талаар 7 удаа сэрэмжлүүлэг, мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудсанд 12 удаа бэлтгэн тавьж, хяналт шалгалтын ажил, үр дүнг олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулсан.	100	
411	3.5.9.Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал бүхий 297 өрхийн 9031 толгой малыг гаргана.	Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс 100 хувь малыг гаргана.	1	Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс мал гаргах үйл ажиллагаг үргэлжлүүлэн зохион байгуулна.	2025-2028	-	20.0	-	-	-	-	20.0	Гаргасан малын эзлэх түвшин	18.9	25	5.0	НХХААГ	НЗД-ын 2025 оны А/1589 дугаэр захирамжаар НИТХ-ын 2024 оны 09 дүгээр тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллах чиг үүрэг бүхий Ажлын хэсэг шинэчлэн байгуулагдаж, Нийслэлийн Засаг даргын 01/6957 дугаар албан бичиг, Хотын Ерөнхий менежерийн 10.29-ны А/161 дугаэр удирдамжийн дагуу зохион байгуулсан нэгдсэн арга хэмжээнд Ажлын хэсгийн бүрэлдэхүүн байгуулагуудын төлөөлөл, дүүргүүдийн дэд Ажлын хэсэг болон хороодын давхардсан тоогоор 767 албан хаагч, 173 машин техниктэйгээр төвийн 6 дүүргийн бүс нутагт самналт хийж хориглосон бүсээс 1160 адуу, 33 үхэр илрүүлж, 748 толгой адууг хашаалан 28 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 6.30.3 дах заалтаар арга хэмжээ авч ажилласан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 88 өрхийн 3370 толгой малыг хориглосон бүсээс гаргаж, нийт 209 өрхийн 5661 толгой, мал хориглосон бүсэд байна.	100	
412	3.5.10.Нийслэлийн хүн амын хүнсний аюулгүй байдлыг ханган, лабораторийн чадавх, тоног төхөөрөмжийг сайжруулан итгэмжлэлийн хүрээг өргөтгөж, оношилгоо, тандалт шинжилгээ, хүнсний аюулгүй байдлын лабораторийн барилгыг шинээр бариулах, мөн дагуул хотод Мал эмнэлгийн лабораторийн ажиллуулах бэлтгэл ажлыг хангана.	Нийслэлийн нутаг дэвсгэрийг мал, амьтны гоц халдварт өвчнөөр тайван бус болгоно.	1	Нийслэлийн Мал эмнэлгийн газрын оношилгоо, тандалт, шинжилгээ, хүнсний аюулгүй байдлын лабораторийн барилгыг барина.	2025-2028	-	5,553.8	-	-	-	-	5,553.8	Барилгын угсралтын ажлын явц, хувь	5	10		НМЭГ	НМЭГ-ын оношилгоо, тандалт шинжилгээ, хүнсний аюулгүй байдлын лабораторийн барилгыг бариулах санхүүжилтийн асуудлыг шийдвэрлүүлэхийн тулд анх хийлгэсэн зураг, төсөвт магадлал хийлгэхээр Лайнконстракшн ХХК-тай гэрээ байгуулж, Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэхээр ажиллаж байна. Улсын болон нийслэлийн төсвөөр санхүүжих төсөл, арга хэмжээний цахим системд уг барилгын ажлын мэдээллийг оруулсан. Барилгын санхүүжилтийн асуудлыг нийслэлийн 2026 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгуулах талаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын албан бичгийг Нийслэлийн Засаг даргад хүргүүлсэн.	40	
413			2	Налайх, Багануур дүүрэгт мал эмнэлгийн лаборатори байгуулах бэлтгэл ажлыг хангана.	2025-2028	360.0	-	100.0	-	-	-	460.0	Бэлтгэл ажлын явц, хувь	-	10	80.0	НМЭГ	Налайх, Багануур дүүрэгт Мал эмнэгийн лаборатори байгуулах бэлтгэл ажлын хүрээнд ажиллах шинжээч эмч нарын орон тоог тус газрын бүтцэд нэмүүлэхээр саналаа Мал эмнэлгийн ерөнхий газарт хүргүүлсэн боловч батлагдаагүй. Засгийн газраас төрийн хэмнэлттэй холбогдуулан төрийн албан хаагчийн орон тоог 10 хувь хүртэл бууруулахтай холбогдуулан шинжээч эмч нарын орон тоо батлагдаагүй болно. (ХХААХҮ-ийн сайдын 2025 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн А/342 дугаар тушаалаар 93 болгон цөөрүүлж баталсан.)	ХБ	
414	3.5.11.Мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандалт шинжилгээ хийх, оношлох, эмчлэх, тэмцэх, гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлж, эрүүлжүүлэх, хяналт тавих арга хэмжээг хэрэгжүүлнэ.		3	Мал, амьтны гоц халдварт, халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх, тандах, оношлох, тэмцэх, гэрийн тэжээвэр амьтныг бүртгэлжүүлж, эрүүлжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2025-2028	1,286.0	1,562.8	-	-	-	-	2,848.8	Дархлаажуулалтад хамрагдах мал, амьтан, тоо толгой /мянга/	1599.5	1359.2	657.2	НМЭГ	Мал, амьтны гоц халдварт болон зоонозын өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын тушаал, Нийслэлийн Засаг даргын захирамжийн дагуу дархлаажуулалт, тандалт шинжилгээ, халдваргүйтгэлийн ажлыг зохион байгуулан ажиллав. Үүнд: Шүлхий өвчний яаралтай дархлаажуулалт: 318,925 толгой мал дархлаажуулж, хамралт 93.2%. Бог малын мялзан өвчнөөс сэргийлэлт: 63,469 хурга, ишиг хамрагдан, дархлаажуулалтын хамралт 93.9%. Бруцеллёзын эсрэг дархлаажуулалт: 79,158 толгой малыг хамруулж, гүйцэтгэл 93.8%. Үхрийн арьс товруутах 97,986 үхэр, тугал хамрагдаж, хамралт 88.4%. Хонины цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 153,360 толгой мал хамрагдаж, 90.5%-тай биелсэн. Малын халдварт боом, галзуу, гахайн мялзан, шувууны тахал, адууны томуу өвчний дархлаажуулалтад 434,970 толгой мал, амьтан хамрагдаж, 90% хувийн гүйцэтгэлтэй байна. Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээнд 475,470 толгой мал, амьтан хамруулсан. Нийт 1,623,518 толгой мал, амьтан дархлаажуулсан.	100	
						-	-	-	-	-	-	-	Тандалт шинжилгээний дээж, тоо	14022	21048		НМЭГ	Мал, амьтнаас хүнд дамжин халдварладаг архаг халдварт өвчин бруцеллёзолоос урьдчилан сэргийлэх, Улаанбаатар хотын хүн амыг эрүүл сүүгээр хангах, бруцеллёз өвчнийг эрүүлжүүлэх тандалт шинжилгээний ажлыг зохион байгуулсан. Бруцеллёзын шинжилгээнд цусны 22,957 дээж, 1182 өрхийн 14,115 үнээний сүүний 1577 дээж авсан. Бруцеллёзыг илрүүлэх шинжилгээний ажил хийгдэж байна.	100	
415	3.5.12.Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний		4	Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн дээжид шинжилгээ хийж, баталгаажуулалт олгоно.	2024-2028	430.0	-	-	-	-	-	430.0	Шинжилгээ хийж баталгаажуулалт олгосон дээж, тоо	36034	36500	100.0	НМЭГ	Мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, эмгэгт материал, арчдасны 41,750 дээжид мал эмнэлэг, ариун цэвэр, хүнсний нян судлал, ийлдэс судлал, эм, хүнд металлын үлдэгдэл тодорхойлох, аскол, эмнэл зүйн нян судлал, биохимийн шинжилгээг батлагдсан стандарт, арга зүйн дагуу хийж баталгаажуулалт олгосон.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
416	бүтээгдэхүүний дээжид шинжилгээ хийж баталгаажуулах, мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Махны техникийн зохицуулалтыг бүрэн нэвтрүүлнэ.		5	Мал, амьтны гаралтай хүнсний бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдаа эрхэлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалтыг бүрэн нэвтрүүлнэ.	2024-2028	400.0	-	-	-	-	-	400.0	Техникийн зохицуулалт нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн түвшин, хувь	-	50	200.0	НМЭГ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын улсын ерөнхий байцаагч, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу үйлдвэрийн үйл ажиллагаанд 23 улсын байцаагч хяналт шалгалт хийж ажилласан. Нийт 165 аж ахуйн нэгж, иргэн хамрагдахаас үйлдвэр, үйлдвэрийн агуулах 88, хүнсний зах, худалдааны төв 19, лаборатори 1, махны төрөлжсөн агуулах 21, үйл ажиллагаа бүрмөсөн зогссон 7, үйл ажиллагаа түр зогссон 21, нийт 113 аж ахуйн нэгж, 24 иргэний үйл ажиллагаанд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар нийт 653 зөрчил, дутагдал илрүүлж, газар дээр нь 286 зөрчлийг арилгуулах, эрсдлийг бууруулах чиглэлээр улсын байцаагчийн 65 заалт бүхий 9 албан шаардлага, 38 заалт бүхий 10 албан даалгавар хүргүүлж, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллалаа. Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу 36.0 сая төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч, 5,1 сая төгрөгийн хууль бус орлогыг хураан авч, Нийслэлийн Прокурорын тогтоолоор 10 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг зогсоосон байна.	83	
ДӨРӨВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО																				
Салбарын үр дүн: Байгаль орчныг хамгаалж нөхөн сэргээн, орчны бохирдол, доройтлыг бууруулж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан хот болно.																				
Зорилтын үр дүн: 4.1.Байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангана.																				
417	4.1.1.Байгаль орчны хамгаалах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, бүс, дэглэм тогтоох, орон нутгийн тусгай хамгаалалтад авах шаардлагатай газар нутгийг ангилал тус бүрээр бүрэн хамгаалалтад авна.	Тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хэмжээг 30 хувьд хүргэнэ.	1	Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг нэмэгдүүлж, менежментийн төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2024-2028	-	270.0	-	-	-	270.0	540.0	Тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь	29.34	29.4	100.0	НБОГ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 24/18 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хороонд 5,926 га, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт А, Б хэсэг бүхий 14,429 га 2 байршлын нийт 20,345 га талбайг экологийн коридор нутгийн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. Экологийн коридорын 2 байршилд менежментийн төлөвлөгөө боловсруулах ажлыг "Ногоон ой нийгэмлэг" НҮТББ-тай БОГ-2025/44 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Гэрээт ажлын үр дүнг хүлээн авахаар ажиллаж байна.	98	
418		Нийслэлийн хэмжээнд гадаргын усны нөөцийг нэмэгдүүлнэ.	2	Булаг шандны эхийг хашиж хамгаалан, тохижуулна.	2024-2028	-	400.0	-	-	-	-	400.0	Хамгаалсан булаг, тоо	6	4	100.0	НБОГ	2025 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр БЗД-ийн 20-р хорооны Дээндийн амны "Дээд булаг", 33-р хорооны "Баяндөхөмийн булаг", "Шивэртийн амны булаг", 11 дүгээр хорооны "Сахарын рашаан", аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд БЗД-ийн 33-р хорооны Шар хоолойн "Хавчуугийн булаг", ХУД-ийн 14-р хорооны "Тавьжийн шанд", Тургэний гол дагуу "Хар үзүүрийн булаг", 12-р хорооны "Биогийн булаг", "Булгатайн булаг"-ийн эхийг хашиж хамгаалсан. 100.000.000 (100 сая төгрөг)-г нийслэлийн төсвөөс, 32.779.000 (32 сая 779 мянгыг нь аж ахуйн нэгж байгууллагаас санхүүжүүлсэн.)	100	
419	4.1.2.Байгалийн нөөц, баялаг, даацад нь тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, илэрсэн эрчлийг арилгуулах хяналтыг сайжруулна.	Хүлэмжийн хийн ялгарлыг үе шаттайгаар бууруулна.	1	Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах үндэсний хувь нэмэрт нийслэл Улаанбаатар хотын оруулах хувь нэмрийг тодорхойлж, төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ.	2025-2028	-	200.0	-	-	-	-	200.0	Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хувь	-	10	200.0	НБОГ	Үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Байгаль орчны газрын захиалгаар "Улаанбаатар хотын 2025–2035 он хүртэлх уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт(GGGI)-ын дэмжлэгтэйгээр "Номадик Нью Энержи" ХХК гүйцэтгэсэн. Үүнд: 2025 онд Улаанбаатар хотын хүлэмжийн хийн ялгарал нь 16.45 сая тн CO_2е-д хүрч, 2010 оноос 63% өссөн бөгөөд нийт ялгарлын 76% нь эрчим хүчний үйлдвэрлэл, 21% нь хэрэглээ, 3% нь бусад салбарт ногдож байна. Суурь тооцоогоор 2035 онд ялгарлын хэмжээ 19.39 сая тн CO_2е болж, үүний 90%-ийг эрчим хүчний үйлдвэрлэл эзлэх төлөвтэй байна. Улсын зорилттой уялдуулан 2035 онд ойролцоогоор 20% буюу 4.5 сая тн CO_2е-ээр бууруулах зорилт дэвшүүлж, хэрэгжилтийг хангахад 13 арга хэмжээнд нийт 18.6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай тооцоог гаргасан. Ирэх онд "Улаанбаатар хотын 2026–2035 он хүртэлх уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулахаар төлөвлөсөн.	80	
420			2	Улаанбаатар хотын хүлэмжийн хийн ялгарал багатай хөгжлийн төлөвлөлтийн судалгаа хийх (эрчим хүч, зам тээвэр, барилга дэд бүтцийн салбар)	2025	-	150.0	-	-	-	-	150.0	Судалгааны ажлын явц, хувь	-	100	150.0	НБОГ	2025 оны байдлаарх Улаанбаатар хотын хүлэмжийн хийн ялгарлын тооцооллоор эрчим хүчний үйлдвэрлэл нь нийт 16.40 сая тонн CO_2е ялгарлын 76 хувийг бүрдүүлж байна. Үүнд цахилгаан, дулаан үйлдвэрлэл 12.48 сая тонн CO_2е, эрчим хүчний эцсийн хэрэглээ (тээвэр, барилга зэрэг) 3.45 сая тонн CO_2е буюу 21 хувь, бусад салбарууд (хог хаягдал, аж үйлдвэр, хөдөө аж ахуй) 0.46 сая тонн CO_2е буюу 3 хувийг тус тус эзэлж байна. Уг тооцооллын судалгааг Даян Дэлхийн Ногоон Хөгжлийн Институт (GGGI)-ын дэмжлэгтэйгээр "Номадик Нью Энержи" ХХК боловсруулан, хамтран ажилласан болно.	100	
421			3	Сонгинохайрхан дүүргийн Баянголын амны усны нөөцийн хайгуул судалгаа хийнэ.	2025-2026	-	400.0	-	-	-	-	400.0	Судалгааны ажлын явц, хувь	-	30		НБОГ	Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны Баянголын амны ус хангамжийн эх үүсвэрийн усны нөөц, түүнээс ашиглах боломжит нөөцийн хэмжээг тогтоолгох хайгуул судалгааны ажлыг Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгуулсан боловч төсөв нь батлагдаагүй болно. 2024 онд БОУАӨЯ, Усны газарт усны нөөцийн хайгуул судалгааны ажлын санхүүжилтийг улсын төсөвт тусгаж өгөх талаар хүсэлтийг хүргүүлсэн. Усны газар БОУАӨЯ- нд улсын төсөвт тусгаж өгөх талаар 2024 оны 01/1096 дугаартай албан бичгийг хүргүүлсэн боловч 2025 оны улсын төсөвт тусгагдаагүй болно.	59	
422	4.1.3.Экологийн	Экологийн коридор бүхий нүхэн болон гүүрэн гарцын загварыг гаргана.	1	Экологийн коридор орон нутгийн тусгай хэрэгцээний газрын менежмент төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангуулна.	2025	-	100.0	-	-	-	-	100.0	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувь	-	100	100.0	НБОГ, НГЗБА	Газрын даргын А/18 дугаартай тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг экологийн коридор орон нутгийн тусгай хэрэгцээний газрын менежментийн төлөвлөгөө боловсруулах ажил гүйцэтгэчийг сонгон шалгаруулахаар худалдан авах ажиллагаат зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан "Ногоон ой нийгэмлэг" НҮТББ-тай БОГ-2025/44 дугаартай ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан. Газрын даргын А/172 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг гүйцэтгэлийг хүлээн аваад байна.	100	
423		Тарваганы тоо толгойг 15 хувиар нэмэгдүүлнэ.	1	Суурьшлын бусэд тархац нутаггүй болсон 200 тарвагыг шилжүүлэн нутагшуулж амьдрах орчныг тэтгэнэ.	2024-2028	-	40.0	-	-	-	-	40.0	Шилжүүлсэн тарвага, тоо толгой	286	100	20.0	НБОГ	Суурьшлын бусэс тархац нутаггүй болсон монгол тарвага (marmota sibirica)-г шилжүүлэн нутагшуулах ажлын хүрээнд "Агнуурын менежментийн тэх төв" ТББ-тай БОГ 2025/04 дугаар гэрээ байгуулсан бөгөөд БОУАӨЯ-аас олгосон зөвшөөрлийн дагуу Сонгинохайрхан дүүргийн зуслангийн бусэс 100 бодгаль монгол тарвагыг барьж Баянзүрх дүүргийн 20-р хороо Дээндийн нурууны орон нутгийн тусгай хамгаалалттай газарт шилжүүлэн нутагшууллаа. Газрын даргын А/71 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг ажлын тайлан болон гүйцэтгэлийг хүлээн авсан.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
424	коридор байгуулах, амьтан, ургамлын төрөл зүйлийг нутагшуулах, хамгаалж, нөхөн сэргээнэ.	Зэрлэг амьтны зүй бус хорогдлыг бууруулна.	1	Ой, уулын туруутан амьтдын тархац нутагт идэш тэжээлийн дэмжлэг үзүүлэх биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	2024-2028	-	80.0	-	-	-	-	80.0	Хэрэгжүүлсэн биотехникийн арга хэмжээ, тоо	8	1	20.0	НБОГ	Ой, уулын туруутан амьтдын тархац нутагт биотехникийн арга хэмжээ авах ажилд “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ шалгарч БОГ 2025/05 дугаар гэрээ байгуулан хавар намрын улиралд 12 байршлын 18 цэгт 15000 кг нуурын давсаар биотехникийн арга хэмжээ авч газрын даргын А/159 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг гүйцэтгэлийг хүлээн аваад байна.	100	
425			2	Улаанбаатар хот орчимд тархсан зэрлэг амьтдын амьдрах орчны сөрөг нөлөөллийг бууруулах хашаа хайсыг стандартад нийцүүлнэ.	2024-2028	-	40.0	-	-	-	-	40.0	Стандартын хэрэгжилтийн явц, хувь	-	50	10.0	НБОГ	Тус стандарт нь НИТХ-ын 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 25/05 тогтоолоор батлагдсан бөгөөд 2025 оны 10 дугаар сарын 01 өдрөөс мөрдөгдөж эхэлсэн. Стандартыг мөрдүүлэх, олон нийтэд таниулах ажлын хүрээнд БЗД, ЧД, СБД, СХД, ХУД-ийн Тамгын газруудад стандартыг мөрдүүлэх албан бичиг хүргүүлсэн бөгөөд зуслангийн бүсийн иргэдэд хашаагаа стандартын дагуу өөрчлөх, шинэчлэх талаар албан шаардлага хүргүүлээд байна.	100	
426		Байгальд сэргээн нутагшуулсан минжний бүлийн тоог 20 хувиар нэмэгдүүлнэ.	1	Минжийг өсгөн үржүүлж туул голын эхэнд 40 минж байгальд нь сэргээн нутагшуулна.	2024-2028	-	712.0	-	-	-	-	712.0	Нутагшуулсан минж, тоо	77	10	178.0	НБОГ	ШУА-ын Биологийн хүрээлэнгээс Туул голын эхэнд минж сэргээн нутагшуулахдаа хүний зүгээс дэмжлэг үзүүлж тавих нь зүйтэй гэсэн мэргэжлийн зөвлөгөө ирүүлсэн тул 2025 онд нутагшуулахаар төлөвлөсөн 5 бүлийн 10 бодгаль минжийг минж үржүүлэх, нутагшуулах төвийн минж гадаалуулах байранд байгальд дасгаж, 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр Тэрэлжийн гүүрнээс 158 км зайд, Хан Хэнтийн УТХГ-ын байгаль хамгаалагчийн постоос дээш Галтай, Булнайн Туул голын бэлчир орчимд, өвөлжөө болон айлаас алс газарт байгальд нутагшууллаа. Тус минжнүүд нь 4-8 хүртэлх насны залуу үржлийн минжнүүд болно.	100	
427		Ойн сэргэн ургалтыг дэмжсэн талбайн хэмжээг 13 хувиар нэмэгдүүлнэ.	1	Ойн түймэр, хөнөөлт шавж, өвчин, мод бэлтгэлийн улмаас хомсдол, доройтолд өртсөн 1600 га талбайг ойжуулна.	2025-2028	2,400.0	8,960.0	-	-	-	1,440.0	12,800.0	Ойжуулсан талбай, га	132	400	3,200.0	НБОГ	2021-2024 507 га-д ойжуулалт, ойн нөхөн сэргээлт хийсэн. 2025 онд ойжуулалт ойн нөхөн сэргээлтийг 28 га талбайд, жижиг гол, горхины эх, татмын ойжуулалтыг 4,4 га талбайд, байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээг 67 га талбайд нийт 99,4 га талбайд ойжуулалт,ойн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэв.	83	
428			2	Ойн сан бүхий 46 га талбайн байгалийн сэргэн ургалтыг дэмжинэ.	2025-2028	15.5	18.5	-	-	-	-	34.0	Сэргэн ургалтыг дэмжсэн талбай, га	93	16	11.8	НБОГ	Байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах А/41 дугаартай тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагаат зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр “Ойн хайгуул” ХКК шалгарч, гэрээ байгуулан, Баянзүрх дүүргийн 33 дугаар хороо, Шар хоолойн аманд 67 га талбайд 46,900 ширхэг 2-3 насны шинэсний тарьцаар ойжуулах, шан татах ажлыг хийж гүйцэтгэсэн. Газрын даргын 2025 оны А/110 дугаартай гүйцэтгэлийг хүлээн авах Ажлын хэсэг гэрээнд заасны дагуу 10 дугаар сарын 20-ны өдөр амьдралтын хувийг тооцон, акт үйлдэн хүлээн авав.	100	
429		Газрын доройтлыг бууруулах замаар усны нөөцийн хомсдохоос сэргийлнэ.	3	Жижиг гол, горхины татмын 80 га талбайг ойжуулах замаар усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлнэ.	2025-2028	798.0	798.0	-	-	-	-	1,596.0	Ойжуулсан талбай, га	83.8	20	390.0	НБОГ	Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвгэр Дээндийн аманд жижиг гол, горхины эх, татмыг ойжуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гүйцэтгэгчтэй “Шилмүүст модны төгөл” ХКК -тай НБОГ/20250201008 дугаартай гэрээг байгуулан ажлыг 4,4 га талбайд гүйцэтгүүлсэн. Ойжуулалтад 5,280 ширхэг 3-4 насны навчит модны суулгац тарьсан. Газрын даргын 2025 оны А/109 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг 10 дугаар сард тарьсан модны амьдралт 81 хувьтай байгааг тогтоон акт үйлдэн хүлээн авсан.	84	
430	4.1.4.Ойжуулах, ойн тэлэлт ургалтыг дэмжих, нөхөн сэргээх, хамгаалах замаар ойгоор бүрхэгдсэн талбайг нэмэгдүүлж, “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлнэ.	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан модыг 22 хувиар нэмэгдүүлнэ.	4	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 7,300.000 мод тарьж, байнгын арчлалт хамгаалалт хийж, замаар бүрэн ургалтыг дэмжинэ.	2025-2028	200.0	320.0	-	-	-	-	520.0	Тарьсан мод, тоо	3,300.000	1,500,000	100.0	НБОГ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны "Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 44, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн”178 зарлиг, Засгийн газрын 2021 оны “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 350 дугаар тогтоолын дагуу уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, цөлжилтийг саруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, мод тарих, арчлан ургуулах соёлыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээний хүрээнд 2025 онд нийслэлийн хэмжээнд 7 байршилд мод тарих үйл ажиллагаат хавар, намрын мод тарих аяныг нэгдсэн журмаар зохион байгуулж, төрийн байгууллагын болон иргэдийн төлөөлөл нийт 37,996 хүн оролцож, 693,855 ширхэг мод бут тарьсан. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны байдлаар нийслэлийн хэмжээнд өссөн дүнгээр 4,063,474 ширхэг мод тариад байна.	85	
431		Тарьц, суулгацын нөөцийг 18 хувиар нэмэгдүүлнэ.	5	Ойжуулалт, ой нөхөн сэргээлт, хот цэцэрлэгжүүлэлтэд нийлүүлэх 21.400.000 тарьц, суулгацын нөөцийг бүрдүүлнэ.	2025-2028	-	10,700.0	-	-	-	-	10,700.0	Ургуулсан тарьц, суулгацын тоо	1,200.000	4.400.000	2,000.0	НБОГ	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор шинэс модны үр 7 кг, 1500 ширхэг шинэс модны тарьц худалдан авах БОГ2025/69 дугаартай гэрээг байгуулан худалдан авсан. 2025 оны хаврын байдлаар нийслэлийн хэмжээнд 7.1 сая ширхэг тарьц суулгацын нөөцтэй байв. Намрын тооллого, нэгтгэлийн ажил хийгдэж байна.	100	
432		Нийслэлийн ногоон бүсийн ойн хөнөөлт шавж, өвчнөөс шалтгаалсан доройтлыг бууруулна.	6	Ойн хөнөөлт шавжийн тархалт, нягтшил, хөнөөлийн голомтыг тогтоох судалгаг 80,000 га талбайд хийнэ.	2025-2028	-	80.0	-	-	-	-	80.0	Судалгаа хийсэн талбай, га	80.000	80.000	20.0	НБОГ	Нийслэлийн ногоон бүсэд ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт нягтшилын судалгааг 2021-2024 онд нийт 320.0 мянган га талбайд ойн мэргэжлийн байгуллагаар гүйцэтгүүлсэн. 2025 онд Нийслэлийн ногоон бүсэд ойн хөнөөлт шавж, өвчний голомтолсон тэмцлийн ажил гүйцэтгэх шаардлагатай талбайн хэмжээг тогтоох судалгаг байгуллагыг сонгон шалгаруулах тухай газрын даргын 2025 оны А/46 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсгийн бүрэлдэхүүн сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулж, гүйцэтгэгчээр шалгарсан ойн мэргэжлийн байгуллага болох "Нямын өндөр" ХХК-тай 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулсан. Ойн хөнөөлт шавж, өвчний судалгааны ажлыг нийслэлийн ногоон бүсийн ойгоор бүрхэгдсэн 80,000 га талбайд хийсэн ажлын тайланг гэрээнд заасан хугацаанд бүюу 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлсэн тул хүлээн авах Ажлын хэсэг хуралдаж, акт үйлдэж, хүлээн авсан.	100	
433			7	Ойн сангийн 13000 га талбайд хөнөөлт шавж өвчинд нэрвэгдэх сэргийлэх тэмцлийн ажлыг хийнэ.	2025-2028	-	1.131.5	-	-	-	-	-	Тэмцлийн ажил гүйцэтгэсэн талбай, га	10.695	2500	182.5	НБОГ	Нийслэлийн ногоон бүсэд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлыг судалгаанд үндэслэн жил бүр төлөвлөн зохион байгуулж байна. 2021 онд 3033 га, 2022 онд 6602 га, 2023 онд 8099 га, 2024 онд 10765 га, 2021-2024 онд нийт 28,499 га талбайд тэмцлийн ажлыг нийслэлийн болон улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна. 2025 онд нийслэлийн ногоон бүсэд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлыг үүргийн шуршигч багаж ашиглан, микробиологийн аргаар 6793 га талбайд зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Газрын даргын А/41 дугаартай тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагаат зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр ойн мэргэжлийн байгуллагын түсгай зөвшөөрөлтэй "Хатант форест" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Газрын даргын 2025 оны А/99 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 10 дугаар сарын 20-ны өдөр ажлын гүйцэтгэлийг хянаж, ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, судалгааны тайланд дурьдсан үр дүн 81 хувьтай байгааг тооцон, акт үйлдэн хүлээн авсан.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
434	4.1.5.Ойн гал түймрээс урьдчилан сэргийлэх халз зурвасыг сэргээж, нэмэгдүүлнэ.	Ойн нөөцийг түймэрт өртүүлэхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.	1	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, түймрийн эрсдэлийг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2025-2028	-	720.0	-	-	-	-	720.0	Тухайн жилийн төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, хувь	100	100	180.0	НБОГ	Улсын Онцгой комиссын 2025 оны 01 дүгээр албан даалгавар, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын А/112 дугаар тушаал, Нийслэлийн Онцгой комиссын 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Нийслэлийн Байгаль орчны газрын даргын "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" 2025 оны А/28 дугаар тушаал гарч, 03 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газруудын хамтарсан хөдөлгөөнт эргүүлийн бүрэлдэхүүн Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн ногоон бүсийн 5 чиглэлд өдөр бүр хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах ажлыг гүйцэтгэв. Энэ ажлын хүрээнд Нийслэлийн Онцгой байдлын газраас 7 албан хаагч 2 тээврийн хэрэгсэл, Нийслэлийн Цагдаагийн удирдах газраас 11 албан хаагч 1 тээврийн хэрэгсэл, Нийслэлийн Байгаль орчны газраас 6 албан хаагч 2 тээврийн хэрэгслээр үүрэг гүйцэтгэсэн. Хуурайшилт өндөртэй үе буюу нийт 135 өдрийн турш мэдээлэл солилцон ажилласан. 2025 онд нийслэлийн хэмжээнд 279 шар өвсний түймэр, ой, хээрийн 3 түймэр бүртгэгдсэнээс 45 тохиолдлыг хөдөлгөөнт эргүүлийн бие бүрэлдэхүүн Нийслэлийн Онцгой байдлын газрын гал унтраах ангитай хамтран унтраасан. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг өдөр тутмын хэвлэл мэдээлийн хэрэгслээр 5, цахим орчинд 21 удаа нийтэд хүргэжд байна. Цахим орчинд нийтэлсэн мэдээллийг нийт 712 хүн хуваалцаж, 1401 хүнд таалагдаж, 131,249 хүн үзсэн байна. Намрын хуурайшилтын үед байгаль хамгаалагчдын түймрийн бэлэн байдлын багаж хэрэгслийг хангах, зуслангийн бүсэд оршин сууж буй болон дамжин өнгөрч байгаа иргэдийг мэдээллээр хангах зорилгоор түймрийн эрсдэл үүсэх нөхцлийг бууруулах, сурталчлан таниулах тараах материал (4000 ширхэг стикер, А3 хэмжээтэй календар 1500 ширхэг, 60х40 см хэмжээтэй автостикер 400 ширхэг)-ыг тараав. Ойн түймэр тархах нөхцөлийг бууруулах зорилгоор 2025 онд Сүхбаатар дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэр Их Баян, Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэх заагт баруунаас эүүн тийш чиглэсэн 1.5 км урттай 40 метрийн өргөнтэй ойн түймрээс сэргийлэх зурвасыг сэргээх ажлыг ойн мэргэжлийн байгуллага "Сайхан санаа" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.	100	
435			2	Ойн сан бүхий 52.0 га талбайд түймрийн халз зурвас сэргээнэ.	2025-2028	-	552.0	-	-	-	-	552.0	Талбайн хэмжээ, га	19.5	4	42.0	НБОГ	Ойн түймэр тархах нөхцөлийг бууруулах зорилгоор 2024 онд БЗД-ийн 33-р хорооны нутаг дэвсгэр Бэрхийн нуруунд 1.5 км урттай / 4.5 га/ талбайд ойн түймрээс сэргийлэх зурвасыг сэргээсэн. 2025 онд Улаанбаатар хот, Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэх хил дагуу нийт 1.5 км урттай /6.0 га/ зурвасыг сэргээх ажлыг ойн мэргэжлийн байгуллага "Сайхан санаа ХХК"-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн. Нэмэлтээр Гамшгийн эрсдэлийг бууруулах нийслэлийн зөвлөлийн хөрөнгөөр СБД-ийн 19-р хорооны нутаг дэвсгэр Их Баянгийн ар Батсүмбэр сумтай хиллэх хил дагуу 710 м урттай /2.8 га/ түймрийн халз зурвас сэргээх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулаад байна.	100	
436	4.1.6.Хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулж хөв цөөрөм, усан сан байгуулна.	Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлнэ.	1	Хур бороо, цас, мөсний усыг хуримтлуулж хөв цөөрөм, усан сан байгуулах зураг төсөв боловсруулна.	2025	-	300.0	-	-	-	-	300.0	Зураг төсөв боловсруулах ажлын явц, хувь	-	100	300.0	НБОГ	2025 онд Нийслэлийн нутаг дэвсгэрт БЗД-ийн 20-р хороо Дээндийн аманд 1, ХУД-ийн 14-р хороо Тургэний гол дагуу 1, НД-ийн 1-р хорооны Энгэр шандад 1, Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо Мухарын аманд 1, Нарийн гол дагуу 2 нийт 6 хөв цөөрөм (усан сан) байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлыг хийлгэсэн.	100	
437	4.1.7.Уул уурхай, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ.	Уул уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газрын нөхөн сэргээлтийг 170 га-гаар нэмэгдүүлнэ	1	Уул уурхайн олборлолтын улмаас ухагдаж эвдэгдэн ээзнгүй орхигдсон газрын нөхөн сэргээлт хийнэ.	2025-2028	-	-	-	-	-	1,800.0	1,800.0	Нөхөн сэргээсэн талбайн хэмжээ, га	149.7	30	300.0	НБОГ	Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 20 га талбайд нийслэлийн төсвийн хөрөнгөөр газрын хэвлийн нөхөн сэргээлт хийлгэх нээлттэй сонгон шалгаруулалтыг Газрын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо зохион байгуулж, "Эм Ди Юу" ХХК 296.3 сая төгрөөр уг ажлыг гүйцэтгэхээр шалгарсан. Тус компанитай байгуулсан НБОГ/20250101013 дугаартай ажил гүйцэтгүүлэх гэрээний дагуу нөхөн сэргээлтийг хийлгэж, гүйцэтгэлийг хүлээн авсан.	84	
Зорилтын үр дүн: 4.2. Агаар, орчин бохирдуулагч эх үүсвэрийг бууруулж, байгальд ээлтэй хэрэглээг нэмэгдүүлнэ.																				
438	4.2.1.Гэр хорооллын айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт /төвлөрсөн дулаан, хий, сэргээгдэх эрчим хүч, цахилгаан болон бусад/ үе шаттай шилжүүлж, хатуу түлшний хэрэглээг бууруулж, амины суудны дулаан	Гэр хорооллоос үүдэлтэй агаарын бохирдлыг 29.5 хувиар бууруулж, нийт агаарын чанарыг 15.5 хувиар сайжруулна.	1	Гэр хороллын 103,090 өрхийг LNG, LPG хий, цахилгаан, сэргээгдэх болон бусад эх үүсвэрт шилжүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Бусад эх үүсвэрт шилжүүлсэн өрх, тоо	-	51080		НАОБТГ	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны "Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" 133 дугаар тогтоолоор нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн 51,080 айл өрхийн халаалтыг цахилгаан болон хийн халаалтад шилжүүлэхээр шийдвэрлэсэн боловч Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар тогтоолоор эхний ээлжид 5,000 айл өрхийг дулаалж, хийн халаалтад шилжүүлэх шийдвэр гарч, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/106 дугаар тогтоолоор 5,000 айл өрхийг дулаалж, шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэх төсөв батлагдсан. Хийн халаалтын тоног төхөөрөмж худалдан авах ажлын хүрээнд 2025 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/1128 дугаар захирамж батлагдсан. НЗД-ын захирамжийг үндэслэн Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын А/83 дугаар тушаалаар 5,000 хийн халаалтын тоног төхөөрөмж, 20,000 зориулалтын баллон худалдан авах ажиллагаг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажилласан. НЗД-ын 2025 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн "Ажил гүйцэтгүүлэх тухай" А/1175 дугаар захирамжаар Баянгол, Чингэлтэй дүүргийн 5,000 өрхийг шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэх төсвийн хуваарийг батлсан. Хийн халаагуурт шилжүүлэх ажлыг "Тавантолгой түлш" ХХК-ийн Төслийн удирдлагын газар хариуцан БНХАУ-ын Haier, Hisense компаниудтай 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр бараа худалдан авах гэрээ байгуулж, 2025 оны 11 дүгээр сард эхний ээлжийн 239 зуух, 2500 яндан хүлээн авч суурилуулахад бэлэн болсон байна.	85	
439		Агаар бохирдуулагч суурин эх үүсвэрийн хяналтыг сайжруулна.	2	100квт-аас дээш хүчин чадалтай уурын болон халаалтын зуухыг магадлан итгэмжилж, хэмжилт хийнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Магадлан итгэмжлэлийн ажлын явц, хувь	-	100		НАОБТГ	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1250 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд Уурын болон усан халаалтын зууханд магадлан итгэмжлэл хийж, мэдээллийн санг шинэчлэн ажилласан. Тус ажлын хүрээнд 100 кВт-аас дээш хүчин чадалтай 246 усан халаалтын зуух бүртгэгдсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн "Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх тухай" А/1493 дугаар захирамж батлагдсан бөгөөд хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.	100	
440			3	Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Нэгдсэн тоо бүртгэл явуулах ажлын явц, хувь	100	100		НАОБТГ	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1250 дугаар захирамжийн хүрээнд 2024 оны агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг зохион байгуулсан. Тус нэгдсэн тоо бүртгэлээр 3-15кВт хүчин чадалтай ахуйн хэрэглээний 171,976 зуух, 16-100 кВт хүчин чадалтай 2,306 зуух, 100 кВт-аас дээш хүчин чадалтай 246 усан халаалтын зуух, 6 дулааны цахилгаан станцын 4200 кВт-аас дээш хүчин чадалтай 41 зуух тус тус тоологдож, мэдээллийн санг шинэчлэн ажилласан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн "Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэл хийх тухай" А/1493 дугаар захирамж батлагдсан бөгөөд тус захирамжийн хүрээнд 2025-2026 оны эх үүсвэрийн шинэчилсэн тоо бүртгэлийг 3-15кВт, 16-100 кВт, 100 кВт-аас дээш, 4200 кВт-аас дээш хүчин чадалтай зуух тус бүрийн тоон мэдээллийг гаргаж, мэдээллийн санг шинэчлэхээр ажиллаж байна.	84	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
441	алдагдлыг бууруулахад иргэд, олон нийтийн үүрэг, оролцоог нэмэгдүүлнэ.	Амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулна.	4	Амины орон сууцны дулаан алдагдлыг бууруулах төслийг хэрэгжүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Төсөлд хамрагдсан өрх, тоо	-	20000		НАОБТГ	Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 05 дугаар тогтоолоор 2025-2026 оны халаалтын улиралд Баянгол, Чингэлтэй дүүргийн 5,000 айл өрхийг дулаалж, шингэрүүлсэн шатдаг хийн халаалтад шилжүүлэхээр шийдвэрлэж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1038 дугаар захирамжаар дүүргүүдэд дулаалгын зардлыг шилжүүлсэн. Дулаалгын ажлын явц 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар гэр дулаалга 100 хувь, байшин дулаалга 82 хувь, нийт 92 хувий гүйцэтгэлтэй байна. Дулаалгын ажлын 11 дүгээр сард багтаан дуусгахаар төлөвлөсөн.	89	
442		Агаарын чанарын хэмжилт хийх үзүүлэлтийн чанарыг сайжруулна.	6	Нийслэлийн болон төрийн өмчийн халаалтын зуухыг үе шаттайгаар буулгаж, төвлөрсөн дулаан хангамжид холбох ажлыг үргэлжлүүлнэ.	2025-2028	4,000.0	-	-	-	-	-	4,000.0	Төвлөрсөн дулаан хангамжид холбосон зуух, тоо	1	2	1,000.0	НАОБТГ	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1250 дугаар захирамжийн хүрээнд агаар бохирдуулагч эх үүсвэрийн нэгдсэн тоо бүртгэлийг нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд зохион байгуулсан. Дулаан үйлдвэрлэх, түгээх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагуудын халаалтын 246 зуух тоологдсон. Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны 2025 оны 04 дүгээр тогтоолоор 2025-2026 оны халаалтын улиралд улсын төсөвт болон төрийн өмчийн байгууллагуудыг халаалтын зуухны технологийн шинэчлэл хийх ажлыг эрчимжүүлэхийг үүрэг болгосон. Тус тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд уурын болон усан халаалтын 2 зуух төвлөрсөн дулаан хангамжид холбогдож, 28 зуух хийн халаалтад шилжсэн байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/1052 дугаар захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд дулаан, эрчим хүч үйлдвэрлэх, түгээх үйл ажиллагаа эрхэлж буй уурын болон усан халаалтын зуухтай аж ахуйн нэгж, байгууллагуудыг түүхий нүүрс хэрэглэхийг үе шаттайгаар зогсоож, технологийг шинэчлэж, угааж баяжуулсан нүүрс (мидлинг)-ний хэрэглээнд бүрэн шилжүүлэхээр шийдвэрлэсэн бөгөөд 430 аж ахуйн нэгж, байгууллага "Тавантолгой түлш" ХХК-тай гэрээ байгуулж, 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 18,987 тонн мидлинг татан авсан байна.	100	
443	4.2.2.Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн технологийг шинэчилнэ.	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийн технологийг шинэчилнэ.	1	Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах яндангүй бүсийг тогтоож, журмыг мөрдүүлнэ.	2024-2028	-	-	-	-	-	-	-	Журмын хэрэгжилтийн явц, хувь	2023	100		НАОБТГ	Агаарын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсэгт зааснаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бус, бүсэд мөрдөх журмын төслийг боловсруулж, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн хамтарсан А/651, А/983 дугаар тушаал/захирамжаар батлагдаж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 7328 дугаарт бүртгүүлсэн.	100	
444			2	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрт шинэчлэлт хийнэ.	2025	900.0	-	-	-	-	-	900.0	Шинэчлэлт хийх ажлын явц, хувь	-	100	900.0	НАОБТГ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдрийн "Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх төслийн жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" 25/109 дүгээр тогтоолын дагуу 2026-2028 онд төр, хувийн хэвшлийн түншлэлээр "Хагас коксын үйлдвэр" төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. "Тавантолгой түлш" ХХК-ийн баруун бүсийн үйлдвэр 2024 онд, төвийн бүсийн үйлдвэр 2025 онд тус тус үйл ажиллагаагаа зогсооссон. 2025-2026 оны халаалтын улиралд "Тавантолгой түлш" ХХК-ийн зүүн бүсийн үйлдвэрт хагас коксон шахмал түлшийг БНХАУ-аас импортлон байгальд ээлтэй бүрэн шатдаг цаасан уутанд савлан ажиллаж байна.	54	
445		Хатуу түлшний хэрэглээг 50 хувиар бууруулна.	4	Гэр хорооллын айл өрхийг стандартын шаардлага хангасан сайжруулсан түлшээр хангах, сайжруулсан түлшийг түгээх, тээвэрлэх, борлуулах үйл ажиллагааг зохион байгуулж, хяналт тавина.	2024-2028	-	170,624.0	-	-	-	-	170,624.0	Түлшний хэрэглээ, тонн	670,000	625,000	55,643.0	НАОБТГ	Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/141 дүгээр захирамжаар нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх үүйцэтгэгчийг сонгон шалгаруулахыг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт, гэрээ байгуулж ажиллахыг НАОБТГ-т тус тус даалгасан. Энэ ажлын хүрээнд нийслэлийн 7 дүүргийн хэмжээнд 2025-2026 онд сайжруулсан шахмал түлш тээвэрлэх 30 багц ажлыг нээлттэй сонгон шалгаруулалтаар зарлаж, 23 тээврийн компанийг хуулийн хүрээнд сонгон шалгаруулж, 3 компанитай түр гэрээ байгуулж, 2025 оны 07 дугаар сарын 24-ний өдрөөс 11 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 26 тээврийн компани зүүн бүсийн үйлдвэрээс борлуулалтын цэг, агуулах руу, агуулахаас борлуулалтын цэг рүү нийт 154,978 тонн сайжруулсан шахмал түлшийг тасралттүй тээвэрлэж, 15,026,970,508 төгрөгийн санхүүжилт олгосон байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Эрх шилжүүлэх тухай" А/140 дүгээр захирамжаар өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах зорилгоор 2025-2026 оны халаалтын улиралд гэр хорооллын айл өрхийн хэрэглэх шахмал түлшний нөөц бүрдүүлэх агуулахыг сонгон шалгаруулах тендерийн үр дүн гарах хүртэл хугацаанд шахмал түлш нөөцлөх агуулах шаардлагатай тул Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" А/76 дугаар тушаалаар шахмал түлшний нөөц бүрдүүлэх агуулахыг сонгон шалгаруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус Ажлын хэсгийн шийдвэрээр тендерийн үр дүн гарах хүртэл хугацаанд 12 агуулахтай түр гэрээ байгуулсан. 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар нээлттэй тендерээр шалгарсан 6, нийслэлийн өмчийн 4, түр гэрээ байгуулсан 12, нийт 22 агуулахад 33,308 тонн сайжруулсан шахмал түлш, хагас коксон шахмал түлш болон савласан мидлингийн нөөцтэй байна. 2025 оны 06 дугаар сарын 01-ний едреес 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн хооронд 18 агуулахад 1,802,395,304 төгрөгийн санхүүжилт олгосон. Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Шахмал түлшний борлуулалтын цэгийн тоог шинэчлэн батлах тухай" А/1405 дугаар захирамжаар 7 дүүргийн хэмжээнд 2025-2026 халаалтын улиралд нийт 425 шахмал түлшний борлуулалтын цэг ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны "Шахмал түлшний борлуулалтын төлбөр олгох тухай" А/1052 дугаар захирамжийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар борлуулагчдад 3,511,401,600 төгрөгийн шахмал түлшний борлуулалтын төлбөр олгосон байна.	100	
446			5	Таван толгой түлш ХХК-ний үйлдвэрлэсэн сайжруулсан шахмал түлш, түүний түүхий эдээс дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулж, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Шинжилгээнд хамруулсан дээж, тоо	30	50		НАОБТГ	Таван толгой түлш ХХК-тай хамтран бүтээгдэхүүн болон барьцалдуулагч өөрчилсөн 18 шахмал түлшинд хаягдал утааны хийн хэмжилт хийж үр дүнг (MNS5216:2016) стандарттай харьцуулсан. Хэмжилтийн үр дүнг стандарттай харьцуулахад шаардлага хангаагүй 18 түлш байна.	79	
447		Дэвшилтэт техник технологи нэвтрүүлсэн өрхийг дэмжинэ.	6	Байгаль орчинд ээлтэй эрчим хүчний хэмнэлттэй байшин, амины орон сууц болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг халаалттай нар, салхины болон бусад сэргээгдэх эрчим хүчийг ашиглаж байгаа өрхөд урамшуулал олгох журмыг батлуулж, хэрэгжилтийг хангана.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Журмын хэрэгжилтийн явц, хувь	-	100		НАОБТГ	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн 25/59 дүгээр тогтоолоор "Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийн гэр хорооллын өрхөд цахилгаан халаагуур болон бүх төрлийн хийн түлшээр ажилладаг төхөөрөмж суурилуулах, тэдгээрийн хэрэглээнд үнийн урамшуулал олгох журам" батлагдсан. Тус журамд зааснаар ногоон бүсийн айл өрхийг бүх төрлийн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийг нэг удаа үнэ төлбөргүй суурилуулж, халаалтын улиралд үнийн урамшуулал олгохоор тусгагдсан байдаг. Тус урамшуулалд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1364 дүгээр захирамжийн дагуу 2025-2026 оны халаалтын улиралд хийн халаалтад шилжиж буй Баянгол, Чингэлтэй дүүргийн 5,000 айл өрх хамрагдана.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
448	4.2.3.Авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй бохирдлын хэмжээг бууруулах, агаар болон чанарын хяналт, шинжилгээний чадавхыг сайжруулна.	Авто замаас үүдэлтэй тоосжилтыг бууруулна.	1	Авто замаас үүдэлтэй хотын дулааны арал болон авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй дуу чимээ, тоосжилтыг бууруулах мод, бут, сөөг зэрэг ногоон байгууламжийг авто зам дагуу нэмэгдүүлнэ.	2025-2028	-	-	8,000.0	-	-	-	8,000.0	Ногоон байгууламж байгуулсан талбай, га	0.5	4	2,000.0	УБЗАА	Нийтийн эзэмшлийн арчилгааны хүрээнд 157 га талбайд 9 дүүргийн хэмжээнд нийт 38 багц зарлагдан ойн мэргэжлийн байгуллагууд болон ОНӨТААТҮГ-аар арчилгааны ажил хийгдсэн. Жилийн эцсийн байдлаар нийтийн эзэмшлийн талбайд 114,359 ш мод, 11,711ш ургамлан хашлага, 8,7га талбайг зүлэгжүүлж, төвийн дүүргүүдэд ногоон байгууламжид 117,964 тн усалгаа хийж, 36,758 ш модыг өвчин хортоноос сэргийлэн, шохойдох арга хэмжээ авсан. Нийт 79,519 ш мод бутыг нөхөн тарьсан ба 511 ш савтай модыг нөхөн сэргээж будаж, 1,123 ш ўхсэн хатсан модыг талбайгаас чөлөөлж, тогоо гаргаж мод сөөгийг хэлбэржүүлсэн.	100	
449		Авто тээврийн хэрэгслээс үүдэлтэй бохирдлыг бууруулна.	2	Авто замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслийн хаягдал утааны агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт, автозамын /маршрутын бус шороон зам/ тоосжилтоос үүдэлтэй орчны бохирдолд хяналт шалгалт хийнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Хяналт, шалгалтад хамрагдсан тээврийн хэрэгсэл, тоо	450	450		НАОБТГ	Авто тээврийн үндэсний төвтэй хамтран Авто замын хөдөлгөөнд оролцож буй тээврийн хэрэгслээс үүдэлтэй орчны бохирдлын агууламжийг тодорхойлох шинжилгээт хяналт шалгалт хийх удирдамжийг боловсруулан ажиллаж байна. Байгуллагын удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын дагуу 2025 оны 03 сарын 19-ний өдөр Дашваанжин ХХК дээр газ автомашин болон бензин, дизель автомашинаас ялгарах хаягдал утаан дээр харьцуулсан хэмжилт хийсэн. Хэмжилтийн дүнгээс үзэхэд СО буюу нүүрстөрөгчийн дутуу исэл нь газ автомашин бензин автомашинаас 55 дахин бага, дизель автомашинаас 30 дахин бага байна.	50	
450	4.2.4.Дуу чимээний бохирдлын судалгаанд үндэслэн мэдрэгчийг суулгаж, оновчтой зохицуулалтыг хийх замаар бохирдлыг бууруулах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	дуу чимээний бохирдлын түвшинг тодорхойлно.	1	Нийтийн орон зайн төрөл ангиллыг тодорхойлж шаардлагатай байршилд оновчтой тохижилт бүтээн байгуулалт хийнэ.	2025-2028	-	2,000.0	-	-	-	-	2,000.0	Бүтээн байгуулалт хийх байршил, тоо	-	1	500.0	УБЗАА	Хотын төвийн байршил нь хүн амын нягтаршил ихтэй байгаагаас шалтгаалан НГЗБА-аас нягтаршил ихтэй бүсүүдэд тохижилтын зориулалтаар газар чөлөөлөлт хийгдэхийг учир СХД-ийн 34-р хорооны нутаг дэвсгэрт ХСҮТ-2 теслийн хүрээнд НЗД-ын 2025 оны А/889-р захирамжаар нийт 6.3 га талбайд иргэдийн амарч зугаалах орчин бүхий тохижилт ногоон байгууламжийн ажил хийгдсэн. 4682мкв явган зам талбай, 6406мкв талбайд 16 нэр төрлийн мод бут сөөг тарьж орчны тохижилтын ажил 90 гаруй хувьтай үргэлжилж байна.	100	
451			2	Нийслэл хотын дуу чимээ болон үнэрийн бохирдлыг бууруулах судалгаа хийж, журам боловсруулж мөрдүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Журам боловсруулах ажлын явц, хувь	-	30		НАОБТГ	Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25 -ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/547 тоот захирамжаар "Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмж" худалдан авах ажлыг зохион байгуулсан. Дуу чимээ, үнэрийн хэмжээг тодорхойлох багаж тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон. Багаж төхөөрөмжийг хүлээн авч дуу чимээ, үнэрийн бохирдлын хэмжилтийг хийж холбогдох стандартад нийцүүлэх судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	55	
452			3	Нийслэл хотод дуу чимээнээс үүсэж буй бохирдлын талаарх судалгаа хийнэ.	2025	-	-	-	-	-	-	-	Судалгааны ажлын явц, хувь	-	100		НАОБТГ	Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 25 -ний өдрийн "Эрх шилжүүлэх тухай" А/547 тоот захирамжаар "Агаар орчны хэмжилтийн тоног төхөөрөмж" худалдан авах ажлыг зохион байгуулсан. Дуу чимээ, үнэрийн хэмжээг тодорхойлох багаж тоног төхөөрөмж нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах эрх олгосон. Багаж төхөөрөмжийг хүлээн авч дуу чимээ, үнэрийн бохирдлын хэмжилтийг хийж, холбогдох стандартад нийцүүлэх судалгаа шинжилгээний ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.	55	
453			5	Дуу чимээний бохирдол хотын стандартыг мөрдүүлнэ.	2025-2028	-	50.0	-	-	-	-	50.0	Стандартын хэрэгжилт, хувь	30	100		ХБХСГ	1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 37 дугаар тогтоолоор Дуу чимээний бохирдол бүлэгт хамаарах дараах 3 хотын стандартыг батлуулав. Үүнд: - UCS 2001A Дуу чимээний бохирдлын менежмент; - UCS 2002A Дуу чимээний бохирдлыг бууруулах технологи, арга зүйн удирдамж; - UCS 2001C Дуу чимээ, дулаан тусгаарлах материал тавигдах ерөнхий шаардлага. 2. Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын холбогдох албан хаагчидтай 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуулж, хотын стандарт боловсруулах аргачилсан заавар, эвлөмж өгч, чиг үүргийн хүрээнд батлагдсан хотын стандартыг мөрдүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар санал солилцож ажиллав. Энэ хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/04 дүгээр тогтоолын хөөрдугаар хавсралтаар батлагдсан "Хотын стандартын арга зүйн заавар"-ыг болон "Дуу чимээний бохирдол" бүлгийн хотын стандартыг хүргүүлэв. 3. Хүний Эрхийн Үндэсний комиссоос санаачилсан УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал, О.Номинчимэг нартай хамтран "Холбон тоглогч-Тайван хот-Аюулгүй орчин" сэдэвт уулзалтад холбогдох албан хаагчид 3 удаа оролцож, Зөрчлийн тухай хуулийн 6.30 дугаар зүйлийн гарчигт "журам" гэсний дараа "стандарт" гэж нэмэх, мөн дуу чимээний түвшинг өдөрт 50 Дцб, шөнөд 40 Дцб-аас хэтрүүлэхгүй байх стандартыг иргэд, аж ахуйн нэгжүүд мөрдөж ажиллах санал хүргүүлэв. Мөн UCS2001A:2023 Дуу чимээний бохирдлын менежмент, UCS 2002A:2023 Дуу чимээний бохирдлыг бууруулах технологи, арга зүйн удирдамж хотын стандартын баримт бичигт нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны холбогдох 9 байгуллагад санал авах тухай 2025 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн 01/973 дугаартай албан бичгийг хүргүүлж, санал авч ажиллав.	59	
Зорилтын үр дүн: 4.3.Хөрсний бохирдлыг бууруулах ажлыг иргэдийн оролцоотойгоор цогц хэлбэрээр авч хэрэгжүүлнэ.																				

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
454	4.3.1.Улаанбаатар хотын хөрсний чанарыг сайжруулах бүсийн дэглэмийг мөрдөж, нүхэн жорлонгийн тоог 2 дахин бууруулж, нянгийн бохирдлыг бууруулна.	Стандартын бус шаардлага хангаагүй нүхэн жорлонг 30 хувиар бууруулна.	1	Нийслэлийн нутаг дэвсгэрт байгаа стандартын шаардлага хангаагүй ариун цэврийн байгууламж, нүхэн жорлонг буулгах, шинэчлэх үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2024-2028	-	1,580.0	-	-	-	-	1,580.0	Стандартад нийцүүлсэн нүхэн жорлон, тоо	13032	7000	300.0	НБОГ	Нийслэлийн ногоон бүс, зуслангийн хэсэгт стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж барьж байгуулах ажлын даалгаврыг боловсруулж, сонгон шалгаруулалт зарласны дагуу 3 аж ахуйн нэгж сонгон шалгаруулалтад оролцсон. Хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Зартиг эн” ХХК-тай 2025 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр БОГ2025/74 дугаартай ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулсан. Уг гэрээний дагуу Сүхбаатар дүүргийн 19-р хороо, Шаргаморьтод хийгдсэн стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн ажлын гүйцэтгэлийг Газрын даргын 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн А/186 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хүлээн авсан..	100	
455		Жил бүр 10000 ариун цэврийн байгууламжий г ариутгаж, халдваргүйжүүлнэ.	2	Нийслэлийн зуслангийн бүс дэх нянгийн бохирдол үүсгэж буй эх үүсвэрүүдийг ашигтай бактер, микробиологийн бэлдмэлээр ариутгаж халдваргүйжүүлнэ.	2025-2028	-	4,600.0	-	-	-	-	4,600.0	Ариутгасан нүхэн жорлон, тоо	-	10000	1,150.0	НБОГ	Нийслэлийн хөрсний байнгын хяналт мониторингийн 500 цэгийн суурь судалгааны дүнгээр бохирдолтой гарсан хэсгүүдээс 1 га талбайг сонгон авч, хөрсний бохирдол бууруулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. Энэ төлөвлөгөөний хүрээнд 2025 оны 04 дүгээр сарын 28-ний өдрийн НБОГ/20250201018 дугаартай ажил гүйцэтгүүлэх гэрээг "Монгол Улсын Их сургуулийн Инженер технологийн сургууль"-тай байгуулсан бөгөөд Баянзүрх дүүргийн 31 дүгээр хорооны нутаг дэвсгэрийн өндөр бохирдолтой 1 га талбайн хөрсний бохирдлыг бууруулах, саармагжуулах ажлыг 100 хувь хийж гүйцэтгүүлсэн. Газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн А/80 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг дээрх ажлын үр дүн, гүйцэтгэлийг 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр гэрээ дүгнэсэн протокол, акт үйлдэн хүлээж авсан.	100	
456	4.3.2.Арьс шир боловсруулах үйлдвэр, авто засвар, томоохон зах худалдааны төв зэрэг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс үүдэлтэй хүнд металлын бохирдлыг бууруулна.	Хүнд металлын элементийн бохирдлыг бууруулна.	1	Арьс ширний үйлдвэрийн бус, харгиа цэвэрлэх байгууламж орчмын хөрсний хүнд металлын бохирдлыг бууруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	2025-2028	-	315.0	-	-	-	5.0	320.0	Бохирдолыг бууруулсан талбайн хэмжээ, га	-	10	80.0	НБОГ	Хот Байгуулалт хотын стандартын газраас зохион байгуулсан "Үйлдвэрийн бүсийн хөрс, усны бохирдлыг саармагжуулах, нөхөн сэргээх нь" хэлэлцүүлэгт 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр илтгэл тавьж оролцсон. Хан-Уул дүүргийн 20-р хорооны нутагт байрлах арьс шир боловсруулах үйлдвэрүүд, Харгиа цэвэрлэх байгууламжийн орчимд хөрсний хүнд металлын бохирдлыг бууруулах, нөхөн сэргээх ажлын төлөвлөгөө боловсруулан НЗДТГ-т 03/2862 дугаартай албан бичиг хүргүүлсэн.	45	
457			1	Хотын нэлттэй болон хаалттай оршуулгын талбайн судалгааг үндэслэн хөрсийг ариутгаж, хамгаалалтын ногоон зурвас үүсгэж цаашид хүндэтгэлийн цэцэрлэгт хүрээлэнг байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Тохижилт хийсэн байршил, тоо	10	1		УБЗАА	Хотын нэлттэй болон хаалттай оршуулгын талбайн судалгааг үндэслэн хөрсийг ариутгаж, хамгаалалтын ногоон зурвас үүсгэж цаашид хүндэтгэлийн цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажлын хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 109 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны 09 дүгээр сарын 24-ний А/733 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, “Самбалхүндэвийн” оршуулгын газрын 10 га талбайд төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд бурхан болоочдыг дурсан хүндэтгэх иж бүрэн тохижилт, барилга, байгууламж бухий “Дурсгал хүндэтгэлийн цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төслийг тус алба нь “Нью Семетри” ХХК-тай хамтран хэрэгжүүлж байна. Мөн цаашид хаагдсан оршуулгын газруудын шарилыг үе шаттай зөөн шилжүүлж, чандарлаж, чөлөөлсөн талбайд "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод бут тарих цэцэрлэгт хүрээлэн байгуулахаар төлөвлөн 2026 оны төсөвт санал тусгаад байна.	100	
458	4.3.3.Оршуулгын үйлчилгээний зохистой менежментийг бий болгон, тохижуулж, цэцэрлэгжүүлнэ.	Оршуулгын газруудыг нүүлгэн шилжүүлж, нөхөн сэргээлт хийнэ.	2	Нийслэлийн нутаг дэвсгэрийн хаалттай оршуулгын газрууд дахь шарилын тооллого судалгаа хийж мэдээллийн нэгдсэн дата үүсгэнэ.	2024-2028	-	-	-	-	-	-	-	Судалгаа хийх ажлын явц, хувь	-	100		УБЗАА	Нийслэлийн нутаг дэвсгэрийн хаалттай оршуулгын газрууд дахь шарилын тооллого судалгаа хийж мэдээллийн нэгдсэн дата үүсгэх ажлын хүрээнд Оршуулгын үйлчилгээний бүртгэлийн нэгдсэн систем: Энэхүү бүртгэлийн систем нь нийслэл тедийгүй, улсын хэмжээний оршуулгын үйлчилгээний бүртгэлийн систем болно. Тодруулбал, нас баралт, түүнтэй холбоотой төрийн байгууллагаас олгож буй баримт бичиг, оршуулгын үйлчилгээ эрхэлж буй байгууллагын үйлчилгээний бүртгэл, үйлчилгээ авч буй нас барагчийн ар гэрийн мэдээлэл зэрэг оршуулгын үйл ажиллагаанд оролцогч бүх талуудын мэдээллийн нэгдсэн бүртгэл юм. Самбалхүндэвийн оршуулгын газар дахь булш, бунхны тооллого: Зөвлөх үйлчилгээний хүрээнд тооллогын дүнг бодит байдалд нийцүүлэх, бурхан болоочдын ар гэрийг бодит мэдээлээр хангах, цаашлаад газар чөлөөлөлтийн ажлын цар хүрээ, гүйцэтгэх хугацааг тодорхойлох зорилгоор булш, бунхны бүртгэлийн цахим сан үүсгэж 57.106 иргэний шарилыг цахим санд зураг жуулж оруулсан. Цаашид цахим санд бусад хаагдсан болон үйл ажиллагаа явуулж буй оруулын газруудын шарилыг оруулахаар төвлөж байна.	100	
459			3	Хотын нэлттэй болон хаалттай оршуулгын талбайн судалгааг үндэслэн газар чөлөөлөлт хийж нүүлгэн шилжүүлэх, чандарлах ажлыг зохион байгуулна.	2024-2028	-	-	-	-	-	-	-	Нүүлгэн шилжүүлсэн талбай, га	162.5	13.9		УБЗАА	Хотын нэлттэй болон хаалттай оршуулгын талбайн судалгааг үндэслэн газар чөлөөлөлт хийж нүүлгэн шилжүүлэх, чандарлах ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас Чингэлтэй дүүргийн 12-р хороонд байрлах “Самбалхүндэвийн” оршуулгын газрын 2000м кавдрат газрын 250 оршуулыг нүүлгэн шилжүүлж, Европын холбооны буцалтгүй тусламжын 3R4UB төслийн хүрээнд Экологийн төв буюу Эко Хаб-г байгуулсан. Тус Эко Хаб нь ангилсан хог хаягдал хүлээн авч дахин боловсруулалт хийдэг үйлдвэрүүдэд түүхий эдийг хүлээлгэн өгч дахин боловруулалт хийж болох хоёрдогч түүхий эдийг тойрог эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилготой. Энэ оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар нийт 1286 иргэний шарилыг чандарласан.	100	
Зорилтын үр дүн: 4.4.Хог хаягдлын хэмжээг бууруулах төслүүдийг хэрэгжүүлж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.																				

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуулла-га	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
460	4.4.1.Хог хаягдлыг дахин боловсруулах, эргүүлэн ашиглах, эрчим хүч гаргах зэрэг нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх замаар байгальд булж зайлуулах хаягдлын хэмжээг бууруулна.	Төвлөрсөн хогийн цэгт хоногт 1500 тонн хог шатааж 34 МВт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай "Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх" төслийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ.	1	Хог шатааж 35 МВт хүртэл хүчин чадалтай эрчим хүч гаргах үйлдвэрийг ашиглалтад оруулна.	2025-2028	-	-	-	-	-	758,500.0	758,500.0	Бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, хувь	-	30	227,550.0	ХСТХХТГ	Хотын төвлөрсөн хог хаягдлын цэгүүдэд хөрсний бохирдол үүсч, үүнийг дагаад Улаанбаатар хотын иргэдийн эрүүл мэнд, аюулгүй байдал хөндөгдөх болсон. Тэр дундаа нийт бохидлын 50 орчим хувийг Улаанбаатар дангаараа бий болгодог. Жилдээ нийслэлд 1.5 сая тонн хог хаягдал гардаг бөгөөд үүнээс ердөө 25 хувийг нь дахин боловсруулж байна. Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх төслийг Морингийн давааны хогийн цэгийг түшиглэн барихаар техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулан батлагдсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/85 дугаар тогтоолоор Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Хан-Уул дүүргийн 12 дугаар хороонд 35 МВт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай Хог шатааж, эрчим хүч гаргах үйлдвэр барих төслийн хэлэлцээнд "Наанова грийн энержи Монголиа" ХХК, "Сычуань эрчим хүчний хөрөнгө оруулалт, эрчим хүчний хэмнэлт, байгаль орчныг хамгаалах хөрөнгө оруулалт" ХХК, "Шанхай Эс Юу Эс" ХХК гэх гурван оролцогч саналаа ирүүлсэн. Сонгон шалгаруулалтад хамгийн өндөр үнэлгээ авсан оролцогчтой түншлэлийн гэрээ байгуулах хэлэлцээ хийгдэж дуусан. Түншлэлийн гэрээ байгуулах эрх олгох тухай асуудлыг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөлжит бус V хуралдааныаар хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлж дэмжигдсэн. Хан-Уул дүүргийн 12 дугаар хороонд 35 МВт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай Хог шатааж, эрчим хүч гаргах үйлдвэр барих төслийн гэрээг 2025 оны 10 дугаар сарын 24-ны өдөр байгуулсан. Төслийн хүрээнд 158 нэгж талбар өртөж байгаагаас 101 нэгж талбарыг чөлөөлсөн бөгөөд үлдсэн нэгж талбаруудтай зөвшилцөх ажил үргэлжилж байна. Төсөл хэрэгжсэнээр гэр хорооллын 2,333 яндан байхгүй болно гэсэн тооцоо гараад байгаа юм. Морингийн давааны үйлдвэрийн хүчин чадлын хувьд, жилд 1.5 сая тонн хог шатааж, 34 МВт эрчим хүч үйлдвэрлэх хүчин чадалтай байх урьдчилсан тооцоолол гарсан.	59	
461	4.4.2.Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийнэ.	Нийт хог хаягдалд эх үүсвэр дээр ангилан ялгасан хог хаягдлын хэмжээг 40 хувиар нэмэгдүүлнэ.	1	Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгийн ангилан ялгах үйлдвэрийг ашиглалтад оруулж, хог хаягдлыг ангилан ялгана.	2024-2028	-	2,526.5	-	-	-	-	2,526.5	Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээ, тонн	-	105	631.6	УБЗАА	УБЗАА: Барилга хот байгуулалт, орон сууцжуулалтын яамны 8.8 тэрбум төгрөгийн төсөөр Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгт едерт 300 тн хог хаягдал ангилан ялгах үйлдвэрийг "Наму дэвжих" ХХК барьж байгуулан улсын комисст хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж байна. Тус яамнаас үйлдвэрийг хариуцан ажиллах тухай хүсэлтийг нийслэлд ирүүлсэн бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар өмчид бүртгэсний дараагаар тухайн байгууллагын тогтоолоор нийслэлийн өмчид бүртгэх боломжтой тухай Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025.11.18-ны 01/1922 дугаартай албан бичгийг Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Тухайн үйлдвэрийн жилийн үйл ажиллагааны зардалд 2.4 тэрбум төгрөг шаардлагатай бөгөөд Нийслэлийн төсөвт суулгахаар хүргүүлсэн боловч батлагдаагүй.	ХБ	Нийслэл хариуцан хүлээж аваагүй байгаа.
462			2	Ангилсан хог хаягдлыг цуглуулах 298 ширхэг ухаалаг хогийн сав байршуулна.	2024-2028	-	-	2,516.0	-	-	-	2,516.0	Байршуулсан хогийн сав, тоо	-	230	1,900.0	Дүүргүүд	УБЗАА: Ухаалаг Улаанбаатар смарт сити төслийн хүрээнд Гүүдтек Софт ХХК 1.9 тэрбум төгрөгөөр цогч систем бүхий 230 ширхэг хогийн сав нийлүүлэхээр төндэрт шалгарсан. Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээнд захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны А/102 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг хуралдаж, 2025 оны 12 дугаар сар хүртэл гэрээг сунгасан. Дээрх ухаалаг хогийн савыг Нийслэлийн их дээд сургуулиуд болон ерөнхий боловсролын сургуулиудад байршуулахаар жагсаалт гаргасан бөгөөд тухайн сургуулиудад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах сургалтыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хийж хэрэжүүлж байна.
Багануур дүүрэг: Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас төвийн 6 дүүрэгт тус хогийн савнуудыг байршуулах хуваарь гарсан тул алслагдсан дүүргүүдэд хэрэгжээгүй.
Бэд: Дүүргийн хэмжээнд зах худалдааны төв болон аж ахуйн нэгжийн 10 байршилд ухаалаг хогийн сав байршуулах хүсэлттийг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 02/1441 дугаартай албан бичгээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлж ажилласан.
БГД: Нийслэлийн төсвийн 100.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1, 28 дугаар хороонд "СДММ" ХХК, "Кристал Инженеринг" ХХК хог ангилан ялгах асгуурын ажлыг 4 байршилд хийж гүйцэтгэсэн. Үүнд:
1-р хороо, 1А, 2А, 21А байрны хажууд 28-р хороо, Голден Парк-2 хотхон дотор
НАЛАЙХ: Ангилсан хог хаягдлыг цуглуулах 70 ширхэг хогийн сав байршуулсан. Үүнд: Нийтийн эзэмшлийн зам талбайд-8, аж ахуйн нэгж, байгууллагын гадна талбай-62
Багахангай дүүрэг: Нийтийн эзэмшлийн орон сууцны айл өрхийн хог хаягдлыг цуглуулахаар ангилан ялгах 8ш хогийн савны шинэчлэлт хийж, хогийн бункер 6ш, энгийн хогийн сав 40ш-ийг будаж өнгө үзэмжийг сайжруулан, хог хаягдал ангилан ялгах тур цуглуулах бункер 4 ширхэгийг шинээр байршуулав. Мөн ААНБ-уудад 20ш цикл хогийн сав байршуулан хуримтлагдсан хогийг тогтсон хуваарийн дагуу татан авч байна.
СБД: Дүүргийн 19 дүгээр хороонд ангилсан хог хаягдлыг цуглуулах ухаалаг хогийн цэг байгуулахаар Онсив баялаг ХХК-тай гэрээ байгуулан ажил хийгдэж байна.	83	
463	4.4.3.Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийн лагийг байгальд ээлтэй аргаар устгах төсөл хэрэгжүүлнэ.	Гэр хорооллын нүхэн ариун цэврийн байгууламж сайжруулна.	1	Төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд гэр хорооллын нүхэн жорлонгийн шингэн хог хаягдлыг байгальд ээлтэй аргаар боловсруулна.	2024-2028	-	-	5,600.0	-	-	-	5,600.0	Ариутгасан нүхэн жорлон, тоо	-	200	1,400.0	УБЗАА	БНСУ-ын буцалтгүй тусламжаар Сонгинохайрхан дүүргийн 24 дугээр хороо, Бумбатын рашаан орчмын 726 айл өрхийн бие засах газрыг эко нойл болгох ажлыг 2024-2025 онд хийж гүйцэтгэсэн. Дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас тендер шалгаруулалт зохион байгуулж, гэр хорооллын айл өрхийн 85000 орчим нүхэн жорлон болон бохирын цооногт ариутгал, халдваргүйтгэлийн ажил хийсэн.	100	
464	4.4.4.Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд шилжүүлнэ.	Хог хаягдлын менежментийн тогтолцоог 100 хувь хувийн хэвшилд шилжүүлнэ.	1	Хог хаягдлын үйлчилгээг үе шаттай хувийн хэвшилд шилжүүлнэ.	2024-2028	-	-	-	-	-	-	-	Хувийн хэвшилд шилжүүлсэн түвшин, хувь	30	45		УБЗАА	Тайлант үеийн байдлаар хог тээвэр, зам талбайн цэвэрлэгээг нийт 43 аж ахуйн нэгж, байгууллага гүйцэтгэж байгаа бөгөөд үүнээс 12 нь ОНӨААТҮГ, 31 нь хувийн хэвшилд ногдож байна. Энэ нь 2022 онтой харьцуулахад хувийн хэвшлийн байгууллагын оролцоо 86.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100	
Зорилтын үр дүн: 4.5.Иргэд оршин суугаа газраасаа 400 метр дотор амарч, тухлах ногоон байгууламж бухий тохилог орчныг байгуулж, иргэдийн ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.																				
465	4.5.1.Дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, бичил тохижилтыг нэмэгдүүлнэ.	Нэг хүнд ногдох ногоон байгууламжий н хэмжээ нэмэгдэж иргэд амарч зугаалах ая	1	Шинээр байгуулах 14 хотод томоохон цэцэрлэгт хүрээлэн байгуулна.	2025-2028	-	4,500.0	10,500.0	-	-	-	15,000.0	Шинээр байгуулсан цэцэрлэгт хүрээлэн, байршил тоо	18	2	3,000.0	УБЗАА	НИТХ-ийн 2019 оны 21/05 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу 2030 он хүртэл нийслэлийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 33 байршилд нийт 27.836 га талбайг шинээр тохижуулах судалгаат газар дээр нь хийж, дрон ашиглан танилцуулга боловсруулсан бөгөөд байршлуудыг зориулалт, онцлогийн дагуу гурван үндсэн бүсэд ангилсан. Голын эргийн бүсэд 9 байршил багтаж, нийт 898.4 га талбайд 80 орчим хувьд нь зөөлөн ландшафт төлөвлөж, 1.282.674 ширхэг мод тарих тооцоо гаргасан бөгөөд байгалийн унаган төрхийг хадгалах, амралт зугаалгын орчин бүрдүүлэх, хөв цөөрөм байгуулах, уулын бүсэд 8 байршил, 3581.6 га талбайд 80 хувьд зөөлөн ландшафт төлөвлөж, 5.350.024 ширхэг мод тарихаар тооцсон бөгөөд хотын стратегийн харагдацыг хадгалах, байгалийн бүсийг хамгаалах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго тавьсан. Цэцэрлэгжүүлэх бүсэд 16 байршил, 27.836 га талбайд 60 хүртэл хувьд зөөлөн ландшафт төлөвлөж, 44.244.199 ширхэг мод тарихаар тооцсон бөгөөд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, хотын захын хүртээмжийг нэмэгдүүлэхийг зорьсон. Эдгээр 33 байршлын зурат төсөл хийх ажлын даалгаврыг хот байгуулалтын назраас гаргуулан батлагуулсан тохижилтод шаардагдах төсвийг 2030 оны төлөвлөгөөнд тусган, мөн төсвийн тодотголд дахин тусгаж ажилласан. Улсын төсвийн хөрөнгөөр СХД-ийн 34-р хороо Хавдар судлал-2 эмнэлгийн гадна талбайн тохижилт төсөвт тусгагдаж явган замын ажил эхэлсэн ба хаврын тарилтаар 3,000 ш мод бут тарих ажилд хяналт тавин ажиллаж байна.	83	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
466		тухтай орчин бүрдэнэ.	2	Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу газраа 2 жил ашиглаагүй байршлуудад тохижилт, ногоон байгууламжийн ажил хийнэ.	2025-2028	-	3,500.0	3,500.0	-	-	-	7,000.0	Тохижилт, ногоон байгууламж хийсэн байршил, тоо	-	1	1,000.0	УБЗАА	НЗД-ын 2025 оны А/237 дугаар захирамжийн хүрээнд зөвшөөрөлгүй барьсан хашаа хайс, зориулалтын бусаар ашигласан газрыг чөлөөлөх ажлыг 9-н дүүрэгт зохион байгуулж, зөрчил арилгах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Нийт 25 хорооны 295 газар чөлөөлсөн байршилд тохижилт, ногоон байгууламж хийсэн. Үүнээс нийт 6536 мкв бухий 4 авто зогсоол, 290 байршилд торхтой мод, сандал, хогийн сав, 1 байршилд ногоон байгууламж бухий авто зам, явган зам хийж тус тус тохижуулсан байна.	100	
467	4.5.2.Голуудын эргийн дагуу иргэд амарч зугаалах, спортоор хичээллэх ая тухтай орчныг бүрдүүлнэ.	Голуудын эргийн дагуух тохижилт хийсэн байршлыг нэмэгдүүлнэ.	4	Улаанбаатар хотын стратегийн харагдац бүхий байршлуудад мод тарих, ногоон байгууламж бий болгох замаар үндсэн төрхийг хадгална.	2025-2028	-	3,000.0	3,000.0	-	-	-	6,000.0	Хамгаалсан байршил, тоо	3	-		УБЗАА	НИТХ-ийн 2019 оны 21/05 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө"-нд тусгагдсаны дагуу 2030 он хүртэл нийслэлийн хэмжээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 33 байршилд шинээр тохижуулах судалгааг газар дээр нь хийж, байршлуудыг зориулалт, онцлогийн дагуу гурван үндсэн бүсэд ангилсан. Голын эргийн бүсэд 9 байршил багтаж, нийт 898.4 га талбайд 80 орчим хувьд нь зөөлөн ландшафт төлөвлөж, 1.282.674 ширхэг мод тарих тооцоо гаргасан бөгөөд байгалийн унаган төрхийг хадгалах, амралт зугаалгын орчин бүрдүүлэх, хөв цөөрөм байгуулах, уулын бүсэд 8 байршил, 3581.6 га талбайд 80 хувьд зөөлөн ландшафт төлөвлөж, 5.350.024 ширхэг мод тарихаар тооцсон бөгөөд хотын стратегийн харагдацыг хадгалах, байгалийн бүсийг хамгаалах, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилго тавьсан. Дээрх ажлын хүрээнд Хотын ерөнхий менежерийн 2025 оны А/106 дугаар тушаалаар Тохижилт, ногоон байгууламж, цэцэрлэгт хүрээлэнгийн зураг төсөв хийлгэх 1.5 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд үнэлгээний хороо байгуулах ажил хийгдэж байна.	100	
468			1	Улаанбаатар хотын ногоон байгууламжид ашиглах стандартын чимэглэлийн суулгац бэлтгэх Мод үржүүлгийн газар, туршилт судалгааны төв байгуулна.	2025-2028	-	1,200.0	-	-	-	-	1,200.0	Судалгаа хийсэн талбай, га	600.0	2,000.0	200.0	УБЗАА	Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 11, 20, 23, 28 дугаар хороо, Налайх дүүргийн 1, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит "Эв нэгдлийн цэцэрлэгт хүрээлэн"-г байгуулах Нийслэлийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24 –ний өдрийн А/701 дугаар захирамж гарсан бөгөөд уг ажлын эхлэл болох Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дэргэдэх 32-га мод үржүүлгийн газрыг төлөвлөн эхлүүлсэн. Хотын ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийн хүрээнд стандартын суулгац ургуулах бэлтгэл ажлыг хангах зорилгоор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дэргэдэх мод үржүүлгийн газар байгуулж хувийн хэвшлийн 15 байгуллагa үйл ажиллагаат гэрээний дагуу өдөр тутмын ажилд хяналт тавьж ажиллав.Тэрбум модны хүрээнд Мод үржүүлгийн газрын үйл ажиллагаат өргөтгөх хүлэмж нэмэгдүүлэх хүрээнд иж бүрэн 62 ширхэг 8х20 харьцаатай зуны хүлэмж, 2000м2 дөрвөн улиралын хүлэмжтэй 1.2 сая 1-3 настай суулгац бойжуулан ажиллаж байна.	98	
469	4.5.3."Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний стратеги төлөвлөгөө, "Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөө"-тэй уялдуулан нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдэнэ.	2	Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлнэ.	2025-2028	-	11,000.0	80,000.0	-	-	-	91,000.0	Ногоон байгууламж хийсэн талбай, га	95	135	13,000.0	Дүүргүүд	Багануур дүүрэг: Нийтийн эзэмшлийн гудамж талбайн ногоон байгууламж, цэцэрлэгжүүлэлтийг нэмэгдүүлж усалгаа, арчлалт, хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд 645 ширхэг улиас модны хэлбэржүүлэлтийг хийж, 5600 уртааш метр ургамлан хашлаганы хэлбэржүүлэлт тайралтыг 7, 8, 9-р саруудад хийж, ногоон байгууламжийн 30,000 м2 талбайн цэвэрлэгээ үйлчилгээ, мөн 15000 ширхэг нэг наст цэцгийг төв талбай болон авто замын тусгаарлах зурвас, авто зам дагуу тарьсан. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд "Бүх нийтээр мод тарих өдөр"-ийг дүүргийн хэмжээнд 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрийн хооронд зохион байгуулж, 11450, намрын бүх нийтээр мод тарих өдрийг 10 дугаар сарын 11, 12-ны өдөр зохион байгуулж 8290 ширхэг мод бутыг тарьж, цэнэг усалгаа арчилгааг хийсэн. 1 хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг 36.2 м2, нийт талбайг 1,241.300 м2 хүргэзд байна. БЗД: "Дүүргийн 28 дугаар хороо, Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэнгийн төслийн талбайд Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны 05 дугаар сарын 03-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ны өдөр хүртэлх хугацаанд 82 аж ахуйн нэгж, гэр бүлийн 3130 иргэн, алба хаагч 235 ширхэг том мод, 3410 ширхэг бут сөөг, 23224 ширхэг модыг ургамлан хашлаганд, нийт 26869 ширхэг мод бут сөөг тарьсан. Дүүргийн арчлалт хамгаалалтад байх нийтийн болон хязгаарлагдмал хэрэгцээний 40 байршлын 337,136м.кв ногоон байгууламжийг хариуцан ажиллаж буй "Олон Улсын Эко цэцэрлэгт хүрээлэн" ОНӨААТҮГ болон "Охь мандал" ХХК, "Бат өндөр хайрхан" ХХК, "Эрдэст булаг" ХХК, "Ногоон харш" ХХК, "Агрофорест" ХХК, "Баян сөөт" ХХК, "Модны эмч" ХХК-ууд ногоон байгууламжийн талбайд 36,124 ширхэг мод бут сөөгийг нөхөн тарьж нийт 2025 оны хаврын улиралд 17 нэр төрлийн 80,639 ширхэг бут сөөгийг шинээр тарьж дүүргийн ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлээд байна. БГД: "Тэрбум мод" аяны хүрээнд 2025 онд дүүргийн хэмжээнд нийт 594 байршилд 280 СӨХ, 395 ААНБ, 495 айл өрх, давхардсан тоогоор 1430 иргэд хамтран 53225 ширхэг мод бутыг тарьсан байна. Ингэснэр дүүргийн 1 хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээг өмнөх оноос 0,8 м2 аар нэмэгдүүлсэн байна. НАЛАЙХ: Нийтийн эзэмшлийн 3500м2 талбайд нөхөн зүлэгжүүлэлт, 300м2 талбайд шинээр зүлэгжүүлэлт хийж, 306кг үр тарих ажлуудыг гүйцэтгэж, арчилгаа усалгаар хуваарийн дагуу хийж байна. Мөн нийтийн эзэмшлийн талбайн 8 байршлын цэцгийн мандалд 38000 ширхэг нэг наст цэцгийг суулгаж, талбай тус бүрд чийгшлийг хэмжих ажлыг тогтмол гүйцэтгэж байна. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөн эхэлсэн 2021 оноос хойш дүүргийн хэмжээнд 68036 мод шинээр тарьж, 2025 оны байдлаар нийтийн эзэмшлийн 33,6 га талбайд нийт 107953 модтой болсон.Нэг хүнд ноогдох ногоон байгууламжийн хэмжээ 9,4м2, амьдралтын ургалтай 95%-тай байна. ЧД: Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр 2025 онд 9 байршилд 15 төрлийн 46,988 ширхэг мод, 705у/м ургамлан хашлага шинээр тарьж 14,000м2 талбайг шинээр зүлэгжүүлж ногоон байгууламжийн талбайн хэмжээг 1,2 га-аар нэмэгдүүлсэн. Энэхүү ажлын хүрээнд авто зам дагуух ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр Энхтайваны өргөн чөлөө Цэцэг төвийн уулзвараас Баруун дөрвөн замын уулзвар хүртэлх 1385м.кв 1,3 км үргэлжлэх 11 сектор бухий авто зам дагуух карма зогсоолуудыг хааж тохижуулан нийт 2400 м2 зүлэг, нарс 66 ширхэг, гацуур 53 ширхэг,хайлаас 9960 ширхэг буюу 664у/м ургамлан хашлага хэлбэрээр тарьж тохижуулж, Баянбүрдээс 32 тойрог хүртэл шинээр 5300м2 зүлэг 300 ш нарс мод 185 ширхэг голт бор, 1488 ширхэг хайлаас 992 у/м ургамлан хашлага, 32-ын тойрог -7 буудал хүртэл 6214ш зүлэг, 11 төрлийн 170 ш мод сөөг, Гэсэр сүмийн баруун талаас Сити авто сервис хүртэл 180м2 зүлэг 30ш гацуур, 30ш агч, Баянбүрдийн тойрогт 15 ш нарс 3500 ш хайлаас мод тус тус тарьж нийт шинээр 14094м2 талбайг зүлэгжүүлэн 14 төрлийн 12222ш мод , 1656у/м ургамлан хашлага таригдаж ногоон байгууламжит талбайг 1,2 га-аар нэмэгдүүлсэн байна. Багахангай дүүрэг: Тайлангийн хугацаанд хороо холбосон авто замын дагуух 0,3 га талбай бухий хайс хашаанд 200ш улиас, 500ш голт бор, Улаанбаатар-Замын-Үүд чиглэлийн авто замын дагуу 1,1 га талбайд, 1 дүгээр хорооны ногооны талбайн 0,27 га талбайд 1000ш агч модыг тус тус тарьсан. Түүнчлэн 1800м2 талбай бухий зүлэгт талбай, 3ш цэцэгт байгууламж байгуулах ажлуудыг гүйцэтгэв. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 35 аж ахуйн нэгж, байгууллага 424 өрх агч, голт бор, монос, улиас гэсэн 4 нэр төрлийн 7179 ширхэг мод тарьж, нийт 424 ажилтан, албан хаагч болон иргэд хамрагдаж, 53,7 сая төгрөг зарцуулсан байна. СБД: Дүүргийн Засаг даргын Албан даалгаврын биелэлтийг хангах ажлын хүрээнд дүүргийн хэмжээнд 2025 оны бүх нийтийн мод тарих өдөрлөгөөр 126 аж ахуйн нэгж байгууллага, 1125 өрхийн 1500 орчим иргэн, ажилтан алба хаагчид 14,400 мод, бут сөөг шинээр тарьсан байна.Мөн мод тарих хүсэлт ирүүлсэн айл өрх, сууц өмчлөгчдийн холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу 25,725 ширхэг жимс, жимсгэний бут сөөгний суулгац, мод тарихад шаардлагатай хар шороо, элс, бордоо зэргийг дүүргийн Засаг даргын Тамгын газраас тарааж мод тарих үйл ажиллагаанд арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.	100	
470			3	Тусгай хэрэгцээний ногоон байгууламж бухий оршуулгын газар, төвлөрсөн хогийн цэгүүдийг ойжуулах, хамгаалалтын зурвас байгуулна.	2025-2028	-	1,500.0	-	-	-	-	1,500.0	Хамгаалалтын зурвас байгуулсан байршил, тоо	3	-		УБЗАА	2024 оны ногоон байгууламжийн урсгал зардлын хүрээнд БЗД цагаан даваааны оршуулгын цэгийн хамгаалалтын зурваст 14,000 ширхэг улиас мод тарих ажлыг зохион байгуулан арчилгаа хамгаалалтыг Баянзүрх дүүрэгт хариуцуулан, хүлэзлгэн өгсөн, цаашид нийслэлийн орчмын оруулгын газар, хогийн цэгүүдэд хамгаалалтын зурвас байгуулах төлөвлөлтийн ажлыг хийж байна.	95	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хөвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
471	4.5.4.Хотын ногоон байгууламжийг хамгаалах, нэмэгдүүлэх, хотын соёлыг бүрдүүлэхэд иргэдийн оролцоотой хяналтын тогтолцоог бэхжүүлнэ.	Хотын ногоон байгууламжийн суурь судалгаатай болж мэргэжлийн түвшинд арчилж хамгаална.	2	Цэцэрлэгжүүлэлтийн ажил гүйцэтгэх төсвийн норм дүрэм шинэчлэх, нэгж талбайн арчилгааны зардлын үнэлгээг шинээр боловсруулж мөрдүүлнэ.	2025	-	-	-	-	-	-	-	Норм дүрэм боловсруулж батлуулах ажлын явц, хувь	-	100		УБЗАА	Барилгын хөгжлийн төвөөс нийт норм дүрэм стандартыг шинэчлэн 6-р сарын дотор урьдчилсан байдлаар мэдээллэх тул тухайн стандартад санал тусгахаар ажиллаж байна.	55	
472			3	Улаанбаатар хотын ногоон байгууламжийн ашиглалт хамгаалалтын ажлын хүрээнд баримтлах журам шинэчилж мөрдүүлнэ.	2025	-	100.0	-	-	-	-	100.0	Журам шинэчлэн боловсруулах ажлын явц, хувь	-	100	100.0	УБЗАА	Журмын төсөл боловсруулах Ажлын хэсгийн тушаал боловсруулах шатандаа явж байна.	59	
473			4	Нийслэлийн нийтийн ээмшлийн ногоон байгууламжийн тооллого судалгаа хийнэ.	2025-2028	-	-	1,050.0	-	-	-	1,050.0	Тооллого судалгаа хийх ажлын явц, хувь	-	100	450.0	УБЗАА	Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн нийтийн ээмшлийн ногоон байгууламжийн тооллого судалгаа хийх, газарзүй мэдээллийн систем (ArcGIS) суурилсан мэдээллийн сан үүсгэх ажил гүйцэтгэх нийтийн ээмшлийн 157га талбайн ногоон байгууламжийн тоон мэдээг Улаанбаатар хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт, удирдлагын цогц систем (https://ub-engineering.gov.mn/)-д оруулна.	100	
474			5	Барилга байгууламж шинээр барих үйл ажиллагаанд ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай байгуулах зэрэг барилгын тухай хуульд заасан шаардлагыг бүрэн хангуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Барилга угсралтын ажлын явцад норм, стандартыг газар дээр нь хангуулсан түвшин, хувь	-	10	-	ХБХСГ, ХШГ	ХБХСГ:2025 онд иргэн, аж ахуйн нэгж, төрийн байгуллагаас ирүүлсэн Загвар зурагт Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.8-д "...барилгажих талбай нь тухайн газрын 60 хувиас илүүгүй бүюу төлөвлөгөөнд хамааруулсан нийт газар нутгийн болон барилга барих зориулалтаар олгосон газрын нийт талбайн 20-иос доошгүй хувь нь цэцэрлэг, ногоон байгууламж, 20-иос доошгүй хувь нь авто зогсоол байна." гэж заасны дагуу 1302 архитектур төлөвлөлтийн даалгавар, 670 Загвар зурагт хууль норм, стандартыг хангуулан Барилга, байгууламж шинээр барих үйл ажиллагаанд ногоон байгууламж, авто зам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбайг тусгуулан батлуулсан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчаас өгсөн үүрэг даалгаврын дагуу дүүргийн нутаг дэвсгэрт авто зогсоол төлөвлөх боломжтой 1500 м2-аас багагүй талбайтай газрын судалгаг 40 байршилд гаргаж, авто зогсоолын ТЭЗҮ, ажлын зураг төсөл боловсруулах байршлын схем гаргав. Улаанбаатар хотод унадаг дугуй, цахилгаан скутэрийн хөдөлгөөнийг сайжруулах зорилготой төлөвлөгдөж буй байршлуг иргэдийн оролцоотой хотыг хөгжүүлэхэд трасс схем зургуудыг бэлтгэн иргэдээс санал асуулга авч ажиллав. ХШГ:Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 23-ны өдрийн 02-13-04/023/21 дугаартай удирдамжийн дагуу нийслэлийн хэмжээнд байнгын ашиглалтад хүлээн авсан нийт 88 барилга байгууламжид гүйцэтгэлийн хяналт шалгалтыг зохион байгуулж, ногоон байгууламж, автозам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбайг дутуу хийж гүйцэтгэсэн зөрчил дутагдалд 13 албан шаардлага хүргүүлж, хэрэгжилтийг бүрэн хангуулав. Ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хүүхдийн тоглоомын талбайг өөрчилж хийсэн үндэслэлээр 1 иргэнд хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаг явуулж, 1.0 сая төгрөгийн торгууль ногдуулсан.	100	
475	4.5.5.Айл өрх хашаандаа мод тарих, ногоон байгууламж байгуулах, хур усыг цуглуулах технологийг нэвтрүүлж, ногоон байгууламжийн усалгааанд хэрэглэнэ.	Иргэд хашаандаа мод тарих санал санаачилга нэмэгдэнэ.	1	Иргэдийг хашаандаа мод тарих ажлыг дэмжих, урамшуулах эрх зүйн орчныг бүрдүүлж, хэрэгжилтийг хангана.	2025-2028	-	100.0	200.0	-	-	-	300.0	Журмын хэрэгжилтийн явц, хувь	-	100	75.0	УБЗАА	Нийслэл хотын хөгжилд хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ногоон оноогоор урамшуулах үйл ажиллагааг зохицуулах "Ногоон хөгжлийг дэмжих санд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах болон ногоон оноог олгох шалгуур үзүүлэлт, хэмжээ, түүнийг менгөн хэлбэрт шилжүүлэх, санхүүжүүлэх, оноо зарцуулах журам"-ын төслийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн Нийслэлийн Засаг даргын А/159 дүгээр захирамж гарсан. Ногоон хөгжлийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, захиран зарцуулах, хяналт тавих журам, Ногоон оноог олгох шалгуур үзүүлэлт, хэмжээ, түүнийг менгөн хэлбэрт шилжүүлэх, санхүүжүүлэх, оноо зарцуулах журам гэсэн хэсэт хуваагдаж санал боловсруулагдаж байна. "Журам"-ын төсөл боловсруулах ажлын хэсэгт орсон харьяа байгууллагуудаас санал авахаар Ажлын хэсгийн ахлагч 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 02-02/3786 дугаартай албан бичиг хүргүүлсэн. Журмын төсөл нь 5 бүлэг 27 зүйл, 2 хавсралттай боловсруулагдан санал авч байна. Ажлын хэсгийн хурал 2025 оны 12 дугаар сард хуралдахаар санал авч нэттгэн ажиллаж байна.	84	
476			2	Ой жуулалт, мод тарьж ургуулах асуудлыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах, соён гэгээрүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулна.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Зохион байгуулсан арга хэмжээ, тоо	-	9		УБЗАА		65	
ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО																				
Салбарын үр дүн: Иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, ил тод, үр нөлөөтэй, цахимжсан, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.																				
Зорилтын үр дүн: 5.1. Нийслэл хотын засаглалын шинэчлэлийг хэрэгжүүлнэ.																				
477	5.1.1.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад удирдлагын тогтолцооны реформ хийх замаар засаглалын тогтолцоог оновчтой болгоно.	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад удирдлагын тогтолцооны реформ бодитоор хэрэгжиж, засаглалын оновчтой тогтолцоо сайжирна.	1	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ хийж, засаглал удирдлагын тогтолцооны реформ хийх үндсэн чиглэлүүдийг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна.	2025	-	50.0	-	-	-	-	50.0	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувь	-	100	50.0	НЗДТГ-ТЗҮГ	Нийслэлийн нутгийн захиргааны 87 байгуллага, 9 дүүргийн хэмжээнд Засаглалын төлөв байдлын үнэлгээ, албан хаагчдын үнэлгээг хийж, тус үнэлгээний үр дүнгүүдэд тулгуурлан тогтвортой хөгжилд түшиглэсэн засаглалын шинэчлэлийн бодлогын хүрээг боловсруулж, нийслэл, дүүргийн бүх байгуллагуудын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд засаглал удирдлагын тогтолцооны реформ хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бүрэн тусгаж ажиллалаа.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгуул-лага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зорилтот түвшин	Төсөв (сая төгрөг)				
478	5.1.2.Нийслэлийн дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлт боловсруулж, батлах, нийслэлийн удирдлагын шийдвэр гаргах түвшинд мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, олон нийтээр хэлэлцүүлж, саналыг тусгах замаар оролцоог хангана.	Нийслэлийн бодлого, төлөвлөлтөд олон нийтийн оролцоог хангана.	1	Нийслэлийн дунд, богино хугацааны бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг зохион байгуулахад мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн оролцоог хангаж, саналыг тусгана.	2025-2028	-	500.0	-	-	-	-	500.0	Хамтарч ажилласан байгууллага, тоо	-	2	125.0	НЗДТГ-НБТГ	Нийслэлийг 2026-2030 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, нхт 2026 оны төлөвлөгөөг нутгийн захиргааны байгууллагуудаас санал авч тусгах саналыг авч боловсруулсан.	29	
479	5.1.3.Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж, нэгжийн удирдлагаас хотын удирдлагад чиг үүргийг шилжүүлэх ажлыг зохион байгуулна.	Нэгжийн удирдлагаас хотын удирдлагад шилжих чиг үүргийн тоо 20 хувиар нэмэгдэж, төрийн үйлчилгээний хариуцлагын төвөрөл 20 хувиар сайжирна	2	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж, нэгжийн удирдлагаас хотын удирдлагад чиг үүргийн шилжилтийн үйл явцыг хэрэгжүүлэх, хяналт-шинжилгээ хийнэ.	2025-2026	-	155.0	-	-	-	-	155.0	Шинжилгээ хийсэн чиг үүргийн өөрчлөлтийн түвшин, хувь	-	-		НЗДТГ-ТЗУГ	ТЗУГ: Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга нь нийт 8 бүлэг, 54 зүйлээс бүрдэнэ. Энэхүү хууль нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хот, тосгоны удирдлага болон зохион байгуулалтын эрх зүйн үндсийг тодорхойлж, хот, тосгон байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах нийтлэг журам, хотын зэрэглэл тогтоох шалгуурыг зохицуулна. Мөн хот, тосгоны удирдлагаас засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, аж ахуйн нэгж, байгуллага, оршин суугчидтай харилцах харилцааг зохицуулах бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 01-нээс эхлэн хэрэгжинэ. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ "Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын чиг үүргийн судалгаагаар Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд (ННЗБ)-ын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлж, байгууллага тус бүрийн чиг үүргийн давтамж, хамрах хүрээ, чиглэлийг тодорхойлов. Судалгаанд нийслэлийн нутгийн захиргааны байгуллага бүрийн үйл ажиллагааны чиглэлүүдийг баримт бичиг, бүртгэл мэдээлэлд тулгуурлан нэгтгэсэн бөгөөд чиг үүргийг байгууллагаар нь бүлэглэн тоон үзүүлэлт гаргав. •Нийслэлийн нийт 70 гаруй байгуллага хамрагдсан бөгөөд нэг байгуллага дунджаар 5–10 чиг үүрэг хэрэгжүүлж байна. •Нийслэлийн Байгаль орчны газар хамгийн олон буюу 28 чиг үүрэг гүйцэтгэдэг нь тогтоогдсон бол Нийслэлийн Агаарын бохирдолтой тэмцэх газар зэрэг байгуллагууд 1–3 чиг үүрэгтэй байна. •Чиг үүргүүдийн агуулга нь хууль эрх зүйн хэрэгжилт, мэргэжлийн хяналт, үйлчилгээний зохицуулалт, хөгжлийн бодлого төлөвлөлт гэх мэт өргөн хүрээг хамардаг. Чиг үүргийн нягтаршил, үр нөлөөний шинжилгээ хийгдэж, байгууллагын бүтэц, үүргийн хуваарилалтад зохион байгуулалтын шинэчлэл, чиг үүргийг дахин сайжруулах нэмэлт судалгааны ажил хийгдэх шаардлагатай."	89	
480	5.1.4.Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем, стандартыг нэвтрүүлнэ.	Хяналт-шинжилгээ, үнэлгээний гүйцэтгэлийн үзүүлэлт 35 хувиар нэмэгдэж, төрийн үйлчилгээний ил тод байдал 30 хувиар сайжирна.	1	Олон улсын үнэлгээний систем, стандарт, нийслэлийн нуттийн захиргааны байгуллагуудын өнөөгийн нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ хийж, нутагшуулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна.	2025	-	60.0	-	-	-	-	60.0	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц, хувь	-	100	60.0	НЗДТГ-ТЗУГ	ННЗБ-уудын өнөөгийн Засаглалын төлөв байдлын үнэлгээ 1. Үнэлгээний хүрээ, аргачлал – Тус үнэлгээ нь байгуллагын стратеги, зорилго, алсын хараатай уялдуулан гүйцэтгэлийн гол үзүүлэлт (KPI)–ийн тогтолцоо, үр дүнгийн үнэлгээ, цаг хугацааны явцад ахиц дэвшил, харьцуулсан жишиг үзүүлэлтүүд болон оролцогч талуудын хүлээлт, хувь нэмрийг үнэлэх үйл явцыг хамарч гүйцэтгэгдсэн. Өгөгдөл цуглуулах, анхан болон гүнзгий дүн шинжилгээ хийх, сайжруулалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх шат дамжлагыг бодитоор нягтлан үзэв. 2. ННЗБ-уудын албан хаагчдын үнэлгээ Судалгааны үр дүнд хийсэн гүнзгийрүүлсэн шинжилгээг нэгтгэн дүгнэхэд, нийслэлийн нутгийн захиргааны байгуллагууд нь "Ажлын утга учир" ба "Хамт олны эв нэгдэл" гэсэн хоёр асар том соёлын капитал дээр тогтож байна. Гэвч энэхүү эерэг суурийг "Удирдлагын чадамжгүй байдал", "Шударга бус урамшууллын систем", "Хөгжих боломжийн хомсдол" зэрэг системийн шинжтэй ноцтой сорилтуд идэвхтэйгээр сулруулж байна. Энэхүү нөхцөл байдал нь байгуллага доторх хамгийн чадварлаг, идэвх санаачилгатай ажилтнууд өөр боломж хайхад хүргэх, улмаар хүний нөөцийн чадавх сулрах ноцтой эрсдэлийг бий болгож байна. Иймд, байгуллагын соёлын хүчтэй талыг бэхжүүлж, системийн сул талуудыг арилгахад чиглэсэн цогц, стратегийн арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байна. Дээрх дүгнэлтэд үндэслэн ажилтны сэтгэл ханамж, бүтээмжийг дээшлүүлэх, чадварлаг боловсон хүчнийг тогтоон барих зорилгоор дараах тодорхой, хэрэгжихүйц зөвлөмжүүдийг дэвшүүлж байна. 3.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон нутгийн захиргааны байгуллагуудын засаглалын шинэчлэлийн бодлогын хүрээ бодлогын баримт бичиг боловсруулав. Энэхүү бодлогын хүрээг хэрэгжүүлснээр нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын засаглалын чанар сайжирч, төрийн үйлчилгээний үр өгөөж нэмэгдэн, иргэдийн итгэлцэл бэхжиж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах юм. Засаглалын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд манлайллыг бэхжүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн оролцоог хангах бодит механизм бий болгох зэрэг нэн тэргүүний алхмуудыг хэрэгжүүлнэ.	100	
481	5.1.5.Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал, ил тод байдлыг сайжруулна.	Мэдээллийн ил тод байдал 40 хувиар нэмэгдэнэ.	1	Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглал удирдлагын тогтолцооны нөхцөл байдлын судалгаа, шинжилгээ хийж хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулна.	2025	-	60.0	-	-	-	-	60.0	Судалгааны ажлын явц, хувь	-	100	60.0	НЗДТГ-ТЗУГ	1.Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын засаглалын шинэчлэлийн бодлогын хүрээ бодлогын баримт бичиг боловсруулав. Энэхүү бодлогын хүрээний баримт бичиг нь Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын засаглалын тогтолцоонд тулгамдаж буй сорилтуудыг оношилж, тэдгээрийг шийдвэрлэхэд чиглэсэн, олон улсын жишиг нийцсэн, Монгол Улсын хууль тогтоомжид суурилсан стратегийн цогц загварыг дэвшүүлж байна. Энэхүү дүгнэлт нь асуудлын мөн чанар, шинэчлэлийн үндсэн гурван тулгуур, хэрэгжүүлэх арга зам, хүлээгдэж буй үр дүнг товч танилцуулна. Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын нь хууль эрх зүйн зохицуулалтын хийдэл, санхүүгийн хязгаарлагдмал байдал, хүний нөөцийн чадавхын сулрал, хүнд суртал, иргэдийн оролцооны хангалттүй байдал зэрэг системийн шинжтэй сорилтуудтай тулгарч байна. Эдгээр сорилт нь нийтийн үйлчилгээний үр ашгийг бууруулж, иргэдийн төрд итгэх итгэлийг сулруулах, ноцтой эрсдэлийг бий болгож байна. Эдгээр сорилтыг шийдвэрлэх зорилгоор боловсруулсан энэхүү бодлогын хүрээ нь дараах гурван стратегийн тулгуурт суурилна: 1.Стратегийн манлайлал ба байгуллагын соёл: Байгуллагын эрхэм зорилго, алсын хараг тодорхойлж, ёс зүйтэй, ил тод, инновацыг дэмжсэн соёлыг төлөвшүүлэхэд манлайллын үүргийг тодорхойлох. 2.Гүйцэтгэлд суурилсан удирдлага ба тогтвортой үнэ цэнийн бүтээмж: Үйл ажиллагаар бодит үр дүнд чиглүүлж, гүйцэтгэлийг хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтээр үнэлдэг, нийгэм, эдийн засаг, байгаль орчны урт хугацааны үнэ цэнийг эрхэмлэдэг тогтолцоог бүрдүүлэх. 3.Оролцогч талуудын итгэлцэл ба хамтын ажиллагаа: Иргэд, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгуллагуудын оролцоог хангаж, тэдний итгэлд тулгуурласан хамтын ажиллагааны механизмыг бий болгох. Энэхүү бодлогын хүрээг хэрэгжүүлснээр нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын засаглалын чанар сайжирч, төрийн үйлчилгээний үр өгөөж нэмэгдэн, иргэдийн итгэлцэл бэхжиж, Монгол Улсын тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах юм. Засаглалын шинэчлэлийг амжилттай хэрэгжүүлэхийн тулд манлайллыг бэхжүүлэх, гүйцэтгэлийн үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгох, иргэдийн оролцоог хангах бодит механизм бий болгох зэрэг нэн тэргүүний алхмуудыг хэрэгжүүлнэ. Тус баримт бичигт үндэслэн Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын засаглалын шинэчлэлийн бодлогын хүрээ бодлогын баримт бичгийн хэрэгжлийг хангах зорилгоор нийслэлийн засаг даргын тамгын газар болон нийслэлийн нутгийн захиргааны 86 байгуллагуудын стратеги төлөвлөгөөнд тусгав.	100	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдээгүй шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
482	5.1.6.Төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх, олон улсын дэвшилтэт технологи нутагшуулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоно.	Хүнд суртал багасна.	1	Төрийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангана.	2025-2028	-	375.0	-	-	-	-	375.0	Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлсэн чиг үүрэг, тоо	-	-		НЗДТГ-ТЗҮГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар Бодлогын судалгаа, шинжилгээний төвтэй хамтран иргэд болон хуулийн этгээдэд үзүүлэх нийслэлийн төрийн үйлчилгээнд хиймэл оюун ухаанд суурилсан шийдэл нэвтрүүлэх судалгааг хийж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн Ажлын хэсэг байгуулах тухай А/1673 дугаар захирамжаар нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын хүний нөөцийг хиймэл оюун (AI)-аар орлуулах ажлыг тодорхой нэгж, ажлын байранд туршилтаар хэрэгжүүлэхэд байгуллагуудыг нэгдсэн удирдлага, арга зүйгээр ханган ажиллаж, үр дүнг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдааналаар хэлэлцүүлэн, 2025 онд багтаан "Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын хүний нөөцийг хиймэл оюун (AI)-аар орлуулах мастер төлөвлөгөө"-г батлуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус судалгааны хүрээнд захиргааны ажлын давхардлыг бууруулж, AI-аар орлуулах бүюу дэмжих боломжтой үйл явц, чиг үүргийг тодорхойлох; өргөдөл, гомдолд хариу өгөх хугацаат 50 хувиар богиносгох; цахим үйлчилгээний хүртээмжийг нийт иргэдийн 80 хувьд хүргэж, үйлчилгээг цахимаар мөрдөх боломжийг бий болгон ил тод байдлыг нэмэгдүүлэх; одоогийн мэдээллийн системүүдийг нэгтгэж, өгөгдлийн нэгдсэн сан бүрдүүлэх замаар авлигын эрсдэл болон хүний хүчин зүйлээс шалтгаалах алдааг бууруулах, зарим тусгай зөвшөөрлийн процессыг алгоритмаар дэмжүүлэх зэрэг шийдлийг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	83	
483	5.1.7.Төрийн хяналт шалгалтын давхардлыг арилгах, хараат бус, үр дүнтэй хяналтын тогтолцоог бүрдүүлж, хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.	Төрийн хяналт шалгалтын давхардал арилж, эрх зүйн орчин боловсронгуй болж, хяналтын үр дүнтэй тогтолцоо бүрдэнэ.	1	Төрийн хяналт шалгалтын эрх зүйн орчныг хөгжингүй улс орны эрх зүйн орчинтой харьцуулсан судалгааг хийж, хяналт шалгалтын үр нөлөө, тогтолцоог сайжруулах хүрээнд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах, шинэчлэх саналыг боловсруулж, шийдвэрлүүлнэ.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Эрх зүйн шинэчлэлт хийх ажлын явц, хувь	-	30		ХШГ НЗДТГ-ын ХТГЭЗГ: ХАМТРАН	ХШГ: Монгол Улсын төрийн хяналт шалгалтын эрх орчныг Ром-Германы эрх зүйн бүл бүхий дараах хөгжингүй улс орны эрх зүйн орчинтой харьцуулсан судалгаг хийсэн. Үүнд: Бүгд Найрамдах Солонгос Улсын төрийн хяналт шалгалт, барилгын хяналтын тогтолцоо, эрх зүйн орчин-Аудит болон хяналт шалгалтын тухай хууль (Board of Audit and Inspection Act), Барилгын хууль (Building act)Бүгд Найрамдах Словень улсын төрийн хяналт шалгалтын тогтолцоо, эрх зүйн орчин- Хяналт шалгалтын тухай хууль (Inspection act of Slovenia) Дээх судалгаа болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2021 оны "Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ"-нд үндэслэн хяналт шалгалтын үр нөлөөг дээшлүүлэх, байгууллагуудын уялдаа холбоо, улсын байцаагчийн эрх зүйн байдлыг сайжруулах, барилга, дэд бүтцийн салбарын оролцогчдын хариуцлагыг нэмэгдүүлэх, эрх зүйн орчныг боловсронгуй болгох зорилгоор 8 хууль тогтоомжийн 36 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг боловсруулсан. Тус саналыг 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр 01/890 дугаартай албан бичгээр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд, 01/891 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргад тус тус хүргүүлсэн. НЗДТГ-ын ХТГЭЗГ: Төрийн хяналт шалгалтын хуульд 2024 онд өөрчлөлт оруулан батлуулсан. Ингэснээр Хяналт шалгалт нь хуульд заасан үндэслэл, шаардлагын дагуу зохион байгуулагдаж, хараат бус болон шударга зарчмыг баримтлан, эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа нээлттэй, ил тод явагдана.	100	
484	5.1.8.Хяналт шалгалтын цахим системийг нэвтрүүлж, шаардлагатай мэдээллийн хүртээмж, ил тод байдлыг хангана.	Төрийн хяналт шалгалтыг оновчтой, үр ашигтай, ил тод явуулах боломжийг нэмэгдүүлж, үйл ажиллагаг боловсронгуй болгоно.	1	Газар, хот байгуулалт, дэд бүтцийн дундын мэдээллийн санд суурилсан хяналт шалгалтын нэгдсэн систем хөгжүүлж, зайнаас хянах цахим хяналтыг бий болгож, хяналт шалгалтын үйл ажиллагаг иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.	2025-2028	-	-	-	-	-	-	-	Цахим систем нэвтрүүлэх ажлын явц, хувь	-	30		ХШГ	Төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаг цахимжуулах, ил тод байдлыг хангах, үр дүнтэй болгох зорилтын хүрээнд гар утас болон вебд суурилсан "UBInspection – Хяналт шалгалтын аппликейшн" программ хангамжийг хөгжүүлэх ажлыг гүйцэтгэхээр "Промакс" ХХК-тай 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр 24/10 дугаартай гэрээ байгуулав. Үг "UB Inspection" цахим системийг хүлээн авч, Нийслэлийн Хяналт шалгалтын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/93 дугаар тушаалаар албан ёсоор үйл ажиллагаанд нэвтрүүлэв. Мөн тус газраас нийслэлийн нутаг дэвсгэр дээрх барилгажилтын үйл ажиллагааг хянах зорилгоор Google Earth Engine платформыг ашиглан хиймэл дагуулын зураг болон хиймэл оюун ухааны загвар, шийдлүүдийг ашиглан зөвшөөрөлгүй барилгын ажлыг алсаас тандан илрүүлэх, хянах системийн судалгаа, туршилтын ажлыг эхлүүлсэн. Энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "И ТИ Креатив" ХХК-тай 2025 оны 06 дугаар сарын 24-ний өдөр "Ажил гүйцэтгэх гэрээ"-г байгуулж, нийслэлийн хэмжээнд зөвшөөрөлгүй барилгажилт өрнөж буй талбайн координатыг таамаглах, газрын ашиглалт, хөрсний нөхцөл байдлын өөрчлөлтийг ажиглах аргачлалыг боловсруулан туршилтын шатанд бэлтгэл ажлыг хангаж байна.	70	
485	5.1.9.Хяналтын чиг үүргийн байгууллагын харьяанд туршилт шинжилгээний дэвшилтэт технологи бүхий итгэмжлэгдсэн лабораторийг өргөжүүлж, чадамжийг дээшлүүлнэ.	Дэвшилтэт технологи бүхий цогц лабораторийг бий болгож, баталгаажсан үр дүн бүхий төрийн хяналтыг хэрэгжүүлнэ.	1	Барилгын болон автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, эрүүл ахуй, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлын сорилт шинжилгээний нэгдсэн лабораторийг шинээр байгуулж, итгэмжлэлд хамруулна.	2025-2028	-	8,000.0	-	-	-	-	8,000.0	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулж, лаборатори байгуулах ажлын явц, хувь	-	10	800.0	ХШГ	Барилгын болон автозамын материал, хийц, бүтээц, эзлэхүүний шинж чанарыг тодорхойлох, газрын тос, хийн үзүүлэлтийг хэмжих, сорилт шинжилгээний иж бүрэн лабораторийг байгуулах төслийн хүрээнд шаардлагатай дагалдах багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, судалгааны үндэслэл болон урьдчилсан төсвийн тооцоог нэгтгэн боловсруулж, 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 01/84 дугаартай албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. "Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд тусгасан энэхүү арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг 2026 оны төсөвт тусгуулж, санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн Санхүү, хөрөнгө оруулалтын газарт 2025 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 01/1149 дугаартай албан бичгээр хүргүүлсэн бөгөөд улсын төсвийн орлого бүрдэлтээс шалтгаалан зардлын зарцуулалтын эрх нээгдэхгүй байгаатай холбоотойгоор тус зардлыг санхүүжүүлэх боломжгүй гэсэн хариуг тус газраас ирүүлээд байна.	35	

Д/д	ЗДҮАХ-т тусгагдсан зорилт	Хөтөлбөр-ийн үр дүн	№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Эх үүсвэр						Нийт төсөвт өртөг (сая төгрөг)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин 2023	Хүрэх түвшин, үр дүн, төсөв (сая төгрөг)		Хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжилт	Хувь	Биелэгдэж шалтгаан
						Улс	Нийслэл	Дүүрэг	Гадаад зээл	Гадаад тусламж	Төр, хувийн хэвшил				2025 он		Үндсэн			
															Зориптот түвшин	Төсөв (сая төгрөг)				
486	5.1.10.Нийслэлийн харьяа байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог сайжруулах, цахим сургалтын системийг хөгжүүлэх, сургалтын нэгжийн материаллаг баазыг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	Олон улсын сургалтын байгууллагын менежментийн тогтолцооны шаардлагуудад нийцсэн байна.	1	Төрийн албан хаагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн агуулга хөтөлбөр шинэхэн боловсруулах, шинэчилж, чанартай сургалтын үйлчилгээг төрийн албан хаагчдад хүргэнэ.	2024-2028	-	#REF!	-	-	-	-	#REF!	Сургалтын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, хувь	-	25	346.0	НЗДТГ-ТЗУГ-ХНХХ	ХНХХ: Нийслэлийн нутгийн захиргааны 52 байгууллагаас ирүүлсэн сургалтад хамрагдах албан хаагчдын тоон мэдээлэлд үндэслэн "ННЗБ-уудад зориулсан 2025 оны сургалтын төлөвлөгөө"-г боловсруулан хэрэгжүүлсэн. Үүнд: 1396 цагийн сургалтад 6320 албан хаагчийг хамруулахаас 245 удаагийн 805 цагийн сургалтыг зохион байгуулж, нийт 5017 албан хаагчийг хамруулсан. Сургалтын үр нөлөөний үнэлгээг 3 түвшинд үнэлдэг бөгөөд 2025 оны хувьд 95.6 хувь. Өмнөх онтой харьцуулахад 2.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнд: 1.Сэтгэл ханамжийн үнэлгээ: Сургалтын дараах сэтгэл ханамжийн үнэлгээнд 3666 албан хаагч буюу 73 хувь нь хамрагдсан. Сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ нь 94.84 хувь байна. Үүнд: - Сургалтын үр дүн-95 хувь, - Сургагч багшийн ур чадвар -95.2 хувь, - Сургалтын агуулга нь хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэх-94.7 хувь, - Сургалтын зохион байгуулалт-95 хувь, - Сургалтын орчин-94.6 хувь. 2.Мэдлэгийн ахицын хувьд: Мэдлэгийн ахицын үнэлгээг нийт 136 албан хаагч өгсөн. Тус албан хаагчдын сургалтын өмнөх болон дараах мэдлэгийн зөрүүний дундаж 33.4%-иар өссөн үзүүлэлттэй байна. 3.Зан төлөвийн үнэлгээ- сургалтад хамрагдсан албан хаагчид сургалтын үеэр сурсан мэдлэг, ур чадвараа ажилдаа хэрхэн ашиглаж байгааг тогтоох, багийн болон хувийн гүйцэтгэл, албан хаагчдын ямар ур чадвар нэмэгдсэнг тогтоох зорилготой юм. Үнэлгээний дундаж 91.5 хувь. Сургалтын үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээнд нийслэлийн нутгийн захиргааны 14 байгууллагын 109 албан хаагч хамрагдсан. 2025 оны үнэлгээний дундаж 76 хувийг 2024 онтой харьцуулахад 2.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. -Нийслэлийн төрийн албан хаагчдыг идэвхжүүлэх зорилтын хүрээнд нийт 8 арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: Бүтээмж ба шийдэл-2025 мэтгэлцээний тэмцээн, Ахмадын туршлага байгууллагын хөгжилд - хэлэлцүүлэг, Зөвлөн чиглүүлэх менторшип хөтөлбөр, "Бүтээмж ба инновации - UB2025" нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн сайн туршлагыг илрүүлэх, түгээн дэлгэрүүлэх харилцан суралцах арга зүйн форум, -Төрийн албаны үнэ цэнэ видео контентуудыг бүтээн түгээх ажлыг зохион байгуулсан. НЗДТГ-ын албан хаагчид болон тэдний үр хүүхдүүдэд зориулсан "Жаргалтай гэр бүл арга хэмжээ", ННЗБ-уудын Хүний нөөцийн асуудал хариуцсан албан хаагчдад зориулсан HR-2025 сургалт арга хэмжээ зэрэг болно. Нийт 547 албан хаагч хамрагдсан. Үр дүн: Сургалт, арга хэмжээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын давхардсан тоогоор нийт 5564 албан хаагчийн хамруулж, 212,966,400 төгрөгийг зарцуулсан байна.	100	
11.		2.3.2. Сургууль дээрх болон хичээлээс гадуурх сургалтын үйл ажиллагааг дэмжих замаар хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлсэн байна.	2021 - 2025	НБГ		2019 он 35	Хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээнд хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	2021-2025 40	-	-	Сурагчдын авьяасыг нээн илрүүлэх, хөгжүүлэх, багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх зорилгоор 2021 онд нийт сурагчдын 36 хувийг, 2022 онд нийт сурагчдын 37 хувийг, 2023 онд нийт суралцагчдын 44.4 хувийг дугуйлан секц, клуб, хүүхдийн өөрөө удирдлагын байгууллага, клубүүдэд хамруулсан байна. 2024-2025 оны хичээлийн жилд ЕБС (Ерөнхий боловсролын сургууль)-ийн суралцагчдын авьяас чадварыг хөгжүүлэх урлаг, спорт, техник технологи, математик сэтгэхүй, хэл, илтгэх урлаг зэрэг 7 чиглэлийн 5923 төрлийн дугуйлан секц, клубт нийт 187857 суралцагч, 1254 суралцагчдын өөрөө удирдлагын оролцооны байгууллагад 33593 суралцагч, нийт 398437 суралцагчаас 221450 суралцагч хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдсан бөгөөд нийт суралцагчдын 55.5 хувийг эзэлж байна. 2025-2026 оны хичээлийн жилд монгол ёс заншлаас суралцах, өвлүүлэн авч үлдэх зорилгын хүрээнд сурагчдын зан төлөвийн төлөвшил, уламжлалт аж төрөх ёс, үндэсний өв соёл, бахархлаа дээдэлж, түүнээс суралцахаар "Би монгол хүүхэд" ёс заншлын наадмыг нийслэлийн ЕБС-ийн бага ангийн сурагчдын дунд 11 дэх жилдээ, зохион байгуулж нийслэлийн 9 дүүргийн 166 сургуулийн 156928 сурагч, 4120 багш оролцлоо. Дугуйлан секцэд хамрагдалтын тоон мэдээлэл 2026 оны 1 дүгээр сард эцэслэгдэн гарна. 100%	100%
12.		2.3.3. Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн агуулгын хүрээнд цахим хичээлийн иж бүрэн сан бүрдүүлж, зайн сургалтын үйл ажиллагааг дэмжинэ.	2021 - 2025	НБГ		2020 0	Сургалтын хөтөлбөрийн агуулгад нийцсэн цахим хичээл болон үнэлгээний даалгавар	2021-2025 900/13000	-	-	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад 2021-2025 онд нийт цахим даалгаврын тоо өссөн дүнгээр 12177 хүрсэн байна. Тухайлбал: 2021-2022 оны хичээлийн жилд 2122 ээлжит хичээлийн 577 цахим хичээл, 13 судлагдахууны 4213 ширхэг тест, даалгаврын сан үүсгэн, ерөнхий боловсролын сургуулийн мэргэжлийн багш нараар дамжуулан сурагчдад хүргэж анги дэвших болон стандарт хэрэгжилтийн шалгалтыг зохион байгуулсан. 2023 онд 13 судлагдахууны 3170 ширхэг цахим, даалгаврын сан үүсгэж ерөнхий боловсролын сургуулиудад хүргэж явцын болон стандарт хэрэгжилтийн шалгалтууд авч ажилласан. 2024 онд 17 судлагдахуунаар нийт 2100 гаруй анги дэвших төгсөх шалгалтын цахим даалгавар боловсруулан мэргэжлийн багш нарын цахим орчинд байршуулж сурагчдад бие даан суралцах боломжийг бүрдүүлсэн. 2025 онд Монгол хэлний судлагдахуунаар 127 даалгавар, дүрслэх урлаг, дизайн зураг зүй, технологийн судлагдахуунаар 863, математикийн судлагдахуунаар 234 даалгавар, физик, мэдээллийн технологийн судлагдахуунаар 280 даалгавар, хими, биологийн судлагдахуунаар 220 даалгавар, эрүүл мэндийн хичээлийн судлагдахуунаар 40 даалгавар, Амжилтын гараа төсөл арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр 10 судлагдахуунаар 930 даалгавар, нийт 2694 даалгавар боловсруулан, цахим санг баяжуулан, судлагдахуун тус бүрийн цахим хуудсанд байршуулж түгээн ашиглаж байна. Мөн төгсөх ангийн болон анги дэвших шалгалт, олимпиадад бэлтгэх зорилгоор анги тус бүрийн агуулгад нийцсэн 78 үнэлгээний даалгаврыг боловсруулсан.	93.6%
13.	2.4. Боловсролын байгууллагуудыг хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй, жендэрийн мэдрэмжтэй болгон хөгжүүлж, хүн бүрийг аюулгүй, хүртээмжтэй, үр дүнтэй суралцах орчин нөхцөлөөр хангана.	2.4.1. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээг тодорхойлж, сурагчдад зориулсан түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл бүрдүүлсэн байна.	2021 - 2025	НБГ		2019 он 2.06	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургалтын орчин бүрдүүлсэн сургууль, цэцэрлэгийн эзлэх хувь	2021-2025 10	"Нийслэлийн төсөв 800.0"	-	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд сурах орчин, нөхцөлийг хангасан сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга 2021 онд Баянзүрх дүүрэгт 1, Хан-Уул дүүрэгт 2, Сонгинохайрхан дүүрэгт 3, нийт 6-аар, 2022 онд Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргүүдэд тус бүр 1, нийт 4-өөр, 2023 онд нийт 15-аар, 2024 онд 10-аар нэмэгдэн шинээр ашиглалтад орсон. 2025 оны 11 сарын байдлаар 7 сургууль, 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орж сургуулийн суудлын тоог 6140-өөр нэмэгдүүлсэн байна. Эдгээр ашиглалтад орсон сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчныг хангасан зураг, төслийн дагуу баригдсан бөгөөд олон улсын стандартад нийцсэн дотор, гадна талын налуу шат, давхар бүрд тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан довжоотой анги танхим бүхий 14 ердийн сургуулийн орчинг бүрдүүлснээр нийт 59 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчин бүрдээд байна. Энэ нь нийт ерөнхий боловсролын сургуулийн 17.8 хувь, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 33.1 хувийг эзэлж байна. 100%	100%
14.		2.4.2. Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийг эрүүл баталгаат хоол, хүнсээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна.	2021 - 2025	НБГ		1. 2019 он 15.7 2. 2019 он 38	1. Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлдэг сургуулийн эзлэх хувь 2. Мэргэжлийн хоол зүйч, тогоочоор хангагдсан сургуулийн эзлэх хувь	1. 2021-2025 70 2. 2021-2025 100	-		1."Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай" хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Засгийн газрын 2021 оны 18 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан төлөвлөгөөнд нийслэлийн хэмжээнд 2021 онд 21 сургууль, 2022 онд 34 сургууль, 2023 онд 29 сургууль, 2024 онд үлдсэн буюу 45 сургуулийн цайны газрын түрээсийн гэрээг үе шаттай дуусгавар болгож, сургууль бие даан үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгагдсан. 2021 онд 21 сургууль, 2022-2023 оны хичээлд 39 сургууль нэмэгдэж нийт 60 сургууль буюу нийт сургуулийн 38 хувь нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээг бие даан хэрэгжүүлж байсан бол 2023-2024 оны хичээлийн жилд төрийн өмчийн 19 сургууль нийт 79 сургууль буюу 52.4 хувь нь, 2024-2025 оны хичээлийн жилд 105 сургууль буюу нийт сургуулийн 68.2 хувь нь, 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 164 сургуулиас 110 сургууль буюу 67.9 хувь нь "Үдийн хоол" хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлж байна. 96% 2.2021 онд бие даан үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж байсан 21 сургуульд мэргэжлийн хоол зүйчгүй байсан ба нийт сургуулийн 30% нь тогоочоор хангагдсан. 2022 онд бие даасан үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж нийт сургуулийн 15 хувь нь буюу 60 сургууль 9 хоол зүйч, 100 хувь нь буюу 170 тогоочоор хангагдсан. 2023 онд бие даан үдийн хоол хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа нийт сургуулийн 66 хувь нь буюу 79 сургууль 52 хоол зүйч, 100 хувь нь буюу 194 тогоочоор хангагдсан. 2024-2025 оны хичээлийн жилд төрийн болон төрийн бус өмчийн сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээнд 99 хувь мэргэжлийн хоол зүйч, тогоочоор хангагдсан ба 66 хоол зүйч, 350 мэргэжлийн тогооч, бэлтгэгч 112, туслах ажилтан нийт 627 хүн ажилласан. 98%	97%

15.		2.4.3. Мэргэжлийн байгууллагатай хамтран суралцагчдыг зам тээврийн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлнэ.	2021 - 2025	НБГ, ТЦА-ны ЗЦГ		1. 2019 он 182 2. 2019 он 0.2	1.Хүүхэд тээврийн автобус 2.Нийт зам тээврийн осолд сургууль орчмын ослын эзлэх хувь	1. 2021-2025 257 2. 2021-2025 0	-	-	1.Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулиудад “Сургуулийн автобус” төслийн хүрээнд нийт 75 автобус нийлүүлэхээр төлөвлөж 2021 онд 5 автобус, 2022 онд 20 автобус, 2023 онд 50 автобус нэмэгдэж, 2024 онд 69 автобус үйлчилгээнд гарсан. Сургуулийн автобусны үйлчилгээнд 2024-2025 оны хичээлийн жилд нийт 296 автобус, 2025-2026 оны хичээлийн жилд ЕБС-ийн 83 сургуулийн 67 чиглэлд 67 сургуулийн хүүхдийн автобусаар давхардсан тоогоор 13400 хүүхэд зорчиж байна. Нэгдсэн дүнгээр "Сургуулийн автобус" төслийн 67, сургуулийн өөрийн өмчийн 59, түрээсийн 233, нийт 359 автобусаар суралцагчдад үйлчилгээ үзүүлж байна. 100% 2.2021 онд 12 сургууль нэмэгдэж 109 сургууль, 2022 онд 14 сургууль нэмэгдэж 123 сургууль, 2023 онд 22 сургууль нэмэгдэж нийт 145 сургуульд сургууль орчмын аюулгүйн бүс байгуулж, сургууль орчмын ослын эзлэх хувь 0.1-д хүрсэн. 2024 онд нийслэлийн замын сангийн хөрөнгөөр “Сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажил”-ын хүрээнд 17 сургууль, 5 цэцэрлэгт авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл суурилуулж сургууль орчмын аюулгүй бүс байгуулсан сургуулийн тоо 167 болсон. 2024 онд нийт хүүхэд өртөж хохирсон осол нийслэлийн хэмжээнд хүүхэд өртсөн нь 842 бүртгэгдсэнээс 11 хүүхэд амь хохирч, 916 хүүхэд гэмтсэн тохиолдол бүртгэгдсэн. Үүнээс сургууль орчмын бүсэд нийт 61 тохиолдол бүртгэгдсэн байна. Энэ нь 2024 онд бүртгэгдсэн 21053 зам тээврийн ослын 61 нэгж буюу буюу 0.2% нь сургууль орчмын бүсэд сургуулийн насны хүүхэд осолд өртсөн байна. 2025 онд Нийслэлийн хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн осол 608 бүртгэгдэж 16 хүүхэд нас барсан нь өнгөрсөн онтой харьцуулахад бүртгэгдсэн осол 27,8 хувь, нас барсан тохиолдол 45,5 хувь өссөн үзүүлэлттэй байна.	100%
16.	2.5. Халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, эмчлэх замаар халдварт бус өвчнөөс үүдэлтэй нас баралтын хувийг бууруулна.	2.5.1. Халдварт бус өвчний эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээ сайжирсан байна.	2021 - 2025	НЭМГ		1.2019 он 15.5 2.2019 он 2.7 3.2019 он 77 4.2019 он 66.8	1. Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин 2.Амьсгалын замын өвчний шалтгаант нас баралтын түвшин 3.Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн хамралтын хувь 4.Чихрийн шижин өвчний үеийн эрт илрүүлгийн хамралтын хувь	1.2021-2025 14 2.2021-2025 2.1 3.2021-2025 80 4.2021-2025 72.0	-		Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/12 дугаар тушаалын дагуу Зонхилон тохиолдох үндсэн 4 халдварт бус өвчний илрүүлэгт иргэдийг хамруулах ажлын зохион байгуулж байна. 2025 оны 11 дүгээр сарын 30-ний байдлаар илрүүлгийн үзлэгт давхардсан тоогоор 1,682,009 иргэн хамрагдахаас 1,281,246 иргэн хамрагдаж, эрт илрүүлгийн хамрагдалт 76,2%-тай байна. Тодруулбал: 1.Зүрх судасны өвчний шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүнд ногдох) 13.1-тай байна. 100% 2.Амьсгалын замын өвчний шалтгаант нас баралтын түвшин (10,000 хүнд ногдох) 2.5-тай байна. Амьсгалын замын өвчний шалтгаант нас баралт сүүлийн жилүүдэд ихсэж байгаа нь агаарын бохирдол, хүн амын дундах тамхидалт зэрэг хүчин зүйлс нөлөөж байна. 66.7% 3.Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгийн үзлэгт 1,027,326 иргэн хамрагдахаас 68.9 хувь нь буюу 725890 иргэн хамрагдаж, 3015 онош батлагдсан тохиолдлыг шинээр хяналтад авч, эмийн эмчилгээг хийж гүйцэтгэсэн байна. 86% 4.”Чихрийн шижин хэв шинж 2”-ын эрт илрүүлгийн үзлэгт 654,683 иргэн хамрагдахаас 80.9 хувь нь 555356 иргэн хамрагдаж, чихрийн шижин оношлогдсон 1016 иргэн хяналтад авсан. 100%	88.2%
17.		2.5.2. Дүүрэг бүрд эрэгтэйчүүдийн кабинет байгуулагдсан байна.	2021 - 2025	НЭМГ		2019 он 0	Байгуулагдсан кабинетийн тоо	2021-2025 8	-		Нийслэлийн хэмжээнд нийт 10 эрэгтэйчүүдийн кабинет ажиллаж байна. Үүнд: Долоон дүүргийн Эрүүл мэндийн төв, 3 нэгдсэн эмнэлэг (БНДЭМТ, БГДЭМТ, БЗДЭМТ, ХУДЭМТ, НДЭМТ, ЧДЭМТ, СБДЭМТ, ХУНЭ, СБНЭ, СХНЭ-2025 онд) эрэгтэйчүүдийн болон урологийн кабинетыг байгуулж, тусламж үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна. Дээрх байгуллагууд эрүүл мэндийн сайдын 2022 оны А/449 тушаалын 3 дугаар хавсралтад заасан кабинетад шаардлагатай тоног төхөөрөмж, эм эмнэлгийн хэрэгслээр хангагдсан.	100%
18.		2.5.3. Эрүүл мэндийг дэмжих төвийг 8 дүүрэгт байгуулсан байна.	2021 - 2025	НЭМГ		2019 он 0	Байгуулагдсан дэмжих төв	2021-2025 8	-		Нийслэлийн хэмжээнд нийт 7 (ХУДЭМТ, БЗДЭМТ, ЧДЭМТ, СХДЭМТ, СХНЭ, ХУНЭ, Амгалан амаржих газар) байгууллагад эрүүл мэндийг дэмжих төвийг шинээр байгуулан ажиллаж байна. Эдгээр төвөөр дамжуулан иргэдийн эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчний урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, оношилгоог зохион байгуулан ажиллаж байна.	87.5%
19.	2.6. Халдварт өвчнөөс сэргийлэх, илрүүлэх, хянах, тандах, эмчлэх үйл ажиллагааг сайжруулан, өвчлөлийг бууруулна.	2.6.1. БЗДХ/ДОХ, сүрьеэ, халдварт гепатит болон бусад халдварт өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, эмчилгээнд бүрэн хамруулсан байна.	2021 - 2025	НЭМГ		1.2019он 55.4 2.2019он 14.7 3.2019он 8	1. БЗДХ өвчний тохиолдол 2.Сүрьеэ өвчний тохиолдол 3.В гепатитын тохиолдол	1. 2021-2025 50.0 2. 2021-2025 12.4 3. 2021-2025 6	-		Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-ын тохиолдол 30.6, сүрьеэ өвчний тохиолдол 6.2, В гепатитын тохиолдол 0.22 байна. Тайлант хугацаанд халдварт өвчний 32,191 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 194 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 15,919 тохиолдол буюу 49.4 хувиар нэмэгдсэн байна. 1.БЗДХ-ын 5,074 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 15.76%-ийг эзэлж байна. Үүнээс, 27.3% нь заг хүйтэн, 46% нь тэмбүү, 26% нь трихомониаз, 0.67% нь хүний дархлал хомсдолын вирус (ХДХВ/ДОХ) байна. Төрөлхийн тэмбүүгийн тохиолдол 2025 онд 12 бүртгэгдсэн байна. БЗДХ өвчний эмчилгээнд нийт 4,811 хүн хамруулж, эмчилгээний амжилт 94.8%-тай байна. 100% 2.Нийслэлийн хэмжээнд нийт 79,946 үзлэг хийснээс урьдчилан сэргийлэх үзлэг 47,968 буюу 60.2%-тай байна. Сүрьеэгийн 1,022 шинэ тохиолдол бүртгэгдсэн ба 10,000 хүн амд 6.2 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 56 тохиолдлоор (0.5 промиль) буурсан байна. Нийт тохиолдлын 99%-ийг эмчилгээнд хамруулж, эмчилгээний амжилт 79.9%-тай байна. 100% 3.Тайлант хугацаанд Вируст гепатит өвчний 130 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 0.78 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 20 тохиолдол буюу 0.1%-иар нэмэгдсэн. Вируст гепатитын тохиолдлын 28.4%-ийг эзэлж буй “Вируст гепатит В”-ийн 37 тохиолдол (0.22 промиль) бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 тохиолдлоор нэмэгдсэн байна. 100%	100%
20.		2.6.2. Товлолт дархлаажуулалтын хувийг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдол буурсан байна.	2021 - 2025	НЭМГ		1.2019 он 99.6 2.2019 он 98 3.2019 он 94.8	1.Вирусны гепатит В өвчний товлолт дархлаажуулалтын хамралтын хувь 2.Тавт/Халдварт саа өвчний товлолт дархлаажуулалтын хамралтын хувь 3.Улаанбурхан-Гахайн хавдар-Улаануудаа өвчний товлолт дархлаажуулалтын хамралтын хувь	1.2021-2025 99.8 2.2021-2025 99 3.2021-2025 96.0	-	-	2025 оны жилийн эцсийн байдлаар товлолт вакцины 17 тунгийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 394,849 хүүхэд хамрагдахаас 384,794 хүүхэд хамрагдаж хамралтын дундаж 97,5% байна. Тухайлбал үүнд 1.Вирусийн гепатит В (1 тун) өвчний товлолт дархлаажуулалт 99.3 хувь, 2.Саа өвчний товлолт дархлаажуулалт (4 тун) 95,0 хувьтай байна. 97% 3.Монгол улсад Улаанбурхан өвчин бүртгэгдсэнтэй холбогдуулан нэмэлт дархлаажуулалтыг ажлыг зохион байгуулж, 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 121,706 хүн Улаанбурхан өвчний дархлаажуулалтад хамруулахаас 114,912 хүн хамруулж, хамралт 94.4%-тай байна. Нийслэлийн хэмжээнд 11 дүгээр сарын байдлаар Улаанбурхан өвчний 11,098 тохиолдол бүртгэгдэж, батлагдсан тохиолдлын ойрын хавьтал болох 73,768 хавьтлаас 49,012 хүнийг голомтын дархлаажуулалтад хамруулахаас 47,649 хүн хамруулж, хамралт 96%-тай байна. 100%	98%

21.	2.7. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тогтолцоог бий болгоно.	2.7.1. Дүүрэг бүрд “Нийгмийн эрүүл мэндийн төв”-ийг байгуулсан байна.	2021 - 2025	НЭМГ		2019 он 0	Нийгмийн эрүүл мэндийн төв	2021-2025 8	-	-	Нийслэлийн хэмжээнд 3 нийгмийн эрүүл мэндийн төвийг байгуулсан байна. Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төвийн барилгыг барьж ашиглалтад оруулсан. ЭМЯ-аас Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тушаал, бүтцийн болон ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байгаа тул дүүргийн эрүүл мэндийн төвийг нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлэг болгон өөрчлөх үйл явц хүлээлтийн байдалтай байна. Налайх болон Хан-Уул дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах барилгын боломж хомс, Сүхбаатар, Баянгол дүүрэгт зохицуулалт хийх боломжтой.	37.5%
22.	2.8. Эх, хүүхдийн эндэгдлийг бууруулна.	2.8.1. Эх, хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, эндэгдлийг бууруулна.	2021 - 2025	НЭМГ		1.2019 он 24.3 2.2019 он 89.1 3.2019 он 12.9 4.2019 он 14.9 5.2019 он 95	1.Эхийн эндэгдэл /амьд төрөлт/ 2.Жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүдийн эзлэх хувь 3.Нялхсын эндэгдэл /1 хүртэлх нас/ 4.Хүүхдийн эндэгдэл /5 хүртэлх нас/ 5.Тухайн жилийн товлолт дархлаажуулалтад хамрагдсан хүүхдийн эзлэх хувь	1.2021-2025 22.0 2.2021-2025 91 3.2021-2025 11.5 4.2021-2025 12.9 5.2021-2025 98	-	-	1.2025 оны эхний 10 сарын байдлаар эхийн эндэгдлийн 10 тохиолдол бүртгэгдэж 100,000 амьд төрөлтөд 40.4 байна. 0% 2.Жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүд буюу жирэмсний эрт хяналт 92.8 хувьтай байна. 100% 3.0-1 насны нялхсын эндэгдэл 1,000 хүн амд 14.5 байна. 0% 4.Тав хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 17.2 байна. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар нь авч үзэхэд 83.9% нь перинаталь үеийн эмгэг, 27,8% нь төрөлхийн гажиг хөгжил, 10,2% нь амьсгалын тогтолцооны өвчний улмаас эндсэн байна. 0% 5.2025 оны эхний 10 сарын байдлаар товлолт вакцины 17 тунгийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 394,849 хүүхэд хамрагдахаас 384,794 хүүхэд хамрагдаж хамралтын дундаж 97,5% байна. Үүнд: 1.БЦЖ (1 тун) – 99.5% 2.Гепатит В (1 тун) – 99.3% 3.Саа (4 тун) – 95,0% 4.Тавт (3 тун) – 95.5% 5.УГУ (2 тун) – 97,3% 6.Гепатит А (2 тун) – 95.3% 7.Пневмококк (3 тун) – 95.5% 8.Сахуу-татран (2 тун) – 73,3% байна. 99%	39.5%
23.	2.9. Гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн бүрд хүргэнэ.	2.9.1. Өсвөр насны хүүхдийн урьдчилан сэргийлэх үзлэгийг сайжруулж, эрүүлжүүлнэ.	2021 - 2025	НЭМГ		1.2019 он 26,340 2.2019 он 26.9	1. Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдсан хүүхэд 2. Өсвөр насны охидын төрөлт	1.2021-2025 35,200 2.2021-2025 25	-	-	1.2025 оны 11 сарын байдлаар нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн кабинетаар болон урьдчилан сэргийлэх үзлэгээр нийт 42,416 хүүхдийг үзлэг хамруулсан байна. Үзлэгийн дүнд 16,028 хүүхдэд эмчилгээ шаардлагатай байгаагаас 14,695 хүүхдийг эмчилгээнд хамруулж, 91.6%-ийг эрүүлжүүлээд байна. 100% 2.Өсвөр насны охидын төрөлт 1,000 өсвөр насны охидод 6.3 промиль байна. 100%	100%
24.		2.9.2. Нөхөн үржихүйн насны зорилтот бүлгийн эмэгтэйчүүдийн жирэмснээс сэргийлэх арга хэрэглээг нэмэгдүүлэх, гэр бүлийн боловсрол олгох ажлыг эрчимжүүлнэ.	2021 - 2025	НЭМГ		2019 он 58.3	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргаар хангагдсан нөхөн үржихүйн насны (15-49) эмэгтэйчүүдийн эзлэх хувь	2021-2025 67.9	-		Нийт нөхөн үржихүйн насны 422,442 эмэгтэйчүүдээс 62,268 зорилтот бүлгийн эмэгтэйчүүд байна. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар жирэмснээс сэргийлэх арга хэрэгслээр 41,987 зорилтот бүлгийн эмэгтэй хангагдаж, хамрагдалт 67.4 хувь байна. 1.Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай” А/770 дүгээр захирамжийн дагуу жирэмслэхээс сэргийлэх таниулах хөтөч дэвтрийг боловсруулан 28,000 ширхгийг гарган 9 дүүргийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан гэр бүл төлөвлөлт, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийг хэрэглэхийн ач холбогдол, хүсэгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх тухай мэдээлэл, сургалтыг үйл ажиллагаанд ашиглаж байна. 2.2025 оны 11 дүгээр сарын байдлаар оюутны бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх, хүсэгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор 14 их, дээд сургуулийн 14,080 оюутанд нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, мэдлэг хандлагыг дээшлүүлэх сургалтыг зохион байгуулсан. Мөн Налайх, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Тамгын газруудтай хамтарч, 12 удаагийн сургалтад хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан гээд нийт 1,369 албан хаагчдыг хамруулсан.	99.2%
25.	2.10. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.	2.10.1. Шаардлагатай хүний болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц, бэлэн байдал хангагдсан байна.	2021 - 2025	НЭМГ, НЗДТГ		1. 2019 он 1 2. 2019 он 1	1. Нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн эрүүл мэндийн байгууллага 2. Нийслэлийн эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага, сургуулилт	1. 2021-2025 20 2. 2021-2025 5	-	-	1.2025 онд Нийслэлийн Эрүүд мэндийн газар (НЭМГ)-ын харьяа 27 эрүүл мэндийн байгууллагад нийт 25.3 тэрбум төгрөгөөр нэн шаардлагатай тоног төхөөрөмж, эмнэлгийн зориулалттай автомашинаар хангаж сайжруулсан. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлэх зорилгоор 27 байгууллагын Улаанбурхан өвчний эсрэг вакцин, А аминдэм, вирусийн эсрэг эм, халдваргүйтгэлийн бодисын нөөцийн бэлэн байдалд үнэлгээ хийсэн. НЭМГ-ын даргын 2025 оны “Шуурхай удирдлагын баг томилох тухай” А/43, “Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллах тухай” А/154 дүгээр тушаалыг хэрэгжүүлэн төлөвлөлт, тандалт, хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж, үйлчилгээ, санхүү, нөөц хангалт, эрсдэлийн харилцаа зэрэг чиглэлээр шуурхай удирдлагын баг, нэгжүүд ажиллаж, эм эмнэлгийн нөөцийн мэдээг 7-14 хоног тутам авч ажиллаж байна. 2.Нийслэлийн эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага сургуулилт, сургалтыг 5 удаа хийсэн.Тухайлбал шувууны томуугийн халдварын үеийн бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааны чадавхыг сайжруулах зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 21-22-ны өдрүүдэд нийт 8 байгууллагын 45 мэргэжилтэнг хамруулсан үзүүлэх сургалт зохион байгуулсан. “Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, гамшгийн үеийн хариу арга хэмжээ” сэдэвт 2025 оны 05 дугаар сарын 8-9-ний өдрүүдэд зохион байгуулагдсан улсын дадлага сургуулилтад харьяа 9 дүүргийн ЭМТ, түргэн тусламжийн төвийн 27 мэргэжлийн албан хаагчдын бүрэлдэхүүнтэйгээр оролцсон. Газар хөдлөлтийн дуут дохио, бэлэн байдлын хангах нийслэлийн эрүүл мэндийн албаны мэргэжлийн ангиудын бие бүрэлдэхүүний дадлага, сургуулилтын сургалтыг 2 удаа, Улаанбурхан өвчний бэлэн байдал хариу арга хэмжээний сургалтыг 1 удаа зохион байгуулсан.	100%

26.	2.11. Хотын хүн амыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, тэр дундаа нэн шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай хүргэж, аюулгүй, үр дүнтэй, нэн хэрэгцээтэй эм, вакцинаар ханган, эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулна.	2.11.1. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НЭМГ		1. 2019 он 0 2. 2019 он 0 3. 2019 он 5 4. 2019 он 1 5. 2019 он 1 6. 2019 он 2 7. 2019 он 0.9	1.Нийслэлд эмнэлэгийн тусламж үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн сүлжээг байгуулах 2.Хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалд шилжсэн дүүргийн эмнэлэг 3.Шинээр нэмэгдсэн тусламж, үйлчилгээний нэр төрөл 4.Наркологийн эмнэлэг 5.Жишиг нэгдсэн эмнэлэг 6.Тосгоны эрүүл мэндийн төв 7.Нэг эмчид ногдох сувилагч	1. 2021-2025 3 2. 2021-2025 8 3. 2021-2025 12 4. 2021-2025 1 5. 2021-2025 4 6. 2021-2025 3 7. 2021-2025 1.4	-	-	1.Нийслэлд эмнэлгийн тусламж үйлчилгээний нэгдсэн зохицуулалттай бүсчилсэн 2 сүлжээг байгуулсан. 100% 2.Нийслэлийн 4 нэгдсэн эмнэлэг Төлөөлөн Удирдах зөвлөлтэй, 2 дүүргийн эмнэлэг хамтын удирдлагатай, хагас бие даасан засаглалд шилжсэн бөгөөд нийт 6 эмнэлэг байна. Эрүүл мэндийн яамнаас Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тушаал, бүтэц болон түүний ажиллах журам, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй хүлээгдэж байна. 75% 3.2021-2025 онд нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудад шинээр нийт 16 тусламж үйлчилгээ нэмэгдсэн. Үүнээс 2025 онд 5 нэр төрлийн тусламж, үйлчилгээг шинээр нэвтрүүлж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна. 100% 4.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Аддиктологийн төвийн хуучин барилгыг нурааж, шинээр барих ажлыг 2022-2025 онд нийт төсвт өртөг нь 39.8 тэрбум төгрөгийг төсөвлөсөн. Тендерт “Бүрэн Одод” ХХК шалгарч 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулж, хуучин барилгын ажлыг нураах ажил хийгдэж эхэлсэн. Аддиктологийн төвийн барилга угсралтын ажлын явц 90 хувийн гүйцэтгэлтэй ба барилгыг 2026 оны 2 дугаар сард ашиглалтад бүрэн хүлээлгэж өгнө. 100% 5.Хан-Уул дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн барилга барилга угсралтын явц 40 хувийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна. Чингэлтэй дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга барихаар төлөвлөсөн талбайн газар чөлөөлөлтийн ажил үргэлжилж байна. 85% 6.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гачуурт тосгоны Эрүүл мэндийн барилгын ажлын гүйцэтгэгчээр “Пи Эм” ХХК шалгарч барилгын ажил бүрэн дуусаж, 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр улсын комисс хүлээн авч, ашиглалтад орсон. 100% 7.Монгол Улсад эмч, сувилагчийн харьцааг 1:2 хүргэх зорилт тавьж, сувилагч бэлтгэх сургалтын төлбөрийг чөлөөлсөн ч Улаанбаатар хотод 2025 оны 10 сарын байдлаар эмч сувилагчийн харьцаа 1:0.9 байна. Үүнд нөлөөлж байгаа гол хүчин зүйл нь сувилагч мэргэжилтний цалин бага, ажлын ачаалал их, мэргэжлийн үнэ цэнэ бага байгаатай холбогдуулан мэргэжил сонголт бага байна. 0%	85.0%
27.		2.11.2. Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төвийн тоог нэмэгдүүлж, үйлчилгээний хүртээмж, хүчин чадлыг сайжруулна.	2021 - 2025	НЭМГ		2019 он 11	Стандартын шаардлага хангасан байртай өрхийн эрүүл мэндийн төв	2021-2025 31	-	-	Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2020-2025 онд 12 бие даасан,13 цогцолбор, нийт 25 Өрхийн эрүүл мэндийн төв (ӨЭМТ)-ийн барилга ашиглалтад орсон байна. 2025 онд Сонгинохайрхан дүүргийн 42-р хорооны ӨЭМТ-ийн цогцолбор барилгыг ашиглалтад оруулсан. Улсын төсвийн хөрөнгөөр Багануур дүүргийн 4-р хорооны 1 ӨЭМТ, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Сонгинохайрхан дүүргийн 6, 8, 33, 34, 35, 36, 37, 40-р хороо, Чингэлтэй дүүргийн 4-р хороо, Сүхбаатар дүүргийн 16-р хороо, Баянзүрх дүүргийн 35-р хороо, Баянгол дүүргийн 18-р хороо нийт 13 цогцолбор барилга шинээр баригдаж байна. Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк (АХБ)-ны хоорондбайгуулсан гэрээний дагуу хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн 1-р үе шатанд 4 дүүрэгт жишиг ӨЭМТ барих ажлын барилгын ажлын явц 70% байна. Үүнд Чингэлтэй дүүргийн 19-р хорооны барилгын ажлын гүйцэтгэл 80%, Сонгинохайрхан дүүргийн 26-р хорооны барилгын ажлын гүйцэтгэл 90%, Баянзүрх дүүргийн 17-р хорооны барилгын ажил 30% байна.	100%
28.	2.12. Гэр бүлийн боловсрол, хөгжил, төлөвлөлтийг хийж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангана.	2.12.1. Гэр бүлийн боловсрол, хөгжлийг дэмжих замаар эцэг эхийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангасан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1. 2019 он 7.4 2. 2019 он 1 3. 2019 он 2,782	1. Гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагаанд хамрагдсан иргэдийн эзлэх хувь 2. Гэр бүлийн боловсролын төв 3. Төвөөр үйлчлүүлсэн хүн	1.2021-2025 57.4 2.2021-2025 9 3.2021-2025 19,474	-	-	1.2021-2025 онд Гэр бүлийн боловсрол олгох үйл ажиллагаанд нийт 946,676 иргэнийг буюу нийт иргэдийн 27 хувийг хамруулж, Гэр бүлд зөвлөгөө өгөх 8 төвөөр дамжуулан 113,193 иргэнд сэтгэл зүйн, хууль эрх зүйн зөвлөгөө өгч, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээх, гэр бүлийн хөгжлийг дэмжих сургалт нөлөөллийн үйлчилгээнд хамруулсан. 100% 2.2021 онд “Гэр бүлийн зөвлөгөө өгөх төвийн үйлчилгээ, орчинд тавигдах нийтлэг шаардлага MNS 6417:2013” стандартын дагуу Сонгинохайрхан, Баянзүрх дүүрэгт Гэр бүлд зөвлөгөө өгөх өрөөг тохижуулж, ашиглалтад оруулсан. 2022 онд Сонгинохайрхан дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст “Насанд хүрээгүй гэрч, хохирогчоос мэдүүлэг авах өрөө”-1, Гэр бүлд зөвлөгөө өгөх өрөө-1-ийг тус тус шинээр байгуулсан. Чингэлтэй дүүргийн Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст Гэр бүлд зөвлөгөө өгөх төвийг Азийн хөгжлийн сангийн санхүүжилтээр шинээр байгуулсан. 2023 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүүжилтээр Баянгол дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэст “Гэр бүлд боловсрол зөвлөгөө өгөх төв”-ийг байгуулсан. Багануур дүүрэгт 2024 онд гэр бүлд зөвлөгөө өгөх төв шинээр байгуулагдсан. Нийслэлийн хэмжээнд гэр бүлд зөвлөгөө өгөх 8 төв үйл ажиллагаа явуулж байна. 88% 3.Нийслэлийн хэмжээнд 2021-2024 онд нийт 85,289 иргэнд үйлчилгээ үзүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар 8 Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдээр дамжуулан 1,731 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээх, гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилгоор сургалт нөлөөллийн 322 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 54,829 хүнийг хамруулж, цахимаар 270,251 хүнд хүрсэн байна. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан хүний тоо 15 хувиар, цахим орчинд хүрсэн хүний тоо 116 хувиар өссөн байна. 100%	96.0%
29.	2.13. Эмэгтэйчүүд, охидыг ялгаварлан гадуурхах болон хууль бус наймаа, бэлгийн мөлжлөг зэрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг устгана.	2.13.1. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх олон талт хамтын ажиллагааг өргөжүүлж, гэр бүлийн хүчирхийллийг бууруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1. 2019 он 437 2. 2019 он 2	1. Бүртгэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид 2. Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх нэг цэгийн төв	1. 2021-2025 222 2. 2021-2025 9		-	1.Гэр бүлийн хүчирхийллийн хор уршгийг танин мэдэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн архины хор хөнөөлийг таниулах сургалтад 3,194 иргэн, 616 өрх хамрагдсан. Архины хамаарал бүхий өрхөд чиглэсэн Архи, хорт зуршлаас үүссэн гэр бүлийн хүчирхийллийг бууруулахад чиглэсэн “Урам” төсөл дүүрэг бүрд зохион байгуулагдаж 2,250 өрхийг хамруулсан. 2021 онд гэр бүлийн хүчирхийллийн 619 хохирогч, 2022 онд 711 хохирогч, 2023 онд 571 хохирогч, 2024 онд 798 хохирогч бүртгэгдсэн байгаа бол 2025 онд 678 гэмт хэрэг үйлдэгдсэн байна. 0% 2.2025 онд Нийслэлийн хэмжээнд 10 түр хамгаалах байр, 6 нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байгаагаас 6 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дэргэд Түр хамгаалах байр, 2 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсийн дэргэд Нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна. 2025 онд тус хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа 16 байгууллагаар хүчирхийлэлд өртөж, эрх нь зөрчигдсөн нийт 1,011 насанд хүрэгчдэд 521 өдрийн, 858 хоногийн үйлчилгээ, 2,189 хүүхдэд 336 өдрийн, 37,328 хоногийн үйлчилгээг үзүүлсэн байна. 100%	50%

30.	2.14. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн бүх хэлбэрийг зогсооно.	2.14.1. Хүүхдийн эрхийг хангахад эцэг, эх, олон нийтийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1. 2019 он 921 2. 2019 он 51.3	1.Хүүхдийн эрхийн бүртгэгдсэн зөрчил 2.Хэргийн тохиолдлын шийдвэрлэлт	1. 2021-2025 421 2. 2021-2025 100 хувь	-		1.Нийслэлийн хэмжээнд хүүхдийн эрхийн зөрчил, гомдол 2021 онд 498, 2022 онд 297, 2023 онд 181, 2024 онд 67 бүртгэгдсэн байна. 2025 онд 9 дүүргийн Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд хохирогч хүүхэд 130 бүртгэгдсэн байна. Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооноос боловсролын үйлчилгээ, Хууль зүйн туслалцаа, Сэтгэл зүйн зөвлөгөө, Эрүүл мэнд, Нийгмийн халамжийн үйлчилгээ, Иргэний бүртгэлийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.100%	100%
31.		2.14.2. Хүүхэд ажиллуулахыг хориглосон ажлын байранд хүүхэд ажиллуулахыг таслан зогсооно.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		2019 он 120	Хориглосон ажлын байран дахь хөдөлмөр эрхлэгч хүүхэд	2021-2025 0	-		2021 онд хориглосон ажлын байранд хүүхэд ажиллуулахыг таслан зогсоох зорилгоор нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 370 аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт, шалгалт тогтмол зохион байгуулж, хөдөлмөр эрхэлж байсан 172 хүүхдийг тогтоон, хориглосон ажлын байранд ажиллаж байсан 9 хүүхдийг илрүүлэн байгууллагад хариуцлага тооцсон. 2022 онд нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 348 аж ахуй нэгж, байгууллага, гудамж, талбайд хяналт шалгалт явуулж, хөдөлмөр эрхлэгч 59 хүүхдийг илрүүлэн бүртгэлд оруулж эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгсөн. 2023 онд “Хүүхэд хамгаалал 2023” арга хэмжээг улирал тутам зохион байгуулж хориглосон ажлын байранд хөдөлмөр эрхэлж байсан 69 хүүхдийг илрүүлэн эцэг эх, асран хамгаалагчдад нь хүлээлгэн өгч, Аж ахуйн нэгж байгууллагад 26.8 сая төгрөгийн торгууль ногдуулсан. 2024 онд хориглосон ажлын байранд хөдөлмөр эрхлэгч 50 хүүхдийг хүүхдийг олж тогтоож, хамгааллын үйлчилгээнд хамруулсан. 2025 онд “Хүүхэд хамгаалал 2025” нэгдсэн арга хэмжээний хүрээнд нийслэлийн 9 дүүргийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс харьяа дүүргийн Цагдаагийн хэлтэстэй хамтран нийт 204 албан хаагч хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан. Хүүхэд хамгаалал нэгдсэн арга хэмжээний хүрээнд эрсдэлт нөхцөлд байгаа 220 хүүхдэд эргэн хяналт хийж, 417 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, хөдөлмөр эрхлэгч 9 хүүхэд, хараа хяналтгүй 10 хүүхдийг илрүүлж, хорооны хамтарсан багтай хамтарч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажилласан. 2020 онд хөдөлмөр эрхлэгч 191 хүүхэд байсан бол 2025 онд 59 хүүхэд байна.	56%
32.		2.14.3. Эцэг, эхийн хараа хяналт сул, эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг эрт илрүүлэх, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний хяналтыг сайжруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1.2019 он 11.3 2.2019 он 70	1. Хараа хяналтгүй хүүхэд 2. Хараа хяналтгүй хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулан шийдвэрлэсэн хувь	1. 2021-2025 5 2. 2021-2025 100	-		1.2021 онд хараа хяналтгүй, хараа хяналт сул, гудамжны нөхцөлд амьдарч байгаа 182 хүүхэд илрүүлснээс хараа хяналтгүй 3 хүүхдэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. 2022 онд "Хүүхэд хамгаалал 2022” 4 удаагийн арга хэмжээний хүрээнд хараа хяналт сул 63, хараа хяналтгүй 2 хүүхдийг илрүүлэн асрамж, халамжийн төвд шилжүүлсэн. 2023 онд "Хүүхэд хамгаалал 2023” арга хэмжээний хүрээнд хараа хяналт сул 59, хөдөлмөр эрхлэгч 69, нийт 128 хүүхдийг олж илрүүлснээс хараа хяналтгүй 7 хүүхдийг Нэг цэгийн үйлчилгээний төвд байрлуулж хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. 2024 онд “Хүүхэд хамгаалал 2024” арга хэмжээний хүрээнд хараа хяналт сул 292 хүүхэд олж илрүүлэн, эргэн хяналт хийснээс хараа хяналтгүй хүүхэд илрээгүй. 2025 онд “Хүүхэд хамгаалал 2025” нэгдсэн арга хэмжээний хүрээнд эрсдэлт нөхцөлд байгаа 220 хүүхдэд эргэн хяналт хийж, 417 аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, хөдөлмөр эрхлэгч 9 хүүхэд, хараа хяналтгүй 10 хүүхдийг илрүүлж, хорооны хамтарсан багтай хамтарч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажилласан. 2.2021-2025 онд хараа хяналтгүй хүүхдийг хүүхэд хамгааллын үйлчилгээнд хамруулан 100 хувь шийдвэрлэсэн байна. Тухайлбал 2021 онд хараа хяналт сул 28 хүүхдэд хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэн ар гэрт нь эргэн нэгтгэж, хараа хяналтгүй 3 хүүхдийг асрамж халамжийн төвд шилжүүлсэн. 2022 онд хараа хяналт сул 122 хүүхдээс 107 хүүхэд эцэг эх, асран хамгаалагчид нь хүлээлгэн өгч, 13 хүүхдэд түр хамгаалах үйлчилгээ үзүүлэн ар гэрт нь эргэн нэгтгэж, 2 хүүхдийг асрамж халамжийн төвд шилжүүлсэн. 2023 онд хараа хяналтгүй 7 хүүхдийг түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэн ар гэрт нь нэгтгэж, эргэн хяналт хийж ажилласан. 2024 онд хараа хяналт сул 72, хөдөлмөр эрхлэгч 50, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн нийт 292 хүүхдээс 164 хүүхдэд эргэн хяналт тавьж, 122 хүүхдийг эцэг эхэд нь хүлээлгэн өгч, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хамгаалал шаардлагатай 6 хүүхдэд түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн. 2025 онд хараа хяналтгүй 10 хүүхдийг илрүүлж, хорооны хамтарсан багтай хамтарч хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж ажилласан. 100%	100%
33.		2.14.4. Урьдчилан сэргийлэх замаар хүүхдийн эсрэг хүчирхийллийг бууруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ, НЦУГ		2019 он 123	Хүчирхийлэлд өртсөн хүүхэд	2021-2025 43	20	20	Нийслэлийн хэмжээнд бие махбод, үл хайхрах, сэтгэл санаа, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон хүүхэд 2021 онд 130, 2022 онд 184, 2023 онд 185, 2024 онд 180 байна. 2025 онд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хамтдаа сэргийлье” арга хэмжээг зохион байгуулсан. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийг шийдвэрлэх, зөрчлийн давтамжийг тодорхойлох, хариуцлага хүлээлгэх чиглэлээр зөрчил үйлдсэн этгээдийг регистрийн дугаараар бүртгэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна. “Хүүхэд хамгаалал-2025” нэгдсэн арга хэмжээг улирал бүр зохион байгуулж эрсдэлт нөхцөлд байгаа нийт 1030 хүүхдийг бүртгэл судалгаанд авч, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. Энэ оны эхний 10 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн улмаас 56 хүүхэд хохирсон байна. 2019 онд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 123 байсан бол 2025 онд 56 болж буурсан байна.	85.00%
34.		2.14.5. Улаанбаатар хотын хүүхдэд ээлтэй байдлын индексийг тогтоож, индексийн үзүүлэлтийг сайжруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		2020 он 0	Хүүхдэд ээлтэй байдлын индекс	2021-2025 5	-		Нийслэлийн хүүхдэд ээлтэй байдлын үзүүлэлтийг 4 бүлгийн 23 үзүүлэлтээр боловсруулсан. Нийслэлийн хүүхдэд ээлтэй байдлын ерөнхий индекс 6.40 байгаа бөгөөд өмнөх оноос 0.02, 2020 оноос 0.17 нэгжээр тус тус буурсан дүнтэй байна. Хүүхдийн боловсрол, хүүхдийн аюулгүй байдал бүлгийн индекс өнгөрсөн оны дүнгээс өссөн бол хүүхдийн эрүүл мэнд, хүүхэд хамгаалал бүлгийн индекс буурсан нь ерөнхий индексийн дүн буурахад гол нөлөөлсөн. 2024 оны байдлаар Хүүхдэд ээлтэй байдлын үзүүлэлт 6.40% байна. *(Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 196 дугаар тогтоолоор Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын чиг үүргийг төрийн захиргааны болон харьяа дүүрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор нийслэлд эдгээр чиг үүргийн дагуу төлөвлөсөн ажлууд хийгдэх боломжгүй байна.)*	100%

35.	2.15. Хотын хүн амыг зохистой ажлын байраар ханган бүрэн хөдөлмөр эрхлэлтэд хамруулж, адил үнэлэмжтэй ажилд адил цалин хөлс олгох, хөдөлмөр, боловсрол, сургалтад хамрагдах залуучуудын хувийг нэмэгдүүлнэ.	2.15.1. Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчдыг дэмжин, иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НСГ, НХХГ		1.2019 он 25.9 2.2018 он 53.4 3.2018 он 7.6 4.2018 он 5,000	1.Ядуурлын түвшин 2.Ажиллах хүчний оролцооны түвшин 3.Ажилгүйдлийн түвшин 4. Шинэ ажлын байр	1.2021-2025 18.4 2.2021-2025 57.2 3.2021-2025 5.0 4.2021-2025 25,000	-	-	1.Ядуурлын түвшинг 2 жил тутамд “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа”-ны үр дүнд үндэслэн Үндэсний Статистикийн хорооноос тооцдог. Дээрх судалгааг 2022 оноос хойш тооцоогүй бөгөөд 2022 оны байдлаар ядуурлын түвшин 21.6 хувь байна. 57.3% 2.2024 оны байдлаар нийслэлийн хэмжээнд хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.0 хувь, ажилгүйдлийн түвшин 5,6 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 58,3 хувь байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал ажилгүйдлийн түвшин 1,4 пунктээр, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 5,1 пунктээр, ажиллах хүчний оролцооны түвшин 6,2 пунктээр тус тус нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 100% 3.Ажилгүйдлийн түвшин 2024 оны байдлаар 5.8 хувь байна. 100% 4.Шинээр ажлын байр бий болгосон ажил олгогчийг дэмжих зорилгоор 2021, 2022, 2023, 2024 онд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөр, арга хэмжээг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж, нийт 18,841 иргэн, 63 баг, 162 аж ахуйн нэгж байгууллагад 533,239,047,659 төгрөгийн санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлж ажиллалаа. Үүний үр дүнд нийт 23,092 ажлын байр шинээр бий болсон. 2025 оны байдлаар нийслэлийн хэмжээнд 6024 ажлын байр шинээр бий болсон үзүүлэлттэй байна. 100%	89.3%
36.		2.15.2. "Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв"-ийг олон улсын жишигт нийцүүлж, бүсчилсэн байдлаар хөгжүүлж, хөдөлмөр эрхлэлтийн цогц үйлчилгээг хүргэсэн байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1.2019 он 1 2.2019 он 15,000 3.2019 он 7,000 4.2019 он 48.8	1.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв 2.Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төвөөр үйлчлүүлэх иргэд 3.Ажилд зуучлуулан орсон иргэд 4.Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	1.2021-2025 3 2.2021-2025 75,000 3.2021-2025 52,000 4.2021-2025 60	-	-	1.Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төслийн хүрээнд "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв"-ийг нийслэлийн 9 дүүрэгт шинээр байгуулсан. 100% 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв болон Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний загвар төв нь 2021 онд 694 ажил олгогчоос 7,439 ажлын байрны захиалгыг авч, 22,655 иргэнд, 2022 онд 308 ажил олгогчоос 5,674 ажлын байрны захиалгыг авч, 22,199 иргэнд, 2023 онд 3,755 ажил олгогч байгууллагаас 17,246 ажлын байрны захиалгыг авч, 19,952 иргэнд хөдөлмөр, эрхлэлтийн үйлчилгээг хүргэсэн. 2024 онд 5,268 ажил олгогч байгууллагаас 16,665 ажлын байрны захиалга авч 50,715 иргэнд, тайлант хугацаанд нийт 10,025 ажил олгогчоос 47,024 ажлын байрны захиалгыг авч, 115,521 иргэнд хөдөлмөр, эрхлэлтийн үйлчилгээг хүргэсэн. 100% 3. 2021 онд 8,934 иргэн, 2022 онд 8,013 иргэн, 2023 онд 13,644 иргэн, 2024 онд 9,829 иргэн, тайлант хугацаанд нийт 40,420 иргэнийг ажилд зуучлан оруулсан. 90% 4. 2024 оны байдлаар хөдөлмөр эрхлэлтийн түвшин 55.0 хувь, ажиллах хүчний оролцооны түвшин 58.3 хувь байна. 55%	86.3%
37.		2.15.3. Хөдөлмөр эрхлэлтийн сургалт, мэргэжлийн болон давтан сургалтыг бүрэн дунд, түүнээс доош боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлагагүй залуу ажиллах хүчинд чиглүүлэн зохион байгуулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		2019 он 40	Сургалтад хамрагдсан иргэдэд эзлэх хувь	2021-2025 70	-	-	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”-ийн хүрээнд богино хугацаанд мэргэжлийн ур чадвар эзэмшүүлэх зорилготой мэргэжлийн сургалтыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүллээ. Сургалтад хамрагдах хүсэлтэй иргэдийн судалгааг эдийн засгийн 5 салбар, 59 мэргэжлийн хүрээнд гаргаж, сургалтын хэрэгцээнд үндэслэн мэргэжлийн сургалтын байгууллагуудтай хамтран мэргэжлийн сургалтыг зохион байгуулав. Сургалтад 2021 онд 11 мэргэжлээр 352 иргэн, 2022 онд 18 мэргэжлээр 978 иргэн, нийт 1330 иргэн хамрагдсанаас 60 хувийг бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлага багатай иргэд эзэлж байна. 2023 онд хөдөлмөр эрхлэлтийн танхимын сургалтад суралцахаар 1469 иргэн хүсэлт ирүүлсэн бөгөөд мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлт ирүүлсэн иргэдийг зорилтот бүлгээр авч үзвэл 78% нь 6 сараас дээш хугацаагаар ажил олж чадахгүй байгаа, 12% нь хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг, 9% нь хөгжлийн бэрхшээлтэй болон хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ асарч буй иргэд байна. 2023 онд 30 сургалтын байгууллагад 1151 иргэнийг 14 мэргэжлийн чиглэлээр сургалтад хамруулсан. Нийт иргэдийн 74% буюу 1123 иргэн бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой залуучууд эзэлж байна. 2024 онд 1,080 иргэнийг сургалтад хамруулснаас 60 хувийг бүрэн дунд болон түүнээс доош боловсролтой, мэргэжилгүй, ажлын туршлага багатай иргэд эзэлж байна. 2025 оны байдлаар Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаанд нийслэлийн хэмжээнд нийт 5915 иргэн хамрагдсан.	100%

38.	2.16. Угийн бичиг хөтлөлтийг дэлгэрүүлэн таниулна.	2.16.1. Нийслэлийн айл өрхүүдийн угийн бичиг хөтлөлтийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НСУГ, НЗДТГ-НБГ		2020 он 10	Угийн бичиг хөтөлдөг өрхийн эзлэх хувь	2021-2025 50	-	-	Нийслэлийн хэмжээнд жил бүр угийн бичиг хөтлөх арга зүйн сургалт, угийн бичиг хөтлөхийн ач холбогдлыг таниулах чиглэлээр нөлөөллийн арга хэмжээг соёл, урлагийн байгуллагууд зохион байгуулж байна. Тухайлбал 2025 онд Баянзүрх, Чингэлтэй дүүргийн Соёлын ордон "Угийн бичиг хөтлөх арга зүй" сэдэвт сургалтыг 11 удаа зохион байгуулж, 1310 иргэнийг хамруулсан. Мөн сургалтад хамрагдсан иргэдэд угийн бичиг хөтлөх гарын авлага тараасан байна. Нийслэлийн хэмжээнд 2021-2025 онд нийт өрхийн 27 хувь нь угийн бичиг хөтөлж байгаа бөгөөд 2020 оноос 17 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100%
ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА												
Зорилго 3. Нийгмийн хамгааллын үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлж, албан бус салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж, нийгмийн даатгалын тогтолцооны шинэчлэлтийг хэрэгжүүлэн ажиллана.												**98.1**
39.	3.1. Өрхийн амьжиргааны түвшинг тогтоох шинэчилсэн аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлж, үр дүнд тулгуурлан нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлнэ.	3.1.1. Зорилтот өрхийг оновчтой тодорхойлж, халамжийн үйлчилгээнд хамруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1.2019 он 73,027 2.2019 он 250	1.Халамжийн үйлчилгээнд хамрагдах өрхийн тоо 2.Нийгмийн хамгааллын үйлчилгээнд хамруулсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд	1.2021-2025 56,505 2.2021-2025 100,000	-	-	1.Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгаанд хамрагдсан өрхийн мэдээллийн нэгдсэн санд бүртгэлтэй нийслэлийн хэмжээнд 306,452 өрх байгаагаас 2021 онд 13,446 өрх, 2022 онд 9,969 өрх, 2023 онд 20,135 өрх, нийт 43,550 өрхийг халамжийн үйлчилгээнд хамруулсан. 2024 онд Нийслэлийн хэмжээнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээний босго шугам болох 292,5 болон түүнээс доош оноотой хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ болон Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмжид нийт 45,551 өрхийг хамруулсан. 100% 2.Нийгмийн халамжийн үйлчилгээ болон нөлөөллийн 49 удаагийн арга хэмжээнд нийслэлийн хэмжээнд 2021 онд хөгжлийн бэрхшээлтэй 55,191, 2022 онд хөгжлийн бэрхшээлтэй 67,690, 2023 онд хөгжлийн бэрхшээлтэй 67,313 иргэн тус тус хамрагдсан бөгөөд үзэсгэлэн худалдаанд 117 иргэн оролцож, 27,7 сая төгрөгийн борлуулалт хийсэн. 2021-2023 онуудад нийт хөгжлийн бэрхшээлтэй 190,194 иргэн (хүүхэд, насанд хүрэгч) нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдаж, мэдээ мэдээллээр хангагдсан. Тайлант хугацаанд нөлөөллийн олон талт 58 удаагийн арга хэмжээнд нийт 221,471 хөгжлийн бэрхшээлтэй иргэн (хүүхэд, насанд хүрэгч) үйлчилгээнд хамрагдаж, мэдээ мэдээллээр хангагдсан. 100%	100%
40.	3.2. Нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан, орлогын эх үүсвэртэй болох нөхцөлийг бүрдүүлнэ.	3.2.1. Нийгмийн харилцаанаас тусгаарлагдаж болзошгүй иргэдийг амьдралын зөв дадал хэвшилд сургаж, нийгмийн суурь үйлчилгээнд хамруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		2019 он 150	Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдээс нийгмийн суурь үйлчилгээнд хамруулсан иргэд	2021-2025 300	-	-	Гэр оронгүй иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн амьдрах итгэлийг нэмэгдүүлэх, нийгэмшүүлэх, бичиг баримтжуулах, түр хоноглох байранд байршуулах үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэж буй Төрийн бус 7 байгууллагад давхардсан тоогоор нийт 3,073 иргэн түр хоноглож, 1,488,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2024 онд давхардсан тоогоор гэр оронгүй нийт 4,744 иргэнийг нийгмийн суурь үйлчилгээнд хамруулсан.	100%
41.	3.3. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжин цагийн ажлын тогтолцоог бий болгоно.	3.3.1. Оюутан, залуучуудын цагийн ажил хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1.2019 он 462 2.2019 он 6,799	1. Ажлын байр бий болгосон аж ахуйн нэгж 2. Цагийн ажилд хамрагдсан оюутан, залуучууд	1.2021-2025 2500 2.2021-2025 35000	-	-	1.Оюутан, залуучуудыг цагаар ажил, хөдөлмөр эрхэлж, орлого олох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цагийн ажилд зуучлах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд зохион байгуулан хэрэгжүүлэв. Цагийн ажилд зуучлах арга хэмжээний хүрээнд 2021 онд 634 ажил олгогч байгуллагаас 7,977, 2022 онд 382 ажил олгогч байгуллагаас 7,384, 2023 онд 539 ажил олгогч байгуллагаас 6,530, 2024 онд 706 ажил олгогч байгуллагаас 3,273, тайлант хугацаанд нийт 2,261 ажил олгогч байгуллагаас 25,164 цагийн ажлын байрны захиалга төвлөрүүлж, мэдээллийн сан үүсгэсэн. 100% 2.Оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах арга хэмжээг нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлж, 2021 онд 8,893, 2022 онд 7,013, 2023 онд 7,629, 2024 онд 2,549, тайлант хугацаанд нийт 26,084 оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучилсан байна. 92.5%	100%
42.		3.3.2. Залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжинэ.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1. 2019 он 1,336 2. 2019 он 78	1.Бизнес эрхлэлтийн сургалтад хамрагдсан залуучууд 2.Гарааны бизнес эрхлэлтийн дэмжлэг авсан залуучууд	1. 2021-2025 7,500 2. 2021-2025 400	-		1.Тайлант хугацаанд нийслэлийн хэмжээнд нийт 10,258 залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулан, гарааны бизнес эрхлэлтийг дэмжин ажилласан. Үүний хүрээнд: Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс батлсан "Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр" болон "Оролцоо" төслийн хүрээнд 2021-2022 онд 2,254 залуучуудыг бизнес эрхлэх сургалт, арга хэмжээнд хамруулсан. 2023 онд "Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа"-ны хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтад 1,332, залуучуудын сургалт зөвлөгөөнд 170, "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны хүрээнд гарааны бизнесийн санаог хөгжүүлэх сургалтад 54 багийн 317, "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа"-ны хүрээнд зээлийн өмнөх ба дараах сургалтад 701, нийт 4,774 залуучуудыг бизнес эрхлэлтийн сургалтад хамруулсан. 2024 онд "Хөдөлмөрт бэлтгэх сургалтын үйл ажиллагаа"-ны хүрээнд аж ахуй эрхлэлтийн сургалтад 3,069, залуучуудын сургалт зөвлөгөөнд 170, "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны хүрээнд гарааны бизнесийн санаог хөгжүүлэх сургалтад 53 багийн 161, нийт 3,230 залуучуудын гарааны бизнес эрхлэлтийг дэмжин ажиллалаа. 100% 2."Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох арга хэмжээ"-г нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, шинэ технологи, инновац бүхий гарааны бизнесийн төслөөр 2021-2024 онд шалгарсан 63 баг (157 залуу) тус бүрд 10 сая төгрөг буюу 630,000,000 төгрөгийн эргэн төлөх нөхцөлгүй санхүүгийн дэмжлэг олгосон. Мөн 2022 онд "Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр"-ийн хүрээнд шаардлага хангасан 79 багийн төсөлд 395,000,000 төгрөг, 2023 онд "Санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа"-ны хүрээнд 133 залуучуудад 1,330,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг тус тус олгосон байна. Дээрх хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2021-2024 онд нийт 142 багийн 369 залуучуудад 2,355,000,000 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгов. 100%	100%
43.		3.3.3. Залуучуудын хөгжлийн төвөөр дамжуулан хувь хүний хөгжлийг дэмжиж, амьдрах ухааны чадвар эзэмшүүлнэ.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		1. 2019 он 2 2. 2019 он 20	1. Залуучуудын хөгжлийн төв 2. Залуучуудын хөгжлийн төвийн арга хэмжээнд хамрагдсан залуучуудын эзлэх хувь	1. 2021-2025 10 2. 2021-2025 45			1.2020 онд залуучуудын хөгжлийн төв 2 байсан бол 2023 онд нийт 8 дүүрэгт Залуучуудын хөгжлийн төв үйл ажиллагаа явуулсан. Чиг үүргийн хувьд Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан байгуллага нь 2023 оны 11 дүгээр сараас хойш тусгаарлагдаж, 2024 оны 7-р сараас хойш Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд харьяалагдаж байна. 100% 2.Нийслэлийн 9 дүүргийн залуучуудын хөгжлийн төвөөр жилийн эцсийн байдлаар залуучуудын хөгжлийг дэмжих чиглэлээр 125, оролцоог дэмжих чиглэлээр 73, зорилтот бүлгийн залуучуудыг нийгэмшүүлэх чиглэлээр 65 нийт 263 удаагийн олон талт арга хэмжээ зохион байгуулсан. Нийт 350,396 мянган залуучуудыг хамруулж, олон нийтийн цахим сүлжээгээр 848,295 залуучуудад хүрч ажилласан. Залуучуудын хөгжлийн төвийн зохион байгуулсан арга хэмжээнд 2020-2022 онд залуучуудын 23%-ийг хамруулж байсан бол 2023 онд залуучуудын 19,5%-ийг цахимаар 48%-ийг хамруулсан. Чиг үүргийн хувьд Залуучуудын хөгжлийн асуудал хариуцсан байгуллага нь 2023 оны 11 дүгээр сараас хойш тусгаарлагдаж, 2024 оны 7-р сараас хойш Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яаманд харьяалагдаж байна. 100%	100%

44.	3.4. Бүтээмжтэй үйл ажиллагаа, зохистой ажлын байр, инновацыг дэмжин санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх замаар аж ахуй, бичил, жижиг, дунд бизнесүүдийг албан хэвшилд шилжүүлж, өсөлтийг дэмжинэ.	3.4.1. Бичил бизнес эрхлэгчдийг жижиг бизнес эрхлэгч болгох суурь нөхцөл бүрдсэн байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		2019 он 0	Бичил бизнесээс жижиг бизнес эрхлэгч рүү шилжсэн иргэд	2021-2025 500	-		Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөтөлбөр, арга хэмжээний хүрээнд 2023 онд борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 357 иргэнийг хамруулсан. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас олгодог жижиг зээлийн хүрээнд 10,093,180,000 төгрөгийн зээлийг нийт 881 иргэн, 106 аж ахуйн нэгж байгууллагад, финтекээр олгодог богино хугацааны эргэлтийн хөрөнгийн дэмжлэгт 4,112 иргэн, нийт 5,350 бичил бизнес эрхлэгчдийг жижиг бизнес эрхлэгч болоход дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Мөн цар тахлын болон түүний дараах үед холбогдох байгуллагаудтай хамтран "ДЭМ ДЭМЭНДЭЭ" явуулын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, бичил бизнес эрхлэгч хөгжлийн бэрхшээлтэй 15 иргэнийг хамруулснаар 1,304,000 төгрөгийн борлуулалт хийсэн бол “Ажлын байрыг дэмжих хөнгөлөлттэй зээлд хамрагдах тухай”, “Өрхийн тариалан, мини хүлэмж байгуулах тухай" нийт 13 удаагийн сургалтад бичил бизнес эрхлэгч 527 иргэнийг хамруулж, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих тухай хууль болон холбогдох бусад мэдээ, мэдээллийг хүргэсэн. 100%	100%
45.		3.4.2. Албан бус эдийн засгийн салбарт ажиллагсдыг албан салбарт шилжүүлж зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн байна.	2021 - 2025	НЗДТГ-НБГ		2019 он 110,000	Албан бус хөдөлмөр эрхэлж буй иргэн	2021-2025 25,000	-		2021-2024 онд албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хөдөлмөр эрхлэлтийн албан салбарт шилжүүлж, зохистой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор хөдөлмөр эрхлэлтийн албан салбарт шилжихийн ач холбогдол, татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын тухай хууль, зэрэг сэдэвт сургалт, нөлөөллийн арга хэмжээг цахим болон танхимаар нийт 245 удаа зохион байгуулж, 28,256 иргэнд мэдээлэл, зөвлөгөө өгч, 2021 онд 10,121 иргэн, 2022 онд 8,491 иргэн, 2023 онд 12,171 иргэн, 2024 онд 9,829 иргэн, тайлант хугацаанд нийт 40,612 иргэнийг ажилд зуучлан оруулж, албан салбарт шилжүүлэн ажилласан байна. Үүний зэрэгцээ ажлын цагийг уян хатан зохицуулах замаар бүтээмжийг нэмэгдүүлэх боломж, ажил олгогчдын сайн туршлагын талаарх судалгаа, мэдээлэл бүхий постер бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэд, олон нийтэд хүргэсэн.	100%
47.		3.4.3. Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж, ажлын байраа хадгалсан, шинэ ажлын байр бий болгосон бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгч, ажил олгогчдыг дэмжин, үйл ажиллагааг өргөжүүлэн ажилласан байна.	2021 - 2025	НЖДҮДТ НӨҮГ		2019 он 204	Хамтран ажилласан аж ахуйн нэгж	425	77,009,992,000	-	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1184 дүгээр захирамжаар "Цар тахлын нөлөөнд өртсөн нийслэл хотын жижиг, дунд үйлдвэрлэл (ЖДҮ) эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг, нэмэгдүүлэх богино хугацааны төлөвлөгөө"-г батлуулсан. Тус төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд сургалт зөвлөх үйлчилгээнд 150 орчим ЖДҮҮ эрхлэгч хамрагдсан. 2022-2023 онд нийт 48 аж ахуйн нэгжид 3.985.310.000 төгрөгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсэн байна. Нийслэлийн Засаг даргын 2024 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн А/1104 дугаар захирамжаар “Улаанбаатар хотын жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г батлуулан хэрэгжүүлж, гурван удаагийн бүртгэлээр 90 гаруй үйлдвэр эрхлэгчийг сургалт, зөвлөх үйлчилгээнд хамруулж, 57 үйлдвэр эрхлэгч амжилттай төгсөж сертификат гардан авсан. Төлөвлөгөөний хүрээнд арилжааны банкнуудад хүсэлт хүргүүлж, манай хүсэлтийг хүлээн авч хамтран ажиллах санал ирүүлсэн Худалдаа хөгжлийн банктай хамтран 57 үйлдвэрлэгчээс 8 үйлдвэр эрхлэгчид 1,150 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.	85%
48.		3.4.4. Бичил, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийг гадаад, дотоодын зах зээлд гаргахад дэмжлэг үзүүлэн, борлуулалтын зах зээлийг өргөтгөх, нэмэгдүүлэхэд хамтран ажилласан байна.	2021 - 2025	НЖДҮДТ НӨҮГ			Хамтран ажилласан аж ахуйн нэгж	2021-2024 50	-	-	Бичил, жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдийг гадаад, дотоодын зах зээлд бараа бүтээгдэхүүнээ танилцуулахад дэмжлэг үзүүлэн, борлуулалтын зах зээлийг өргөтгөх, нэмэгдүүлэх зорилгоор жил бүр гадаадын 2 4 үзэсгэлэн арга хэмжээ, дотоодын 10 гаруй үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Нийт 11 үзэсгэлэн арга хэмжээ зохион байгуулж 3000 гаруй иргэдийг хамруулан давхардсан тоогоор 1.8 сая иргэдэд Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бүтээгдэхүүнийг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж 55,2 тэрбум төгрөгийн борлуулалт хийсэн байна. 2025 онд нийт 3 гадаадын үзэсгэлэн арга хэмжээ төлөвлөж, 40 гаруй Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн 2500 гаруй нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг сурталчлан таниулж, давхардсан тоогоор гурван үзэсгэлэн арга хэмжээг 20 мянга гаруй хүн үзэж сонирхсон байна.	100%
49.	3.5. Биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг сайжруулж, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	3.5.1. Нийслэлийн хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний чанар сайжирсан байна.	2021 - 2025	НБТСГ		1.2019 он 0 2.2019 он 11 3.2019 он 53	1.Биеийн тамирын арга зүйч 2.Магадлан итгэмжлэгдсэн спорт клуб 3.Иргэдийн бие бялдрын хөгжлийн суурь үзүүлэлт	1. 2021-2025 27 2. 2021-2025 34 3. 2021-2025 60	-	#VALUE!	1.2024 оны “Биеийн тамир, спортын тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад хороодод орон тооны арга зүйч ажиллуулах тухай заалт туссан. Үүнтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд биеийн тамир, спортын чанар хүртээмжийг сайжруулах, арга зүйч нарыг ажиллуулах арга хэмжээг тусгаж хууль эрх зүйн таатай орчныг бүрдүүлсэн байна. 80% 2.Нийслэлийн хэмжээнд стандарт шаардлага хангасан орчинд магадлан итгэмжлэгдсэн сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн багш дасгалжуулагч ажиллаж иргэдэд чанартай үйлчилгээ үзүүлэх чиглэлээр магадлан итгэмжлэгдсэн нийт 13 спорт клуб үйл ажиллагаагаа явуулж байна. 2024 оноос Биеийн тамир, спортын тухай хууль шинэчлэн батлагдсантай холбогдуулан Биеийн тамир, спортын улсын хорооноос Спорт клубийн магадлан итгэмжлэх журмыг шинэчилж байгаа тул магадлан итгэмжлэх спорт клубийн материалыг хүлээн авахгүй байгаа тул гадаад хүчин зүйлээс шалтгаалан үр дүн зорилтод түвшинд хүрээгүй болно. 3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны "Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай" 53 дугаар зарлигийн дагуу "Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил"-ыг жил бүр авч байна. Тус сорилгод 2022 онд нийслэлийн хэмжээнд 87,356 иргэн хамрагдсан бөгөөд нийт хамрагдсан иргэдийн 60 хувь нь А, В, С үнэлгээ авсан. 2023 онд 175,500 иргэн хамрагдсанаас 82 хувь нь А, В, С үнэлгээ авсан бол 2024 онд 193,000 иргэн хамрагдаж 80 хувь нь А, В, С үнэлгээ авсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 606 байгууллагын 85.122 иргэн хамрагдаж, сорилд хамрагдсан иргэдийн 77 хувь нь А, В, С үнэлгээ авсан бөгөөд 2019 оны суурь үзүүлэлтээс 24 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 100%	90%

50.		3.5.2. Дүүрэг, хороод болон шинэ дагуул хот, шинэ дэд төвүүдэд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан байна.	2021 - 2025	НСХ		1.2020 он 94 2.2020 он 60	1. Төрөлжсөн спортын талбай 2. Спортын барилга байгууламжийн хүртээмж	1.2021-2025он 110 2.2021-2025он 65	-	-	1.2021 онд нийслэлийн хэмжээнд биеийн тамир, спортын барилга байгууламжийг норм, стандартын дагуу барьж байгуулсан эсэх суурь судалгааг хийж төрөлжсөн спортын талбайг цаашид нэмэгдүүлэх чиглэлээр ажиллан 2022 онд 4-өөр нэмэгдэж 105, 2023 онд 36 талбай нэмэгдэж 141, 2024 онд 62-оор нэмэгдэж 203 болсон. 2025 онд Сонгинохайрхан дүүргийн 3-р хороонд хөл бөмбөгийн хиймэл зүлэг бүхий спортын иж бүрэн талбай шинээр байгуулагдсан бол бусад дүүргүүдэд 58 байршилд спортын зориулалтын талбайг хувийн аж ахуй нэгж байгууллагуудаас шинэчлэн тохижуулж нийт 234 талбай болсон байна. 100% 2.Нийслэлийн хэмжээнд 2021 онд 5 спортын заалтай барилга, 2022 онд 4 спортын заалтай барилга, 2023 онд 7 спортын заалтай барилга, 2024 онд 8 спортын заалтай барилга, нийт 19 спортын заалтай барилга ашиглалтад орсон бөгөөд 1000 хүнд оногдох спортын барилга байгууламжийн хүртээмж 2021 онд 61м2, 2022 онд 62м2, 2023 онд 63,5м2, 2024 онд 65м2-д хүрсэн үр дүнтэй байна. 2025 онд улсын төсвөөр Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хороонд усан спортын төвийн бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусан. Баянзүрх дүүргийн спорт цогцолборын бүтээн байгуулалтын ажил 85 хувьтай, Нийслэлийн Спорт цогцолборын бүтээн байгуулалтын ажил 40 хувьтай, Багахангай дүүргийн спорт цогцолборын бүтээн байгуулалтын ажил 95 хувьтай, Сонгинохайрхан дүүргийн 20-р хорооны өвлийн ордны бүтээн байгуулалтын ажил 50 хувьтай, Хан-Уул дүүргийн оюуны спортын ордны бүтээн байгуулалтын ажил 90 хувьтай баригдаж байгаа бол Сүхбаатар дүүргийн төсвөөр баригдаж байгаа спорт цогцолборын бүтээн байгуулалтын хэрэгжилт 80 хувьтай, Баянхошуу дэд төвийн спорт цогцолборын бүтээн байгуулалтын ажил 85 хувьтай үргэлжилж байна. 100%	100%
51.		3.5.3.Нийслэлийн иргэдийн дунд биеийн тамир, спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулснаар оролцоог нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НСХ		2020он 725,196	Нийт хүн амд биеийн тамир, спортын арга хэмжээнд хамрагдсан иргэн	2021-2025 900,000	-		Нийслэлийн хэмжээнд нийт хүн амд биеийн тамир, спортын арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулж 2021 онд 340 арга хэмжээг цахим болон практик хэлбэрээр зохион байгуулж 2876 байгууллагын 635,486 иргэнийг хамруулсан бол 2022 онд 340 арга хэмжээнд 1,170,073 иргэд, 2023 онд 368 арга хэмжээнд 9930 байгууллагын 873,313 иргэд, 2024 онд 345 арга хэмжээ зохион байгуулж 6413 байгууллагын 888,500 иргэдийг хамруулсан. 2025 онд нийслэл, дүүргүүдийн хэмжээнд 270 арга хэмжээ зохион байгуулж 6600 байгууллагын 1,151,456 иргэдийг хамруулсан. Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас 13 (ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, нийслэлийн өвлийн спортын наадмын нээлт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, цэцэрлэгийн хүүхдүүдийн уран хөдөлгөөнт гимнастикийн тэмцээн, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, “Дугуйтай Улаанбаатар-2025” арга хэмжээ, “Улаанбаатар марафон-2025”, “Алхацгаая гүйцгээе” хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ, Сагсан бөмбөгийн дасгалжуулагч доктор Брюс Хоскинсын сургалт, Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр, Хүрээ цам даншиг наадам, Нийслэлийн Ерөнхий боловсролын сургуулийн багш нарт зориулсан сургалт, Авто машингүй өдөр гэх мэт) арга хэмжээ зохион байгуулж 303 байгууллагын 487,144 иргэдийг хамруулсан. Мөн Нийслэлийн 9 дүүргийн Биеийн тамир, спортын хороодоос 237 удаагийн биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулж, 6171 байгууллагын 447,500 иргэдийг хамруулсан. Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр нийслэл дүүргийн хэмжээнд 20 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ, 22 байршилд мөсөн гулгуурын талбай, цанын баазыг байгуулж, биеийн тамир, спортын үйлчилгээг нийт 126 байгууллагын 447,500 иргэдэд хүргэж ажилласан	100%
52.		3.5.4. Нийслэлд спортын төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэдэг болсон байна.	2021 - 2025	НСХ		1. 2019 он 152,096 2. 2019 он 22	1. Тэмцээнд оролцсон тамирчид 2. Өсөөрийн шигшээ багуудын спортын төрөл	1. 2021-2025 152,500 2. 2021-2025 25	-		1.Спортын тэмцээн уралдааныг үндэсний спорт, орчин үеийн спортын төрөл болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрлөөр өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийн насны ангиллаар 2021 онд нийт 23 удаа зохион байгуулж 518 байгууллагын 34505 тамирчдыг, 2022 онд 19 удаа зохион байгуулж 804 байгууллагын 133102 тамирчдыг, 2023 онд 38 төрлөөр зохион байгуулж 673 байгууллагын 153317 тамирчдыг, 2024 онд 29 төрлөөр зохион байгуулж 601 байгууллагын 166634 тамирчдыг оролцуулсан. 2025 онд нийслэл, дүүргийн хэмжээнд 255 тэмцээн уралдаан зохион байгуулж 13,853 байгууллагын 219,961 тамирчдыг оролцуулсан. Үүнээс Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 24 төрлөөр зохион байгуулж, 9171 байгууллагын 175,325 тамирчид оролцсон. Спортын тэмцээнд 2019 онд 152096 хүүхэд, багачууд, тамирчид хамрагдаж байсан бол 2025 онд 175,325 тамирчид оролцож хүрэх түвшинд бүрэн хүрсэн. 100% 2.Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангаж өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэхэд дэмжлэг үзүүлж ажилласны үр дүнд дүүргүүдийн Засаг дарга нарын дэргэдэх өсвөр үеийн шигшээ багийг 2021 онд спортын 24 төрлөөр 82 дасгалжуулагч, 1814 тамирчинтай, 2022 онд спортын 3 төрөл (крикет, хоккей, усан спорт)-өөр нэмэгдүүлж 25 төрлөөр 65 багт 101 дасгалжуулагч, 2856 тамирчинтай, 2023 онд 28 төрлөөр 105 дасгалжуулагч 2944 тамирчинтай, 2024 онд спортын 28 төрөлд 109 багт 109 дасгалжуулагчтай 3525 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулсан. 2025 онд спортын 28 төрөлд 124 багийн 124 дасгалжуулагчийн удирдлаганд 4001 тамирчид бэлтгэл сургалтад хамрагдаж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2025 онд дотоодын болон олон улс, тив, дэлхийн 382 удаагийн тэмцээнд оролцож 2067 медаль авсан амжилт үзүүлсэн. Тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх зорилгоор өсвөрийн шигшээ багийг 2020 онд 22 спортын төрлөөр байгуулж сургалт дасгалжуулалт явуулж байсан бол 2025 онд спортын 28 төрөл болгон өргөжүүлж суурь түвшнээс 6 төрлөөр нэмэгдүүлэн бэлтгэл сургуулилт, дасгалжуулалтад хамруулж байна. 100%	100%

53.		3.5.5. Нийслэл Улаанбаатар хотноо олон улсын спортын наадмыг зохион байгуулж дэлхийд сурталчлан, таниулах ажлыг шат дараатай зохион байгуулсан байна.	2021 - 2025	НСХ		2020он 0	Улаанбаатар хотноо зохион байгуулж буй Олон улсын спортын наадам	2021-2025 2	-		“Улаанбаатар-2023” Зүүн Азийн Залуучуудын наадмыг эх орондоо анх удаа 11 спортын 12 төрлөөр 2023 оны 08 дугаар сарын 16-наас 23-ны өдрүүдэд нийслэл Улаанбаатар хотод зохион байгууллаа. Зүүн Азийн олимпын хороо нь есөн үндэсний олимпын хороог өөртөө нэгтгэдэг бөгөөд энэ удаагийн наадамд долоон үндэсний олимпын хорооны 880 тамирчин 8 өдрийн турш ур чадвар, авхаалж самбаа, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс БНХАУ-ын баг тамирчид 38 алт, 32 мөнгө, 19 хүрэл медаль авч багийн дүнгээр тэргүүлсэн бол Япон улс 22 алт, 7 мөнгө, 13 хүрэл, БНСУ 11 алт, 21 мөнгө, 24 хүрэл, Хятадын Тайвань 11 алт, 10 мөнгө, 21 хүрэл, Монгол улс 3 алт, 13 мөнгө, 28 хүрэл, Хятадын Хонконг 3 алт, 5 мөнгө, 12 хүрэл авсан амжилт үзүүлсэн байна. “Улаанбаатар-2023” Зүүн Азийн Залуучуудын наадмын зохион байгуулалтын бэлтгэл ажлыг спорт, ёслолын ажиллагаа, наадмын байгууламжууд, байр, сууц, ажиллах хүч, хангамж, тээвэр, мэдээлэл технологи, хэвлэл мэдээлэл, олон улсын харилцаа, протокол, баталгаажилт, бүртгэл, аюулгүй байдал, олон нийттэй харилцах, маркетинг гэсэн 15 чиглэлд хуваан бэлтгэл ажлыг бүрэн ханган ажиллаж амжилттай зохион байгууллаа. (Нийт 2 арга хэмжээ зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч давагдашгүй хүчин зүйл болох ковид 19 цар тахлын нөхцөл байдалтай холбоотойгоор 1 наадам зохион байгуулагдаагүй.)	100%
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ												
Зорилго 4. Инновацад тулгуурласан, өрсөлдөх чадвартай үйлдвэрлэл, үйлчилгээ, хөрөнгө оруулалт, оюуны бөөгнөрлийг дэмжиж, бүтээлч, бие даасан,												**96.00%**
53.	4.1. Нийслэлийн орлогын эх үүсвэрүүдийг нэмэгдүүлж, эрсдэл даах чадвартай бие даасан эдийн засгийг бүрдүүлнэ.	4.1.1. Нийслэлийн өмчийн хөрөнгийг эргэлтэд оруулж, өмч ашиглалтын үр өгөөжийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НӨХГ, НТаГ, НГЗБА		1. 2019 он 5 2. 2019 он 1,075.40 3. 2019 он 62,946.20 4. 2019 он 65,187.10	1.Нийслэлийн төсвөөс санхүүжиж буй орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар болон орон нутгийн өмчит хаалттай хувьцаат компани 2. Орон нутгийн өмчийн түрээсийн орлого 3.Газрын төлбөрийн орлого 4.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын орлого	1.2021-2025 0 2.2021-2025 2,300 3.2021-2025 100,714 4.2021-2025 104,299.4	-	-	2021-2025 онд 8 байгууллагыг татан буулгаж, 4 байгууллагыг өөрчлөн, 5 байгууллагыг шинээр байгуулж, 1 байгууллагыг нийслэлийн өмчид шилжүүлсэн. -НИТХ-ын 2021 оны 191 дүгээр тогтоолоор "Дүүжин тээврийн ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ-ыг, НИТХ-ын 2022 оны 10 дугаар тогтоолоор "Үртсэн шахмал түлшний үйлдвэр" ОНӨААТҮГ-ыг, НИТХ-ын 2024 оны 61 дүгээр тогтоолоор "Улаанбаатар шинэ бүтээн байгуулалт" ХХК-ыг, НИТХ-ын 2024 оны 87 дугаар тогтоолоор "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-ыг, НИТХ-ын 2024 оны 122 дугаар тогтоолоор "Улаанбаатар зүүн Азийн наадам зохион байгуулах хороо" ХК-г, НИТХ-ын 2024 оны 123 дугаар тогтоолоор "Нийслэлийн нутгийн захиргааны цогцолбор барилгын ашиглалтын өмнөх захиргаа" ОНӨТҮГ-ыг татан буулгаж, - НИТХ-ын 2024 оны 28 дугаар тогтоолоор "Зорчигч тээвэр 1", "Зорчигч тээвэр 2", "Зорчигч тээвэр 3", "Зорчигч тээвэр 4", "Зорчигч тээвэр 5" ОНӨААТҮГ-ыг байгуулж, "Зорчигч тээврийн нэгтгэл" ОНӨААТҮГ, "Зорчигч тээвэр 3" ОНӨААТҮГ-ыг татан буулгасан. -НИТХ-ын 2023 оны 67 дугаар тогтоолоор "Эмээлт үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨААТҮГ-г, НИТХ-ын 2024 оны 36 дугаар тогтоолоор "Багахангай үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ыг, 37 дугаар тогтоолоор "Багануур үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ыг, 38 дугаар тогтоолоор "Налайх барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк" ОНӨТҮГ-ыг тус тус хаалттай ХК болгон өөрчлөн байгуулж, дүрмийг батлсан. -НИТХ-ын 2024 оны 41 дүгээр тогтоолоор “Төв цэнгэлдэх хүрээлэн” ХХК-ийг нийслэлийн өмчид 100 хувь шилжүүлэн авсан. 70% 2.Нийслэлийн өмчийн байр талбайг иргэд, аж ахуйн нэгжид түрээсийн гэрээгээр ашиглуулах хүрээнд нийт 1316 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажилласан. 2021-2025 оны зорилтот түвшингээр нийслэлийн төсөвт нийт 11,937.8 сая төгрөг төвлөрүүлэхээс 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 9,557.8 сая төгрөг төвлөрүүлсэн байна. 80% 3.Газрын төлбөрийн төрлөөр 2020 онд 40 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 91.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 77.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. 84.8% 4.Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төрлөөр 2020 онд 57,8 тэрбум төгрөг төвлөрүүлж байсан бол 2025 оны 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 102.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 88.9 тэрбум төгрөг төвлөрүүлсэн. 87.2%	79%

54.		4.1.2. Хөрөнгө оруулалтын сан байгуулах, үнэт цаас гаргах ажлыг хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	НӨУБХОМҮЦК ХХК, УБ ХК		1. 2020 он 20 2. 2020 он 0	1. Хөрөнгө оруулалтын сан байгуулах ажлын хэрэгжилт 2. Үнэт цаас гаргах ажлын хэрэгжилт	1. 2021-2025 100 2. 2021-2025 100	-	50	Нийслэлийн Ногоон Хөгжлийн Сан Хувийн ХОС ТЗК-г байгуулан удирдаж байгаа бөгөөд Улаанбаатар хотод хэрэгжих орон сууцны төслүүдийн хөрөнгө оруулалтыг тус сангаар дамжуулан хэрэгжүүлэхээр НОСК болон УБ түншлэл төвүүдтэй харилцан зөвшилцөж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн схемийг гаргаад байна. Мөн "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууц сан"-г Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02/07 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууц сан"-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн "Багц журам батлах тухай" 01/03 дугаар тогтоолоор “Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан хувийн ХОС” ХХК-ийн “Дотоод хяналтын журам”, “Нэгж эрх эзэмшигчдийг бүртгэх журам”, “Орлогыг сангийн активт бүртгэх журам”, “Зардлын зүйл, дээд хэмжээг тогтоох журам”, “Орлого болон ногдол ашиг хуваарилах журам”, “Эрсдэлийн удирдлагын журам”, “Санг татан буулгах журам”, “Ёс зүйн дүрэм ба мэргэжлийн үйл ажиллагааны стандарт”, “Сангийн хөрөнгөөр барьцаалан зээл авах журам”, “Гишүүдийн хурал зарлан хуралдуулах журам”-ыг тус тус баталсан. Шархад дэд төв, Баянхошуу дэд төвүүдэд нийт 4200 айлын “Ногоон орон сууцны төсөл” хэрэгжүүлэн ажиллаж байна. 2.Олон улсын аудит, хөрөнгийн үнэлгээ, бусад санхүүгийн болон мэргэжлийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр: Олон улсын аудитын байгууллагаар нийслэлийн хөрөнгийг үнэлүүлэх, гадаад улсад үнэт цаас гаргахтай холбоотойгоор аудитын зөвлөгөө авахтай холбоотойгоор 2025 оны 1-3 дугаар саруудад Улаанбаатарт байгаа EY (Ернест Янг аудит - БНХАУ-д байдаг салбарт харьяалагддаг), PwC (ПиДаблюСи Аудит - Бүгд Найрамдах Солонгос улсад харьяалагддаг), KPMG (КэйПиЭмЖи Аудит -Казакстан улсын салбарт харьяалагддаг) зэрэг аудитын байгууллагуудтай уулзаж зах зээлийн дүн шинжилгээ хийсэн. 2.Олон улсын зээлжих эрхийг тогтоодог Fitch байгууллагатай ажил хэргийн цахим уулзалтыг 2025 оны 06 дугаар сард, биечилсэн уулзалтыг 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. Үнэт цаас гаргахтай холбоотой зээлжих эрх олгох тус байгууллагын хамтран ажиллах болон үнийн саналыг 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдөр авсан. Fitch байгууллага нь S&P болон Moody’s байгууллагаас харьцангуй бага үйлчилгээний төлбөрийг авах саналыг Монгол улсын үйлчлүүлэгчдэдээ өгдөг. Монгол улсын талаар зах зээлийн судалгааг хийж бусдаас илүү дэлгэрэнгүй бөгөөд илүү давтамжтай мэдээллийг өөрийн цахим хаягтаа тавьдаг. 3. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтын ажиллагаа: Korea Investment & Securities Asia Limited компани нь Монгол Улсын Голомт банкны 300 сая ам долларын 3 жилийн хугацаатай, Монголын Ипотекийн Корпорацийн 225 сая ам. долларын 3 жилийн хугацаатай бондыг амжилттай гаргахад оролцсон компани юм. Тус компанитай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр үзүүлэх үйлчилгээний цар хүрээ болон үнийн саналын мэдээллийг бичгээр авсан. Гадаад бонд гаргах төслүүдэд санал авч хууль эрх зүйн орчныг судлан, Төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
55.		4.1.3. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төлөвлөж, сахилга батыг сайжруулсан байна.	2021 - 2025	НХОГ, НЗХГ		1. 2020 он 40 2. 2020 он 0	1.Нийслэлийн төсвийн төлөвлөлтөд иргэдийн оролцоо 2.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем	1. 2021-2025 80 2. 2021-2025 1	-		1.Жил бүр нийслэлийн төсвийн төлөвлөлтөд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулж, иргэдээс ирүүлсэн саналыг эрэмбэлэн төсвийн төсөлд тусган боловсруулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Тухайлбал 2021 оны төсвийн төсөлд тусгах иргэдийн саналыг 2020 оны 11 дүгээр сарын 18-наас 20-ны өдөр цахимаар зохион байгуулж 343 санал, 2022 оны төсвийн төсөлд тусгах иргэдийн санал авах ажлыг 2021 оны 11 дүгээр сарын 18-наас 20-ны өдөр цахимаар зохион байгуулж 266 санал, 2023 оны төсвийн төсөлд тусгах иргэдийн санал авах ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж 455 санал, 2024 оны төсвийн төсөлд тусгах иргэдийн санал авах ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулж 637 санал, 2025 оны төсвийн төсөлд тусгах иргэдийн санал авах ажлыг 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр цахимаар зохион байгуулж 637 санал нэгтгэн тусгасан. 100% 2.Төсвийн Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх, үр ашиг болон үр өгөөжийг сайжруулах, түүнчлэн иргэдийн оролцоог бий болгох зорилтын хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтын цахим систем болох pimis.publicinvestment.gov.mn-ийг бий болгож, улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтийн үйл явцыг бүрэн цахимжуулсан.Түүнчлэн 2025 онд дүүргүүдийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилтийг цахим системд холбох бэлтгэл ажил хийгдэж байна. 100%	100%
56.		4.1.4. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн оновчтой хэлбэрт тулгуурлан, эрх ашгийг хамгаалж, хувийн хэвшлийн санаачилгыг дэмжиж ажилласан байна.	2021 - 2025	УБХК ХК, НЗДТГ		2020 он 1	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжсэн төсөл	2021-2025 5	-		Нийслэл хотод хэрэгжүүлэхээр батлагдсан МЕГА төслүүдээс Төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх "ДЦС-5" болон “Хог шатааж, эрчим хүч гаргах үйлдвэр” төслүүдийн бэлтгэл ажлыг бүрэн хангаж, холбогдох хууль, журмын дагуу сонгон шалгаруулалтын ажлыг зохион байгуулсан ба хувийн хэвшлийн аж ахуйн нэгжтэй түншлэлийн гэрээ байгуулагдсан. Мөн “Хүннү хотын өөрийн эх үүсвэрээр цэнэглэгдэх 90 МВт батарей хуримтлуур”, Улаанбаатар Трам”, “УБ хотын такси үйлчилгээг сайжруулах нь” төслүүдийн урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээний үе шат дахь судалгаа шинжилгээний ажил хийгдэж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаас хувийн хэвшлийн түншлэгчийг сонгох сонгон шалгаруулалтыг хийж гүйцэтгэх шийдвэр гарсан. Цаашид “Дэнжийн 1000 дэд төвд баригдах оргил ачааллын үед хангах дулааны эх үүсвэр (93МВт)”, “Улаанбадрах 300 МВт цахилгаан станц” “Лаг хатаах шатаах, шатааж цэвэрлэх үйлдвэр”, “Хагас коксын үйлдвэр” төслүүд болон Хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх ач холбогдол бүхий “Усан спортын ордон”, “УБ арена”, “Хүүхдийн зуслан” төслүүдийг хэрэгжүүлэхээр холбогдох бэлтгэл ажлыг хангаж, урьдчилсан үнэлгээ, бүрэн шинжилгээний үе шатыг эхлүүлсэн.	100%
57.		4.1.5. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжсэн байна.	2021 - 2025	НХААГ, ННЗБ-ууд		2019 он 3	Нийслэлийн худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлийн эзлэх хувь	2021-2025 11	**-**	**106,534.60**	Нийслэлийн хэмжээнд 2021-2025 онд өссөн дүнгээр 27,300,804.3 (хорин долоон их наяд гурван зуун тэрбум найман зуун дөрвөт сая гурван зуун мянга) төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, тухайн жилд санхүүжих 9,834,825.9 (есөн их наяд найман зуун гучин дөрвөн тэрбум найман зуун хорин таван сая есөн зуун мянга) төгрөгийн санхүүжих дүнтэй 8033 төсөл, арга хэмжээ хэрэгжсэн. Үүнээс 1183 төсөл, арга хэмжээнд дотоодын худалдан авалтыг нутгийн захиргааны 142 (давхардсан тоогоор) байгууллага дотоодын үйлдвэрлэгч 544 байгууллагаас бараа бүтээгдэхүүний ерөнхий ангиллын 16 нэр төрлийн 106,534.6 (нэг зуун зургаан тэрбум таван зуун гучин дөрвөн сая зургаан зуун мянга) төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан байна. Энэ нь дотоодын худалдан авалтын дэмжин ажилласан нийт худалдан авалтын 11 хувийг эзэлж, зорилтот түвшинд 100 хувь хүрсэн байна.	100%

58.		4.1.6. Татвар ногдуулах, хураах үйл ажиллагаанд технологийн дэвшил нэвтрүүлэн, хялбаршуулсан байна.	2021 - 2025	НТаГ		2020 он 20	Татварын системийг цахимжуулсан ажлын хувь	2021-2025 100	-	77.9тб	Нийслэлийн хэмжээнд “Татвар төлөгчийн шинэчилсэн бүртгэл, тооллого” зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Татварын удирдлагын нэгдсэн системийн Татвар төлөгчийн бүртгэлийн хэсэг, “E-Tub” апп-д өөрчлөлт оруулах бодлогын даалгаврыг Ажлын хэсгийн гишүүдээс 2025 оны 02 дугаар сарын 27-ноос 03 дугаар сарын 10-ыг хүртэлх хугацаанд саналыг хүлээн авч боловсруулан нэгтгэж, “Программ хангамж хөгжүүлэх үйл ажиллагааны журам”-ын дагуу боловсруулан 2025 оны 03 дугаар сарын 11-ний өдөр хүргүүлэн Татварын удирдлагын нэгдсэн систем болон E-tub аппликэйшныг хөгжүүлж дуусгасан. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр нийслэлийн 10 албаны удирдлага болон бүртгэл хариуцсан татварын улсын байцаагчдад сургалтыг зохион байгуулан ажиллаж, Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа 202 зах худалдааны төвтэй хамтран ажиллах тухай албан хүсэлт хүргүүлж, татвар төлөгчийн мэдээллийг хүлээн авч ажилласан. E-Tub аппликэйшний нэвтрүүлэлт болон ТУБ-н ашиглалтын хэрэглээний талаар Нийслэлийн 9 дүүргийн татварын хэлтсийн удирдлага болон ТУБ-д хуваарийн дагуу өдөр бүр Цахим зөвлөмж, уулзалтыг зохион байгуулан ажилласан.	100%
59.		4.1.7. Олон улсын байгууллага, хөгжлийн түншлэгч орон, олон улсын банк санхүүгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлж буй хотын хөгжлийн томоохон төсөл, хөтөлбөрүүдийн ил тод, үр ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.	2021 - 2025	НЗДТГ-ТХХТ		2020он 19	Хөгжлийн төсөл хөтөлбөр	2021-2025 24	-		2025 оны байдлаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хэрэгжиж буй гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр нийт 12 төсөл, төлбөрийн үйл ажиллагаа, хэрэгжилтэд хяналт тавьж, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллаа. АХБ, Дэлхийн банк, ЕСБХБ, КОЙКА, ЖАЙКА, UNDP, Хятадын ЭКСИМ, Солонгосын ЭКСИМ банк зэрэг 10 гаруй хөгжлийн түнш, хандивлагч байгуулагуудтай хамтран ажилласан. Тайлант хугацаанд төсөл хөтөлбөрийн хүрээнд 30 уулзалт, семинар хийгдэж, 20 удаа төслийн дунд хугацааны хяналтын уулзалт, 8 удаа ТУХ-ны хурлыг зохион байгуулсан. Цаашид шинээр 1 төсөл, хөтөлбөрийг шинээр хэрэгжүүлэхээр санхүүжүүлэгч байгууллага болон холбогдох улс, нийслэлийн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Тайлант хугацаанд Тусгай замын автобус (BRT) төслийн санхүүжилтийн зээлийн хэлэлцээр болон Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох, шинэчлэх технологийг нэвтрүүлэх төслийн бэлтгэл ажлыг хангах буцалтгүй тусламжийн хэлэлцээр шинээр байгуулагдаад байна. 2021-2025 онд нийт 50 хөгжлийн төсөл хөтөлбөр хэрэгжиж, хамтын ажиллагааг өргөжүүлж байна. 100%	100%
60.	4.2. Инновацыг хотын тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлнэ.	4.2.1. Инновац, энтрепренёршипд оролцох боломжийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НБИХГ		1. 2020 он 0 2. 2020 он 0 3. 2020 он 32 4. 2020 он 80	1.Шинээр боловсруулсан инновацын баримт бичиг 2.Инновацын соёлыг бий болгох, түгээх зорилтот арга хэмжээ 3. Шинээр бойжсон гарааны бизнес эрхлэгчид 4. Зохион байгуулсан арга хэмжээ	1. 2021-2025 2 2. 2021-2025 20 3. 2021-2025 157 4. 2021-2025 480	-	-	1.Нийслэлийн бизнес инновацыг хөгжүүлэхээр 7 зорилт 42 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/558 дугаар захирамжаар батлуулсан. 2023 онд Нийслэлийн бизнес инновацыг хөгжүүлэх “Science” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан. 2024 онд Японы Шинагава хотын “Gotanda valley association”-той хамтран хоёр орны технологийн чиглэлийн компаниудын үйл ажиллагааг дэмжих, нэгтгэх зорилгоор хамтарсан Япон-Монголын “Ай ти консерциум” байгуулсан. 100% 2.Инновацын соёлыг бий болгох, түгээх зорилгоор 2021-2025 онд нийт 37 арга хэмжээ зохион байгуулан ажилласан. Тухайлбал 2021 онд Инновацын соёлыг бий болгох, түгээх 4 арга хэмжээг, 2022 онд 5 арга хэмжээг, 2023 онд 12 арга хэмжээг, 2024 онд 14 томоохон арга хэмжээг тус тус зохион байгуулан ажилласан. 2025 онд 6 арга хэмжээ, 10 контент, 29 постер бэлтгэн олон нийтэд хүргэсэн. 100% 3.2021-2025 онд нийт 129 гарааны компани болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэдийг бойжуулсан байна. Улаанбаатар инновацын төвд 2021 онд 33 гарааны компани болон жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг, 2022 онд 22 гарааны компани болон бичил бизнес эрхлэгчдийг, 2023 онд Улаанбаатар инновацын төв болон Баянхошуу бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд нийт 37 гарааны болон бичил бизнес эрхлэгчдийг, 2024 онд Улаанбаатар инновацын төв болон Баянхошуу бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвүүдэд нийт 21 гарааны болон бичил бизнес эрхлэгчдийг тус тус бойжуулан хөгжүүлсэн. 2025 онд Инновацын төвүүдэд бойжуулах гарааны болон жижиг дунд бизнес эрхлэгчдийг сонгон шалгаруулах ажлыг 2 удаа зохион байгуулж 16 компанийг шалгаруулаад байна. 100% 4.Нийт 536 удаагийн сургалт, арга хэмжээ зохион байгуулж, 20432 иргэн, жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгч хамрагдсан. 2021 онд 115 сургалт, эвэнт арга хэмжээ, 2022 онд 95 сургалт, эвэнт арга хэмжээ, 2023 онд 137 сургалт, эвэнт арга хэмжээ, 2024 онд 95 сургалт, эвэнт арга хэмжээг тус тус зохион байгуулсан. 2025 онд Гарааны болон жижиг дунд, бизнес эрхлэгчдийг бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд нь шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт болон уулзалтуудыг 94 удаа зохион байгуулж 2364 бизнес эрхлэгчийг хамруулсан байна. 100%	100%
61.		4.2.2. Салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлж, инновацыг дэмжих дэд бүтцийг хөгжүүлсэн байна.	2021 - 2025	НБИХГ		2020 он 2	Инновацын төв	2021-2025 7	-	-	2021 онд "Сэлбэ дэд төв”-ийн барилгын бүтээн байгуулалтын ажил бүрэн дуусаж, улсын комисс хүлээн авсан. 2023 онд Монголын метаверсе орчин дахь хамгийн олон бизнестэй Метафорсе компанийн хөгжүүлсэн Metaland метаверсийн 8 блок виртуал газарт Улаанбаатар инновацын төвийн виртуал хувилбар болох HUB Innovation Center-ийг байгуулсан. Тус виртуал инновацын төвийн дотор талд инновацын төв, соёлын төв гэсэн зохион байгуулалт бүхий 3D хөгжүүлэлтийн ажлууд хийгдсэн бөгөөд VR төхөөрөмжид зориулсан хувилбарыг шинээр хөгжүүлж ашиглалтад оруулсан. 2025 онд БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв” байгуулах асуудлаар хамтран ажиллах, санал солилцох уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтад БНСУ-ын холбогдох албаны төлөөлөгчид, нийслэлийн удирдлагууд, БНСУ-ын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Куаг Хан Сул нар оролцож саналаа солилцсон. Уулзалтаар БНСУ-аас Монгол Улсад буцалтгүй тусламжийн хүрээнд урт болон дунд хугацаанд нийт 58 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд нэн тэргүүнд “Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв” байгуулах төслийг хэрэгжүүлэхээр болж НЗД-ын 2025 оны А/258 дугаар захирамж гарсан.	86%

62.		4.2.3. Инновацын судалгаа, хөгжүүлэлтийг эдийн засгийн хөшүүргээр дэмжихэд санаачилга гарган ажилласан байна.	2021 - 2025	НБИХГ		2020 он 0	Дэмжигдсэн судалгаа хөгжүүлэлтийн судалгаа хийх	2021-2025 8	-	-	2021-2025 онд нийт 21 судалгааны ажил хийгдсэн. Тухайлбал 2021 онд Нийслэлийн хэмжээнд цэвэр усыг хэмнэх, саарал усны хэрэглээг нэмэгдүүлэх инновац технологийн шийдлийг судлан, саналыг боловсруулж, НЗД-ын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. 2022 онд Улаанбаатар инновацын төвийн виртуал хувилбар болох Улаанбаатар “Метахаб”-ыг AR болон MR технологи ашиглан хөгжүүлэлт хийгдсэн. Төслийн хүрээнд Нийслэлийн бэлгэ тэмдэг болох Хангардийн 3D модель, Улаанбаатар хотын түүх, соёлын 20 дурсгалт газрын мэдээллүүдийг интерактив байдлаар оруулж, 10 гарааны компанийн бүтээгдэхүүн үйлчилгээний танилцуулгыг цахим орчинд сурталчлан ажилласан. 2023 онд Улаанбаатар хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, инновацын хөгжлийг дэмжих, шинэ технологи нэвтрүүлэх, нутагшуулахтай холбоотой судалгааны 20 ажлыг хийсэн. 2024 онд Нийслэлийн тулгамдсан асуудлыг эрдэмтэн судлаачдын нөөц бололцоонд тулгуурлан шийдвэрлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор их, дээд сургуулиудтай хамтран ажиллах “Санамж бичиг” байгуулан ажиллаж байна. Санамж бичгийн хүрээнд Монгол орны нөхцөлд далайн гаралтай загас үржүүлэг, загасны аж ахуй хөгжүүлэх төслийн судалгааны ажлыг эхлүүлж, Утаагүй сайжруулсан түлшний найрлага дахь ургамлыг нутагшуулах төслийн судалгааны ажлыг хийсэн. 2025 онд Гарааны компаниудын бизнесийн орчныг судлах, тулгарч буй асуудлыг тодорхойлох, цаашид хөгжлийг дэмжих зорилготой Бизнесийн орчны судалгааг хийсэн. Судалгааны үр дүнг гарааны болон жижиг дунд бизнес эрхлэгч нарт танилцуулсан.	100%
63.		4.2.4. Нийслэлийн тулгамдсан асуудлыг шийдэхэд иргэдийн дэвшүүлсэн инновацлаг санааг дэмжиж, оролцоог нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НБИХГ		1.2020 он 1 2.2019 он 3	1.Бүтээгчдийн талбар 2. Олон нийтийн оролцоотой гаргасан шийдэл, арга хэмжээ	1. 2021-2025 3 2. 2021-2025 15	-		1.2021-2025 онд нийт 2 бүтээгчдийн талбар байгуулсан. 2022 онд Гарааны бизнес эрхлэгчид болон энтрепренер оюутан залуучууд орчин үеийн дэвшилтэт техник, технологийн тусламжтайгаар бүтээгдэхүүнийхээ анхны загварыг турших, сайжруулах, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломж, нөхцөлийг бүрдүүлэх орон зай бүхий “Бүтээгчдийн талбар”-ыг Техник, технологийн дээд сургууль дээр байгуулж, ашиглалтад оруулсан. 2024 онд Баянхошуу бизнес инкубатор сургалт үйлдвэрлэлийн төвд мэдээлэл технологийн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор “Компьютерын лаборатори” сургалтын танхим байгуулан үйл ажиллагааг эхлүүлсэн. 100% 2.2021-2025 онд нийт 21 удаагийн Хакатон тэмцээн зохион байгуулж 99 шийдэл шалгарсан. Тухайлбал 2021 онд 2 шийдэл арга хэмжээ, 2022 онд 2 шийдэл арга хэмжээ зохион байгуулсан. 2023 онд Нийслэлийн асуудлуудыг шийдвэрлэх 10 удаагийн Хакатон тэмцээн зохион байгуулж 74 шийдэл, 2024 онд 5 удаагийн Хакатон тэмцээн зохион байгуулж 15 шийдэл шалгарсан. 2025 онд Хүнсний эрүүл ахуйн тулгамдсан асуудлуудыг бодит өгөгдөлд суурилан салбарын мэргэшсэн залуусаар шилдэг инновацын шинэлэг шийдлийг гаргах зорилгоор хакатон тэмцээнийг 1 сарын турш 3 үе шаттайгаар “Хүнсний нарийн ногооны хүлэмж, далайн гаралтай бүтээгдэхүүнийг дотооддоо бий болгох боломжийг бүрдүүлэх”,“Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах, ашиглах”,“СӨБ болон ЕБС-ийн хүнс хангамжийн менежментийг сайжруулах, Нийслэл хотын хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэлтийн шийдэл боловсруулах” тухай 3 сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан. Шилдгээр шалгарсан 3 баг тус бүрд 3 сая төгрөгийн грант олгосон. Мөн “Дэлгэцийн донтолтыг бууруулах инновац” сэдвийн хүрээнд холбогдох байгууллагуудтай хамтран тэмцээн зохион байгуулсан. Шалгарсан 3 баг Япон улсад болох олон улсын тэмцээнд оролцохоор болсон.	100%
64.	4.3. Эдийн засгийн бүтцийг төрөлжүүлж, бүтээлч эдийн засгийг хөгжүүлнэ.	4.3.1. Үндэсний онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, олон улсын аялал жуулчлалын зах зээлд өрсөлдөх чадварыг дээшлүүлсэн байна.	2021 - 2025	НАЖГ		1.2020 он – 2.2019 он 0.5 3.2019 он 13	1.Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх арга хэмжээ 2.Хүлээн авах гадаад жуулчдын тоо 3.Шинээр нэвтрүүлсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ	1. 2021-2025 1 2. 2021-2025 0.9 3. 2021-2025 21	4,969.90	4,499.00	1.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар Найрсаг Улаанбаатар-2” нийслэлийн аялал жуулчлалыг 2022-2025 онд хөгжүүлэх 7 зорилтын 77 арга хэмжээний төлөвлөгөөг батлуулсан. Төлөвлөгөөний биелэлт 2022 онд 60 хувь, 2023 онд 80 хувь, 2024 онд 90 хувь, 2025 оны жилийн эцсийн байдлаар 95 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн. 100% 2.Монгол Улс 2021 онд 0.03 сая жуулчин, 2022 онд 0.3 сая жуулчин, 2023 онд 0.7сая жуулчин, 2024 онд 0.8 сая жуулчин хүлээн авсан. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 264 дүгээр тогтоолоор 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарлаж 1 сая жуулчин хүлээн авах зорилт дэвшүүлэн Монгол Улс гадаад сурталчилгаа, олон нийттэй харилцах үйл ажиллагаанд “Go Mongolia” түлхүүр үгийг, Улаанбаатар хот “Visit Ulaanbaatar” логог ашиглаж үйл ажиллагаагаа сурталчлан ажиллаж байна. 2025 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 0.8 сая жуулчин хүлээн авсан байна. Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах, урсгалыг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2025 онд нийт 71 эвент арга хэмжээг зохион байгууллаа. Мөн Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “ITB Berlin”, “Messe Stuttgart CMT, “SITF-Seoul Internatiol Travel Fair”, “JATA”, “COTTM”, “Travel Expo Japan”, Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбоо (WTCF)-ны чуулга уулзалт зэрэг олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, арга хэмжээнд 2021-2025 онуудад нийт 32 удаа оролцож үйл ажиллагаагаа сурталчилсан. 89% 3.Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2024 онд 11 арга хэмжээ зохион байгуулж, 4 бүтээгдэхүүн, үйлчилгээг шинээр нэвтрүүлсэн. 2025 онд Ви Ар (VR) Web AR 3D модель контент бүтээх ажил, “Мөсөн замын авто машины уралдаан”, “Нарны баяр”, "Бурхан багшийн дүйчин өдөр", “Монгол үндэстэн угсаатан дээлтэй жагсаал”, “Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр -Хүрээ цам даншиг наадам” зэрэг нийт 21 бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүллээ. 100%	96%
65.		4.3.2. Мэдээллийн технологийн салбарыг дэмжиж, эдийн засагт оруулах хувь нэмрийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НБИХГ		2020 он 2,320	"10,000 програмист" төсөлд хамрагдсан хүн	2021-2025 10,000	-		Мэдээллийн технологийн салбарыг дэмжин "10,000 программист" төслийг хэрэгжүүлэн 2021-2025 онд нийт 10958 иргэн хамрагдсан байна. Тухайлбал 2021 онд 2076, 2022 онд 3550, 2023 онд 2954, 2024 онд 58, 2025 онд 30 иргэн хамрагдсан. Тус төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх зорилгоор www.10k.mn платформоор дамжуулан программчлалын хэлний 9 төрлийн онлайн сургалтуудыг зохион байгуулсан.	100%

66.		4.3.3. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн инженерийн дэд бүтцийг хөгжүүлэн, дэвшилтэт технологи бүхий үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НБИХГ		1.2020 он 5 2.2020 он 20 3.2020 он 5 4.2020 он 0 2020 он 0	1."Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт 2."Налайхын Барилгын материалын үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт 3."Багануур үйлдвэрлэл технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт 4."Багахангайн үйлдвэрлэл, технологийн парк"-ийн инженерийн дэд бүтцийн бүтээн байгуулалт Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийн суурь судалгаа	1.2021-2025 100 2. 2021-2025 100 3. 2021-2025 81 4. 2021-2025 100 2021 2025 1	30,000.00	0.0 (30,000.0 Санхүүжилт хийгдээгүй)	1.Эмээлтээс Шувуун фабрик хүртэлх 12.5 км гадна авто замыг барьж байгуулах зураг төсвийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1249 дугаартай захирамжаар шинэчлэн боловсруулж 2026 оны нийслэлийн төсөвт тусгуулсан. Үерийн байгууламжийн төсвийг 2025 онд тарифын өөрчлөлтийг тусгаж Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 2094/2025 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан. 100% 2.Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд хоногт 1000мкуб хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, Паркийн 120 га газрын 10.3 км дотор авто зам, 7.06 км гадна авто зам, 26 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц барих, Төв аймгийн Баян зөрлөгөөс паркийг холбох 11,7 км төмөр зам тавих ажлууд тусгуулаад байна. 90% 3. Паркийн цахилгаан хангамжийн хүрээнд 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын хүрээнд нийт төсөв 9,911.6 сая төгрөг бөгөөд Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 50% буюу 4,955.8 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 1,048.9 сая төгрөг тусгагдаж дараах шатанд ажил явагдаж байна. Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендер 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нээгдэж оролцогч 3 байгууллагууд шаардлага хангаагүй тул Багануур үйлдвэрлэл технологийн паркийн дэд станцын ажил, 110/35/10кВ-ын НХААГ/20250101634/02/01 урилгын дугаартай тендерийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүртэл дахин зарласан. 70% 4. Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсийн Хөгжлийн төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах 90.0 сая төгрөгийн санхүүжилт Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/769 дүгээр захирамжаар шийдвэрлэгдэж, тендер зарлагдан "Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв" ТББ шалгарч, гэрээ байгуулсан.100%	90%
67.	4.4. Бизнес, үйлчилгээ эрхлэхэд таатай орон зайг хөгжүүлнэ.	4.4.1. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг татах "Эдийн засгийн чөлөөт бүс" байгуулах ажлыг шат дараалалтай хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	УБХК ХК		2020 он 0	Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийн суурь судалгаа	2021-2025 1	-		Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн Эдийн засгийн тусгай бүс байгуулах тухай 220 дугаар тогтоолоор хүнсний аюулгүй байдлыг хангах, экспортын чиг баримжаатай хүнс, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт хүлэмж агуулахын аж ахуй, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр "Агро-сити" Эдийн засгийн тусгай бүсийг байгуулж, бүс байгуулах газар нутгийн хэмжээг 9,000 га-аар тогтоож, эдэлбэр газрын байршил, хил заагийн эргэлтийн цэгийн солбицол, талбайн хэмжээг баталсан. "Агро-сити" дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийт 24,294.7 га талбайд, үүнээс 9,000 га талбайг эдийн засгийн тусгай бүсийн зориулалтаар хөгжүүлэхээр “Агро-сити” дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө”-г боловсруулж, дунд шатны тайланг 2025 оны 12 дугаар сарын 04-ний өдөр Хот байгуулалт, хотын стандартын газрын "Нийслэлийн нутаг дэвсгэрт хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөл"-ийн 61 дүгээр хурлаар хэлэлцүүлж, дэмжигдсэн. Эцсийн тайланг 2026 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр хүлээлгэн өгч, 03 дугаар сард Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна. Эдийн засгийн тусгай бүсийн төлөвлөлтийг олон улсын сайн туршлагатай уялдуулах, чөлөөт бүсийн бодлого, менежмент, инновацын чиг хандлагыг судлах, хүлэмж агуулахын аж ахуй, хөнгөн болон хүнсний үйлдвэрлэл,орчин үеийн хөдөө аж ахуйн дэвшилтэт технологийг нэвтрүүлэх болон хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 12 улсын төр, хувийн хэвшил, хөрөнгө оруулгчид, олон улсын 41 байгууллагатай харилцаа холбоо тогтоож, 3 хамтын ажиллагааны санамж бичиг, 1 урьдчилсан хэлэлцээр байгуулсан. Мөн хамтын ажиллагааны хүрээнд гадаад, дотоод 60 гаруй уулзалтыг зохион байгуулж, цаашдын хамтын ажиллагааны санал солилцон ажиллалаа.	90%
68.		4.4.2. Цахим зайн ажлын байр, ажлын уян хатан цагийг дэмжих замаар ажиллах хүчний нөөцийг татсан байна.	2021 - 2025	НЗДТГ-ХНХХ		2020 он 0	Ажлын байрыг цахимд шилжүүлэх, ажлын уян хатан цагийг дэмжих чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний хэрэгжилт	2021-2025 100	-		Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/161, А/108, А/246 зэрэг захирамж гарч алба хаагчдыг цахим болон ээлжээр ажиллуулж, 0-12 хүртэлх насны хүүхдүүдийг цахимаар ажиллуулахаар шийдвэрлэсний дагуу нийслэлийн нутгийн захиргааны 74 байгууллагын алба хаагчид цахимаар болон ээлжээр ажилласан. 2022 онд Нийслэлийн зарим ерөнхий боловсролын сургуулийн хичээл эхлэх цагт зохицуулалт хийх тухай Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/217 захирамж гарч ажлын уян хатан цагийг дэмжих чиглэлээр нийслэлийн 9 дүүргийн 59 дунд сургуулиудын багш, ажилчид хамрагдаад байна. 2023 онд цахим зайн ажлын байр, ажлын уян хатан цагийг дэмжих чиглэлээр нийслэлийн нутгийн захиргааны 10 байгууллагууд ажлын байрыг цахимд шилжүүлэх, уян хатан цагийг дэмжиж ажилласан. Үүнд: 1. Замын хөдөлгөөний удирдлагын төв 2. Нийслэлийн Замын хөгжлийн газар 3. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар 4. Нийслэлийн Бизнес инновацын газар 5. Нийслэлийн Агаар орчны бохирдолтой тэмцэх газар 6. Хот төлөвлөлт, судалгааны институт 7. Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба 8. Хот байгуулалт, хөгжлийн газар 9. Нийслэлийн Эрүүл мэндийн газар 10. Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар. Засгийн газрын 2024 оны “Хуулийн биелэлтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” 164 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хуулийн хэрэгжилтийг хангах талаар авах арга хэмжээний тухай” А/1430 дугаар захирамжийн хүрээнд 2025 онд Нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын ажил, амьдралын тэнцвэртэй байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор уян хатан цагийн зохицуулалт болон ажлын цагийн уян хатан цагийн зохицуулалтын хуваарийг гаргаж зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас ажлын байрыг цахимд шилжүүлэх, уян хатан цагийг дэмжих чиглэлээр арга хэмжээ зохион байгуулан ажилласан. 2021-2025 онд цахимд шилжүүлэх, ажлын уян хатан цагийг дэмжих чиглэлээр арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажилласан.	100%

69.	4.5. Хариуцлагатай, тогтвортой хэрэглээ болон үйлдвэрлэлийг дэмжинэ.	4.5.1. Технологи нутагшуулах, лаборатори, тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх замаар стандартын шаардлага хангасан хүнсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НХХААГ		1. 2019 он 38.6 2. 2019 он 0 3. 2019 он 0	1. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн сүүний хэмжээ 2.Мах боловсруулах цогцолборын тоо 3.“Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй хүн амын хүнсний чанар, аюулгүй байдлыг хангах ургацыг чанартай, үр ашигтай үйлдвэрлэх чадавхыг бэхжүүлэх” нь төслийн үйл ажиллагааны хэрэгжилт	1. 2021-2025 46.6 2. 2021-2025 2 3. 2021-2025 100	-		1.2021-2024 онд Үйлдвэрийн аргаар боловсруулсан 195.2 сая литр (2021 онд 43сая литр, 2022 онд 44.4 сая литр, 2023 онд 49 сая литр, 2024 онд 58.8 сая литр) болж жилд 10 хувиар өсөж, 60 хувийг хангаад байна. Үйлдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүүний хэмжээ 2025 оны 10 дугаар сарын байдлаар 49 сая литр байгаа нь өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 2158.3 мян.л-ээр буюу 5%-иар өссөн дүнтэй байна. 100% 2.Малын зах, мах боловсруулах үйлдвэрийн цогцолбор төвийг хотын зүүн, баруун бүсэд байгуулах бэлтгэл ажлыг төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны хүрээнд “МБҮ Трөйд” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороо Эмээлт төвийн баруун хойд талд 15.0 га, Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны Оргил худалдааны төвийн хойд талд 6.26 га талбай газрын асуудлыг шийдвэрлэн техник, эдийн засгийн үндэслэл болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, байгаль орчны үнэлгээ, ажлын зураг төсөл хийгдсэн. Тус аж ахуйн нэгж нь үйл ажиллагаг өргөжүүлэн хүнсний ногоо, жимс, жимсгэнийн хадгалалт борлуулалтын логистикийн төвийг нэмж байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Бүтээн байгуулалтын ажил 70 хувьд хүрсэн ч санхүүжилтээс шалтгаалан зогссон байна. 70% 3.ХХААХҮЯам, Азийн хөгжлийн банк (Ядуурлыг бууруулах Японы сан) “Хоршоолсон хэлбэрээр ногооны аж ахуй эрхлэх замаар өрхийн амьжиргаг сайжруулах 9192-MON” төслийн нэгжтэй хамтран төслийг ХХААХҮЯамнаас тодорхойгүй хугацаагаар зогсоосон. 2024 оноос Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор ухаалаг хүлэмжийн аж ахуйг ХУД-ийн 13-р хороонд байрлах НХХААГ-ын ээзмшлийн 8 га газарт байгуулах төслийг БНСУ-ын КОЙКА ОУБ-д санал хүргүүлж, анхан шатны судалгаанд дэмжигдэж, ТЭЗҮ, зураг төслийн ажил хийгдэж байна. Итали улсын ASIA олон улсын байгууллагын буцалтгүй тусламжаар Хүнс, Хөдөө аж ахуйн уян хатан, тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэхэд тариаланчдыг дэмжих төслийг 2025-2026 онд хэрэгжүүлж байна. Тус төсөлд БЗД-ийн 33, 34-р хорооны 30 өрх, СХД-ийн 22, 34, 42-р хорооны 45 өрх, нийт 75 өрх хамрагдаж, гудамж бүрт хутаг гаргаж, хүнсний ногооны үр болон гар багаж зэргийг олгож, үр дүнд нь хүнсний ногоо тариалсан талбайн хэмжээ 0,3 га талбайгаар нэмэгдсэн байна.100%	90%
70.		4.5.2. Дагуул, хаяа хот, тосгодод хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн үйл ажиллагааг бодлогоор дэмжиж, эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлсэн байна.	2021 - 2025	НХХААГ, НМЭГ		1.2020 он 9,208 2.2020 он 5 3.2020 он 0 4.2020 он 248	1. Хориглосон бүсэд байгаа мал 2. Мал эмнэлгийн лабораторийн тоо 3. Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн мал, амьтны гаралтай биологийн хаягдлыг устгаж аюулгүй болгох цогцолборын ТЭЗҮ 4. Мал, амьтнаас хүнд халдварладаг бруцеллёз өвчнөөр өвчилсөн мал	1. 2021-2025 0 2. 2021-2025 9 3. 2021-2025 1 4. 2021-2025 0	-		1.2020 онд мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсэд нийт 9208 толгой мал байснаас 2021-2022 онд 5154 толгой малыг мал аж ахуй эрхлэхийг зөвшөөрсөн бүсэд шилжүүлэн, 2022 оны жилийн эцсийн байдлаар 4054 мал үлдсэн байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 09 дүгээр тогтоолоор Багахангай, Багануур, Налайх дүүргийн төвийн хэсэгт мал аж ахуй эрхлэхийг хориглож, хориглосон бүс 15856.5га талбайгаар, малын тоо 7775 толгойгоор нэмэгдсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар 88 өрхийн 3370 толгой малыг хориглосон бүсээс нэмж гаргаснаар одоо 209 өрхийн 5661 толгой мал хориглосон бүсэд байна. 100% 2.Нийслэлийн хэмжээнд 2020 онд мал эмнэлгийн чиглэлийн 5 лаборатори үйл ажиллагаа явуулж байсан. 2021 онд улсын төсөв, Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр 1.Биохими, 2.Малын эм, хүнд металлын үлдэгдэл тодорхойлох, 2022 онд 1.Молекул биологийн лаборатори, 2023 онд 1.Эмнэл зүйн нян судлалын лабораторийг байгуулан нийт 9 дэд лабораторитой болсон. Эдгээр лаборатори нь 2021-2025 оны байдлаар мал, амьтны гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүн, эмгэгт материалын 306530 дээжид шинжилгээ хийж баталгаажуулалт олгоод байна. 100% 3.Хөнгөн, хүнсний үйлдвэрлэлийн мал, амьтны гаралтай биологийн хаягдлыг устгаж, аюулгүй болгох цогцолборыг Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо Барын аманд байгуулахаар НЗД-ын 2023 оны А/225 дугаар захирамжаар газрын гэрээ, гэрчилгээ, кадастрын зургийг батлуулан газрын үнэлгээ хийлгэсэн. 2025 оны байдлаар байгаль, орчны ерөнхий үнэлгээ хийлгэх зардлын асуудлыг шийдвэрлүүлэхээр Мал эмнэлгийн ерөнхий газарт хүсэлт хүргүүлсэн бөгөөд байгууллагаас шалтгаалах ажлыг бүрэн хийж хэрэгжүүлсэн байна. 100% 4.2021-2023 онд 3094 өрхийн үхрийн сүү, цусны 30882 дээжид бруцеллёзын шинжилгээ хийхэд 167 үнээний сүү, цусны дээжид бруцеллёзын үүсгэгч илэрсэн байна. 2024 онд 10200 дээжийг MNS 5198:2002 стандарт арга зүйн дагуу Роз-бенгалын урвал, ХХУ, Элиза урвалаар шинжлэхэд 11 өрхийн 19 дээж эерэг буюу бруцеллёзтой, 4 дүүргийн 310 өрхийн 5113 үнээний сүүний 12 дээжид бруцеллёзын эсрэгбием илэрсэн. Цус болон сүүний шинжилгээгээр 11 өрхийн 31 дээж бруцеллёзтой гарсан байна. 2025 онд Бруцеллёзын шинжилгээнд цусны 22957 дээж, 1182 өрхийн 14115 үнээний сүүний 1577 дээж авсан. 10%	78%
71.		4.5.3. Хотын стратегийн хүнсний улирлын нөөцийг эрэлт, нийлүүлэлттэй уялдуулан хувийн хэвшлийн оролцоотойгоор бүрдүүлсэн байна.	2021 - 2025	УБЗАА, НХХААГ		2020 он 12,000	Үйлдвэрийн аргаар бэлтгэж, боловсруулсан махны нөөц	2021-2025 20,000	-		Нийслэлийн хүн амын 2021-2025 оны хаврын улирлын махны хэрэгцээ, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор давхардсан тоогоор 89 аж ахуйн нэгж 52132.5 тн мах (жилд дунджаар 10,426тн) бэлтгэн боловсруулж 9 дүүргийн 2252 дэлгүүр, 123 байршилд өргөтгөсөн худалдаа зохион байгуулж зах зээлийн үнээс хямд үнээр худалдан борлуулсан байна. Тухайлбал: 1.2020-2021 онд 28 аж ахуйн нэгж 11,980 тн нөөцийн мах бэлтгэн 9 дүүргийн 169 хорооны 411 хүнсний дэлгүүрээр, 2.2021-2022 онд 23 аж ахуйн нэгж 12,700 тн мах бэлтгэн 9 дүүргийн 468 дэлгүүр, 63 байршилд үзэсгэлэн худалдаагаар, 3.2022-2023 онд 12 аж ахуйн нэгж 7858 тонн мах бэлтгэн 9 дүүргийн 431 хүнсний дэлгүүр, 50 сүлжээ дэлгүүр, 42 байршлын өргөтгөсөн худалдаагаар, 4.2024 онд 7 аж ахуйн нэгж нийт 6198 мян.тн мах бэлтгэн 375 цэгээр худалдаж 100 хувь борлуулалттай ажилласан. 5.2025 онд 10 аж ахуйн нэгж, 8380 тн мах бэлтгэн 9 дүүргийн хэмжээнд 446 цэгээр, өргөтгөсөн худалдааг 18 байршилд зохион байгуулж 6900 тн мах тус тус худалдан борлуулсан. 6.2026 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бэлтгэх 15 аж ахуйн нэгж сонгон шалгаруулалтад тэнцсэнээс 9 аж ахуйн нэгж 5016,5 тн мах бэлтгэн нийлүүлэхээр "Мах бэлтгэх гэрээ" байгуулан бэлтгэл ажилдаа орон ажиллаж байна. Одоогийн байдлаар 2630 тн мах бэлтгэсэн байна.	100%

72.		4.5.4. Үйлдвэрлэл, үйлчилгээний менежментийг сайжруулж стандартад нийцүүлсэн байна.	2021 - 2025	УБЗАА, НХХААГ		1. 2019 он 10/9 2. 2019 он 70	1. ISO 22000, HACCP нэвтрүүлсэн аж ахуйн нэгжийн тоо 2. Тохирлын гэрчилгээтэй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газар	1. 2021-2025 20/19 2. 2021-2025 200	-		1. 2021-2025 онд хүнсний чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгчдэд үйлдвэрлэлийн зохистой дадлыг нэвтрүүлэх, сурталчлан таниулах зорилгоор 1276 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулан 17 удаагийн сургалтыг зохион байгуулсан байна. Үүнд: 2021 онд 9 аж ахуйн нэгжийн 102 ажилтан, мастер технологич, удирдах албан тушаалтнууд, 2022 онд 15 аж ахуйн нэгжийн 19 оролцогчид, Нийслэлийн Эрүүл мэндийн газар, Хоол зүй шим судлалын Монголын нийгэмлэг, 7 дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэстэй хамтран хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 795 иргэн, аж ахуйн нэгж, ХХААХҮЯ, Нутгийн захиргааны байгууллага, ТББ болон бусад байгууллагуудтай хамтран 4 удаагийн 245 иргэн, аж ахуйн нэгж, 2024 онд 2 удаагийн сургалтаар нийт 50 аж ахуйн нэгжийн төлөөлөл, 2025 онд 1 удаагийн сургалтаар хүнсний боловсруулах үйлдвэрлэлийн 75 аж ахуйн нэгжид тус тус хүнсний үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлын хялбаршуулан нэвтрүүлэх зааврыг сурталчлан таниулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх сургалтыг зохион байгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгч ажилласан. Нийслэлд “Чанарын менежментийн тогтолцоо ISO22000”, HACCP нэвтрүүлсэн 2021 онд 6 үйлдвэр, 2022 онд 8 үйлдвэр, 2023 онд 14 үйлдвэр, 2024 онд 19 үйлдвэр байна. Мөн хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо ISO22000 нэвтрүүлсэн 13, Эгзэгтэй цэгийн аюултай байдлын хяналтын тогтолцоо (HACCP) нэвтрүүлсэн 14, нийт 46 үйлдвэр, аж ахуйн нэгж байна. 2025 онд Хүнсний аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо болох FSSC 22000 Version 6 олон улсын стандартыг 1 аж ахуйн нэгж нэвтрүүлсэн. 100% 2.Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2018 оны "Жагсаалт журам батлах тухай" 291 дүгээр тогтоолоор "Тохирлын баталгаанд заавал хамруулах бүтээгдэхүүн, үйлчилгээний жагсаалт"-ыг баталсан. "Тохирлын гэрчилгээ"-гээр баталгаажсан худалдаа, үйлчилгээг бодлогоор дэмжих зорилгоор тайлант хугацаанд хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээний газруудыг тохирлын үнэлгээнд хамруулах бодлого зохицуулалтын арга хэмжээ авч ажилласны дүнд тайлант хугацаанд хоол үйлдвэрлэл үйлчилгээний 7, худалдааны буюу ая тухтай дэлгүүрийн тохирлын гэрчилгээтэй 384, нийт 391 ААН шаардлага ханган тохирлын гэрчилгээг авсан байна. 100%	100%
73.	4.6. Олон улсын хотуудтай харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлж, хөрөнгө оруулалт, худалдаа, эдийн засгийн харилцааг нэмэгдүүлнэ.	4.6.1. Бүс нутгийн хотуудтай харилцан ашигтай худалдаа, эдийн засаг болон олон талт хамтын ажиллагааг өргөжүүлсэн байна.	2021 - 2025	НЗДТГ		2020 он -	Хотуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр хийсэн арга хэмжээ	2021-2025 5	-		Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт болох ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцааг өргөжүүлэх ажлын хүрээнд тус улсын хотуудтай худалдаа, эдийн засаг, соёл, боловсрол, эрүүл мэнд, аялал жуучлал зэрэг бүхий л салбарт хамтран ажиллаж, Халх голын байлдаанд ялалт байгуулсны 85 жилийн ойг тохиолдуулан ОХУ-ын Ленинград мужийн Засгийн газартай хамтран Зайсан толгой дахь Зөвлөлтийн дайчдын дурсгалын цогцолборын талбайн тохижилтын ажлыг хийж гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлж, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатарын БНХАУ-ын Ханжоу, Тайжоу, Шанхай, Чифенг, Чөндү, Кунминь хотуудад албан айлчлаын бэлтгэл ажлыг ханган, Харбин, Хөх хотод ногоон байгууламж, хот нийтийн аж ауйн үйлчилгээ, өвлийн аялал жуулчлал, цас, мөс цэвэрлэх технологийг судалж, цаашид хамтын ажиллагааг өргөжүүлэхээр тохиролцов. Бүгд Найрамдах Солонгос Улсын (БНСУ) Кёнсанбүг мужийн Захирагч Ли Чол Ү нь тэргүүтэй төлөөлөгчид 2024 оны 04 дүгээр сарын 17-19-ний өдрүүдэд Улаанбаатар хотод зочилсон бөгөөд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар, Кёнсанбүг мужийн Захирагч Ли Чол Ү нар хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурав. Зүүн хойд Азийн хотуудын өмнө тулгарч байгаа асуудлуудыг хэлэлцэж, харилцан туршлага солилцох, бүс нутгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Зүүн хойд Азийн хотын дарга нарын 6 дахь удаагийн чуулга уулзалтыг “Зүүн хойд Азийн хотуудын тогтвортой хөгжил: Төр, хувийн хэвшлийн түншлэлийг (ТХХТ) дэмжин хэрэгжүүлэх нь” сэдвийн хүрээнд Зүүн хойд Азийн бүс нутгийн 4 улсын (ОХУ, БНХАУ, БНСУ, Япон Улс), 9 хот (Санкт- Петербург, Улаан-Үүд, Бээжин, Чөндү, Далянь, Сөүл, Пусан, Борёон, Мияконожо), Монгол Улс дахь ЭСЯ, олон улсын байгууллагуудын 100 гаруй гадаадын төлөөлөгчдийг хамруулан Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулав. Улаанбаатар хотын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр ОХУ, БНХАУ, АНУ, БНСУ, Япон, Европын Холбооны орнуудын хотуудтай нийт 8 арга хэмжээг зохион байгуулав. 2021-2024 онд гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх чиглэлээр нийт 34 арга хэмжээг зохион байгуулсан. 100%	100%
ТАВ. ЗАСАГЛАЛ												
Зорилго 5. Хөгжлийн төлөөх түншлэлийг бэхжүүлж, иргэдийн оролцоог хангасан, авлигаас ангид, үр нөлөөтэй, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.												**94.1%**
74.	5.1. Нийслэлийн эрх зүйн орчныг эрх мэдэл, захиргааны төвлөрлийг сааруулж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлэх замаар сайжруулна.	5.1.1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хууль, Нийслэл хотын албан татварын тухай хуульд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна.	2021 - 2025	НЗДТГ-ТЗУГ		1.2020 он 0 2.2020 он 0	1.Нэмэлт өөрчлөлт орсон хуулиудын тоо 2.Чиг үүргийн шинжилгээ хийгдсэн байгууллагын эзлэх хувь	1. 2021-2025 4 2. 2021-2025 100	-	-	1.Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг боловсруулан өргөн барьж, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг хүчингүй болгон Монгол улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдөр батлагдсан бөгөөд 2022, 2023, 2024 онуудад нэмэлт, өөрчлөлт орсон. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт дагалдах 32 хуулийн төсөл боловсруулсан бөгөөд үүнд Хотын албан татварын тухай хуулийн шинэчилсэн найруулга багтаж УИХ-аас 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдөр батлагдсан. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх бөгөөд Нийслэл хотын албан татварын тухай хууль тус өдрөөс эхлэн хүчингүй болсонд тооцогдоно. 100% 2. 2021 онд Нийслэлийн өмчит болон аж ахуйн тооцоот 18 байгууллагад чиг үүргийн шинжилгээ хийв. 2022 онд Нийслэлийн Засаг даргад хуулиар олгогдсон чиг үүргийг төлөөлөн хэрэгжүүлж буй хэрэгжүүлэгч 35 агентлагийн чиг үүргийг нийслэлийн Засаг даргад хуулиар олгогдсон 288 дэд чиг үүргийн хүрээнд нарийвчлан тодорхойлох судалгаг хийсэн. 2023 онд нийслэлийн харьяа байгууллагуудын стратеги төлөвлөгөөтэй танилцан мандатын шинжилгээ хийсэн. Байгууллагуудын стратеги төлөвлөгөө дээр хийсэн мандатын шинжилгээнд үндэслэн нийслэлийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоонд дүн шинжилгээ хийн ажиллав. 100%	100%

75.		5.1.2. Аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шат дараалыг бууруулах, зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулсан байна.	2021 - 2025	УБЗАА, НЗДТГ		2020 он 0	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахимжуулах ажлын хэрэгжилт	2021-2025 100	-		Монгол Улсын Ерөнхий сайдын дэргэдэх Зөвшөөрлийн зөвлөлийн 2025 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийн 1.1-д “Зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон захиргааны хэм хэмжээний акт, журмыг хүчингүй болгож, холбогдох мэдээллийг ирүүлэхийг зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллагуудад” үүрэг болгосны дагуу Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам”-ыг шинэчлэн боловсруулж 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулсан. Мөн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Мэдээллийн технологийн газар, И Монгол академи УТҮГ-тай хамтарсан уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, нийслэлийн зөвшөөрөл олгохтой холбоотой үйл ажиллагааг e-mongolia.mn платформд шилжүүлэх процессыг туршиж, нэмэлт хөгжүүлэлт хийх ажлын даалгаврыг боловсруулан хүргүүлээд байна.	85%
76.	5.2. Нийслэл хотын хяналт удирдлагын цогц систем бий болгож, нийслэлийн мэдээллийн сан, өгөгдлийн бүрэн байдал, аюулгүй байдлыг хангаж, нэг эх сурвалж бүхий мэдээлэл, нээлттэй өгөгдлийг бий болгосон байна.	5.2.1. Нийслэлийн алслагдсан 3 дүүргийг цахим мэдээллийн нэгдсэн сан, сүлжээнд холбож, дэд бүтэц сайжирсан байна.	2021 - 2025	НЗДТГ-МТГ		1. 2020 он 6 2. 2020 он 20	1.Нэгдсэн сүлжээнд холбогдсон дүүргийн тоо 2.“Цахим засаглал төсөл”-ийн үйл ажиллагааны хэрэгжилт	1. 2021-2025 9 2. 2021-2025 100	-		1.Улаанбаатар хотын алслагдсан 3 дүүрэг Налайх дүүргийн 8 хороо, Багануур дүүргийн 5 хороо, Багахангай дүүргийн 2 хороо, Сүхбаатар дүүргийн 4 хороодод шилэн кабелын урсгал түрээсийн үйлчилгээ ашиглан интернэт, Улсын бүртгэл, Төрийн сангийн сүлжээний хэвийн найдвартай ажиллагааг хариуцан ажиллаж байна. Скайнэтворкс ХХК-тай байгуулсан шилэн кабелийн түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж хэвийн ажиллагааг хангасан. 100% 2.Цахим засаглалын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. 1.Засгийн газрын их өгөгдөлд суурилсан шийдвэр гаргалт, нэгдсэн мэдээлэл хяналтын системийн шинэ хувилбар дээр Нийслэл цэс нэмж холбогдох байгуллагуудтай хамтран нийслэл хотын шийдвэр гаргалтад нөлөөлөхүйц томоохон системүүдийн мэдээллийг харуулахаар Iframe-р дуудаж харуулах холболтыг хийсэн. Үүнд: Хот байгуулалт, хотын стандартын газраас олгодог барилгын зөвшөөрлийн мэдээлэл, нийслэлийн зам, замын байгууламж, замын хөдөлгөөн, нийтийн тээвэр, боловсролын байгуллагын мэдээлэл, цаг уур, орчны шинжилгээний мэдээлэл, эрүүл мэнд, өргөн хэрэглээний барааны үнэ, Цэцэрлэг, ЕБС хөдөлмөр эрхлэлт, Замын хөдөлгөөний удирдлагын төвийн камерын хяналтын нэгдсэн систем, хотын инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналтын систем, Автотээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын төв зэрэг байгууллагуудын мэдээллүүдийг нэмж холбосон. 2.“Теле камерын нэгдсэн төв байгуулах, авто замыг бүрэн камержуулах” төсөл арга хэмжээний хүрээнд 2024 онд Нийслэл хотод авто замын 176 уулзвар, гарц замуудад нийт 2606 хяналтын камер суурилуулсан. “Теле камерын хяналтын нэгдсэн төв” 2025 оны 02 дугаар сарын 01-ний өдөр ашиглалтад орсон. Улаанбаатар хотын ачаалал ихтэй 7 байршилд хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан камераар зөрчил илрүүлэн ажиллав. 3.“Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем” дээр үзүүлж буй 134 үйлчилгээг И Монгол академи УТҮГ-ын систем И бизнес систем рүү шилжүүлэх хамтарсан ажлын төлөвлөгөө боловсруулан бүртгэлийн бүх үйлчилгээг нэвтрүүлэхэд бэлэн болсон. Тус системийн хүсэлтүүд Имонголиа систем рүү 2026 оны 01 сард багтаан бүрэн шилжихээр төлөвлөгдөж байна. 100%	100%
77.		5.2.2. "Нэг иргэн-Нэг бүртгэл" хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	НЗДТГ		2020 он 20	“Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийн хэрэгжилт	2021-2025 100	-		2021 оны 10 дугаар сарын 13 хүртэлх хугацаанд Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Дүүргийн зарим чиг үүргийг хороодод үе шаттайгаар шилжүүлэх арга хэмжээний хүрээнд 2021 онд 171 хорооноос иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг шилжүүлсэн. Ингэснээр иргэний шинэчилсэн бүртгэлийн үйлчилгээг зөвхөн дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсээс авдаг байсан бол хороодод шилжүүлснээр нийт 171 цэгээс үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, төрийн үйлчилгээг иргэдэд ойртуулан иргэдийн үйлчилгээ авах цаг хугацаа болон зардлыг хэмнэсэн. Мөн Багануур, Хан-Уул дүүрэгт орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр шаардлагатай техник тоног төхөөрөмжүүдийг шинэчилсэн. Нэг иргэн-Нэг бүртгэл” хөтөлбөр нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 314 дүгээр тогтоолоор хүчингүй болсон. “Нэг иргэн-нэг бүртгэл” үндэсний хөтөлбөр хэрэгжиж дуусан.	100%
78.		5.2.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгуллагуудын мэдээллийн аюулгүй байдлыг хангасан байна.	2021 - 2025	НЗДТГ-МТГ		2020 он 20	Цахим аюулгүй байдлыг хангасан хувь	2021-2025 70	-		1.Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/371 дүгээр захирамжийн хүрээнд Хангарди ордны нэг давхрын нийслэлийн дата төвийн систем, сервер болон сүлжээний тоног төхөөрөмжүүдийг Засаг захиргааны 5 дугаар байранд нүүлгэн шилжүүлэх ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн. 2.Шинээр байгуулсан нийслэлийн нэгдсэн Дата төвд зориулалт бүхий 8 рак, 30 физик сервер, 193 виртуал сервер, хадгалах төхөөрөмж, 130 систем, 278 цахим хуудасны мэдээлэл байрладаг бөгөөд тэдгээрийн хэвийн найдвартай байнгын горимоор тасралтгүй ажиллагаат ханган ажиллаж байна. 3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын сервер, дотоод сүлжээ, тоног төхөөрөмжийн найдвартай ажиллагааг ханган, албан хаагчдад техник болон программ хангамжийн туслалцааг давхардсан тоогоор 538 удаа үзүүлж, хэвийн ажиллагааг хангасан.	100%
79.		5.2.4. Улаанбаатар хотын алслагдсан гэр хороолол болон хүн ам ихээр цуглардаг тодорхой бүсүүдийг үе шаттайгаар утасгүй интернетжүүлэх төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	НЗДТГ-МТГ		2020 он 155	Интернетийн утасгүй сүлжээнд холбогдсон цэгийн судалгаа	2021-2025 195	-		Нийслэлийн Засаг даргын Тамгын газар , Кевико ХХК хамтран 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/15 дугаартай “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийг байгуулсан. Уг санамж бичгийн хүрээнд нийслэлийн Баянгол, Баянзүрх, Чингэлтэй, Налайх, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн 160 цэцэрлэгт аюулгүй, найдвартай интернэтийн сүлжээ, утасгүй сүлжээний орчин бий болгох ажлыг хийхээр төлөвлөсөн бөгөөд 2025 оны 09 дүгээр сарын 1-ний өдөр холболт хийсэн байхаар ажлын хуваарь гарган ажиллаж байна. 2024 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Баянзүрх, Сонгинохайрхан дүүргийн нийт 39 цэцэрлэгийг интернэтийн сүлжээнд холбосон ба бусад байршлуудад дэд бүтэц байгуулах ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна.	97.50%

80.	5.3. Мэргэшсэн, чадварлаг, иргэндээ үйлчилдэг, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	5.3.1. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад болон олон улсын чанарын менежментийн тогтолцоо, стандартыг нэвтрүүлсэн байна.	2021 - 2025	НХСХГ, НЗДТГ		2020 он 2	Олон улсын чанарын менежментийн тогтолцоо "ISO9001:2016, MNS ISO 18091" стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлж баталгаажуулалт хийгдсэн байгууллагын тоо	2021-2025 34	-		Олон улсын чанарын менежментийн тогтолцоо "ISO9001:2016, MNS ISO 18091" стандартыг нийслэлийн нутгийн захиргааны байгуллагын үйл ажиллагаанд нэвтрүүлж баталгаажуулалт хүрээнд 20 байгуллагын нийт 150 гаруй албан хаагчийг дотоод аудитор бэлтгэх тусгай сургалтад хамруулж, MNS ISO 9001:2016 стандартын дагуу дотоод аудиторын гэрчилгээ олгосон. Нийслэлийн Засаг даргын 2024 оны "Нийслэлийн хэмжээнд засаглалын үзүүлэлтийг тооцох, чанарын удирдлагын тогтолцооны MNS 180 9001:2016 стандартын баталгаажуулах ажлыг зохион байгуулах тухай" А/1041 дүгээр захирамжаар эрх шилжсэн НХААГ/20240103580 дугаартай "Нийслэлийн нутгийн захиргааны зарим байгуллагуудад MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулалт хийлгэх нээлттэй тендер зарлаж, "ЭС ЭФ СИ ЭС" ХХК, Менежмент ба ур чадварын хүрээлэн шалгарсан. Тус нээлттэй тендерийн хүрээнд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сард "Гэрээ байгуулах тухай" 03/198, 03/199 дугаар албан бичиг ирүүлснийг үндэслэн Менежмент ба ур чадварын хүрээлэн ТББ-тай гэрээ байгуулж, MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартын дотоод аудит болон баталгаажуулах ажлыг нийт 21 байгууллагад нэвтрүүлэхээс 3 газар татан буугдаж 18 байгууллага баталгаажилтын гэрчилгээ авсан.	100%
81.		5.3.2. Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НАГ,НЗДТГ		1. 2017 он 3.17 2. 2017 он 20 3. 2017 он 0 4. 2017 он 21	1.Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн үнэлгээ 2. Архивын шинэ барилгын бүтээн байгуулалтын хувь 3.Нийслэлийн түүх, соёлын өвийг хамгаалах, түүхэн ой санамжийг баяжуулж, түгээн дэлгэрүүлнэ. 4.Архивын цаасан болон тусгай төрлийн баримтын эзлэх хувь	1. 2021-2025 4 2. 2021-2025 100 3. 2021-2025 100 4. 2021-2025 52.5	-		1.Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөс Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилгоор жил бүр хэрэглэгчийн судалгаа авч, үр дүнг сайжруулах арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэн ажиллалаа. Судалгааны дүнгээр 2021-2023 онд нийт 16,498 иргэдээс судалгаа авч үнэлгээний дундаж 94.01 хувьтай үнэлэгдсэн. Мөн 2023 онд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үзүүлж буй үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг хэрэглэгчийн хүлээлт ба бодит байдлын харьцаагаар хэмжих Servqual аргын 5 хэмжүүр үзүүлэлтийн хүрээнд "Мэргэжлийн социологичдын холбоо"ТББ-тай хамтран асуулга боловсруулан үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс түүврийн аргаар судалгаг авсан. Судалгааны дүнгээр 94 хувь нь сайн, 4 хувь нь дунд, 2 нь муу үнэлгдсэн бөгөөд үнэлгээг үндэслэн тусгай хэрэгцээт үйлчлүүлэгчдэд шаардлагатай зүйлсийг шийдсэн байх асуудалд анхаарч дохионы хэлний сургалт зохион байгуулах мөн үйлчилгээ авах таатай орчныг бүрдүүлэх чиглэлээр арга хэмжээг авч ажилласан. 2024 онд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авч буй 1,658 иргэн, хуулийн этгээдээс санал асуулга авч холбогдох байгууллагуудад төрийн үйлчилгээг сайжруулах арга хэмжээ авах чиглэл хүргүүлэн ажилласан. 2025 онд иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр төлөвлөгөө батлан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны 20 байгууллагаас үйлчилгээ авч буй 6,187 иргэдээс 2 удаагийн сэтгэл ханамжийн судалгаг цахимаар авсан. 100% 2.Архивын зориулалтын барилгыг 2020 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр эхлүүлж, барилгын суурийн цутгалт, дулааны холболт, цахилгааны дэд өртөөний байгууламж, холболтын ажлыг бүрэн хийж дуусгасан. Цар тахалтай холбоотойгоор Нийслэлийн төсвөөс дахин санхүүжилт хийгдэхгүй тул цаашид барилгыг үргэлжлүүлэх боломжгүй 5 жил өнжсөн. Улмаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд Сүхбаатар дүүрэг дэх архивын барилгын газар нь "Загвар гэр хороллын төсөл"-тэй давхардсан, хөрсний ус, цэвдэг ихтэй тул архивын зориулалтын барилга барихад тохиромжгүй гэсэн шалтгаанаар байршлыг өөрчлөх шийдвэр гаргасан. Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Архивын барилга барих газрын шинэ байршлыг Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 5000 м.кв газар олгохоор тусгаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит бус II дугаар чуулганаар хэлэлцэж баталсан. Гэвч Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас шинээр олгох газрын байршилд давхцал үүссэн тул барилгын газрын асуудал шийдвэрлэгдээгүй байна. *(Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 6.6. дахь хэсэгт заасан "Давагдашгүй хүчин зүйлийн улмаас бодлогын баримт бичгийн хэрэжих хугацааг сунгасан бол биелэлтийг үүйцэтгэлд тулгуурлан тооцно")* 100% 3.Нийслэлийн түүх, соёлын өвийг хамгаалах, түүхэн ой санамжийг баяжуулж, түгээн дэлгэрүүлэх хүрээнд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Тухайлбал Үндэсний төв архивын сан хөмрөгөөс Их Хүрээ, Нийслэл Хүрээ, Улаанбаатар хотын түүхэнд холбогдох 1911-1999 оны 1,428 цаасан суурьт баримт, 22 баримтад кино, 674 гэрэл зургийг цахимаар хуулбарлан авч олон нийтэд түгээн дэлгэрүүлэх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Их хотын баримтат өв "UB weekly" нийтлэлийг 2021 оны 7 сараас эхлэн пүрэв гараг бүр байгууллагын веб сайт, пэйж хуудсанд 239 удаа нийтэлж сурталчилж, 6 төрлийн үзэсгэлэн, 2 удаагийн эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулж "Нийслэл Хүрээ 110" Архивын баримт, гэрэл зургийн биет үзэсгэлэн зохион байгуулсан. Үндэсний төв Архиваас хуулбарлан авсан Нийслэл Хүрээний түүхэнд холбогдох 1911-1924 оны 654 баримтын 3270 хуудсыг кирилл бичигт хөрвүүлж судалгааны эргэлтэд оруулсан. "Нийслэл хүрээний түүхэнд холбогдох баримт бичгүүд" (1911-1921 он) эмхэтгэлийн I ботийн эхийг бэлтгэж хэвлэлд шилжүүлэхэд бэлтгэсэн. 100%	100%
82.		5.3.3. Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёлыг төлөвшүүлнэ.	2021 - 2025	НЗДТГ		2020 он 50	Төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, иргэдийн итгэлийг хүлээсэн үйлчилгээний соёлыг дүгнэсэн үйл ажиллагааны хэрэгжилт	2021-2025 100	-		Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төв (НҮНТ)-ийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд: 1.НҮНТ салбарууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авахад зориулсан налуу зам, авто зогсоол, тэргэнцэртэй бөгөөд Баянгол, Мишээл салбарт харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан харааны шил, таягийг шинээр байршуулж, 6 салбарт брайль үсэгтэй Төрийн үйлчилгээний жагсаалтыг товхимол хэлбэрээр хэвлүүлэн ашиглаж байна. 2.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг цаасан болон цахим хэлбэрээр авч хэвшсэн бөгөөд үнэлгээд тулгуурлан тухай бүр үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөлийг сайжруулах, үйлчилгээний шат дамжлага, хүнд суртлыг бууруулах, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн цахимжуулах үйлчилгээний судалгаг гарган холбогдох байгууллагад хүргүүлэх зэрэг ажлыг зохион байгуулан ажилласан. 3.ЦХХХ-ны Сайдын 2023 оны А/13 дугаар тушаалаар баталсан Брэнбүүкийг НҮНТ-ийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн бөгөөд 2023 онд Мишээл салбар, 2024 онд Драгон салбар, 2025 онд Яармаг салбарт тус тус нэвтрүүлсэн. 4. НҮНТ нь МУ-ын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар баталсан "Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны журам", Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/01 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан "Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны түр журам", Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 7068:2025, Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 6984:2022, Монголын Улсын Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолоор 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам" зэрэг журам, стандартыг үйл ажиллагаанд нэвтрүүлэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

83.	5.4. Хүний эрхийг хамгаалах чиглэлд иргэн, төр, хувийн хэвшлийн түншлэлийг бэхжүүлж, оролцоог хангана.	5.4.1. Бүх нийтийн оролцоог хангасан, үр нөлөөтэй, хариуцлагатай, чадварлаг, институцийг бүх шатанд бий болгож, иргэдийг аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлөөр хангана.	2021 - 2025	НСГ, НЦУГ, НГБХЗХГ		1.2018 он 0.47 2.2018 он 57 3.2018 он 652 4.2018 он 263 5.2018 он 76.1 6.2018 он 6,729 7.2018 он 17,465 8.2018 он 646	1.Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 2.Хараа хяналтгүй хүүхдийн тоо 3.Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тоо 4.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо /16 ба түүнээс дээш нас/ 5.Нийт яллагдагчаар татагдсан хүмүүст шүүхээр ял шийтгүүлсэн хүний эзлэх хувь 6.Ял шийтгүүлсэн хүний тоо 7. Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 8. Хулгайлах гэмт хэргийн тоо	1.2021-2025 0.2 2. 2021-2025 25 3. 2021-2025 281 4. 2021-2025 180 5. 2021-2025 84.9 6. 2021-2025 4364 7. 2021-2025 10868 8. 2021-2025 456	-		1.Нийслэлийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар хүн худалдаалах 10 гэмт хэрэг бүртгэгдсэн ба 100.000 хүн тутамд 0.17 хохирогч ногдож байна.100% 2.2020 онд хараа хяналтгүй хүүхэд 100.000 хүнд ногдох түвшин 6 хувь, 2021 онд 0, 2022 онд 2 хувь, 2023 1.1 хувь, 2024 онд 0 байна, 2025 онд 10 байна. 100%. 3.2021 онд Хүчирхийлэлд өртсөн хүүхэд 130, 2022 онд Нийслэлийн хэмжээнд бие махбод, үл хайхрах, сэтгэл санаа, гэр бүлийн хүчирхийллийн улмаас хохирсон 184 хүүхэд, 2023 онд Хүүхдийн эрхийн хууль зүйн хороонд бүртгэгдсэн хүчирхийллийн хохирогч 185 хүүхэд бүртгэгдсэн. 2024 онд Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 106 хүүхэд хохирсон байна. 100% 4.Нийслэлд 2025 онд 33144 гэмт хэрэг бүртгэгдсэн ба 16 ба түүнээс дээш насны 10.000 хүн тутамд 300 гэмт хэрэг ногдож байна. 0% 5.Улсын хэмжээнд 2021 онд 18078 хүн гэмт хэргийн яллагдагчаар татагдсанаас 11263, 2022 онд 23665 гэмт хэргийн яллагдагчаар татагдсанаас 14394, 2023 онд 24134 гэмт хэргийн яллагдагчаар татагдсанаас 14204, 2024 онд 25291 хүн гэмт хэргийн яллагдагчаар татагдсанаас 14663 хүн шүүхээр ял шийтгүүлсэн. Нийт яллагдагчаар татагдсан хүмүүст шүүхээр ял шийтгүүлсэн хүний эзлэх хувь дунджаар 60 хувийг эзэлж байна. 0% 6.Нийслэлийн хэмжээнд 2021 онд 6277, 2022 онд 8033, 2023 онд 7695, 2024 онд 7596 хүн шүүхээр ял шийтгүүлсэн байна. 100% 7.Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэргийн тоо 2025 оны жилийн эцсийн байдлаар 22547 байна. 0% 8.2025 онд хулгайлах 5379 гэмт хэрэг бүртгэгдсэн байна. 100.000 хүн тутамд 324 гэмт хэрэг ногдож байна.100%	62.50%
84.	5.5. Шударга ёсыг эрхэмлэн бэхжүүлэх замаар авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлийн гэмт хэргийг бууруулна.	5.5.1. Шударга, хариуцлагатай, ил тод, нийтийн албыг бэхжүүлж, авлигын бүх хэлбэрийг таслан зогсоож, хяналтыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	НЗДТГ-ТЗУГ		2020 он 67.7	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын шударга байдлын үнэлгээ	2021-2025 85	-		2024 онд Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын гадаад шударга байдлын үнэлгээ 2020 онд 63.6 оноогоор үнэлэгдэж байсан бол 2024 онд 64.4 оноогоор үнэлэгдэж 0.8 оноогоор өссөн үзүүлэлттэй, дотоод шударга байдлын үнэлгээ 2020 оны 72.7 оноогоор үнэлэгдэж байсан бол 2024 онд 80.1 оноогоор үнэлэгдэж 7.4 оноогоор өссөн үзүүлэлттэй, шударга байдлын үнэлгээ 72.3 оноогоор үнэлэгдсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны Шударга байдлын үнэлгээний судалгааг 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдөр хүртэл 14 хоногийн хугацаанд А1 маягтаар 180 иргэн, А2 маягтаар 80 албан хаагч, А3 маягтаар 20 бодлогод оролцогч, шинжээчид зэрэг нийт 280 судалгааг авч "Бодлогын шийдэл" ТББ-д хүлээлгэн өгсөн.	85%
85.		5.5.2. Төрийн байгууллага, албан тушаалтныг авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангана.	2021 - 2025	НЗДТГ-ТЗУГ		2020 он 60.7	Авлигын индекс	2021-2025 79.4	-		Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын авлигын индекс 2020 онд 73.7 оноогоор үнэлэгдэж байсан бол 2024 онд 78.9 оноогоор үнэлэгдэж 5.2 оноогоор өссөн үзүүлэлттэй, авлигын эрсдэлийн индекс 2020 оны 62.9 оноогоор үнэлэгдэж байсан бол 2024 онд 49.9 оноогоор үнэлэгдэж 13 оноогоор буурсан үзүүлэлттэй байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/393 дугаар захирамжаар батлагдсан "Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-ний 2.1-д заасан “Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 05-04/529 дугаартай гэрээг “Олон нийтийн хяналт хэрэгжүүлэгч хуульт ёс судалгааны төв” НҮТББ-тай байгуулан, хамтран ажиллаж байна. Мөн "Нийслэлийн хэмжээнд хэрэгжүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны 2025 оны төлөвлөгөө"-ний 2.2-д заасан "Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх" хүрээнд Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 05-04/528 дугаартай гэрээг "Оператив" НҮТББ-тай байгуулан, хамтран ажиллаж байна.	99%
ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ												
Зорилго 6. Байгалийн нөөцийг хамгаалж, экологийн тэнцвэрт байдлыг хангах замаар хүрээлэн буй орчны доройтлыг бууруулж, уур амьсгалын өөрчлөлтөд												**92.6%**
86.	6.1. Байгалийн нөөцийг хадгалж, хамгаалан, нөхөн сэргээнэ.	6.1.1. Орон нутгийн хамгаалалттай газар нутгийн хэмжээг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НБОГ, НХБХГ, НГЗБА		1.2020 он 29.2 2.2020 он 0	1. Нийслэлийн нутаг дэвсгэрт тусгай хамгаалалттай газар нутгийн эзлэх хувь 2. Тусгай хэрэгцээнд авсан экологийн коридор байгуулах газар	1. 2021-2025 30 2. 2021-2025 7	-	-	1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 24/18 дугаар тогтоолоор Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хороонд 5926 га газар, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт А, Б хэсэг бүхий 14429 га газар нийт экологийн коридор байгуулах 2 байршилд 20345 га талбайг орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан. 2025 оны байдлаар улсын тусгай хэрэгцээний газар 42 байршлын 85989.1 га талбай, орон нутгийн тусгай хэрэгцээний газар 69 байршлын 90104.72 га талбай буюу нийт Нийслэлийн нутаг дэвсгэрийн 37,3 хувийг эзэлж байна. 100% 2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 24/18 дугаар тогтоолоор Биологийн олон янз байдлыг хамгаалах, тоо толгой өсгөх, шилжилт хөдөлгөөн генетик солилцоог дэмжих, байгаль экологийн тэнцвэрт байдлыг хадгалах зорилгоор Баянзүрх дүүргийн 11, 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх 5926 га газар, Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх 14419 га газар, нийт 20345 га талбай бүхий экологийн коридорын хамгаалалтын бүсэд хамаарах газрыг орон нутгийн тусгай хэрэгцээнд авч, хил заагийг нэгдүгээр, хамгаалалтын дэглэм, горимыг хоёрдугаар хавсралтаар тус тус батлсан. Орон нутгийн тусгай хэрэгцээнд авсан нийт 3 байршлын 20,345 га талбай бүхий экологийн коридорын хамгаалалтын бүсийн хил заагийг газрын кадастрын нэгдсэн систем Лэнд менежер программын “Орон нутгийн тусгай хэрэгцээний газар” давхаргад бүртгэсэн. 70%	85.0%

87.		6.1.2. Нийслэлийн ногоон бүсийн ойн сангийн хомсдол, доройтлыг бууруулна.	2021 - 2025	НБОГ		3.2020 он 20.1 4.2020 он 67 5.2020 он 13 6.2020 он 80,000 7.2020 он 0 8.2020 он 9.6	3.Ойгоор бүрхэгдсэн газрын нийт газар нутагт эзлэх хувь 4.Ойжуулалт нөхөн сэргээлт хийсэн талбай 5.Ойн сангийн доройтолд орсон талбайд иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр тарьж ургуулсан төгөл 6.Ойн хөнөөлт шавж, өвчний тархалтын судалгаа хийсэн талбай 7.Судалгааны дүнд үндэслэн тэмцлийн ажлыг зохион байгуулсан талбай 8. Сэргээсэн ойн түймрийн зурвас	3.2021-2025 21 хувь 4.2021-2025 617 га 5.2021-2025 28 га 6.2021-2025 480,000 га 7.2021-202 25,000 га 8.2021-2025 34 га	-	-	3.2021-2025 онд нийт 528.4 га талбайд ойжуулалт, ой нөхөн сэргээлтийг хийсэн. Ойжуулсан талбайг холбогдох хууль журамд заасны дагуу 10 жилийн дараа ойн санд хүлээн авдаг бөгөөд нийслэлийн нутаг дэвсгэрийн ойн санд 2016 онд ойн тооллого, ой зохион байгуулалт хийгдсэн. Ойн тухай хуульд заасны дагуу 10 жилийн давтамжтайгаар ойн тооллого, ой зохион байгуулалтыг 2026 онд хийнэ. 100% 4.2021-2025 онд 528.4 га талбайд ойжуулалт нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн. 2025 онд ойжуулалт ойн нөхөн сэргээлтийн 28 га талбайд, жижиг гол, горхины эх, татмыг ойжуулахаар 4,4 га талбайд, байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээг 67 га талбайд, нийт 99,4 га талбайд ойжуулалт ойн нөхөн сэргээлтийн тус тус гүйцэтгэсэн. 85.6% 5.Ой модны сургалт судалгааны хүрээлэн Баянзүрх дүүргийн Улиастай аманд 5 га талбайд ойг нөхөн сэргээх ажлыг Тэрбум сангийн хөрөнгөөр 2025 оныг хүртэл хугацаанд 10000 ширхэг бортогтой тарьц суулгац, “Бүжгар адуу” ХХК 3 га талбайд 7500 ширхэг шилмүүст модны тарьцаар ойжуулалтыг тус тус гүйцэтгэсэн. Инчон хотын санхүүжилтээр “НҮРИ” ХХК 2018-2024 онуудад 7 дахь жилдээ 132,000 мод тарьж ургуулсан бөгөөд 2025 оны хаврын улиралд 10,000 ширхэг шинэс модны тарьцыг 7 га талбайд тарьж, арчилгаг хийж байна. Амьдралтын хувь 95 хувьтай үнэлэгдсэн.100% 6.Нийслэлийн ногоон бүсэд ойн хөнөөлт шавжийн тархалт, голомт нягтшилын судалгааг 2021-2025 онд нийт 400.0 мянган га талбайд ойн мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн. 2025 онд Нийслэлийн ногоон бүсэд ойн хөнөөлт шавж, өвчний голомтолсон тэмцлийн ажил гүйцэтгэх шаардлагатай талбайн хэмжээг тогтоох судалгаа хийх гүйцэтгэгч байгууллагыг сонгон шалгаруулж гүйцэтгэгчээр "Нямын өндөр" ХХК шалгарч, судалгааны ажлыг нийслэлийн ногоон бүсийн ойгоор бүрхэгдсэн 80,000 га талбайд хийж гүйцэтгэсэн. 100% 7.Нийслэлийн ногоон бүсэд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлыг судалгаанд үндэслэн жил бүр төлөвлөн зохион байгуулж байна. 2021 онд 3033 га, 2022 онд 6602 га, 2023 онд 8099 га, 2024 онд 10765 га, 2021-2024 онд нийт 28,499 га талбайд тэмцлийн ажлыг нийслэлийн болон улсын төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн байна. 2025 онд Нийслэлийн ногоон бүсэд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлын гүйцэтгэгчээр ойн мэргэжлийн байгууллага болох "Хатант форест" ХХК шалгарч нийслэлийн 6793 га талбай ногоон бүсэд үүргийн шүршигч багаж ашиглан микробиологийн аргаар гэрээний ажлыг хийж гүйцэтгэсэн. 100% 8.Ойн түймэр тархах нөхцөлийг бууруулах зорилгоор 2021-2025 онд нийт 2 байршилд 20.5 га талбайд ойн түймрээс сэргийлэх зурвасыг сэргээсэн. 2025 онд Улаанбаатар хот, Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэх хил дагуу нийт 1.5 км урттай (6.0 га) зурвасыг сэргээх ажлыг ойн мэргэжлийн байгууллага "Сайхан санаа" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг гүйцэтгүүлсэн. 100%	97.60%
88.		6.1.3. Амьтан, ургамлын төрөл зүйлийг нутагшуулан хамгаалж, нөхөн сэргээсэн байна.	2021 - 2025	НБОГ		1. 2020 он 38 2. 2020 он 0	9. Туул голд нутагшуулсан минж 10. Хамгаалалтад авч нөхөн сэргээсэн ургамлын зүйл	1. 2021-2025 125 2. 2021-2025 3	0	0	9.2021-2025 онуудад Төв аймгийн Эрдэнэ сумын Босгын гүүрнээс дээш Хан Хэнтийн УТХГ-ын байгаль хамгаалагчийн пост, Галтай, Булнайн орчим туул голын бэлчирд өвөлжөө болон айлаас алс газарт 20 бүлийн 49 бодгаль минжийг байгальд нутагшууллаа. 70% 10.Улаанбаатар хот орчимд байгалийн ургамлыг тарималжуулах чиглэлийн мэргэжлийн эрх бүхий аж ахуйн нэгж байгууллага болох "Эмийн үйлдвэр" ХХК, "Богдхан уулын байгалийн цогцолбор төв" ТББ-ууд “Ховор ургамлын жагсаалт”-д багтсан Дэрвэгэр жиргэрүү (Saposhnikovia divaricate), Монгол хунчир (Astragalus mongolicus), Чихэр өвс (Glycyrrhiza uralensis), Монгол бүйлс (Onosma transrhymnense Pulicaria prostrata), нэн ховор ургамлын жагсаалтад багтсан Алтан гагнуур (Rhodiola Rosea) зэрэг байгалийн ургамлыг үрээр тарималжуулж байна. 100%	85.00%
89.		6.1.4. Байгаль хамгааллын үйл ажиллагаанд иргэдийн оролцоо нэмэгдсэн байна.	2021 - 2025	НБОГ		2020 он 57	Идэвхтэн байгаль хамгаалагч	2021-2025 132	190.8	190.8	Нийслэлийн хэмжээнд 2021 онд 80, 2022 онд 40, 2023 онд 60, 2024 онд 60, 2025 онд 60 морин эргүүл идэвхтэн байгаль хамгаалагч, морин эргүүлийг авч ажиллуулсан.	100%
90.	6.2. Орчны бохирдлыг багасгаж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.	6.2.1. Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр бүрэн хангаж, агаарын бохирдлыг бууруулсан байна.	2021 - 2025	НАБТГ		1. 2020 он 99 2. 2020 он 64 3. 2020 он 141	1.Сайжруулсан түлшээр хангагдсан хороо 2. PM 2.5 тоосонцрын дундаж агууламж 3. PM10 тоосонцрын дундаж агууламж	1. 2021-2025 114 2. 2021-2025 40 3. 2021-2025 88	102,911.00	2025-2026 оны халаалтын улиралд 20,340.7	1.Нийслэлийн 7 дүүргийн гэр хорооллын айл өрхийг сайжруулсан түлшээр тасралтгүй хангах ажлын хүрээнд 2022 2025 оны халаалтын улиралд нийт 1,488,429 тонн шахмал түлш борлуулсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1405 дугаар захирамжийн дагуу нийслэлийн 7 дүүргийн 121 хороонд 425 борлуулалтын цэгээр иргэдэд шахмал түлш борлуулж түлшээр тасралтгүй хангаж ажилласан. 100% 2.Нийслэлийн хэмжээнд хүйтний улирлын агаар дахь PM2.5 тоосонцрын агууламж 2021 оны 60 мкг/м3, 2022 онд 65 мкг/м3, 2023 онд 61 мкг/м3, 2024 онд 63 мкг/м3 байсан бол 2025 онд 53 мкг/м3 хүрч буурсан байна. 45% 3.Нийслэлийн хэмжээнд хүйтний улирлын агаар дахь PM10 тоосонцрын агууламж 2021 онд 107 мкг/м3, 2022 онд 122 мкг/м3, 2023 онд 107 мкг/м3, 2024 онд 101 мкг/м3 үзүүлэлттэй байсан бол 2025 онд 106 мкг/м3 болж буурсан. 66%	70%
91.		6.2.2. Агаарын чанарын хяналтыг сайжруулсан байна.	2021 - 2025	НАБТГ		1. 2020 он 0 2. 2020 он 6 3. 2020 он 2	1.Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийг судалж, шинжлэх иж бүрэн лаборатори 2. Нийслэлийн агаарын бохирдлыг хянах суурин станц 3. Агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн аян зохион байгуулах	1. 2021-2025 1 2. 2021-2025 9 3. 2021-2025 10	-		1.2022 онд Нийслэлийн Агаар, орчны бохирдолтой тэмцэх газрын дэргэдэх Агаарын чанар хяналтын лабораторийг олон улсын MNS ISO/IEC 17025:2018 стандартын шаардлагыг хангасан лаборатори гэж итгэмжлэгдэж 2022 оны 04-р сарын 28-ны өдөр TL 176 дугаартай Итгэмжлэлийн гэрчилгээ авч 2025 онд гэрчилгээг сунгуулсан. Агаар бохирдуулагч эх үүсвэрүүд, хатуу түлшний хэмжилт хийх иж бүрэн лабораторийн барилгыг Хан-Уул дүүргийн 10-р хороонд барихаар бэлтгэл ажил бүрэн хангагдсан байсан боловч 2025 онд лабораторийн зураг төсөл хийх нийслэлийн санхүүжилт татагдсанаар тус ажлын хэрэгжилт удааширсан байна. 100% 2.2022 онд Орчны чанарын хяналтыг сайжруулах ажлын хүрээнд Цаг уур орчны шинжилгээний газар БЗД-ийн 9-р хорооны СЭМҮТөвийн орчим, НД-ийн 7-р хороонд Франц улсад үйлдвэрлэгдсэн ENVIRONMENTAL-SA маркийн орчны агаарын чанарыг 13 үзүүлэлтээр тодорхойлох 2 суурин харуулыг суурилуулсан. 2025 онд Япон Улсын буцалтгүй тусламж “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд агаарын чанарын хэмжилтийн суурин харуулын тоног төхөөрөмжийг шинэчлэх 275 сая иен буюу 6,8 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан.Тус ажлын хүрээнд Японы Олон улсын хамтын ажиллагааны систем (JICS)-ийн төлөөлөгчид худалдан авалтын бэлтгэл хангах зорилгоор 5 удаагийн уулзалт зохион байгуулж, 5 суурин харуулын тоног төхөөрөмжийн ажиллагааг шалгах, одоо ашиглагдаж буй сүлжээний нөхцөл байдал, теслийн өгөгдөл дамжуулах боломжийн талаар хэлэлцэж, мөн лабораторид ашиглагдаж буй тоног төхөөрөмжийг танилцуулж ажилласан. 89% 3.Агаар, орчны бохирдлыг бууруулахад олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, зөв дадал хэвшилд сургахад чиглэсэн мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн аяны хүрээнд нийт 30,200,000 төгрөгийн санхүүжилтээр контент, зар мэдээллийн 16 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. 100%	96.30%

92.		6.2.3. Улаанбаатар хотын хог хаягдлыг ангилан ялгаж, цуглуулж тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологийг нэвтрүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар төвлөрсөн цэгт дарж булагдах хог хаягдлын хэмжээг бууруулна.	2021 - 2025	УБЗАА		1. 2019 он 11.4 2. 2019 он 85	1. Ангилан ялгаж, дахин боловсруулалтад орсон хог хаягдлын өсөлтийн хэмжээ, хувь 2.Төвлөрсөн хогийн цэгт дарж булагдсан хог хаягдлын хэмжээний бууралт, хувь	1. 2021-2025 50 2. 2021-2025 75	-	-	1.Нийслэлийн хэмжээнд энгийн хог хаягдлыг дахин боловсруулах 27 үйлдвэр үйл ажиллагаа эрхэлж байна. Эдгээр үйлдвэрүүдийн дийлэнх хувийг хуванцар дахин боловсруулах үйлдвэр эзлэж байгаа бөгөөд картонон цаас, хөнгөн цагаан, дугуй, хаягдал тос, гялгар уут зэргийг дахин боловсруулан хоёрдогч түүхий эд бэлтгэн зах зээлд нийлүүлж байна. Эдгээр үйлдвэрүүд жилд дунджаар 300.0 мянган тонн хог хаягдлыг дахин боловсруулж байна. Энэ нь нийт хог хаягдлын 23 хувийг эзэлж байна. 46% 2.Улаанбаатар хотын хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын болон бусад үйл ажиллагаанаас гардаг аюултай хог хаягдлыг дахин боловсруулдаг болон устгадаг 10 аж ахуйн нэгж тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас хариуцсан чиг үүргийн хүрээнд аюултай хог хаягдал үүсгэгчээр бүртгүүлэх хүсэлт ирүүлсэн 181 байгуллагуудыг хог хаягдлын мэдээллийн санд бүртгэн хяналт тавьж ажиллаж байна. Нийслэлийн хэмжээнд 2020-2023 онуудад жилд дунджаар 1.2-1.5 сая тонн ахуйн хог хаягдал гарч төвлөрсөн хогийн цэгүүдэд дарж булшилж байна. 2024, 2025 онуудад нийслэлийн хүн амын болон ахуйн хэрэглээний өсөлт, хог хаягдлын цэвэрлэгээ, тээвэрлэлтийн үйлчилгээ сайжирч байгаатай холбогдуулан хог хаягдлын хэмжээ эрс нэмэгдэж байна. 2024 онд 1.7 сая тонн, 2025 оны эхний 10 сарын байдлаар 1.7 сая тонн хог хаягдал төвлөрсөн хогийн цэгүүдэд ирсэн. Үүний 11,5 хувийг дахин боловсруулж байгаа болов ч дахин боловсруулж байгаа хог хаягдлын бүртгэл мэдээллийн нэгдсэн системгүй учир үүнээс их хэмжээгээр хог хаягдлыг дахин боловсруулж, хаягдлын хэмжээг бууруулсан байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 онд 74 тэрбум төгрөгийн худалдан авалт зохион байгуулж 167 машин механзмаар парк шинэчлэл хийгээд байна. Мөн хог хаягдлын салбарт ажилладаг ажилтнуудын цалин урамшууллын асуудлыг шийдвэрлэж 3,5 сая төгрөг хүргэсэн нь ажиллах хүчний хомсдол шийдэгдсэн байна. 100%	73%
93.		6.2.4. Хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, олон жил хог дарж булсан ландфилын талбайг үе шаттайгаар хэсэгчлэн хааж, нөхөн сэргээлт хийнэ.	2021 - 2025	УБЗАА		2019 он 12	Хаалт хийж нөхөн сэргээсэн ландфилын талбайн хэмжээ	2021-2025 56	-	-	Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2025 оны А/45 дугаар “Үнэлгээний хороо байгуулах тухай” тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдан Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгийг нөхөн сэргээх ажилд "Улаанбаатар шинэчлэл ХХК", Нарангийн энгэрийн нөхөн сэргээх ажилд "Гранд зевс" ХХК гүйцэтгэгчээр шалгаран нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийт төвлөрсөн 3 хогийн цэгт 47,2 га талбайг нөхөн сэргээсэн байна. Үүнд нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Сонгинохайрхан дүүргийн 36-р хорооны нутаг дэвсгэрт орших Нарангийн энгэрийн төвлөрсөн хогийн цэгийн 27 га, Баянзүрх дүүргийн 24-р хорооны нутаг дэвсгэрт орших Цагаан давааны төвлөрсөн хогийн цэгийн 14 га, Хан-Уул дүүргийн 12-р хороо Морингийн давааны төвлөрсөн хогийн цэгийн 3 га, мөн тухайн байршилд Европын сэргээн босголт хөгжлийн банкны санхүүжилтээр 3.2 га талбайг хэсэгчлэн хааж нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэлээ. Нөхөн сэргээлтийн талбайн хаалтыг хийхдээ 70-100см-ын зузаантай хадархаг чулуун хөрс, хамгийн дээд давхаргад нь үржил шимтэй 20 см хар шороон хөрсөөр хучилт хийн олон наст зүлэг тарьсан. Монгол орны нөхцөлд тэсвэртэй, ургалт сайтай Хайлаас модыг зүлэгжүүлсэн талбайн зах хязгаараар ургамлан хашлага хэлбэрээр суулгаж тарих бөгөөд энэхүү ногоон байгууламжийн арчилгааны ажлыг гүйцэтгэч компани 2 жилийн хугацаанд хариуцаж, мод, зүлэгний нөхөн тарилтыг тогтмол хийж байх юм. Мөн хог хаягдлын ялзралаас үүдэн төвлөрсөн хогийн цэгээс шатдаг метан хий ихээр ялгардаг тул хог дарж булагдсан талбайгаас үүсэх метан хийг саармагжуулах зорилгоор 1000см диаметртэй 5 метрийн урттай агааржуулалтын бетон хоолойг суурьлуулаад байна.	100%
94.		6.2.5. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төлөх нээлттэй ил тод хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ.	2021 - 2025	УБЗАА		1.2019 он 50 2. 2019 он 90	1. Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төвлөрүүлэлт 2. Гэр хорооллын айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний төлбөр, хураамж төвлөрүүлэлт	1. 2021-2025 100 2. 2021-2025 100	-	-	1.УБЦТС ТӨХК-тэй айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын хураамжийн орлого төвлөрүүлэх ажил гүйцэтгэх Ерөнхий гэрээ байгуулан цахилгааны төлбөр дээр хог хаягдлын үйлчилгээний хураамжийг 10 хувийн шимтгэл төлөн төвлөрүүлэх ажлыг эхлүүлсэн. Ерөнхий гэрээний дагуу дүүргүүд УБЦТС ТӨХК-ний ХҮТ-үүдтэй гэрээ байгуулан орлого төвлөрүүлэх ажлыг хийж байна.	75%
95.		6.2.6. Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлж, ангилан ялгаж, тээвэрлэх, түр хадгалах, саармагжуулан устгах тогтолцоог бий болгоно.	2021 - 2025	УБЗАА		1. 2019 он 60 2. 2019 он 5 3. 2019 он 5	1. Хяналтад авсан аж ахуйн нэгж, байгууллага 2. Аюултай хог хаягдал түр хадгалах агуулах 3. Хяналтад авсан аюултай хог хаягдлын хэмжээ	1. 2021-2025 100 2. 2021-2025 1 3. 2021 2025 100	-	-	1.Нийслэлийн хэмжээнд аюултай хог хаягдал үүсгэгч 210 аж ахуйн нэгж, аюулгүй хог хаягдлыг дахин боловсруулдаг 9 үйлдвэр үйл ажиллагаа эрхэлж байна. Дээрх 210 аж ахуйн нэгжээс үүсэж байгаа хог хаягдал нь ихэвчлэн сав баглаа, болон ашиглалтаас гарсан тос, аккумлятор зэрэг байдаг бөгөөд эдгээр аюултай хог хаягдлыг үйлдвэрүүд авч устгалд оруулж байна. 100% 2.Нийслэлийн их дээд сургууль болон туршилтын бүсад лабораторид ашигласан түүнээс гарсан хог хаягдлыг авах газрын асуудлыг шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна. 3. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хог хаягдлын мэдээллийн https://eic.mn/waste цахим санд аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагааг эрхлэх аж ахуйн нэгжээр нийт 41 аж ахуйн нэгжийг бүртгэж бүртгэлийн дугаар олгон хяналтад авсан байна. 90%	95%
96.		6.2.7. Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулж, өдөрт 2,000 кг бордоо үйлдвэрлэх хүчин чадал бүхий үйлдвэрийг ашиглалтад оруулсан байна.	2021 - 2025	УБЗАА		2020 он 0	Хүнсний хог хаягдал боловсруулах үйлдвэр	2021-2025 1	-	-	Хүнсний хог хаягдлыг дахин боловсруулах, бордоо хийх туршилтын төслийг 50 өрх, 20 аж ахуйн нэгжийн түвшинд амжилттай зохион байгуулж 14 хоног бүр тогтмол хяналтыг тавьж байна. 2025 оны байдлаар нийт 11000кг орчим хүнсний хог хаягдлыг бордоо болгон сургалт судалгааны ажлыг төлөвлөгөө гарган тогтмол зохион байгуулж байна. Үйлдвэр байгуулахад санхүүгийн асуудал үүссэн тул төслийн Удирдах хорооноос гарсан шийдвэрийн дагуу Хувийн хэвшлийн байгуулагуудтай хамтран зохион байгуулахаар болсон бөгөөд илүү гарсан зардлаар Хот нийтийн аж ахуйд шаардлагатай, бүтцийн материал цуглуулах машин техник, төхөөрөмжүүдийг авах ажлыг үе шаттай зохион байгуулсан. Нийт 9 төрлийн хүнсний хог хаягдал цуглуулах, хог ачих, бобкат, зэрэг 5 төрлийн машиныг 6 сард багтаан нийлүүлэхээр ажиллаж байна. Мөн бүтцийн материал цуглуулах зорилгоор нийт 20 навч сорогч төхөөрөмж авах ажлыг зохион байгуулж төвийн 6 дүүрэг, Хот тохижилтын газар ОНӨААТҮГ-т тус тус нийлүүлсэн. Төслийн үйл ажиллагаа бүрэн дууссан. 100%	100%
97.		6.2.8.“Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г боловсруулж, хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	УБЗАА, НБОГ		2020 он 0	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	2021-2025 1	-	10	“Нийслэлийн хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний төслийг шинэчлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/146 дугаар захирамжаар төлөвлөгөө боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан 5 бүлэг 65 дэд арга хэмжээ бүхий төлөвлөгөөний төсөл боловсруулсан. 2026 оны 1 дүгээр улиралд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулахад бэлэн болсон.	100%

98.		6.2.9. Гэр хорооллын айл өрхүүдэд эдийн засгийн дэмжлэг үзүүлэх замаар стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг үе шаттайгаар нэмэгдүүлж, бохир цуглуулж, тээвэрлэх, байгальд ээлтэй аргаар устгах арга технологийг нэвтрүүлнэ.	2021 - 2025	УБЗАА		1. 2019 он 4 2. 2019 он 85	1.Сайжруулсан ариун цэврийн байгууламжийг нэмэгдүүлсэн хэмжээ, хувь 2.Ариутгал, халдваргүйтгэл хийсэн нүхэн жорлон, бохирын цооногийн эзлэх хэмжээ, хувь	1. 2021-2025 10 2. 2021-2025 100	-	-	1.Хөрсний бохирдлоос сэргийлэх бодлого, зорилтын хүрээнд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас мэргэжлийн байгуллагуудад санал тавьсаны үндсэн дээр Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Газарзүй геоэкологийн хүрээлэнтэй хамтран нийслэлийн төвийн 6 дүүрэг, алслагдсан Налайх дүүргийн гэр хорооллын нүхэн жорлонгийн тооллого хийх, мэдээллийн сан үүсгэх ажлыг 2021 онд хэрэгжүүлсэн. Улаанбаатар хотын төвийн 7 дүүргийн хэмжээнд нийт 144,992 ширхэг нүхэн жорлон тоологдсон. Дүүрэг тус бүрээр авч үзвэл Сонгинохайрхан дүүрэгт 49022, Баянзүрх дүүрэгт 32147, Сүхбаатар дүүрэгт 19628, Чингэлтэй дүүрэгт 22739, Хан-Уул дүүрэгт 11373, Баянгол дүүрэгт 5308, Налайх дүүрэгт 4775 ширхэг нүхэн жорлон байна. Хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөр нь 4 бүсэд хувааж авч үзсэн ба Улаанбаатар хотод нүхэн жорлон ашиглахыг хориглох шаардлагатай нянгийн бохирдол маш өндөр бүсэд 9443, хөрсний бохирдол их бүсэд 43377, хөрсний бохирдол дунд бүсэд 71150, харьцангуй бага бохирдолтой бүсэд 21022 нүхэн жорлон байна. 2020-2024 оны хооронд нийслэлийн гэр хорооллын нийт 15960 айл өрхийн нүхэн жорлонг сайжруулсан эко жорлонгоор солих ажлыг улс, дүүргийн төсөв, буцалтгүй тусламжийн санхүүжилтаар хийж гүйцэтгэсэн. Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 26 дугаар тогтоолоор дүүргийн нутаг дэвсгэрт 2025-2028 онд хэрэгжүүлэх “Гэр хорооллын 20,000 хүртлэх айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах төсөл”-өөр 2025 онд 3000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг шинэчлэхээр төлөвлөснөөс 2025 оны байдлаар 1622 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг бүрэн шинэчилсэн. 2021-2025 онд нийт 17,582 нүхэн жорлонг шинэчилсэн бөгөөд сайжруулсан ариун цэврийн байгууламжийг 12 хувиар нэмэгдүүлсэн. 2.Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 2025 оны “Хөрөнгө гаргах тухай” А/75 дугаар тушаалаар 370.0 сая төгрийн санхүүжилтын шийдвэрлэж тендер сонгон шалгаруултаар шалгарсан байгууллагуудтай гэрээ байгуулж Үерийн хамгаалалтын барилга байгууламж, Туул, Сэлбэ, Дунд голын ай сав газар, нийтийн ээмшлийн гудамж талбайн, бохирдсон хөрс бүхий нийт 2 сая.мкв талбайд ариутгал, халдваргүйтгэлийн ажлын хийлгэсэн. 100%	100%
99.		6.2.10. Нийслэлийн нутаг дэвсгэр дэх оршуулгын үйлчилгээний зохистой менежментийг бий болгож, оршуулгын газруудыг нөхөн сэргээж, ойжуулна.	2021 - 2025	УБЗАА		1. 2020 он 2 2. 2020 он 80 3. 2020 он 1	1. Нөхөн сэргээж, тохижуулж, цэцэрлэгжүүлэлт хийсэн талбайн 70 давхрын оршуулгын газрын талбайд эзлэх хувь 2. Ил тавих, газарт оршоох оршуулгыг бууруулсан хэмжээ 3. Оршуулгын газруудад мод, бут, сөөг тарьж ургуулсан талбайн нийт оршуулга хийгдсэн талбайд эзлэх хувь	1. 2021-2025 8 2. 2021-2025 70 3. 2021-2025 10	-	-	1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 109 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/733 дугаар захирамжаар Чингэлтэй дүүргийн 12 дугаар хороо, “Самбалхүндэвийн” оршуулгын газрын 10 га талбайг нөхөн сэргээж 14252 шарил нүүлгэн шилжүүлж төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд өөд болоочдыг дурсан хүндэтгэх иж бүрэн тохижилт, барилга, байгууламж бүхий “Дурсгал хүндэтгэлийн цэцэрлэгт хүрээлэн” байгуулах төслийг "Нью Семетри" ХХК-тай хамтран хэрэгжүүлж нийт талбайн 14 хувийг нөхөн сэргээлт хийсэн. Мөн 2025 онд Чингэлтэй дүүргийн 12-р хороонд байрлах 70 давхрын оршуулгын газрын 2000м.кв газрын 250 шарилыг тус албанаас нүүлгэн шилжүүлж Европын холбооны буцалтгүй тусламжийн "3R4UB" төслийн хүрээнд ангилсан хог хаягдал хүлээн авч дахин боловсруулалт хийдэг үйлдвэрүүдэд түүхий эдийг хүлээлгэн өгч дахин боловруулалт хийж болох хоёрдогч түүхий эдийг тойрог эдийн засгийн эргэлтэд оруулах зорилготой Экологийн төв буюу Эко Хаб-г барьсан. 2.Ил тавих, газарт оршуулах шарилын тоог бууруулахаар Баруун буяны төв цогцолбор 652, Зүүн буяны төв цогцолбор 634, нийт 1286 иргэний шарилыг чандарласан ба чандарлах үйлчилгээний тоог нэмэгдүүлэхээр ажиллаж байна. 100% (Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй) 3.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хот орчмын оршуулгын газруудад мод тарих ажлыг зохион байгуулж "Улаанбаатар Буян" ХХК, "Нью Семетри" ХХК, "Диваажин хүрээлэн" ХХК, "Суварга буян" ХХК, "Дөл буян" ХХК, "Сувд буян" ХХК, "Хайрхан Мандал Буян" ХХК, "Зүүн Түмэн Буян" ХХК гэх мэт нийт 8 аж ахуйн нэгж хариуцсан оршуулгын газруудад нийт 41.542 мод бутыг тарьсан. 100% *(Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй)*	100%
100.		6.2.11. Байгалийн баялгийн олборлолтоос эвдэрсэн талбайд нөхөн сэргээлт хийсэн байна.	2021 - 2025	НБОГ		2020 он 65	Нөхөн сэргээлт хийгдсэн талбай, га	2021-2025 87	-		2021 онд төсвийн болон иргэн, аж ахуйн нэгжийн хөрөнгөөр 131.49 га, 2023 онд 'Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 25 га, 2024 онд 17.9 га, нийт 174.39 га талбайд нөхөн сэргээлт хийсэн. 2025 онд Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 20 га талбайд нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх” ажлын даалгаврыг боловсруулж, Газрын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороонд хүргүүлсэн. Нээлттэй тендер сонгон шалгаруулалтад “Эм Ди Юу” ХХК нь 296.3 сая төгрөгөөр хийхээр ажлын гүйцэтгэчээр шалгарч, нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэн хүлээлгэн өгсөн.	100%

101.	6.3.Усны нөөцийг хамгаална.	6.3.1. Ундны усны нөөцийг судалж, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн хязгаарлалтын бүс, тэжээгдлийн мужийг тогтоож, хамгаалалтад авна.	2021 - 2025	НБОГ, УСУГ, НГЗБА, УБЗАА		1. 2020 он 27.2 2. 2020 он 3,698 3. 2020 он 1.8 4. 2020 он 100 5. 2020 он 0 6. 2020 он 3 7. 2020 он 0 8. 2020 он 0	1. Хамгаалалтад авсан усны урсац бүрэлдэх эхийн эзлэх хувь 2. Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд чөлөөлсөн газар 3. Ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын хашаа 4. Усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор ойжуулсан талбай 5.Тусгай хэрэгцээнд авсан ундны эх үүсвэрийн байршил 6. Шинээр болон сэргээн тохижуулсан булаг шанд 7. Ундны усны эх үүсвэрийн талбайд нөхөн сэргээлт хийсэн газрын хэмжээ, га 8. Сонгинохайрхан дүүргийн Баянголын ам, Багануур дүүргийн усны нөөцийн судалгаа	1. 2021-2025 28.0 хувь 2. 2021-2025 0 3. 2021-2025 31.5 км 4. 2021-2025 200 га 5. 2021-2025 10 6. 2021-2025 18 7. 2021-2025 35 га 8. 2021-2025 2	-		1.2021 онд Баянзүрх дүүргийн 20-р хорооны нутагт Туул голын сав дагуу 145 га, 2023 онд Сүхбаатар, Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэрт Сэлбэ, Дунд голын дагуу 534 га, Сонгинохайрхан дүүргийн 24-р хорооны Толгойтын Баруун салааны Бумбатын амны 44.1 га газрыг байгалийн нөөц газрын ангилалаар орон нутгийн хамгаалалтад авсан. НИТХ-ын 2024 оны 69-р тогтоолоор усны сан бүхий газрын онцгой хамгаалалтын бүс 22,921.8 га, энгийн хамгаалалтын бүсийг 37,439.4 га болгон шинэчлэн тогтоосон. 100% 2.Усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор 2021 онд 75 га, 2022 онд 4,4 га, 2023 онд 4.4 га, нийт 83.8 га талбайд ойжуулалт хийсэн. Сонгинохайрхан дүүргийн 21,32 дугаар хорооны нутаг дэвсгэр дах Нарийний ам, Өндөрхааны булаг, Хунт нуур орчмын 16 га талбайг нийслэлийн орон нутгийн хамгаалалтанд авах ажлын хэсэг байгуулахаар холбогдох байгууллагаас санал авч аван ажиллаж байна. 70% 3.Ус хангамжийн эх үүсвэрүүдийг 38,8 км хашаа, 24.9 км хашлагаар хамгаалж байна. Гүний худгуудыг хамгаалж буй өргөст торыг тухай бүрт засварлаж, хамгаалалтанд авч хэвшсэн. 2025 оны байдлаар ус хангамжийн эх үүсвэрийн бүс дэх 200м хамгаалалтын хашаа, хашлага, 470м өргөст торыг засварласан байна. 100% 4.Усны эх үүсвэрийг хамгаалах зорилгоор 2021 онд 75 га, 2022 онд 4,4 га, 2023 онд 4.4 га, 2024 онд 10 га, нийт 93.8 га талбайд ойжуулалт хийсэн. 2025 онд БЗД-ийн 20-р хороо, Дээндийн голын татамд 4.4 га талбайд ойжуулалт хийж байна. 98.2% 5. 2024 онд Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн 936 га газрыг тусгай хэрэгцээнд авсан. 2025 онд зарим газрыг тусгай хэрэгцээний газраас цуцалсан. 10% 6.2021 онд 3, 2022 онд 1, 2023 онд 1, 2024 онд 5, 2025 онд 9, нийт 19 булгийн эхийг хашин хамгаалж, гадаргын усны нөөц хомсдох, эх ундрага татрах аюулаас урьдчилан сэргийлсэн. 100% 7.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Налайх дүүргийн нутаг дэвсгэрт 2021 онд 25 га, 2023 онд 25 га, 2025 онд 20 га, нийт 70 га талбайд нөхөн сэргээлтийн ажил хийлгэсэн. 100% 8.Багануур дүүргийн ус хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны ордын ашиглалтын хайгуул судалгааны ажлыг 2021 онд нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийж гүйцэтгэсэн ба баталгаат усны нөөцтэй болж, усныхаа нөөцийг түшиглэн төлөвлөлт хийх боломж бүрдсэн. Сонгинохайрхан дүүргийн усны нөөцийн хайгуул судалгааны ажлын санхүүжилтийг улсын төсөвт тусгаж өгөх талаар хүсэлтийг 2021, 2024 онд хүргүүлсэн боловч нийслэлийн төсөвтөө суулгаж хийлгэх талаар зөвлөмж ирсэн. 2023, 2024, 2025 оны онд санхүүжилт нь батлагдаагүй. 50%	85%
102.		6.3.2. Гадаргын усыг хуримтлуулж, ашиглалтыг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НБОГ		2020 он 1	Шинээр байгуулсан хөв, цөөрөм	2021-2025 4	-		2021 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Баянзүрх дүүргийн 11 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Хөлийн гол дагуу 10695.5 м3 эзлэхүүнтэй хөв, 2023 онд аж ахуйн нэгжийн хөрөнгөөр Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр Их баянгийн аманд 280000 м3 эзэлхүүнтэй хөв цөөрөм (хиймэл нуур)-ийг байгуулсан. 2025 онд Нийслэлийн нутаг дэвсгэрт Баянзүрх дүүргийн 20-р хороо, Дээндийн аманд 1, Хан-Уул дүүргийн 14-р хороо Түргэний гол дагуу 1, Налайх дүүргийн 1-р хорооны Энгэр шандад 1, Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо Мухарын аманд 1, Нарийн гол дагуу 2 нийт 6 хөв цөөрөм (усан сан) байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлыг хийсэн.	100%
103.	6.4. Улаанбаатар хотын цэцэрлэгжүүлэлтийн мастер төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	6.4.1. Дүүрэг бүрд цэцэрлэгт хүрээлэн байгуулж, нийтийн эзэмшлийн зам талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нягтруулах замаар нэг хүнд ногдох ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	УБЗАА		1. 2020 он 4.8 2. 2020 он 18 3. 2020 он 16 4. 2020 он 23 5. 2020 он 2 6. 2020 он 122	1. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ, м.кв 2.Цэцэрлэгт хүрээлэн, амралтын талбай, тоо 3. Гадна талбайг тохижуулсан эмнэлэг, тоо 4.Спорт, тоглоомын талбайн тохижилт, тоо 5. Гадна талбайг тохижуулсан түүх, соёлын дурсгалт газар, тоо 6. Сул шороон хөрсийг зүлэгжүүлсэн талбай, га	1. 2021-2025 8 2. 2021-2025 24 3. 2021-2025 19 4. 2021-2025 44 5. 2021-2025 7 6. 2021-2025 222	-	-	1.2025 онд нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ 8.1м2-д байна. 100% 2.Улаанбаатар хотын 9 дүүрэгт цэцэрлэгт хүрээлэн байгуулах, ногоон байгууламж нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2021-2025 онд 50 байршилд бичил цэцэрлэгт хүрээлэн байгуулсан. 100% 3.Нийслэлийн хэмжээнд СХД-ийн Нягдсэн эмнэлэг, Улсын клиникийн төв эмнэлэг, АШУИС-ын Монгол-Японы эмнэлэг, Эх-нярай эмэгтэйчүүдийн төв нийт 4 эмнэлгийн гадна тохижилт хийгдсэн. 100% 4.Нийслэлийн хэмжээнд 2024 онд 907 хүүхдийн тоглоомын талбай, 428 спорт талбай байсан бол 2025 онд хүүхдийн тоглоомын талбай 88-аар нэмэгдэж 995, спорт талбай 16-аар нэмэгдэн 444 болсон байна. 100% 5.2022 онд Богд хааны цэцэрлэгт хүрээлэнгийн гадна тохижилт, 2023 онд Чойжин лхамын цэцэрлэгт хүрээлэн гадна тохижилт, 2024 онд Улсын драмын театрын гадна тохижилт, 2025 онд Гандантэгчилэн хийдийн гадна тохижилтын ажлыг тус тус гүйцэтгэж ажиллаа. 80% 6.Нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн 157га талбайд гудамж тайлбайн нийт 38 багц зарлагдан ойн мэргэжлийн байгууллагууд болон ОНӨТААТҮГ арчилгааны ажил хийж гүйцэтгэж байна. Жилийн эцсийн байдлаар нийтийн эзэмшлийн 8,7га талбайг зүлэгжүүлж төвийн дүүргүүдэд ногоон байгууламжид 117,964тн усалгаа хийж, 36,758ш модыг өвчин хортон шавжнаас сэргийлэн шохойдох арга хэмжээ авсан. Нийт 79,519ш мод бутыг нөхөн тарьсан ба 511ш савтай модыг нөхөн сэргээж будаж, 1,123ш үхсэн хатсан модыг талбайгаас чөлөөлж, тогоо гаргаж мод сөөгийг хэлбэржүүлэн талбайн цэвэрлэгээнээс нийт 6,617тн хогийг зөөж тээвэрлэв. Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх урсгал зардлын хүрээнд Улаанбаатар хотын ерөнхий менежерийн 6 тушаалын 27 төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхээр 5,05 тэрбум төгрөг батлуулж, тайлант хугацаанд 5 төсөл арга хэмжээний 1,4 тэрбум төгрөгний гэрээний шатандаа, 22 төсөл арга хэмжээ гэрээ байгуулан байнгын хүлээж авах комисс ажиллан ажиллаж байна. 100%	97%
104.		6.4.2. Сэлбэ, Дунд гол, Туул голын эрэг орчмын газрыг нийтийн зориулалттай ногоон байгууламж, спортын төрөлжсөн талбай бүхий байгалийн төрхийг хадгалсан, амралт зугаалгын бүс болгон тохижуулсан байна.	2021 - 2025	УБЗАА		2020 он -	Тохижуулсан талбай	2021-2024 4,087.5	-	-	Туул голын эрэг орчмын 4 байршилд нийтийн зориулалттай ногоон байгууламж бүхий спорт болон тоглоомын талбай, амарч зугаалах, алхах, дугуйгаар зорчих боломжтой талбайг шинээр нэмэгдүүлсэн. Талбайн нийт хэмжээ 6.4 га хүрсэн.	100%
ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ												
Зорилго 7. Иргэдийг аюулгүй, амар тайван, гамшгийн эрсдэлгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.												**91.0%**

105.	7.1. Цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажиллагаа, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	7.1.1. Цагдаагийн байгууллагын хэлтэс, хэсгийн байруудыг шинээр барьж, төрийн үйлчилгээг хүртээмжтэй болгоно.	2021 - 2025	НЦУГ		1. 2020 он 17 2. 2020 он 17	1. Цагдаагийн хэлтсийн барилга 2. Цагдаагийн хэсгийн барилга	1. 2021-2025 21 2. 2021-2025 21	1,006.00	1,006.00	Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02/15 дугаар тогтоолоор 396.0 сая төгрөгийг дүүргийн 2025 оны төсөвт суулгаж, Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр Шарга морьтын уулзварт 140м2 талбай бүхий зуслангийн цагдаагийн хэсгийн байрыг шинээр барьж ашиглалтад оруулсан. Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороонд байрлах тус цагдаагийн удирдах газрын хоёрдугаар байрны их засварын ажлыг улсын төсвийн 610.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж, Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Ажиллагааны хэлтсийн алба хаагчид байрлан ажиллаж байна.	85%
106.		7.1.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай автомашин, техник хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НЦУГ, ТЦА-ны ЗЦГ		1. 2020 он 329 2. 2020 он 70	1. Цагдаагийн автомашин 2. Цагдаагийн тусгай хэрэгсэл, төхөөрөмжийн нөхөн хангалт	1. 2021-2025 453 2. 2021-2025 70	575.1	11295.1	1.Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 185 сая төгрөгийг шийдвэрлүүлж, "Албан хэрэгцээнд шаардлагатай тээврийн хэрэгсэл худалдан авах тухай" нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж, "Киамоторс Монгол" ХХК-аас шалгарч 2025 оны 1 дүгээр улиралд Киа Карнывал маркийн тусгай тоноглол бүхий 1 автомашиныг хүлээн авсан. Мөн Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс Ниссан патрол Y61 маркийн тусгай тоноглол бүхий 1 автомашин, Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар Т2 ENDURO маркийн кросс загварын тусгай тоноглол бүхий 1 мотоциклыг тус тус хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна. Өссөн дүнгээр нийт 10.2 тэрбум төгрөгийн үнэ бүхий 88 автомашиныг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. 71% 2.Морьт эргүүлийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалд шаардлагатай 296.1 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлж, хангалтыг хийсэн. Олон нийтийн цагдаагийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, таних тэмдэг, үнэмлэх, тусгай хэрэгслийн зардалд 571.4 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлж, 214 олон нийтийн цагдаад 100 хувь хангалт хийгдсэн. Мөн дүүргийн цагдаагийн газар, хэлтсүүд орон нутгийн санхүүжилтээр иж бүрэн компьютер 84, принтер 50, ширээ 42, сандал 64, баримт бичгийн шүүгээ 15, бичлэг хадгалах төхөөрөмж 3, камер 52, дрон 1, согтуурал хэмжигч төхөөрөмж 4, цахилгаан дугуй 4, чанга яригч 5 зэрэг техник, хэрэгслийн нийт 575.1 сая төгрөгийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын 30.1 хувьд хангалт хийгдсэн. 2021 онд 5, 2022 онд 10, 2023 онд 10, 2024 онд 15, өссөн дүнгээр нийт 70.1 хувьд хангалт хийгдсэн. 100%	85.50%
107.		7.1.3. Эрүүлжүүлэх, саатуулах төвийн барилгыг шинэчлэн барьж, үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг сайжруулсан байна.	2021 - 2025	НЦУГ		2020 он 1	Шинэчлэн барьсан эрүүлжүүлэх, саатуулах төв	2021-2025 1	-	-	Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын 338,9 сая төгрөгийн санхүүжилтээр 2021 онд Баганаур дүүргийн цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх, саатуулах байрыг шинээр барьж ашиглалтад оруулсан. Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сангийн 265,0 сая төгрөгийн санхүүжилтээр 2021 онд Эрүүлжүүлэх, саатуулах төвийн байрны их засварын ажлыг хийж орчин нөхцөлийг сайжруулсан. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлөөс 2023 онд 119.8 сая төгрөгийн үнэ бүхий хими цэвэрлэгээний тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, гал тогооны тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлсэн. Мөн 2025 онд “Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан”-гийн 42.8 сая төгрөгийн санхүүжилтээр 16 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шийдвэрлүүлсэн. Яаралтай үед эмчийн тусламж дуудах, эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүлжүүлэх, саатуулах төвийн 18 өрөөнд тусламжийн хонх суурилуулж, өрөөний шалыг стандартад нийцсэн резин нь шалтай болгосон. Стандарт, хэмжил зүйн газрын даргын 2025.12.03-ны өдрийн С/46 дугаар тушаалаар "Эрүүлжүүлэх үйлчилгээний ерөнхий шаардлага MNS 5527:2025" стандартыг батлуулсан.	100%
108.	7.2. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, гэмт хэргийн гаралтын түвшинг бууруулна.	7.2.1. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, цагийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, хамтран ажилласан байна.	2021 - 2025	НЦУГ, ТЦА-ны ЗЦГ		1. 2020 он 500 2. 2020 он 796 3. 2020 он 150	1. Олон нийтийн байцаагч 2. Олон нийтийн цагдаа 3. Оюутан цагдаа	1. 2021-2025 500 2. 2021-2025 796 3. 2021-2025 150	1300 4666.7 299.9	1300 4666.7 299.9	1.Нийслэлийн хэмжээнд 2025 онд 104 олон нийтийн байцаагч ажиллаж байна. 2021 онд 104, 2022 онд 105, 2023 онд 103, 2024 онд 105, өссөн дүнгээр 521 олон нийтийн байцаагч ажилласан. 100% 2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 24/35 дугаарт тогтоолоор 2025 онд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр 214 хүртэл, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр 524 хүртэл, нийт 738 олон нийтийн цагдаа ажиллахаар, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин буюу 2.3760.000 төгрөгийн урамшуулал олгуулахаар батлуулсан. Олон нийтийн цагдаагийн 73 орон тоо сул байсныг нөхөх чиглэлээр болзол шалгууруг хангасан иргэдийг дүүргийн цагдаагийн газар, хэлтсээс судлан тус Цагдаагийн удирдах газрын даргын 2025 оны “Олон нийтийн цагдаагаар бэлтгэх иргэдийг сургалт, дадлагад хамруулах тухай ”Б/53 дугаар тушаал, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн даргын баталсан “Үйлдвэрлэлийн дадлага сургалтын удирдамж”-ийн дагуу сургалтад хамруулж, 2025 оны Б/84 дүгээр тушаалаар 73 иргэнийг сул орон тоонд томилж, 214 олон нийтийн цагдаа ажиллаж байна. 100% 3.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын 2025 оны "Оюутан цагдаа 2025 арга хэмжээг зохион байгуулах тухай" А/117 дугаар захирамж батлагдаж, шаардагдах төсөвт 299.994.930 төгрөгийг шийдвэрлэсэн. Оюутан цагдаагийн 1 цагийн урамшуулыг 15.000 төгрөгөөр тогтоосон учир батлагдсан төсөвт тохируулан нийт 62 оюутан цагдааг энэ оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хугацаанд ажиллуулсан. 2022 онд 150, 2023 онд 150, 2024 онд 50, 2025 онд 62, жилд дунджаар 103 оюутан цагдааг ажиллуулсан байна.69%	85%
109.		7.2.2. Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртөхөөс хамгаалах “Хүүхэд хамгаалагч” төслийг хэрэгжүүлж, хүүхдийг гэмт хэрэгт өртөх, хохирогч болох эрсдэл бууруулсан байна.	2021 - 2025	НЦУГ		2020 он 173	Хүүхэд хамгаалагчаар ажиллах хүн	2021-2025 173	154.3	154.3	"Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 154,303,400 төгрөгийг урамшуулалд шийдвэрлүүлж, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр хүүхэд хамгаалагчаар 194 иргэн ажиллаж байна. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хүүхдийн эрхийг хангах, аюулгүй орчныг бүрдүүлэх, орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх зохилгоор 89 удаагийн сургалт зохион байгуулсан.	100%

110.		7.2.3. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлж, хохирогчийг хамгаалалтад авах, аюулгүй байдлыг хангах түр хамгаалах байрыг шинэчилж, барьсан байна.	2021 - 2025	НЦУГ		1. 2020 он 418 2. 2020 он 1 3. 2020 он 154	1.Түр хамгаалалтад авах хохирогч 2.Засварласан түр хамгаалах байрны барилга 3.Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг	1. 2021-2025 200 2. 2021-2025 1 3. 2021-2025 85	8700	8,700.00	1.Түр хамгаалах байранд 2025 онд нийт 86 гэр бүлийн 228 үйлчлүүлэгч (насанд хүрсэн эрэгтэй 1, насанд хүрсэн эмэгтэй 86, эмэгтэй хүүхэд 76, эрэгтэй хүүхэд 65) хүлээн авч, тусламж үйлчилгээ үзүүлсэн. Мөн төрийн болон төрийн бус байгууллагад холбон зуучлах, ар гэр асран хамгаалагч, эрх бүхий албан тушаалтанд 81 гэр бүлийн 216 үйлчлүүлэгчийг (насанд хүрсэн эрэгтэй 1, насанд хүрсэн эмэгтэй 81, эмэгтэй хүүхэд 73, эрэгтэй хүүхэд 61) хүлээлгэн өгсөн. 87.2% 2.Азийн хөгжлийн банкны 8.7 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Баянзүрх дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт шинээр баригдаж байгаа Түр хамгаалах байрны барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай. 100% 3.Нийслэлд 2025 оны эхний 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх 43 гэмт хэрэг бүртгэгдсэн. 100%	95.70%

111.	7.3. Гудамж, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор камерын нэгдсэн хяналтын системийг бий болгоно.	7.3.1. Нийслэлийн удирдлага, хяналтын цогц системийг байгуулж хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	2021 - 2025	НЦУГ, НЦХМТГ, НЗХГ, ТЦА-ны ЗЦГ		1.2020 он 18 2.2020 он 0	1.Нэгдсэн систем байгуулах ажил 2.Дэвшилтэт технологиор тоноглогдсон авто замын хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн систем	1. 2021-2025 100 хувь 2. 2021-2025 1	40100 83419	40100 72534	1.Нийслэлийн хэмжээнд “IREX”, “NX WITNESS” ухаалаг программ хангамжтай “Теле камерын хяналтын нэгдсэн төв”, 9 дүүрэгт “Теле камерын хяналтын дэд төв” байгуулах ажил бүрэн дуусаж, ашиглалтад оруулсан. 100% 2.Хяналтын теле камерын тусламжтайгаар авто замын зөрчил илрүүлэх, видео менежмент, видео аналитик систем, түүний сервер, хадгалах төхөөрөмжийг суурилуулж, нэгтгэн харах зориулалт бүхий нэгдсэн сүлжээг зохион байгуулсан. “Теле камерын хяналтын нэгдсэн төв"-ийн Ухаалаг программ хангамж системд 2025 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар Замын хөдөлгөөн удирдлагын төвийн зөрчил бүртгэл, хяналтын нийт 2440 теле камер, 9 дүүргийн дэд төвүүдийн нийт 1248 камер нэгдсэн төвийн системд холбогдсон. Улаанбаатар хотын нийт 114 байршилд хиймэл оюун ухаан (AI)-д суурилсан хяналтын камераар 3 төрлийн зөрчил илрүүлж тээврийн хэрэгслийн ээмшигчдийн бүртгэлтэй гар утасны дугаарт 21,364,079 зөрчилд сануулга, мэдэгдэл хүргүүлсэн. 176 цэгт суурилагдсан ухаалаг теле камерын өгөгдлийг ашиглаж зам тээврийн осолтой холбоотой 264, гэмт хэрэгтэй холбоотой 222, замын хөдөлгөөний оролцсон маршрут 258, хойшлуулашгүй ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн 70, бусад 344, нийт 1088 камер шүүлгэх хүсэлт хүлээн авч, 744 нотлох баримтыг холбогдох байгууллагад гарган өгч, гэмт хэргийг илрүүлэхэд туслалцаа үзүүлсэн. Замын хөдөлгөөнд оролцож байгаа нийт тээврийн хэрэгслийн тоо, хөдөлгөөний ачаалал ихтэй уулзвар гарц, осол саад, түгжрэлийн шалтгаан нөхцлийг шууд харах боломж бүрдэж 151 уулзварт 967,922 удаа хөдөлгөөн зохицуулалт хийсэн үр дүнтэй. 100%	100%
112.		7.3.2. Бичлэг болон зурган мэдээллээс үл давтагдах өгөгдлөөр программ хангамжийг нэвтрүүлэх, гэмт хэргийн цахим зураглал /Griemmap, Compstat/-ыг цагдаагийн байгууллагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд холбох ажлуудыг хийж, Улаанбаатар хотын хэмжээнд ашиглагдаж буй хяналтын камерыг “Камерын удирдлагын нэгдсэн төв”-тэй холбож, гудамж, зам талбайн хяналт, гэмт хэрэг илрүүлэлт сайжруулж, гэмт хэргийн гаралт бууруулсан байна.	2021 - 2025	НЦУГ, НЦХМТГ		1. 2020 он 415 2. 2020 он 25,652 3. 2020 он 11.8	1.Шинээр холбогдсон хяналтын камер 2.Гэмт хэргийн гаралт 3. Хохирол нөхөн төлүүлэлт	1. 2021-2025 8000 2. 2021-2025 20,352 3. 2021-2025 21.8	1,000.00	1,000.00	1.Нийтийн ээмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуй нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дэд бүтцийг ашиглан “Теле камерын хяналтын дэд төв”-д холбох ажлын хүрээнд Баянгол дүүрэгт 349, Баянзүрх дүүрэгт 301, Сонгинохайрхан дүүрэгт 132, Сүхбаатар дүүрэгт 270, Хан-Уул дүүрэгт 242, Чингэлтэй дүүрэгт 2532, Багануур дүүрэгт 113, Багахангай дүүрэгт 68, Налайх дүүрэгт 246, нийт 4253 ширхэг телекамер холбогдсон байна. Нийслэлийн 31 хорооны гудамж талбай, олон нийтийн газарт шинээр 299 теле камерыг, аж ахуйн нэгж байгууллагын гадна орчинд шинээр 661 теле камер, авто замын 176 уулзвар, гарцад 2525 ширхэг автомашины улсын дугаар таних, зөрчил илрүүлэх ухаалах программ хангамжид суурилсан теле камерыг тус тус суурилуулж, нэгдсэн болон дэд төвд холбосон. Нийт 7738 теле камерыг нэгдсэн болон дэд төвд холбосон. 100% 2.Нийслэлд 2025 оны эхний 11 сарын байдлаар 28.888 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс буюу 10.1 хувиар өссөн. Гэмт хэргийг бууруулах чиглэлээр ажлын хэсэг байгуулж, нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж ажилласан. 0% 3.Нийслэлийн хэмжээнд 2025 оны эхний 11 сарын байдлаар иргэн, хуулийн этгээдэд 552.5 тэрбум төгрөгийг хохирол учирснаас 162.5тэрбум төгрөг буюу 29.4 хувийг нөхөн төлүүлсэн байна. 100%	66.70%
113.	7.4. Гамшгаас авран хамгаалах, иргэдэд үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг сайжруулна.	7.4.1. Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх техник, хэрэгслийн хангамжийг нэмэгдүүлж, хүн амын нягтрал ихтэй байршлуудад гал түймэр унтраах, аврах анги байгуулж, иргэдийг аюул, ослоос авран, хамгаалах чадавхыг сайжруулсан байна.	2021 - 2025	НОБГ		1. 2020 он 15 2. 2020 он 92	1.Гал унтраах, аврах анги 2.Тусгай зориулалтын автомашины тоо	1. 2021-2025 17 2. 2021-2025 102	3,960.00	-	1.Улсын төсвийн 23 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн 4 дүгээр хорооны нутаг дэвсгэрт Гал түймэр унтраах, аврах 10 дугаар ангийн барилга угсралтын ажлыг 2020 оны 6 дугаар сарын 26-ны өдөр эхлэн, 2023 оны 1 дүгээр сарын 2-ны өдөр ашиглалтад орсон. Чингэлтэй дүүргийн 2024, 2025 оны төсвийн 5,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Гал түймэр унтраах, аврах ангийн барилга угсралтын ажил хийгдэн бүрэн дуусч 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүлээн авснаар нийслэлийн хэмжээнд 16 гал түймэр унтраах анги, 1 аврах анги үйл ажиллагаа явуулж байна. 100% 2.2021 онд Монгол Улсын Засгийн газар Бүгд найрамдах Франц Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй төслөөр нийлүүлэгдсэн РЕНО загварын гал түймэр унтраах үндсэн албаны 13 тэрбум төгрөгийн өртөг бүхий 16 автомашин, 2022 онд Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2021 оны А/233 дугаар тушаалаар 239,6 сая төгрөгийн өртөг бүхий шуурхай албаны автомашин 11 ширхэг, гал түймэр унтраах хөөсний 13 тонны 3 ширхэг автомашиныг тус тус хүлээн авсан. 2024 онд НИТХ, Сөүл хотын ИТХ-ын хамтын ажиллагааны хүрээнд аврах ажиллагааны 1, гал түймэр унтраах 2, автомеханик шат 1, эмнэлгийн түргэн тусламжийн 6, нийт 10 автомашиныг Улаанбаатар хотод хандивласныг 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авсан. 2021-2025 онд техник, хэрэгслийн тоог 40 -өөр нэмэгдүүлсэн. 2025 онд Сонгинохайрхан дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөс 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус дүүргийн Онцгой байдлын хэлтэст шаардлагатай бага оврын ачааны автомашин, туулах чадвар сайтай Танк 300, хүн зөөврийн Тоёота Вокси, Хьюндай Старекс, Давхар кабинтай портер маркийн шуурхай албаны автомашин худалдан авахаар тус дүүргийн Худалдан авах ажиллагааны газраас тендер зарлан гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулж, автомашиныг 2025 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүлээн авсан. 100%	100%
НАЙМ. БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ												
Зорилго 8. Хүн амын нутагшилт, суурьшлын оновчтой тогтолцоог бүрдүүлж бүс, орон нутгийн хөгжлийн уялдааг хангуулна.												**94.3%**
114.	8.1. Монгол Улсын үндэсний түвшний хөгжлийн бодлоготой нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулж, дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийг эрчимжүүлж, хотын төвлөрлийг сааруулах бодлогыг боловсруулна.	8.1.1. "Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", "Бүсийн хөгжлийн хөтөлбөр"-ийн төсөлд нийслэлийн хөгжлийн бодлого, төлөвлөлтийг уялдуулсан байна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 0	Уялдсан хөгжлийн бодлогын баримт бичиг	2021-2025 2	-	-	"Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл", "Бүсийн хөгжлийн хөтөлбөр"-ийг уялдуулан төлөвлөсөн бөгөөд Засгийн газрын 2023 оны 35 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж дэмжигдсэн. 2024 онд "Хот, тосгоны эрхзүйн байдлын тухай" хуулийн шинэчилсэн найруулга, "Шинэ Зуунмод хотын эрх зүйн байдлын тухай" хуулиуд батлагдаж эдгээр хуулиудаар Нийслэл дэх хотууд болон бүсад засаг захиргааны нэгж дэх нийслэлийн дагуул хотын эрх зүйн байдал, удирдлага зохион байгуулалт, тэдгээрийг хэрхэн байгуулах асуудлыг нарийвчлан зохицуулсан. Улсын Их Хурлын 2024 оны "Хот байгуулах тухай" 72 дугаар тогтоолоор нийслэлийн нутаг дэвсгэрт улсын зэрэглэлтэй 2 хот, орон нутгийн зэрэглэлтэй 14 хот, нийслэлийн дагуул 3 хотыг болгох, мөн Улсын Их Хурлын 2024 оны "Хот байгуулах тухай" 76 дугаар тогтоолоор Төв аймгийн нутаг дэвсгэрт нийслэлийн дагуул хот "Шинэ Зуунмод хот"-ыг байгуулах, Засгийн газрын 2024 оны "Эдийн засгийн тусгай бүс байгуулах тухай" 220 дугаар тогтоолоор Агросити, Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүс байгуулах шийдвэрийг баталгаажуулсан. Эдийн засгийн Тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, татварын бус дэмжлэг үзүүлэх журмын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/122 дугаар тогтоолоор батлуулсан.	100%

115.		8.1.2. “Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх ажлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулсан байна.	2021 - 2025	ХБХСГ НГЗБА		1. 2020 он 0 2. 2020 он 5	1.Хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг (“Шинэ Зуун мод”, “Майдар”) 2.“Шинэ Зуунмод”, “Майдар” шинэ дагуул хотын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хилийн цэсийг өөрчлөх ажил	1. 2021-2025 2 2. 2021-2025 100	-	-	1."Засгийн газрын 2022 оны 143 дугаар тогтоолоор "Шинэ Зуунмод (Хүннү хот)" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсан. Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд тодорхойлсноор Хүннү хот нь Улаанбаатарын бүсэд хамаарагдаж байгаа бөгөөд Төв аймгийн Сэргэлэн, Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт нийт 31,500 га эдэлбэр газартай байхаар тогтоож, 150,000 оршин суугчтай байхаар төлөвлөсөн. 100% 2.“Шинэ Зуунмод” хот, “Майдар” хотуудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах, бүтээн байгуулалтын хэрэгжилтийг чиг үүргийн дагуу Барилга, хот байгуулалтын яам, Хүннү хотын Захирагчийн ажлын алба хариуцан ажиллаж байна."	100%
116.		8.1.3. Төв аймагтай хамтран ажиллах эдийн засгийн болон нийгмийн хөгжлийн чиглэлийг тодорхойлж, хамтын ажиллагааг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 0	Хамтран ажиллах гэрээ, санамж бичиг	2021-2025 1	-	-	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/595 дугаар захирамжаар “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төслийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэгт дэмжлэг үзүүлэх дэд Ажлын хэсэг байгуулагдсан. “Монгол Улсын Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын төслийг боловсруулах ажлын хүрээнд Төв аймагтай хүн ам зүй, нийгэм эдийн засаг, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох ажил хийгдэж, Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор батлагдсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/304 дүгээр захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд Улаанбаатарын бүсийн зөвлөлийн өргөтгөсөн хуралдаан зохион байгуулж, хамтын ажиллагааг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.	100%
117.		8.1.4. Богд уулыг тойрсон “Хөгжлийн алтан тойрог” төсөл, Улаанбаатар хотын дагуул хотуудыг түшиглэн ачаа тээврийн логистик төв байгуулах техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулсан байна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 0	Техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	2021-2025 3	-	-	Багахангай, Хөшгийн хөндий чиглэлийн төмөр замын төслийг Зам, тээврийн яам хариуцан ажиллаж байна. Хүннү хот	85%
118.		8.1.5. Улаанбаатар хотын дагуул, хаяа хот, тосгодын хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгүүдийг боловсруулж дуусгана.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 11	Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө (Жаргалант, Рашаант, 361 гарам)	2021-2025 12	-	-	СХД-ийн 21-р хорооны нутаг дэвсгэр Жаргалант, Рашаант, 361 гарам орчимд Эдийн засгийн тусгай бүс байгуулах тухай Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1243 дугаар захирамж гарч, ажлын төлөвлөгөөний дагуу хамрах бүсийн төлөвлөлтийн хилийн саналыг боловсруулсан. Улсын Их Хурлын 2024 оны “Хот байгуулах тухай” 72 дугаар тогтоолоор Нийслэлийн дагуул “Багахангай хот, Агросити хот, Шарга морьт хот”-ыг байгуулах шийдвэр, 76 дугаар тогтоолоор Төв аймгийн нутаг дэвсгэрт “Шинэ Зуунмод хот”-ыг Нийслэлийн дагуул хотоор байгуулах шийдвэр баталгаажсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Эрх шилжих тухай” А/107 дугаар захирамжаар Агросити дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд Захиалагчийн хяналт тавин ажиллаж, ажлын даалгавар боловсруулж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Дээрх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын эхлэлийн тайланг буюу суурь судалгааны ажлыг 2025 оны 2025/01 тоот ажил хүлээлцэх актаар хүлээн авч, Нийслэлийн нутаг дэвсгэрт Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн 2025 оны 44 дүгээр хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Гүйцэтгэгч тал болох Гоби Травел ХХК нь ажлыг хуваарийн дагуу дундын тайланг боловсруулж байгаа боловч, Сангийн яам Нийслэлийн төсвийн хөрөнгийн дансыг хаасан шалтгаанаар санхүүжилт саатсанаас шалтгаалан зарим гэрээт ажлууд, лабораторийн дүгнэлтүүдийг товлосон хугацаанд гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүссэн. "Говь травел" ХХК аас гэрээ сунгах хүсэлт ирүүлснийг судлан сунгалтын гэрээг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр НХААГ/20250103049-2 дугаартай байгуулав. Дундын тайлан боловсруулах шатандаа явж байна.	85%
119.		8.1.6. “Барилгын материалын бөөний худалдааны төв”-ийн техник, эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг батлуулж, ажлыг эхлүүлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 0	Техник ,эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө	2021-2025 1	-	-	Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор Барилгын материалын бөөний худалдааны төвүүдийг Улаанбаатар хотоос нүүлгэн шилжүүлж, нэгдсэн бодлого төлөвлөлттэй хөгжүүлэх зорилгоор Нийслэлийн Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт тээвэр логистик, барилгын материалын үйлдвэрлэлийн кластер бүхий “Налуу-Ухаа” эдийн засгийн тусгай бүс байгуулахаар болсон. Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ батлуулах 700.0 сая төгрөгийн санхүүжилт 2025 оны Монгол Улсын төсөв, Шадар сайдын багцад тусгагдсан. Захиалагчийн хяналтыг “Бүсчилсэн хөгжлийн Үндэсний хүрээлэн” УТҮГ хариуцан ажиллаж байна.	85%

120.		8.1.7. Улаанбаатар хотод сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгжийг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ, НМХГ, НБИХГ, ХСОАБХЗГ		2020 он 0	Боловсруулсан бодлогын бичиг баримт	2021-2025 1	-	-	"Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр, аж ахуйн нэгж, байгуллагыг хотоос шилжүүлэх" судалгаа боловсруулах ажлын хүрээнд "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-ийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг, НИТХ-ын 2023 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан. Тус аулын хүрээнд: 1.Арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх асуудлаар ХУД-ийн 20-р хорооны суурьшлын бүсийн арьс шир, завод, ноосны анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх тухай хэлэлцүүлгийг Эмээлт эко үйлдвэрийн парк ХК-д 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Үүний хүрээнд 4 арьс шир, 1 ноолуур боловсруулах үйлдвэртэй "Паркийн нэгжийн гэрээ" болон "Паркт газар ашиглуулах гэрээ"-г байгуулсан. Мөн Нийслэлийн Ерөнхий Архитекторын санаачлаагаар "ХУД-ийн 20-р хорооны үйлдвэрийн бүсийн хөрс, усны бохирдлыг саармагжуулах, нөхөн сэргээх нь" сэдэвт хаалттай хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж хэлэлцүүлгийн үр дүнд оролцогч талууд тухайн үйлдвэрийн бүсийн байгаль орчныг нөхөн сэргээх аргачлал, төлөвлөгөө боловсруулж хамтран ажиллахаар болов. 2."Морингийн даваа" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах асуудлаарх ерөнхий судалгаа боловсруулах ажлын хүрээнд Морингийн даваан ландфиллын байршил болох Хог шатааж эрчим хүч үйлдвэрлэх байршлыг нэгтгэн 260-300 га газарт эхний ээлжийн төлөвлөлтийн концепци боловсруулсан. 3.Хотын түгжрэл болон хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж буй зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мега төслүүд, зам тээвэр, логистикийн сүлжээ, өнөөгийн байдлын суурь судалгаанд үндэслэн хот төлөвлөлтийн үндсэн 4 хүчин зүйлсийг харгалзан судалж төвлөрөл, түгжрэл, агаар орчны бохирдолд хамгийн их нөлөөлж буй томоохон 9 зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх төсөл боловсруулсан. Дээрх зах худалдааны төвүүдийг нийслэлээс нүүлгэн шилжүүлэхэд шаардагдах төсөв санхүүг тооцоолж, үе шат дараатай нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал болон НИТХ-д танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	100%
121.		8.1.8. Зарим их, дээд сургуулиудыг мэргэжлийн чиглэл, салбараар төрөлжүүлж, дагуул хотууд болон бусад аймгуудад шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ, НЗДТГ		2020 он 0	Их, дээд сургуулиудыг шилжүүлэх чиглэлээр гаргасан шийдвэр	2021-2025 1	-	-	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/996 дугаар захирамжаар БНСУ-тай хамтран хэрэгжүүлэхээр зорьж байгаа "Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах, Монгол Улсад бүсийн тэнцвэртэй хөгжлийг дэмжих төсөл"-ийн хүрээнд хотын төвлөрлийг задалж, олон төвт хотын тогтолцоог бий болгох, судалгааг боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Үйл ажиллагааны хүрээнд төсөл хэрэгжүүлэгч KOICA олон улсын байгууллагын судлаачидтай уулзалт зохион байгуулж Улаанбаатар хотын тогтвортой хөгжлийг хангах чиглэлээр Хүннү хот байгуулах чиглэлийн судалгаа хийж зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр шийдэлд хүрэв. Тухайлбал Хүннү хотын Оюутны хотхон эрдэм шинжилгээний бүсэд их, дээд сургуулиудыг шат дараатай нүүлгэн шилжүүлэх судалгааг боловсруулахаар тохиролцож 2025 оны 09 дүгээр сарын 03, 04-ний өдрүүдэд Хүннү хотын төлөвлөлтийн байршилд ажилласан. Боловсролын яам болон холбогдох яам, агентлагуудтай KOICA судалгааны баг уулзалт хийж эхний ээлжид нүүлгэн шилжүүлэх их сургуулийн санал авч ажиллаж байна. Цаашид үе шат дараатай судалгааны ажлыг үргэлжлүүлэн хийх бөгөөд тус төсөл нь 2027 он хүртэл үргэлжлэн хийгдэнэ.	100%
ЕС. УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ												
Зорилго 9. Орон зайн оновчтой төлөвлөлтийн хүрээнд хотын төвлөрлийг задалж орон сууц, дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэн, хот байгуулалтын үйл ажиллагаанд ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.												**88.90%**
122.	9.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.	9.1.1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагалдан гарах зураг төсөл, баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлж эхэлсэн байна.	2021 - 2025	НХБХГ, НГЗБА		1. 2020 он 0 2. 2020 он 0	1. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 2. Хот байгуулалтын баримт бичиг, зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, мастер төлөвлөгөө	1. 2021-2025 2 2. 2021-2025 36	9,935.40	9,239.63	1."Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-ний зөвлөх үйлчилгээний ажлын удирдамж, ажлын даалгавар боловсруулан, "Дэхан консалтент" ХХК-тай 2024 оны НХААГ/20240103147 дугаартай "Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө"-г боловсруулах Зөвлөх үйлчилгээний ажлын гэрээг байгуулж, 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдөр Зөвлөх үйлчилгээний эцсийн тайланг ирүүлснийг үе шаттай хэлэлцүүлэн "Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө" хот байгуулалтын баримт бичгийг боловсруулсан холбогдох газарт өргөн барьсан. 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай" төслийг хэлэлцэх нь дэмжигдсэн. УИХ-ын даргын 2025 оны "Ажлын хэсэг байгуулах тухай" 65 дугаар захирамжаар "Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай" УИХ-ын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. 100% 2.Засгийн газрын 2022 оны 99 дүгээр тогтоолоор "Монгол наадам үндэсний спорт цогцолборын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө" батлагдсан. -Нийслэлийн Засаг дарга (НЗД)-ын 2021 оны А/524 дүгээр захирамжийн дагуу Улаанбаатар хотыг нэг төвт хотоос олон төвт хотын тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд шинээр 3 дэд төв ("Амгалан", "Шинэ төв", "Сонсголон" дэд төвийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл), 7 олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл ("Нисэх", "Тахилт", "Дарь-Эх", "Монель", "Бичил", "Ургах наран", "Хайлааст" олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл) ийг боловсруулах ажлын хүрээнд Сонсголон, Амгалан, Шинэ дэд төв болон Нисэх, Бичил, Ургах наран, Хайлааст олон нийтийн төвийн ТЭЗҮ, барилгажилтын төслийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (НИТХ)-ын ээлжит бус 2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанд өргөн барьж батлуулсан. Шинээр 3 олон нийтийн төв "Дарь-Эх, Монель, Тахилт"-ийн ТЭЗҮ, барилгажилтын төсөл боловсруулах ажил Барилгын хөгжлийн төвд магадлалын нэгдсэн дүгнэлт баталгаажих шатанд хэрэгжиж байна. -НИТХ-ын 2023 оны 65 дугаар тогтоолоор "Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө" баталсан. -НИТХ-ын 2023 оны 66 дугаар тогтоолоор "Эмээлт эко аж үйлдвэрийн парк"-ийн ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотголыг баталсан. -НЗД-ын 2023 оны А/1309 дугаар захирамжийн дагуу "ББСМО" ХХК-тай "Сэлбэ" дэд төв орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилгажилтын төсөл, олон улсын зөвлөх үйлчилгээ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг байгуулсан. НЗД-ын 2025 оны А/1233 дугаартай захирамжаар НЗД-ын 2025 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/515 дугаар захирамжийн 1 дэх заалтад өөрчлөлт оруулж тус ажлыг "Сэлбэ хорин минутын хот корпорац" ХХК-д захиалагчийн хяналтыг шилжүүлж ХБХСГ/03 дугаартай актаар хүлээлгэн өгсөн. -НЗД-ын 2023 оны А/1517 дугаар захирамжийн дагуу "Гоби травэл" ХХК-тай "Зайсан орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах" ажлын НХААГ/20240103246 гэрээг 2024 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр байгуулсан. 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр эцсийн тайланг ирүүлсэн бөгөөд Хот байгуулалтын инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтэст дулаан хангамжийн төлөвлөлтийг зөвшилцөж байна. 100%	100%

123.		9.1.2. Хүн амын тооцоот нягтралаас хэтэрсэн байршлын судалгааг гаргаж, хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох бүсийг тогтооно.	2021 - 2025	ХБХСГ, НГЗБА		2020 он 1	Хүн ам, барилгажилтын нягтралыг хориглох шийдвэр	2021-2025 2	-	-	Улаанбаатар хотын нутаг дэвсгэрийн хэмжээнд “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтын норм ба дүрэм” БНбД 30.01.04-т заасан хүн амын тооцоот нягтрал 1га газарт 460 хүн байх хязгаарыг давсан 6 дүүргийн 111 хэсгийн 1163га газрын нягтралын судалгааг гаргаж, Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2022 оны 19 дүгээр хурлаар хэлэлцүүлсэн. Тус судалгааг үндэслэж хотын төвийн хэсгийн барилгажилтын нягтрал өндөртэй хэсэгт инженерийн болон нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж, нийтийн эзэмшлийн зам, талбай барихаас бусад зориулалтаар, шинээр газар эзэмших, ашиглах эрх, барилга байгууламж барих зөвшөөрөл олгохгүй байх саналыг танилцуулсан. Үүний үр дүнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (НИТХ)-ын 2023 оны 64 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг дарга (НЗД)-ын 2023 оны “Хууль тогтоолын хэрэгжилтийг хангах тухай” А/867 дугаар захирамж тус тус батлагдсан. Мөн НИТХ-ын 2025 оны 25/110 дугаар тогтоолоор Чингэлтэй дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6-р хороо, Сүхбаатар дүүргийн 4, 5, 6, 8-р хороодын нутаг дэвсгэрт байрлах Бага тойруугийн хэсгийн 243,3 га талбайд барилгын өндрийг 7 давхар хүртэл байхаар төлөвлөж, батлагдсан техник, эдийн засгийн үндэслэлийг мөрдөж ажиллах шийдвэрийг батлуулсан.	100%
124.		9.1.3. Гэр хорооллыг хөгжүүлэх стратеги төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ, НГЗБА		2020 он 1	Стратеги төлөвлөгөө	2021-2025 2	760	-	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1418 дугаар захирамжийн дагуу 2025 оны 05 дугаар сарын 27-ны өдөр “Нийслэл Улаанбаатар хотыг ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөө” боловсруулах ажлын НХААГ/20240103601 дугаар гэрээг “Нью урбанизм” ХХК-тай байгуулсан. “Нийслэл Улаанбаатар хотыг ухаалаг орон сууцжуулах стратеги төлөвлөгөө”-г хэрэгжүүлж ажиллах үндсэн байгууллага нь Нийслэлийн Орон сууцны бодлогын газар бөгөөд “Нью урбанизм” ХХК-иас 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдөр эхлэлийн тайланг Нийслэлийн Орон сууцны бодлогын газарт хүргүүлсэн. Тус газрын 2025 оны 2/1725 дугаартай албан бичгээр тайланг “Ажлын даалгаврын дагуу боловсруулагдсан гэж хүлээн зөвшөөрөх боломжгүй тухай” ирүүлсэн.	80%
125.	9.2. Төр захиргаа, мэдээлэл технологи, бизнес санхүү, соёл, боловсрол, худалдаа үйлчилгээ, орон сууц, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн хангамж бүхий хотын шинэ төв, дэд төв, олон нийтийн төвүүдийг байгуулж, хотын хэт төвлөрлийг бууруулна.	9.2.1. "Яармаг" хотын шинэ төвийн ерөнхий төлөвлөгөө /Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол/ шинэчлэн боловсруулагдаж, төлөвлөлтийн дагуу бүтээн байгуулалт хэрэгжих боломжийг бүрдүүлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 0	Нисэх, Яармаг орчмын орон сууцны хорооллын ерөнхий төлөвлөгөөний тодотгол	2021-2025 1	208.21	-	Нийслэлийн Засаг даргын 2023 оны “Хөрөнгө оруулалтын ажлыг зохион байгуулах тухай” А/893 дугаар захирамжаар “Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулахыг Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ-т, захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Хот байгуулалт, хөгжлийн газарт тус тус даалгасан. 2023 оны 2023/А/893/01 дугаартай ажлын гэрээ батлагдсан. Тус гэрээний тусгай нөхцөлийн 2 дугаар зүйлийн 2.5-д “захиалагч болон зөвлөхөөс үл хамаарсан шалтгааны улмаас ажил гүйцэтгэх хугацаа хэтэрсэн тохиолдолд талууд харилцан тохиролцож энэхүү гэрээний хугацааг нэг удаа сунгаж болно” гэж заасны дагуу 2024 оны 2023/А/893/02 дугаартай хугацаа сунгах нэмэлт гэрээг байгуулж хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл сунгасан. Гүйцэтгэгч гэрээний сунгалтын хугацаанд гэрээт ажлыг хүлээлгэн өгөөгүй тул гэрээний 7, 9 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэгчид төлбөр төлөх үндэслэлгүй бөгөөд “Хот төлөвлөлт, судалгааны институт” ОНӨААТҮГ-тай байгуулсан 2023/А/893/01 дугаартай “Яармаг” хотын шинэ төв буюу 27 дугаар нэгж хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг шинэчилсэн боловсруулах зөвлөх үйлчилгээ үзүүлэх” гэрээг цуцлахаар шийдвэрлэж, гэрээ дүгнэсэн акт үйлдэв.	70%
126.		9.2.2. "Баянхошуу", "Сэлбэ", "Дамбадаржаа", "Дэнжийн 1000", "Толгойт", "Шархад" дэд төвүүдийг байгуулна.	2021 - 2025	УБГХХХОДТ-ийн нэгж, НСХ, НБИХГ		2020 он 0	Хотын дэд төв	2021-2025 6	-	-	1.Дэнжийн мянга дэд төвд хийн түлштэй дулааны станцын нарийвчилсан зураг төслийг боловсруулж холбогдох эрх бүхий байгууллагуудтай зөвшилцөх ажил үргэлжилж байна. 2.Дамбадаржаа дэд төвд баригдах дулааны станцын барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрлийг Эрчим хүчний яамнаас 2025 оны 3 дугаар сарын 6-ны өдөр олгосон. Үүний дагуу барилга угсралтын ажил эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар ажлын явц 20%-тай байна. Дамбадаржаа дэд төвийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 297 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 296 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 98%-тай байна. Худалдан авах ажиллагааны явц 98%-тай байгаа. Барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: 2.8 км авто замын ажлын явц 59%, 63МВт-ын хүчин чадалтай дулааны станцын барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 20%, 2.15 км дулааны шугам сүлжээний ажлын явц 83%, 4ш ус дулаан дамжуулах төвийн барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 90%, 6.6 км цахилгааны шугам сүлжээ, 5.9 км холбооны сувагчлал, 4.8 км шилэн кабель, 1 хуваарилах байгууламж, 2 хаалттай дэд өртөө болон мэдээлэл холбооны сүлжээний нэгдсэн үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлын явц нийт 57.4%, 2.24 км цэвэр усны, 3 км ариутгах татуургын шугам сүлжээний ажлын явц 61%, 1.2 км хөрсний ус доошлуулах шугамын угсралтын ажлын явц 76%, 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц 83% тай байна. 3.Толгойт дэд төвийн газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 501 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 472 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 96.1%-тай байна. Авто зам инженерийн барилга байгууламжийн ажлын трасст өртсөн 1 өрх эд хөрөнгийн өмчлөлийн маргаантай, шүүхдэж байгаа тул хэлэлцээр эцэслэн хийгдээгүй байна. Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 98%-тай хэрэгжиж байна. Худалдан авах ажиллагааны явц 85%-тай, барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: 1.8 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 95%-тай, 5.2 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 46%-тай, 2.84 км цэвэр усны шугам сүлжээний ажил 98%, насос станцын барилга угсралтын ажлын явц 90%, Хаалттай дэд өртөө болон хувиарлах байгууламжийн суурийн арматурчлал болон цутгалтын ажил хийгдэж барилга угсралтын ажлын явц 5%тай, Сургалтын төвийн барилга угсралтын ажлын явц 96%, 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлын явц 42%тай байна.	85%

127.	9.3. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн сангийн үйл ажиллагаанд ухаалаг технологийг нэвтрүүлж, нийслэлийн хот байгуулалтын дундын мэдээллийн санг өргөжүүлэн, иргэд, олон нийтэд нээлттэй болгоно.	9.3.1. Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд суурилсан газар олгох, барилга барих зөвшөөрлийг иргэд, олон нийтэд нээлттэй болгосон байна.	2021 - 2025	ХБХСГ, НГЗБА, ХСОАБХЗГ, НЦХМТГ		1. 2020 он 0 2. 2020 он 0	1.Газар олгох, барилга барих зөвшөөрлийг цахимжуулах систем 2.2.Иргэн, хуулийн этгээдэд зориулсан газрын удирдлагын цахим систем	1. 2021-2025 1 2. 2021-2025 1	200	196.5	1.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/923, 2023 оны А/73 дугаар захирамжийн дагуу "Смартдата" ХХК-тай байгуулсан НХААГ/202212160, НХААГ/202212160-1 дугаартай гэрээнд захиалагчийн хяналт тавин, ХБМХ-2023/06 дугаартай актаар эцсийн тайланг хүлээн авч, сервер, тоног төхөөрөмж, eBarilga геопортал, гар утасны аппликэйшний эх файл, дотоод удирдлагын системийн гарын авлага зэргийг хүлээн авч, хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна. 100% 2. Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоолын дагуу хөгжүүлэгдсэн Газрын удирдлагын нэгдсэн цахим системийг өдөр тутмын хэрэглээнд нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны хэмжээнд хэрэглэгчийн эрхээр нэвтрэн ашиглаж байгаа бөгөөд ашиглалтын явцад үүсэж буй хэрэгцээ шаадлагаас хамааран тухай бүр хөгжүүлэлтийн саналыг журамд заасны дагуу хүргүүлж байгаа болно. Мөн түүний дараа Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дугээр тушаалаар батлагдсан “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам”-ын дагуу шинэчлэн хөгжүүлэгдсэн egazar.gov.mn болон Egazar утасны аппликейшнээр газар олголтын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нэвтрүүлэн нийслэлийн хэмжээнд газар олгогдсон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэдийн нэр, газрын хэмжээ, төлбөр, захирамжийн мэдээлэл зэргийг нээлттэй харах боломжоор ханган ажилласан. 100%	100%
128.		9.3.2. Улсын кадастрын мэдээллийн нэгдсэн системд холбогдож, хэрэглээнд нэвтрүүлэн, гудамж, зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчлэн, хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ, НГЗБА, УБЗАА, Дүүргүүд		1. 2020 он 20 2. 2020 он 0	1.Улсын мэдээллийн санд холбох ажлын хувь 2.Гудамж зам талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийг шинэчлэх ажлын хувь	1. 2021-2025 100 2. 2021-2025 100	-	-	1.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар батлагдсан тус ажлын тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас зохион байгуулж, шалгарсан “АйСиТи групп” ХК-тай гэрээ байгуулан, Хот төлөвлөлтийн асуудал хэлэлцэх Мэргэжлийн зөвлөлийн хурлаар эхлэлийн болон дундын тайланг хэлэлцүүлэн хүлээн авсан. Улсын хаягийн системтэй холболт хийх ажлыг Барилга, хот байгуулалтын Сайд, Цахим Хөгжил, Харилцаа холбооны сайдын хамтарсан 2022 оны 227/А/76 ажлын хэсгээс www.urban.gov.mn геопорталаар дамжуулан Улсын хаягийн системтэй холбох шийдвэр гарч, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газар нь хаягийн систем дээр нэмэлт хөгжүүлэлт хийснээр гэрээнд заасан хугацаанаас хойшилж эхний туршилт 2023 оны 04 дүгээр сарын 11, эцсийн туршилт 2023 оны 11 дугээр сарын 27-ны өдрүүдэд хийж амжилттай холбосон. Эцсийн тайланг 2023 оны 12 дугаар сарын 07-ны өдөр хүлээн авч, хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна. 100% 2.Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын дагуу хаягийн мэдээллийн санг хэрэглээнд нэвтрүүлэхэд шаардлагатай суурь мэдээллийг засварлах ажлыг гүйцэтгэж, 9 дүүрэг болон төв зам дагуух нийт 64021 гудамж зам болон 529907 орц гарцны хаягжуулалтыг бүрэн зураглаж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газарт хүлээлгэж өгсөн. Хаягийн мэдээллийн системийг Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газраас нэвтрүүлсний дараа хаяг олгогдоогүй нэгж талбаруудад шинээр хаяг олгох ажлыг зохион байгуулна. 70%	85%
129.		9.3.3. Нийслэлийн нутаг дэвсгэрийг том масштабын байр зүйн тоон зургаар бүрэн зурагжуулсан байна.	2021 - 2025	ХБХСГ, НГЗБА		1.2020 он 0 2.2020 он 113,878	1.1:1000-ны масштабтай тоон байр зүйн зураг шинэчлэн хийгдсэн газар нутаг (суурьшлын бус) 2.1:2000-ны масштабтай тоон байр зүйн зураг хийгдсэн газар нутаг (суурьшлын бүсээс бусад)	1. 2021-2025 50,000 2. 2021-2025 420,440	5,599.70	1,679.90	1.Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 5.7.3-т заасныг үндэслэн Нийслэлийн Засаг дарга, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газартай хамтран 2024 оны 2024/03, 2024/34 дугаартай “Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох” ажлын даалгавар, хил зааг, эргэлтийн цэгийн солбицлыг баталсан. 2.2024 оны 04 дугээр сарын 22-ны өдөр худалдан авах ажиллагааны тендер зарлаж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Геосан, Геокад ХХК-ийн түншлэлтэй “Нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000-ны масштабтай байр зүйн зураг зохиох” ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Эхлэлийн тайланг 2024 оны ХОЗМТХ-2024/14 дугаартай актаар, дундын тайланг 2025 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн ХОЗМТХ-2025/21 дугаартай актаар тус тус хүлээн авсан. "Геосан" ХХК-иас 2025 оны 02/431, 02/446 дугаар албан бичгүүдээр гэрээг дахин сунгуулах тухай хүсэлтийг ирүүлснээр Захиалагч хяналтыг хийж буй Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын 2025 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 02/503, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2025 оны 09 дүгээр сарын 10-ний өдрийн 03/5744 дугаартай албан бичгүүдээр гэрээний хугацаа 2025 оны 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл сунгаж, НХААГ/20240103238-2 дугаартай сунгалтын нэмэлт гэрээг баталсан. 153283 га талбайд агаарын зураглал бүрэн хийсэн. 85%	85%
130.		9.3.4. Замын бүртгэл мэдээллийн нэгдсэн санг цахим хэлбэрт шилжүүлсэн байна.	2021 - 2025	НЗХГ		2020 он 0	Замын сүлжээний нэгдсэн мэдээллийн сан	2021-2025 1		**4,075.00**	1. Нийслэлийн Засаг даргын 202... оны А/892 дугаар захирамжийн дагуу авто зам, замын байгууламжийн бүртгэл, мэдээллийн сангийн хөгжүүлэлтийн ажлын хүрээнд авто замын цахим системийг хөгжүүлж дуусан бөгөөд тус систем нь динамик зохион байгуулалттай, цаашид гарах өөрчлөлт, хөгжүүлэлтийг дэмжих байдлаар уян хатан, хялбар, аюулгүй, орон зайнаас үл хамаарах байдлаар хийгдсэн. 2. Нийслэлийн Засаг даргын 202... оны А/434 дугаар захирамжийн дагуу авто зам, замын байгууламжийг паспортжуулах ажлын хүрээнд хийгдсэн нийслэлийн хатуу хучилттай авто зам, замын байгууламжийг бүрэн зураглаж нийт хатуу хучилттай авто зам, замын байгууламжийн урт, талбай, байршлын мэдээллийг орон зайн хувьд гаргах боломжтой болсон бөгөөд энэ нь бүх төрлийн дүн шинжилгээ хийх, өгөгдөл суурьтай шийдвэр гаргах, цаашлаад бусад олон төрлийн судалгаа, тооцоололд ашиглах нөхцөл бүрдсэн.	100%
131.	9.4. Нийслэлийн газрын харилцааны бодлогыг шинэчлэн, цахим системийг нэвтрүүлж, стандартыг хангуулна.	9.4.1. Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	2021 - 2025	НГЗБА		2020 он 0	Боловсруулах газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө	2021-2025 1	-	-	Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/126 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Нийслэлийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө” шинэчлэн боловсруулах ажлын даалгаврын боловсруулан 2020 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн НХААГ/202001278/0202 дугаартай Зөвлөх үйлчилгээний гэрээг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргатай байгуулан Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 8 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжигдэж 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн 95 дугаар тогтоолоор батлуулсан.	100%

132.		9.4.2. Гэр хорооллын мухар гудамж, зуслангийн бүсийн орц, гарц, орон сууцны хороолол дундах газар, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийн асуудлыг бүрэн шийдвэрлэж, түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай хүргэх, нэвтрэх боломжийг бүрдүүлсэн байна.	2021 - 2025	НГЗБА		2020 он 491	Газрын зөрчил шийдвэрлэлт, тоо	2021-2025 2,500	-	-	2021 онд 1556 байршилд 37459 метр, 2022 онд 354 байршилд 17616 метр, 2023 онд 345 байршилд 32893 метр, 2024 онд 224 байршилд 9074 метр хашааг буулгаж зөрчил арилгаж нийтийн эзэмшлийн зам талбайг нэмэгдүүлсэн. Нийслэлийн хэмжээнд 2021 онд 1556 гарааш, 2.8 га газар, 2022 онд 4522 гарааш, 8.14 га газар, 2023 онд 1990 гарааш, 3.58 га газар, 2024 онд 1546 гарааш 2.78 га газрыг чөлөөлж, нийтийн эзэмшлийн зам талбайг нэмэгдүүлсэн. 2025 оны жилийн эцсийн байдлаар: 1.Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор нийслэлийн 6 дүүргийн 83 байршилд 887 гараашыг чөлөөлөн зөрчил арилгаж нийтийн эзэмшлийн зам талбайг 15966 м.кв-аар нэмэгдүүлсэн. 2.Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 “Хууль тогтоомжийн хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулах, хотын өнгө үзэмжийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” дугаар захирамжийн хүрээнд 7 дүүргийн нутаг дэвсгэрт 1,664 “түргэн үйлчилгээний цэг”-ийг нүүлгэн шилжүүлсэн 3.Нийслэлийн 6 дүүргийн нийт 131 байршлын 9547 метр хашааг буулгаж газар чөлөөлөх ажлыг зохион байгуулахаар төлөвлөсөнөөс 112 байршилд 6175 метр хашаа хайсыг чөлөөлөн ажиллаад байна.	100%
133.		9.4.3. Улс, нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртсөн иргэн, хуулийн этгээдэд хуулийн дагуу нөхөн олговрыг олгох, газар чөлөөлөх ажлыг зохион байгуулсан байна.	2021 - 2025	НГЗБА		2020 он 353	Газар чөлөөлөлт, нөхөх олговорт хамрагдсан нэгж талбар	2021-2025 2,853	-	-	Нийслэлийн Засаг даргын захирамжаар 2021 онд 138 нэгж талбарын 3,9 га газрыг 6,0 тэрбум төгрөгөөр, 2022 онд 744 нэгж талбарын 26,6 га газрыг 69,43 тэрбум төгрөгөөр, 2023 онд 202 нэгж талбарын 7,4 га газрыг 47,16 тэрбум төгрөгөөр, 2024 онд 2082 нэгж талбарын 92,7 га газрыг 407,4 тэрбум төгрөгөөр чөлөөлсөн. Улмаар 2021-2024 онд 3166 нэгж талбарын 130,6 га газрыг чөлөөлсөн байна. 2025 оны 11-р сарын 19-ний өдрийн байдлаар НЗД-ын 254 захирамжаар 1,073 нэгж талбарын 48.55 га талбайд нийт 251.36 тэрбум төгрөгийн нөхөх олговор олгохоор гүйцэтгэлийн гэрээ байгуулан ажиллаж байна. НЗД-ын захирамжийн 43 төсөлд 289 нэгж талбарын 5.13 га талбайд 77.7 тэрбум төгрөгийг нөхөх олговортойгоор олгохоор хянагдаж байна.	100%
134.		9.4.4. Ойн, голын, усан сан бүхий газрын, үер, цэвэрлэх байгууламж, өндөр хүчдэл, түүх соёл, дурсгалт зүйлийн хамгаалалтын бүс болон төлөвлөж буй экологийн коридор, хотын суурьшлын бүс /тиг гортиг/-ийн гадна байгаа суурьшлыг чөлөөлж, нүүлгэн шилжүүлэх менежментийн төлөвлөгөөг боловсруулсан байна.	2021 - 2025	НГЗБА, НХБХГ		2020 он 0	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн менежментийн төлөвлөгөө	2021-2025 1	-	-	Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хороллыг орон сууцжуулах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7-д заасныг үндэслэн Монгол Улсад гадны зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж буй томоохон төсөл хөтөлбөрүүд болох Азийн хөгжлийн банкны хамгааллын бодлого, Олон улсын санхүүгийн стандартын газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн дүрэмд нийцүүлэн жендерийн тэгш байдлыг хангах, барилга байгууламжид элэгдэл хорогдол тооцохгүй байх, нийгмийн эмзэг бүлгийн өрхөд нэн тэргүүнд сонголт хийх боломж олгох, мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад хамруулах, иргэн хуулийн этгээд зөвхөн нүүн шилжих үүрэгтэй буюу нөхөх олговроо авсаны дараа газраа чөлөөлөх үүрэг хүлээхгүй байх, сайн дурын бус газар чөлөөлөлтөд баримтлах зарчмуудыг тусган боловсруулж, “Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх журам”, “Газар чөлөөлөх гэрээ”, “Санал асуулгын хуудас”, “Нийгэм эдийн засгийн судалгаа”-ны загварыг Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолоор батлуулсан. Тус журмыг 2024 оны 03 дугаар сарны 06-ны өдрөөс хойш газар чөлөөлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж байна.	100%
135.		9.4.5. Газрын мониторингийн цахим системээр дамжуулан газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийгдэнэ.	2021 - 2025	НГЗБА		2020 он 8,000	Газрын хянан баталгаа	2021-2025 48,000	-	-	Нийслэлийн хэмжээнд 2021 онд 18,881, 2022 онд 26,712, 2023 онд 8,736, 2024 онд 14,586, нийт 68,915 газрын мониторингийн цахим системээр ирүүлсэн захиалгат хянан баталгааны дүгнэлтийг хянаж баталгаажуулсан. 2025 онд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн дэд систем болох Газрын мониторингийн цахим системээр ирүүлсэн 23,148 захиалгат хянан баталгааг хянаж баталгаажуулсан. 2021-2025 онд нийт 92,063 захиалгат хянан баталгааг хянаж баталгаажуулсан	100%
136.		9.4.6. Нийслэлийн нутаг дэвсгэрт нийтийн эзэмшлийн амралт, зугаалга, биеийн тамирын зориулалттай газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, холбогдох шийдвэрийг гаргуулан, бүртгэлжүүлэх, хамгаалах ажлыг зохион байгуулна.	2021 - 2025	НГЗБА		2020 он 70	Нийтийн эдэлбэр газрын байршил	2021-2025 170	-	-	Нийслэл хотын иргэдийн эрүүл, аюулгүй орчинд, чөлөөт цагаа ая тухтай, зөв боловсон өнгөрүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах нөхцөлийг бүрдүүлэхээр нийтийн эдэлбэрийн газрыг нэмэгдүүлэх зорилгоор 2021-2025 онуудад Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 удаагийн тогтоолоор нийт 291 байршлын 178.49 га газрыг нийтийн эдэлбэрийн газарт бүртгэзд байна.	100%
137.	9.5. Нийслэлийн хэмжээнд иргэдийн эрүүл, ая тухтай амьдрах орчны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн хотын стандарт, норм, дүрмийг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, мөрдүүлэх ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ.	9.5.1. Хот төлөвлөх, байгуулах үйл ажиллагаанд болон нийгмийн үйлчилгээний барилгуудад стандартыг мөрдүүлдэг тогтолцоог бий болгоно.	2021 - 2025	ХБСГ		1. 2020 он 22 2. 2020 он 40	1. Хот төлөвлөх, хот байгуулах үйл ажиллагаанд мөрдөх стандартыг хэрэгжүүлэх шаардлага /багц/, тоо 2. Хүртээмжтэй дэд бүтцийн стандартад нийцүүлэх төрийн болон нийгмийн үйлчилгээний барилга	1. 2021-2025 45 2. 2021-2025 213	-	-	2022-2023 онд 15 бүлэг 52 хотын стандартын баримт бичиг, 2025 онд 7 бүлэг 16 хотын стандартын баримт бичгийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар үе шаттайгаар хэлэлцүүлэн батлуулсан бөгөөд, нийт 16 бүлгийн 68 хотын стандартын хэрэгжилтийг хангах арга хэмжээг тухай бүр зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: - Нийслэлийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар хотын стандартын хэрэгжилтийг хангуулах нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, үр дүнг Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнүүдэд тухай бүр танилцуулж ажилласан. - UCS 1102B:2022 “Ерөнхий боловсролын сургуулийн гадна орчинд тавих ерөнхий шаардлага”, UCS 1101B:2022 “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадна орчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандартууд 2022 оны 10 дугаар сараас эхлэн хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. - Нийгмийн дэд бүтэц булгийн хүрээнд батлагдсан Ерөнхий боловсролын сургуулийн барилгын гадна засалд тавигдах шаардлагад, Ерөнхий боловсролын сургуулийн барилгын дотор засалд тавигдах шаардлага, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын гадна засалд тавигдах шаардлага, Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын дотор засалд тавигдах шаардлага стандартууд нь 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх бөгөөд бэлтгэл аялыг ханган ажиллаж байна.	100%

138.		9.5.2. Ногоон барилгын стандарт боловсруулж, нэвтрүүлсэн байна.	2021 - 2025	НОСК, ХБХСГ, НХБХГ		2020 он 0	Ногоон барилгын стандарт	2021-2025 1	-	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/07 дугаар тогтоолоор UCS1101C:2025 “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны жишиг зураг төсөл” хотын стандартыг батлуулав. Тус хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулах ажлын хүрээнд “Монголын амины орон сууцны инновац хөгжлийн төв”-тэй хамтран 2025 оны 05 дугаар сарын 25-ны өдөр уулзалт зохион байгуулан, цаашид ААНБ-д “Эрчим хүчний хэмнэлттэй хүлэмжийн хийг бууруулсан ногоон амины орон сууцны чадавхжуулах сургалт” зохион байгуулж, сертификат олгож ажиллахаар болсон.	100%
139.		9.5.3. Хотын стандартын дагуу орчны аюулгүй байдлын хяналт, шалгалтыг сайжруулж, иргэдийн амьдрах орчны эрсдэлийг бууруулсан байна.	2021 - 2025	НОСК, НХСХГ, НХБХГ		2019 он 0	Хотын стандарт	2021-2025 120	-	-	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/237 дугаар захирамж, Улаанбаатар хотын ерөнхий менежерийн А/31 дүгээр тушаалын дагуу хуулль, тогтоомж, стандартын хэрэгжилт, орчны аюулгүй байдлыг хангуулахаар 9 дүүргийн нутаг дэвсгэрт ажиллан, 1270 зөрчлийн мэдээг Qfield программд бүртгэж, илэрсэн зөрчилд хотын стандартыг мөрдүүлэн ажиллах зөвлөмжийг иргэд, ААН-д өгч ажиллав. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2025 оны А/07 дугаар тушаалын хүрээнд 01 дүгээр сарын 30,31-ны өдрүүдэд Баянзүрх дүүргийн нутаг дэвсгэр дэх 2023 болон 2024 онд хийгдсэн тохижилт, бүтээн байгуулалтын ажлуудаас түүвэрчлэн хяналт, шинжилгээ хийж ажиллав. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/214 дүгээр захирамжийн хүрээнд Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Нийтийн байрны орчин, нөхцөлд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг Баянгол дүүрэгт 02 дугаар сарын 21 болон 24-ний өдрүүдэд зохион байгууллаа. Мөн Баянгол дүүргийн 23 дугаар хорооны 26-120-д байрлах нийтийн байранд UCS1001C:2023 “Хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл” хотын стандартын зөвлөмжийг хүргүүлж, хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлыг ханган, барилгын налуу замыг шинэчлүүлэх ажилд оролцов. Нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцах, 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу хийгдсэн бүтээн байгуулалтын ажилд UCS 1001A:2023 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд дэд бүтцийн хүртээмжийг дээшлүүлэх арга зүйн удирдамж, UCS 1001C:2023 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй дэд бүтцийн зураг төсөл хотын стандартыг мөрдүүлсэн эсэх, хотын стандартыг иргэд, олон нийтэд сурталчлан таниулсан байдлыг газар дээр нь шалгаж ажиллав.	100%
140.	9.6. Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн, барилгажуулах, гэр хорооллын газрыг дахин зохион байгуулах төслүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан, орчны бохирдлыг бууруулсан нийтийн болон амины орон сууцны хороолол болгон хөгжүүлнэ.	9.6.1. Төвийн бүсийн гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан орон сууцыг ашиглалтад оруулсан байна.	2021 - 2025	НОСБГ, ХБХСГ		2020 он 9,229	Гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд ашиглалтад орсон орон сууц	2021-2025 21604	-	-	Төвийн бүсийн гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулж, инженерийн болон нийгмийн дэд бүтцээр хангагдсан орон сууцыг ашиглалтад оруулах ажлын хүрээнд 2024 онд 2659 айлын орон сууц ашиглалтад оруулахаар төлөвлөн ажилласнаас 2024 айлын орон сууцыг ашиглалтанд оруулсан. 2014-2024 онд өссөн дүнгээр 20247 айлын орон сууц ашиглалтад орсон байна.	89%
141.		9.6.2. Дундын бүсийн гэр хороололд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх "Дэд бүтцийн төв" төслийг хэрэгжүүлнэ.	2021 - 2025	НОСБГ,НХБХГ, НХОГ		2020 он 1	Дэд бүтцийн төв	2021-2025 8	-	-	Монгол Улсын Засгийн Газрын 2017 оны 179 дүгээр тогтоолоор “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэх 50 байршлыг баталсан бөгөөд тус төслийг БНХАУ-ын буцалтгүй тусламжийн 2 тэрбум юанийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэхээр тусгасан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 118 дугаар тогтоолоор “Дэд бүтцийн төв” төслийг хэрэгжүүлэх эхний ээлжийн 16 байршлыг баталсан. Уг төслийг хэрэгжүүлснээр нийт 10,000-15,000 гэр хорооллын айл өрх хамрагдаж, дэд бүтэц бүхий амины сууцтай болж амьдрах орчноо сайжруулах юм. Дэд бүтцийн төвүүдийн хэрэгжилт: 1.Чингэлтэй дүүргийн 7 дугаар хорооны нутаг дэвсгэрт “Дэд бүтцийн төв” төслийн хамгийн эхний загвар төслийг 220 нэгж талбарыг хамарсан 14 га газарт 2018 онд амжилттай хэрэгжүүлсэн. 2.Сүхбаатар дүүргийн 18 дугаар хороонд хэрэгжиж буй дэд бүтцийн төвийн эхний ээлжийн барилга угсралтын ээлжийн ажил 100% дуусан бөгөөд 2 дугаар ээлжийн ажил 50%-тай гүйцэтгэлтэй үргэлжилж байгаа ба Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас санхүүжүүлж байна. 3.Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраас Налайх дүүргийн 1 хороонд хэрэгжиж буй Дэд бүтцийн төв төслийн ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж байгаа ба 2025 оны байдлаар явц нь 75%-тай боловч гүйцэтгэгчийн ажил удааширсантай холбоотойгоор төсөл зогсонги байдалд орсон байна. 4.Хан-Уул дүүргийн 9 дүгээр хороо, Баянзүрх дүүргийн 23 дугаар хороо, Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороонд баригдах дэд бүтцийн төвийн зураг төсөл боловсруулагдаж, 2023 онд магадлал хийгдсэн ба нийт төсөвт өртөг 31.8 тэрбум төгрөг байна. Үүнээс 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд Хан-уул дүүргийн 9 дүгээр хороо, Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороонд нийт 2 байршилд дэд бүтцийн төв байгуулахаар 18.9 тэрбум төгрөгийг 2025 оны Улс, Нийслэлийн төсвийн төсөлд санал хүргүүлсэн ч төсөвт тусгагдаагүй болно.	85%
142.		9.6.3. Захын бүсийн алслагдмал гэр хорооллын бүсэд бие даасан сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр бүхий технологийг нэвтрүүлсэн байна.	2021 - 2025	НОСБГ		1. 2020 он 0 2. 2020 он -	1. Техник эдийн засгийн үндэслэл 2. Бие даасан эх үүсвэр бүхий технологи нэвтрүүлсэн өрх	1. 2021-2025 1 2. 2021-2025 400	-	-	Тухайн төслийн хүрээнд 2019, 2020, 2021 онуудад тендер сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулсан бөгөөд санал ирээгүй. Иймд тус ажлын төсвийг татан авч хэрэгжих боломжгүй болсон.	0%
143.		9.6.4. Төвлөрсөн шугам сүлжээнд холбогдох боломжтой гэр хорооллын бүсэд иргэдийн газрыг орон сууцаар солино.	2021 - 2025	НОСК ХК		2020 он 210	Газраа орон сууцаар сольж орон сууцанд орсон өрх	2021-2025 1210	-	-	Гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах төслийн хүрээнд Сонгнохайрхан дүүргийн 5 дугаар хороо Ханын материал орчмын 12.6 га газарт 1,800 айл, Хан-Уул дүүргийн 8 дугаар хороо, Яармаг орчмын 24.77 га газарт 2,280 айлын орон сууцны төсөл хэрэгжүүлэхээр сонгон шалгаруулалтыг явуулж төсөл хэрэгжүүлэгчийг батламжилсан.	100%

144.	9.7. Түрээсийн олон төрөлт болон орлогод нийцсэн орон сууц төслүүдийг хэрэгжүүлж, нийслэлийн зорилтот өрхүүдийг орон сууцаар хангана.	9.7.1.Түрээсийн олон төрөлт орон сууцыг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НОСК ХК		2020 он 1,744	Ашиглалтад орсон түрээсийн орон сууц	2021-2025 6,744	-	-	Монгол банк, Улсын онцгой комисс, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороотой хамтран хэрэгжүүлсэн уг хөтөлбөрт хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган нийслэлийн 9 дүүрэг болон 18 аймгаас Ковид-19 цар тахлын эрсдэлтэй нөхцөлд биечлэн ажилласан төрийн жинхэнэ болон төрийн үйлчилгээний 147 байгууллагын нийт 1,177 албан хаагчийг орон сууцжуулсан. Төслийн хэмжээнд 55 аж ахуйн нэгж, 152 иргэний 100.0 тэрбум төгрөгийн орон сууцыг худалдан борлуулж бодит дэмжлэг үзүүлсэн. Үүнээс гэр хорооллын дахин төлөвлөлтийн 5, хувийн хэвшлийн 50 аж ахуйн нэгж 1,000 орон сууцыг худалдан борлуулсан нь цар тахлын үеийн эрсдэлийг даван туулахад нь хувийн хэвшлийн байгууллагад дэмжлэг болж чадсан. Мөн 2023 онд “НОСК ТАВ” ТЗК ХХК байгуулан, уг компаниар дамжуулан 50 тэрбум хүртэлх төгрөгийн түрээсийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гарган Монголбанкинд худалдах хэлбэрээр санхүүжин зах зээл дээр бэлэн байгаа 450 орон сууцыг худалдан авч нийслэлийн төр захиргааны ажилтан, албан хаагч болон цар тахлын үед ажлын байраа тогтвортой хадгалан үлдсэн хувийн хэвшлийн аж ахуйн нэгжийн ажилтнуудыг орон сууцанд хамруулах ажлыг хэрэгжүүлэн ажиллаж байна. 1,594 иргэн түрээслээд өмчлөх хөтөлбөрт хамрагдсан	85%
145.		9.7.2. Улаанбаатар хотын дэд төвүүдэд орлогод нийцсэн ногоон орон сууцны төсөл, Баянголын амны орон сууцны төсөл, төр хувийн хэвшлийн хамтын ажиллагааны орон сууцны төслүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	НОСК ХК,		2020 он 0	Ашиглалтад орсон орон сууц	2021-2025 5,500	-	-	1. Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1014 тоот захирамжийн дагуу ашиглалтын шаардлага хангахгүй, нийтийн зориулалттай 34, 35 дугаар орон сууцны барилгыг дахин барилгажуулах төсөл шилжиж ирсэн. Нийт 560 айлын үйлчилгээ бүхий 16 давхар 4 блок барилга угсралтын ажлыг амжилттай гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажлын хувьд 503, 504 дүгээр байруудын барилга угсралт, бусад ажил бүрэн дуусан бөгөөд гадна зам талбай, тохижилтын ажлыг одоо гүйцэтгэж байгаа ба улсын комисс хүлээн аваад байна. Харин үлдсэн 501, 502-р блок нь зоорийн болон 16 хүртэлх давхрын бетон цутгалтыг авсан ба гадна фасад болон цонх суурилуулах, дотор засал, өрлөгийн ажлыг гүйцэтгэж байна. 2026 оны 3 дугаар улиралд багтаан барилга байгуламжийг ашиглалтад оруулахаар бэлтгэж байна. 2.Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо Zuu residence (Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байрыг буулган, барилгажуулах- Бүх барилгыг буулган барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа бөгөөд эхний ээлжийн 2 блок байр улсын комисс ажиллаж ашиглалтад оруулахаар бэлтгэж байна. 2.Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо Zuu residence (Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байрыг буулган, барилгажуулах- Бүх барилгыг буулган барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа бөгөөд эхний ээлжийн 2 блок байр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээлгэн өгсөн. 3.СХД-ийн 19 дүгээр хороо White flora (Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 3-20 дугаар байрыг буулган, барилгажуулах ажлыг Очир бумбат констракшн компани гэрээ хийж гүйцэтгэж байгаа ба гадна инженерийн дэд бүтцийн иж бүрэн зураг, төсөл, төсвийн хамт магадлалын ерөнхий дүгнэлтээр албажин батлуулсан бөгөөд тус ажлын санхүүжилтийн 2026-оны төсөвт суулгуулахаар хүсэлтээ оруулсан, одоогоор санхүүжилтийн ажил хүлээгдэж байна. 4. Налайх дүүргийн 2 дугаар хороо /Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 24, 25, 26, 27, 29, 30 дугаар байрыг буулган, барилгажуулах-Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 26, 27 байрнуудыг буулган 2023 онд 126 айлын 2 блок орон сууцыг ашиглалтад оруулсан. Бусад байрны бүх оршин суугчдыг тус 2 байранд нүүлгэн шилжүүлсэн. 2025 онд 24, 25, 29, 30-р байрыг буулган барилгажуулах төслийн Гүйцэтгэгчийг сонгон шалгарах ажлыг зохион байгуулж төсөл хэрэгжүүлэгчээр “Ханхөгшин стейт” ХХК-г батламжилсан. Холбогдох зураг төслийн ажлыг боловсруулж байгаа ба ирэх 2026 оны хавар барилгын ажил эхлэхээр бэлтгэгдэж байна.	100%
146.		9.7.3. Шинэ суурьшлын бүсэд инженерийн болон нийгмийн дэд бүтэц бүхий орон сууцны хорооллын бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	НОСК ХК		2020 он 0	Шинэ суурьшлын бүсэд ашиглалтад орсон орон сууц	2021-2025 7,000	-	-	Морингийн даваа орчмын орон сууцжуулах төсөл нь 34.4 га газрыг хамарч байгаа бөгөөд Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК дулаанаар хангах боломжгүй болсон тул инженерийн тооцоолол хийсний үндсэн дээр шинээр дулааны станц барих шаардлагатай болсон. Шинэ суурьшлын бүсийн орон сууцны хорооллын төслийн хүрээнд 28 мВт хүчин чадалтай уурын зуух шинээр барих санхүүжилтийг Нийслэлийн 2025 оны төсөвт суулгасан боловч шийдвэрлэгдээгүй тул төсөл зогссон. Иймд хувийн хэвшлийн байгууллагуудад хандан санхүүжилт босгох ажлыг явуулж байна.	0%
147.	9.8. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулж, нийтийн зориулалттай орон сууцыг засварлан иргэдийн эрүүл, аюулгүй таатай орчинд амьдрах эрхийг хангана.	9.8.1. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулсан байна.	2021 - 2025	ХБХСГ, НОСБГ		2020 он 27	Буулгах барилга	2021-2025 55	-	-	2022-2023 онд нийт 25 багцын 72 барилгад дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах ажлыг зарлан, 7 багцад 12 хуулийн этгээдээс төслийн санал ирсэн. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1460 дугаар захирамжаар байгуулагдсан Үнэлгээний хорооны саналыг хүлээн авч, 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдөр үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, 5 хуулийн этгээдэд төсөл хэрэгжүүлэх эрх олгож, 2 болон 3 талт гэрээ байгуулах эрх олгосон. 2023 онд 307 айл өрхийн 3 орон сууц ашиглалтад орсон. (2019 онд 100 айлын 4 орон сууцыг буулган, 259 айлын 2 орон сууц (16 давхар), 2022 онд 12 айлын 1 орон сууцыг буулган, 48 айлын 1 орон сууц) 2024 онд 2 байршилд 296 айлын үйлчилгээтэй орон сууц ашиглалтад орсон. 2025 онд Хан-Уул дүүргийн 10 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1014 тоот захирамжийн дагуу ашиглалтын шаардлага хангахгүй, нийтийн зориулалттай 34, 35 дугаар орон сууцны барилгыг дахин барилгажуулах төсөл шилжиж ирсэн. Нийт 560 айлын үйлчилгээ бүхий 16 давхар 4 блок барилга угсралтын ажлыг амжилттай гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажлын хувьд 503, 504 дүгээр байруудын барилга угсралт, бусад ажил бүрэн дуусан бөгөөд гадна зам талбай, тохижилтын ажлыг одоо гүйцэтгэж байгаа ба улсын комисс хүлээн аваад байна. 2.Сүхбаатар дүүргийн 10 дугаар хороо Zuu residence (Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 1, 2, 3, 4, 6, 9, 10 дугаар байрыг буулган, барилгажуулах- Бүх барилгыг буулган барилга угсралтын ажил гүйцэтгэж байгаа бөгөөд эхний ээлжийн 2 блок байр улсын комисс ажиллаж ашиглалтад хүлээлгэн өгсөн. 3.СХД-ийн 19 дүгээр хороо White flora (Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 3-20 дугаар байрыг буулган, барилгажуулах ажлыг Очир бумбат констракшн компани гэрээ хийж гүйцэтгэж байгаа ба гадна инженерийн дэд бүтцийн иж бүрэн зураг, төсөл, төсвийн хамт магадлалын ерөнхий дүгнэлтээр албажин батлуулсан бөгөөд тус ажлын санхүүжилтийн 2026-оны төсөвт суулгуулахаар хүсэлтээ оруулсан, одоогоор санхүүжилтийн ажил хүлээгдэж байна. Бүх барилгыг буулган барилга угсралтын ажил гүйцэтгэж байна. 10 давхар хүртэлх барилга угсралтын ажил явагдаж байна. 4. Налайх дүүргийн 2 дугаар хороо /Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 24, 25, 26, 27, 29, 30 дугаар байрыг буулган, барилгажуулах-Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 26, 27 байрнуудыг буулган 2023 онд 126 айлын 2 блок орон сууцыг ашиглалтад оруулсан. 2025 онд 24, 25, 29, 30-р байрыг буулган барилгажуулах төслийн Гүйцэтгэгчийг сонгон шалгарах ажлыг зохион байгуулж төсөл хэрэгжүүлэгчээр “Ханхөгшин стейт” ХХК-г батламжилсан. Холбогдох зураг төслийн ажлыг боловсруулж байгаа ба ирэх 2026 оны хавар барилгын ажил эхлэхээр бэлтгэгдэж байна.	100%

148.		9.8.2 Нийтийн зориулалттай орон сууцны барилгын дээврийг засварласан байна	2021 - 2025	УБЗАА, Дүүргүүд		2020 он 187	Дээвэр засварласан барилга	2021-2025 362	4 тэрбум	3.5 тэрбум	2023 онд 91, 2024 онд 158, 2025 онд 71 барилгын дээврийн засвар буюу тайлант хугацаанд 320 угсармал орон сууцны барилгын дээврийн дулаалах ажил Улс, Нийслэлийн төсвөөр тус тус хийгдсэн. Мөн энэ оноос хуучнаар Барилга хот байгуулалтын яам, Улаанбаатар хотын Захирагчийнажлын алба, Германы хамтын ажиллагааны нийгэмлэгээс хамтран хэрэгжүүлж байгаа "Угсармал орон сууцны үр ашгийг дээшлүүлэх нь" төслийн хүрээнд 2025 онд нийт 27.8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж, Нийслэлийн төсвийн санхүүжилт 9.8 тэрбум төгрөгөөр Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт 15 блок барилга, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилт 18 тэрбум төгрөгөөр Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Налайх дүүрэгт 30 блок барилгын гадна фасад дулаалах, дээвэр засварлах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж байна	100%
149.		9.8.3. Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй цахилгаан шатыг шинэчилсэн байна.	2021 - 2025	УБЗАА, Улаанбаатар лифт ОНӨААТҮГ		2020 он 51	Цахилгаан шат	2021-2025 170	5.4	4.5	Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны лифт шинэчлэлийн ажилд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2023 онд 8 цахилгаан шат, 2024 онд 76 цахилгаан шат, 2025 оны А/188 дугаар захирамжийн хүрээнд Баянзүрх Сонгинохайрхан Хан-Уул Сүхбаатар Чингэлтэй дүүргүүдэд 37 байршилд ОКС экспресс монголиа ХХК Баянгол дүүрэг 5 байршилд Төвхөн трэйд ХХК нийт 42 ширхэг цахилгаан шатны шинэчлэлийн ажил бүрэн хийгдэж дуусан байна. Нийлэл болон нийслэлийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2023-2025 онд нийслэлийн 6 дүүргийн нийтийн зориулалттай орон сууцны ашиглалтын хугацаа дуусан болон ашиглалтын шаардлага хангахгүй нийт 136 цахилгаан шатыг бүрэн шинэчилж, 6550 өрхийн 26450 оршин суугчдын цахилгаан шатаар аюулгүй, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн.	100%
150.		9.8.4. Угсармал орон сууцн барилгыг дулаалсан байна.	2021 - 2025	УБЗАА		2020 он 73	Дулаалсан барилга	2021-2025 375	**27.8**	**-**	2022 онд 34, 2023 онд 89, 2024 онд 105, 2025 онд 142 блок буюу ний тайлант хугацаанд 370 угсармал орон сууцны дулаалгын ажлыг Улс, Нийслэлийн төсвөөр дулаалсан байна. Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл 2022 оноос хэрэгжихээр төлөвлөж, айл өрхийн эргэн төлөлтийн хувь хэмжээ нь 50 хувь байсныг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оршин суугчдаас авах эргэн төлөлтийн хувь хэмжээний хувилбарыг танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 25/54 дүгээр тогтоолоор “эргэн төлөлтийн хувь хэмжээг 25 хувь хүртэл байхаар” тогтоосон. Тогтоол батлагдаж эргэн төлөлтийн хувь хэмжээ 25 хувь хүртэл болсноос хойш нийт 95 блок барилгын оршин суугчидтай гэрээ байгуулсан. Герман улсын олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас 5 давхар, 9 давхар, 12 давхар угсармал орон сууцыг дулаалах давтан хэрэглэх нэг маягийн зургийг захиалан гүйцэтгүүлж, Барилгын хөгжлийн төвөөр 2025 оны 08, 09 дүгээр сард магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан байна. Төслийн хүрээнд 2025 онд нийт 27.8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж, Нийслэлийн төсвийн санхүүжилт 9.8 тэрбум төгрөгөөр Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт 15 блок барилга, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилт 18 тэрбум төгрөгөөр Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Налайх дүүрэгт 30 блок барилгыг дулаалах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж байна.	100%
151.		9.8.5	2021 - 2025	ОСНААУГ		1. 2020 он 5 2. 2020 он 1 3. 2020 он 0.3	1.Одоо байгаа 535 ус, дулаан дамжуулах төвөөс автомат удирдлага бүхий Scada систем суурилуулж, диспетчерийн нэгдсэн хяналтад шилжүүлэх шаардлагатай УДДТ-ийн тоо 2.Одоо байгаа 535 ус, дулаан дамжуулах төвөөс нэн яаралтай зэв шүүх төхөөрөмж суурилуулах шаардлагатай тоо 3.Ариутгах татуургын одоо байгаа 213.9 км шугамаас өргөтгөл, шинэчлэл хийх шаардлагатай шугам сүлжээний урт, км	1. 2021-2025 25 2. 2021-2025 21 3. 2021-2025 0.3	-	-	1.Тайлант хугацаанд нийт 10ш УДДТ-д СКАДА систем нэвтрүүлэн БТТ-ийн 10 УДДТ-г Нэгдсэн удирдлагын системд холбосон. Тус системийг нэвтрүүлснээр горимын хяналт сайжирч гэмтэл саатлын үед удирдлагын төвөөс шуурхай арга хэмжээ авах нөхцөл бүрдсэн. 60% 2.2021 онд нийт 4 байршилд зэвтэй ус бууруулах Vulcan -S5 болон RUSTSCAle Ionizer суурилуулж зэв бууруулан ажилласан. 2025 онд Солонгос улсын зэврэлтээс хамгаалах, усны чанар сайжруулах, шугам хоолойн ашиглалтын хугацаа уртасгах Vulcan төхөөрөмжийг 2 ширхэгийг суурилуулсан. 33% 3.2021-2025 онд 40.3 км ариутгах татуургын шугам сүлжээг шинэчлэн солисон байна. 100%	64%
152.	9.9. Хотын барилга байгууламжийг паспортжуулан, газар хөдлөлтөд тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийнэ.	9.9.1. 2002 оноос өмнө баригдсан орон сууц болон олон нийтийн зориулалттай барилга, байгууламжийн бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гарган, паспортжуулах ажлыг хийж дуусан байна	2021 - 2025	ХБХСГ		1. 2020 он 840 2. 2020 он 15	1.Дүгнэлт гаргаж, паспортжуулсан барилга 2.Бат бэх, найдваржилтын төлөв, хэмжилтийн иж бүрэн багаж, хэрэгсэл	1. 2021-2025 1,415 2. 2021-2025 26	187.9	187.9	1. 2002 оноос өмнө баригдсан паспортжуулах шаардлагатай 1844 барилгаас 2011-2025 онд нийт 1023 барилгад буюу 55.4% хувьд нь судалгаа хийн дүгнэлт гаргаж паспортжуулсан. Үүнд: Нийтийн зориулалттай орон сууцны 698 барилга, Олон нийтийн 325 барилга байна. Судалгаа хийсэн 1023 барилгаас Газар хөдлөлтөд тэсвэртэй 227 барилга, Хүчитгэл, бэхэлгээ хийх 224 барилга, болзошгүй газар хөдлөлтөд тэсвэргүй 572 барилга байна. 2025 онд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын даргын 2025 оны А/28 дугаар захирамжаар Газар хөдлөлтийн тэсвэрлэлтийн үнэлгээ хийж, бат бэх, найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргах ажлын хүрээнд "Онч тэнхлэг" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан захиалагчийн хяналт тавин ажиллаж, ажлын эцсийн тайланг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр ирүүлж, 23 барилгын дүгнэлтийг холбогдох эзэмшигч, өмчлөгчдөд хүргүүлсэн. 100% 2. Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас Нийслэлийн хэмжээнд ашиглагдаж байгаа болон баригдаж буй барилга байгууламжид газар хөдлөлтөд тэсвэрлэх чадвар, бат бэх найдваржилтын төлөв байдалд мэргэжлийн дүгнэлт гаргаж, паспортжуулах үйл ажиллагаанд шаардагдах үл эвдэх сорилын Silver Schmidt OS8200 алх, лазер метр бусад багаж хэрэгслийг 2024 оны 12 дугаар сарын 16-ны өдөр “Эн Ди Ти Эс” ХХК-тай ХБХСГ2024/17 дугаартай худалдах, худалдан авах гэрээг байгуулан худалдан авсан байна. 60%	80%

153.		9.9.2. Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, олон нийтийн барилгын хүчитгэлийн зураг, гамшгийн эрсдэлд тэсвэртэй амины сууцны загвар зургийг боловсруулсан байна.	2021 - 2025	ХБХСГ		1. 2020 он 0 2. 2020 он 5	1. Загвар зураг 2.Хүчитгэлийн зураг	1. 2021-2025 15 2. 2021-2025 20	-	-	Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/554 дүгээр эрх шилжүүлэх захирамжаар Гамшигт тэсвэртэй амины орон сууцны нэг маягийн 10 төрлийн загвар зураг боловсруулах ажилд “Эм Эм Инженеринг” ХХК 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр 96.3 сая төгрөгийн өртөг бүхий гэрээ байгуулсан. Гэрээнд тусгагдсаны дагуу 2 хийц бүтээц бүхий 10 төрлийн барилгын иж бүрэн зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, барилгын төсвүүдийн хамт хүлээлгэн өгч, иргэд, олон нийтэд нээлттэй ашиглуулж байна. Монгол Улсын Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх чадавхыг бэхжүүлэх төслийн 2 дугаар үе шатны ажил эхлэхтэй холбоотой 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр Япон Улсын хамтын ажиллагааны ЖАЙКА байгууллагын төлөөлөлтэй уулзаж, барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчин, бодлого, норм дүрэм, хүчитгэх үйл ажиллагаа, боловсон хүчний чадавхыг бэхжүүлэх талаар санал солилцов. Тус уулзалтаар 5 барилгын хүчитгэлийн зураг боловсруулахаар шийдвэрлэсэн. Төсөл 2022-2026 онд хэрэгжинэ. Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/377 дугаар эрх шилжүүлэх захирамжаар Хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын хүчитгэлийн зураг төслийг зөвлөх үйлчилгээний “А И Си архитектс” ХХК боловсруулан хүлээлгэн өгсөн.	100%
154.	9.10. Эрчим хүчний ашиглалтын үр ашгийг өсгөж, дэд бүтцийг өргөжүүлэн, технологийн шинэчлэл хийж, хүн амыг тогтвортой эрчим хүчээр хангана.	9.10.1. Цахилгааны шугам сүлжээг шинэчлэн, хүчин чадлыг нэмэгдүүлж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай айл өрхийг цахилгаан эрчим хүчээр бүрэн хангана.	2021 - 2025	УБЗАА		1. 2020 он 1,300 2. 2020 он 42,000	1.Гэрэл цахилгаанд холбогдож, хүчдэлийн уналтыг сайжруулсан айл өрх 2.Цахилгаан халаагуураар хангагдах техникийн боломж бүрдсэн айл өрх	1. 2021-2025 6,500 2. 2021-2025 122,000	9.5 тэрбум 75.8 тэрбум	9.5 тэрбум 75.8 тэрбум	1.2020–2025 оны хооронд айл өрхүүдийг цахилгаан эрчим хүчинд холбох, хүчдэлийн уналтыг бууруулах ажлыг үе шаттай хэрэгжүүлсний үр дүнд 2020 онд 2,915, 2021 онд 2,018, 2022 онд 10,452, 2023 онд 486, 2024 онд 2,217, 2025 онд 4,250 өрх шинээр цахилгаанд холбогдож, хэрэглээний хүчдэлийн найдвартай байдал сайжирсан байна. 100% 2.Нийслэлийн 5 дүүргийн 42 хороонд гэр хорооллын 46,976 айл өрхийг цахилгаан халаагуур ашиглах боломжтой болгох зорилгоор түгээх сүлжээний техникийн нөхцөлийг бүрдүүлэх 75.8 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажлыг 2017-2019 болон 2023 онуудад гурван үе шаттайгаар хэрэгжүүлсэн. 2025 оны байдлаар нийт 61,245 айл өрх цахилгаан халаалтын системд холбогдсоноос дан цахилгаанаар дулаанаа шийдэж халаадаг 26,763 өрх, цахилгаан болон галлагааг хосолсон хосолмол халаалттай 34,482 өрх бүртгэгдсэн байна.	100%
155.		9.10.2. Эрчим хүчний цэнэг хураагуурын станц шинээр ашиглалтад оруулсан байна.	2021 - 2025	НХБХГ		2020 он 0	50 МВт чадалтай цэнэг хураагуурын станц	2021-2025 1	-	-	2022 он: 220/110/35 кВ-ын Сонгино дэд станцыг түшиглэн эрчим хүчний сүлжээнд ашиглах 80 МВт/200 МВт.ц чадалтай том чадлын хуримтлуурын төслийг БНХАУ-ын ZTT болон ZEST компаниудын хамтарсан консорциум 2022-2025 онд хэрэгжүүлэхээр гэрээ байгуулагдав. Зураг төслийн ажлыг эхлүүлэхээр төслийн талбайд Геодези болон Инженер-геологийн судалгааны ажлуудыг гүйцэтгэж дуусан, ажлын зураг төсвийг боловсруулахаар судалгаа тооцооны ажил хийгдэж байна. 2023 он: 80 МВт/200 МВт.ц чадалтай эрчим хүч хуримтлуулах зай хураагуурын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “ZTT” болон ZEST” компаниудын хамтарсан консорциумтай 2022 оны 07 дугаар сард ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил дуусаж, 2023 оны 12 дугаар сард сүлжээнд залгаж ашиглалтад оруулсан. 2024 он: Улаанбаатар хотод том чадлын батарей хуримтлуур бүхий дэд станц байрлуулах боломжтой байршлуудыг эрчим хүчний яамнаас ирүүлсэн бөгөөд 220/110/35кВ-ын Багануур дэд станцад 50/200мвт/ц чадал бүхий хуримтлуурын станц байгуулахаар ажлын хэсэг байгуулагдсан. Тус хуримтлуур нь эрчим хүчний системийн оргил ачааллын үед хуримтлуулсан цэнэгээр цахилгаан эрчим хүч түгээх, шөнийн бага ачааллын үед төвийн эрчим хүчний системээс цэнэглэгдсэнээр өвлийн их ачааллын үед эрчим хүчний системд бодитой дэмжлэг болохуйц ач холбогдолтой төсөл. Төслийн гүйцэтгэгчээр БНХАУ-ын ЭНВИЖН ЭНЕРЖИ ХХК шалгарч 2024 оны 09 дүгээр сарын 06-нд ажил гүйцэтгэх гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг гүйцэтгэж эрчим хүчний нэгдсэн сүлжээнд холбож ажиллагаанд залгасан.	100%
156.	9.11. Гудамж, зам талбайн гэрэлтүүлгийг нэмэгдүүлнэ.	9.11.1. Гудамж, зам, талбайн гэрэлтүүлгийг үе шаттай нэмэгдүүлж, нэгдсэн удирдлагын автомат системд холбосон байна.	2021 - 2025	УБЗАА		1. 2020 он 65,030 2. 2020 он 918	1. Гудамжны гэрэлтүүлэг 2. Цахилгаан хуваарилах самбар	1. 2021-2025 95,030 2. 2021-2025 1,168	5,141,186,096	5,141,186,096	1.Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гэрэлтүүлгийн хэмжээ сүүлийн жилүүдэд тогтмол өссөн бөгөөд 2020 онд 61,163 ш, 2022 онд 70,000 ш, 2023 онд 92,870 ш, 2024 онд 100,596 ш-т хүрч, 2025 онд нийт 115,642 ширхэг гэрэлтүүлэг ашиглагдаж байна. Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн хэмжээнд 5,141,186,096 төгрөг санхүүжилттай 1627 ш гэрэлтүүлэг хийгдсэн. 10 дугаар сарын байдлаар төвийн 6 дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, авто замын гэрэлтүүлгийн засвар, үйлчилгээний дараах ажлуудыг гүйцэтгэлээ. Гэрэлтүүлгийн 11,599 ш гэрлийн толгойд засвар үйлчилгээ хийж, асалтын хувийг сайжруулсан. Агаарын СИП кабель нийт 64,524 метр засварлаж, сольж асалтыг сайжруулсан. Гэрэлтүүлгийн шонгийн өнгө үзэмжийг сайжруулах зорилгоор 6,699 ш шон будсан, 873 ш шон угаасан. Аюулгүй байдлыг хангах үүднээс 473 ш эвдэрсэн, таггүй гэрлийн шонг тагжуулсан. Гэрэлтүүлгийн 468 ш шонд засвар үйлчилгээ хийсэн. 1082 ш гэрэлтүүлгийн кабельд засвар хийж, хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Шаардлага хангахгүй 40 ш шонг буулгаж, шинэчлэлт хийсэн. 786 ш гэрэлтүүлгийн шонд цацруулагч хийсэн. Асалтын чанарыг сайжруулах зорилгоор 50Вт, 100Вт, 150Вт-ын 805 ш гэрлийг шинээр сольж суурилуулсан. 100% 2.2021-2025 онд Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн хуваарилах самбарын тоо жил бүр нэмэгдэж, 2021 онд 1,103 ш, 2022 онд 1,198 ш, 2023 онд 1,300 ш, 2024 онд 1,333 ш, 2025 оны 12 дугаар сарын байдлаар 1,435 ш-т хүрсэн байна. Нийт 1,435 самбараас нэгдсэн удирдлагын “Тулга” системд холбогдоогүй 196 самбар үлдсэн бөгөөд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн А/179 тушаалын дагуу 100 ширхэг алсын удирдлагын тоноглол бүхий самбар худалдан авах ажил гэрээний шатанд үргэлжилж байна. Худалдан авалт хэрэгжсэнээр гэрэлтүүлгийн хуваарилах самбарын нэгдсэн удирдлагын түвшин нэмэгдэж, хяналт удирдлагын үр ашиг сайжрах нөхцөл бүрдэнэ. 100%	100%

157.	9.12. Дулааны эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангах эх үүсвэрийн чадлын нөөцийг бий болгоно.	9.12.1. Дулааны станцын хүчин чадал, гол магистраль шугамын дулаан нэвтрүүлэх чадвар нэмэгдсэн байна.	2021 - 2025	НХБСГ		1. 1 2. 379.5 3. 15.1	1.Дулааны станц 2.Шинээр ашиглалтад оруулах дулааны магистраль шугмын урт 3. Одоо байгаа дулааны магистраль 379.5 км шугамаас өргөтгөн шинэчлэх шаардлагатай шугмын урт	1. 4 2. 396.9 3. 15.1	-	-	2022-2025 онд: Сэлбэ дэд төвийн дулааны станц 2021 оны 4 дүгээр улиралд ашиглалтад орсон. 100% Налайх дүүрэг 180МВт-ийн дулааны станцын ажлын зураг төсөл хийгдэж дууссан. Дамбадаржаа дэд төвийн 63МВт-ын хатуу түлшний дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ, ажлын зураг төсөл бүрэн дууссан. 2025 онд: ЧД-ийн 19-р хороо, Дамбадаржаа дэд төвийн гадна инженерийн шугам сүлжээ, 63МВт-ын дулааны станцын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Дулааны шугамын угсралтын ажил 100 хувьтай, дэд төвийн барилга угсралтын ажил 7 хувьтай хийгдэж байна. Амгалан дулааны станцыг 116 МВт (100 Гкал/цаг) хүчин чадалтай нэг зуухаар өргөтгөтгөж ажиллагаанд залгагдсан. НИТХ-ын 2023 оны 61 дүгээр тогтоолын хүрээнд Сэлбэ дэд төвийн 158 га талбайд барилгажилтын төсөл, гадна инженерийн шугам сүлжээний төлөвлөлтийн шийдэл зөвшилцсөн. 2.2022 он: Улс, нийслэл, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр 7 байршилд шинээр хийгдэх болон өргөтгөл шинэчлэлтийн ф250/350/400/700/800/1000мм голчтой 11,42 км төвлөрсөн дулаан хангамжийн шугам сүлжээний ажлын зураг төсөл зөвшилцсөн.100% Улсын төсөв болон Европын сэргээн босголтын банкны санхүүжилтээр төвлөрсөн дулаан хангамжийн өргөтгөл шинэчлэлтийн 2ф200/350/400/500/ 700/800/1000мм-ийн голчтой 8.404км дулааны шугамын барилга угсралтын ажлыг хийхээр төлөвлөгдсөн. 2023 он: Сэлбэ дулааны станцаас хангагдах УДДТ-12, 1,2 км дулааны шугам сүлжээ ашиглалтад орсон. - ТЭЦ-3-аас холбогдсон 5 дугаар магистралийн өргөтгөл шинэчлэлийн ажил хийгдсэн. - Төвлөрсөн дулаан хангамжийн 10вгд магистраль шугамын ОЦ-1050 /ТК703/-р цэгээс 3д магистралын 22 дугаар онцлог хүртэл 2ф1000 мм-н голчтой дулааны шугам шинээр татах, мөн цэгээс насос станц №3 хүртэл 2ф800 мм-ийн голчтой шугамыг 2ф1000 мм-ийн голчтой болгож өргөтгөх ажлын зургийн даалгаварт санал хүргүүлж, төвлөрсөн дулаан хангамжийн шинэчлэлтийн ажлын зураг төсөл зөвшилцсөн. - 1а магистраль, ДХ110-17 цэгээс Зайсангийн ДДТ /одоо буй/ хүртэлх 2ф300мм-н голчтой шугамыг 2ф350мм болгож 380хос метр болгон өргөтгөх ажлыг Нийслэлийн 2024 оны төсвийн тодотголд тусгуулах санал хүргүүлсэн мөн Монгол улсын хөгжлийн 2025 оны төсвийн тодотголд 01/203 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. ХУД-ийн 16-р хороонд Даралт өргөх станц №7-ийн барилга уусгалтын ажил 40 хувьтай хийгдэж байна. 90% 3.2ф600/400мм-ийн голчтой 1.8км дулааны шугамын барилга угсралтын ажлыг 2024 онд угсралт болон салбар шугамын угсралт дууссан. Хэрэглэгчдийг дулаанд залгасан. ХУД-ийн 6-р хороонд ДЦС-4–өөс Яармаг гэр хороолол хүртэлх 2ф600-2ф700мм-ийн голчтой 0.722км дулааны шугамын хөрсний уснаас гарган шилжүүлэх шугамын угсралтын ажил хийгдэж дууссан ба ажиллагаанд залгасан. 100%	97%
158.		9.12.2. Амгалан дулааны станц болон 3 дугаар цахилгаан станцын өргөтгөл шинэчлэлтийн ажилтай уялдуулан, төрийн өмчийн халаалтын зуухнуудыг үе шаттайгаар төвлөрсөн дулаанд холбосон байна.	2021 - 2025	УБЗАА		2020 он 557	Төвлөрсөн дулаанд холбох шаардлагатай зуух, тоо	2021-2025 432	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны 258-р тогтоол, 2018 оны “Агаарын бохирдлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоол, 2019 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоол, Шадар сайдын 2020 оны “Усан халаалтын болон уурын зуухыг дэвшилтэт технологид шилжүүлэх тухай” 58-р тушаал, Нийслэлийн засаг даргын 2019 оны 1377 дугаар захирамжийн хүрээнд Нийслэл хотын 6 дүүргийн хэмжээнд 2021 онд 49 халаалтын уурын зуух, 2022 онд 13 халаалтын зуух, 2023 онд 23 халаалтын зуух, 2024 онд 7 халаалтын зуу нийт 92 ширхэг халаалтын зуухыг буулгаж нийт 123 барилгын 13.9 Гкал/ц ачаалалыг төвлөрсөн дулаан хангамжийн системд холбосон байна.	98%
159.		9.12.3. Хийн түлшний дулааны эх үүсвэрүүдийг барьж байгуулна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 0	Хийн түлшний дулааны эх үүсвэр	2021-2025 5	-	-	Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2021 оны V дугаар хуралдааны 01 дүгээр хурлын тэмдэглэлээр Төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолмол ажиллагаатай 80 Гкал/цаг-ийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ дэмжигдсэн. Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд Эрчим хүчний яамнаас оргил ачааллын үед төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээтэй хосолмол ажиллагаатай шингэрүүлсэн хийн түлшний технологи бүхий нийт 270 МВт хүчин чадалтай дулааны станцыг 4 байршилд төлөвлөсөн. Тархмал эх үүсвэрийг барих байршлууд батлагдаагүй байна. Дэнжийн мянга дэд төвийн 93МВт-ийн хийн түлшний дулааны эх үүсвэрийн ажлын зураг төслийг зөвчилцсөн бөгөөд Хот байгуулалтын мэдээллийн санд оруулсан. Онцгой байдлын өрөнхий газартай зөвшилцөх шатанд явж байна. Эрчим хүчний сайд, Нийслэлийн Засаг даргын хамтарсан 2025 оны А/55, А/124 дугаартай тушаал захирамжаар Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдсан Ажлын хэсгийн хүрээнд 2025-2028 онд хэрэгжүүлэх орон сууцны төслүүдийн хүрээнд тусгасан ба шаардлагатай хөрөнгө тусган ээлжит Ажлын хэсгийн хуралд хэлэлцүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1215 дугаартай захирамжийн хүрээнд Хан Хиллсын 4 га гадарт 112МВт-ийн хийн эх үүсвэр баригдахаар төлөвлөсөн. ЧД-ийн 10-р хороо, дүүргийн нэгдсэн эмнэлгийн бие даасан 5МВ-ийн хийн хангамжийн дулааны эх үүсвэрийн ТЭЗҮ, ажлын зураг боловсруулах ажлын даалгавар 2025 оны МЗХ 2025/46-001 дугаартай батлагдсан.	85%

160.		9.12.4. Төвлөрсөн дулаан хангамжид холбогдох боломжгүй аж ахуйн нэгж, байгууллагын хатуу түлшний халаалтын зуухнуудыг хийн түлшинд шилжүүлсэн байна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 20	Хатуу түлшнээс хийн түлшинд шилжсэн аж ахуйн нэгж, байгууллага	2021-2025 70	-	-	Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн нэгжид Нийслэлийн СХД, СБД, БЗД-ийн 10 байршилд сургууль, цэцэрлэгийн барилгын халаалтын зуухыг шинэчлэн хийн түлш болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэртэй хосолмол ажиллагаатай ажиллах ажлын зургийн даалгавар батлуулж хүргүүлсэн. Тус ажлуудын ажлын зураг төслийг зөвшилцсөн. Нисэх, Яармаг орчмын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу хийн түлшний дулааны эх үүсвэр барих ТЭЗҮ боловсруулах зардлыг 2023 оны Улс, нийслэлийн төсөвт тусгуулахаар 2022 оны 02/01/1250 дугаар албан бичгээр саналаа хүргүүлсэн. Сүхбаатар дүүргийн 17-р хороо, 58 дугаар сургууль 2022 онд хийн түлшний эх үүсвэртэй болсон. Улаанбаатар хотын төвлөрсөн дулаан хангамжийн хүндрэлтэй (хөлдөлт үүсэх эрсдэлтэй) цэгүүдэд оргил ачааллын горимд ажиллах хийн түлшний тархмал 4 эх үүсвэрийг шинээр барихаар төлөвлөж байгаа ба эхний ээлжид Насос Станц №10-ын урд Цэцэрлэгт хүрээлэнгийн хашаанд, Дунжингарав худалдааны төвийн замын урд, Үндэсний цэцэрлэгт хүрээлэнгийн ээзмшил газарт, Зайсан Хөдөө Аж Ахуйн Их сургуулийн Агропаркийн хашаанд, Хилийн цэргийн 124 дүгээр ангийн газарт байрших хийн дулааны станцын судалгааг тус тус боловсруулсан. Гэр хорооллын дахин төлөвлөлтөд орох боломжгүй айл өрхийн дулаан хангамжийг бусад эх үүсвэрт шилжүүлэх ажлын хүрээнд БЗД-ийн 2, 27-р хорооны 180 өрхийг шингэрүүлсэн хийн түлшний хэрэглээнд шилжүүлэхэд 2,800.00 сая төгрөгийн санхүүжилт Тархмал эрчим хүчний дэд бүтэц ХХК-д олгогдсон.	100%
161.	9.13. Мэдээлэл, холбооны электрон автомат станц, мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилгуудыг холбож, нэгдсэн том сүлжээ үүсгэн, зохион байгуулалтыг сайжруулна.	9.13.1. Мэдээлэл, холбооны нэгдсэн төвийн барилга, худаг сувагчлалын байгууламж шинээр барьж, мэдээлэл холбооны нэгдсэн сүлжээ бий болгосон байна.	2021 - 2025	ХБХСГ, УБХГХХХОДТ-ийн нэгж		1. 2020 он 10 2.2020 он 1,066	1.Мэдээлэл, холбооны нэгдсэн төв 2.Сувагчлалын байгууламжийн урт, км	1. 2021-2025 17 2.2021-2025 1,126	-	-	1.2022 онд Баянхошуу дэд төв, Сэлбэ дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга, 5.6 км худаг сувагчлалын байгууламжийг ГХХХОДХ төслийн хүрээнд гүйцэтгэн ашиглалтад оруулан “Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-д шилжүүлэн өгсөн. 2022 онд Нисэх, Яармаг орчмын мэдээлэл холбооны нэгдсэн төвийн барилга, худаг сувагчлалын байгууламжийн ажлын зураг төслийг гүйцэтгэж дууссан. 2023 онд Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд Баянхошуу дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийг холбосон 2,94 км худаг сувагчлал, Сэлбэ дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийг холбосон 2,78 км худаг сувагчлал шилэн кабелийн сүлжээний барилга угсралтын ажил дууссан. Нийт 9,72 км худаг сувагчлалын байгууламж барьсан. 2024 онд Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд Дамбадаржаа дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийг холбох нийт 8,43 км худаг сувагчлалын байгууламжаас 2,49 км худаг сувагчлалын угсралтын ажил хийгдсэн. 2025 онд Гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр төслийн хүрээнд Дамбадаржаа дэд төвийн мэдээлэл холбооны нэгдсэн төвийг холбох нийт 8,43 км худаг сувагчлалын байгууламж 55% гүйцэтгэлтэй худаг сувагчлалын угсралтын ажил хийгдсэн. 100% 2.Морин давааны чиглэлд 4 км худаг сувагчлалын байгууламж 100 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж дууссан. Хан-Уул дүүргийн 4, 8, 10 дугаар хороо Яармаг Шинэ Яармаг Буянт-Ухаа хороололд мэдээлэл холбооны нэгдсэн төв,11.7 км худаг сувагчлалын байгууламж барих ажил болон зураг төсөл шаардлагатай 4.9 км 4+0 худаг сувагчлалын байгууламж барих зураг төсөл /Баянхошуу дэд төвөөс МҮОНРТ хүртэл/, 32-ын уулзвараас 7 буудал хүртэлх авто замын гэрэлтүүлгийн баганаар татагдсан кабелийг худаг сувагчлалд шилжүүлэх ажлын зураг, 8.2 км 4+0 худаг сувагчлалын байгууламж барих зураг төсөл /Улиастайн Р-С 03-17-9 дугаартай төгсгөлийн худгаас гачуурт станц хүртэл/, 3.6 км 4+0 худаг сувагчлалын байгууламж барих зураг төсөл. /Дамбадаржаа миний захаас Бэлх зах хүртэл/ дээрх ажлуудыг 2025 оны төсөв, төсвийн тодотголд тусгуулахаар санал хүргүүлсэн.	100%
162.	9.14. Инженерийн бэлтгэл арга хэмжээний барилга байгууламжийг барьж, иргэдийг үер, усны аюулаас урьдчилан сэргийлэн, амьдрах орчныг сайжруулна.	9.14.1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний баримт бичиг, зураг төсөл боловсруулсан байна.	2021 - 2025	НЗДТГ, УБЗАА, ХБХСГ		1. 2020 он 0 2. 2020 он 3	1. Инженерийн бэлтгэл арга хэмжээний бодлогын баримт бичгийг боловсруулан батлагдсан тоо 2. Өндөржилтийн зураг төсөл хийгдсэн дүүргийн тоо	1. 2021-2025 1 2. 2021-2025 6	1200 .0	-	1.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 65 дугаар тогтоолоор Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөөг батлагдсан. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/174 тоот захирамжийн дагуу Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (НЗДТГ), Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (УБЗАА), Цаг уур, орчны шинжилгээний газар (ЦУОШГ), Нийслэлийн Онцгой байдлын газар (НОБГ), Геодези, усны барилга байгууламжийн газар (ГУББГ) ОНӨААТҮГ хамтран “Нийслэлийн 2025 оны үерийн эрсдэлийн ерөнхий үнэлгээний тайлан”-г 2025 оны 06 дугаар сард боловсруулсан. Эрсдэлийн үнэлгээ, үнэлгээний аргачлал, аюулын дүгнэлт, үерийн чадавхын үнэлгээ, өнгөрсөн үерийн сургамж, үерийн эрсдэлийг бууруулахад нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг шат дараатайгаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын алба (НГЗБА), НОБГ хэрэгжүүлэн ажиллаж байна. 100% 2.Барилга, хот байгуулалтын сайдын 2020 оны А/169 дүгээр тушаалаар 2021 онд “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар дараа онуудад хэрэгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, төсөл арга хэмжээний хүрээнд хийгдэх ажлын жагсаалт”-ыг батлагдсан. Тус жагсаалтын хүрээнд Улаанбаатар хотын өндөржилтийн нэгдсэн төлөвлөлтийн зураг төслийн ажлыг боловсруулах гүйцэтгэгчээр зөвлөх үйлчилгээний “Инженер Геодези” ХХК шалгарч, Улаанбаатар хотын суурьшлын хэсгийн нутаг дэвсгэр дэх Сонгинохайрхан дүүргийн 14,454 га, Баянгол дүүргийн 2,506 га /баруун бүс/, Хан-Уул дүүргийн 9,150 га /урд бүс/ нийт 26,110 га талбайд өндөржилтийн нэгдсэн төлөвлөлтийн зураг төслийг бүрэн боловсруулан дуусгаж Барилга, хот байгуулалтын яаманд хүлээлгэн өгсөн. 100%	100%
163.		9.14.2. Үерийн хамгаалалтын далан, суваг, шугам сүлжээг шинээр барих болон өргөтгөн, шинэчилсэн байна.	2021 - 2025	УБЗАА, НЗХГ, ХБХСГ, НГЗБА, ГУББГ		1.148 2.187 3.18.3 4.5.1	1.Шинээр ашиглалтад орох үерийн хамгаалалтын далан, сувгийн урт 2. Шинээр ашиглалтад орох зам, талбайн борооны ус зайлуулах шугам сүлжээний урт 3. Шинээр ашиглалтад орох хөрсний усны шугам сүлжээний урт 4. Одоо байгаа 148 км үерийн далан сувгаас засвар, шинэчлэлт хийх шаардлагатай үерийн сувгийн урт	1. 158.6 км 2. 223.1 км 3. 30 км 4. 5.1 км	-	-	1.2021 онд 1.1 км, 2022 онд 0.9 км, 2023 онд 0.88км, 2024 онд 0.93 км, 2025 онд 5.63 км буюу тайлант хугацаанд нийт 9.44 км үерийн хамгаалалтын далан сувгийн ажлыг гүйцэтгэж 2025 оны байдлаар Улаанбаатар хотод нийт 165.7 км үерийн хамгаалалтын далантай болсон. 100% 2.Нийслэлийн Замын хөгжлийн газрын санхүүжилтээр 2025 онд 14 байршилд 7.7км шугам угсралтын ажлыг Геодези, усны барилга байгууламж хийж гүйцэтгэв. 100% 3.2021-2025 оны хооронд 7 байршилд /ЧД 17 18 хороо, БЗД 27 хороо, Сэлбэ дэд төв, СХД 7 хороо, СБД 14 15 17/ 8.5 км зам хөрсний усны шугам угсралтын ажлыг Геодези, усны барилга байгууламж ОНӨААТҮГ гүйцэтгэж ашиглалтад оруулав. 4.Улаанбаатар хотын Ерөнхий менерийн 2024 оны А62, 2025 оны А09 дугаартай тушаалаар 2024 онд 890м, 2025 онд 120 м үерийн хамгаалалтын далан сувагт засвар шинэчлэлтийн ажлыг тус тус хийж гүйцэтгэв.	100%

164.		9.14.3. Далан суваг, шугам сүлжээний цэвэрлэгээ, үйлчилгээ, засварт шаардлагатай машин, механизмаар хангана.	2021 - 2025	УБЗАА, ГУББГ, НЗДТГ		2020 он 51	Машин, механизм	2021-2025 71	-	-	Нийслэлийн хэмжээнд үер, хур тунадас болон хөрсний уснаас хамгаалах барилга байгууламж, хурын ус зайлуулах шугам сүлжээний ажлыг зохион байгуулах, үер усны эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ хариуцан ажиллаж 2021-2025 онд далан суваг, шугам сүлжээний цэвэрлэгээ, үйлчилгээ, засварт шаардлагатай машин, механизмын тоо 26-аар нэмэгдсэн байна.	100%
165.	9.15. Ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх болон усны алдагдлыг бууруулж, шугам доторлох төслийг үргэлжлүүлж дуусгана.	9.15.1. Хотын баруун хэсэгт ус хангамжийн шинэ эх үүсвэр барьж, төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усыг гүн цэвэршүүлэн, дулаан, цахилгааны станцуудад техникийн усны зориулалтаар дахин ашиглана.	2021 - 2025	УБЗАА, ХБХСГ, НГЗБА, УСУГ		2020 он 0	Улаанбаатар хотын усны эх үүсвэрийг сайжруулах төсөл"-ийн бүтээн байгуулалт	2021-2025 100	-	-	Америкийн Нэгдсэн Улсын Мянганы сорилтын сангийн II компакт гэрээний хүрээнд 350 сая доллар буцалтгүй тусламж, Монголын Засгийн газрын 120 сая долларын хөрөнгө оруулалтаар 2021-2025 онд Улаанбаатар хотын үндны усны хүртээмжийг сайжруулах чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүллээ. 1.Баруун доод эх үүсвэрийн бохирдолтой усыг дахин цэвэршүүлж хотын үндны усны хэрэглээнд ашиглах шугам сүлжээ, үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажил 97 хувьтай хийгдэж байна. 2.Улаанбаатар хотын гүний усны нөөцийн 30 хувийг ТЭЦ-үүдийн хөргүүрт ашиглаж байгааг дахин цэвэршүүлсэн усаар хангах зорилгоор төв цэвэрлэх байгууламжаас гарсан бохир усыг дахин цэвэршүүлэн технологийн хэрэглээнд ашиглахаар бүтээн байгуулалтын ажил хийгдсэн. Цэвэршүүлэх үйлдвэрт 50000 м3/хон усыг дахин цэвэршүүлж, үйлдвэрээс ТЭЦ-3 хүртэл 10,5 км шугам, насос станцын ажил хийгдсэн. 3.Гэр хорооллын айл өрхүүдийн ус хангамжийн үйлчилгээг сайжруулах ажлын хүрээнд гэр хороололд байгаа 156 худгийг автоматжуулж хэрэглэгчид 24 цаг усаар тасалдахгүй байх нөхцөл бүрдсэн. Мөн компакт гэрээний салшгүй хэсэг болох шинээр ашиглалтад орох үйлдвэрүүдэд ажиллах боловсон хүчин бэлтгэх ажил хийгдсэн.	97%
166.		9.15.2. Туул усан цогцолборын техник, эдийн засгийн үндэслэлийг эцэслэн дуусгаж, барилга угсралтын ажлын зураг төслийг боловсруулсан байна.	2021 - 2025	ХБХСГ		2020 он 0	Туул усан цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, ажлын зураг төсөл	2021-2025 2	-	-	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/479 дүгээр захирамжаар “Туул усан цогцолбор” төслийн ТЭЗҮ, хөрөнгө оруулалтыг төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх санал дүгнэлт боловсруулах үүрэн бүхий ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хэсгийн хуралдааны үүрэг даалгаврын хүрээнд Туул усан цогцолборын техник эдийн засгийн үндэслэлийг Энэтхэгийн компани боловсруулж байна.	70%
167.		9.15.3. Ундны усны эх үүсвэрийн гүний худаг, тоолуургүй айл өрхийг тоолуржуулж усны бодит хэрэглээг тооцож, усны лабораторийн хүчин чадлыг өргөтгөн шинэчилсэн байна.	2021 - 2025	УБЗАА, УСУГ		1. 2020 он 0 2. 2020 он 85,831 3. 2020 он Ф15/100 4. 2020 он 1	1.Ундны усны эх үүсвэрийн тоолуржуулах худгийн тоо 2.Усны тоолууртай өрх 3.Цэвэр, бохир усны лабораторийн хүчин чадлыг өргөтгөх диаметр 4.Усны төв лабораторийн химийн элементийн шинжилгээний багажийг өргөтгөн шинээр суурилуулах тоо	1.2021-2025 218 2.2021-2025 105,580 3.2021-2025 Ф15/500 4.2021-2025 1	454.7	454.7	1.Баянхошуу (дээд, доод), Шархад, Чингэлтэй, Хайлааст, Баруун дүүрэг зэрэг 6 дамжуулах насос станц болон Төв, Үйлдвэр зэрэг 2 эх үүсвэрийн станцад нийтдээ 37 ширхэг тоолуурыг цахилгаан соронзон тоолуураар шинэчлэх ажлыг зохион байгуулсан. 7.3% 2.Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар (ОСНААУГ) ОНӨААТҮГ нь 151,346 айл өрх, 11,965 аж ахуй нэгжийн ашиглалт үйлчилгээг хариуцан ажилладаг бөгөөд үүнээс тоолууртай айл өрх 412,423, тоолуургүй айл өрх 40,542 байна. ОСНААУГ-ын даргын 2023 оны А/154 дүгээр тушаалын хүрээнд 2025 онд 8,112 айл өрхөд нийт 18,292 тоолуур баталгаажуулж суурилуулсан. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар өрхийн тоолуржуулалт 89.38 хувь, аж ахуй нэгжийн тоолуржуулалтын 100 хувь, дундаж үзүүлэлт 94.69 хувь байна. 3.2021-2025 онд улс, нийслэлийн төсөвт хөрөнгө батлагдаагүй. 0% 4.Мянганы сорилтын сангийн дэмжлэгтэйгээр цэвэр, бохир ус болон лаганд элементийн шинжилгээ хийх ICP-OES Agilent 5800 (1 иж бүрдэл) багажийг 2025 оны 5 сард хүлээн авч, 7 сард сургалт явуулсан бөгөөд одоогоор багажийг жигдрүүлэх туршилтын шинжилгээг хийж эхлээд байна. 100%	51%
168.	9.16. Улаанбаатар хотод ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр болон өргөтгөн барьж, цэвэр усны түгээлт, хүртээмжийг сайжруулна.	9.16.1. Ус хангамжийн усан сан, шугам сүлжээг шинээр барьж, байгуулсан байна.	2021 - 2025	НХБХГ, НГЗБА, УСУГ		1.99.5 2.0 3.0 4.0 5.586 6.236	1.Шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь 2.Хужирбуланд барих усан сан, шугам сүлжээний бүтээн байгуулалтын хувь 3.Буянт-Ухаа 2 хороолол орчимд барих усан сан, шугам сүлжээний бүтээн байгуулалтын хувь 4.Толгойт, Их нарангийн орчимд барих усан сан, шугам сүлжээний бүтээн байгуулалтын хувь 5.Шинээр ашиглалтад оруулах ус хангамжийн шугам сүлжээний урт 6.Шинээр ашиглалтад оруулах ариутгах татуургын шугам сүлжээний урт	1.99.8 2.100 3.100 4.100 5.597.4 6.266.2	-	-	1.Баталгаат ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын тоо 1252685 буюу 77% байна.0% 2.Хөрөнгө оруулалт шийдэгдээгүй тул хэрэгжих боломжгүй байна. 0% 3.Буянт Ухаа-2 хорооллын 2 дугаар ээлжийн ус хангамжийн шугам сүлжээний зураг төслийг зөвшилцөн “Залуус-2” төслийн усан сан шугам сүлжээний ажлын зураг төсөл хийгдсэн. Инженерийн шугам сүлжээний хонгилын барилга угсралтын ажил хийгдэж, Барилга хөгжлийн төв захиалагчын хяналт хийж байна. Хан-Уул дүүргийн 8 дугаар хорооны орон сууцны хорооллын ус хангамж ариутгах татуургын шугам сүлжээний ажлын зураг төсөл боловсруулах ажлын даалгавар 2022 оны 11 дүгээр хурлаар батлан төслийн хүрээнд шинээр төлөвлөж буй усан сангийн байршлын газар олголтын асуудлыг шийдүүлсний дараа зураг төслийг зөвшилцөнө. Насос станц, УДХТ-ийн газар олголт хийгдсэн. 4. Их Нарангийн усан сан, ус хангамжийн шугам сүлжээний барилга угсралт ажил хэсэгчилж хийгдсэн. Захиалагчийн хяналтыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар хийж байна. 5.Дулааны 4аб магистраль бага тойруугийн хэсэг, 2а магистраль, 1а, 2д магистраль шугамын шинэчлэлтийн ажилд трасс давхацсан ф200-400мм 3 км цэвэр усны шугамыг шинэчлэн өргөтгөсөн. 6.СХД-ийн 4-р хороо, Их Нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф400мм ийн 2,8 км шугамын барилга угсралтын ажил хийгдсэн. - Буянт-Ухаа-2 хорооллын 2 дугаар ээлжийн төслийн ариутгах татуургын шугамын 1,3 дугаар ээлжийн ажлын зураг төсөл ф500/ф600 мм-ийн 2.1 км шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. - Буянт-Ухаа -2 хорооллын хэсэгт шугамын барилга угсралтын ажил хийгдэж дууссан. - СХД-ийн 2, 3, 26, 35, 36-р хороо, Толгойт, Их Нарангийн гэр хорооллын ус хангамжийн шугам сүлжээ, усан сан, насос станцын ажлын зураг төслийг баталгаажуулсан. - Дарь-Эхийн гэр хорооллын төвлөрсөн ариутгах татуургын шугамын ажлын зураг төсөл зөвшилцсөн. Барилга угсралтын ажлыг улсын төсвийн хөрөнгөөр Бумбод ХХК гүйцэтгэж байна. Нийт ариутгах татуургын 4,9км шугамын барилга угсралтын ажил дууссан. Сонгинохайрхан дүүргийн 4 дүгээр хороо, Их Нарангийн авто зам дагуу Баянхошуу коллектор хүртэл хийгдэх ариутгах татуургын ф300мм - ийн 2,8 км шугамын барилга угсралтын ажил хийгдэж дууссан.	85%

169.		9.16.2. Одоо байгаа ус хангамжийн усан сан, шугам сүлжээг өргөтгөн, шинэчилсэн байна.	2021 - 2025	НХБХГ, НГЗБА, УСУГ, НДЗДТГ, УБЗАА		1.6,000м3 2.0 3.7.6 4.1.4	1.Зүүн хойд бүсийн усан санг өргөтгөх эзлэхүүн 2.Налайх дүүргийн усан сан, насос станц, шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх бүтээн байгуулалтын хувь 3.Одоо байгаа ус хангамжийн 586 км шугамаас өргөтгөн шинэчлэлт хийх шаардлагатай шугамын урт 4.Одоо байгаа ариутгах татуургын 236 км шугамаас өргөтгөн шинэчлэлт хийх шаардлагатай шугамын урт	1.2021-2025 30,000м3 2.2021-2025 100 3.2021-2025 7.6 4.2021-2025 1.4	5.6 тэрбум	5.6 тэрбум	1.2025 оны Нийслэлийн төсөвт Зүүн хойд бүсийн усан сангийн өргөтгөлийн ажилд 5.6 тэрбум төгрөг батлагдаж гүтйцэтгэгчээр Наранбулаг ХХК ажиллаж, Захиалагчийн хяналтад Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар ажиллаж байна. 2025 онд ажлын талбай бэлтгэх, түр хашаа босгох ажлууд хийгдсэн. 50% 2.Налайх дүүргийн цэвэр усан сан, насос станц дамжуулах гол шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлын зураг төсөл боловсруулах хөрөнгийг 2026 оны төсөвт тусгуулах саналыг холбогдох газарт хүргүүлсэн. 0% 3.Нийслэл 2025 онд 88,3 км инженерийн гадна шугам сүлжээний шинэчлэлийн ажил хийсэн бөгөөд үүнд дулаан хангамжийн гол шугам сүлжээ 15.6 км, орон сууцны хорооллын доторх ус, дулааны 22.9 км шугам шинэчлэх, борооны ус зайлуулах шугам сүлжээ 15.6 км шинээр угсрах, боловсролын салбарт 135 барилгын их засвар, барилга байгууламжийн 139 төсөл арга хэмжээ хэрэгжсэн. Дулааны 4аб магистраль бага тойруугийн хэсэг, 2а магистраль, 1а, 2д магистраль шугамын шинэчлэлтийн ажилд трасс давхацсан ф200-400мм 3 км цэвэр усны шугамыг шинэчлэн өргөтгөсөн. 2025 онд ариутгах татуургын 970 м шугам, халаалт, халуун хуйтэн усны 822 метр шугам сүлжээг шинэчилэн сольсон. 100% 4.Бохир усны Туул-1 коллекторын ф1500 мм голчтой 10.0 км шугам шинээр барих ажлыг Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ нь 2025 оны 09 дүгээр сараас угсарч 11 дүгээр сарын байдлаар1650 метр шугам сүлжээг угсраад байна. 100%	63%
170.		9.16.3. Ус хангамжийн шугамыг шуудуу ухалгүй доторлох төслийг хэрэгжүүлж, зөөврийн ус түгээх байруудыг төвлөрсөн шугам сүлжээнд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулсан байна.	2021 - 2025	НХБХГ, УСУГ, НДЗДТГ, УБЗАА		1.2020 он 376 2.2020 он 7.8	1.Төвлөрсөн шугамд холбож, ухаалаг төхөөрөмж суурилуулах ус түгээх байр 2.Ус хангамжийн шугам доторлох урт	1.2021-2025 317 2.2021-2025 22	-	-	1.Монгол Улсын Засгийн газар болон АНУ-ын Мянганы сорилтын корпорацын II Компакт гэрээний дагуу "Усны салбарын тогтвортой байдлыг хангах" төслийн хүрээнд нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг бүрэн автоматжуулсан. Мөн Ус сувагийн удирдах газар (УСУГ) 151 ус түгээх байрыг автоматжуулсан. Нийт 331 ухаалаг ус түгээх байр бүгд нэгдсэн удирдлага хяналтын системээр ажиллаж, хэрэглэгчдэд 24 цагийн турш үйлчилж байна. 100% 2.Австри Улсын буцалтгүй тусламжаар 2017 оноос Улаанбаатар хотын ус хангамжийн шугам хоолойг шуудуу ухалгүй доторлон шинэчлэх төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд 2025 оны байдлаар ф150-300мм голчтой 18.6 км цэвэр усны магистраль шугамыг шинэчилсэн. 85%	93%
171.	9.17. Шинээр цэвэрлэх байгууламж барьж, хуучин байгууламжуудад техник технологийн шинэчлэлт хийж, эрүүл ахуйн хамгаалалтын бүсийг баталгаажуулна.	9.17.1. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон лаг хатаах байгууламжийг ашиглалтад оруулсан байна.	2021 - 2025	НХБХГ, НЗДТГ, УБЗАА		1. 2020 он 10 2. 2020 он 0	1. Улаанбаатар хотын “Төв цэвэрлэх байгууламж”-ийг шинэчлэн барьж ашиглалтад оруулах бүтээн байгуулалтын хувь 2. Лаг хатаах байгууламж	1. 2021-2025 100 2. 2021-2025 1	-	-	1.Улаанбаатар хотын "Төв цэвэрлэх байгууламж"-ийн төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Чайна Тисижу сивил инженеринг групп” ХХК, “Бээжин констракшн инженеринг групп” ХХК-иудын консорциум ажиллаж 33 нэр төрлийн барилга угсралт, тоног төхөөрөмжийн угсралт 100 хувь дуусан. 2025 оны 7 дугаар сараас 1 дүгээр биореакторт ус хүлээн авч туршилт тохируулгын ажил эхэлж насос станц, элс баригч, нарийн сараалж, хоёрдогч болон гуравдагч тунгаагуурийг ажиллагаанд орсон. 100% 2.Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/01 дүгээр тогтоолоор Төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийслэлд хэрэгжүүлэх мега төслийн жагсаалтад “Лагийг хатаах, шатаах, цэвэрлэх үйлдвэр байгуулах” төсөл багтсан бөгөөд урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлийг Хот төлөвлөлт, судалгааны институт боловсруулж Барилгын хөгжлийн төвийн 2025.07.22-ны өдрийн ЭЗ-002/2025 дугаартай магадлалын дүгнэлтийн нэгтгэлээр баталгаажсан. “Лагийн менежментийн урт хугацааны төлөвлөгөө” боловсруулах ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын яам (БХБЯ)-ны төрийн нарийн бичгийн даргын 2025.05.22 ны өдрийн А/93 дугаартай тушаалаар байгуулагдан ажиллаж байна. 30%	65%
172.		9.17.2. Буянт-Ухаа орон сууцны хорооллын бохир ус цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамын нэмэлт ажлуудыг ашиглалтад оруулсан байна.	2021 - 2025	НХБХГ, УСУГ, УБЗАА		2020 он 10	Буянт-Ухаагийн цэвэрлэх байгууламжийн дулааны шугам сүлжээний бүтээн байгуулалт	2021-2025 100	1.2 тэрбум	1.2 тэрбум	2021 онд Морингийн Цэвэрлэх байгууламжийн дулааны *(ф150мм 450 урт хос метр)* шугам сүлжээний угсралтын ажлыг "Сан" ХХК бүрэн хийж дууссан. 2021-2022 онд “Буянт-Ухаа” орон сууцны хорооллын бохир усны цэвэрлэх байгууламжийн гадна дулааны шугамын ажил хийгдэж дууссан. Одоо бие даасан эх үүсвэрээр ажиллаж байна.	100%
173.	9.18. Орон сууц нийтийн аж ахуйн үйлчилгээний байгууллагуудад шаардлагатай машин механизм, тоног төхөөрөмжөөр хангана.	9.18.1. Цэвэр, бохир усны зөөврийн болон шугам сүлжээний засвар үйлчилгээний машин механизмаар хангалт хийж, шугам сүлжээний засвар үйлчилгээнд зарцуулах хугацааг багасаж, ус түгээх үйлчилгээний хүртээмжийг сайжруулсан байна.	2021 - 2025	УБЗАА, НЗДТГ, УСУГ, ОСНААУГ,Дүүргүүд		2020 он 188	Цэвэр, бохир усны зөөврийн болон засвар үйлчилгээнд авах машин механизм	2021-2025 222	6.4 тэрбум	6.4 тэрбум	1.Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (УБЗАА)-ны 2025 оны 09 дүгээр сарын 02-ний өдрийн 25/03-67 гэрээгээр Орон сууц, нийтийн аж ахуйн удирдах газарт XE150WD Экскаватор 1ш, байгууллагын хөрөнгөөр Бохир сорох автомашин 1 (165,150,000), Микоавтобус 1 (127,716,000), нийт 34 тусгай зориулалтын машин, механизм хүлээлгэн өгч техникийн бэлэн байдлыг хангаж, өдөр бүр үзлэг шалгалтыг хийж ажиллаж байна. 2.Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар УБЗАА-ны 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 25/03-58 тоот "Машин механизмыг төлбөртэй ашиглуулах гэрээ"-гээр Геодези, усны барилга байгууламж ОНӨААТҮГ-т үеийн хамгаалалтын барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээний тусгай зориулалтын 15 машин механизмыг хүлээлгэн өгсөн. 3.Нийслэлийн хөрөнгө оруулалтаар Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-т ус зөөврийн автомашин 6, кран 1, сонсмол 1 ширхэгийг нийлүүснээс гадна байгууллагын хөрөнгө оруулалтаар кран 1, автобус 1 ширхэгийн худалдан авалт хийсэн байна.	100%
174.	9.19. Авто зам, дугуйн зам, явган замын нөхцөлийг сайжруулан, гол, туслах гудамж болон хорооллын доторх замыг өргөтгөн, шинэчилж, авто замыг шинээр барьж, үндсэн сүлжээг нэмэгдүүлэн хөгжүүлнэ.	9.19.1. Авто замын сүлжээний уртыг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НЗХГ, ЗХТЗИГ, НГЗБА, НХБХГ		2020 он 1,135	Авто замын сүлжээний урт	2021-2025 1425	-	-	2022-2024 онд шинээр 80.6км авто замыг ашиглалтад хүлээн авсан. 2025 оны төсвийн жилд шинээр болон он дамжин хэрэгжиж буй 30 төсөл, арга хэмжээ байгаагаас байнгын ашиглалтад хүлээн авсан 13, барилгын шатанд 18 зам байна.	100%
175.		9.19.2. Гол болон туслах гудамж замын техник ашиглалтын түвшинг сайжруулж, өргөтгөн, шинэчилсэн байна.	2021 - 2025	НЗХГ, ЗХТЗИГ, НГЗБА, НХБХГ		2020 он 29.7	Өргөтгөж шинэчлэх авто замын урт	2021-2025 129.7			2022-2024 онд нийт 107.9км авто замын засвар шинэчлэлтын ажлыг хүлээн авсан. 2025 оны төсвийн жилд нийслэлийн хэмжээнд нийт 45 байршилд 76.83 км авто замын шинэчлэлтийн ажил хийгдсэн бөгөөд эдгээрээс 42 ажил бүрэн дуусаж, шат дараатайгаар улсын комиссоор хүлээн авч ашиглалтад оруулсан.	100%

176.		9.19.3. Дугуйн замын сүлжээг нэмэгдүүлсэн байна.	2021 - 2025	НЗХГ, ЗХТЗИГ		2020 он 84.6	Шинээр баригдах дугуйн замын урт	2021-2025 234.6	-	-	2021-2024 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 37.94 км дугуйн замыг хүлээн авсан. 2025 оны байдлаар Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/1322 дугаар захирамжаар батлагдсан “Авто замын нүхэн гарц дагуух тусгаарлагдсан зурвас бүхий дугуйн болон явган хүний замын ажил”-ын хүрээнд нийт 24 байршилд 46,995.4 м² талбайд явган замын шинэчлэлтийн ажлыг бүрэн гүйцэтгэлээ. Мөн тухайн онд хэрэгжүүлж буй авто замын шинэчлэлтийн ажлын хүрээнд нийт 14.6 км явган замын засвар, сэргээн шинэчлэх ажлыг хийв. (Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй)	100%
177.		9.19.4. Сул шороон хөрсийг явган зам, талбай болгон тохижуулна.	2021 - 2025	УБЗАА, НЗХГ, Дүүргүүд		2020 он 144,882	Явган хүний зам, талбай	2021-2025 344,882	-	-	Улс, Нийслэлийн Төсвийн хөрөнгө оруулалтаар УБЗАА-аас 2022 онд 57,189 мкв, 2023 онд 28,300мкв, 2024 онд 30,753мкв, 2025 онд УБЗАА, НХОГ хамтран 116,399 мкв буюу нийт тайлант хугацаанд 232,641 мкв явган замын ажил хийгдсэн байна.	100%
178.	9.20. Авто замын хөдөлгөөний төлөвлөлтийг оновчтой түвшинд төлөвлөж, авто замын хөдөлгөөний ачааллыг бууруулна.	9.20.1. Замын хөдөлгөөний ачааллыг бууруулах цогц арга хэмжээ авч хотын хэсгийн тээврийн хэрэгслийн дундаж хурдыг нэмэгдүүлнэ.	2021 - 2025	НЗХГ, ЗХТЗИГ		2020 он 10	Тээврийн хэрэгслийн дундаж хурд	2021-2025 25	-	-	Нийслэлийн хэмжээнд тээврийн хэрэгслийн дундаж хурдыг нэмэгдүүлэх зорилгоор 2025 онд гол болон туслах гудамж замын 257 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталснаас 66 байршилд 86.5 км шинэ замын барилгын ажил (явц 85 хувьтай), 87 байршилд 262 км авто замын шинэчлэлтийн ажил (явц 86 хувьтай), 13 байршилд 94.304 м2 явган замын шинэчлэлийн ажил тус тус хийгдэж байна. Томоохон төсөл арга хэмжээ болох 32 км урттай "Туулын хурдны зам"-ын барилгын ажлыг 2025 онд гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан эхэлсэн бөгөөд 2026 онд авто зам болон гүүрэн байгууламжийн барилгын ажлыг үргэлжлүүлэн барихаар төлөвлөж байна. Ажлын явц 5 хувьтай. Тус төсөл хэрэгжсэнээр тээврийн хэрэгслийн дундаж хурдыг 13 хувиар нэмэгдүүлэх боломж бүрдэнэ. (Шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй)	85.50%
179.		9.20.2. “Нийслэл хотын замын хөдөлгөөн, тээврийн ухаалаг систем” төслийг бүрэн хэрэгжүүлсэн байна.	2021 - 2025	НЦХМТГ		2020 он 0	Зам тээврийн салбарт нэвтрүүлсэн ухаалаг систем	2021-2025 1	-	-	Нийслэлийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/207 дугаар захирамжийн хүрээнд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн А/28 дугаар тушаалаар “Үнэлгээний хороо” байгуулагдаж тээврийн хэрэгслийн техникийн хяналтын цахим гэрчилгээ (RFID tag)-г суурилуулах ажлын худалдан авах ажиллагаанд зохион байгуулж, гүйцэтгэгч компанийг сонгон шалгаруулж, гүйцэтгэгчээр “Бодь-Электроникс” ХХК-тай 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрөөс 09 дүгээр сарын 25-ны өдөр хүртэлх хугацаанд байгуулсан. Нийслэлийн хэмжээнд гэрээний хуваарийн дагуу хийж байсан боловч тодорхой шалтгааны улмаас гүйцэтгэгчийн гэрээ сунгах хүсэлтийг ирүүлж хүсэлтийн дагуу ажлын хэсгийн гишүүд хуралдан хүсэлтийг хүлээн авч үлдэгдэл RFID tag-г суурилуулж дуусах хугацааг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн хооронд НХААГ/202303129-01 тоот сунгалтын гэрээг байгуулсан. Тус нэмэлт гэрээний хугацаанд нийслэлийн хэмжээнд цахим гэрчилгээг суурилуулж дуусгахаар ажиллаж байсан боловч Хүний эрхийн үндэсний комиссоос хүний эрх зөрчигдөж байна гэсэн шаардлагыг Зам тээврийн хөгжлийн яаманд ирүүлж суурилуулах явц удааширч зогссон. Иймд “Бодь электроникс” ХХК тус гэрээний хугацааг сунгуулахаар нэмэлт гэрээ байгуулах албан хүсэлтийг удаа дараа ирүүлсэн боловч хүний эрх зөрчигдөж буй асуудлаас шалгаалан хариу өгөх боломжгүйд хүрч, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдрийн А/71 тоот “Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулан тухай” тушаал батлагдан ажлын хэсгийн гишүүд 2025 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр хуралдаж RFID tag суурилуулах ажлын гэрээг нэмэлтээр байгуулж дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. 2025 оны 12 дугаар сарын байдлаар нийслэл болон орон нутгийн нийт 999,477 авто тээврийн хэрэгсэлд “RFID tag” суурилуулахаас 471,058 буюу нийт авто тээврийн хэрэгслийн 47%-д суурилуулаад байна. 2024 оны 12 сард нийт 433,825 ширхэг “RFID tag” суурилуулагдсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 471,058 ширхэг суурилуулагдаж өмнөх оноос 37,233 ширхэг “RFID tag” буюу 7,9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Зам тээврийн хөгжлийн яам системийг хариуцан ажиллаж байгаа бөгөөд системийн худалдан авах ажиллагааг зарлаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа явагдаж байгаа.	100%
180.	0	.	2021 - 2025	НТБГ		2020 он 0	Нийтийн тээврийн чиглэлийн давхцал буурах хувь	2021-2025 50	-	-	Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратегийн эцсийн тайланг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Мөн 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хэлэлцүүлэн 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын "Улаанбаатар хотын нийтийн тээврийн стратегиийн төсөл дэмжих тухай тогтоол гарч 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдөр Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны Шинжлэх ухаан техник, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлсэн.Улаанбаатар хотын Нийтийн тээврийн стратеги боловсруулах зөвлөх үйлчилгээг Тогтвортой авто зам тээвэр төслийн нэгж хариуцан боловсруулж байна. Улаанбаатар хотын автозамын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны 02 дугаартай Зөвлөмжийн дагуу нийтийн тээврийн чиглэлийн давхцалыг бууруулах хүлээгдлийн хугацааг багасгах ажлын хүрээнд нийтийн тээврийн чиглэлийг шинэчлэн баталж 74 чиглэлд 1075 автобусаар үйлчилгээг 2024 оны 01 дүгээр сарын 20-ны өдрөөс хэрэгжүүлсэн. Сүлжээ төлөвлөлтийн хүрээнд нийт чиглэлийн давхцал 25%-иар буурсан үзүүлэлттэй байна.	85%
181.		9.21.2. Зорчигч тээврийн урсгалаас хамаарч дагуул, хаяа хот, тосгод нийтийн тээврийн сүлжээнд холбогдсон байна.	2021 - 2025	НТБГ		2020 он 11	Холбогдсон дагуул, хаяа, хот, тосгод	2021-2025 15	-	-	2021 онд Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн шинээр баригдах “Агро сити” буюу дагуул хотын нийтийн тээврийн үйлчилгээний 4 чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан, батлуулсан. Дээрх ажлын хүрээнд Хөшигийн хөндийн “Чингис хаан” олон улсын шинэ нисэх онгоцны буудал ашиглалтад орж, үйл ажиллагаа нь 2021 оны 07 сарын 04-ний өдрөөс эхэлсэн хэдий ч Ковид-19 цар тахалтай холбогдуулан үйл ажиллагааг түр зогсоосон байна. 2022 онд Улаанбаатар хотын хаяа дагуул 16 хот тосгодын 13 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 16 чиглэлд хүргэж, өдөр тутам 60 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлсэн. 2023 онд Улаанбаатар хотын хаяа дагуул 16 хот тосгодын 14 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 16 чиглэлд хүргэж, өдөр тутам 60 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Дагуул хот байгуулах байршил буюу Чингис хаан олон улсын нисэх буудалд 2023 оны 07 дугаар сарын 03-ны өдрөөс 2023 оны 09 дүгээр сарын 10-ны хүртэлх хугацаанд 586 зорчигч тээвэрлэсэн. 2024 онд Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 18 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 19 чиглэлд хүргэж, өдөр тутам 73 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлсэн. 2025 онд Улаанбаатар хотын хаяа дагуул тосгодын 20 суурьшилд нийтийн тээврийн үйлчилгээг 21 чиглэлд хүргэж, өдөр тутам 81 тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна.	100%

182.		9.21.3. Нийтийн тээврийн үйлчилгээнд олон төрөлт, ухаалаг зорчигч тээврийн төрөл нэмэгдсэн байна.	2021 - 2025	НТБГ, НЗДТГ		2020 он 0	"Агаарын дүүжин замын тээврийн төсөл"-ийн чиглэлийн урт	2021-2025 10.1	177,987.55	115,664.24	"Монгол, Франц улсын Засгийн газрын хоорондх 2022 онд байгуулсан санхүүжилтийн хэлэлцээрийн дагуух хөнгөлөлттэй зээлийн гэрээ (60.7 сая евро)-нд тусгагдсан 1-р шугам болох "Баянхошуу-Ханын материал-Гэмтлийн эмнэлэг чиглэл"-г сольж, “Нийтийн тээвэрт дүүжин замын тээврийг нэвтрүүлэх төсөл”-ийг 2022-2024 онд барьж байгуулахыг даалгасан Засгийн газрын 2022 оны 05 сарын 31-ний өдрийн 31 дугаар тэмдэглэл гарсан. Төслийн 2-р шугам "Нийслэлийн нутаг захиргааны төв байгууллага-Драгон төв" хүртэлх 4.2 км чиглэлийн техник, эдийн засгийн үндэслэлийг хийж гүйцэтгэх шийдвэрийг Франц тал 2022 оны 10 сард зөвшөөрч, ТЭЗҮ, газрын хөрсний судалгаа зэргийг хийх, шаардлагатай санхүүжилтийг 1-р шугамын урьдчилгаа төлбөрөөс үлдсэн үлдэгдэл санхүүжилтээр гүйцэтгэхээр шийдвэрлэсэн. Дүүжин замын тээвэр нэвтрүүлэх төслийн хоёрдугаар шугамын 1 дүгээр үе шатны барилгын зардал болох 25.3 сая евро, 2 дугаар шатны зардал болох 15.6 сая еврог санхүүжүүлэхийн тулд хоёр улсын Сангийн яам харилцан зөвшилцөж санхүүгийн хэлэлцээрийн төслийн нэгдүгээр шугам (35.4 сая евро)-ын хугацаат 2023 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс 2027 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл сунгасан. Төслийн 2 дугаар шугам "Нийслэлийн нутаг захиргааны төв байгууллага-Драгон төв" хүртэл 4.2 км шугамын барилгын ажил гүйцэтгэх (EPC) гэрээг 2023 оны 06 дугаар сард байгуулж, техник, эдийн засгийн үндэслэлийг 2023 оны 06 дугаар сард эцэслэн батлуулсан. 2024 онд чиглэлийн нэршлийг “Яармаг, Арцат-Өнөр хороолол” болгон өөрчилж, төслийн нөлөөлөд өртсөн газрыг бүрэн чөлөөлж, “Хүн тээвэрлэх зориулалттай дүүжин замын тээврийн байгууламжийн аюулгүй байдлын шаардлага”-тай холбоотой Европын Холбооны 15 стандартыг эрх бүхий байгууллагаар батлуулан MNS бүртгэлд шилжүүлсэн. 2024 онд “Яармаг, Арцат-Өнөр хороолол” чиглэлийн загвар зургийг 2025 онд нарийвчилсан зургийн тус тус батлуулсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар "Яармаг, Арцат - Өнөр хороолол" хүртэлх 4.2 км шугамын барилгы угсралтын ажил 53 хувьтай хэрэгжиж байна. Нийт 19 тулгуур баганаас 14 тулгуур баганыг угсарч дууссан, төслийн хүрээнд гүйцэтгэгч талаас 150 чингэлэг ачаа хүлээн авах ёстой бөгөөд тайлант хугацаанд 114 чингэлэг төслийн талбайд буусан байна.	85%
183.	9.22. Зорчигчдын ариун цэвэр, аюулгүй байдлыг хангасан, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлсэн, нийтийн тээврийн хэрэгсэл, зогсоолтой болно.	9.22.1. Нийтийн тээврийн үйлчилгээнд байгаль орчинд ээлтэй автобусаар парк шинэчлэлт хийсэн байна.	2021 - 2025	НТБГ		2020 он 12	Байгаль орчинд ээлтэй автобус	2021-2025 931	-	-	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор “Нийслэлийн Нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажил”-ын хүрээнд 2021-2025 онд евро-5 (дизель) маркийн 995 автобус, цахилгаан хөдөлгүүртэй 98 автобусаар нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлж, автобус хоорондын хүлээгдлийн хугацааг бууруулан үйлчилгээнд ажиллах тээврийн хэрэгслийн тоог 1093 автобусаар нэмэгдүүлж ажилласан. Үүнээс 2021 онд 35 автобус, 2022 онд 71 автобус, 2023 онд 364 автобус, 2024 онд 596 автобус, 2025 онд 27 автобус тус тус нэмэгдсэн байна.	100%
184.		9.22.2. Цахилгаан тээврийн хэрэгслийг цахилгаан эх үүсвэрээр цэнэглэх цэгийг байгуулсан байна.	2021 - 2025	НТБГ, НБОГ		1. 2020 он 3 2. 2020 он 6	1.Цахилгаан автобус цэнэглэх цэг 2.Цахилгаан авто машин цэнэглэх цэг	1. 2021-2025 10 2. 2021-2025 11	-	-	1.2025 оны жилийн эцсийн байдлаар нийслэлийн 4 байршилд 17 цэнэглэгчээр цахилгаан автобусыг цэнэглэж байна. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны “Ажлын хэсэг байгуулах тухай” А/83 дугаартай тушаалын дагуу Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх “Цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжийн ажлын үе шат бүрд захиалагчийн хяналт тавьж, байнгын ашиглалтад оруулах үүрэг бүхий” ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэг БММЗ эцэст байрлах троллейбусны 2*692 кВа чадалтай 6/0,6 кВ-ийн татах дэд станцыг 2*800 кВа чадалтай 6/0,4 кВ-ийн өргөтгөсөн дэд станцыг 2024 оны 08 дугаар сард хүлээн авсан. Цахилгаан автобус цэнэглэх саравч, зогсоолтой цэнэглэх дэд станцыг байгуулах зураг, төслийг боловсруулан, хамтран ажиллах тухай саналыг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны 01/07/33 дугаартай албан бичгээр Зам, тээврийн яаманд хүргүүлсэн. 2025 оны 05 дугаар сарын 07-ны өдөр Бодлогын судалгаа, шинжилгээний төвд БНСУ-ын Кёнсанбүг мужийн холбогдох албан тушаалтан хүрэлцэн ирж, цахилгаан автобус, цэнэглэх станц, дэд бүтцийн бүтээн байгуулалт болон карбон кредит төслийн талаар танилцуулж, санал солилцсон. Баянгол дүүрэг, Хан-Уул дүүрэг, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 192/ШШ2025/05784 дугаар шүүхийн шийдвэрийн дагуу Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/1349 дүгээр захирамжаар 11 ширхэг цахилгаан автобусны цэнэглэгч төхөөрөмжүүдийг техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу шалгаж, хүлээн авах ажлыг хоёр үе шаттай зохион байгуулж, 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр “Зорчигч тээвэр хоёр” ОНӨААТҮГ-т актаар хүлээлгэн өгсөн. 100% 2. 6 байршилд 13 цэнэглэгчээр цахилгаан автомашиныг тогтмол цэнэглэж байна. 100%	100%
185.		9.22.3. Зорчигч тээврийн үйлчилгээний зогсоолыг сайжруулж, стандартын дагуу байгуулна.	2021 - 2025	НТБГ		1.930 2.3 3.2020 он 212	1.Шинээр бариглах нийтийн тээврийн зогсоол 2.Нийтийн тээврийн үйлчилгээний зогсоолд байршуулах мэдээллийн самбар 3.Нийтийн тээврийн үйлчилгээний тохижуулах зогсоол	1.2021-2025 980 2.2021-2025 253 3.2021-2025 250	-	-	1.2021-2025 онд нийт 112 зогсоолыг шинээр байгуулж, 54 зогсоолын засвар тохижуулалт хийгдсэн байна. 2025 онд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/618 дугаар захирамжаар “Нийтийн тээврийн эцсийн зогсоолыг иж бүрэн тохижуулах, одоогийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, төлөвлөлтийн шийдэл боловсруулах, хөрөнгө оруулалтын судалгаа гаргах” үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажилласан. Дулаан зогсоол буюу капсул байрлуулах шаардлагатай 25 байршлын жагсаалтыг танилцуулж бүтээн байгуулалтын ажлыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Мөн тайлант хугацаанд Улаанбаатар хотын 8 байршилд шинээр дулаан зогсоолыг байгуулан ашиглалтад оруулж, Сонгинохайрхан дүүргийн 34-р хорооны нутаг дэвсгэрт байрлах найрамдлын зам дагуу 18, БЗД Нарны зам дагуу 1, Сонсголонгийн зам дагуу 3, Ажилчдын гудамжинд 2 нийт 24 зогсоолын саравч шинээр хийгдсэн. 100% 2.Нийтийн тээврийн хэрэгслийн 209 зогсоолын мэдээллийн самбарт дахин төлөвлөлтийн ерөнхий мэдээллийг байршуулснаас гадна иргэд, олон нийтэд мэдээллийг цахимаар хүргэх зорилгоор “Imap.mn” цахим сайт, апликейшнд дамжин суултын мэдээллийг байршуулсан. 2025 онд Нийтийн тээврийн зогсоолын байгууламж дахь чиглэлийн мэдээллийн зураглалын боловсруулалтыг автоматжуулах ажлын хэрэгцээ шаардлагыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн А/13 дугаар захирамжаар батлуулсан. Тус захирамжийн хүрээнд Нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийтийн тээврийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхэд орчин үеийн техник, технологийн дэвшлийг ашиглан нийтийн тээврийн чиглэлийн мэдээллийн зураглалыг боловсруулах ажлын гүйцэтгэгчээр "Дата дэүс" ХХК шалгарч чиглэлийн зураглалыг автоматжуулах ажил хийгдэж байна. Уг системийн тооцооллоор хийгдсэн зогсоолын 50 зураглалыг Энхтайваны өргөн чөлөө дагуух зогсоолын саравчуудад байршуулаад байна. 100%	100%

186.	9.23. Улаанбаатар хотод ачаа тээврийн логистик, зорчигчдын ая тухтай зорчих нөхцөлийг хангасан зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулна.	9.23.1. Улаанбаатар хотын зүүн, баруун хэсэгт ачаа тээврийн логистик, зорчигч тээврийн нэгдсэн терминал байгуулсан байна.	2021 - 2025	НӨУБХОМҮЦК ХХК, ОУХЛТ ХК, НТБГ		1. 2020 он 0 2. 2020 он 0	1. Зүүн, баруун хэсэгт байгуулагдах нэгдсэн логистикийн төв 2.Зорчигчдын ая тухтай үйлчилгээ авах нөхцөлийг бүрдүүлэх зорчигч тээврийн нэгдсэн терминал	1. 2021-2025 2 2. 2021-2025 2	-	-	1.Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/311 дугаар захирамжаар “Нийслэлийн зүүн хэсэгт олон улсын ачаа тээвэр, логистикийн төв” байгуулах төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд төслийн гүйцэтгэгчээр “Туушин” ХХК, нийслэлийн хүлээсэн эрх, үүргийг 2022 оны 03 дугаар сарын 11-ний өдрийн 01/02 дугаартай хамтран ажиллах гэрээгээр “Улаанбаатар хотын хөгжлийн корпорац” ХК хариуцан ажиллаж байна. Зам Тээврийн Сайдаас 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг Дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид ирүүлсэн 01/445 дугаартай албан бичгийн дагуу Улаанбаатар хотын баруун, зүүн хэсэгт төрөлжсөн тээвэр, логистикийн төв байгуулах байршлыг тогтоох судалгааны Ажлын хэсэгт Нийслэлээс орж ажиллах албан тушаалтнуудын мэдээллийг Зам тээврийн яаманд хүргүүлсэн. Тус ажлын хэсгийн дүгнэлтээр “Улаанбаатар хотын зүүн хэсэгт олон улсын ачаа, тээвэр, логистикийн төв байгуулах төсөл”-ийг хэрэгжүүлэх байршил болон төслийн холбогдох үзүүлэлтүүд тодорхой болохоор хүлээгдэж байна. Олон улсын худалдаа, логистикийн төв ХК нь баруун хэсэгт төрөлжсөн логистикийн “Хангарди терминал”, “Төмөр замын хяналтын бүс”, “Хүнс, бараа бүтээгдэхүүний бөөний худалдааны төв” төслүүдийн гүйцэтгэгчээр ажиллаж байна. 50% 2.Автобусны богино эргэлтийн терминалыг Таван шар, Офицеруудын ордон, Баянбүрдийн орчимд байгуулах талаар тусгасан байдаг. Дээрх заалтын хүрээнд Сүхбаатар дүүргийн 9 дүгээр хороо, 32-ын тойргийн урд талд нийтийн тээврийн хэрэгслийн болон 500 авто машины зогсоолыг байгуулах ажлыг Нийслэлийн Замын хөгжлийн газар гүйцэтгэж байгаа бөгөөд ажлын зураг нийтийн тээврийн хэрэгслийн буцаж эргэх нөхцөлийг хангуулах талаар санал тусгасны дагуу зогсоолын суурь хучилтын ажил хийгдэж эхлээд байна. 30%	50%
9 бүлэг, 66 зорилтын хүрээнд 186 арга хэмжээний хэрэгжилтийн явцын дундаж үнэлгээ												**91.6**

НИЙСЛЭЛИЙН ХӨГЖЛИЙН 2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ
ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/д	Зорилт	Үндсэн үйл ажиллагаа, төсөл, арга хэмжээ	Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал	Суурь түвшин		Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Зорилтот түвшин	Санхүүжилт сая.төгрөг	Хэрэгжилт	Үнэлгээ
					он	түвшин						
НЭГ. БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГО												
1.1 Улаанбаатар "20 минутын хот" стандарт												
Салбарын үр дүн: Улаанбаатар хотын дагуул хотуудад эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлж, төвлөрлийг сааруулна.												
1	НХТЖҮЧ 9.1.1	Улаанбаатар хотын бүсчлэлийн дүрмийг батлуулах	НЗДТГ-ХТГЭЗГ, ХБХСГ, ХТСИ ОНӨААТҮГ	НТ	2023	-	Батлагдсан баримт бичиг	тоо	1	350	Нийслэл хотын суурьшлын бүсийг Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичигт 35206.0 га, Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний концепцид 47044.4 га байхаар тогтоосон байна. Нийслэл хотын эдэлбэр газрын хэмжээ, заагийг тогтоосны үндсэн дээр Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэл тогтоох шалгуур үзүүлэлтийг баталж, Нийслэл хотын эдэлбэр газрын бүсчлэлийн дүрмийг боловсруулах ажил хийгдэх тул Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлагдсаны дараа дээрх ажлуудыг шат дараатай хэрэгжүүлнэ. Улсын Их Хурлын даргын 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 65 дугаар захирамжаар “Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх, бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.	30%
2		Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах	ХБХСГ, ХТСИ ОНӨААТҮГ	НТ	2023	-	Боловсруулсан баримт бичиг	тоо	2	2,007.00	"Налуу-Ухаа" эдийн засгийн тусгай бүсийг хөгжүүлэх ТЭЗҮ, үзэл баримтлал ерөнхий төлөвлөгөө боловсруулах 700.0 сая төгрөгийг Улсын төсвийн хөрөнгөөр Шадар сайдын багц мөнгөн дүнд тусгагдаж, "Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн" УТҮГ захиалагчийн хяналт тавин ажиллаж байна. Тус ажлын тендер шалгаруулалт 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нээлттэй тендер зарлагдсан боловч гүйцэтгэгч байгууллага тавигдах шаардлагад нийцээгүйн улмаас тендер амжилтгүй болж төсөв татагдсан.	30%
3		Агро сити эдийн засгийн тусгай бүсийн Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, ТЭЗҮ боловсруулах	ХБХСГ, ХТСИ ОНӨААТҮГ	НТ	2023	-	Боловсруулсан баримт бичиг	тоо	2	2,817.00	“Агросити” дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд НХААГ/20250103049 гэрээний дагуу “Гоби травэл” ХХК гүйцэтгэж, суурь судалгааны ажлууд хийгдэж эхний шатны тайланг нийслэлийн нутаг дэвсгэрт хот байгуулалтын асуудал хэлэлцэх мэргэжлийн зөвлөлийн 44 дүгээр хурлаар хэлэлцэн дэмжигдсэн боловч Сангийн яам нийслэлийн төсвийн хөрөнгийн дансыг хаасан шалтгаанаар санхүүжилт удааширч, шийдвэрлэгдээгүй. Гүйцэтгэгч тал болох "Гоби Травел" ХХК нь ажлыг хуваарийн дагуу гүйцэтгэн дундын тайланг боловсруулж байгаа боловч санхүүжилт саатсанаас шалтгаалан зарим гэрээт ажлууд, лабораторийн дүгнэлтүүдийг товлосон хугацаанд гүйцэтгэх боломжгүй нөхцөл үүссэн тухай 2025 оны 161/25 дугаартай албан бичгээр гэрээ сунгах хүсэлт ирүүлснийг судлан үзэж хугацаа сунгалтын гэрээг 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр НХААГ/20250103049-2 дугаартай гэрээг байгуулав. “Агросити” дагуул хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажилд Хот байгуулалт хотын стандартын газар нь Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/107 дугаар захирамжийн дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%
4		Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу байгаль орчин, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлж байгаа үйлдвэр аж ахуйн нэгж байгууллагыг хотоос шилжүүлэх бодлого боловсруулж хэрэгжүүлэх	ХБХСГ, ХТСИ ОНӨААТҮГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	120	**Зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх:** Улаанбаатар хотын томоохон, зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг Улаанбаатар хотын 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, мега төслүүд, зам тээвэр, логистикийн сүлжээтэй уялдуулан өнөөгийн байдлын суурь судалгаанд үндэслэн зах худалдааны төвүүдийг нүүлгэн хот төлөвлөлтийн 4 хүчин зүйлсийг /хот төлөвлөлтийн уялдаа, тээвэр логистикийн сүлжээ, эдийн засгийн хүчин зүйл, замын хөдөлгөөний ачаалал/ харгалзан судалж төлөрөл, түгжрэл, агаар орчны бохирдолд хамгийн их нөлөөлж буй томоохон 9 зах худалдааны төвүүдийг нүүлгэн шилжүүлэх урьдчилсан төлөвлөгөө боловсруулав. Зах худалдааны төвүүдийн нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг НЗД-ын зөвлөлийн хурал болон НИТХ-д танилцуулах бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. **Арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэх:** Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төсөл, НИТХ-ын 2024 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан “Эмээлт эко аж үйлдвэрийн парк”-ын ТЭЗҮ, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд ХУД-ийн 20-р хороонд Арьс ширний 28 нэгж үйлдвэр, 3 нэгж ноосны үйлдвэр болоод 10 дагалдах үйлдвэрийг эмээлтийн үйлдвэрийн бүсэд нүүлгэн шилжүүлэх ажил үе шат дараатай хийгдэж байна. Нүүлгэн шилжүүлэх хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр Эмээлт эко аж үйлдвэрийн паркт зохион байгуулсан. Эхний ээлжид ХУД-ийн 20-р хорооны 30.27га талбайг дахин төлөвлөх барилгажилтын зураг төслийн ажил хийгдэж байгаа бөгөөд НХТСИ төслийн гүйцэтгэгчээр ажиллаж байна. Мөн Арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлэх зөвлөлдөх уулзалт зохион байгуулж, Эмээлт эко аж үйлдвэрийн паркт арьс ширний үйлдвэрүүдийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө болон үйлдвэрүүдэд нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой тулгамдаад байгаа асуудлаар санал, хэлэлцүүлэг зохион байгуулж, нүүлгэн шилжүүлэх нэгдсэн төлөвлөлтөд санал нэгдэн ажиллав.	100%
5		Иргэд оршин суугаа газраасаа “20 минутын зай”-д эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах бүтэц, зохион байгуулалтыг хийх	НЭМГ, ДЭМТ	-	2023	-	Баримт бичиг боловсруулах ажлын явц	хувь	30	-	“20 минутын хот” концепцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/142 дугаар тушаалаар байгуулан үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн харьяа 28 байгууллагыг 14 хотын газрын зураг дээр байрлуулан зураглал хийж, бодлогын санал боловсруулсан. Мөн Эрүүл Мэндийн яамны Ажлын хэсэгтэй хамтарсан нийт 4 удаагийн уулзалт, хурлыг зохион байгуулсан. Нийслэлийн эрүүл мэндийн салбарыг бүсчилсэн хөгжлөөр хөгжүүлэх зураглал, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах шатандаа явж байна. 100%	100%
			НЭМГ	-	2023	-	Бэлтгэл ажлын явц	хувь	10	-	“20 минутын хот” концепцийг хэрэгжүүлэх асуудлаар 2025 оны 08 дугаар сарын 13-ны өдөр Улсын Их Хурлын Г.Лувсанжамц гишүүнтэй уулзалт, хэлэлцүүлэг хийсэн. Тус хэлэлцүүлгээр Иргэд оршин суугаа газраасаа 20 минутын зайд эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авах бүтэц, зохион байгуулалтын талаар Нийслэлийн Эрүүл мэндийн газар, харьяа 28 эрүүл мэндийн байгууллагын удирдлагатай өнөөгийн нөхцөл байдал, цаашдын төлөвлөгөөний талаар хэлэлцсэн. Улсын Их хурлаас “20 минутын хот” хорооллын хилийн цэсийн зааг тодорхой болоогүй, нэг жилээр хойшлуулсан тул хүлээгдлийн байдалтай байна. 80%	
6		Иргэд оршин суух газраасаа "20 минутын зайд" алхаж хүрэх ногоон байгууламж бүхий соёл, амралтын хүрээлэн байгуулах	НСУГ	НТ	2023	-	Соёл, амралтын хүрээлэнгийн тоо	тоо	2	2,400.00	Нийслэлийн засаг даргын 2025 оны А/149 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэл Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг иргэдэд танилцуулах өдөрлөгт Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн 12 салбарыг иргэдэд танилцуулсан. Нийслэлийн Соёл, урлагийг салбарын үйл ажиллагааны 2025-2028 он, 2040 он хүртэлх төлөвлөлтийн зураглалыг "Улаанбаатар-2040", "20 минутын хот" концевцтой уялдуулан гаргаж, 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын шуурхай зөвлөгөөнд танилцуулсан. "Бүсчилсэн хөгжил-Салбарын уялдаа" зөвлөгөөнийг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулж, салбарын 300 гаруй албан хаагчид хамрагдсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1530 дугаар захирамжаар Дамбадаржайлин хийдийг уламжлал, шинэчлэлийг хослуулсан, үндэсний түүх дурсгалын цэцэрлэгт хүрээлэн бүхий орчин үеийн соёл, гэгээрлийн төв болгон хөгжүүлэх санал, дүгнэлт боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан. Тус Ажлын хэсэг 2 удаагийн хурал зохион байгуулж, Дамбадаржайлин хийдийг соёл, гэгээрлийн төв болгон хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах бэлтгэл ажлыг гүйцэтгэж байна.	30%
7	НХТЖҮЧ 9.1.1	Хот байгуулалтын кадастрын мэдээллийн системийг бүрэн ашиглалтад оруулж иргэд олон нийтэд нээлттэй болгох	НЗДТГ-ДБХБХ, ХБХСГ	НТ	2023	70	Систем ашиглалтад оруулах ажлын хэрэгжилт	хувь	100	200	“eBarilga хот байгуулалтын цахим системийн нэмэлт хөгжүүлэлт хийх” ажлын гүйцэтгэгчээр “Смартдата” ХХК шалгарч, 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр НХБХГ20240103002 дугаартай гэрээ байгуулан, Хот байгуулалт, хотын стандартын газрын үйл ажиллагааг бүрэн цахимжуулж, хот төлөвлөлт, барилга байгууламжийн зөвшөөрөлтэй холбоотой мэдээллийг иргэд, олон нийтэд нээлттэй болгох, хот төлөвлөлтийн үйл ажиллагаанд иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээг цахимаар шуурхай хүргэх, дотоод удирдлагын системд нэмэлт хөгжүүлэлт хийх, бусад төрийн байгууллагуудтай өгөгдөл, мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлэн программын эх код, тайланг хамт ирүүлснийг 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн №ХОЗМТХ-2024/02 дугаартай актаар хүлээн авсан.	100%

8	НХТЖҮЧ 9.3	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд тохируулан нэвтрүүлэх, газар олголтын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгож хөгжүүлэх	НГЗБА	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	800	Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай Засгийн Газрын 2020 оны 110 дугаар тогтоолын дагуу хөгжүүлэгдсэн Газрын удирдлагын нэгдсэн цахим системийг өдөр тутмын хэрэглээнд нийслэл, дүүргийн газар зохион байгуулалтын албаны хэмжээнд хэрэглэгчийн эрхээр нэвтрэн ашиглаж байгаа бөгөөд ашиглалтын явцад үүсэж буй хэрэгцээ шаардлагаас хамааран тухай бүр хөгжүүлэлтийн саналыг журамд заасны дагуу хүргүүлж Мөн түүний дараа Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 121 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн үйл ажиллагааны журам”-ын дагуу шинэчлэн хөгжүүлэгдсэн egazar.gov.mn болон Egazar утасны аппликейшнээр газар олголтын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд нээлттэй болгон нийслэлийн хэмжээнд газар олгогдсон газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэдийн нэр, газрын хэмжээ, төлбөр, захирамжийн мэдээлэл зэргийг нээлттэй харах боломжоор ханган ажилласан болно.	100%
9		Иргэн, хуулийн этгээдэд зориулсан газрын биржийн цахим системийг хөгжүүлэх	НГЗБА	НТ	-	-	Систем хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилт	хувь	100	120	Нийслэлийн Газрын биржийн удирдлагын мэдээллийн системийг хөгжүүлэх зөвлөх үйлчилгээний тендерт “Смарт дата” ХХК шалгарч Газрын биржийн цахим системийг Газрын удирдлагын системтэй бүрэн холбож газрын нөөц сан бүрдүүлэх давхарга үүсгэсэн бөгөөд Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газрын даргын зөвлөлийн 2024 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 22 дугаар хурлын шийдвэрээр Газрын биржийн цахим системийн шинэчлэсэн хувилбарыг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд нэвтрүүлэн ажиллаж байна. Цахим системээр нийт 68 байршилд 8 удаагийн дуудлага худалдаа, мөн 3 байршилд 1 удаагийн төсөл сонгон шалгаруулалтыг тус тус зохион байгуулж нийслэлийн төсөвт 12,5 тэрбум төгрөгийг төвлөрүүлээд байна	100%
10	НХТЖҮЧ 9.4.5	Нийтийн эдэлбэр газрын байршлыг тогтоож, бүртгэлжүүлэх, хамгаалах аж ахуйн зохион байгуулах	НГЗБА	-	2023	89	Нийтийн эдэлбэрт бүртгэх байршил	тоо	20	-	Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 24/26 дугаар тогтоолоор, нэмэлт, өөрчлөлтийг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 24/49 дүгээр тогтоолоор тус тус батлуулж Нийслэлийн нутаг дэвсгэрт амралт, зугаалга, нийтийн биеийн тамирын зориулалттай нийтийн эзэмшлийн газар, цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх, нийтээр зүй зохистой ашиглах, хамгаалах зорилгоор нийслэлийн 9 дүүрэгт, 53 байршлын 67.4 га талбай бүхий газрыг 2025 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 25/89 дугаартай тогтоолоор нийтийн эдэлбэрт авж, мэдээллийн санд бүртгэсэн.	100%
11		Гэр хороолол, зуслангийн бүс, орон сууцны хороолол, нийтийн эзэмшлийн зам, талбайн газрын зөрчлийг арилгаж түргэн тусламж, гал унтраах, аврах ажиллагааг шуурхай зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлэх	НГЗБА	НТ	2023	481	Арилгасан зөрчил	тоо	500	990	Нийслэлийн иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, нийтийн эзэмшил явган замын хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, газрын зөрчил арилгах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/211 дүгээр захирамжаар нийслэлийн 6 дүүргийн 83 байршилд 887 гараашыг чөлөөлөн зөрчил арилгаж нийтийн эзэмшлийн зам талбайг 15966 м.кв-аар нэмэгдүүлсэн. Мөн 2 байршилд 5 байгууламжийг буулгаж, газар чөлөөлсөн. Баянгол дүүргийн Засаг даргын 2025 оны А/478 дугаар захирамжаар 1 байршлын 7 гараашь, Налайх дүүргийн Засаг даргын 2025 оны А/127 дугаар захирамжийн 1 байршлын 116 тус тус чөлөөлсөн байна. 7 дүүргийн нутаг дэвсгэрт 1,664 “түргэн үйлчилгээний цэг”-ийг нүүлгэн шилжүүлж, үйл ажиллагааг зогсоосон. 6 дүүргийн 112 байршилд 6175 метр хашаа хайсыг чөлөөлсөн	100%
12	НХТЖҮЧ 9.4.5	Газрын мониторингийн цахим системээр дамжуулан газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийх	НГЗБА	-	2023	13461	Хянан баталгаа хийсэн нэгж талбар	тоо	15000	-	Нийслэлийн хэмжээнд 2025 онд Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийн дэд систем болох Газрын мониторингийн цахим системээр ирүүлсэн 23,148 захиалгат хянан баталгааг хянаж баталгаажуулсан.	100%
13		Газрын төлөв байдал, чанарын улсын төлөвлөгөөт хянан баталгааг Нийслэлийн хот тосгон, бусад суурин газарт хийх	НГЗБА	НТ	2024	207	Хянан баталгаа хийсэн талбайн хэмжээ	мян.га	79557.87	1,490.00	Газрын тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.7-д заасны дагуу нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэлийн 6 дүүргийн хэмжээнд газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газарт Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийхээр Нийслэлийн Засаг дарга болон Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны даргын хамтарсан НГЗБА/20250101015-01-05 ажлын даалгавар батлагдсан. Баянгол, Багануур, Багахангай, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргүүдийн нутаг дэвсгэрт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх” 5 багц ажлын гүйцэтгэх “Ланд овнер” ХХК, “Вектор мэп” ХХК, “Геоботаник” ХХК-тай 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. 2025 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдаар хээрийн судалгааны тайланг ирүүлээд байна. Багануур, Багахангай, Баянгол, Сонгинохайрхан, Налайх, Хан-Уул дүүргүүдийн хэмжээнд газрын нэгдмэл сангийн бүх ангилалын газарт буюу нийт 316,262 га газарт “Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх” ажлын даалгаврыг батлуулж Бэлчээрийн 67 цэгт, Тариалангийн 76, Хадлангийн 2, Хот тосгон, бусад суурины 321, Зам шугам сүлжээний 27, Ойн сангийн 17, Усан сангийн 27, Тусгай хамгаалалттай газар нутгийн 24, нийт 561 цэгт агро хими, хүнд металл, эрүүл ахуйн дээжийг авч итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ хийлгэсэн.	100%
14		Баянхошуу дэд төвийн нийгмийн бүтээн байгуулалтын ажлыг дуусгах	УБГХХХОДХ төслийн нэгж	УТ, ГЗ	2023	72	Дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын явц	хувь	100	12,873.60	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэлтийн хүрээнд нийт 52 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 51 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 98%-тай байна. Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил бүрэн хэрэгжиж дууссан байна. Худалдан авах ажиллагааны явц 98%-тай байгаа бөгөөд Баянхошуу дэд төвд баригдаж буй олон нийтийн хөгжлийн төв болон спорт цогцолборын 3 багц тавилга, тоног төхөөрөмж худалдан авах барааны худалдан авалт үлдсэн байна. Баянхошуу дэд төвийн барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: • 3.4 км дулааны шугам сүлжээний угсралтын ажлын явц 95%-тай, 1ш УДДТ-ийн барилга угсралтын ажлын явц 98% • 2.4 км цэвэр усны, 0.36 км ариутгах татуургын шугам сүлжээний ажлын явц 99%тай байгаа бөгөөд туршилт, тохируулга хийх, улсын комисс ажиллуулах, дренажийн шугам, цахилгаан кабель өндөрлөх ажлууд үлдсэн байна. • 240 хүүхдийн ортой цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц 17.2%-тай байгаа бөгөөд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр барилгын материалын үнийн өсөлт болон тарифт цалингийн өсөлтөөс шалтгаалж, барилга угсралтын ажил 2021,2022 оноос хойш зогссон байдалтай байна. Төсөвт өртөгт дахин магадлал хийгдэж байна. • 650 хүний суудал бүхий спорт цогцолборын барилга угсралтын ажлын явц 79% • 200 хүний суудал бүхий олон нийтийн хөгжлийн төвийн барилга угсралтын ажлын явц 28%-тай байгаа бөгөөд Ковид-19 цар тахлын нөлөөгөөр барилгын материалын үнийн өсөлт болон тарифт цалингийн өсөлтөөс шалтгаалж төсөвт өртгийн дахин магадлал хийлгэсэн. Үүнтэй холбогдуулан гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах зөвшөөрлийн хүсэлтийг санхүүжүүлэгч байгууллагад хүргүүлээд байна. • Аврах, гал унтраах 29-р ангийн барилга угсралтын ажлын явц 59.1%, • 20’000 м2 цэцэрлэгт хүрээлэнгийн барилга угсралтын ажлын явц 81.3%-тай байгаа бөгөөд тарифт цалингийн өсөлттэй холбоотой дахин магадлал хийлгэж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан 2025 оны 6 сарын 3-нд батлаад байна. Дэд төвийн бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц 93.6%-тай байна.	93.60%

15	МУХТЖҮЧ-9.3.2 НХТЖҮЧ-9.2.2	Дамбадаржаа дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	УБГХХХОДХ төслийн нэгж	УТ, ГЗ	2023	54.7	Дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын явц	хувь	90	72,974.10	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 297 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 296 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 98%-тай байна. Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажил бүрэн хэрэгжиж дуусан. Худалдан авах ажиллагааны явц 98%-тай байгаа бөгөөд 63МВт-ын дулааны станцын зөвлөх үйлчилгээний 1 багц ажил, 58-р сургууль орчмын орц, гарц, гадна тохижилтын 1 багц ажил болон цэцэрлэгийн тавилга худалдан авах 1 багц ажил үлдсэн байна. Дамбадаржаа дэд төвийн барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: • 2.8 км авто замын ажлын явц 59% • 63МВт-ын хүчин чадалтай дулааны станцын барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 20%-тай байгаа бөгөөд Эрчим хүчний яамнаас ажил эхлүүлэх зөвшөөрөл 2025 оны 3 сарын 6-нд гарсан. 21МВт-ын 3 зуух болон метал хийц, бусад голлох тоног төхөөрөмжүүдийн гадаад захиалга хийгдээд байна. • 2.15 км дулааны шугам сүлжээний ажлын явц 83%, 4ш ус дулаан дамжуулах төвийн барилга болон тоног төхөөрөмж угсралтын ажлын явц 90% • 6.6 км цахилгааны шугам сүлжээ, 5.9 км холбооны сувагчлал, 4.8 км шилэн кабель, 1 хуваарилах байгууламж, 2 хаалттай дэд өртөө болон мэдээлэл холбооны сүлжээний нэгдсэн үйлчилгээний төвийн барилга угсралтын ажлын явц нийт 57.4% байгаа бөгөөд “Авто зам, талбай, тохижилт, ногоон байгууламжийг сэтлэх, сүвлэх, орц, гарц гаргах болон нөхөн сэргээх зөвшөөрөл олгох” ажлын хэлтсийн хурлаар орж зам сэтлэх, сүвлэх зөвшөөрөл авах шаардлагатай хурлын тов хүлээгдэж байна. • 2.24 км цэвэр усны, 3 км ариутгах татуургын шугам сүлжээний ажлын явц 61% • 1.2 км хөрсний ус доошлуулах шугамын угсралтын ажлын явц 76% • 150 хүүхдийн цэцэрлэгийн барилга угсралтын ажлын явц 83%-тай байна. Дэд төвийн бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц 60.8%-тай байна.	80.0%
16		Толгойт дэд төвийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	УБГХХХОДХ төслийн нэгж	УТ, ГЗ	2023	32.5	Дэд төвийн бүтээн байгуулалтын ажлын явц	хувь	55	129,265.30	Газар чөлөөлөлт, нүүлгэн шилжүүлэх ажлын хүрээнд нийт 501 өрх газар чөлөөлөлтөд өртсөнөөс 472 айл өрхөд нөхөн олговор олгосон бөгөөд хэрэгжилт 96.1%-тай байна. Нийгмийн болон инженерийн барилга байгууламжуудын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын явц 98%-тай хэрэгжиж байна. Худалдан авах ажиллагааны явц 85%-тай байгаа бөгөөд Толгойт дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн 4 багц ажил, тавилга, тоног төхөөрөмж худалдан авах 2 барааны худалдан авалт үлдсэн байна. Толгойт дэд төвийн барилга угсралтын ажил дараах байдлаар хэрэгжиж байна. Үүнд: • 1.8 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 95%-тай байгаа бөгөөд Е1 үерийн хамгааллын сувагтай огтлолцсон дулааны шугамыг агаарын шугам болгон зөөж шилжүүлэх ажил 50%-тай хийгдэж байна. • 5.2 км үерийн хамгаалалтын сувгийн барилга угсралтын ажлын явц 46%-тай байгаа бөгөөд Д-1, Д-2.1, Д-2.3 үерийн хамгаалалтын сувгийн угсралтын ажил хийгдэж байна. А1 замын доогуурх ус гаргуурын асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. • 2.84 км цэвэр усны шугам сүлжээний ажил 98%, насос станцын барилга угсралтын ажлын явц 90%-тай байгаа бөгөөд туршилт тохируулгын ажлууд, гадна цахилгааны нэмэлт ажлууд, шугам хоолойн шахалтын ажлууд зэрэг улсын комисс ажиллуулахад шаардлагатай бэлтгэл ажлууд хийгдэж байна. • 10 кВ-ын хүчдэлийн 13 км урттай 4 хос цахилгааны кабель шугам, 2 хаалттай дэд өртөө болон 1 хуваарлах байгууламжийн ажлыг гүйцэтгэхээр гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажил эхлүүлэх зөвшөөрөл хүссэн байна. Түр болон үндсэн цахилгааны техникийн нөхцөлийг сунгах болон шинээр авах хүсэлтийг itc.energy.mn цахим системээр дамжуулан хүргүүлсэн боловч тоон гарын үсэгтэй холбоотой техникийн асуудал гарснаас шалтгаалан системд хандах боломжгүй болсон. Уг асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Хаалттай дэд өртөө болон хуваарлах байгууламжийн суурийн арматурчлал болон цутгалтын ажил хийгдэж барилга угсралтын ажлын явц 5%-тай байна. • Сургалтын төвийн барилга угсралтын ажлын явц 96%-тай байгаа бөгөөд улсын комисс ажиллуулах хүсэлт өгсөн. • 640 хүүхдийн сургуулийн барилга угсралтын ажлын явц 42%-тай байна. Дэд төвийн бүтээн байгуулалтын хэрэгжилтийн явц 43.1%-тай байна.	70.0%
17		Сэлбэ дэд төвийн гэр хорооллыг орон сууцжуулах төслийг үргэлжлүүлэх	НОСБГ, НОСК ХК	үнэт цаас	2023	15	Төслийн хэрэгжилт	хувь	70	1,638,200.00	“Сэлбэ хорин минутын хот” төсөл, арга хэмжээний хүрээнд Чингэлтэй дүүргийн 14, 18 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр хорооны нутаг дэвсгэрт нийт 158 га талбайд Сэлбэ дэд төв орчмын гэр хорооллыг дахин төлөвлөн орон сууцжуулах иж бүрэн цогцолбор хороолол төслийг хэрэгжүүлж байгаа бөгөөд 8565 өрхийн 113 блок орон сууц, 7,1 км авто зам, 39 км явган зам, 23 км дугуйн зам, 3.6 га талбайд тоглоомын талбай, 3 сургууль, 5 цэцэрлэг, эмнэлэг, спорт байгууламж, нийт талбайн 36 хувьд ногоон байгууламж барихаар төлөвлөсөн. 158 га газрын 2206 нэгж талбар чөлөөлөхөөс 2118 айлын газрыг чөлөөлж, газар чөлөөлөлт 94 хувьтай байна. Талбайн цэвэрлэгээ, ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлын хүрээнд нийт 2206 нэгж талбарт ариутгал халдваргүйжүүлэлт хийхээс 1919 нэгж талбарын цэвэрлэж ариутган ажлын явц 83.0%, Холбооны худаг буулгалтын ажил 95%, Барилгын төслийн байршилд зөвшөөрөлгүй баригдаж буй барилгын буулгалтын ажил 95% хийгдсэн. Гэр хорооллыг орон сууцжуулах Багц 1,2,3,4 төслийн нийт 7 гүйцэтгэгч компаниуд шалгарч барилгажилтын ажлыг эхлүүлсэн. Нийт төслийн гүйцэтгэлийн хувь: 1.Төслийн ТЭЗҮ, зураг төслийн гүйцэтгэлийн хувь 95%, 2.Багц 1,2 ГИШС зураг төсөл 100% магадлагдсан, Багц 3,4 ГИШС 98%, магадлуулах ажил хийгдэж байна. 3.Газар чөлөөлөлт 94%, Цэвэрлэгээ буулгалт 70.4% 4.Сонгон шалгаруулалт, Гүйцэтгэгчтэй гэрээлэх ажил 78.6% 5.Барилга угсралтын гүйцэтгэлийн хувь 7% 6.Багц 1 Бэлтгэл ажил-98.6%, Суурь ухлагын ажил-89.7%, Суурийн ажил-52.6%, Зоорийн давхрын угсралтын ажил-38%, Барилга угсралтын ажил-4.5% 7.Багц 2 Бэлтгэл ажил 98.2%, Суурь ухлагын ажил-91.1%, Суурийн ажил-61.3%, Зоорийн давхрын угсралтын ажил 76.2%, 1-р давхрын угсралтын ажил 37.8%, 2-р давхрын угсралтын ажил-7.3%, Барилга угсралтын ажил-5.6% 8.Багц 3.1 Бэлтгэл ажил-6% 9.Багц 3.2 Бэлтгэл ажил-66%, Суурь ухлагын ажил-80%, Суурийн ажил-30.6%, Барилга угсралтын ажил-2.6% 10.Багц 3.3 Бэлтгэл ажил-54%, Суурь ухлагын ажил-56.8%, Суурийн ажил-33.3%, Зоорийн давхрын угсралтын ажил-34.8%, Барилга угсралтын ажил-2.6% 11.Багц 4.1 Бэлтгэл ажил-55%, Суурь ухлагын ажил-70.3%, Суурийн ажил-46.8%, Зоорийн давхрын угсралтын ажил-43.9%, Барилга угсралтын ажил-3.5 хувьтай төслийн ажил үргэлжилж байна. "Сэлбэ хорин минутын хот" төслийн гүйцэтгэлийн хувь 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 24,5 байна.	100%

1.2 Гэр хорооллын дахин төлөвлөлт, орон сууцжуулалт												
Салбарын үр дүн: Нийслэлийн орон сууцны хангамжийг 7000 өрхийн орон сууцаар нэмэгдүүлнэ.												
18	МУХТЖҮЧ-9.3.2 НХТЖҮЧ-9.6.1	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийг үргэлжлүүлэх	НОСБГ, НХОГ ОНӨААТҮГ	НТ	2023	17,984	Ашиглалтад орсон орон сууц 6508	өрх	24,492	38,392.80	Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд нийслэлийн хэмжээнд нийт 26 байршлын 82 хэсэгчилсэн талбай батлагдсан. 2025 оны жилийн эцсийн байдлаар 17 байршлын 40 хэсэгчилсэн талбай буюу нийт 851.05 га газарт 36 төсөл хэрэгжүүлэгч дахин төлөвлөлтийн үйл ажиллагаа явуулж байна. 2025 онд ашиглалтад орсон орон сууцыг байршил, төсөл хэрэгжүүлэгчээр нь авч үзвэл: Үүнд: Сонгинохайрхан дүүрэгт "Шинэ барилга" ХХК 60 өрхийн 1 блок орон сууц, Баянзүрх дүүргийн 12 дугаар “Б” хэсэгчилсэн талбай "Бүргэд констракшн" ХХК 517 өрхийн орон сууц, "Б" хэсэгчилсэн талбай "Жигүүр гранд групп" ХХК 150 өрхийн орон сууц, Баянзүрх дүүргийн 13, 14 дүгээр хороо Орон сууцны 14 дүгээр хороолол орчим “Е” хэсэгчилсэн талбай "Цагаан хуаран консалтинг" ХХК 135 өрхийн орон сууц, "З" хэсэгчилсэн талбай Таун констракшн ХХК 509 айлын орон сууц, "Б" хэсэгчилсэн талбай "Моннис урбан девелопмент" ХХК 330 өрхийн орон сууц, "Бүрд констракшны ГХДТ" ХХК 570 өрхийн орон сууц, Баянзүрх дүүргийн 8, 16 дугаар хороо А хэсэгчилсэн талбай "Баганат өргөө" ХХК 1078 өрхийн орон сууц, Баянгол дүүргийн 10, 11 дүгээр хороо “А” хэсэгчилсэн талбай Грийн ресурс констракшн ХХК 222 айлын орон сууц, “Б” хэсэгчилсэн талбай Очирням проперти девелопмент ХХК 336 айлын орон сууц, Баянзүрх дүүргийн 12 дугаар хороо Амгалан орчимд төсөл хэрэгжүүлэгч Грандлайн ХХК 240 айлын орон сууц, Сүхбаатар дүүргийн 9, 10, 11 дүгээр хороо “Б” хэсэгчилсэн талбай Пример инвестмент групп ХХК 96 айлын орон сууц, Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороо “Е” хэсэгчилсэн талбай "Андын зам констракшн" ХХК 360 айлын орон сууц, Баянзүрх дүүрэг 13, 14 дүгээр хороо “И” хэсэгчилсэн талбай Би Си Кей Си ХХК 360 айлын орон сууц, Чингэлтэй дүүрэг 9 дүгээр хороо “А” хэсэгчилсэн талбай Бармон ХХК 234 айлын орон сууцыг тус тус байнгын ашиглалтад оруулсан. 2014-2025 оны хоорондо ашиглалтад орсон орон сууцны тоо өссөн дүнгээр 24513 хүрсэн байна.	100%
19	МУХТЖҮЧ-9.3.2 НХТЖҮЧ-9.8.1	Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийг үргэлжлүүлэх	НОСБГ, НОСК ХК	НТ	2023	3,270	Ашиглалтад орсон орон сууц	өрх	4,311	9,229.70	Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хууль, Барилга, хот байгуулалтын сайдын 2016 оны 126 дугаар тушаалаар батлагдсан “Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны журам”-ын дагуу 2015 оноос хойш Нийслэлийн Засаг даргын 22 удаагийн захирамжаар 208 барилгыг буулган, дахин төлөвлөж, барилгажуулах тухай шийдвэр гарсан. Үүнээс 4 байрны сууц өмчлөгчид өөрийн хүсэлтээр төсөл хэрэгжүүлэхээс татгалзсан. 2025 онд Нийслэлийн Засаг даргын 2 удаагийн захирамжаар 22 барилгын дахин төлөвлөн барилгажуулах шийдвэр гарч төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй урилгыг удаа дараа нийтэлсэн боловч санал ирэхгүй байгаа болон төсөл хэрэгжүүлэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалан иргэд хохирсон ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны 82 барилгыг "Улаанбаатар орон сууцжуулалт" ХХК-д, 25 барилгыг "Нийслэлийн Орон сууцны корпораци" ХК-д тус тус шилжүүлсэн бөгөөд төслийн үйл ажиллагаанд хяналт тавин ажиллаж байна. Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган, шинээр барих төслийн хүрээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 43 байршилд 5427 айлын үйлчилгээтэй орон сууц ашиглалтад оруулсан.	100%
20	МУХТЖҮЧ-9.3.3 НХТЖҮЧ-9.6.2	Дэд бүтцийн төв төслийг үргэлжлүүлэх	НОСБГ, ХБХСГ, НХОГ ОНӨААТҮГ	НТ	2023	3	Дэд бүтцийн төв	тоо	5	8,983.70	Сонгинохайрхан дүүргийн 4, Хан-Уул дүүргийн 9, Баянзүрх дүүргийн 23 дугаар хорооны нутаг дэвсгэрт гэр хорооллын дундын бүсэд хэсэгчилсэн инженерийн хангамжийг нэвтрүүлэх Дэд бүтцийн төвийн ажлын зураг төсөл боловсруулах ажлын гэрээг "Эм Эс Эл" ХХК-тай байгуулсан. Ажил бүрэн хэрэгжиж дуусан бөгөөд 2023 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн 1516/2023, 2023 он 08.31-ний өдрийн 1380/2023, 2023.08.28-ны өдрийн 1364/2023 магадлалын ерөнхий дүгнэлтээр тус тус баталгаажсан. Ажлын дундаж гүйцэтгэл 100%	100%
21	МУХТЖҮЧ-3.2.1 НХТЖҮЧ-9.7.2	"Улаанбаатар хотын орлогод нийцсэн 712 айлын ногоон орон сууц төсөл"-ийг үргэлжлүүлэх	НОСБГ	ГЗ	2023	10	Төслийн хэрэгжилт	хувь	30	20,539.60	2025 онд төслийн хүрээнд байгуулах 712 айлын орон сууцны хорооллын ерөнхий гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажлыг 2025 оны 4 дүгээх сард эхлүүлэн Европын Сэргээн Босголт ба Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ны Худалдан авах ажиллагааны дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж байна. Төслийн барилга угсралтын зураг төслийг шинэчлэн гаргаж 2024 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Хотын Ерөнхий архитектор батлсан. Төслийн барилга угсралтын талбайн цэвэрлэгээний ажлыг барилгын бетонон суурь болон хог хаягдлыг цэвэрлэх ажлыг 2025 оны 5 сард эхлүүлэн хэрэгжүүлж байна.	90%
22	МУХТЖҮЧ-3.2.1 НХТЖҮЧ-9.7.2	"Баянгол ам түрээсийн орон сууцны хороолол барих төсөл"-ийг үргэлжлүүлэх	НОСБГ	ГЗ	2023	15	Төслийн хэрэгжилт	хувь	50	136,323.20	Сонгинохайрхан дүүргийн 34 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 10 га талбайд 2007 айлын орон сууцны хороолол барих төслийн барилга угсралтын ажил хийгдэж байна Бүгд Найрамдах Солонгос Улсын Экспорт-Импорт банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй "Баянголын амын орлогод нийцсэн орон сууц төсөл"-ийн барилга угсралтын ажлын захиалагчийн хяналтыг БНСУ-ын “Аум ба Лий” консорциумтай зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу хийж гүйцэтгэж байна. Барилга угсралтын ажил ерөнхий гүйцэтгэгчээр “ИЛ СОНГ” ХК, туслан гүйцэтгэгчээр “Сүмбэр цамхаг” ХХК барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэж байна. Газар шорооны ажил 100%, Суурийн ажил 90%, Зоорийн давхар карказ угсралт 85%, Төслийн нийт ажлын гүйцэтгэл 86%-тай явагдаж байна.	100%
23	НХТЖҮЧ 9.7.2	Баянхошуу дэд төвд ногоон орон сууц бүхий эко хороллын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	УБХОННОСБДЗЧБ ХШС төсөл	ГЗ	2023	60	1,2-р ээлжийн ажлын хэрэгжилт	хувь	100	28,288.40	Төслийн хүрээнд тогтвортой хөгжлийн 37 гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) бүхий ногоон орон сууцны барилгын техникийн шаардлагыг хангасан, мөн Олон улсын ногоон барилгын үнэлгээний EDGE системийн шалгуурын дагуу 800 айлын орон сууцны барилга болон ухаалаг удирдлагын СКАДА төвийн барилгын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд болон магадлалаар хянуулан батлуулсан. Баянхошуу дэд төвд баригдаж буй эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны 4 блок барилга угсралтын ажил бүрэн дуусч, 2025 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр үүрэг даалгаврын биелэлттэйгээр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах улсын комисст хүлээлгэн өгсөн ба 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн БА-311/2025 дугаар барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комиссын дүгнэлт гарсан.	100%
				ГЗ	2023	-	3-р ээлжийн ажлын хэрэгжилт	хувь	40	23,822.90	Баянхошуу дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын явц 100 хувийн хэрэгжилттэй, улсын комиссд 2024 оны 12 сарын 26-нд хүлээлгэн өгсөн. Харин Баянхошуу дэд төвд 2024 оны 7 сараас эхлүүлсэн 226 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 68 хувьтай хэрэгжиж байна. Баянхошуу дэд төвийн барилгуудыг EDGE стандартын шаардлагыг хангасан байдалд эрх бүхий "Sintali" Ltd аудит хийсэн ба 2025 оны 8 дугаар сарын 13-нд B15 талбарын 4 блок барилгууд нь EDGE стандартыг зураг төслийн шатанд хангасан болохыг батлан GP1-MNG-23112910179665-110-P дугаартай EDGE гэрчилгээ олголоо. Аудитын явцад тус төслийн эрчим хүчний хэмнэлт - 34%, Усны хэмнэлт - 20%, Материалд шингэсэн хүлэмжийн хийн хэмнэлт - 21% гэж үнэлэгдсэн болно.	
24	НХТЖҮЧ 9.7.2	Шархад дэд төвд ногоон орон сууц бүхий эко хороллын бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	УБХОННОСБДЗЧБ ХШС төсөл	ГЗ	2023	90	1-р ээлжийн ажлын хэрэгжилт	хувь	100	7,465.20	Төслийн хүрээнд тогтвортой хөгжлийн 37 гүйцэтгэлийн үзүүлэлт (KPI) бүхий ногоон орон сууцны барилгын техникийн шаардлагыг хангасан, мөн Олон улсын ногоон барилгын үнэлгээний EDGE системийн шалгуурын дагуу 800 айлын орон сууцны барилга болон ухаалаг удирдлагын СКАДА төвийн барилгын нарийвчилсан зураг төслийг боловсруулж, холбогдох мэргэжлийн байгууллагууд болон магадлалаар хянуулан батлуулсан. Шархад дэд төвд баригдаж буй эхний ээлжийн 110 айлын ногоон орон сууцны 4 блок барилга угсралтын ажлын хэрэгжилт дунджаар 99.9 хувийн гүйцэтгэлтэй байна. Энэхүү барилгыг 2025 оны 12 дугаар сард Улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж байна. Шархад дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын явц 100 хувийн хэрэгжилтэд хүрч, 2025 оны 11 дүгээр сарын 12-нд барилга байгууламжийг байнгын ашиглалтад өгөх улсын комисст хүлээлгэн өгсөн. 99%	90%
				ГЗ	2023	30	2-р ээлжийн ажлын хэрэгжилт	хувь	100	45,071.20	Шархад дэд төвийн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийн ажлын явц 100 хувийн хэрэгжилтэд хүрч, 2025 оны 11 дүгээр сарын 12-нд барилга байгууламжийг байнгын ашиглалтад өгөх улсын комисст хүлээлгэн өгсөн. Шархад дэд төвд 2024 оны 7 сараас эхлүүлсэн 152 айлын ногоон орон сууцны барилга угсралтын ажил 71%, 2025 оны 03 дугаар сард эхлүүлсэн 76 айлын ногоон орон сууцны барилга угсралт 51.4%-тай, нийт гүйцэтгэл дунджаар 61,2%-тай хэрэгжиж байна. Төслийн барилгуудыг EDGE стандартын шаардлагыг хангасан байдалд эрх бүхий "Sintali" Ltd аудит хийсэн ба 2025 оны 5 дугаар сарын 15-нд S27-2 төслийн 6 блок барилгууд нь EDGE стандартыг зураг төслийн шатанд хангасан болохыг батлан GP1-MNG-24101310211650-240-P дугаартай EDGE гэрчилгээ олголоо. Аудитын явцад тус төслийн эрчим хүчний хэмнэлт 38%, Усны хэмнэлт 29%, Материалд шингэсэн хүлэмжийн хийн хэмнэлт 23% гэж үнэлэгдсэн болно. 45%	
25	МУХТЖҮЧ 2.1.1 НХТЖҮЧ 2.2.1	Орлогод нийцсэн орон сууцны төслийг үргэлжлүүлэх (Баянголын ам)	НОСК ХК	ТХХТ	2023	10	Төслийн хэрэгжилт	хувь	40	3,000.00	Төсөл хэрэгжүүлэгч “Сайхан төмөрт” ХХК нь 102 дугаар блок 6 давхар хүртэлх арагт бүтээцийн ажил, 103 дугаар блок суурь болон зоорины давхрын арагт бүтээцийн ажлыг гүйцэтгэзд байна. Гэвч тухайн бүсэд байрлах инженерийн дэд бүтцийн найдвартай хангамжийн дутмаг байдал болон Дулааны техникийн нөхцөлийн сунгалт удааширч байгаагаас шалтгаалан үлдсэн барилга угсралтын ажил удаашралтай байна.	40%

26	НХТЖҮЧ 9.7.2	Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууны сан байгуулах	УБХОННОСБДЗЧБ ХШС төсөл, ДБМ Ассет Менежмент ҮЦК ХХК	ГЗ	2024	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	96,850.20	Төслийн бүрэлдэхүүн 2-ыг хэрэгжүүлэх Уур амьсгалын ногоон сангийн МОН-8348 эх үүсвэрийг Сангийн яамнаас Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт дамжуулан зээлдүүлэх гэрээ 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал (НИТХ)-ын 2024 оны 09 сарын 19-ний 108 дугаар тогтоолоор "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан"-д хөрөнгө оруулах тухай тогтоолыг гарсан. Санхүүгийн зохицуулах хороонд сан үүсгэн байгуулахад шаардлагатай баримт бичгүүдийг бүрдүүлэн хүргүүлж, санг бүртгэх тухай тус хорооны шийдвэрийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр гаргуулсан. Мөн "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан"-д хөрөнгө оруулах тухай Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/608 дугаар захирамж гарсан ба энэхүү захирамжийг үндэслэн 2025 оны 06 дугаар сарын 3-ны өдөр санг хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэсэн. Сангийн нэгж эрх эзэмшигч буюу Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК ХХК-тай “Хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээ”-г 2025 оны 07 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан. Энэхүү сангийн хөрөнгө оруулалтаар хөгжүүлэх дэд төвүүдийн 33.8 га талбарт барилгажилтын судалгааг гүйцэтгэж, төслийн техникийн бэлтгэл ажлыг хангасан ба тус талбарын 694 хашааны газрын эздээс нийгэм эдийн засгийн судалгаа болон төсөлд оролцох сонирхлын судалгааг гүйцэтгэсэн.	100%
27	МУХТЖҮЧ 2.1.1 НХТЖҮЧ 2.2.1	Шинэ суурьшлын бүсийн орон сууцны хорооллын төслийн хүрээнд 28 мВт хүчин чадалтай уурын зуух шинээр барих /Морингийн даваа/	НОСК ХК	НТ	2023	-	Барилгын ажлын хэрэгжилт	хувь	100	4,500.00	Шинэ суурьшлын бүсийн орон сууцны хорооллын төслийн хүрээнд 28 мВт хүчин чадалтай уурын зуух шинээр барих санхүүжилтийг Нийслэлийн 2025 оны төсөвт суулгасан боловч шийдвэрлэгдээгүй. Төсөв тавигдаагүй тул ажил зогссон ба Хог шатаах үйлдвэрээс дулаан хангаж болох эсэх талаарх судалгаа болон хувийн хэвшлийн байгууллагуудад хандан санхүүжилт босгох ажлыг явуулж байна.	30%
28	НХТЖҮЧ 9.8.4	Угсармал орон сууцны барилгын дулаан алдагдлыг бууруулах, дулаалах "NAMA FACILITY" төслийг эрчимжүүлэх	УБЗАА	ГЗ	2023	5	Төслийн хэрэгжилт	хувь	15	7,410.00	Улаанбаатар хотын орон сууцны эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэх төсөл 2022 оноос хэрэгжихээр төлөвлөж, айл өрхийн эргэн төлөлтийн хувь хэмжээ нь 50% байсныг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба нь Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурал, Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оршин суугчдаас авах эргэн төлөлтийн хувь хэмжээний хувилбарыг танилцуулж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн 25/54 дүгээр тогтоолоор “эргэн төлөлтийн хувь хэмжээг 25% хүртэл байхаар” тогтоосон. Тогтоол батлагдснаас хойш нийт 95 блок барилгын оршин суугчидтай гэрээ байгуулсан. Герман улсын Олон улсын хамтын ажиллагааны байгууллагаас 5 давхар, 9 давхар, 12 давхар угсармал орон сууцыг дулаалах давтан хэрэглэх нэг маягийн зургийг захиалан гүйцэтгүүлж, Барилгын хөгжлийн төвөөр 2025 оны 08, 09 дүгээр сард магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан байна. Төслийн хүрээнд 2025 онд нийт 27.8 тэрбум төгрөгийн санхүүжилт батлагдаж, Нийслэлийн төсвийн санхүүжилт 9.8 тэрбум төгрөгөөр Баянзүрх, Сүхбаатар дүүрэгт 15 блок барилга, Германы олон улсын хамтын ажиллагааны байгууллагын санхүүжилт 18 тэрбум төгрөгөөр Сонгинохайрхан, Баянгол, Баянзүрх, Налайх дүүрэгт 30 блок барилгыг дулаалах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулж байна.	100%
1.3 Дэд бүтэц												
1.3.1 Инженерийн бэлтгэл арга хэмжээ												
29	МУХТЖҮЧ-2.5.6, 9.3.3 НХТЖҮЧ - 6.2.3, 9.14.1	Үер, борооны усыг хуримтлуулах, зайлуулах талаар барилга байгууламж, авто замын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажилд мөрдүүлэх хотын стандартын төслийг боловсруулах	ХБХСГ	НТ	2023	-	Боловсруулах хотын стандарт	тоо	3	180	1. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 34 дүгээр тогтоолоор Үер борооны усны байгууламж бүлгийн дараах 3 хотын стандарт, 2025 оны 25/06 дугаар тогтоолоор 1 хотын стандарт, нийт 4 хотын стандартыг батлуулав. Үүнд: - UCS 0501A Үерээс хамгаалах, борооны ус зайлуулах байгууламжийг төлөвлөх удирдамж; - UCS 0501B:2023 Үерийн хамгаалалт, борооны ус зайлуулалтын байгууламжийн материал, эдлэлийн чанарын шаардлага; - UCS 0501C:2023 Үер, борооны ус хуримтлуулах, зайлуулах байгууламжийн зураг төслийн каталог; - UCS0502B:2025 Хөв цөөрөм үүсгэх болон хур тунадасны усыг хуримтлуулах, дахин ашиглахад тавигдах шаардлага гэх мэт стандартуудыг баталж Архитектур төлөвлөлтийн даалгаварт тусгуулж байна. 2. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/11 дүгээр тогтоолоор Авто зам, замын байгууламж бүлгийн дараах 2 хотын стандартыг баталсан. Үүнд: - UCS0401A:2025 Хотын авто зам төлөвлөх ерөнхий шаардлага; - UCS0401B:2025 Авто зам, замын байгууламжийн засвар арчлалтад тавигдах шаардлага орно. Дээрх стандартууд нь 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа бөгөөд Нийслэлийн нутгийн захиргааны байгуудад хотын стандартын хэрэгжилт хангуулан хамтран ажиллах тухай 01/301 дугаартай албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.	100%
30	МУХТЖҮЧ-2.5.6, 9.3.3 НХТЖҮЧ - 6.2.3, 9.14.1	Туул голын үерийн хамгаалалтын барилга байгууламжид хэсэгчилсэн засвар, шинэчлэлт хийх	УБЗАА, ХБХСГ,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	-	Шинэчлэх барилга байгууламжийн ажлын хэрэгжилт	хувь	100	7,500.00	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/447 дугаар захирамжаар Туул, Сэлбэ голын тохижилт, үерийн хамгаалалтын барилга байгууламж, усан сан барих төслийн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний баримт бичиг боловсруулахаар эхлэлийн тайланг хэлэлцэж байна.	85%
31		“Сэлбэ сэргэлт” төслийн Сэлбэ-Дунд голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн угсралтын I ээлжийн ажлыг үргэлжлүүлэх	УБЗАА, ХБХСГ,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	30	Шинээр барих далан, сувгийн ажлын хэрэгжилт	хувь	100	10,594.00	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/234 дугаар захирамжийн дагуу Натурын гүүрнээс төмөр замын гарам хүртэл нийт 1,4 км урт, 4-6,1 м өндөр төмөр бетон хийцтэй үерийн хамгаалалтын далангийн ажлыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгаар "Билгүүн Монгол Констракшн" ХХК гүйцэтгэж байна. Одоогийн байдлаар Сэлбэ-Дунд голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн угсралт нийт L= 1400 м угсарч гүйцэтгэсэн байна.	100%
32	МУХТЖҮЧ-2.5.6, 9.3.3 НХТЖҮЧ - 6.2.3, 9.14.1	Сэлбэ гол дагуу хэрэгжих авто замыг голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн хамт хэрэгжүүлэх	НЗХГ, ХБХСГ,ГУББГ ОНӨААТҮГ, УБХТАЗТ Төслийн нэгж	-	2023	-	Төслийн хэрэгжилт	хувь	30	-	"Сэлбэ-сэргэлт" төслийн далан, зам гүүрийн тохижилтын техник-эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд хийгдэх авто зам, гүүрийн инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулагдаж дуусан. Натурын гүүрнээс төмөр замын гарам хүртэл нийт 1,4 км урт, 4-6,1 м өндөр төмөр бетон хийцтэй үерийн хамгаалалтын далангийн ажлыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгаар “Билгүүн Монгол Констракшн” ХХК гүйцэтгэж байна. Сэлбэ-Дунд голын үерийн хамгаалалтын барилга байгууламжийн угсралт нийт L= 1400 м угсарч гүйцэтгэсэн байна.	100%
33		"Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах төсөл"-ийг эхлүүлэх	УБЗАА, ХБХСГ,НГЗБА, ГУББГ ОНӨААТҮГ, Дүүргүүд	ГЗ	2023	-	Төслийн хэрэгжилт	хувь	30	28,500.00	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/319 дүгээр захирамжаар ажлын хэсэг байгуулагдан, Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах төслийн ТЭЗҮ-ийн ажлын даалгавар боловсруулж батлуулсан. Улаанбаатар хотын үерийн эрсдлийг бууруулах, бохир усны шугам хоолойг шуудуу ухалгүйгээр доторлох шинэчлэх технологийг нэвтрүүлэх төслийн хүрээнд байгаль орчин нийгмийн нөлөөллийн үнэлгээний баримт бичиг боловсруулах ажлын даалгавар батлагдаж, Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар тендер зарлагдсан, ТЭЗҮ боловсруулах ажил Хот төлөвлөлт, судалгааны институт ОНӨААТҮГ хийгдэж байна. Тус байгууллагаас төслийн суурь мэдээллүүдийг өгч газар дээр нь хамтран ажилласан. Нийслэлийн төсвийн хөрөнгө хөрөнгө оруулалтаар Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ Хан-Уул дүүргийн 1, 3, 15, 20 дугаар хорооны 3 байршилд 8.3 км борооны ус зайлуулах шугамын өргөтгөл, шинэчлэл, 8, 21 дүгээр хорооны Жаргалантын амны үерийн байгууламжийн үргэлжлэл 438 метр далангийн ажлыг хэрэгжүүлсэн. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр төлөвлөгдсөн “Арцат, Нүхт, Морь барьдгийн ам, уяачдын хотхоны үерийн хамгаалалтын барилга байгууламж (Хан-Уул дүүргийн 4,5,6,7,8 дугаар хороо)” төсөл, арга хэмжээний хүрээнд 5 км урт үерийн далан, сувгийн ажлын гүйцэтгэгчээр “Монгол менежмент төв” ХХК шалгарсан боловч нийслэлийн төсвийн тодотголоор хасагдсан. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 2.8 км урт үерийн ус зайлуулах далан, шугамын 2 төсөл, арга хэмжээний 13, 14 дүгээр хороонд хэрэгжих төсөл гүйцэтгэгч шалгаруулах шатанд байсан бөгөөд 24 дүгээр хороонд хэрэгжих төсөл хувийн эзэмшлийн газар, барилгажилтын талбай давхардаж, дүүргийн төсвийн тодотголоор хасагдсан.	100%

34	АХ- 9.2.37, 9.3.42 МУХТЖҮЧ- 2.5.6, 9.3.3НХТЖҮЧ- 9.14.1, 9.14.2	“Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн ажлыг үргэлжлүүлэх	УБЗАА, ХБХСГ,НГЗБА, СБДЗДТГ, СХДЗДТГ,ГУББГ ОНӨААТҮГ	ГТ	2023	10	Шинээр барих далан, сувгийн ажлын хэрэгжилт	хувь	50	10,177.50	“Гэр хорооллын иргэдийн үерийг тэсвэрлэх чадавхыг бэхжүүлэх төсөл”-ийн хүрээнд хийгдэх Сонгинохайрхан дүүргийн 26, 27, 4, 5 дугаар хороо, Сүхбаатар дүүргийн 15, 16, 18, 20 дугаар хороодын нутаг дэвсгэр буюу Толгойт болон Бэлхийн голын байгын халиа, тошин, үер усанд өртдөг хэсэгт голын эргийн хамгаалалт болон үерийн хамгаалалтын байгууламж барих, моджуулах, өвлийн цагт халиа үүсэхээс сэргийлэх үерийн хамгаалалтын суваг, хөрсний усны түвшин бууруулах шугам сүлжээ, хөв цөөрөм байгуулах ажлын хэрэгжилтийг хангах зураг төсөл, барилга угсралтад шаардлагатай арга хэмжээг шуурхай зохион байгуулах ажлын хэсгийн нарийн бичгийн даргаар ажиллаж, зөвлөх шалгаруулах үнэлгээний хороо, техникийн шийдэл зөвшилцөх 2 удаагийн хурал, уулзалтад оролцож санал өгсөн. Ажлын зураг төсөл боловсруулах даалгаврыг 2023 оны Мэргэжлийн зөвлөлийн 43 дугаар хурлын шийдвэрээр боловсруулж батлуулан захиалагчид хүргүүлсэн. 2 байршилд эхний ээлжид хийх ажлын зураг төсөл зөвшилцсөн бөгөөд Сүхбаатар дүүргийн 20 дугаар хороо, Гүнжийн булаг орчмын хөв цөөрмийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгчээр "Төрөлх Мөрөн" ХХК шалгаран барилга угсралтын ажил эхэлсэн. Толгойт голын ай сав дагуу 2600 метр үерийн хамгаалалтын сувгийн ажлын зураг теслийг зөвшилцсөн. Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр хурлаар хэлэлцүүлж, тэмдэглэлийг холбогдох байгуллагуудад хүргүүлсэн.	100%
35		Арцат, Нүхт, Морь барьдгийн ам, уяачдын хотхоны үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлыг үргэлжлүүлэх	УБЗАА ,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	10	Шинээр барих далан, сувгийн ажлын хэрэгжилт	хувь	50	11,990.00	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2022 оны 05 дугаар сарын 26-ны өдөр тендер шалгаруулалтын дугаар НХААГ/202205475 болон 2025 оны 10 дугаар сарын 26 /дугаар НХААГ/20240101243/ сонгон шалгаруулалт зарлаж, "Монгол менежмент" ХХК 2024 онд шалгарсан. "Гүйцэтгэгч Монгол менежмент" ХХК нь үерийн далан барих трассад айл өрхийг нүүлгэн шилжүүлэх боломжгүй тул гэрээ цуцлах саналыг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт ирүүлсэн. Төсөв бага шалтгаанаар 2 удаагийн тендер сонгон шалгаруулалт амжилтгүй болсон.	50%
36		Чингэлтэй дүүргийн Үерийн хамгаалалтын барилга байгууламж I, II сувгийн ажлыг үргэлжлүүлэх	УБЗАА,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	50	Шинээр барих далан, сувгийн ажлын хэрэгжилт	хувь	100	1,316.90	Чингэлтэй дүүргийн Үерийн хамгаалалтын барилга байгууламж I, II сувгийн ажлын хүрээнд тус дүүргийн 23 дугаар хорооны халиа тошин үүсдэг байршилд 1025 у/м үерийн далан сувгийн ажил гүйцэтгэхээр "КТК" ХХК шалгар, гэрээ байгуулан, теслийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд 300м урт далд шугамын ажил хийгдсэн байна. Мөн дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Салхит орчмын үерийн хамгаалалтын суваг хийх ажил (19 дүгээр хороо)” төсөл арга хэмжээ (Үерийн хамгаалалтын сувгийн урт 185 метр)-г “Төрөлхмөрөн” ХХК хэрэгжүүлэн ажилласан. Ажлын гүйцэтгэл 100 хувьтай, комисс ажиллуулах хүсэлтээ хүргүүлсэн байна.	100%
37		Нисэхийн үерийн хамгаалалтын сувгийг өргөтгөн шинэчлэх	УБЗАА,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	-	Шинэчлэх далан, сувгийн ажлын хэрэгжилт	хувь	100	6,495.00	Нийслэлиийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгаар Хан-Уул дүүргийн 18, 21 дугаар хороо Жаргалантын амны 1,8 км үерийн хамгаалалтын барилга байгууламжийн барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%
38		Алтай хотхон орчмын үерийн далан суваг шинээр барих	УБЗАА, ХБХСГ, НХОГ ОНӨААТҮГ	-	2023	-	Шинээр барих далан, сувгийн ажлын хэрэгжилт	хувь	100	-	Алтай Хотхоны 14-р байрны орчмын борооны ус зайлуулах шугам угсралтын ажлын хүрээнд үзлэгийн худаг 10ш, шүүрт худаг 18ш, нийт 385.6 у/м шугам угсралтын ажил хийсэн байна. Ажлын явц 100%	100%
39		Үерийн хамгаалалтын барилга байгууламж, шугам сүлжээний засвар шинэчлэлтийн ажлыг хийх	УБЗАА,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	-	Шинэчлэх далан, сувгийн ажлын хэрэгжилт	хувь	100	5,000.00	1. Баянгол дүүргийн 16 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Баруун уулын суваг "Гэсэр сүмээс Занабазар гудамж" нурж эвдэрсэн хэсгийг сэргээн засварлах ажлыг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдрөөс 2025 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хооронд 36м босоо түшиц ханыг засварлах ажил хийгдэж талбайн бэлтгэл ажил, бараа материал буулгах, илүүдэл 799 тн хог хаягдал, лаг хагшаас цэвэрлэн, зөөж тээвэрлэх, хананы дүүргэлт нягтруулалт, арматурчлалын ажил, хэв хашмал угсрах, хуулах, 44 м3 бетон цутгалтын ажил болон авто замын 30 ш бродюр нөхөн сэргээн засварлах, 30 м урт хамгаалалтын хайс хашлага засварлах ажлуудыг тус тус хийж гүйцэтгэсэн. 2.Авто замын борооны ус зайлуулах шугам сүлжээний засвар, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд нийт 302ш шүүрт болон үзлэгийн худгийн засвар нөхөн сэргээлтийн ажил хийгдсэн.	100%
40	АХ- 9.2.37, 9.3.42МУХТЖҮЧ- 2.5.6, 9.3.3НХТЖҮЧ- 9.14.1, 9.14.2	Үерийн хамгаалалтын барилга байгууламж, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах	ХБХСГ, НБОГ,НГЗБА	НТ	2023	-	Зураг төсөл боловсруулах ажлын хэрэгжилт	хувь	100	3,000.00	Туул усан цогцолбор теслийг хэрэгжүүлэн үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлж, гадаргын 125'000 м3/хоног хүчин чадалтай эх үүсвэр барих бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлснээр Туул гол дагууд үерийн эрсдлийг бууруулах, ус хангамжийн эх үүсвэрт гадаргын ус ашиглах, усны эх үүсвэрийн нөөц нэмэгдэж, Туул голын урсац тохируулга хийгдэнэ. НЗДҮАХ-т нийт 2,245,811,6 сая төгрөгийн хөрөнгө оруулалт төсөвлөснөөс 2025 онд 48,052,3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын санал хүргүүлсэн. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Усны газын захиалгаар Энэтхэг Улсын хөрөнгө оруулалтын банкны санхүүжилтээр хийгдэж байгаа урьдчилсан ТЭЗҮ танилцуулах уулзалтад оролцсон.	30%
41		Авто замын ус зайлуулах шугам сүлжээг нэмэгдүүлэх	УБЗАА, НЗХГ,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	190	Шинээр барих шугам сүлжээ, урт	км	216.3	1,000.00	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн Эрх шилжүүлэх тухай А/108 дугаар захирамжаар нийслэлийн замын сангийн хөрөнгөөр 2025 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний ажлын жагсаалт батлагдсан. Захирамжийн дагуу 2025 оны 02 дугаар сарын 19-ний өдөр Нийслэлийн Замын хөгжлийн газар (НЗХГ), Геодези, Усны барилга байгууламжийн газар (ГУББГ) ОНӨААТҮГ-тай НЗХГ/25А/108-001 дугаартай ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 5 байршилд гэрээ байгуулагдаж дүрмээр хүлээсэн чиг үүргийн дагуу 2025 онд 6788,1у/м урттай борооны ус зайлуулах инженерийн шугам, үзлэгийн худаг 107 ш, шүүрт худаг 295 ш угсрах ажлыг ГУББГ ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн. Мөн Баянгол дүүргийн 16-р хороо төв гандантэгшилэн хийдийн борооны ус зайлуулах шугам угсралтын ажилд ф600 төмөр бетон хоолой 310у/м, ф300 хуванцар хоолой 110у/м, төмөр бетон лотки 760у/м, шүүрт худаг 35ш, үзлэгийн худаг 7ш угсарч нөхөн сэргээлтийн ажлууд хийгдээд байна.	100%
42	НХТЖҮЧ- 9.14.3	Үерийн хамгаалалтын барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээний машин, механизмыг төхөөрөмжийг нэмэгдүүлэх	УБЗАА,ГУББГ ОНӨААТҮГ	НТ	2023	50	Техник, тоног төхөөрөмж	тоо	55	1,000.00	2025 оны Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба Геодези, Усны барилга байгууламжийн газар (ГУББГ) ОНӨААТҮГ-тай 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн 25/03-58 тоот гэрээг хийж 15 машин механизмыг хүлээлгэн өгөв. Үүнд үерийн хамгаалалтын барилга, байгууламжийн ашиглалт, үйлчилгээний машин, тусгай зориулалтын механизм доргиурт индүү 3, авто ачигч 2, экскаватор 8, өөрөө буулгагч 2 гэх мэт байна.	100%
1.3.2 Ус хангамж												
43	АХ- 9.3.40 МУХТЖҮЧ- 2.5.6, 6.3.3, 9.3.3НХТЖҮЧ-	Газрын доорх усны баруун эх үүсвэрийг шинээр байгуулах бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	УБЗАА, ХБХСГ,УСУГ ОНӨААТҮГ,НГЗБА,	ГТ	2023	60	Теслийн хэрэгжилт	хувь	80	306,000.00	Мянганы сорилын сангийн хөрөнгөөр хийгдэх баруун доод эх үүсвэрийн ус дамжуулах шугам сүлжэний барилга угсралтын ажил хийгдэж байна. Цэвэршүүлэх үйлдвэрийн барилга угсралтын ажил 90 хувьтай байна. Ус гүн цэвэршүүлэх байгууламжийн угсралт 100% гүйцэтгэлтэй. Гадна тохижилт зам талбайн ажил хийгдэж байна. DN600-1000mm хос ус дамжуулах шугамын угсралт 97%-тай байна. Нийт урт 9.6 км DN300-900mm цуглуулах шугамын угсралт 100%-ийн гүйцэтгэлтэй байна.Нийт урт 22 км. Гүний 30 худгийн барилга угсралт 70%, цахилгаан хангамжийн ажил 80% байгаа бол байгууламжууд, шугам хоолойн угаалга, халдваргүйжүүлэлтийн ажил хүлээгдэж байна.	100%
44		Хаягдал усыг дахин боловсруулах үйл ажиллагааны ажлын зураг төсөл, бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх		-	2023	30	Теслийн хэрэгжилт	хувь	50	-	Хаягдал ус дахин боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл 95%-тай явагдаж байна. Тоног төхөөрөмжийн устай тестүүд хийгдэж техникийн комисс 2025 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр ажилласан. Туршилт тохируулгын ажил эхлээгүй байна.	100%

45	9.15.1,НЗД УБХЗҮАХ 2024-2028 он	Усны салбарын тогтвортой байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилтийг ханган ажиллах		-	2023	70	Төслийн хэрэгжилт	хувь	90	-	1.Мянганы сорилын сангийн санхүүжилтээр Ус сувгийн удирдах газар (УСУГ) нь Нидерландын Витенс Эвидес Интернэйшнл компанитай хамтран 2023-2025 онд "Ус ашиглалтын байгууллагуудын түншлэлийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлж дууслаа. Хөтөлбөрийн хүрээнд УСУГ-ын хүний нөөцийн чадавхийг 12 төслийн багийн үйл ажиллагаагаар дамжуулан сайжруулж, Нидерланд улсад 11 удаагийн сургалтыг зохион байгуулж УСУГ-аас 98 ажилтан хамрагдсан байна. 2. Монгол Улсын Засгийн газар болон АНУ- ын Мянганы сорилтын корпорацын II Компакт гэрээний дагуу Усны салбарын тогтвортой байдлыг хангах төслийн хүрээнд нийслэлийн 6 дүүргийн гэр хорооллын шугамд холбогдсон 180 ус түгээх байрыг бүрэн автоматжуулж, 2025 оны 9 дүгээр сард комисс ажилласан. Санхүүжилтээр автоматжуулсан 180, УСУГ-н автоматжуулсан 151, нийт 331 ухаалаг ус түгээх байр бүгд нэгдсэн удирдлага хяналтын системээр ажиллаж, хэрэглэгчдэд 24 цагийн турш үйлчилж байна.	100%
104		Нийтийн тээврийн парк шинэчлэлт хийх	НТБГ	НТ	2024	1,100	Шинээр үйлчилгээд нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл	тоо	297	89,100.00	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, “Юүтонг бус” ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/202310014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу Yutong ZK6117H загварын их багтаамжийн MNS 4598:2011 стандартын 8.1.1 “Улс хоорондын, хот хоорондын, хот орчмын үйлчилгээнд ажиллах автобус нь 1-ээс 2 хаалгатай, бүх зорчигчид сууж явахаар олон суудал, гар тээшний тавиураар тоноглогдсон, тээш хадгалах хонгил байна” дэх шаардлагыг хангасан 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Х:18 “Тэнгэр плаза-Багахангай” чиглэлд, 4 дүгээр сарын 30-ны өдрөөс Х:17 "Тэнгэр плаза-Багануур", 05 дугаар сарын 02-ны өдрөөс Х:19 “ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол”, Х:20 "ЧХНОУНБ-5 шар" чиглэлд үйлчилгээнд нэвтрүүлсэн. Skywell маркийн 15 цахилгаан автобусыг нийтийн тээврийн үйлчилгээний Ч:42, Ч:58, Ч:57 чиглэлүүдэд 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс үйлчилгээнд гаргасан. Нийслэлийн нийтийн тээврийн парк шинэчлэлтийн ажлын хүрээнд БНХАУ-д үйлдвэрлэгдсэн Yutong маркийн дизель евро-5 хөдөлгүүртэй хот орчмын 10, skywell маркийн 15, zinhui маркийн 2, нийт 27 автобусаар парк шинэчлэлт хийсэн. Хувийн хэвшлийн 6 аж ахуйн нэгж, байгууллага их багтаамжийн дизель хөдөлгүүртэй 84 автобусаар нөхөн хангалт хийсэн. 46%	85%
			НТБГ	-	2023	1,000	Өдөрт гарах тээврийн хэрэгсэл	тоо	1,301	-	2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 138 чиглэлд ажлын өдөр 1180, амралтын өдөр 1006 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Энэ нь өдөрт үйлчлэх тээврийн хэрэгслийн гаралт 2023 оны суурь түвшин 1000 тээврийн хэрэгслийн гаралттай харьцуулахад 18%-иар, 2024 оны суурь түвшинөөс 47 тээврийн хэрэгслийн гаралтаар буюу 4.1%-иар тус тус өссөн үзүүлэлттэй байна. 91%	

105		Такси үйлчилгээнд үйлчилж буй шаардлага хангасан таксины парк шинэчлэлт хийх	УБХК ХК	ТХХТ	2023	243	Шинээр үйлчилгээд нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл	тоо	2,243	100,000.00	“Улаанбаатар хотын такси үйлчилгээг сайжруулах нь” төслийг хөгжүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн А/599 тоот захирамжаар байгуулагдсан Ажлын хэсэг төслийн бүрэн шинжилгээг хийж, эх төслийг бэлтгэн, дүгнэлт гаргасан. Төсөл нь Нийслэлтйг иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн хурлаар хэлэлцүүлэн дэмжигдсэн. Төр, хувийн хэвшлийн түншлэгчийг сонгон шалгаруулах ажил хийхээр бэлтэл ажлыг ханган ажиллаж байна.	30%
106		Зорчигчийн урсгалаас хамааруулан дагуул, хаяа хотуудыг холбосон их багтаамжийн тээврийг нэвтрүүлэх	НТБГ	-	2023	15	Чиглэлийн тоо	тоо	20	-	Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах ажлын хүрээнд Нийслэлийн Засаг Даргын Тамгын Газар, “Юутонг бус” ХХК-ийн хооронд 2025 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан НЗДТГ/20231014-03 дугаартай нэмэлт гэрээний дагуу хот орчмын нийтийн тээврийн зориулалттай Yutong ZK6117H загварын их багтаамжийн 10 автобусыг 2025 оны 04 дүгээр сард 2 үе шаттай худалдан авч, Багануур болон Багахангай дүүргийн иргэдийн зорчих эрэлтийг хангах үүднээс Х:17 Тэнгэр плаза-Багануур, Х:18 Тэнгэр плаза-Багахангай чиглэлийн үйлчилгээнд нийт 3 тээврийн хэрэгсэл, Чингис хаан олон улсын нисэх буудал руу Х:19 “ЧХОУНБ-Сүхбаатарын талбайн төв зогсоол”, Х:20 "ЧХНОУНБ-5 шар", ШҮ:4 "Сүхбаатарын талбай-Чингис хаан ОУНБ" гэсэн 3 чиглэлд нийт 7 тээврийн хэрэгслийг үйлчилгээнд нэвтрүүлсэн.	60%
107		Гэр хороллын 5 чиглэлд дунд оврын автобусны үйлчилгээг нэвтрүүлэх	НТБГ	-	2023	-	Чиглэлийн тоо	тоо	5	-	Нийтийн тээврийн үйлчилгээг хүргэх, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор шинээр баригдсан гэр хороллын дундах авто замын нөхцөл байдлыг судалж холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Судалгаагаар Сонгинохайрхан дүүргийн 14, 21, 31, 43-р хороо Баянгол дүүргийн 10, 22-р хороо, Баянзүрх дүүргийн 17,18,19,27-р хорооны 11 байршилд дунд оврын тээврийн хэрэгслээр үйлчилгээг хүргэх боломжтой дүгнэлт гарч холбогдох төлөвлөлтийг боловсруулсан. Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хорооны иргэдийн нийтийн тээврээр зорчих эрэлтийг хангах зорилгоор судалгаг хийж, чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан Нийтийн Тээврийн бодлогын газрын даргын 2025 оны А/27 дугаар тушаалаар Д:4 "Хайрханы шинэ эцэс-Алтай-Цамбагарав-176-р цэцэрлэг" чиглэлийн замналд өөрчлөлт оруулан 2025 оны 03 дугаар сарын 08-ны өдрөөс дунд багтаамжийн 1 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн. Мөн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор Баянзүрх дүүргийн 10, 24, 35 дугаар хорооны нутаг дэвсгэрт нийтийн тээврийн үйлчилгээ хүрээгүй суурьшлын бүсийн авто замын нөхцөл байдал, зорчих эрэлтийн судалгаг хийж, чиглэлийн төлөвлөлтийг боловсруулан Нийтийн Тээврийн бодлогын газрын даргын 2025 оны А/106 дугаар тушаалаар Д:1 "Шархад-Хангамж-Ботаник", Д:11 "Офицеруудын ордон-Цахлай-Баянзүрх дүүргийн 24-р хороо", Д:12 "Баянзүрх дүүргийн 35 дугаар хороо-Улиастайн шинэ эцэс", Д:13 "Улиастайн шинэ эцэс-Шархадны эцэс" чиглэлүүдийн замналыг баталж, 2025 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс дунд багтаамжийн 7 тээврийн хэрэгслээр үйлчилгээг эхлүүлсэн.	100%
108	(МУХТ-2025 -7.1.2) НХТЖҮЧ-9.21.3	Нийтийн тээврийн санхүүжилтийн тогтолцоог оновчтой болгож, салбарыг бие даасан болгох	НТБГ	-	2023	139	Нэмэгдүүлэх зорчигч	тоо, сая/жилд	173	-	Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч байгууллагуудын зардлын санхүүжилтийг “Үр дүнд суурилсан үнэлгээ” /KPI/ тогтолцоонд шилжүүлэх цогц арга хэмжээ авах тооцоо судалгаа хийж, санал боловсруулж, танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/344 дүгээр захирамжаар Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалайгаар ахлуулан байгуулсан, Ажлын хэсэг 2025 оны 03 дугаар сарын 15, 04 дүгээр сарын 15, 08 дугаар сарын 19-ний өдрүүдэд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэгч аж ахуй нэгж байгууллагын төлөөлөл, салбарын холбоодын төлөөлөлтэй уулзаж "Үр дүнд суурилсан үнэлгээ"-ний талаар мэдээлэл өгч, санал солилцсон. "Үр дүнд суурилсан үнэлгээ" (KPI) тогтолцоонд шилжүүлэх системийн нэмэлт хөгжүүлэлтийг Улаанбаатар смарт карт ХХК, Ай Си Ти групп ХК-ийн системүүдэд хийгдэж эхлээд байна. ??	30%
109		Нийтийн тээврийн чиглэл, тээврийн хэрэгслийн хуваарилалтыг оновчтой болгох	НТБГ	-	2023	15	Хүлээлтийн хугацааны бууралт	минут	13	-	Нийтийн тээврийн үйлчилгээнд нийт 138 чиглэлд 1180 тээврийн хэрэгсэл өдөр тутам үйлчилгээ үзүүлж байна. Үндсэн чиглэлүүдийн үйлчилгээний дундаж хүлээгдлийн хугацаа 10.1 минут байгаа нь 2023 оны суурь түвшинтэй харьцуулахад 33%-иар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд зорчих эрэлт, зорчигч урсгалын тооцоо судалгаанд үндэслэн нийт 14 чиглэл шинээр нээж, 16 чиглэлд өөрчлөлт оруулсан байна. Үүнээс богино эргэлтийн 14 чиглэл байна. Цагдаагийн Ерөнхий газрын Тээврийн цагдаагийн албаны дарга, Нийтийн тээврийн бодлогын газрын дарга, “Замын хөдөлгөөний удирдлагын төв” ОНӨТҮГ-ын захирал нарын хамтарсан 2025 оны А/72, А/78, А/34 дугаар тушаалаар чиглэлийн тээврийн хэрэгслийн эгнээ, зогсоолыг чөлөөлөх, замын хөдөлгөөний түгжрэл, ачааллыг бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг бүхий шуурхай ажиллагааны баг байгуулагдаж 2025 оны 08 дугаар сарын 18-аас 09 дүгээр сарын 19-ний өдрийг дуусталх хугацаанд Нийтийн тээврийн бодлогын газрын 51 албан хаагч ажилласан. Дээрх ажлын хүрээнд хамтарсан багийн гишүүд бодит цагийн байдлаар замын хөдөлгөөний нөхцөл байдалд телекамераар хяналт тавьж замын хөдөлгөөний ачаалал, түгжрэлийг зохицуулан, нийтийн тээврийн хэрэгслийг авто замын нэгдүгээр эгнээгээр чөлөөтэй нэвтрүүлэх зохицуулалтыг тухай бүр хийснээр Энхтайваны өргөн чөлөө дагуух нийтийн тээврийн хэрэгслийн ашиглалтын дундаж хурд 10.6 км/цаг байсан нь 12.9 км/цаг болж 18%-иар өссөн эерэг үр дүн гарсан.	100%
110		Нийтийн тээврийн хэрэгслээр тэргэнцэртэй иргэн зорчих нөхцөлийг бүрдүүлэх	НТБГ	-	2024	996	Тавцан төхөөрөмжтэй тээврийн хэрэгсэл	тоо	297	-	2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн тээврийн бүртгэлийн санд 1311 тээврийн хэрэгсэл байгаагаас 76.9% буюу 1009 автобус нь тэргэнцэртэй иргэдэд зориулагдсан нам шалтай, тусгай зориулалтын зорчигчийн хэсэг, бэхэлгээ хийгдсэн, дуут зарлан мэдээлэгч, лед дэлгэц, хяналтын камер зэрэг хөгжлийн бэрхшээлтэй иргэний зорчих нөхцөлийг хангасан тусгай тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тээврийн хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байна. Тоноглогдсон тээврийн хэрэгслийг төрлөөр нь авч үзвэл Skywell - 96, Golden dragon - 282, Yutong - 631 байна. Үүнээс Yutong - 631 автобус нь харааны бэрхшээлтэй иргэдэд дуут зарлан мэдээлэгч тоног төхөөрөмжөөр тоноглогдсон.	78%
111		Багануур дүүрэгт нийтийн тээврийн автобусны гарааш барих	НТБГ, БНДЗДТГ	НТ	2023	-	Барилгын ажлын явц	хувь	100	3,500.00	Орон нутгийн төсвийн 3,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Багануур дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах Нийтийн тээврийн гараашны барилгын зураг төслийг 2022 онд “Эрхэс констракшн” ХХК гүйцэтгэж, Нийслэлийн Ерөнхий архитектураар батлуулсан. Багануур дүүргийн “Тээвэр зохицуулалтын алба” ААТҮГ-ын Нийтийн тээврийн гараашны барилга барих ажлыг 2025 онд эхлүүлэхээр 1 тэрбум төгрөгийг төсөвлөж, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр НХААГ/20250101027 дугаартай нээлттэй тендер шалгаруулалтыг зарлаж, 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр гүйцэтгэгчээр “Наран босголт” ХХК шалгарсан. Ажлын явц 35 хувийн гүйцэтгэлттэй байна. Үүнд: - Төмөр бетон карказ угсралтын ажил дууссан. - Дээвэр хийх ажил дууссан. - Төмөр багана, дам нуруу, холбоос угсрах ажлууд дууссан.	85%
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО												
Салбарын үр дүн: Хүний хөгжлийн үзүүлэлтийг нэмэгдүүлнэ.												
2.1 Нийгмийн эрүүл мэнд												
			НЭМГ	-	2023	1	Салбар дундын уулзалт, зөвлөгөөн	тоо	4	-	1.“Хариуцлагатай сонголт” аяны удирдамжийн хүрээнд өсвөр насны хүүхдийн бэлгийн эрүүл мэндийн асуудал, охидын жирэмслэлт, төрөлт, БЗХӨ түүнээс урьдчилан сэрийлэх, хамтын ажиллагааг эрчижүүлэх чиглэлээр нийслэлийн 3 дүүргийн боловсрол, нийгэм, эрүүл мэндийн салбарын 39 хувийн хэвшлийн төлөөлөлд 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг нийт 168 хүнийг хамруулан зохион байгуулсан. 2.Хүний папиллома вирусийн халдвар, түүний хор уршиг, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, өсвөр насны хүүхдүүдийг дархлаажуулах зорилгоор нийслэлийн боловсрол, эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг хамруулан 26 удаагийн уулзалт зохион байгуулж, 3,443 иргэнийг хамруулсан. 3. Амьсгалын замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх хүрээнд "Маскаа зүүцгээе" аян өрнүүлж, нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллага, өрхийн эрүүл мэндийн төвүүд боловсролын байгууллагуудад амьсгалын замын халдварт өвчнөөс сэргийлэх тухай нийт 111 удаагийн сургалт зохион байгуулж, 14,339 сурагч, багш ажилчдыг хамруулсан. 4.Угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх чиглэлээр цэцэрлэгийн багш, сурагчдад нийт 12 удаагийн сургалт зохион байгуулж 4283 багш, сурагчдад орсон. Нийтдээ 149 удаагийн сургалт зохион байгуулсан байна. 100%	

112	НХТЖҮТ-2.9.1 МУХТЖТ-2.2.2	Хүүхэд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсролыг олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж, салбар хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх	НЭМГ	НТ	2023	1	Эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх нөлөөллийн уулзалт	тоо	6	12	Хүүхэд өсвөр үеийнхэнд эрүүл мэндийн боловсролыг олгох, эрүүл зан үйлийг төлөвшүүлэх нөлөөллийн нийт 3968 удаагийн арга хэмжээнг зохион байгуулсан байна. Тухайлбал томоохон арга хэмжээнүүдээс: 1.Ерөнхий боловсролы сургуулийн ахлах ангийн сурагчдад “Электрон тамхины хор хөнөөлийн талаар” 44 удаагийн сургалтыг 4500 гаруй хүүхдийг, 2.Урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаж буй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдад “Шүд угаах арга техник, шүдээ арчлах, шүдэнд ээлтэй хоол хүнс” сэдвээр эмчлэгч эмч, мэргэжилтэн 936 удаагийн сургалтыг, 3.Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад "Угаарын хийн хордлогоос сэргийлье" сэдэвт нийт 12 удаагийн сургалт зохион байгуулж 4283 багш, сурагчдад орсон байна. 4.Нийслэлийн нийгмийн хэв журам сахиулах чиг үүргийн байгууллагууд хамтран ерөнхий боловсролын сургуулиудад “Хорт бодисын хэрэглээ, дэлгэцийн хэрэглээ, вейп ба тамхи, донтолт, эрүүл зохистой хооллолт, хөдөлгөөний дутагдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, бэлгийн эрүүл ахуй, аюултай бэлгийн харилцаа, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь, бэлгийн замын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх нь, электрон тамхины хор уршиг” сэдвүүдээр сургалт хийж, нийт 108 ерөнхий боловсролын сургуулийн 10-18 насны 41193 сурагч, 1569 эцэг, эх асран хамгаалагч нарт 972 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, зөвлөгөө өгсөн. 5. Хүний папиллома вирусийн халдвар, түүний хор уршиг, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, өсвөр насны хүүхдүүдийг дархлаажуулах зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарын албан хаагчдыг хамруулан 34 удаагийн уулзалт зохион байгуулж, 4066 хүнийг хамруулсан. 100%	100%
			НЭМГ	НТ	2023	5	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дэмжих сургалт	тоо	50	40	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дэмжих нийт 108+42 удаагийн танхимын сургалтыг 41,193 сурагч болон 1,569 эцэг эх, асран хамгаалагч, 14000 оюутаныг хамруулан ажилласан байна. Тодруулбал: “Өсвөр үеийнхнийг сонсъё, ойлгоё” сарын ажлын хүрээнд 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 2 нэгдсэн эмнэлэг, тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүд харьяалах нутаг дэвсгэр дэх цагдаагийн газар, засаг даргын тамгын газар, боловсролын хэлтэстэй хамтран хорт бодисын хэрэглээ, дэлгэцийн хэрэглээ, вейп ба тамхи, архи, тамхины донтолт, эрүүл зохистой хооллолт /таргалалт, шим тэжээлийн хомсдол/, хөдөлгөөний дутагдал, нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх нь, БЗХӨ-нөөс урьдчилан сэргийлэх нь, электрон тамхины хор уршиг сэдвүүдээр ерөнхий боловсролын сургуульд 108 удаагийн танхимын сургалт зохион байгуулж, 10-18 насны 41,193 сурагч болон 1,569 эцэг, эх асран хамгаалагч нарыг хамруулсан. 100%	
			НЭМГ	НТ	2023	50,000	Амны хөндийн эрүүл мэндийн сургалтад хамрагдсан сургуулийн өмнөх боловсролын байгууллагад суралцагсдын эцэг, эх, асран хамгаалагчид	тоо	65,000	50	Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж буй 40,753 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 33,310 хүүхдийг хамруулсан. Үзлэгт хамрагдсан хүүхдүүдээс 12,447 хүүхдийн шүдийг эмчлэн эрүүлжүүлээд байна. Урьдчилан сэргийлэх үзлэг болон эмчилгээнд хүүхдээ авчирсан бүх эцэг эх, асран хамгаалагч нарт шүд угаах арга техник, шүдээ арчлах, шүдэнд ээлтэй хоол хүнс сэдвээр эмчлэгч эмч, урьдчилан сэргийлэх үзлэг хийж, сургалт зохион байгуулсан. Дээрх ажлын хэрэг жилтийг 2025 оны 07 дугаар сараас тодорхойгүй хугацаагаар зогсоосон. 100%	
113		Зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд гэр бүл төлөвлөлтийн талаар мэдлэг, мэдээлэл олгох ажлыг эрчимжүүлж, жирэмслэхээс сэргийлэх арга хэмжээг нэмэгдүүлэх	НЭМГ	НТ	2023	62	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүд	хүн	64	30	Жирэмслэхээс сэргийлэх арга хэрэгсэлд хамрагдсан зорилтот бүлгийн эмэгтэйчүүд 41,987 буюу 67.4%-тай байна. Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/11 дүгээр тушаалын дагуу нийслэлийн харьяа 9 дүүргийн эрүүл мэндийн төвд дүүргийн хэмжээнд нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгааг сайжруулах чиглэл өгч шинэчлэн, нийт нөхөн үржихүйн насны 422,442 эмэгтэйчүүд, үүнээс 62,268 зорилтот бүлгийн эмэгтэйчүүд байна. 2025 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар 41,987 зорилтот бүлгийн эмэгтэйд зөвлөгөө мэдээллээр хангаж, жирэмснээс сэргийлэх арга хэрэгслийн хамрагдалт 67,4% байна. Бэлгийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, өсвөр насны охидын жирэмслэлт, хүсэзгүй жирэмслэлт, үр хөндөлтөөс сэргийлэх зорилгоор Нийслэлийн Засаг даргын 2025 оны “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх тухай” А/770 дүгээр захирамжийг батлуулж, нийт 42 удаагийн сургалт зохион байгуулсан. 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нөхөн үржихүйн эрүүл мэндийн боловсрол, мэдлэг, хандлагыг дээшлүүлэх 30 удаагийн сургалтад нийт 14 их, дээд сургуулийн 14080 оюутанг, Налайх, Чингэлтэй, Хан-Уул, Баянзүрх, Баянгол, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн тамгын газруудтай хамтарч, нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахад хэрхэн ажиллах, түүний ач холбогдол сэдвээр мэдлэг хандлага дээшлүүлэх 12 удаагийн сургалтад хороодын хэсгийн ахлагч, нийгмийн ажилтан нийт 1369 албан хаагчдыг хамруулсан.	100%
114	ТЖҮЧ-2.7, 2.	Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй албан хаагчдыг чиглэлийн давтан сургалтыг нэмэгдүүлэх	НЭМГ	УТ	2024	30	Давтан сургалтад хамрагдсан албан хаагчид	тоо	50	100	Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагуудын хүний нөөцийн судалгааг гарган 2025 онд төрийн сангийн санхүүжилтээр төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтад 12 эмч, сувилагч тусгай мэргэжилтэн, дархлаажуулалтын 1 сарын сургалтад 29 сувилагч хамрагдаж төгссөн ба 2025-2026 оны хичээлийн жилд 30 эмч, 34 сувилагч, тусгай мэргэжилтэн суралцаж байна. Мөн байгууллагын зардлаар “Өсвөр үеийн эмч” бэлтгэх мэргэшүүлэх жилийн сургалтад 1 эмч хамрагдсан. Харьяа эрүүл мэндийн байгууллагын нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй 104 албан хаагчийг чиглэлийн давтан сургалтуудад хамруулсан. Тухайлбал: 1.Нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтнүүдийн нийгэмлэгээс зохион байгуулсан “Нийгмийн эрүүл мэндийн үндэс” сургалтад харьяа эрүүл мэндийн байгууллагын 32 албан хаагчийг, 2.НЭМҮТ, НҮБ-ийн хүүхдийн сангаас "Эхийн хоол тэжээлийн тусламж үйлчилгээг сайжруулах " чиглэлээр сургагч багш бэлтгэх сургалтад НЭМГ-ийн хүнсний аюулгүй байдал, хоол тэжээл, амны хөндийн асуудал хариуцсан мэргэжилтэн болон 6 дүүргийн эрүүл мэндийн төвийн 23 албан хаагч, нөхөн үржихүйн зохицуулагч нарыг, 3.Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн ”Өсвөр үеийнхэнд ээлтэй тусламж үзүүлэх анхан шатны эмч, мэргэжилтнүүдийг чадавхжуулах” сэдэвт сургалтад 3 дүүргийн эрүүл мэндийн төвийн өсвөр үеийн тусламж үйлчилгээний зохицуулагч эмч, 46 өрхийн эрүүл мэндийн төвийн нийт 49 албан хаагч нарыг тус тус хамруулсан. Глобал сангийн дэмжлэгээр 2025-2026 онд эрүүл мэндийн байгууллагуудын удирдлага, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн болон эмч, мэргэжилтнийг чадавхжуулах “Удирдах ажилтны 21 хоногийн сургалт”-д 27, “Анхан шатны эмнэлэгт ажиллаж буй нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтний мэргэжил дээшлүүлэх 3 сарын сургалт”-д дүүргийн эрүүл мэндийн төвийн 37, өрхийн эрүүл мэндийн 54 эмч, мэргэжилтний сургахаар нэрсийг гарган ЭМХТ-д хүргүүлэн бэлтгэл ажлыг хангасан.	100%
115		Нийслэлийн нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	НЭМГ	-	2023	-	Салбар зөвлөлийн хурал	тоо	2	-	Эрүүл мэндийн Үндэсний зөвлөлийн 2018 оны “Нийслэлийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг батлах” тухай 01 дүгээр тогтоолоор Нийслэлийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийг байгуулсан. Тус тогтоолын дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны “Ажлын алба байгуулах тухай” А/162 дугаар тушаалаар Нийслэлийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн ажлын албыг байгуулсан. Нийслэлийн Нийгмийн эрүүл мэндийн салбар зөвлөлийн хурлыг 2025 оны III улиралд хийхээр төлөвлөсөн боловч Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Зарим үндэсний хороо, зөвлөлийг татан буулгах тухай” 22 дугаар тогтоолоор Үндэсний зөвлөлийг татан буулгасан. Тус тогтоолын дагуу Нийгмийн эрүүл мэндийн нийслэлийн зөвлөл хуралдах эрх зүйн үндэсгүй болсон тул зөвлөлийг хуралдуулаагүй болно.	100%

116		Иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтыг зохион байгуулах	НЭМГ	УТ	2024	25	Зохион байгуулах сургалт	тоо	250	25	Тайлант хугацаанд зонхилон тохиолдох халдварт бус өвчний шалтгаан, эрсдэлт зан үйлийг бууруулах чиглэлээр дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Үүнд: 1. 8 удаагийн нөлөөллийн уулзалт 2. 6 удаагийн арга хэмжээ 3. 4 удаагийн уулзалт хэлэлцүүлгийг зохион байгуулан ажилласан байна. Хорт хавдраас урьдчилан сэргийлэх өдөр, Дэлхийн эрүүл мэндийн өдөр, Цусны даралт ихсэлттэй тэмцэх дэлхийн өдөр, Тамхигүй өдөр, Донорын өдөр, Альцхеймэрийн өдөр, Зүрх судасны өвчний өдөр, Сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих өдөр, Дэлхийн хараа алдалтаас сэргийлэх өдөр, Чихрийн шижингийн өдөр, Давсны хэрэглээг бууруулах өдөр, Автомашингүй өдөр зэргийг тэмдэглэн постер сурталчилгааны материалыг НЭМГ-ын вэб сайт, олон нийтийн сүлжээнд оруулж иргэдэд сурталчилсан. Дүүргийн эрүүл мэндийн төвүүдээс алслагдсан бүсэд амьдардаг болон хөгжлийн бэрхшээлтэй, эрүүл мэндийн зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр 6 удаагийн арга хэмжээгээр 7,518 иргэнд эрүүл мэндийн боловсрол олгож ажилласан. Өсвөр насны хүүхдийн бэлгийн эрүүл мэндийн асуудал, охидын жирэмслэлт, төрөлт, БЗХӨ түүнээс урьдчилан сэргийлэх, хамтын ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах ажлыг хийж хэрэгжүүлсэн. Боловсрол, нийгэм, эрүүл мэндийн салбарын төлөөлөл нийт 168 хүнийг 4 удаагийн уулзалт, хэлэлцүүлэгт хамруулсан. Хүний папиллома вирусийн халдвар, түүний хор уршиг, умайн хүзүүний хорт хавдраас урьдчилан сэргийлэх, өвчлөлийг бууруулах, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх зорилгоор зорилтот бүлгийн өсвөр насны хүүхдүүдийг дархлаажуулах ажлын хүрээнд 8 удаагийн нөлөөллийн уулзалтыг дүүргүүдэд зохион байгуулан 3443 хүнийг хамруулан зохион байгуулсан.	100%
			НЭМГ	УТ	2023	250	Хамрагдсан иргэд, аж ахуйн нэгж	тоо	2500	25	Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх сургалтад 306 аж ахуйн нэгж, байгууллагын 7,518 ажилтан 1,070 удаагийн сургалтад 70,000 гаруй иргэнийг хамруулсан байна.	
117	МУХЖТ-1.3.1, 2.2.1	Нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй худалдаа, нийтийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийх, холбогдох хууль, тогтоомж, тушаал шийдвэр, стандартын хэрэгжилтийг хангуулах	НЭМГ	УТ	2023	224	Төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	тоо	850	10	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан “Хяналт шалгалт хийх тухай” 10-00/05, 10-00/09, 10/00/14, 10-00/10 дугаартай удирдамжийн дагуу нийт 862 эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагад хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна. Шалгалтын явцад нийт 875 зөрчил дутагдал илрүүлснээс 495 (56.5%) зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулж, бусад зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 1145 заалт бүхий 175 улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага, 2 эмнэлэгт улсын байцаагчийн зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавин ажиллаж байна. Илэрсэн зөрчилд холбогдуулан 23 эмнэлэгт 33,000 сая төгрөгийн шийтгэл оногдуулж, 8190 төгрөгийн нөхөн төлбөр тогтоож, 100% барагдуулж ажилласан байна. 100%	100%
			НЭМГ	УТ	2023	815	Худалдаа, нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний газар	тоо	865	10	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан “Хяналт шалгалт хийх тухай” 10-00/13, 10-00/06, 10-00/03, 10-00/06, 08-00-02-02, 03-00/02 дугаартай удирдамжуудын дагуу худалдаа, нийтийн хоол, үйлдвэрлэл үйлчилгээний 2,489 объектод хяналт шалгалт хийж шалгалтын явцад нийт 1,905 зөрчил дутагдал илрүүлснээс 1447 (76%) арилгуулсан. Бусад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах зорилгоор 129 улсын (ахлах) байцаагчийн албан шаардлага, 539 зөвлөмж хүргүүлэн хэрэгжилтэд хяналт тавьж, 26 иргэн, хуулийн этгээдэд 35,000 сая төгрөгийн шийтгэл оногдуулан барагдуулж ажилласан байна.100%	
			НЭМГ	УТ	2023	167	Ахуйн болон төв цэвэрлэх байгууламж, ус түгээх байр	тоо	175	100	Эрүүл мэндийн яамны Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын баталсан 10-00/12 дугаартай удирдамжийн дагуу төвлөрсөн ба төвлөрсөн бус ус хангамжтай 219 байгууллага, ААН-ээс 467 ундны усны дээж авч шинжлүүлсэн. Сорилтын дүнгээр 58 дээж буюу 12.4% нь “Ундны ус” MNS 0900:2018 стандартын шаардлага хангахгүй гарсан байна. Дээрх стандартын шаардлага хангаагүй, 65 объектын шугам сүлжээ, нөөцийн савыг угаан халдваргүйжүүлж, давтан шинжилгээнд хамруулан, стандартын шаардлагад нийцүүлэн, шинжилгээний дүнг үндэслэн, улсын (ахлах) байцаагчийн 134 дүгнэлт гаргаж, холбогдох хуулийн этгээд, иргэнд хүргүүлээ. Давтан шинжилгээгээр ундны ус нь стандартын шаардлагад нийцээгүй 1 аж ахуйн нэгжид Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэлийн арга хэмжээ авч, албан даалгавраар хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна. ЭМЯ-ны СХШҮДАГ-ын даргын баталсан 10-00/07 дугаартай удирдамжийн дагуу УСУГ-ын харъяа Төв, Нисэх, Биокомбинат, Харгиа, Чингэлтэй, Дамбадаржаа, Чандмань налайх ОНӨААТҮГ, Жуулчин тэрэлж ресорт амралтын газрын цэвэрлэх байгууламжийн оролт, гаралтын цэгээс бохир усны 26 сорьцыг авч, химийн судлалын 4 үзүүлэлт, нян судлалын 3 үзүүлэлтээр Стандарт, хэмжилзүйн газрын Нийслэлийн лабораторид шинжлүүлсэн. Цэвэрлэх байгууламжаас гарч буй бохир усны дээжийг Ерөнхий шаардлага MNS 4943:2015, Ариутгах татуургын сүлжээнд нийлүүлэх хаягдал усны MNS 6561:2023 стандартад нийцэж буй эсэхэд үнэлэлт өгсөн. Шинжилгээ сорилын дүнгээр 22 буюу 84.6% нь стандартын шаардлагад нийцэж, 4 буюу 15.4% шаардлага хангаагүй байна. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжид бохир ус нийлүүлдэг арьс шир, ноос ноолуур, хүнсний үйлдвэрүүдийн хаягдал, бохир усанд агуулагдах бодисын найрлагын хэмжээ, технологийн горимд ЭМЯ, ХХААХҮЯ, ХББОСЯ, УСУГ, БОЯ-ны холбогдох мэргэжилтэн, улсын байцаагч нарын хамт 71 үйлдвэрт лабораторийн шинжилгээтэй хяналт хийсэн. Үйлдвэр үйлчилгээ, ААН, байгууллагын бохир усны гаргалгаа шугамд бохирдол бууруулах тоног төхөөрөмжийн суурилуулалт, үйлдвэрүүдийн урьдчилан цэвэрлэх байгууламж угсрах, суурилуулах ажлын явцад хяналт тавьж, 12 газарт албан шаардлагаар хугацаатай үүрэг өгч, биелэлтэд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. 100%	
118		Зонхилон тохиолдох амьсгалын замын, гэдэсний бактерит болон зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, боловсрол олгох үйл ажиллагаа явуулах	НЭМГ	УТ	2023	2	Зохион байгуулах арга хэмжээ	тоо	38	100	Зонхилон тохиолдох амьсгалын зам, гэдэсний бактерит, зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх боловсрол олгох үйл ажиллагааг зохион байгуулахаар “НЭМГ-ын НЭАХӨХ-ийн 2025 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”, ”Зонхилон тохиолдох гэдэсний халдвар, хоол хүнс, ундны усаар дамжих өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний төлөвлөгөө”, “Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээ авах” талаар харьяа эмч, ажилчдад зайны сургалт зохион байгуулах удирдамж зэрэг тусгайлсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 18 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллалаа. Тухайлбал: - Зонхилон тохиолдох гэдэсний халдвар, хоол хүнс, ундны усаар дамжих өвчнөөс сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээний хүрээнд Нийслэлийн дүүргүүдэд 2 аян, 1 өдөрлөг зохион байгуулсан, - Тархвар судлалын заалтаар балнад өвчнөөс сэргийлэх, тарилгад хамрагдах шаардлагатай нийслэлийн эрсдэлтэй ажил, мэргэжлийн 438 иргэний судалгааг гаргасан. - Зоонозын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлтгэл бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авах талаар “Галзуу өвчний хяналт, сэргийлэлт”, “Хачгаар дамжин халдварладаг өвчнүүдийн хяналт, сэргийлэлт” сэдэвт 2 чиглэлийн зайны сургалтыг тус тус зохион байгуулж нийт 160 эмч мэргэжилтнүүдийг хамруулсан, - “Сүрьеэтэй тэмцэх дэлхийн өдөр”-ийг тэмдэглэх үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу 13 төрлийн үйл ажиллагааг тус тус зохион байгуулсан. - Иргэдэд зонхилон тохиолдох халдварт өвчин ялангуяа “Зонхилон тохиолдох гэдэсний халдвар, хоол хүнс, ундны усаар дамжих өвчин”-өөс сэргийлэх талаарх эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх чиглэлээр Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагууд нь 181 удаагийн мэдээлэл, сургалт сурталчилгааг, зохион байгуулахад 37525 иргэн, 151 байгууллага, аж ахуйн нэгж хамрагдсан.	100%
119	МУХТЖҮЧ-2.2.1	Сүрьеэ, өвчний илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулах	НЭМГ	УТ	2023	7.9	10000 хүн амд ноогдох илрүүлэлт	промиль	21.4	50	Нийслэлийн хэмжээнд 10,000 хүн амд сүрьеэ өвчний тохиолдол 6.2 байна. Нийслэлийн 9 дүүргийн сүрьеэгийн кабинетад нийт 79,946 үзлэг хийснээс, урьдчилан сэргийлэх үзлэг 47,968 буюу 60.2%-тай байна. Сүрьеэгийн 1,022 шинэ тохиолдол бүртгэгдсэн ба 10,000 хүн амд 6.2 байгаа нь өмнөх онтой харьцуулахад 56 тохиолдлоор (0.5 промиль) буурсан байна. Нийт тохиолдлын 99%-ийг эмчилгээнд хамруулж, эмчилгээний амжилт 79.9%-тай байна. 0%	85%
			НЭМГ	УТ	2023	79	Шинээр илэрсэн халдварын эмчилгээний амжилт	хувь	84	100	Нийт 1022 шинэ тохиолдлоос эмчилгээнд хамрагдсан 1009 хүн буюу хамрагдалт 99%-тай байна. Тайлант хугацаанд 557 хүн эмчилгээ дуусгаж, эдгэрэн хяналтаас гарсан ба сүрьеэгийн халдварын тохиолдлын эмчилгээний амжилт 79.9% байна. 18%	

120	НХТЖҮЧ-2.6	БЗДХ-ийн илрүүлэлтийг нэмэгдүүлж, өвчлөлийг бууруулах	НЭМГ	УТ	2023	38.6	10000 хүн амд ноогдох илрүүлэлт	промиль	33.6	50	Нийслэлийн хэмжээнд 10,000 хүн амд БЗДХ өвчний тохиолдол 30.6 промиль байна. Нийслэлийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын байдлаар халдварт өвчний 32,191 тохиолдол бүртгэгдэж, 10,000 хүн амд 194 байна. Зонхилон тохиолдох БЗДХ-ын 5,074 тохиолдол бүртгэгдсэн нь нийт халдварт өвчний 15.76%-ийг эзэлж байна. Үүнээс, 27.3% заг хүйтэн, 46% тэмбүү, 26% трихомониаз, 0.67 ХДХВ/ДОХ байна. Төрөлхийн тэмбүүгийн тохиолдол 2025 онд 12 бүртгэгдсэн байна. БЗДХӨ-ний эмчилгээнд нийт 4,811 хүн хамруулж, эмчилгээний амжилт 94.8%-тай байна. 100%	100%
			НЭМГ	УТ	2023	38.6	Эмчилгээнд хамрагдалтын түвшин	хувь	43.6	100	Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар шинээр илэрсэн бэлгийн замаар дамжих халдварын тохиолдлыг 99 хувь эмчилгээнд хамруулсан ба нийт 4,811 хүн хамруулж, эмчилгээний амжилт 94.8%-тай байна. 100%	
121		Товлолт дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх замаар тарилгаар сэргийлэгдэх халдварт өвчний тохиолдлыг бууруулах	НЭМГ	УТ	2023	95	Товлолт дархлаажуулал-тын хамрагдалт	хувь	96	100	2025 оны эхний 10 сарын байдлаар товлолт вакцины 17 тунгийн дархлаажуулалтад давхардсан тоогоор 394,849 хүүхэд хамрагдах хамралтын дундаж 97.5% байна. Үүнд: 1.БЦЖ (1 тун) – 99.5%, 2.Гепатит В (1 тун) – 99.3%, 3.Саа (4 тун) – 95,0%, 4.Тавт (3 тун) – 95.5%, 5.УГУ (2 тун) – 97,3%, 6.Гепатит А (2 тун) – 95.3%, 7.Пневмококк (3 тун) – 95.5%, 8.Сахуу-татран (2 тун) – 73,3% байна. 2025 оны эхний 10 сарын байдлаар Хүний папиллома вирус (1тун) дархлаажуулалтын хамрагдалт - 47.8%-д хүрсэн.	100%
122		Тархвар судлалын зааптаар хийгддэг өвчний эсрэг дархлаажуулалтыг нэмэгдүүлэх замаар халдварт өвчний тохиолдлыг бууруулах	НЭМГ	УТ	2023	95	Товлолт бус дархлаажуулал-тын хамрагдалт	хувь	96	100	Монгол улсад менингитийн халдвар 2025 оны 1 дүгээр сард 1 бүртгэгдсэнтэй холбоотой Эрүүл мэндийн сайдын 2025 оны “Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, ялган оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 дугаар албан даалгаврын хүрээнд “Менингококкт халдварын бэлэн байдал, эмчилгээ, ялган оношилгоо, хариу арга хэмжээг эрчимжүүлэх төлөвлөгөө - 2025”-г гарган харьяа 27 байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Батлагдсан нэг тохиолдлын голомтын дархлаажуулалтад тархвар судлалын зааптаар 8 хүнийг 100 хувь хамруулсан. Монгол Улсад Улаанбурхан өвчний тохиолдол 2025 оны 2 дугаар сараас эхлэн бүртгэгдсэнтэй холбогдуулан Улаанбурхан өвчний голомтын дархлаажуулалтад 49,012 хүнийг хамруулахаас 46,829 хүн хамрагдаж, 95.5%-ийн хамрагдалттай байна. Улаанбурханы нэмэлт дархлаажуулалтад 4,546 эмч эмнэлгийн мэргэжилтнээс 4,031 ажилтан буюу 88.6%-ийн хамрагдалтай байна.	100%
123	НХТЖҮЧ-2.5	Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллагын болон ерөнхий боловсролын сургуулийн суралцагсдын амны хөндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүлжүүлэх	НЭМГ	-	2023	30	Хамтран ажилласан хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	тоо	50	-	Ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангийн суралцагчдад амны хөндийн үзлэг хийж, шүдний эмчилгээ хийх зорилгоор 9 дүүргийн эрүүл мэндийн төв 85 хувийн хэвшлийн шүдний эмнэлэгтэй гэрээ байгуулан үзлэг, эмчилээг хийн ажилласан. Дээрх ажлын хэрэгжилт амжилттай хэрэгжиж, цаашид тодорхойгүй хугацаагаар зогссон. 100%	90%
			НЭМГ	-	2024	40	Урьдчилан сэргийлэх үзлэгт орсон хүүхэд	тоо	100	-	Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангид суралцаж буй 40,753 хүүхдийг урьдчилан сэргийлэх үзлэгт оруулахаас 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 33,310 хүүхэд буюу 81.7%-г хамруулж, амтран ажиллаж буй 86 эмнэлгийн эмчлэгч эмч нар урьдчилан сэргийлэх үзлэг болон эмчилгээнд хүүхдээ авчирсан эцэг, эх, асран хамгаалагч нарт шүд угаах арга техник, шүдээ арчлах, шүдэнд ээлтэй хоол хүнс сэдвээр 5,418 удаагийн сургалтыг хийсэн. Мөн АШҮҮИС-ийн НАСС-ийн хүүхдийн тэнхимтэй хамтарч, тусгай хэрэгцээт хүүхдүүдийн сургууль, цэцэрлэгт амны хөндийн арчилгаа сэдвээр 70 удаагийн ганцаарчилсан сургалтад хүүхдийг эцэг, эхийн хамт хамруулсан. 70%	
			НЭМГ	-	2025	8	Эмчилгээнд хамрагдан эрүүлжсэн хүүхдийн хувьд	тоо	40	-	Үзлэгт хамрагдан эрүүлжсэн хүүхдийн хувьд 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн байдлаар 12,447 буюу 41.48%-ийг эмчлэн эрүүлжүүлсэн байна. 100%	
124		Хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлт суурилсан халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хүн амыг хамруулах ажлыг чанартай зохион байгуулах	НЭМГ	УТ	2023	39	Эрт илрүүлэгт хамрагдалт	хувь	70	100	Хүн амын нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг, шинжилгээ, оношилгоог нийслэлийн 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 нэгдсэн эмнэлэг, 4 тосгоны эрүүл мэндийн төв, өрхийн эрүүл мэндийн төвүүдэд зохион байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн яамны харьяа эмнэлгүүдээс Улсын гуравдугаар төв эмнэлэг оролцож байна. Нийслэлийн хэмжээнд 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын байдлаар эрт илрүүлэгт 911892 хүн буюу 59.5%-ийг хамруулсан. 2025 онд 37692 иргэн хамрагдсан байна. Эрүүл мэндийн сайдаас ирүүлсэн албан бичгийн дагуу эрт илрүүлгийг зогсоосон болно.	100%
125	МХҮХТЖТ-2.1	Нийслэлийн “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	НЭМГ	-	2023	-	Салбар зөвлөлийн хурал	тоо	2	-	Нийслэлийн “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл”-ийн хурлыг 2025 оны 05, 06 дугаар саруудад зохион байгуулж, дүүрэг тус бүр эх, хүүхдийн асуудлыг хэлэлцэн ажилласан. Гэвч Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээний төлөвлөгөөний 1.1-д заасны дагуу зөвлөх чиг үүрэг бүхий “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөл” байгуулагдсан. Уг арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацаа дуусан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/590 тушаалын 03 дугаар хавсралтад “аймаг, нийслэлийн орон тооны бус зөвлөлийн бүрэлдэхүүн” гэж заасны дагуу тус орон тооны зөвлөлийн бүрэлдэхүүнд байх ННЗБ-ууд болох Нийслэлийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар, Нийслэлийн Нийгмийн даатгалын газар, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар тус тус татан буугдсан. Тиймээс тус салбар зөвлөлийг хучингүй болгохоор НЗДТГ-ын холбогдох дарга нараас санал авч, НЗД-ын 2025 оны “Захирамж хучингүй болгох тухай” А/1336 дугаар захирамжийг батлуулсан.	100%
126		Жирэмсний эрт хяналтыг нэмэгдүүлэх	НЭМГ	-	2023	93	Жирэмсний эхний 3 сарын хяналтад орсон эмэгтэйчүүд	хувь	93.5	-	2025 оны 10 сарын байдлаар жирэмсний эхний 3 сартайдаа хяналтад хамрагдалтын хувь 92,8%-тай байна. Жирэмсний хяналтыг сайжруулах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд: 1.Жирэмсний эхний 3 сарын хэт авиан шинжилгээ хийх чадамжтай (Fetal Medicine Foundation-ий албан ёсны сертификаттай, програмын эрх эзэмшсэн) эмч нийслэлийн 3 амаржих газарт 9, дүүргийн эрүүл мэндийн төвд 7 эмч бэлтгэгдсэн. Хоёрол тестийн шинжилгээг Нийслэлийн Өргөө амаржих газар хийж эхэлсэн. 2.Нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судлагааг анхан болон лавлагаа шатны эрүүл мэндийн байгууллагууд хамтран хийж байна. 3.Хяналтгүй төрөлт, үр хөндөлт, гэрийн төрөлт, өсвөр үеийн төрөлтөд хүргэж буй шалтгааныг илрүүлэх зорилгоор 3 амаржих газар, 2 дүүргийн эрүүл мэндийн төвөөр дамжуулан судалгааг хийж байна. 4.Эх баригч нарын биеэ даасан тусламжийг өргөжүүлэх ажлын хүрээнд 2025 оны 09 сарын 22-оос 2025 оны 9 сарын 25-ны өдрүүдэд “Гэр бүл төлөвлөлтийн урт хугацааны аргуудыг тавих ба авах арга техникт сургах нь” сургалтыг MSI reproductive Choices ОУБ, Women care global international байгууллагатай хамтран зохион байгуулж 8 дүүргийн эмнэлгээс нийт 22 эмч, эх баригч хамрагдсан.	99%

127	МУХТЖТ-2.2.2 НХТЖТ 2.5	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад шүдний тусламж, үйлчилгээг нэвтрүүлэх	НЭМГ	УТ	2023	-	Шинээр тусламж үйлчилгээ нэвтрүүлсэн байгууллага	тоо	10	400	1.Анхан шатны 155 эрүүл мэндийн байгууллага, Гачуурт, Жаргалант, Хонхор, Туул тосгоны Эрүүл мэндийн төвд шүдний тусламж үйлчилгээг нэвтрүүлж, 2,228 хүнд үзлэг хийж, эрүүлжилт 78%-тай байна. 2.Шүдний тусламж үйлчилгээг 2025 оны 12 дугаар сард 10 анхан шатны эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлэхэд шаардагдах 13 төрлийн 149 ш, нийт 1,178,915,000 төгрөгийн төсөв, тоног төхөөрөмж худалдан авах саналыг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр ЭМЯ-нд хүргүүлсэн. Нийслэлийн 151 өрхийн эрүүл мэндийн төв нь хувийн хэвшлийн шүдний эмнэлэгтэй хамтран 6 настай 33,310 хүүхдэд амны хөндийн өвчлөлийн эрт илрүүлэх үзлэгийг зохион байгуулсан. Үүнээс 30,008 хүүхдэд амны хөндийн өвчлөл илэрсэн ба 12,446 хүүхдийг эмчлэн эрүүлжүүлсэн.	100%
128		Эхийн сүүний банкийг амаржих газруудыг түшиглэн байгуулах	НЭМГ	НТ	2023	-	Эхийн сүүний банк байгуулсан амаржих газар	тоо	1	30	Эхийн сүүний банк байгуулсан амаржих газар 2 байгуулсан байна. Нийслэлийн Өргөө, Амгалан амаржих газарт “Эхийн сүүний банк” ажиллуулах бэлтгэл ажлыг хангасан. Ажлын хэсэг эхийн сүүний эмнэлзүйн заавар боловсруулж, ЭМЯ-д хүргүүлсэн байна. Өргөө амаржих газар тус банкыг ажиллуулах өрөөг тохижуулж, сүү хадгалахад шаардлагатай 3 зориулалтын хөргөгчийг байршуулж, сургагч 4 багшийг бэлтгэн банкыг байршуулсан. Амгалан амаржих газар тус банкыг ажиллуулах 3 өрөө, 2 сургагч багшийг бэлтгэж, нийт ажилчдыг 1 удаагийн сургалтад хамруулан банкыг суурьлуулахад бэлэн болсон байна. 2025 оны 10 сарын байдлаар 35 нярайд тус банкыг ашиглаж хооллосон.	100%
129		Хоол, тэжээлийн цочмог дутал илэрсэн хүүхдийг эмчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулах	НЭМГ	-	2023	92	Эрүүлжилт	хувь	92.5	-	2025 оны 10 дүгээр сарын байдлаар 8 дүүргийн эрүүл мэндийн төв, 5 нэгдсэн эмнэлэг, 3 хүүхдийн сэргээн засах төв, өрхийн эрүүл мэндийн төв, тосгоны эрүүл мэндийн төвүүдээр дамжуулан 0-5 насны 176,523 хүүхдийг давхардсан байдлаар 568,236 удаа өсөлт хөгжлийн хяналтад хамруулсан. Өсөлт хөгжлийн хяналтын үзлэгээс туранхай 736, тураалтай 578, өсөлтийн хоцрогдолтой 742, цус багадалттай 1456, сульдаатай 896 хүүхдийг илрүүлэн өрхийн эрүүл мэндийн төв, хүүхдийн сэргээн засах төвүүдээр дамжуулан 100% хяналтад авч эмчилж, 93,5 % эрүүлжүүлэн ажиллаж байна.	100%
130		Эрт нярайн тархи хөргөөх эмчилгээг амаржих газарт нэвтрүүлэх	НЭМГ	НТ	2023	-	Шинээр тусламж үйлчилгээ нэвтрүүлсэн амаржих газар	тоо	1	300	Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/531 дүгээр тушаалын хүрээнд нийслэлийн 3 амаржих газар шаардлагатай аппаратаар хангагдаж, “Эрт нярайн тархи хөргөх эмчилгээ”-г шинээр нэвтрүүлсэн. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар Нийслэлийн Хүрээ амаржих газар 1, Өргөө амаржих газар 16 нярайд эрт нярайн тархи хөргөх эмчилгээг хийсэн байна.	100%
131		Дутуу төрсөн 250 граммаас дээш жинтэй нярайн амьсгалыг үргэлжилсэн өндөр давтамжаар амьсгал удирдах аппаратаар удирдах эмчилгээг амаржих газарт нэвтрүүлэх	НЭМГ	НТ	2023	-	Шинээр тусламж үйлчилгээ нэвтрүүлсэн амаржих газар	тоо	1	350	Нийслэлийн Амгалан, Хүрээ, Өргөө амаржих газарт дутуу төрсөн нярайд үзүүлэх амьсгал удирдах аппаратыг шинээр нэвтрүүлсэн. 2025 оны 10 сарын байдлаар Амгалан амаржих газарт 16, Хүрээ амаржих газарт 13, Өргөө амаржих газарт 36 нярайг тус аппаратад оруулсан.	100%
132	МУХТЖТ-2.2.8, НХТЖҮЧ-2.11.1	Эрүүл мэндийн ажилтны сурч хөгжих боломжийг нэмэгдүүлэх	НЭМГ	-	2023	2341	Сургалтад хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтэн	тоо	2500	-	Нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллагууд ажлын байранд болон танхимын мэргэшүүлэх, туршлага солилцох чиглэлээр давхардсан тоогоор 2,610 гаруй эмч, ажилтнуудыг хамруулан ур чадварыг дээшлүүлэн чадавхжуулсан. Үүнээс нийт сургалтын 92.8% нь ажлын байран дээр дадлагажуулах, ажилтны мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалт ихэнх хувийг эзэлж байгаа бол 3.6%-ийг Хууль эрх зүй, ёс зүйн чиглэлийн сургалт, 3.6% Хувь хүнийг хөгжүүлэх чиглэлийн сургалтууд эзэлж байна. Сургалтуудаас дурдвал: Нийслэлийн харьяа Эрүүл мэндийн байгууллагуудаас БНХАУ-ын ӨМӨЗО-ны Олон улсын Монгол эмнэлэгт Уламжлалт анагаах ухаан, сэргээн засал судлалын 38 эмч сонгодон сургалтад 6 хоногийн хугацаатай хамрагдсан. Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төв хамтран Японы "ЖАЙКА" Олон Улсын байгууллагын дэмжлэгтэйгээр хэрэгжүүлж буй “Шинэ сувилагч, шинэ эх баригчийн сургалтын хөтөлбөр”-ийг нийслэлийн харьяа 5 байгууллага (СХНЭ, БЗДЭМТ, НХАГ, НӨАГ, СБДЭМТ) 6 сувилагч тус хөтөлбөрт хамрагдаж байна. Эрүүл мэндийн ажилтны 2025-2026 оны төгсөлтийн дараах сургалтын чиглэл Улсын төсвийн санхүүжилтээр төгсөлтийн дараах үндсэн мэргэшил, төрөлжсөн мэргэшил болон мэргэжил дээшлүүлэх сургалтад, 2025-2026 оны хичээлийн жилийн хаврын элсэлтийн сургалтад 30 эмч, 34 сувилагч, тусгай мэргэжилтэн болон 1 сарын дархлаажуулалтын сувилахуйн сургалтад 29 сувилагч, намрын төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтад 12 эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн хамрагдсан.	100%
133		Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр тооцон үнэлж, урамшуулал олгох	НЭМГ	НТ	2023	9 6, 164	Байгууллага, ӨЭМТ, эмч, эмнэлгийн мэргэжилтэн	тоо	12, 9, 180	400	Харьяа эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, нийгмийн баталгаат хангах зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Тухайлбал: - Нийслэлийн эрүүл мэндийн байгууллага, ажилчдын ажлын гүйцэтгэлийг үр дүнгээр үнэлж, урамшуулал, дэмжлэг үзүүлэх Нийслэлийн Засаг даргын 2025 он А/1600 дугаар захирамжаар 15 шилдэг эрүүл мэндийн байгууллага, нийт 186 эмнэлгийн мэргэжилтэн, үүнээс 67 шилдэг эмч, 65 шилдэг сувилагч, тусгай мэргэжилтэн, 54 шилдэг эрүүл мэндийн ажилтан шагнагдсан, 399.7 сая төгрөгөөр	100%
2.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ												
134		Цахим эрүүл мэнд төслийн хэрэгжилтийг хангаж ажиллах	НЭМГ	-	2023	-	Цахим үйлчилгээ үзүүлэх байгууллага	тоо	300	-	1.Нийслэлийн харьяа лавлагаа шатлалын 24 байгууллага өдөр тутмын үйл ажиллагаандаа бодит цагийн горимоор Ehealth программ, Karte систем, Medsoft системийг, 4 тосгоны эрүүл мэндийн төв, 151 өрхийн эрүүл мэндийн төв Health.gov.mn даатгалын систем, andmed программыг ашиглаж тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2.Нийслэлд үйл ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагууд http://tailan.ubhealth.mn системээр сарын болон жилийн эцсийн статистик тайлан мэдээ, хүний нөөц, хүчин чадлын мэдээллийг бүртгэж байна. Сарын мэдээг 1200 гаруй хувийн эмнэлэг ирүүлж байна. 3.Эрүүл мэндийн цахимжилтыг эрчимжүүлэх ажлын хүрээнд 2025 оны VI улирлын байдлаар E-Mongolia 5.0 системтэй хамтран эмнэлгийн 20 үйлчилгээг бүрэн цахимжуулсан бөгөөд иргэдийн хандалт нэмэгдсээр байна. Үүнд: 1.Эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй эмийн жор 2.Цэцэрлэгийн хүүхдийн шинжилгээний хариу-135446 3.Дүрс оношилгооны дүгнэлтүүд-тухайн эмнэлгээс-88040 4. Шинжилгээний хариу- 5823354 5. Вакцины гэрчилгээ-92726270 6. Эмчлүүлэгчдийн карт 7. Жирэмсэн эхийн хөтөч 8. Эмнэлэгт цаг авах -995117 9. Эмнэлгийн магадлагаа-968966 10.Цусны бүлгийн мэдээлэл-735670 11.Эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр-684167 12.Эмнэлэгт иргэнийг илгээх цахим бүртгэлийн маягтын лавлагаа-53330 13.Эрүүл мэндийн даатгалаар хөнгөлөлт, тусламж авсан талаарх лавлагаа- 566409 14.Дүрс оношилгооны зураг-52183 15.Эмчийн үзлэг 105707 16.Эмнэлэг хайх-569273 17.Дархлаажуулалтын мэдээлэл (монгол)-390364 18.Эмийн жор-110452 19. Багц шинжилгээний хариу 20. Урьдчилан сэргийлэх үзлэгийн цагаан дэвтрийг цахимжуулсан. Дээрх үйлчилгээ цахимд шилжсэнээр нийслэлийн харьяа 28 эрүүл мэндийн байгууллага, 151 өрхийн эмнэлэг болон хувийн хэвшлийн эмнэлэг, лабораторууд цахим үйлчилгээг ашиглан иргэдэд хүлээгдэл, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх боломж бүрдэж байна.	100%

135	МУХЖТ-2.1.2, НХТЖҮЧ-2.11	9 дүүргийн эрүүл мэндийн төвийг нэгдсэн эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн төв болгон өөрчлөх бэлтгэл ажлыг хангах	НЭМГ	-	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	30	-	Дүүргийн эрүүл мэндийн төвийг Нэгдсэн эмнэлэг, Нийгмийн эрүүл мэндийн төв болгон өөрчлөх бэлтгэл ажлыг хангах хүрээнд Дүүргийн эрүүл мэндийн төвүүдээс барилга байгууламж, хүн хүч, тоног төхөөрөмжийн судалгааг авч нэгтгэн ЭМЯ-д хүргүүлсэн. Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай Эрүүл мэндийн сайдын тушаал гараагүй хүлээгдэж байна. Мөн ажиллах журам, бүтэц, санхүүжилтийн асуудал шийдэгдээгүй байна.	100%
136		Нийгмийн эрүүл мэндийн төвийг шинээр байгуулж, тусламж үйлчилгээг өргөжүүлэх	НЭМГ	-	2023	2	Шинээр байгуулагдсан нийгмийн эрүүл мэндийн төв	тоо	1	-	Шинээр Багануур, Баянзүрх дүүрэгт нийгмийн эрүүл мэндийн төв байгуулагдан ажиллаж байна. Чингэлтэй дүүргийн нийгмийн эрүүл мэндийн төв буюу эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгыг тус дүүргийн 14 дүгээр хороонд шинээр барьж байна. Барилга угсралтын ажлын явц 90%-ийн гүйцэтгэлтэй байна. 2026 оны 01 дүгээр улиралд ашиглалтад орно.	100%

137		Жишиг өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг дуусгах	НЭМГ	ГЗ	2023	10	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	10,800.00	“Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүрээнд салбар хоорондын ажлыг уялдуулан зохицуулах, теслийн хэрэгжилтийг эрчимжүүлэн ажиллаж байна. Төслийн хүрээнд хийгдэж байгаа барилгын ажлын нийт явц 70% байна. Үүнд: 1. Чингэлтэй дүүргийн 19-р хорооны барилгын ажлыг 3,2 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр “Юузэт Эрдэнэ” ХХК шалгарч, гэрээ байгуулсан. Барилгын суурь цутгалт, суурийн шороо дүүргэлт, бетон дүүргэлт, гадна дотор талын ханын өрлөг, дээвэр, цонх суулгалтын ажлуудыг бүрэн хийж гүйцэтгэсэн. Гадна фасадны хавтан суулгалтын рам төмөр угсралт, цахилгаан, сантехникийн ажил үргэлжилж байна. Нийт ажлын гүйцэтгэл 80%. 2. Сонгинохайрхан дүүргийн 26-р хорооны зураг төсөвт магадлан хийгдэж дуусан. Барилгын ажлыг 2,65 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр “Скудотаур” ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилгын бетон дүүргэлт, гадна дотор талын ханын өрлөг, дээвэр, гадна тохижилтын ажлыг 100% гүйцэтгэсэн. Цахилгаан болон дулааны асуудал шийдэгдэж хангагдсан. Гадна фасадны хавтан суулгалтын рам төмөр угсралт, дотор талын ханын шавардлагаа заслын ажил үргэлжилж байна. Нийт ажлын гүйцэтгэл 90%. 3. Баянзүрх дүүргийн 17-р хорооны гүйцэтгэгчээр “Далуу” ХХК шалгарч, барилгын ажил эхэлсэн боловч барилгажих талбайн хөрснөөс ус гарч, барилгын батлагдсан зураг өөрчлөгдөж, дахин магадлангаар баталгаажсан. Барилгын араг багана бетон дүүргэлт, давхрын хавтангийн ажил дуусан. Улирлын чанартай барилга угсралтын ажил зогссон. Нийт ажлын гүйцэтгэл 30%. Улсын төсвийн хөрөнгөөр Багануур дүүргийн 4 дүгээр хорооны “Энх-Өрх” ӨЭМТ-ийн бие даасан эмнэлгийн барилга, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр нийслэлд нийт 13 цогцолбор ӨЭМТ-ийн барилга ашиглалтад орохоор баригдаж байна.	85%
138		Нийслэлийн Аддиктологийн төвийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	НЭМГ	НТ	2023	20	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	15,000.00	Аддиктологийн төвийн барилга угсралтын ажлын явц 50%-тай байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар Аддиктологийн төвийн хуучин барилгыг буулгаж, шинээр барих ажлыг 2022-2026 онд нийт 39.8 тэрбум төгрөгөөр хийж хэрэгжүүлэхээр төсөвлөсөн. Тус хөрөнгө оруулалтаар 2022 оны санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтын дагуу Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/170 дугаар захирамжаар Аддиктологийн төвийн барилгын ажлын худалдан авах ажиллагаг зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. Уг тендерт “Бүрэн Одод” ХХК нь шалгарч, 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулсан. Хуучин барилгын ажлыг буулгаж, буулгалтын ажил хийгдсэн. Гадна, дотор талын өрлөгийн ажил, гадна фасадны дулаалгын ажил үргэлжилж байна. Барилгын цонх суулгалтын ажил бүрэн хийгдэж дуусан.	85%
139		Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	НЭМГ	ГЗ	2023	10	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	50	48,000.00	Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын явц 40%-тай байна. МУЗГ, АХБ-ны хооронд байгуулсан 3843-MON, 3844-MON (COL) гэрээний дагуу “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүрээнд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр Хан-Уул дүүргийн жишиг Нэгдсэн эмнэлгийн барилга баригдаж байна. Барилгын ажлын гүйцэтгэгчээр Хятад улсын төмөр замын 1 дүгээр компани шалгарч гэрээ байгуулсан. Барилгын суурийн ажил бүрэн хийгдэж, 1-2 дугаар давхрын арагт бетон дүүргэлт хийгдсэн.	85%
140		Чингэлтэй дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх	НЭМГ	ГЗ	2023	-	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	10	12,000.00	Чингэлтэй дүүргийн жишиг нэгдсэн эмнэлгийн барилга угсралтын ажлын явц 5%-тай байна. Тус жишиг эмнэлгийг АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжих Эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийн хүрээнд барьж байгуулна. Чингэлтэй дүүрэгт баригдах эмнэлэг нь АХБ-ны төслийн 2-3 дугаар үе шатанд хамрагдах бөгөөд Монгол Улсын Засгийн газраар орж баталгаажсан. Олон улсын тендер зарлагдана. Чингэлтэй жишиг Нэгдсэн эмнэлгийн инженерийн шугам сүлжээний дэд бүтэц (цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, харилцаа холбоо), инженерийн шугам сүлжээний зураг төслийг “Ричвел интернейшнл” ХХК гүйцэтгэж байна. Дэд бүтэцтэй холбоотой асуудлыг шийдвэрлэвэл барилгын ажлыг эхлүүлэх боломжтой болно. Газар чөлөөлөлтийн ажил үргэлжилж байна. Барилгын зураг магадлал хийгдсэн бөгөөд дүгнэлт гараагүй байна.	85%
141		Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлыг дуусгах	НЭМГ	УТ	2023	40	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	1,000.00	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилга угсралтын ажлын явц 80%-тай байна. Тус барилгын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг Төрийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, гүйцэтгэгчээр “Солармед Монгол” ХХК шалгарч 19.3 тэрбум төгрөгийн гэрээ байгуулсан. Барилга нь 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр ашиглалтад орох байсан ч эмнэлгийн барилгын цахилгааны дэд өртөөг байгуулахад шаардлагатай газрын болон инженерийн шугам сүлжээний ажилтай холбоотой асуудал гарсан. Иймээс 2025 оны 10 дугаар сард ашиглалтад оруулахаар болж, Эрүүл мэндийн яам гэрээг сунгасан байна. Барилгын төмөр бетон арагт бүтээцийн ажил, гадна ханын өрлөгийн ажил бүрэн хийгдсэн. Гадна фасад дулаалга, цонх суулгалтын ажил үргэлжилж байна.	85%
142		Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн оношилгооны төвийн барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	НЭМГ	УТ	2023	40	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	1,000.00	Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн төвийн оношилгооны төвийн барилга угсралтын ажлын явц 90%-тай байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл, арга хэмжээ Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгын ажлыг эхлүүлэхэд 2022-2024 онд нийт 5.5 тэрбум төгрөгтэйгөөр Эрт илрүүлэг, оношилгооны төвийн барилгын тендерийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр “Монхауз” ХХК шалгарч, 2022 оны 10 дугаар сарын 12-ны өдөр гэрээ байгуулсан. Гадна талын фасадны ажил, цонх суулгалтын ажил бүрэн дуусан. Гадна талын тохижилтын ажил хийгдэж байна. Төвийн шугамын огтолгоо авах зөвшөөрөл хүлээгдэж байна. Гадна цахилгааны ажлын комисс ажиллаж акт баталгаажих шатандаа байна.	86%
143		Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	НЭМГ	НТ	2023	5	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	3,000.00	Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилга угсралтын ажлын явц 45%-тай байна. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Баянзүрх дүүргийн эрүүл мэндийн төвийн цогцолбор барилгын ажлыг 2022-2026 онд нийт 13.1 тэрбум төгрөгөөр төсөвлөсөн. Тус барилгын ажлыг гүйцэтгэгчээр "Содон номин констракшн" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. Барилгын бетон цутгалт хийгдэж, ханын блокон дүүргэлтийн өрлөгийн ажил үргэлжилж байна.	85.00%
144		Гачуурт тосгоны эрүүл мэндийн төвийн барилга барилга угсралтын ажлыг дуусгах	НЭМГ	УТ	2023	10	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	500	Гачуурт тосгоны эрүүл мэндийн төвийн барилга барилга угсралтын ажлын явц 100%-тай байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Гачуурт тосгоны Эрүүл мэндийн барилгын ажлын 2022-2024 онд нийт 3.2 тэрбум төгрөгөөр батлагдсан. Барилгын ажлыг 2.9 тэрбум төгрөгөөр гүйцэтгэгчээр “Пи Эм” ХХК шалгарч, гүйцэтгэсэн. Барилгын ажил бүрэн дуусаж, 2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр улсын комисс хүлээн авч, ашиглалтад орсон.	100%

145	МҮХЖТ-2.1.2, НХТЖҮЧ-2.11	Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг дуусгах	НЭМГ	НТ	2023	-	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	3,061.20	Жаргалант тосгоны эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг 2025 онд нийт 6.5 тэрбум төгрөгөөр төсөвлөгдсөн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/566 дугаар захирамжаар эрх шилжсэний дагуу Жаргалант тосгоны Эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх тендерийг Сонгинохайрхан дүүргийн худалдан авах ажиллагааны алба зохион байгуулсан. Тендер шалгаруулалтаар уг барилгын ажлыг 6.3 тэрбум төгрөгөөр "Вайтфиникс" ХХК гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан.	100%
146		Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн салбар амбулаторийн барилга угсралтын ажлыг эхлүүлэх	НЭМГ	НТ	2023	-	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	4,019.10	Улс, нийслэлийн 2025 оны төсөвт арга хэмжээний төсөв батлагдаагүй тул ажил хойшилсон.	0%
147		Эмнэлгийн барилга худалдан авах (Баянзүрх дүүрэг, 32 дугаар хороо)	НЭМГ	УТ	2023	-	Ажлын явц	хувь	100	30,000.00	Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд Баянзүрх дүүргийн 32 дугаар хороонд Эмнэлгийн барилга худалдан авах төсөл, арга хэмжээнд 40 тэрбум төгрөг батлагдсан. Баянзүрх дүүргийн худалдан авах ажиллагааны алба тус ажлын тендер шалгаруулалтыг 2 удаа зарлаж, оролцогч байхгүй шалтгаанаар амжилтгүй болсон. Улс, нийслэлийн 2025 оны төсөвт тус төсөл, арга хэмжээнд төсөв батлагдаагүй тул ажил хойшилсон.	0%
148		Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашины хангалтыг нэмэгдүүлэх	НЭМГ	НТ	2023	-	Нийлүүлэх зориулалтын автомашин	тоо	101	16,000.00	Эрүүл мэндийн байгууллагыг бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангахаар ажиллаж байна. Үүнд: 1.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Засаг дарга (НЗД)-ын 2023 оны А/1510 дугаар захирамжаар 2024 онд Эрүүл мэндийн байгууллагын түргэн тусламжийн авто машинаар хангах төсөл арга хэмжээний худалдан авах үйл ажиллагаар Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж, Нийслэлийн эрүүл мэндийн газар захиалагчийн хяналт тавин ажилласан. Нийслэлийн Амгалан амаржих газарт 1, Нийслэлийн Өргөө амаржих газарт 1, Нийслэлийн Хүрээ амаржих газарт 1, Нийслэлийн шүд, эрүү нүүрний төвд 1, Нийслэлийн түргэн тусламжийн төвд 2 нийт 950.4 сая төгрөгийн 6 ширхэг эмнэлгийн зориулалттай автомашиныг тус тус хүлээлгэн өгсөн. 2.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр НЗД-ын 2025 оны А/107 дугаар захирамжаар эрх шилжсэн "Түргэн тусламжийн бүрэн тоноглогдсон автомашин" төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар байгуулж, уг тендерийг 1,580.0 сая төгрөгөөр нийлүүлэхээр "Монгол хьюндай автомотив" ХХК гүйцэтгэхээр шалгарч гэрээ байгуулсан. Дээрх гэрээний дагуу бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашин 9, туулах чадвар сайтай автомашин 1, нийт 10 автомашин харьяа байгууллагад нийлүүлэгдэнэ. 3.Улсын төсвийн хөрөнгөөр ЭМС-ын 2024 оны А/116, А/212, А/400, А/535 дугаар тушаалын дагуу Баганаур дүүргийн эрүүл мэндийн төв, Налайх дүүргийн эрүүл мэндийн төв, Багахангай дүүргийн эрүүл мэндийн төв, Туул тосгоны эрүүл мэндийн төвүүдийг бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашинаар хангасан. 4.Дүүргийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв, Сүхбаатар дүүргийн эрүүл мэндийн төв, Хонхор тосгоны эрүүл мэндийн төв тус бүр бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашинаар хангагдсан. 23% ?	85.0%
			НЭМГ	-	2023	-	Зориулалтын машинаар хангагдсан байгууллага	тоо	14	-	Эрүүл мэндийн байгууллагыг бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашинаар үе шаттай хангах ажлын хүрээнд 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 3 амаржих газар, 5 дүүргийн эрүүл мэндийн төв, 2 тосгоны эрүүл мэндийн төв, нийслэлийн Шүд эрүү нүүрний төв, нийслэлийн Түргэн тусламжийн төв гэсэн 12 эрүүл мэндийн байгууллага түргэн тусламжийн зориулалтын шинэ автомашинаар хангагдсан. Гэрээ байгуулагдаж 10 түргэн тусламжийн автомашин худалдан авах ажиллагаа хийгдэж байна. 86%	
149	МҮХЖТ-2.1.2, НХТЖҮЧ-2.11	Харьяа эрүүл мэндийн байгууллагын шинээр ашиглалтад орсон барилгын тоног төхөөрөмжийг нийлүүлэх	НЭМГ	НТ	2023	-	Хүрээ амаржих газрыг тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц	хувь	100	11,160.90	Хүрээ амаржих газрыг тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц 93.3%-тай байна. Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр Нийслэлийн Хүрээ амаржих газарт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 6,098.4 сая төгрөгийн төсөв батлагдсан. Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1156 дугаар захирамжаар 6,093.5 сая төгрөгийн "Эмнэлгийн тоног төхөөрөмж" төсөл арга хэмжээний нийт 15 багц ажлын худалдан авах ажиллагаг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Тендер шалгаруулалтад шалгарсан байгууллагатай гэрээ байгуулж бүрэн хэрэгжсэн-13 багц ажил, хэрэгжиж байгаа-2 багц ажил байна. 90%	85.0%
			НЭМГ	НТ	2023	-	БЗД-ийн Ахмад настан, хүүхдийн эмнэлгийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц	хувь	100	2,619.40	Баянзүрх дүүргийн ахмад настан, хүүхдийн эмнэлгийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц 55.5%-тай байна. Нийслэлийн 2024 оны төсвийн хөрөнгөөр тус эмнэлэгт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 5 тэрбум төгрөгийн төсөв баталж Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1156 дугаар захирамжийн дагуу "Баянзүрх дүүргийн ахмад настан, хүүхдийн эмнэлгийн тоног төхөөрөмж" тесөл, арга хэмжээний нийт 9 багц ажлын худалдан авах ажиллагаг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулж бүрэн хэрэгжсэн 3 багц ажил, хэрэгжиж байгаа 4 багц ажил, гомдол гарсан 2 багц ажил байна. 70%	
			НЭМГ	НТ	2023	-	ЧД-ийн ЭМТ-ийн өргөтгөлийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц	тоо	100	12,000.00	Нийслэлийн 2025 оны төсвийн хөрөнгөөр Чингэлтэй нэгдсэн эмнэлэгт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмж худалдан авахад 2,384.30 сая төгрөгийн төсөв баталж Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/430 дугаар захирамжийн дагуу "Чингэлтэй дүүргийн эрт илрүүлэг оношилгооны төвд шаардлагатай тоног төхөөрөмж" төсөл, арга хэмжээний нийт 6 багц ажлын худалдан авах ажиллагаг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар зохион байгуулсан. Гэрээ байгуулагдсан 5 багц ажил, дахин тендер шалгаруулалт зарласан 1 багц ажил байна. 50%	
150		Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн барилгын зураг, төсөв боловсруулах	НМЭГ	НТ	2023	-	Зураг төсөв боловсруулах ажлын явц	хувь	100	250	Нийслэлийн 2025 оны төсөвт Нийслэлийн Зоонозын өвчин судлалын төвийн барилгын зураг, төсвийн ажлыг хийх төсөв батлагдаагүй. Нийслэлийн төсвийн тодотголд тус ажлын төсвийг батлуулахаар 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/249 дүгээр албан бичгээр саналыг НЗДТГ-т хүргүүлсэн. Мөн газар олголтын асуудал шийдэгдээгүй. Өнөөдрийн байдлаар ажил хойшилсон байна.	0%
151		Хүүхдийн сэргээн засах Бяцхан тэмүүлэл төвийн сувиллын барилгын зураг төсөв боловсруулах	НЭМГ	НТ	2023	-	Зураг төсөв боловсруулах ажлын явц	хувь	100	200	Нийслэлийн 2025 оны төсөвт Хүүхдийн сэргээн засах Бяцхан тэмүүлэл төвийн сувиллын барилгын зураг төсөв хийх ажлын төсөв батлагдаагүй. Нийслэлийн 2025 оны төсвийн тодотголд тус ажлын төсвийг батлуулахаар саналыг 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн 01/249 дүгээр албан бичгээр Нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлсэн. Төсвийн улмаас ажил хойшилсон.	0%
152		Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн сувиллын барилгын зураг төсөв боловсруулах	НЭМГ	НТ	2023	-	Зураг төсөв боловсруулах ажлын явц	хувь	100	200	Хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн сувиллын барилгын зураг төсвийн ажил хийгдэж батлагдсан. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжих хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс төвийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэхээр "Элбэггүн" ХХК шалгарч гэрээ байгуулсан. Барилга угсралтын ажил батлагдсан зураг, төсвийн дагуу үргэлжилж байна.	85%
2.3 Эрүүл амьдралын хэв маяг												
153		Спортын клубүүдийг магадлан итгэмжлэлд хамруулах	НБТСГ	-	2023	13	Магадлан итгэмжлэгдсэн клуб	тоо	34	-	Спорт клубүүд магадлан итгэмжлэлд сайн дурын үндсэн дээр хамрагдах, магадлан итгэмжлэгдсэн клубүүдэд хичээллэж буй иргэд эрүүл мэндийн даатгалын сангаас урамшуулал авах эрх зүйн орчин 2019 оноос үйлчилж 2021 оноос түр зогссон.	0%
154		Нийтийг хамарсан биеийн тамирын томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулан иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.	НБТСГ	НТ	2023	873,313	Хамрагдагчид	тоо	916,978	1,639.50	Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийг хамарсан 270 (сургуулийн өмнөх боловсролын байгууллага, ерөнхий боловсролын сургуулийн багш нарын сургалт, хөгжөөн дэмжигчдийн арга хэмжээ, уран хөдөлгөөнт гимнастик, софт, хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил, "Улаанбаатар марафон-2025", "Алхацгаая гүйцгээе" хөдөлгөөн, олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн арга хэмжээ гэх мэт) арга хэмжээ зохион байгуулж 6600 байгууллагын 1,151,551 иргэдийг хамруулсан	100%
			НБТСГ	-	2023	130,000	Тогтмол хичээллэгчид	тоо	136,500	-	Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийтийн биеийн тамираар тогтмол хичээллэгчид 136,600 иргэд байна.	

155	МУХТЖҮЧ-3.5.3, НХТЖҮЧ-3.5.3	Нийслэлийн өвлийн спортын арга хэмжээг зохион байгуулж иргэдийн оролцоог нэмэгдүүлэх	НБТСГ	НТ	2023	425,100	Оролцогчид	тоо	446,355	80	Өвлийн улиралд иргэдийн бие бялдрыг чийрэгжүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр 20 удаагийн биеийн тамир, спортын арга хэмжээ, 22 байршилд мөсөн гулгуурын талбай, цанын баазыг байгуулж, биеийн тамир, спортын үйлчилгээг нийт 447,595 иргэдэд хүргэж ажилласан. Үүнд: 1.Нийслэлийн 9 дүүрэгт нийтийг хамарсан 11 арга хэмжээ зохион байгуулж 26,709 иргэнийг хамруулсан. 2.Өвлийн спортын төрлөөр Улаанбаатар хотын аварга шалгаруулах уралдаан, тэмцээнийг 5 удаа зохион байгуулж 693 тамирчин оролцсон. 3.Дүүргүүдийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багт өвлийн спортын 3 төрөл (хоккей, тэшүүр, шорттрейк)-ийн төрлөөр 95 хүүхэд, багачууд секц, дугуйланд хамрагдаж байна. 4.Хан-Уул, Чингэлтэй дүүрэгт байрлах битүү дээвэртэй мөсөн гулгуурын талбайд 2025 оны 01 дүгээр сарын 02-ноос 11 дүгээр сарын 28-ны хооронд 132,098 иргэн үйлчлүүлсэн байна. 5.Сүхбаатар, Баянзүрх, Багануур дүүрэгт Хандгайт, Скай ресорт, Галуут тур, Улаанбаатар цанын баазуудад 172,000 иргэн үйлчлүүлсэн байна. 6.Орон сууц, гэр хорооллын 22 байршилд мөсөн гулгуурын талбай байгуулагдаж 116,000 иргэдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	100%
156		Бүх ард түмний спортын XVII наадам, Хүүхдийн спортын VIII наадмын анхан шатны тэмцээнүүдийг зохион байгуулах	НБТСГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	30	Монголын хүүхдийн спортын өвөл, зуны VIII наадмыг 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс 06 дугаар сарын 06-ны өдрийг хүртэл зохион байгуулж, нийт 40 спортын төрлөөр 6666 тамирчид оролцсон. Монголын хүүхдийн спортын өвлийн наадамд 1-р байранд Баянзүрх дүүрэг, Зуны спортын наадамд 1-р байранд Хан-Уул дүүрэг, 2-р байранд Сүхбаатар дүүрэг, 3-р байранд Чингэлтэй дүүргийн баг тамирчид тус тус эзэлсэн байна.	100%
157	НХТЖҮЧ-3.5.2.	Баянзүрх, Сүхбаатар, Багахангай дүүргийн спорт цогцолборын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	БТСУХ, НБТСГ	УТ	2023	55	Барилга угсралтын явц	хувь	90	6,000.00	Спортын барилга байгууламжийн хүртээмж 2024 оны жилийн эцсийн байдлаар 1000 хүнд 65 м2-д хүрснийг тодорхойлж гаргасан. 2025 оны жилийн эцсийн байдлаар улсын төсвөөр баригдаж байгаа Баянзүрх дүүргийн спорт цогцолборын барилга угсралт 85%-тай, Багахангай дүүргийн спорт цогцолбор 95%-тай, Сүхбаатар дүүргийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа спорт цогцолборын ажил 60%-тай үргэлжилж байна.	100%
158		Сонгинохайрхан дүүргийн 31 дүгээр хороонд усан спорт сургалтын төв, Баянхошуу дэд төвийн спорт цогцолборын барилгыг ашиглалтад оруулж 20 дугаар хороонд өвлийн ордон барих ажлыг үргэлжлүүлэх	УБГХХХОДХ төслийн нэгж	-	2023	45	Барилгын ажлын явц	хувь	80	-	Сонгинохайрхан дүүргийн 31-р хороонд баригдаж байгаа усан спортын төвийн барилга 97%-тай, Сонгинохайрхан дүүргийн 20-р хороонд баригдаж байгаа Азийн хөгжлийн банкнаас 60%, Нийслэлийн Засаг даргын тамгын газраас 40%-ийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа бол Баянхошуу дэд төвийн спорт цогцолбор 85%-тай хэрэгжиж байна. Нийт ажлуудын гүйцэтгэл 91%-тай хэрэгжиж байна. Спортын барилга байгууламжийн хүртээмжийг жилийн сүүлийн улиралд хийхээр төлөвлөн ажиллаж байна.	100%
159	МУХТЖҮЧ-3.5.2, НХХЗ-3.12.1, 3.12.2, НХТЖҮЧ-3.5.2.	Биеийн тамир, спортын зориулалтын талбайг байгуулна.	УБЗАА, НБГ, НБТСГ	-	2023	34	Шинээр байгуулах талбай	тоо	43	-	2025 оны жилийн эцсийн байдлаар Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо, Жаргалант тосгонд 3х3 сагсан бөмбөгийн талбай, 3-р хороонд спортын цогцолбор талбайг шинээр байгуулагдсан бол бусад дүүргүүдийн 8 байршилд 3х3 сагсан бөмбөгийн талбайг хувийн аж ахуй нэгж байгууллагуудаас шинэчлэн тохижуулж нийт 213 талбайтай болсон. 2025 онд Сонгинохайрхан дүүргийн 3-р хороонд хөл бөмбөгийн хиймэл зүлэг бүхий спортын иж бүрэн талбай шинээр байгуулагдсан бол бусад дүүргүүдэд 20 байршилд спортын зориулалтын талбайг хувийн аж ахуй нэгж байгууллагуудаас шинэчлэн тохижуулж нийт 224 талбай болсон.	100%
160		Багийн спортоор хичээллэх хүүхэд, багачуудыг оролцоог нэмэгдүүлнэ.	НБТСГ, ДБТСХ	НТ	2023	145,350	Оролцогч	тоо	152,617	259.1	Нийслэлийн Засаг даргын нэрэмжит Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын “Улаанбаатар лиг” сагсан бөмбөг, волейбол тэмцээн8 “Мөрөөдлийн гоол” хөлбөмбөгийн тэмцээнийг 2024 оны 12 дугаар сарын 01-нээс 2025 оны 04 дүгээр сарын 23-ны хооронд 2-3 насны ангиллаар, 2-5 үе шаттай амжилттай зохион байгуулсан. Бага, дунд, ахлах насны ангиллаар нийслэлийн 9 дүүргийн ерөнхий боловсролын 333 сургуулийн охид, хөвгүүдийн 8728 багийн 166,694 гаруй сурагч оролцсон.	100%
161		Нийслэл, дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулах	НБТСГ, ДБТСХ	НТ	2023	47,635	Спортоор тогтмол хичээллэгчид	тоо	50,000	422.4	Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар спортын салбарын статистик мэдээгээр 51,000 иргэд спортоор тогтмол хичээллэж байна. 100%	100%
			НБТСГ, ДБТСХ	-	2023	190,538	Оролцогчид	тоо	200,067	-	Төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулах, спортын холбоодын үйл ажиллагааг дэмжих, тухайн төрлийн спортын төрлийг хөгжүүлэх зорилгоор тайлант хугацаанд Нийслэлийн Биеийн тамир, спортын газраас Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг 21 спортын төрлөөр зохион байгуулж, 443 байгууллагын 8631 тамирчид оролцсон. Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 255 уралдаан тэмцээнд 13853 байгууллагын 219,961 тамирчдыг оролцуулсан.	
162		Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн байнгын дасгал сургалт хийх нөхцөлийг хангах	НБТСГ,ДБТСХ	НТ	2023	28	Өсвөрийн шигшээ багуудын спортын төрөл	тоо	30	16	Биеийн тамир, спортын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор өндөр зэрэгтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх, дүүргийн Засаг даргын дэргэдэх Өсвөрийн шигшээ багийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж спортын 30 төрөлд 124 багт 124 дасгалжуулагчтай 4001 тамирчдыг бэлтгэл сургуулилтад хамруулж байна. Өсвөрийн шигшээ багийн тамирчид 2025 оны жилийн эцсийн байдлаар 321 удаагийн тив, дэлхий, олон улс, улс, нийслэл, нэрэмжит тэмцээнд оролцож 2067 медаль авсан амжилт үзүүлсэн байна. Баянзүрх, Сүхбаатар, Хан-Уул, Багануур, Багахангай, Налайх дүүрэг өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг дэмжиж 573,254.500 төгрөгийг зарцуулсан байна.	100%
2.4 Тэгш хүртээмжтэй, чанартай боловсрол												
163	МУХТЖҮЧ-2.1.8	Цэцэрлэгийн барилгыг өргөтгөх, шинээр барих замаар хамран сургалтыг нэмэгдүүлэх	НЗДТГ-НБХ	УТ, НТ	2023	38	Шинээр ашиглалтад орох цэцэрлэг	барилгын тоо	39	22,149.00	Нийслэл Улаанбаатар хотод 2025 онд улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 67 цэцэрлэг, 22 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, нийт 89 цэцэрлэгийн зориулалттай байгууллагын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 2025 оны байдлаар 19 цэцэрлэг, 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орсон. Шинээр 26 цэцэрлэгийн барилга ашиглалтад орж орны тоог 3700-гаар нэмэгдүүлсэн. 67%	85%
	НХТЖҮЧ-2.2.1		НЗДТГ-НБХ	-	2023	92.5	Хамран сургалт	хувь	92.7	#REF!	Улсын Их Хурлын 2022 оны 17 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 218 дугаар тогтоолын дагуу нийслэлийн цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд нийслэлд 2024-2025 оны хичээлийн жилд Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны А/226, А/237, А/283, А/306 дугаар тушаал, 2025 оны А/28 дугаар тушаалуудын дагуу нийт 95 цэцэрлэгийн байранд гэрээ байгуулагдаж, 378 бүлгийн 11420 хүүхдийг хамруулсан. 2025-2026 оны хичээлийн жилд Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны А/197, А/200, А/222 дугаар тушаалын дагуу 80 цэцэрлэгийн түрээсийн байранд 336 бүлгийн 10075 хүүхэд хамрагдаж байна. Нийслэлд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүсэлт гаргасан хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулж байгаа бөгөөд 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 3297 бүлэгт 99450, төрийн бус өмчийн 1117 бүлэгт 25053 хүүхэд хамрагдснаар хамран сургалт 91.8 хувьтай байна. 99%	
164		Цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг жишиг болгон стандартын дагуу тохижуулах	НЗДТГ-НБХ	НТ	2023	-	жишиг тоглоомын талбай	тоо	14	2,800.00	Нийслэлийн хэмжээнд 2025 онд нийслэл, дүүргийн төсвийн 5.1 тэрбум төгрөгний хөрөнгө оруулалтаар нийт 7 сургууль, цэцэрлэгийн гадна талбайн тохижилтын ажил хийгдсэн. Дээрх арга хэмжээнд тусгагдсан цэцэрлэгийн гадна тоглоомын талбайг жишиг болгон стандартын дагуу тохижуулах ажилд тухайлсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ батлагдаагүй тул хэрэгжих боломжгүй болсон.	85%

165	МУХТЖҮЧ-2.1.8 НХТЖҮЧ-2.3.1	Ерөнхий боловсролын сургуулийн барилгыг шинээр барих замаар хүчин чадлыг нэмэгдүүлж барилга ашиглалтын коэффициентыг бууруулах	НЗДТГ-НБХ, НБГ	УТ, НТ	2023	19	Шинээр ашиглалтад орох сургууль /бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор/	барилгын тоо	27	24,837.80	Нийслэл Улаанбаатар хотод 2025 онд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 22 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга баригдаж байна. 2025 оны 11 сарын байдлаар 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орж хүчин чадлыг 1960-аар нэмэгдүүлээд байна. 87.5%	86.0%
			НЗДТГ-НБХ, НБГ	УТ, НТ	2023	26	Шинээр ашиглалтад орох сургууль	барилгын тоо	27	75,095.00	Нийслэл Улаанбаатар хотод 2025 онд улс, нийслэл, дүүргийн төсөв, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 43 сургууль, 22 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор, 7 спорт заал, нийт 72 сургуулийн зориулалттай байгууллагын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 2025 оны 11 сарын байдлаар 7 сургууль, 7 бага сургууль, нийт 14 сургуулийн барилга ашиглалтад орж сургуулийн суудлын тоог 6140-өөр нэмэгдүүлсэн байна. 52%	
			НЗДТГ-НБХ, НБГ	-	2023	1.48	Ээлжийн коэффициент	тоо	1.45	-	Нийслэл Улаанбаатар хотод 2025 оны 11 сарын байдлаар 7 сургууль, 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орж сургуулийн суудлын тоог 6140-өөр нэмэгдүүлсэн байна. Ерөнхий боловсролын сургуулийн барилга ашиглалтын коэффициентийг бууруулах, хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд нийслэлд 2024-2025 оны хичээлийн жилд Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны А/226, А/237, А/283, А/306 дугаар тушаал, 2025 оны А/28 дугаар тушаалуудын дагуу нийт 30 сургуулийн байранд гэрээ байгуулагдаж, 463 бүлгийн 16685 хүүхдийг хамруулсан. 2025-2026 оны хичээлийн жилд Боловсролын ерөнхий газрын даргын 2025 оны А/197, А/200, А/222 дугаар тушаалын дагуу 35 сургуулийн түрээсийн байранд 548 бүлгийн 20835 хүүхдийг хамруулсан. Нийслэлийн хэмжээнд нийслэлийн хэмжээнд 285000 хүүхдийн хүчин чадалтай ерөнхий боловсролын 332 сургуульд 12525 бүлгийн 412394 суралцагч хичээллэж барилга ашиглалтын коэффициент 1.45-д хүрсэн. 100%	
166		ХУД-ийн тусгай хэрэгцээт 63 дугаар сургуулийн барилга угсралтын ажил, засварыг гүйцэтгэх	НЗДТГ-НБХ	НТ	2023	-	Өргөтгөлийн барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	30	12,950.00	Нийслэлийн Хан-Уул дүүргийн 4 дүгээр хороонд байрлах тусгай хэрэгцээт ерөнхий боловсролын 63 дугаар сургуулийн барилгын ажлын гүйцэтгэгчээр "Гурван тахилга оргил" ХХК шалгарсан бөгөөд гэрээ 2025 оны 04 дүгээр сарын 24-нд батлагдсан. Тус барилга нь 2 давхар байхаар төлөвлөгдөн зураг төсөл хийгдсэн бөгөөд одоогийн байдлаар 2 давхар хүртэл карказыг угсарч, гэрээний үнийн дүнгээр 12,435.6 сая төгрөгийг зарцуулсан. Барилга угсралтын ажил 30 хувьтай үргэлжилж байна. 100%	90%
			НЗДТГ-НБХ	НТ	2023	-	Засварын гүйцэтгэл	хувь	100	600	Нийслэлийн 2025 оны төсөвт тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгө батлагдаагүй тул хэрэгжих боломжгүй болсон. 0%	
167	МУХТЖҮЧ-2.1.7 НХТЖҮЧ-2.1.1	Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн багш нарын мэдлэг, заах арга, ур чадвараг дээшлүүлэх үндсэн болон графикт сургалтыг үе шаттай зохион байгуулах	НБГ	НТ	2023	33	Мэргэшүүлэх, давтан сургалтад хамруулсан багшийн эзлэх хувь	хувь	70	50	2024-2025 оны хичээлийн жилд Нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 1-р сарын 13-ны өдөр баталсан графикт сургалтын хуваарийн дагуу 19 судлагдахууны чиглэлээр онлайн болон танхимын хэлбэрээр нийт 500 удаагийн сургалтад давхардсан тоогоор 3095 байгууллагын 24218 багш, 9925 удирдах ажилтан тус бүр хамрагдсан ба давхардсан тоогоор нийт 34144 хүн хамрагдсан байна. Үүнээс онлайнаар зохион байгуулсан 25 удаагийн сургалтад 978 байгууллагын 13981 багш, 5504 сургалтын менежер, захирал, арга зүйч нар, танхимаар зохион байгуулсан 423 удаагийн сургалтад 2117 байгууллагын 10237 багш, 4421 захирал, сургалтын менежер, арга зүйч тус тус хамрагдсан байна. Сургалтыг “Хиймэл оюун ухаан, Зохиолд суурилсан аргазүй”, "арга зүйн санаа", хэрэглээний программ ашиглалт, 12000 орчим сургалтын хэрэглэгдэхүүн материалын үзэсгэлэн гаргаж, тэргүүн туршлагыг түгээн дэлгэрүүлж, туршлага солилцсон. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн 315 нийгмийн ажилтан, 185 сэтгэл зүйчдэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, чадавхжуулах графикт сургалтыг 2 удаа зохион байгуулсан. Боловсролын сургалтын байгууллагад нийт 21778 багш, 2521 удирдах ажилтан ажиллаж байгаагийн 70.4 хувь нь сургалтад хамрагдсан байна. 2025-2026 оны хичээлийн жилд нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр баталсан график сургалтын хуваарийн дагуу 8, 9, 10,11 дүгээр сард 19 судлагдахууны 36 удаагийн сургалтад 5062 багш, бага, дунд, ахлах ангийн сургалтын менежер 710, нийт 5772 хүн хамрагдсан байна.	100%
168		“Судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийг ажиллуулж, гишүүдийг чадавхжуулах, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах	НБГ	НТ	2023	80	Зөвлөн тусалсан байгууллагын тоо	тоо	130	50	Нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны А/93 дугаар тушаалаар “Судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн 23 бүлгийн 518 гишүүнийг томилж, нийслэлийн Боловсролын сургалтын байгууллагуудын хэмжээнд “Судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийг ажиллуулж, гишүүдээр дамжуулан суралцагч, багш ажилтан, удирдлагын хөгжилд тулгамдаж буй асуудал, бэрхшээлийг хамтран шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах, зөвлөн туслах, багш нарын шилдэг арга, технологи, сайн туршлага түгээн дэлгэрүүлэх зорилго, зорилттой ажиллаж байна. Энэ хүрээнд нийслэлийн Засаг даргын 2025 оны А/1438 дугаар захирамжаар "Мэргэжлийн багш нарын бүлэг"-т нийслэлийн төсвийн хөрөнгөөс 50.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. Нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны “Зардал гаргах тухай” А/105 тоот тушаалаар мэргэжлийн багш нарын бүлгийг чадавхжуулах чиглэлээр нийслэлийн хэмжээнд нэгдсэн 2 арга хэмжээг зохион байгуулсан. Үүнд: 1.Нийслэлийн мэргэжлийн багш нарын бүлгийн гишүүдийн чадавх, манлайлах ур чадварыг дээшлүүлэх, багшид мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, сургалтын чанарыг сайжруулах, сайн туршлагаас харилцан суралцах, түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2025 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр "Мэргэжлийн багш нарын бүлгийн зөвлөгөөн"-ийг зохион байгуулж 518 багш нарыг хамруулсан. 2. Мэргэжлийн багш нарын бүлгийн үйл ажиллагааны ур дүнг тооцож, урамшуулах, дэмжлэг үзүүлэх зорилгоор "Нийслэлийн тэргүүний үйл ажиллагаатай мэргэжлийн багш нарын бүлэг" шалгаруулах тайлант өдөрлөгийг 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдөр Монгени сургууль дээр зохион байгуулсан. Мэргэжлийн хөгжлийн бүлгийн гишүүдээрээ зөвлөн туслах ажлыг нийт 46 цэцэрлэг, сургууль дээр зохион байгуулсан байна.	92%
169	НХТЖҮЧ-2.1.3	Эрдэм шинжилгээний онол практикийн бага хурлыг дүүрэг, нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэхэд дэмжлэг үзүүлэх	НБГ	НТ	2023	302	Оролцогчдын тоо	тоо	320	20	Эрдэм шинжилгээний онол практикийн бага хурлыг зохион байгуулахаар нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн А/95 дугаар тушаалаар удирдамж батлагдсан. Дүүргүүдийн Боловсролын хэлтсүүдэд зохион байгуулах чиглэл бүхий 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 01/1457 дугаар албан бичиг хүргүүлсэн. Удирдамжийн дагуу нэгж байгууллага буюу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулиуд 2025 оны 11 дүгээр сарын 08-нд, дүүргүүд Боловсролын хэлтсүүд 2025 оны 11 дүгээр сарын 27-нд тус тус зохион байгуулсан. Нийслэлийн түвшний шалгаруулалт 2025 оны 12 дугаар сарын 01-15-ны өдрүүдэд зохион байгуулагдана. Илтгэлийн уралдаан 23 судлагдахуун тус бүрээр зохион байгуулагдаж байна. I шатны шалгаруулалтад 9 дүүргээс 384 илтгэл ирүүлснээс удирдах ажилтны 90, 16 судлагдахууны 294 илтгэл шалгаран нийслэлийн Боловсролын газарт ирүүлсэн байна.	100%
170	МУХТЖҮЧ-2.1.7 НХТЖҮЧ-2.1.2	Нийслэлийн шилдэг багш, ажилтныг шалгаруулж, урамшуулал олгох	НЗДТГ-НБХ, НБГ	НТ	2023	60	Шалгарсан багш, ажилтны тоо	тоо	80	120	Нийслэлийн боловсролын салбарын шилдэг байгууллага, гэр бүл, удирдах ажилтан, багш, ажилтныг шалгаруулан, шагнаж урамшуулах, тэдний тэргүүн туршлага, ололт амжилтыг олон нийтэд сурталчлан таниулж, түгээн дэлгэрүүлэх зорилгоор “НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛ-АМЖИЛТЫН ЭЗЭД” хүндэтгэлийн үйл ажиллагаг зохион байгуулж 8 номинацид 18 байгууллага, 52 багш, ажилтныг шалгаруулж Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/1322 дугаар захирамжаар 103.072 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлж шагнаж урамшуулсан. Нийт 79 багш ажилтан шилдгээр шалгарсан байна.	99%
	НХТЖҮЧ-	Суралцагчдын мэдлэг шалгах даалгаврын тоог нэмэгдүүлж,багш,	НЗДТГ-НБХ, НБГ	НТ	2023	400	Контентын тоо	тоо	900	40	Судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлэгтэй хамтран багш нарын ажлын байрандаа тасралтгүй хөгжих, сайн туршлагаа мэргэжлийн багш нартаа түгээн дэлгэрүүлэх видео хичээл, эцэг, эх, сурагчдыг цахим орчноос шинэ мэдлэг, мэдээлэл авах заавар, зөвлөмж бүхий хичээл сургалтын үйл ажиллагаанд ашиглах, боловсролын байгууллагаас хийж хэрэгжүүлж буй үйл ажилагааг сурталчилан таниулах зэрэг нөлөөллийн нийт 895 контентыг боловсруулаад байна. Үүнд: Сургуулийн өмнөх боловсролын бүлгийн багш нарын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх 19 контент боловсруулан khuukhed khogjil.mn сайтад байршуулсан. Ерөнхий боловсролын сургуулийн судлагдахуунаас үндэсний бичгийн 32, хөгжмийн 35, биеийн тамирын 18, дүрслэх урлаг дизайн технологийн 32, бага боловсролын 6, хими, биологи, эрүүл мэндийн 9, физикийн 4, мэдээллийн технологийн 20, газар зүй 6, түүх нийгэм 225, математикийн 7, гадаад хэлний 6, ахлах ангийн суралцагчдад зориулсан ЭШ-ын агуулгаар 60, нийт 13 төрлийн 460 контентыг боловсруулан мэргэжлийн багш нарын цахим сүлжээгээр дамжуулан багш, суралцагч, эцэг, эх олон нийтэд хүргэн ажилласан. Бага боловсролд 3 сургуулийн 16 төрлийн контент боловсруулсан. 99%	

171	НХТЖҮЧ-2.3.3	суралцагч, эцэг эх, олон нийтэд зориулсан контент боловсруулан, цахим орчинд байршуулах.	НЗДТГ-НБХ, НБГ	-	2023	6000	Цахим даалгавар	тоо	13000	-	2025 онд монгол хэлний судлагдахуунаар 127 даалгавар, дүрслэх урлаг, диайн зураг зүй, технологийн судлагдахуунаар 863, математикийн судлагдахуунаар 234 даалгавар, физик, мэдээллийн технологийн судлагдахуунаар 280 даалгавар, химии, биологийн судлагдахуунаар 220 даалгавар, эрүүл мэндийн хичээлийн судлагдахуунаар 40 даалгаварыг, Амжилтын гараа төсөл арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр 10 судлагдахуунаар 930 даалгавар буюу нийт 2694 даалгаврыг боловсруулан, цахим санг баяжуулан, судлагдахуун тус бүрийн пэйж хуудсанд байршуулж түгээн дэлгэрүүлэн сургалтдаа ашиглаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд хичээл тус бүрийн хөтөлбөрийн агуулгад нийцсэн монгол хэлний - 36, үндэсний бичгийн - 45, уран зохиолын - 28 нийт 109 цахим хичээлийг боловсруулан хичээл сургалтын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Төгсөх ангийн болон АДШ, олимпиадад бэлтгэх зорилгоор анги тус бүрийн агуулгад нийцсэн 78 үнэлгээний даалгаврыг боловсруулсан. Нийт 2881 цахим даалгавар боловсруулжээ. Суурь түвшингийн 3000 цахим даалгавар болон суралцагчийн мэдлэг чадварыг шалгах, сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор цахим даалгаврын санг 19 судлагдахууны 7076 цахим даалгавар боловсруулж, судлагдахууны мэргэжилтнүүд өөрсдийн мэргэжлийн бүлгийн цахим сандаа байршуулсан. Багш, суралцагч, эцэг эх, олон нийтэд зориулсан цахим даалгаврын тоо өссөн дүнгээр 12177-д хүрсэн байна. 98%	98.5%
172	МУХТЖҮЧ-2.1.7 НХТЖҮЧ-2.1.2	Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр түвшин ахисан, Нийслэлийн шилдэг менежменттэй, ментор сургууль, цэцэрлэг шалгаруулж, индексийн урамшуулал олгож, туршлагыг түгээн дэлгэрүүлэх	НЗДТГ-НБХ, НБГ	НТ	2023	35	Урамшуулал авсан байгууллага	тоо	70	600	Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр түвшин ахисан сургууль, цэцэрлэгийг шалгаруулж Нийслэлийн Засаг даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/879 дүгээр захирамжаар 2024 онд "Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний индексийн түвшин ахисан нийслэлийн ерөнхий боловсролын 6 сургууль, 3 цэцэрлэг нийт 9 байгууллагад 46.6 сая төгрөгийн индексийн урамшууллыг олгосон. Нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/100 дугаар тушаалаар батлагдсан ажлын хэсэг шалгаруулалтад оролцох 21 сургууль, 31 цэцэрлэгийн ирүүлсэн материалыг магадлан Нийслэлийн Засаг даргын 2025 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Шилдэг менежменттэй, ментор сургууль, цэцэрлэг” шалгаруулан , урамшуулах тухай А/1464 дүгээр захирамжийн дагуу 15 сургууль, 14 цэцэрлэгийг шалгаруулан 460.1 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. Индексийн урамшуулал олгох журмыг шинэчлэн жилд 2 удаа олгохоор өөрчлөлт оруулснаар 2025 онд нийт 38 байгууллагад урамшуулал олголоо.	100%
173	НХТЖҮЧ-2.1.3	"Дэлхийд өрсөлдөх Улаанбаатар" сэдэвт англи хэлний уралдааныг үргэлжлүүлэн зохион байгуулах	НБГ	УТ	2023	100	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	190	2025-2026 оны хичээлийн жилд “Дэлхийд Өрсөлдөх Улаанбаатар 2025” төсөл арга хэмжээг зохион байгуулах" тухай нийслэлийн Засаг даргын захирамжаар 47,2 сая төгрөг батлагдсан. “Дэлхийд Өрсөлдөх Улаанбаатар 2025” төсөл арга хэмжээний хүрээнд сурагчийн хөгжлийн чиглэлээр нийслэлийн ерөнхий боловсролын англи хэлний гүнзгийрүүлсэн сургалттай сургуулийн 6-10 дугаар ангийн сурагчдын дунд “Ангиараа зорилготой уншъя”, "Reading with purpose 2025” марафон, “Номын мэтгэлцээн”, “The Book Debate” уралдаануудыг үе шаттайгаар зохион байгуулж үр дүнг танилцуулж байна. Багшийн хөгжлийн чиглэлээр англи хэлний багш нарын хэлний мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилготойгоор 600 англи хэлний багшийн хэлний түвшнийг тогтоож, 3-6 сарын хугацаатай онлайн CELT олон улсын батламжтай онлайн сургалтад үе шаттай хамруулахаад байна. Мөн англи хэлний багш нарын илтгэх болон ярих чадварыг хөгжүүлэх зорилгоор “Туршлагаа хуваалцъя” “Let’s showcase Our experience” англиар илтгэх уралдааныг зохион байгуулж байна.	100%
174	НХТЖҮЧ-2.1.3	Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын төрөлжсөн болон гүнзгийрүүлсэн сургалтын хөтөлбөрийг магадлан, баталгаажуулах	НБГ	-	2023	785	Баталгаажуулах хөтөлбөр	тоо	820	-	2024-2025 оны хичээлийн жилд Боловсрол, Шинжлэх ухааны сайдын 2024 оны А/262 дугаар тушаалаар батлагдсан “Төрөлжсөн сургалт зохион байгуулах журам” шинэчлэгдсэн. Нийслэлийн түвшинд төрөлжсөн сургалт зохион байгуулахаар хүсэлт ирүүлсэн 19 сургуулийн сургалтын орчин нөхцөл, багшлах хүний нөөцийн хүрэлцээ хангамж, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, 14 судлагдахууны чиглэлээр 41 хөтөлбөрийг ажлын хэсэг магадлан дүгнэлт гарган төрөлжсөн хөтөлбөрөөр 329 бүлгийн 11333 суралцагч суралцаж байна. Дүүргийн түвшний төрөлжсөн сургалтаар 2 дүүргийн 6 сургуулийн 74 хөтөлбөрөөр 1938 суралцагч, сургуулийн түвшний төрөлжсөн сургалтаар 84 сургуулийн 554 хөтөлбөрөөр 31245 суралцагч тус тус суралцаж байна. Төрөлжсөн сургалтын нийт 669 хөтөлбөр хэрэгжүүлж буй ангиудаас хамгийн их буюу 18 хувийг 6 дугаар ангийн сурагчид эзэлж байна. Суралцагчдын 30.5 хувь математик, 27.6 хувь нь англи хэлний хичээлийг сонгон суралцаж байна. Нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны А/29 дүгээр тушаалаар батлагдсан ажлын хэсэг хүсэлт ирүүлсэн ерөнхий боловсролын 10 сургуулийн сургалтын хөтөлбөрийг хянах, сургалтын орчинг магадлах ажлыг гүйцэтгэлээ. 2024-2025 оны хичээлийн жилд нийслэлийн хэмжээнд 112 сургуульд 14 судлагдахууны чиглэлээр 1945 төрөлжсөн хөтөлбөрөөр 53978 суралцагч суралцаж байна. 2025-2026 оны хичээлийн жилд нийслэлийн Боловсролын газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/54 дүгээр тушаалаар нийслэлийн түвшний төрөлжсөн сургалтыг 4 сургууль гадаад хэлний 5 хэлээр 51 бүлэгт 1179 суралцагч, 1 сургууль физикийн хичээлийн 2 бүлгийн 72 суралцагч, нийт 5 сургуулийн 53 бүлгийн 1251 суралцагч, 31 хөтөлбөрөөр хичээллэж эхлээд байна. Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын нийт 1976 төрөлжсөн хөтөлбөрийг магадлан хэрэгжүүлж байна.	100%
175	НХТЖҮЧ-2.3.2	Байгалийн ухааны болон мэдээлэл харилцааны технологийн сургалтын чанарыг сайжруулах, программ хангамж, роботын сургалтыг нэвтрүүлж, шаардлагатай тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах	НБГ	НТ	2023	40	Технологийн сургалтын багц, хэрэглэгдэхүүн	тоо	40	200	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын байгалийн ухааны болон мэдээлэл харилцааны технологийн сургалтын чанарыг сайжруулах зорилгоор “РОБОТ БОЛОВСРОЛ” арга хэмжээг 2 дахь жилдээ хэрэгжүүлсэн. Энэхүү арга хэмжээ нь нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудыг роботын иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангах, багш, суралцагчдыг чадавхжуулах, роботын тэмцээн уралдааныг зохион байгуулах гэсэн 3-н цогц зорилтын хүрээнд хэрэгжиж байна. 2024-2025 оны хичээлийн жилд Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1211 дүгээр захирамжаар 176,690,000 төгрөгийн төсвийг батлуулж, нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 18 сургуульд 360 багц роботын тоног төхөөрөмж бүхий сургалтын хэрэглэгдэхүүнийг хүлээлгэн өгснөөр нийт роботын 400 багцтай болж сургалтын орчныг сайжруулсан. Багш, суралцагчдыг чадавхжуулах хүрээнд 2025 оны 1-4 дүгээр саруудад 4 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 140 багш, 310 сурагч хамрагдсан. Багш, суралцагчдын ур чадварын 2 төрлийн тэмцээнийг зохион байгуулсан: Үүнд. Шинэ эрин сургуулийн нэрэмжит “MONROBOT-2025” тэмцээнийг 2 дугаар сард зохион байгуулж, тэмцээнд 86 багийн, 210 сурагч оролцсон. Нийслэлийн аварга шалгаруулах “МИКРО ЛИОН РОБОТ-2025” тэмцээнийг 5 дугаар сард зохион байгуулж, 110 багийн 150 сурагчид тус тус оролцож, мэдлэг чадвар, бүтээлч сэтгэлгээгээ хөгжүүлэн, авъяас чадвараа сорин оролцлоо. Нийслэлийн аварга шалгаруулах “АВТОМАТ РОБОТ-2025” тэмцээнийг 12 дугаар сарын 06, 07 зохион байгуулж, 10.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн. Тэмцээний зохион байгуулах газар, орчин хэрэглэгдэх материалуудыг бэлтгэн ажиллаж байна. Нийслэлийн Засаг даргын 2025 оны захирамжаар 19.173 сая төгрөгөөр робот сургалтын 44 багц төхөөрөмжийг ерөнхий боловсролын 5 сургуульд нийлүүлсэн.	100%
176	НХТЖҮЧ-2.3.2	Хүүхдийн авьяас, нийгэм-сэтгэл хөдлөлийн чадварыг хөгжүүлэх, чөлөөт цагийг үр дүнтэй өнгөрүүлэх, оролцоог хангах чиглэлээр секц, дугуйлан, клубийн үйл ажиллагааг идэвхжүүлэх	НБГ	НТ	2023	39	Хичээлээс гадуурх дугуйлан секцэд хамрагдалт	хувь	40	80	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор урлаг, спорт, техник технологи, математик сэтгэхүй, хэл, илтгэх урлаг зэрэг 7 чиглэлийн 5923 төрлийн өөрийн сургуулийн болон сургуулиас гадуурх дугуйлан секц, клубт нийт 187857 суралцагч, 1254 суралцагчдын өөрөө удирдлагын оролцооны байгууллагад 33593 суралцагч буюу нийт 398437 суралцагчаас 221450 суралцагч хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдсан бөгөөд нийт суралцагчдын 55.5 хувийг эзэлж байна. Хүүхдийн авьяас, чадварыг хөгжүүлж дугуйлан секцэд хамруулахаас гадна монгол ёс заншлаас суралцах, өвлүүлэн авч үлдэх зорилгоор сурагчдын зан төлөвийн төлөвшил, уламжлалт аж төрөх ёс, үндэсний өв соёл, бахархлаа дээдэлж, түүнээс суралцахаар "Би монгол хүүхэд" ёс заншлын наадмыг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд 11 дэх жилдээ, зохион байгуулсан бөгөөд 9 дүүргийн 166 сургуулийн 156928 сурагч, 4120 багш оролцлоо. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/546 дугаар захирамжийн дагуу “МИНИЙ МӨРӨӨДЛИЙН ХОТ-2040” хүүхдийн бүтээлийн уралдааныг 2025 оны 04 дүгээр сарын 08-наас 14-ны өдрүүдэд зохион байгуулсан. Уралдаанд шалгарсан 113 бүтээлээс бага, дунд, ахлах насны ангилал тус бүрээр гар зургийн бүтээлээр шалгарсан 18, баримал нь бүтээлээр шалгарсан 8 сурагч, анги хамт олноо идэвхтэй ороцуулсан багш, сургалтын менежер, сургуулиудыг 5,0 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа.	100%

177	НХТЖҮЧ-2.3.3	Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Их нүүдэл" шатрын тэмцээнийг зохион байгуулж, оюуны спортоор хичээллэхэд дэмжлэг үзүүлэх	НЗДТГ-НБХ, НБГ	НТ	2023	100	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	20	"Их нүүдэл-2025" өсвөрийн шатарчдын тэмцээнд нийслэлийн Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиуд сургуулийн хэмжээнд зохион байгуулж, нийт 25 сургуулийн 6208 суралцагч хамрагдсан байна. Сүхбаатар дүүрэг, дүүргийн хэмжээнд зохион байгуулж, 11 сургуулийн 264 суралцагч хамрагдсан байна. "Их нүүдэл" шатрын тэмцээнийг Улаанбаатар хотын өдрөөр нийслэлийн Засаг даргын нэрэмжит болгон зохион байгуулахаар 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 01/1424 дүгээр албан бичгээр тэмцээн зохион байгуулж зардал гаргах захирамжийн төслийг боловсруулан албан бичгээр хүргүүлсэн боловч төсвийн хэмнэлтийг хэрэгжүүлэн ажиллах хүрээнд НЗДТГ-ын 2025 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 03/6715 дугаар албан бичгээр үйл ажиллагааны зардлыг санжүүжүүлэх боломжгүйг мэдэгдсэн.	100%
178	МУХТЖҮЧ-2.1.8 НХТЖҮЧ-2.4.1	Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээг тодорхойлж, сурагчдад зориулсан тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин нөхцөл бүрдүүлэх	НБГ	-	2023	14	Сургалтын орчныг сайжруулсан сургууль	тоо	22	-	2025 оны 11 сарын байдлаар 7 сургууль, 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга ашиглалтад орж сургуулийн суудлын тоог 6140-өөр нэмэгдүүлсэн байна. Эдгээр ашиглалтад орсон сургуулиуд нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд суралцах орчныг хангасан зураг, төсвийн дагуу баригдсан бөгөөд олон улсын стандартад нийцсэн дотор, гадна талын налуу шат, давхар бүрд тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй, тэргэнцэртэй хүүхдэд зориулсан довжоотой анги танхим бүхий 14 ердийн сургуулийн орчинг бүрдүүлснээр нийт 59 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчин бүрдээд байна. Энэ нь нийт ерөнхий боловсролын сургуулийн 17.8%, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн 33.1%-ийг эзэлж байна. Нийслэлийн ерөнхий боловсролын 15, 88, 118 дугаар сургуулиудын хүүхэд хөгжлийн танхимд нэмэлт тохижилт хийж, бүтээлийн самбар байрлуулан дохионы хэлний сургалтын картаар хэрэглэгдэхүүн баяжуулсан. 88 дугаар сургуулийн хүүхэд хөгжлийн танхимд Аутизмтай хүүхэд амрах булан байгуулсан. 2025 онд 14 сургуулийн орчин нөхцөлийг сайжруулснаар нийт 59 сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд сурах орчин бүрдээд байна.	100%
179	МУХТЖҮЧ-2.1.8 НХТЖҮЧ-2.4.1	Тэгш хамруулах боловсролын төсөл хэрэгжсэн цэцэрлэг, сургуулийг ментор цэцэрлэг, сургууль болгон зөвлөн туслах, хүний нөөцийг чадавхжуулах, эцэг эх олон нийтэд эрэг ойлголт өгөх нөлөөллийн ажлыг зохион байгуулах	НБГ	УТ	2023	50	Зохион байгуулсан ажил	тоо	60	30	Ерөнхий боловсролын сургуульд тэгш хамрагдаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын талаар олон нийтэд эерэг ойлголт өгөх зорилгоор EQUAL төсөл хэрэгжиж буй 118, 15, 88 дугаар сургуулиудад "МИНИЙ НАЙЗ-БИДНИЙ НАЙЗ" нөлөөллийн арга хэмжээг 3 удаа зохион байгуулж, нийт 1052 суралцагч, 84 багш, 18 эцэг эх, асран хамгаалагч нарыг хамрууллаа. Жайка СТАРТ-2 төслийн түгээн дэлгэрүүлэлтэд хамрагдсан 130 дугаар сургуулийн 40 багш нарт "Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйг сайжруулах, чадавхжуулах сургалт", Жайка СТАРТ төсөл хэрэгжсэн ерөнхий боловсролын Гүн галуутай сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагааг сайжруулах, төсөл хэрэгжих хугацаанд олж авсан туршлагыг нь Багануур дүүргийн Боловсрол, Оюуны-Эрин сургуулийн 72 багш нарт түгээн дэлгэрүүлүүлэх үйл ажиллагаа, Жайка СТАРТ-2 төслийн түгээн дэлгэрүүлэлтэд хамрагдсан нийслэлийн хүүхдийн 290 дүгээр цэцэрлэгийн хүүхэд хөгжлийн танхим хариуцсан багш болон дэмжлэгийн багийн 6 гишүүнийг чадавхжуулах сургалтыг зохион байгуулсан. Нийт 6 нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, зөвлөн тусалсан.	60%
180	НХТЖҮЧ-2.4.3	Авто замын түгжрэлийг бууруулах зорилгоор сургуулийн болон хүүхдийн автобус төслийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	НБГ	-	2024	150	Хүүхдийн автобус	тоо	257	-	"Сургуулийн бүсэд хүүхдэд ээлтэй, аюулгүй орчинг бүрдүүлж, суралцагч гэр сургуулийн хооронд үнэ төлбөргүй зорчих "Сургуулийн автобус" төсөл хэрэгжиж байна. 2025-2026 оны хичээлийн жилд сургуулийн автобусны үйлчилгээнд 2025 оны 11 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 83 сургуулийн 67 чиглэлд 67 сургуулийн хүүхдийн автобусаар 119953 хүүхэд зорчиж байна. Үүнд: сургуулийн автобус төслийн 67, сургуулийн өөрийн өмчийн 59, түрээсийн 233, нийт 359 автобусаар суралцагчдад үйлчилгээ үзүүлж байна.	100%
181	НХТЖҮЧ-2.4.3	Сургуулийн орчин дахь гэрэлтүүлэг, гарц, гэрлэн дохио, камер, хурд сааруулагчийг нэмэгдүүлж аюулгүй байдлыг хангах	ТЦА-ны ЗЦГ	-	2023	142	Сургууль орчмын бүс байгуулсан сургууль	тоо	164	-	Улаанбаатар хотын хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах "Сургуулийн бүс"-ийн туршилт суурилуулалт болон чадавхыг бэхжүүлэх төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар Койка ОУ-ын байгууллгаас Улаанбаатар хотын хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах "Сургуулийн бүс"-ийн туршилт суурилуулалт болон чадавхыг бэхжүүлэх төслийн хэрэгжүүлэгч байгууллагаар БНСУ-ын "Духуа инженеринг ХХК шалгарч, сургуулиуд дээр судалгааны ажил хийгдсэн. Улаанбаатар хотын хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах "Сургуулийн бүс"-ийн туршилт суурилуулалт болон чадавхыг бэхжүүлэх төслийн багийнхантай 3 дахь удаагийн уулзалт зохион байгуулж хүүхдийн замын хөдөлгөөний аюулгүй байдлын сургалтын хөтөлбөр, бага, дунд, ахлах ангийнханд зориулсан сурах бичиг, сургалтын агуулгаар хийсэн контентийн эхний хувилбарыг хэлэлцэж, сурах бичгийн агуулгыг нэмж, сайжруулахаар ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд НЗД-ын 2023.05.29-ний өдрийн А/533 дугаар захирамжаар төвийн 6 дүүргийн 22 сургууль, цэцэрлэг орчмын хөдөлгөөний аюулгүй байдлыг сайжруулах ажлыг он дамжин хийж хэрэгжүүлж байгаа бөгөөд зам талбайн ажил 90 хувийн гүйцэтгэлтэй тус ажлыг "Улаанбаатар зам засвар арчлалтын газар" ОНӨААТҮГ хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/104 дүгээр захирамжаар 6 дүүргийн 17 ерөнхий боловсролын сургууль, 5 цэцэрлэг орчмын аюулгүй байдлыг сайжруулах, тохижилтын ажилд 3,500.0 тэр бум төгрөг тесөвлөгдөн зураг төслийн ажил хийгдэж байна. Дээрх ажлыг хийж гүйцэтгэснээр 145 сургууль орчмын аюулгүйн бүстэй боллоо.	88%
182	НХТЖҮЧ-2.4	Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт шаардлагатай их, засвар, тохижилтын ажлыг гүйцэтгэж сургалтын орчныг сайжруулахад дэмжлэг үзүүлэх.	НЗДТГ-НБХ, НБГ	НТ	2023	81	Төсөл хэрэгжүүлсэн байгууллага	тоо	85	6,000.00	2025 онд нийслэл, дүүргийн төсөв, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 22.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй нийт 136 сургууль, цэцэрлэгийн барилгын их засварын ажил хийгдсэн.	100%
183		Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийг сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмжөөр ханган сургалтын орчныг сайжруулах	НБГ	-	2022	40	Сургалтын хэрэглэгдэхүүн тоног төхөөрөмжөөр хангагдсан байгууллага	тоо	80	-	Нийслэлийн Боловсролын газар нь 2025 онд нийслэлийн Засаг даргын холбогдох захирамжийн хүрээнд нийт 9 төсөл, арга хэмжээний 35 багц, ажилд захиалагчийн хяналт тавин ажиллаж бүрэн хэрэгжиж дууссан. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар 61 цэцэрлэг, 16 сургууль, нийт 77 сургууль, цэцэрлэгт 1,762.6 сая төгрөгийн 2766 ширхэг сургалтын хэрэглэгдэхүүн, тавилга хэрэгсэл, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн.	100%
184		Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Амны хөндийн эрүүл мэндийн чиглэлээр үе тэнгийн сургагч багш" бэлтгэх	НБГ	НТ	2023	-	Зохион байгуулах сургалт	тоо	20	20	Нийслэлийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн 168 эмч нарт 2025 оны 02 дугаар сард "Амны хөндийн эрүүл мэнд, томуу томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт үйл ажиллагааг эрүүл мэндийн мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулсан. Амны хөндийн эрүүл мэндийн боловсролыг олгох, эрүүл зөв дадлыг хэвшүүлэх чиглэлээр 2025 оны 10 дугаар сарын 15-нд налайх дүүргийн 8 сургуулийн 4, 5-р ангийн 24 багийн 192 суралцагчийг хамруулж зохион байгуулсан. 192 суралцагч сургагч багшаар бэлтгэгдсэн.	19.20%
			НБГ	-	2023	-	Сургагч багш болсон хүүхдүүд	тоо	1000	-		
185		Нийслэлийн ерөнхий боловсролын байгууллагуудад шүд угаах орчин бүрдүүлж шүд угаах цагийн зохицуулалтыг хийх	НБГ	-	2023	2	Шүд угаах орчин бүрдүүлсэн байгууллага	тоо	42	-	Нийслэлийн ерөнхий боловсролын нийт 135 сургууль дотоод нөөц бололцоонд тулгуурлан шүд угаах цэгийг анги танхим, хоолны зааланд, сургуулийн коридор, ариун цэврийн өрөөнд тус бүр байршуулан хүүхдийн гар, амыг угаах ариун цэвэр, амны хөндийн эрүүл мэндийн дадал хэвшил суулгах орчин нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2025 онд шүд угаах цэг шинээр байгуулсан 12 сургууль байна. Шүд угаах цагийн зохицуулалт хийсэн сургууль 40 байна.	100%

186	НХТЖҮЧ-2.4.2	Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг бие даан хэрэгжүүлэх байгууллагын тоог нэмэгдүүлж, эрүүл хүнсээр хангах ажлыг зохион байгуулах	НБГ	УТ	2023	58	Бие даан хэрэгжүүлэх ерөнхий боловсролын сургууль	тоо	95	4,000.00	Засгийн газрын 2021 оны 18 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 2025-2026 оны хичээлийн жилд төрийн өмчийн 164 сургуулиас 110 сургууль "Үдийн хоол" хөтөлбөрийг бие даан хэрэгжүүлэн ажиллуув байна. Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл үйлчилгээг бие даан хэрэгжүүлэх байгууллагын тоог нэмэгдүүлэх зорилгоор Боловсрол яам, БНСУ-ын олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (КОЙКА)-тэй хамтран хэрэгжүүлж буй "Монгол улсын ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний орчныг сайжруулах, чадавхыг бэхжүүлэх төсөл"-ийн хүрээнд Нийслэлийн ерөнхий боловсролын 10 сургуулийн гал тогоог иж бүрэн засварлахаар төсөл хэрэгжиж байгаа бөгөөд 2025 оны 10 дугаар сарын байдлаар нийслэлийн 9, 40, 48 дугаар сургуулийн гал тогооны засврын ажил бүрэн дууссан. Тоног төхөөрөмжөө хүлээж байна. Тэгш боломжийг дэмжих төслийн хүрээнд нийслэлийн 15 ерөнхий боловсролын сургуулийн гал тогоонд 1.5 сая ам долларын өртөг бүхий 61 нэр төрлийн 8142 ш тоног төхөөрөмжийг хүлээлгэн өгсөн. Уг төслийн хүрээнд 103, 116, 63 дугаар сургуулийн гал тогоонд нийт 210.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Боловсролын яамнаас нийслэлийн ерөнхий боловсролын 32 сургуульд аяга таваг, угаагч нийлүүлсэн. Нийт 327 сургуулиас 231 сургуульд сэтгэл зүйчтэй үйл ажиллагаа явуулж байгаа буюу нийт сургуулийн 70.6%-ийг эзэлж байна.	100%
187	НХТЖҮЧ-2.4.2	Хүүхдийн бие махбодын дархлааг сайжруулж, хэвийн өсөлт, хөгжлийг дэмжих, суралцах идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор "Сүү" зорилтот төслийг үе шаттай хэрэгжүүлэх	НБГ, НЭМГ	УТ	2024	19300	Хамрагдсан суралцагчид	тоо	50000	3,000.00	"Сүү хөтөлбөр"-ийг нийслэлд дараах 2 чиглэлээр хэрэгжүүлж байна. - "Сүүн дархлаа" зорилтот төслийг 2024 оны 05 дугаар сарын 01 өдрөөс хэрэгжүүлсэн бөгөөд нийслэлийн 2025 оны үйл ажиллагааны төсөвт 784.0 сая төгрөг, орон нутаг буюу БЗД, СБД-үүд 338.0 сая төгрөг батлуулж, эцэг эх асран хамгаалагчдын дэмжлэгтэйгээр нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 13 сургуулийн 19400 суралцагч хамрагдаж байна. -Мөн үдийн хоол хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн төрийн өмчийн ерөнхий боловсролын 38 сургуулийн 87400 суралцагч, өрт хамрагдаж байна. -"Өдөр бүр нэг аяга сүү" хөтөлбөрийн хүрээнд Энэ хичээлийн жилд 51 ерөнхий боловсролын сургуулийн 106800 хүүхдийг хамруулан 7 хоногийн 2-3 өдөрт сүү өгч байна. Сүү хөтөлбөрийн хүрээнд нийт 213600 хүүхдийг хамруулж өдөр бүр сүү өгч дэмжиж байна.	100%
2.5 Гэр бүл, хувь хүний хөгжил												
188	НХТЖҮЧ-2.12.1	Гэр бүлийн боловсрол олгох сургалт, соён гэгээрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн ажлыг зохион байгуулах	НХГБХХГ	НТ	2023	229,761	Үйл ажиллагаанд хамрагдсан хүн	тоо	270,000	420	2025 оны жилийн эцсийн байдлаар 8 Гэр бүлд зөвлөгөө өгөх төвүүдээр дамжуулан 1,731 хүнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжүүлэх эрэг аргыг түгээх, гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилгоор сургалт нөлөөллийн 322 удаагийн арга хэмжээ зохион байгуулж, давхардсан тоогоор нийт 54,829 хүнийг хамруулж, цахимаар 270,251 хүнд хүрсэн байна. Өмнөх онтой харьцуулахад хамрагдсан хүний тоо 15 хувиар, цахим орчинд хүрсэн хүний тоо 116 хувиар өссөн байна.	100%
189	НХТЖҮЧ 3.5.2	Монголын Хүүхдийн ордны өргөтгөл "Спорт цогцолбор"-ын барилгыг шинээр барих	МХО	НТ	2024	-	Барилга угсралтын явц	хувь	100	20,500.00	Монголын Хүүхдийн ордны өргөтгөл "Спорт цогцолбор"-ын барилгын зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд "Эм Эс Эл" ХХК-тай НХААГ/20225459 дугаар гэрээг байгуулж, гэрээний дагуу техник эдийн засгийн үндэслэл болон зураг төсөл батлагдаж, Барилгын хөгжлийн төвөөр магадлал хийлгэн, 2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 1139/2025 дугаартай барилга, байгууламжийн зураг төслийн магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан.	50%
190	НХТЖҮЧ-2.14.1	Хүүхдийн хөгжлийн үйлчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлэх	НХГБХХГ, МХО, МХУБТ	НТ	2023	40	Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд	хувь	45	220	Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдын авьяас чадварыг хөгжүүлэх зорилгоор урлаг, спорт, техник технологи, математик сэтгэхүй, хэл, илтгэх урлаг зэрэг 7 чиглэлийн 5,923 төрлийн өөрийн сургуулийн болон сургуулиас гадуурх дугуйлан, секц, клубт нийт 187,857 суралцагч, 1,254 суралцагчдын өөрөө удирдлагын оролцооны байгууллагад 33,593 суралцагч буюу нийт 398,437 суралцагчаас 221,450 суралцагч хичээлээс гадуурх үйл ажиллагаанд хамрагдсан бөгөөд нийт суралцагчдын 55.5 хувийг эзэлж байна. Мөн Монгол ёс заншлаас суралцах, өвлүүлэн авч үлдэх зорилгоор сурагчдын зан төлөвийн төлөвшил, уламжлалт аж төрөх ёс, үндэсний өв соёл, бахархлаа дээдэлж, түүнээс суралцахаар "Би монгол хүүхэд" ёс заншлын наадмыг нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын дунд 11 дэх жилдээ зохион байгуулсан бөгөөд 9 дүүргийн 166 сургуулийн 156,928 сурагч, 4,120 багш оролцлоо. Хүүхэд хөгжлийн үйлчилгээнд давхардсан тоогоор 319,301 хүүхэд буюу нийт хүүхдийн 52.7 хувь нь хамрагдаж өмнөх оны мөн үеэс 5,762 буюу 1.8 хувиар өссөн байна. Мөн нийслэлийн 2025 оны төсөвт Монголын Хүүхдийн ордоны урсгал зардал 1,191.6 сая төгрөг, Хүүхдийн урлан бүтээх төвийн урсгал зардал 12.3 сая төгрөг, Улаанбаатар хотын Нийтийн төв номын сангийн урсгал зардал 20.0 сая төгрөгийг, нийслэлийн 2026 оны төсөвт Монголын Хүүхдийн ордоны урсгал зардал 5,073.5 сая төгрөг, Хүүхдийн урлан бүтээх төвийн урсгал зардал 2,158.1 сая төгрөг, Улаанбаатар хотын Нийтийн төв номын сангийн урсгал зардал 3,525,0 сая төгрөгийг, Хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын хүчитгэлийн ажилд 830.1 сая төгрөгийг тус тус тусган ажилласан.	100%
191	НХТЖҮЧ-2.12.1	"Гэрлэх ёслолын ордон" ОНӨААТҮГ-ын барилгын болон дээврийн засвар хийх	ГЁО	НТ	2024	-	Засварын ажлын гүйцэтгэл	хувь	100	2,600.00	Гэрлэх ёслолын ордон ОНӨААТҮГ-ын барилгын болон дээврийн засварын зураг төсөл хийлгэх ажлыг 2025 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусган Нийслэлийн төсвийн тодотголд суулгасан ба нийт 1,6 тэрбум төгрөгөөр барилга, сантехник, цахилгааны засвар, барилгын дээвэр, танхимыг шинэчлэх зураг төслийн ажлуудын тендер шалгаруулалтын ажил зарлагдаж дууссан ба "Хаус дизайн" ХХК, "Бумт-Өргөө" констракшн ХХК-ууд тус бүр шалгарч гэрээ байгуулан, ажлуудаа гүйцэтгэсэн. Барилга, сантехник, цахилгааны засварын ажлыг гүйцэтгэгч "Бумт-Өргөө констракшн" ХХК ажлаа зураг, төсвийн дагуу 100% гүйцэтгэж, 2025 оны 10 сард хүлээлгэн өгсөн. Барилгын дээвэр, танхимыг шинэчлэх зураг төслийн ажлын гүйцэтгэл 80 хувьтай явагдаж байна. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажил 90 %-тай.	90%
192	НХТЖҮЧ-2.12.2	Багахангай дүүргийн соёлын ордны барилгыг ашиглалтад оруулах	БХДЗДТГ, НХОГ	НТ	2023	50	Барилга угсралтын явц	хувь	100	2,500.00	Дүүрэгт нийслэлийн төсвийн 4,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 5 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байгаагаас 4 төсөл арга хэмжээ нь хэвийн хэрэгжиж, Соёлын ордны барилгын ажил удаашралтай байна. Удаашралтай байгаа ажлын талаар гүйцэтгэгч "Адамант" ХХК-тай удаа дараа уулзалт зохион байгуулсан ч ажилд ахиц гараагүй тул гэрээ цуцлах шийдвэр гарсан. Дараагийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулан барилгын ажлыг хэвийн үргэлжлүүлж, ашиглалтад хүлээн авахаар ажиллаж байна.	30%
193	НХТЖҮЧ-2.14.1	Монголын Хүүхдийн Урлан бүтээх төвийн барилгын бүрэн хүчитгэл болон Их танхимын засварын ажлыг гүйцэтгэх	МХУБТ	НТ	2024	-	Барилгын хүчитгэлийн ажлын гүйцэтгэл	хувь	100	2,452.10	Нийслэлийн Худалдан Авах ажиллагааны газраас тендер зарлан, Хүүхдийн Урлан Бүтээх төвийн барилгын бүрэн хүчиртгэлийн зураг, төсөв хийгдсэн бөгөөд 2024 оны 05 дугаар сарын 09-ний өдөр Барилга, хот байгуулалтын яамд, барилгын хөгжлийн төвөөс Магадлал хийгдсэн.	40%
			МХУБТ	НТ	2024	-	Их засварын ажлын гүйцэтгэл	хувь	100	300	Хүүхдийн Урлан Бүтээх төвийн урлагийн зааланд их засвар хийх зайлшгүй шаардлагатай байгаа бөгөөд одоогийн байдлаар ямар нэг засварын ажил хийгдээгүй болно. Монголын Хүүхдийн урлан бүтээх төвийн барилгын бүрэн өтгөлийн ажлын төсөв нь нийслэлийн 2026 оны төсөвт тусгагдсан. Мөн НЗД-ын 2025 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А/1175 дугаартай захирамжаар Худалдан авах ажиллагааны эрхийг шилжүүлэн авсан.	
194	МУХТЖҮЧ-2.3.3, НХТЖҮЧ-3.3.3	Хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	НСУГ	УТ	2022	24	Хамрагдсан залуучууд	хувь	30	450	1.Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх заалт, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлын хүрээнд албан хаагчид, уран бүтээлчдийг "Гадаад улс орнуудад зохион байгуулагдах соёл, урлагийн үйл ажиллагаанд оролцоход баримтлах зарчим, ёс зүй, хариуцлага", сэдэвт сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын 72 ажилтан, албан хаагч хамрагдсан. 2. Албан хаагчдыг чадавхжуулах, хөгжүүлэх, багаар ажиллахад суралцуулах зорилготой "Share Time" сургалт, мэдээллийн цагийг зохион байгуулж, 5 удаагийн сургалтад давхардсан тоогоор 60 хүн хамрагдсан байна. 3. Хувь хүний хөгжлийг дэмжих 15 төрлийн танхим, цахим хосолсон сургалтад давхардсан тоогоор 350 гаруй албан хаагчид сургалтад хамрагдсан байна.	100%

195	МУХТЖҮЧ-2.3.4, НХТЖҮЧ-3.3.4	Зорилтот бүлгийн залуучуудын амьдралын чанарыг сайжруулах, нийгэмшүүлэх, хөгжлийг дэмжих арга хэмжээг авч хэрэгжүүлэх	НСУГ	УТ	2022	854	Хамрагдсан залуучууд	тоо	900	450	1. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын 2025 оны 79 дүгээр тушаалаар Монголын уламжлалт сар шинийн баярыг угтан зорилтот бүлгийн ахмадуудад, Олон Улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан зорилтот бүлгийн эмэгтэйчүүдэд, Орчин цагийн зэвсэгт хүчин үүсгэн байгуулагдсан өдөр буюу Монгол цэргийн өдрийг тохиолдуулан зорилтот бүлгийн залуучуудад тус тус зориулан соёл, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж нийт 1384 хүнийг хамруулсан. 2.Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран “Анзаар-2” аяны хүрээнд нийслэлийн харьяа Соёл, урлагийн байгууллагуудын уран бүтээлчид, соёлын ажилтнууд, ажилтан, албан хаагчид, нийслэл Улаанбаатар хотод үл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн урлагийн байгууллага, соёл, урлагийн байгууллага, студи, продакшны уран бүтээлчдийг оролцуулсан “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нөхцөл байдал, хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт сургалтыг зохион байгуулж, 150 хүн хамрагдаж, мэдээлэл авсан. Нийслэлийн Соёл, урлагийн газар 2025 оны 12 сарын 03-ны өдөр буюу Олон улсын Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан хөгжлийн бэрхшээлтэй иргэд, түүний асран хамгаалагчдад зориулан тэдний нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, амьдралын эрч хүч, урам зоригийг бадраах, сэтгэлийн дэм өгөх зорилгоор Соёлын тэргүүний ажилтан дуучин Т.Аминагийн сайн үйлсийн тоглолтыг үнэ төлбөргүйгээр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна. Тоглолтод нийслэлийн Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн 1500 хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэдний асран хамгаалагчид оролцох юм.	100%
196	НХТЖҮЧ-2.13.1	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эх, олон нийтэд хүүхэд хүмүүжлийн эерэг аргыг түгээн дэлгэрүүлэх нөлөөллийн ажил зохион байгуулах	НЗДТГ-НБГ	УТ, НТ	2023	20,380	Хамрагдсан хүн	тоо	45,000	230	Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор сургалт нөлөөллийн 12 арга хэмжээ зохион байгуулж, 928 иргэн, албан хаагчийг хамруулж, цахимаар 12,958 хүнд хүрсэн байна. Гэр бүлийн боловсрол олгох, хүүхэд хүмүүжүүлэх эерэг аргыг түгээх, гэр бүлийн хөгжлийг дэмжих зорилготой 12 арга хэмжээ зохион байгуулж 5,277 иргэн албан хаагчийг хамруулж цахимаар 207,415 хүнд хүрсэн байна. Гэр бүлийн боловсрол олгох сургалт, соён гэгээрүүлэх сурталчилгаа, нөлөөллийн 6 төрлийн 49 үйл ажиллагаа зохион байгуулсан. Нийслэлийн хэмжээнд нийт 16 байгуллага хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаагаас 10 түр хамгаалах байр, 6 нэг цэгийн үйлчилгээний төв үйл ажиллагаа явуулж байна. Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй давтамжтай дуудлага мэдээлэл ирүүлдэг 470 хаяг, холбогдогч этгээдийн судалгааг гаргаж, 17 хорооны Засаг дарга, хамтарсан багт албан мэдэгдлээр 2 удаа хүргүүлэн биелэлтийг тооцсон. “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, зөрчлийг шийдвэрлэх, тулгамдаж буй асуудал” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг энэ оны 05 дугаар сарын 29-ний өдөр Хүний эрхийн үндэсний комисс, дүүргийн Эрүү, иргэн хялбар ажиллагааны тойргийн шүүх, Нийслэлийн Прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Иргэний зөвлөл, Засаг даргын Тамгын газар, Хэрэг бүртгэх, Урьдчилан сэргийлэх алба, дүүргийн цагдаагийн газар, хэлтсийн алба хаагчид болон төрийн бус байгууллагын төлөөлүүд оролцуулан зохион байгуулсан. Нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудаас “Сайн хөрш” нөлөөллийн арга хэмжээний хүрээнд эрсдэлт бүлгийн 486 айл өрхийн судалгаа гарган биечлэн хяналт тавьж, Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын хэлтсүүдтэй хамтран нийт 316 иргэнийг хамтарсан багт холбон зуучилж шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлж, сэтгэл зүй, хууль эрх зүйн зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан. Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа хэлтсүүдээс хорооны хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах чиглэлээр нийт 40 удаагийн сургалт, 17 төрийн болон төрийн бус байгууллагад 102 удаагийн сургалтыг тус тус зохион байгуулж, Хүчирхийллийг үл тэвчих нийгмийн хандлагыг төлөвшүүлэх зорилгоор 360 удаагийн сургалт, соён гэгээрүүлэх ажил зохион байгуулж, 41,778 иргэн, 75,624 сурагч, 1,996 оюутныг хамруулсан.	100%
197	НХТЖҮЧ-2.14.4	Архины хамаарал бүхий өрхийг нийгмийн суурь үйлчилгээнд холбон зуучилж, сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээг үзүүлэх	НЗДТГ-НБГ	УТ	2023	772	Хамрагдсан өрх	тоо	1,500	120	Архины хамаарал бүхий өрхийг нийгмийн суурь үйлчилгээнд холбон зуучилж, сэтгэлзүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлж, хамтарсан багаас эргэн хяналт тавьж нэг удаагийн хүнсний тусламж дэмжлэг авсан 245, ажилд холбон зуучилсан 21, архинаас татгалзсан 45, бичиг баримтжуулсан 67 өрхөд хүнсний тусламж үзүүлсэн байна. Архины хор хөнөөлийг таниулах сургалтыг 25 удаа зохион байгуулж 2,472 иргэн, нийгэм сэтгэл зүйн үйлчилгээнд 346 иргэнийг холбон зуучилж, дэмжих бүлгийн уулзалтыг 9 удаа зохион байгуулж 1,800 иргэн 686 өрхийг хамруулсан.	100%
198	НХТЖҮЧ-2.14.2, 2.14.4, 2.14.5	Хүүхдийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх аян, арга хэмжээг зохион байгуулах	НЗДТГ-НБГ	УТ, НТ	2023	27,000	Хамрагдсан хүн	тоо	40,000	240	Орчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр дээрх 4 ангиллын хүрээнд НЗД-ын 2025 оны А/237-р захирамжаар 3892 зөрчил нийслэлийн хэмжээнд илрүүлж, 1368 зөрчлийг арилгасан. Нийт зөрчлийг арилгах үүднээс НЗД-ын 2025 оны А/560-р захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж талбай дах эд хөрөнийн эвдрэл гэмтлийг засварлах, хотын сатндартыг мөрдүүлэх, орчны авулгүй байдлыг хангуулах ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүргийн нийт 204 хороо тус бүрд 50 сая буюу 10,2 тэрбэм төгрөгийн хөрөнгө оруулалтын 600 гаруй тохижилт, засвар шинэчлэлтийн ажил хийгдсэн байна. Гол, усны ослоос урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг нийслэлийн Онцгой байдлын газар, нийслэлийн Цагдаагийн удирдах газар, дүүргүүдийн Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтсүүд хамтран 98 хоногийн хугацаанд нийт 166,559 иргэдэд сэрэмжлүүлэг зөвлөмж өгч, 39,352 ширхэг тараах материал тараж, нийслэлийн нийт хүн амын 10.1 хувьд хүрч ажилласан нь өмнөх онтой харьцуулахад иргэдэд өгсөн сэрэмжлүүлэг 2 дахин өссөн, гол усны дуудлагын тоо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 46 хувиар буурсан байна.	100%
2.6 Соёлын бүтээлч үйлдвэрлэл												
199		Соёл, спорт аялал жуулчлалын "Улаанбаатар" брэнд" арга хэмжээг тогтмолжуулж, гадаад, дотоодын жуулчдыг нэмэгдүүлэх	НСУГ	НТ	2023	1	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	3	3,000.00	1.Монгол Улс, Унгар Улс хоронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд хоёр орны найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэсний соёлын үнэт зүйлсийг сурталчлах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх “Улаанбаатар хотын соёлын өдрүүд”-арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Унгар улс, Будапешт хотод зохион байгуулж, Нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид "Улаанбаатарын үдэш" хүндэтгэлийн тоглолт, Улаанбаатар музей "Нүүдэлчдийн нийслэл хот" сэдэвт түүхэн гэрэл зургийн үзэсгэлэнг дэлгэж, Монголын улсын 90 жилийн түүхтэй кино урлагийн хөгжил дэвшил, Монгол өв соёлыг харуулсан, олон төрлийн кино жанраас бүрдсэн шилдэг кино багцийн дээжийг иргэдэд үнэ төлбөргүй хүргэсэн.Тус үйл ажиллагаанд Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудаас 63 уран бүтээлч, 8 албан хаагч оролцсон. 2.Авто болон мото спорт сонирхогчдын “POWER EXPO & FESTIVAL XIII-2025” наадмыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдрөөс 11-ний өдрүүдэд Сонгинохайрхан дүүргийн Авто худалдааны төвд зохион байгуулж, нийт 5 төрлийн 18 ангилалд 7 улсын сонирхогчдын түвшний 289 тамирчин (онцлох 1 хятад тамирчин 7 настай), мэргэжлийн түвшний 73, 362 тамирчид оролцож шилдгүүдээ шалгаруулсан. Тус наадамд 3 өдрийн турш давхардсан тоогоор 50,000 гаруй залуучууд хамрагдсан. 3."Улаанбаатар биенналь-2025" дэлхийн хотууд өөрсдийн нэрээр улс орны соёлын үнэлэмж, эрэмбийг олон улсад тогтоодог, Улаанбаатар хотын брэнд үйл ажиллагаг анх удаа зохион байгуулж, ЮНЕСКО-ийн Бүтээлч хотуудын сүлжээний 7 төрлийн хүрээнд 19 байршилд 29 улсын 300 гаруй уран бүтээлчдийн 15 үзэсгэлэн, 20 гаруй соёлын нэгдсэн үйл ажиллагаг зохион байгуулж, 60,000 орчим хүнд хүргэсэн. Тус үйл ажиллагааны хүрээнд “Art week” дүрслэх урлагийн 15 үзэсгэлэн гаргаж 2025 оны 06 дугаар сарын 07-20-ны өдрүүдэд үргэлжилж давхардсан тоогоор нийт 32.880 гаруй иргэд, жуулчид үзэсгэлэнгүүдийг үзэж сонирхож, цахимаар 50 гаруй рийлс, фото, ведио контентуудыг нийтлэн 585,900 хандалт авсан байна.	100%

200	НХТЖҮЧ-1.1.1	Үндэсний агуулга шингэсэн уран бүтээлийг дэмжих	НСУГ	НТ	2023	11	Уран бүтээл	тоо	15	1,250.00	Үндэсний агуулга шингэсэн 2 уран бүтээл, 1 цуврал контентыг дэмжин ажиллаж, үндэсний урлагийг олон улсад сурталчлан ажилласан. Үүнд: 1.Хүрээ хөг" шашин, урлагийн дуулал тоглолт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр "ACA APEHA"-цогцолборт зохион байгуулж, 1,290 иргэд, 2.Нийслэлийн Улаанбаатар театртай хамтран "Хархорум" үндэсний агуулга шингэсэн шинэ уран бүтээлийг үзэгчдийн хүртээл болгохоор дэмжин ажиллаж байна. Үндэсний агуулга шингэсэн тус уран бүтээлийн зохиол бичигдсэн бөгөөд хөгжмийн найруулга хийгдэж байна. 3.Хөх дөл" төсөл, Мөнхөө" баримтат киноны нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж, 1012 хүн оролцсон. "Хөх дөл" нүүдэлчин ахуйн 20 ангит баримтат, реалити цуврал нэвтрүүлэг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн Монголын үндэсний олон нийтийн телевизээр олон нийтэд хүрсэн. Гадаад хамтын ажиллагааны хүрээнд үндэсний соёл, урлагийн үйл ажиллагааг сурталчлах ажлыг зохион байгуулсан. Тухайлбал, 1. Бүгд Найрамдах Солонгос Улсын Сөүл хотын захиргаанаас жил бүр зохион байгуулагддаг "Сөүлийн найрамдлын фестиваль" олон улсын арга хэмжээнд Улаанбаатар театрын уран бүтээлчид оролцож, Монгол Улсын үндэсний соёл, урлагийг сурталчилсан. 2.Монгол Улс, Унгар Улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд хоёр орны найрсаг хамтын ажиллагааг хөгжүүлэх, үндэсний соёлын үнэт зүйлсийг сурталчлах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх "Улаанбаатар хотын соёлын өдрүүд"-арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10-11-ний өдрүүдэд Унгар улс, Будапешт хотод зохион байгуулж, Нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолтыг 2 өдрийн турш үнэ төлбөргүй тоглуулсан. 3.Монгол улс, Польш улс хооронд дипломат харилцаа тогтоосны 75 жилийн ойн хүрээнд нийслэлийн Улаанбаатар театрын уран бүтээлчид Польш улсын нийслэл Варшав хотод үндэсний урлагийн тоглолтоо зохион байгуулсан. 4.Бүгд Найрамдах Солонгос Улсын соёлын хот болох Гванжу хотод 2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрөөс 23-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Дурсамж-2025" фестивальд Нийслэлийн харьяа Соёл, урлагийн байгууллагуудын 18 уран бүтээлч, албан хаагчид үндэсний урлаг, өв соёлоо таниулан оролцсон.	100%
201		Соёлын биет бус өвийн мэдээллийн сан үүсгэх, үгийн бичиг хөтлөлтийг дэлгэрүүлэх, номын сангийн баяжилтыг хийж, иргэдэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх	НСУГ	НТ	2023	1,100	Хэвлэмэл, цахим ном	тоо	3,000	50	"Улаанбаатар хотын нийтийн төв номын сан, салбар 4 номын сан, алслагдсан 3 дүүргийн соёлын ордны номын сангууд 2025 оны байдлаар нийт 628 нэрийн 1864 ширхэг 17.801.800 төгрөгийн номын баяжилт хийснээс 586 нэрийн 1688 ширхэг 11.646.800 төгрөгийн номыг бэлэг хандиваар, 42 нэрийн 176 ширхэг 6.154.900 төгрөгийн номыг худалдаагаар авч фондын баяжилт хийсэн байна. Нийслэлийн харьяа Улаанбаатар хотын нийтийн төв номын сан нь цахим каталогт 275 нэрийн 714 ширхэг номын каталогийн мэдээллийг оруулж ажилласан. Үндэсний номын нэгдсэн санд хадгалагдаж буй 1955-1990 он хүртэлх Улаанбаатарын мэдээ сонины 3,866 дугаарын 15,785 нүүр, хуудсыг цахим хэлбэрт шилжүүлж дууссан. 100%	85%
			НСУГ	-	2023	-	Үнэмлэхжүүлсэн өв	тоо	100	-	Нийслэл 9 дүүргийн харьяат соёлын биет бус өвийн өвлөн уламжлагчдын мэдээллийг 7 ай савын хүрээнд нэгтгэн гаргаж, Соёлын биет бус өв, түүнийг өвлөн уламжлагчийн улсын нэгдсэн бүртгэлийн lch.mongoluv.mn программд 1014 өвлөн уламжлагчдын мэдээллийг байршуулсан. 100%	
			НСУГ	-	2023	10	Үгийн бичиг хөтөлдөг өрх	хувь	20	-	Баянзүрх Дүүргийн Засаг даргын Тамгын газраас зохион байгуулсан төрийн байгууллагын ажилтнуудыг хамруулсан "Үгийн бичиг хөтлөх онол, арга зүй" сэдэвт сургалтад дүүргийн 830 албан хаагч хамрагдсан. Чингэлтэй дүүргийн Соёлын ордноос "Үгийн бичиг хөтлөх арга зүй"-ийн сургалтыг 2025 оны 03 дугаар сарын 27-ноос 04 дүгээр сарын 04-нийг хүртэл 10 удаа зохион байгуулж 480 иргэнийг хамруулж гарын авлага тарааж сургалтаар 1,230 иргэд үгийн бичгээ хөтөлж хэвшсэн. Нүүдэлчин дэлхийн соёлын фестивальд Үгийн бичиг хөтлөх арга ухаан төрлөөр доктор Ш.Биндэръяа оролцож Нийслэлийн язгуур урлагийн өргөөнд иргэнд олон нийтэд үгийн бичиг хөтлөх арга ухааныг таниулах ажлыг зохион байгуулсан бөгөөд тус өргөөгөөр 100,000 гаруй иргэд, залуучууд, жуулчид зочилсон. 50% *(шалгуур үзүүлэлтийн дагуу тайлагнаагүй)*	
202		Хотын соёл зорилтот үйл ажиллагааг зохион байгуулах	НСУГ	НТ	2023	10	Шинээр нэмэгдсэн контент	тоо	5	200	Хотын соёлыг түгээн дэлгэрүүлэх, иргэдэд хотын соёлыг төлөвшүүлэх чиглэлээр 2025 онд 3977 арга хэмжээ зохион байгуулж, 529.073 хүнд хүргэсэн. Цахимаар 718 контент түгээж, 964,720 хандалт авсан байна. Үүнд: 1.Нийслэлийн нутаг дэвсгэрт харьяалагдах соёл, урлагийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагууд 2025 онд 3977 сургалт, багц ажил, урлаг соёлын үзвэр үйлчилгээг 529,073 иргэнд хүргэж ажилласан. 2."Хотын соёл" нэгдсэн үйл ажиллагааны хөтөлбөрийг Нийслэлийн Бодлогын судалгаа, шинжилгээний төвийн арга зүйн дэмжлэгтэйгээр боловсруулж, "Хотын соёл"-ыг төлөвшүүлэх асуудлаар 148 байгууллага, иргэнээс санал авч нэгтгэн, 2025-2028, 2028-2040 он хүртэлх үйл ажиллагааны төлөвлөлт, зардлын тооцоолол, үр дүнгийн зураглал гаргаж Нийслэлийн удирдах ажилтнуудад танилцуулсан. 3."Хотын соёл"-ыг төлөвшүүлэх, нийслэлийн иргэдэд соёлын боловсрол түгээх нөлөөллийн арга хэмжээг "Соёл түгээе" ириан дор "Соёлын орон зай бидний орчин" нэртэйгээр бүтээлч аян болгон зарлаж, нийслэлийн 300 гаруй байгууллагууд нэгдэн 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд 221 үйл ажиллагаат зохион байгуулж 58,416 иргэн, залуучуудыг хамруулж, 718 постер, рийлс, контентыг бэлтгэн цахимаар түгээж, 964,720 хандалт, үзэлтийг авсан. 4.Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/727 дугаар захирамжаар "Монгол хүүхдүүд" Олон улсын хүүхдийн баярын урлагийн тоглолтод "Хотын соёл"-ыг түгээгч хүүхдүүдийн дүрийг бүтээж, "Соёлын түлхүүр"-ээр бяцхан хүүхдүүд нийслэлийн иргэд, эзэж аав, ах эгчээ, найзуудаа хотын соёлд уриалсан. Түүнчлэн гэр бүл, хүүхдүүдэд соёлын боловсрол олгохоор байгуулсан 6 хотхонд "Хотын соёл"-ыг сурталчлах соёлын боловсролын хөтөлбөрийг явуулж, давхардсан тоогоор 8250 хүнд хүргэсэн байна.	100%
203		"Бүтээлч хот" төслийг хэрэгжүүлэх	НСУГ	НТ	2023	5	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	10	1,000.00	"Бүтээлч хот" төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах 10 багц ажлыг зохион байгуулан Соёлын бүтээлч үйлдвэрлэлийн тэргүүлэх 6 чиглэлийг хөгжүүлж, иргэдийн соёлын боловсрол, бүтээлч хандлагыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна. 1.Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн суурь судалгааг гаргаж нийт 1787 иргэнийг судалгаанд хамруулж, Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн 6 модуль, 10 агуулга бүхий цахим болон танхим сургалт, сургалтын контентыг боловсруулан 7100 хүнд, цахимаар 35,500 хүнд нийт 42,600 хүнд хүргэн ажилласан. 2."Соёлын биет бус өвийн 7 ай сав"-ын хүрээнд соёлын биет бус өв, соёлын боловсролын хөтөлбөрийг таниулан сурталчлах, арьс, эсгий урлал, үндэсний хувцасны оёдол сурталчлан таниулах, язгуур соёлоо өвлүүлэн уламжлуулах зорилгоор Улаанбаатар хотын харьяат шилдэг гар урлаачид, уран бүтээлчдийн нийт 16 шавь сургалтыг 2,522 хүүхдийг хамруулан зохион байгуулсан. 3.Соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгч байгууллага, иргэдийн үйл ажиллагаа, амжилтыг олон нийтэд сурталчлан таниулж, урамшуулах зорилгоор "Бүтээлч хот" уралдааныг зохион байгуулсан. 4.Гадаад улс орнуудад зохион байгуулагдах гар урлал, ардын урлагийн уралдаан, наадам, фестиваль, үйл ажиллагаанд Улаанбаатар хотын харьяат урлаачид, уран бүтээлчдийг оролцуулахад 125 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан байна. 5. Нийслэлийн Засаг даргын ивээл дор "Азийн хотуудын ардын урлаг, гар урлалын наадам"-ыг Д.Сүхбаатарын талбайд жил бүр зохион байгуулж байна. 6."Бүтээлч Улаанбаатар" брэндинг, логог мэргэжлийн байгууллагатай хамтран бүтээж, иргэд, олон нийт, гадаад, дотоодын жуулчдад таниулах, сурталчлах 3 контент бүтээсэн. 7.Соёлын бүтээлч үйлдвэрлэлээс "медиа арт" урлагийг тэргүүлэн хөгжүүлэхэд анхаарч Бүтээлч хотуудын сүлжээнд соёл, урлагийн олон төрлөөр манлайлдаг БНСУ-ын нэр уран бүтээлч И Нам-ын "Тал нутгийн гэрэл" медиа арт үзэсгэлэнг монголын түүх, өв соёл, уламжлалыг харуулсан 3 контентыг ардын урлагийн "Бэртэ" хамтлагийн уран бүтээл, хөгжмийн аялгуутай хамтатган бүтээж, Чингис хаан музейд 14 хоногийн турш гаргаж, 7285 хүнд хүргэсэн. 8."Улаанбаатар хотын соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчдийн зөвлөлдөх уулзалт"-ыг 2025 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр зохион байгуулсан бөгөөд 300 гаруй соёлын бүтээлч үйлдвэрлэл эрхлэгчид оролцож, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх, дэмжих, эдийн засгийн эргэлтэд оруулах зэрэг асуудлаар саналаа солилцлоо.	100%

204	НХТЖҮЧ-1.2.1	"Улаанбаатар" олон улсын кино наадам, Сонгодог урлагийн гала фестивалийг зохион байгуулах	НСУГ	НТ	2023	4	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	6	250	1. 17 дахь удаагийн “Улаанбаатар” олон улсын кино наадам 2025 оны 10 дугаар сарын 08-15-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Тус наадамд дэлхийн нэр хүндтэй Канн, Берлин, Венец, Торонто, Локарно, Вижн дю Рийл зэрэг наадмуудаас шагнал хүртсэн болон уралдаант хэсэгт сонгогдсон Иран, Франц, Герман, Бразил, Норвег, Хятад, Исланд, Литва, Финланд, Итали, Австрали, Швейцар, Куба, Унгар, Япон зэрэг 17 орны 24 киноны нийт 42 удаагийн үзвэрийг 5,000 орчим гадаад, дотоодын үзэгчдэд 2 театраар дамжуулан толилуулж, үзэгчдийн кино урлагийн талаарх мэдлэг, танин мэдэхүйг дээшлүүлэв. Мөн наадмын шилдгүүдийг шалгаруулах “Хангарди” монгол уралдааны шилдэг эмэгтэй гол дүрээр О.Дөлгөөн, “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, шилдэг эрэгтэй гол дүрээр Т.Нямдорж, “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, шилдэг зураачаар Н.Болор-Эрдэнэ, “ТАТАР” УСК, шилдэг зураглаачаар Г.Гүенбаатар, “ТАТАР” УСК, шилдэг зохиол: “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, Р.Эрхэмбүрэн, А.Баттүшиг, шилдэг продюсерээр Продюсер Наранбаатар, “В1 ДАВХАР” УСК, шилдэг найруулагчаар Найруулагч Ж.Сэнгэдорж, “ЧИМЭЭГҮЙ ХОТЫН ЖОЛООЧ” УСК, Шилдэг уран сайхны кино: “ГУРАВ ДАХЬ ЦОХИЛТ” УСК, шилдэг баримтат киногоор “Шувуулахуй”, мөн наадмын үеэр хамгийн олон хүнд таалагдсан киног цахим санал хураалтаар тодруулан “Үзэгчдийн нэрэмжит шагнал” олгодог ба энэ жил тус шагналыг найруулагч Батаагийн Энхбаярын 2025 оны “Шувуулахуй” баримтат кино хүртсэн. 2. “Улаанбаатар театр”-ын гоцлол дуучин А.Наранбаатар, А.Отгонболд нарын санаачилсан “DUO TENOR” төслийн хүрээнд дэлхийн сонгодог болон мюзикл бүтээлүүдийг поп оркестртой, Монголын сонгодог дуу болон романс хэлбэрийн бүтээлүүдийг амьд хөгжимтэй хослуулсан цогц илэрхийллийг өөрсдийн дуулах ур чадварт тулгуурлан, орчин цагийн хөгжмийн найруулга, тайз дэлгэцийн шинэлэг шийдэлтэй “DUO TENOR” оператик поп концертыг 2025 оны 11 дүгээр сарын 26,27-ны өдрүүдэд зохион байгуулж 847 хүнд хүргэсэн.	100%
205		"Соёлын сэргэлт" аяныг зохион байгуулах (Соёлын эрхийн бичиг)	НСУГ	УТ	2023	8	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	10	1,000.00	Соёлын сэргэлт аяны хүрээнд Ерөнхий сайдын 2025 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр албан даалгаврын 15.1 дэх заалтын дагуу "Соёл түгээе" аяныг зохион байгуулсан. 1.Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг Соёл урлагын газрын даргын 2025 оны "Мөнгөн хөрөнгө зарцуулах тухай" А/56 дугаар тушаал, "Соёл түгээе" уриан дор "Соёлын орон зай-Бидний орчин" бүтээлч аяныг зохион байгуулах удирдамжийн дагуу тус аяныг нийслэлийн хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд 300 гаруй байгууллагыг ороцуулан 221 үйл ажиллагааг зохион байгуулж 58,416 иргэд, залуучуудыг хамруулж, 718 постер, рийлс, контентыг бэлтгэн цахимаар түгээж 964,720 хандалт, үзэлтийг авсан. 2."Монгол бахархал" уриатай "Соёлын бүтээлч сар-2025" аяныг нийслэлийн хэмжээнд 2025 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс 11 дүгээр сарын 30-ны өдрүүдэд зохион байгуулсан. Тус аянд нийслэлийн харьяа Соёл, урлагийн 11 байгууллага нэгдэж соёлын өв, урлаг, уран бүтээл, соён гэгээрэл, боловсролын хөтөлбөр зэрэг чиглэлүүдээр 36 үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулж 16,381 иргэд, залуучуудыг хамруулж, 503,815 цахим хандалтыг авсан.	100%
206		Монгол соёлын ижилсэл, ондоошлыг илэрхийлсэн, уран бүтээл, уран бүтээлчийг дэмжиж "Авьяаслаг, бүтээлч нийслэлийн иргэнийг төлөвшүүлэх" хөтөлбөр хэрэгжүүлэх	НСУГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	750	1.Улаанбаатар хотын “Бүжгийн спортын аварга” шалгаруулах 21 дэх удаагийн тэмцээн 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж мэргэжлийн бүжгийн спортын холбооны гишүүн клубууд болон ерөнхий боловсролын сургуулиудын бүжгийн хамтлагуудаас бүрдсэн 14 байгууллагын 800 гаруй бүжгийн спорт сонирхогч, хичээллэгчид оролцож, шилдгүүдээ тодруулсан. 2. “Хөх дөл” төсөл, Мөнхөө” баримтат киноны нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж, үйл ажиллагааг танхимаар 1012 хүн үзэж, төслийн талаарх 13 видео, танилцуулга мэдээллийг байгуллагын албан ёсны фэйсбүүк хуудсаар 8,820 хүн, “Аагий Номуун”, “Fam Team” фэйсбүүк хуудсаар 785,513 хүн, давхардсан тоогоор нийт 794,333 хүнд дамжуулан хүргэж, мэдээллийгн 40 вебсайт, 3 телевизээр олон нийтэд түгээсэн. 3.Нийслэлийн иргэдэд зориулж, үнэ төлбөргүй хүргэсэн" Улаанбаатар хотын циркийн өдрүүд 2025” үйл ажиллагаат 2025 оны 04 дүгээр сарын 16-22-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд үнэ төлбөргүй зохион байгуулж, циркийн тоглолтод циркийн 12 хамтлагийн 230 гаруй уран бүтээлчид оролцож,7 хоногийн турш 21 удаа тоглосныг нийт 27,900 хүн төв талбайн асарт цуглаж үзсэнээс хүүхэд 13,100, насанд хүрэгчид 16,800, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 600 байв.	100%
207		Д.Лувсаншаравын нэрэмжит “Хүүхдийн найрал дууны 31 дэх удаагийн наадам"-ыг зохион байгуулах	НСУГ	НТ	2023	5	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	6	300	2025 оны 03 дугаар сарын 26-ны өдөр Улсын Хүүхэлдэйн театрт “Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны 31 дэх удаагийн улсын уралдаант наадмын мастер сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Улаанбаатар хотын ерөнхий боловсролын сургуулийн 116 багш танхимаар оролцож, хөдөө орон нутгаас ерөнхий боловсролын сургуулийн 312 багш цахимаар оролцсон. Мөн 14 аймагт Монгол Улсын Хөдөлмөрийн баатар, Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Лувсаншаравын нэрэмжит хүүхдийн найрал дууны 31 дэх удаагийн улсын уралдаант наадмын анхан шатны шалгаруулалтыг зохион байгуулсан. Нийслэл Улаанбаатар хотын өдрийг угтан жил бүрийн 10 дугаар сард зохион байгуулагддаг тус наадам нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 04 дүгээр сарын 16- ны өдрийн 194 дүгээр тогтоолоор "Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдрийг жил бүрийн 6 дугаар сарын дөрөв дэх долоо хоногийн Бямба, Ням гараг”-т тэмдэглэх болсонтой холбогдуулан Нийслэлийн Иргэдийн баярыг угтан зохион байгуулах нэгдсэн үйл ажиллагааг 2026 оны хавар зохион байгуулах тухай шийдвэр гарсантай холбогдуулан тус наадмыг 2026 оны хавар зохион байгуулахаар төлөвлөж, нийслэлийн 2026 хөгжлийн төлөвлөгөөнд 350.0 төгрөгөөр тусгагдсан.	100%
208		Шинэ жилийн “Мөнгөн шөнө” баярын үйл ажиллагааг зохион байгуулах	НСУГ	НТ	2023	5	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	6	400	1.Нийслэлийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах, иргэд, олон нийтэд хүргэх зорилгоор нийслэлийн 9 дүүргийн 14 байршилд сүлд мод засаж чимэглэн, “Мөрөөдлийн мөсөн цэнгэлдэх-2025” арга хэмжээг Төв цэнгэлдэх хүрээлэнд нээлээ. Мөн “Улаанбаатар Мөнгөн шөнө-2025” арга хэмжээг 12 дугаар сарын 31-ний өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, тус арга хэмжээнд 11,000-12,500 орчим иргэн цуглаж урлаг, соёлын тоглолт, арга хэмжээг үзэж сонирхов. Арга хэмжээний үеэр 18 байгууллагын 1,800 гаруй ажилтан, албан хаагчид хамтран ажиллаж, иргэдийн аюулгүй байдал, хэв журмыг ханган ажиллалаа.	100%
209	НХТЖҮЧ-1.2.1	Бүх нийтийн соёлын боловсрол, нийгмийн харилцааны соёлыг төлөвшүүлэх цогц ажлууд, нөлөөллийн аян зохион байгуулах	НСУГ	УТ	2023	2	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	8	500	Бүх нийтийн соёлын боловсролыг төлөвшүүлэх хүрээнд "Хөх дөл" зорилтот төсөл, "Улаанбаатар хотын циркийн өдрүүд -2025" , Анзаар-2 аян, Соёл түгээе аян, Соёлын бүтээлч сар аян, Номын баяр, Утга зохиолын -7 хоног аян, К-М хөгжмийн наадам зэрэг 8 цогц үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. 1. Монгол ахуй, хэл соёл, өв уламжлал, зан заншлаа хойч үедээ өвлөн уламжлуулах, түгээн дэлгэрүүлэх, гэр бүлийн халуун дулаан уур амьсгал, нийгмийн харилцааны соёлыг төлөвлшүүлэх зорилгоор бүх насныханд зориулсан “Хөх дөл” нүүдэлчин ахуйн 20 ангит баримтат, реалити цуврал нэвтрүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс Монголын үндэсний олон нийтийн телевизийн бүх сувгаар олон нийтэд хүргэсэн. 2. Улаанбаатар хотын циркийн өдрүүд 2025” арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 16-22-ны өдрүүдэд Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулсан. 3.Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газартай хамтран “Анзаар-2” аяны хүрээнд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нөхцөл байдал, хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт сургалтыг зохион байгуулав. 4.Соёл түгээе уриан дор "Соёлын орон зай бидний орчин" бүтээлч аянд нийслэлийн 300 гаруй байгууллагууд нэгдэж 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 11 дүгээр сарын 03-ны өдрүүдэд 221 үйл ажиллагааг зохион байгуулж 58,416 иргэд, залуучуудыг хамруулж, 718 постер, рийлс, контентыг бэлтгэн цахимаар түгээж 964,720 хандалт, үзэлтийг авсан. 5."Монгол бахархал" уриатай "Соёлын бүтээлч сар-2025" аяныг нийслэлийн хэмжээгээр 36 үйл ажиллагаа, арга хэмжээ зохион байгуулж 16,381 иргэд, залуучуудыг хамруулж, 503,815 цахим хандалтыг авсан. 6.“Үндэсний бичиг соёл, номын өдрүүд-2025” 37, 38 дах удаагийн номын баярыг зохион байгуулж 30 гаруй олон төрөлт ажил, арга хэмжээг зохион байгуулж 700,000 гаруй хүүхэд, залуучууд, иргэдэд хүргэсэн. 7.“Утга зохиолын 7 хоног” аяны хүрээнд “Ардын урлагийн тоглолт”-ыг дүүргүүдийн соёлын ордон, харьяа байгууллагуудын тоглолтын хөтөлбөр боловсруулж Монгол Улсын драмын театрын урд талбайд зохион байгуулж давхардсан тоогоор 1,500 гаруй иргэд, хүүхэд, залуучуудад хүргэсэн. 8.Монгол, Бүгд Найрамдах Солонгос 2 улсын дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан 2 улсын соёлыг түгээх танин мэдүүлэх зорилготой К-М хөгжмийн наадам 2025 оны 07 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд Улсын драмын эрдмийн театрын урд талбайд зохион байгуулж давхарлсан тоогоор 10,000 гаруй иргэд, жуулчдад хүргэсэн.	100%

210	Соёлын тухай хуулийн 24.1.2	Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагуудын удирдлага, албан хаагчдад зориулсан арга зүйн сургалтыг зохион байгуулах	НСУГ	УТ	2023	2	Зохион байгуулсан сургалт	тоо	3	100	1.Монгол Улсын нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 5.2, 7.1 дэх заалтыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоолоор "Соёл, урлагийн ажилтны өдөр"-ийг жил бүрийн 09 дүгээр сарын 2 дахь долоо хоногийн ням гаригт тэмдэглэн өнгөрүүлдэг. Энэхүү салбарын ажилтны өдрөөр харьяа соёл, урлагийн байгууллагын 200 гаруй албан хаагчдад салбарын стратеги төлөвлөгөө, түүнийг хэрэгжүүлэх арга зүйн сургалт, мэдээлэл өгсөн. 2. Нийслэлийн харьяа соёл, урлагийн байгууллагын албан хаагчдад зориулсан сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулж 20 гаруй захиргааны албан хаагчийг хамруулсан. 3. Нийслэлийн харьяа Соёл, урлагийн байгууллагуудын уран бүтээлчид, соёлын ажилтнууд, ажилтан, албан хаагчид, нийслэл Улаанбаатар хотод үл ажиллагаа эрхэлж буй мэргэжлийн урлагийн байгууллага, соёл, урлагийн байгууллага, студи, продакшны уран бүтээлчдийн дунд “Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын нөхцөл байдал, хор уршиг, хэрэглэсэн хүнд илрэх шинж тэмдэг, таних арга, хууль эрх зүйн хариуцлага” сэдэвт сургалтыг 3-р сард зохион байгуулж 160 гаруй уран бүтээлч, алба хаагчдыг хамруулсан.	100%
211		Нийслэлийн харьяа соёл, урлагийн салбарын шилдгүүдийг тодруулах ”Алтан Хангарди-2025” наадмыг зохион байгуулах	НСУГ	УТ	2023	2	Зохион байгуулсан сургалт	тоо	3	140	2025 оны 12 сард зохион байгуулахаар төлөвлөн удирдамж, төсөв, захирамжийн төслийг боловсруулсан. 2025 оны 12 дугаар сард 3 арга хэмжээ зохион байгуулагдана.	100%
212	НХТЖҮЧ-1.1.2	Соёлын төв өргөөг хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үйлчилгээ үзүүлэх нөхцөл бүрдсэн орчинтой болгож засварлах	НСУГ	НТ	2023	-	үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	500	2025 онд Нийслэлийн хэмжээнд соёл, урлагийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд саадгүй нэвтэрч үзвэр үзэх боломж, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор 4 байгууллага барилгын засвар, өргөтгөлийн ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд Соёлын төв өргөө “А” байрны төв хаалганы шатны хажууд налуу зам, Багануур дүүргийн Соёлын ордон хөгжлийн бэрхшээлтэй хүнд зориулсан ариун цэврийн өрөө, Улаанбаатар хотын музей налуу шат, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан ариун цэврийн өрөө, Улаанбаатар театр ОНӨТҮГ нь театрын төв хаалгаар орох хэсэгт тэргэнцэртэй иргэд зорчих зам, таних тэмдэг, Улаанбаатар нийтийн төв номын сан барилгын өргөтгөл барьж байгаа бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх орчинг бүрдүүлж, налуу зам, явган зам, ариун цэврийн өрөө, авто зогсоолын тэмдэглэгээг хамгийн сүүлийн загвар, стандартын дагуу тус тус барьж тохижуулсан байна.	100%
213		Улаанбаатар хотын музейн одоогийн барилгыг түүхэн дурсгалт хэлбэрээр сэргээн засварлах	НСУГ	НТ	2023	30	Тохижилтын ажлын явц	хувь	100	1,500.00	Түүх соёлын дурсгалыг сэргээн засварлах ажлын хүрээнд Улаанбаатар хотын музейн үзүүлэгийн танхимын засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. Засварын ажлыг дараах байдлаар зохион байгууллаа. Үүнд: 1.Хот төлөвлөлт, судалгааны институт”-тай 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдар ажлын зураг төсөл боловсруулах гэрээ байгуулж зураг төслийн ажил бүрэн хийгдэж дуусан. 2.Дээрх зураг төслийг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын Яам, Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 34/2025 дугаар барилга байгууламжийн зураг төслийн магадлалын дүгнэлт гарч магадлан бүрэн хийгдсэн. 3.Уг төслийг хэрэгжүүлэх 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн Нийслэлийн Засаг даргын А/256 дугаар захирамж гарч Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025.03.24 өдөр НХААГ/20250101603 дугаартай тендер зарлаж Гурвангис ХХК шалгаран 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс зураг төслийн дагуу засварын ажлыг эхлүүлээд 07 сарын 30-ний өдөр засварын ажлыг хийж дуусган 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн №01 дугаартай "Ажил хүлээлцэх акт" үйлдэн хүлээн авсан.	100%
214		Улаанбаатар театрын техник тоног төхөөрөмжийн шинэчлэлийг хийх	НСУГ	НТ	2023	-	үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	1,500.00	Хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор театрын тайзны гэрэлтүүлэг, дуу шумны тоног төхөөрөмжийг шинэчлэх ажлын хүрээнд Нийслэлийн худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр тендер зарласан. Тус тендерт “Электрон Техник” ХХК шалгарч “Улаанбаатар театр”-т шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх №ОН251201555 тоот гэрээний гүйцэтгэлийн дагуу “Электрон техник” ХХК нь тайзны гэрэлтүүлгийн 16 нэр төрлийн 141 ширхэг, дуу шумын 20 нэр төрлийн 103 ширхэг 399,815,000 (гурван зуун ерэн есөн мянга найман зуун арван таван мянга)-н төгрөгийн үнэ бүхий хөрөнгүүдийг 2025 оны 09 дүүэр сарын 18-ны өдрийн №01 дугаар “Тоног төхөөрөмж хүлээлцсэн акт” үйлдэн хүлээн авч 100 хувь ашиглалтад оруулсан. Театрын талаас Захиргааны ахлах мэргэжилтэн Б.Түмэндэлгэр, Тайз үйлдвэрлэлийн ангийн дарга Ц.Батцэнгэл нар хариуцан ажилласан.	100%
2.7 Хөдөлмөр эрхлэлт												
215	НХТЖҮЧ 3.4.1	Залуучуудын гарааны бизнесийг дэмжин, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	БИГ	УТ, НТ	2023	-	Гарааны бизнесийн дэмжлэг авсан залуучууд	тоо	20	1,000.00	Инновацын төвүүдэд 2025 онд сонгон шалгаруулалтаар 16 бойжигчийг шалгаруулан бойжуулан хөгжүүлж байна. Гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжин хөнгөлөлттэй зээл, тусламжид хамруулах зорилгоор зээлийн судалгааг бойжигч нараас авч хөнгөлөлттэй зээлд хамруулах боломжийг судалж 1 иргэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 30 сая төгрөгийн зээлийг 36 сарын хугацаатай авч, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх санхүүгийн боломж бүрдсэн байна. 1.Гарааны болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулан бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж нийт 2364 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан. 2.ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран “MICS-2024” хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр “Ашигласан HEV/EV батарейг дахин ашиглах/дахин боловсруулах технологийг хөгжүүлэх, ноу-хау солилцох” төсөлд Худалдаа хөгжлийн банкнаас 10,000,000 төгрөгийн дэмжлэг олгосон. 3.Хүнсний эрүүл ахуйн тулгамдсан асуудлуудыг бодит өгөгдөлд суурилан салбарын мэргэшсэн залуусаар шилдэг инновацын шинэлэг шийдлийг гаргах хакатон тэмцээнийг 3 сэдвийн хүрээнд 1 сарын турш 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Тус хакатон тэмцээнд нийт 27 баг бүртгүүлсэн бөгөөд шалгарсан 3 багт тус бүр 3 сая төгрөгийн грант олгосон. Үүний үр дүнд -Гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгч 5 иргэн аж ахуйн нэгж дэмжлэг авсан байна. -Гарааны болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулан бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж нийт 2364 иргэн, аж ахуйн нэгж хамрагдсан байна.	100%
216	НХТЖҮЧ 2.15.3,	Худалдаа үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий тусгай бүс, төрөлжсөн байршлуудад үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах бичил, жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг дэмжин ажлыг байрыг нэмэгдүүлэх	НЗДТГ-НБХ, НАЖГ	-	2023	5000	Шинээр бий болсон ажлын байр	тоо	6000	-	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих, түр ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан 20 эвент арга хэмжээ, үзэсгэлэнгийн үеэр 751 жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, үйлчилгээг гаргаж үйл ажиллагааг нь дэмжиж, 6500 гаруй хүнийг түр ажлын байраар хангагдан ажилласан. Мөн Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээний хүрээнд жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 21 аж ахуйн нэгж, иргэн 2130 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаа зохион байгуулав.	100%

217	НХТЖҮЧ 2.15.3	Дагуул хот, дэд төвүүд, паркуудад шинээр ажлын байр бий болохыг дэмжиж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй уялдуулан шаардлагатай мэргэжлээр суралцах боломжийг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах	НЗДТГ-НБХ, НХЭГ	-	2023	3500	Сургалтад хамрагдсан иргэн	тоо	5000	-	Үндсэн хэрэгжүүлэгч Нийслэлийн Хөдөлмөр халамжийн газар татан буугдсантай холбогдуулан үйл ажиллагаа хэрэгжээгүй бөгөөд биелэлт гарах боломжгүй байна.	0%
218	НХТЖҮЧ 3.1.1, 3.2.2	Гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэдийг түр хоноглуулах үйлчилгээ үзүүлж, нийгэмшүүлэх, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	НХТТ	НТ	2023	500	Хамрагдсан иргэн	тоо	400	1,600.00	Нийгмийн хамгааллын тусгай төв нь 2025 онд нийт 783 гэр оронгүй зорилтот бүлгийн иргэнийг түр хоноглох байранд хүлээн авч байрлуулан нийгмийн хамгааллын суурь үйлчилгээнд хамруулан ажилласан байна. Энэ хугацаанд 15 иргэнийг бичиг баримтжуулж, 3 иргэнийг ахмад настны асрамжид шилжүүлж, эрүүл мэндийн анхан шатны үзлэгт 715 иргэн, нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт 355, эрүүл мэндийн яаралтай тусламжид 25, архины сайн дурмын эмчидгээнд 28, эмнэлэгт хэвтүүлэх үйлчилгээнд 172 иргэнийг тус тус хамруулж, хөгжлийн сургалт 61 удаа зохион байгуулан 1825 иргэнийг (давхардсан тоо) хамруулж, сэтгэл зүйн оношилгоонд 353, ганцаарчилсан зөвлөгөөнд 343, бүлгийн зөвлөгөөнд 715 иргэн хамруулж, тогтвортой болон түр ажлын байранд 265 иргэнийг хамруулан, 31 иргэнийг бие даасан амьдралд шилжүүлэн ажилласан байна.	100%
219	НХТЖҮЧ 3.1.1, 3.2.1	Нийгмийн хамгааллын тусгай төвийн "Сургалт хүмүүжлийн төв"-ийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	НХТТ	НТ	2023	50	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	3000 /НТ/	Нийслэлийн Засаг Даргын 2025 оны А/158 захирамжаар төвийн бүтэц орон тоо, А/430 захирамжаар тоног төхөөрөмжийн шаардлагатай төсөв тус тус батлагдсан. Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газарт тоног төхөөрөмж худалдан авах тендертэй холбоотой техникийн тодорхойлолтыг боловсруулан хүргүүлснээр Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар тоног төхөөрөмж худалдан авах ажлыг зохион байгуулж, "Интерворлд" ХХК, "Чиглэл" ХХК-ууд тус тус тендерт шалгарч, тоног төхөөрөмжийн нийлүүлэлт 90%-тай үргэлжилж байна.	100%
ГУРАВ. ЭДИЙН ЗАСАГ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БОДЛОГО												
3.1 Санхүү, төсвийн зохицуулалт												
Салбарын үр дүн : Нийслэлийн төсвийн бус санхүүгийн эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.												
220	НХТЖҮЧ-4.1.1	Нийслэлийн өмчийн байр, талбайг зах зээлийн бодит үнэлгээгээр иргэн, аж ахуйн нэгжүүдэд түрээслүүлж, төсөвт төвлөрүүлэх орлогыг нэмэгдүүлэх	НӨХГ	-	2023	1,973.50	Орон нутгийн өмчийн түрээсийн орлого	сая төгрөг	2,300.00	-	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурал (НИТХ)-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор баталсан "Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам"-ын дагуу иргэд, аж ахуй нэгж, байгууллагуудтай нийслэлийн өмчийн барилга, байгууламжийн гуравласан гэрээ 306, хоёр талт гэрээ 34, Үдийн цай хөтөлбөрийн 71, нийт 411 түрээсийн гэрээг баталгаажуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, жил бүр дүгнэн ажиллаж байна. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолоор батлагдсан "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөв төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай" тогтоолд заасан түрээсийн төлбөрийн доод хязгаарын 1мкв үнэ 6,000-15,000 төгрөгөөр тогтоосон. НИТХ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчийн байр, талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах журам" дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулж Нийслэлийн өмчийн байр талбайг иргэн, аж ахуй нэгжид 1мкв талбайг 25,000-45,000 түрээслүүлж байна. 2025 оны түрээсийн жилийн орлогын төлөвлөгөөг 3,068.9 сая төгрөгөөр баталж, батлагдсан хуваарийн дагуу 2025 оны 11 дүгээр сарын 30-ний өдрийн байдлаар 2,800.0 сая төгрөг төвлөрүүлэхээс **1,779.7** сая төгрөгийг нийслэлийн төсөвт төвлөрүүлсэн. НИТХ-ын 2025 оны 25/27 дугаар тогтоолоор Соёлын төв өргөөний Г корпусын барилга Нийслэлийн өмчийн харилцааны газар (НӨХГ)-ын балансаас Соёлын төв өргөө ОНӨААТҮГ-ын баланст шилжсэн, НОСК ХК нь НӨХГ-т түрээсийн орлого төвлөрүүлэхээ зогсоон шалгаанаар нийслэлийн төсөвт төвлөрүүлэх түрээсийн орлого 835.0 сая төгрөгөөр тасархад нөлөөлсөн. Үүнээс тооцоход нийслэлийн төсөвт 314.7 сая төгрөгийн орлогыг нэмэгдүүлэн төвлөрүүлсэн.	85%
221	НХТЖҮЧ-4.1.1	Нийслэлийн хэмжээнд газар, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийг сайжруулж, татварт хамрагдалтыг нэмэгдүүлэх	НЗДТГ- СХОГ, НТатГ	-	2023	78,148.10	Газраас төвлөрүүлэх орлого	сая төгрөг	90,000.00	-	Газрын төлбөрийн төрлөөр 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 91.9 тэрбум төгрөг төлөрүүлэхээс 77.9 тэрбум төгрөг төвлөрүүлж хэрэгжилт 86.5% байна.	87.7%
				-	2023	92,204	Үл хөдлөх эд хөрөнгөөс төвлөрүүлэх орлого	сая төгрөг	100,000	-	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын төрлөөр 2025 оны 2025 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 102.0 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 88.9 тэрбум төгрөгийн татварын орлого төвлөрүүлсэн ба гүйцэтгэл 88.9% байна.	
222	НХТЖҮЧ-4.1.2,	Нийслэлийг хөгжүүлэх сан болон бусад санг үүсгэн байгуулахтай холбоотой хууль эрх зүйн орчныг судлах, бүрдүүлэх, холбогдох журмыг боловсруулж батлуулах	НӨУБХОМ ҮЦК ХХК	-	2023	-	Сан үүсгэн байгуулах бэлтгэл ажлын хэрэгжилт	хувь	50	-	Нийслэлийн Ногоон Хөгжлийн Сан Хувийн ХОС ТЗК-г байгуулан удирдаж байгаа бөгөөд Улаанбаатар хотод хэрэгжих орон сууцны төслүүдийн хөрөнгө оруулалтыг тус сангаар дамжуулан хэрэгжүүлэхээр Нийслэлийн Орон сууцны корпораци болон Улаанбаатар түншлэл төвүүдтэй харилцан зөвшилцөж, хөрөнгө оруулалтын санхүүжилтийн схемийг гаргаад байна. Мөн "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууц сан"-г Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 02/07 дугаар тогтоолоор үүсгэн байгуулж, "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууц сан"-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн "Багц журам батлах тухай" 01/03 дугаар тогтоолоор "Эко хороолол ба орлогод нийцсэн орон сууцны сан хувийн ХОС" ХХК-ийн "Дотоод хяналтын журам", "Нэгж эрх эзэмшигчдийг бүртгэх журам", "Орлогыг сангийн активт бүртгэх журам", "Зардлын зүйл, дээд хэмжээг тогтоох журам", "Орлого болон ногдол ашиг хуваарилах журам", "Эрсдэлийн удирдлагын журам", "Санг татан буулгах журам", "Ёс зүйн дүрэм ба мэргэжлийн үйл ажиллагааны стандарт", "Сангийн хөрөнгөөр барьцаалан зээл авах журам", "Гишүүдийн хурал зарлан хуралдуулах журам"-ыг тус тус баталсан. Шархад дэд төв, Баянхошуу дэд төвүүдэд нийт 4200 айлын "Ногоон орон сууцны төсөл" хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
223	НХТЖҮЧ-4.1.2,	"Нийслэлийн хөгжлийн сан", "Нийслэлийн ногоон сан", "Гарааны бизнесийг хөгжүүлэх сан", "Эрсдэлийн удирдлагын сан"-д хөрөнгө оруулалт татах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх	НӨУБХОМ ҮЦК ХХК	-	2023	3,400	Сангуудад татан төвлөрүүлэх хөрөнгө оруулалтын хэмжээ	сая төгрөг	304,000	-	2024 оны "Хөрөнгө гаргах тухай" А/762 дугаар тогтоолоор 300,000,000,000 (гурван зуун тэрбум) төгрөгийг "Нийслэлийн хөгжлийн сан хувийн ХОС ТЗК ХХК-ийн нэгж эрхийн хөрөнгө оруулалт" зардлаас гаргахыг захирамжилсан. "Нийслэлийн Ногоон Сан" нь Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын Хангарьд цогцолборын С блок буюу Green Office-ийн нийт хөрөнгө оруулалтыг арилжааны банкны эх үүсвэртэйгээр бүрдүүлэхээр НЗДТГ-тай хамтран хэлэлцээрийн шатандаа явж байна. "Нийслэлийн эрсдэлийн удирдлагын сан"-д нийслэлийн төсвөөс 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийг татан төвлөрүүлэх ажлын хүрээнд "НЭУС"-ийн дүрмийн санг нэмэгдүүлэхээр дүрмийн өөрчлөлтийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/956 дугаар захирамжаар "Нийслэлийн Эрсдэлийн удирдлагын сан Хувийн ХОС ТЗК" ХХК-ийн дүрмийн сангийн хөрөнгөд зориулсан 3,000,000,000 (гурван тэрбум) төгрөгийг санхүүжүүлэхийг зөвшөөрсөн. Нийслэлийн Гарааны бизнесийг дэмжих сан нь ШУА-тай хамтран "Инновацын ХОС" нээхээр харилцан мэдээлэл солилцож уулзалт, харилцан ажиллах санамж бичигт тусгаж болох саналуудыг боловсруулж байна.	100%

224	НХТЖҮЧ-4.1.2,	Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор үнэт цаас гаргах	НӨУБХОМ ҮЦК ХХК	-	2023	50	Үнэт цаас гаргах ажлын хэрэгжилт	хувь	100	-	1. Олон улсын аудит, хөрөнгийн үнэлгээ, бусад санхүүгийн болон мэргэжлийн зөвлөх үйлчилгээний чиглэлээр: Олон улсын аудитын байгууллагаар нийслэлийн хөрөнгийг үнэлүүлэх, гадаад улсад үнэт цаас гаргахтай холбоотойгоор аудитын зөвлөгөө авахтай холбоотойгоор 2025 оны 1-3 дугаар саруудад Улаанбаатарт байгаа EY (Ернест Янг аудит - БНХАУ-д байдаг салбарт харьяалагддаг), PwC (ПиДаблюСи Аудит - Бүгд Найрамдах Солонгос улсад харьяалагддаг), KPMG (КэйПиЭмЖи Аудит -Казакстан улсын салбарт харьяалагддаг) зэрэг аудитын байгуллагуудтай уулзаж зах зээлийн дүн шинжилгээ хийсэн. 2.Үнэт цаас гаргах ажиллагаатай холбоотой зээлжих эрхийн зэрэглэл тогтоох байгуллагатай хамтран ажиллах чиглэлээр: Олон улсын зээлжих эрхийг тогтоодог Fitch байгуллагатай ажил хэргийн цахим уулзалтыг 2025 оны 06 дугаар сард, биечилсэн уулзалтыг 2025 оны 08 дугаар сарын 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотод тус тус зохион байгуулсан. Үнэт цаас гаргахтай холбоотой зээлжих эрх олгох тус байгуллагын хамтран ажиллах болон үнийн саналыг 2025 оны 07 дугаар сарын 05-ны өдөр авсан. Fitch байгуллага нь S&P болон Moody's байгуллагаас харьцангүй бага үйлчилгээний төлбөрийг авах саналыг Монгол улсын үйлчлүүлэгчдэдээ өгдөг. Монгол улсын талаар зах зээлийн судалгааг хийж бусдаас илүү дэлгэрэнгүй бөгөөд илүү давтамжтай мэдээллийг өөрийн цахим хаягтаа тавьдаг. 3. Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтын ажиллагаа: Korea Investment & Securities Asia Limited компани нь Монгол Улсын Голомт банкны 300 сая ам долларын 3 жилийн хугацаатай, Монголын Ипотекийн Корпорацийн 225 сая ам. долларын 3 жилийн хугацаатай бондыг амжилттай гаргахад оролцсон компани юм. Тус компанитай 2025 оны 06 дугаар сарын 18-ны өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. 2025 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр үзүүлэх үйлчилгээний цар хүрээ болон үнийн саналын мэдээллийг бичгээр авсан. Гадаад бонд гаргах төслүүдэд санал авч хууль эрх зүйн орчныг судлан, Төр хувийн хэвшлийн түншлэлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
225	НХТЖҮЧ-4.1.7	Улаанбаатар хотын нийгэм эдийн засаг, санхүүгийн үндсийг бүрдүүлэх зорилгоор байгалийн баялгийн үр өгөөжид тулгуурласан шинэ хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг бий болгох	УБХК ХК	-	2022	20	Бэлтгэл ажлын хэрэгжилт	хувь	30	-	1.Улаанбадрах 300МВт Цахилгаан станц барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ)-ийг боловсруулж ЭХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурал, Эрдэнэс Монгол нэгдлийн Технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулав. 2. Ил уурхайн төслийн ТЭЗҮ-ийг Эрдэнэс Монгол нэгдлийн Технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэв. Төслүүдийн ажил эхэлж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдэж дуусаад байна. 3.Гидрогеологийн хайгуул судалгаа дээжлэлтийн ажил эхэлж геофизикийн судалгааны ажил дууссан, эрлийн 1 цооног өрөмдсөн. 4.Ашигт малтмал ашиглах тусгай зөвшөөрлийг 2025 оны 07 дугаар сарын 22-нд авав. 5.Компанийн зээмшлийн тусгай зөвшөөрөл тус бүрд нөөцийн хуваалт болон талбайн хил хязгаар тогтоох шав тэмдэгтийн ажил хийлгэж Ашигт Малтмал, Газрын тосны газар (АМГТГ)-аар батлуулав. 6.Улаанбадрах сумын 2-р баг болон сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал (ИТХ)-д төслийн танилцуулгыг хийж, төсөл хэрэгжүүлэх газар эзэмших хүсэлтээ сумын ИТХ-д хэлэлцүүлж татгалзсан хариу авсан. 7. ТЗ-тэй холбогдолтой тайлан төлөвлөгөө харьяа байгаль орчны газруудаар батлуулав. 8. Улаанбаатар түншлэл төв ХХК-аар төсөлд урьдчилсан үнэлгээ хийлгэв. 2025 оны 06 дугаар сарын 03-ны УУ25/03 дүгнэлтээр Төр хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх боломжтой үнэлгээ гарсан. Бүрэн шинжилгээ хийлгэхээр ажиллаж байна. 9.Гадны хөрөнгө оруулагчдыг татах зорилгоор БНХАУ-н Бээжин хот, Бугат муж, Улаанбаатар хотуудад хөрөнгө оруулагчидтай танхимын болон цахим уулзалт хийн ажиллав. Мөн Улаанбаатар хот дахь өөрийн байранд БНЧУ, БНХАУ, Азарбайжан, БНСУ зэрэг улсуудын элч төлөөлөгчидтэй уулзалт танилцуулга хийв. БНХАУ-ын "China Gas" LLC-тэй уулзалт зохион байгуулж харилцан санал солилцон ажиллаж байна.	100%
226	НХТЖҮЧ-4.6.1	Гадаад харилцаат хотуудтай хамтарсан арга хэмжээг зохион байгуулж, талуудын худалдаа, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, аялал жуулчлал, хүмүүнлэг зэрэг бүхий л салбарын бодит хамтын ажиллагааг өргөжүүлэх	НЗДТГ- ГХХАГ	НТ	2023	2	Харилцаат хотуудтай хамтран зохион байгуулах арга хэмжээ	тоо	1	650	Гадаад харилцаат хотуудтай хамтарсан 6 арга хэмжээг зохион байгуулж ажилласан.Үүнд: 1.ОХУ-ын БНБурУ-ын тэргүүн А.С.Цедынов тэргүүтэй 34 хүний бүрэлдэхүүнтэй айлчлалыг 03 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо хүлээн авсан. 2.Бүгд Найрамдах Киргиз Улсын Бишкек хотоос 20 гаруй нэр төрлийн хүнс, бараа, материалыг худалдан авах, Улаанбаатар хотод хоолны өдөрлөг зохион байгуулав. 3.БНХАУ-ын олон хүний багтаамж бүхий хөдөлгөөнт асар, сандалыг худалдан авах ажиллагааг зохион байгуулж, Улаанбаатар хотод авчрах ажлыг гүйцэтгэв. 4.Улаанбаатар хот, Унгар Улсын Будапешт хотуудын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд "Улаанбаатарын өдрүүд" арга хэмжээг Будапешт хотуудод зохион байгуулсан. 5.Европын өдөрлөг 2025 арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин оролцох арга хэмжээг зохион байгуулав. 6.Нийгмийн бодлогын газрын дарга Ш.Анхмаа тэргүүтэй "Улаанбаатар театр" ОНӨТҮГ-ын уран бүтээлчид (12 хүн) 2025 оны 05 дугаар сарын 22-ны өдрөөс 26-ны өдөр БНСУ-ын Сөүл хотод албан томилолтоор ажиллалаа. 7.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 30-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо ажиллаж, тус хотын дарга Ин Юнтай уулзлаа. 8.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар БНСУ-ын Гёнсаннам-до аймгийн Захирагч Пак Ван Сү тэргүүтэй 30 гаруй төлөөлөгчдийг 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр хүлээн авч уулзаж, нийслэлд хэрэгжих 24 мега төслийг танилцуулж, цаашид хамтарч ажиллах боломжийн талаар санал солилцов. 9.Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Шанхай хотын орлогч дарга бөгөөд Нийгмийг аюулаас хамгаалах товчооны дарга Жан Яхун тэргүүтэй 6 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг Улаанбаатар хотноо хүлээн авч уулзаж, талууд хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурав.	100%
227	НХТЖҮЧ-4.6.2	Зүүн хойд Азийн Хотын дарга нарын 7 дахь удаагийн форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах	НЗДТГ- ГХХАГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	50	450	Зүүн хойд Азийн Хотын дарга нарын 7 дахь удаагийн форумыг Улаанбаатар хотноо зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд цахим веб сайтыг шинэчлэх хүсэлтийг Азийн санд хүргүүлсэн. Тус арга хэмжээ нь 2 жилд нэг удаа зохион байгууллагдах бөгөөд 2026 онд цөлжилттэй тэмцэх тухай Нэгдсэн Үндэстний Байгууллагын Конвенцын Талуудын бага хурлын 17 дугаар хуралдаан (COP17) 2026 оны 08 дугаар сарын 17-28-ны өдрүүдэд Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод болохтой холбогдуулан Хотын дарга нарын хурлыг нэгдсэн байдлаар хийх ажлын бэлтгэлийг ханган ажиллаж байна.	100%
228	НХТЖҮЧ-4.1.5	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний худалдан авалтыг нэмэгдүүлэх	НЗДТГ-СХОГ, НХААГ, ННЗБ-ууд	-	2023	3	Дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тухайн жилийн худалдан авалт	хувь	11	-	Нийслэлийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар нийт 16,958,854,627,434 (арван зургаан их наяд есөн зуун тавин найман тэрбум найман зуун тавин дөрвөн сая зургаан зуун хорин долоон мянга дөрвөн зуун гучин дөрөв) төгрөгийн батлагдсан төсөвт өртөгтэй, тухайн онд санхүүжих 5,600,634,362,929 (таван их наяд зургаан зуун тэрбум зургаан зуун гучин дөрвөн сая гурван зуун жаран хоёр мянга есөн зуун хорин ес) төгрөгийн санхүүжих дүнтэй 1748 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс 259 төсөл, арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 90 дүгээр тогтоолоор батлагдсан "Дотоодын үйлдвэрээс худалдан авах чанар стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай барааны жагсаалт"-д заасан бараанаас нутгийн захиргааны 51 байгууллага дотоодын үйлдвэрлэгч 155 байгууллагаас бараа бүтээгдэхүүний ерөнхий ангиллын 16 нэр төрлийн 93,111,570,510.0 (ерэн гурван тэрбум нэг зуун арван нэгэн сая таван зуун далан мянга таван зуун арван) төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг худалдан авсан байна. Энэ нь тухайн жилийн зорилтот түвшний 11 хувьд хүрсэн байна.	100%
3.2 Үйлдвэрлэл, технологийн парк												
Салбарын үр дүн : Үйлдвэрлэл, технологийн паркийн бүтээн байгуулалтын ажлыг 40 хувьд хүргэнэ.												

229	НХТЖҮЧ-4.3.3 ~~(МУЭЖТ-1.2.3.3)~~	Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн үйлдвэрүүдийг дэд бүтцээр хангах	НБМҮТП	УТ	2023	-	Дулаан хангамжийн барилгын ажлын гүйцэтгэл	хувь	100	14,300.00	Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд хоногт 1000мкуб хүчин чадалтай цэвэрлэх байгууламж, Паркийн 120 га газрын 10.3 км дотор авто зам, 7.06 км гадна авто зам, 26 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц барих, Төв аймгийн Баян зөрлөгөөс паркийг холбох 11,7 км төмөр зам тавих ажлууд тусгуулаад байна. Дулааны станц барих хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэхээр Монгол Улсын 2026 оны төсөв Монгол Улсын 2025-2028 оны улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулахаар саналаа хүргүүлсэн. ХББОС-ын яаманд дэд бүтцийн ажлын хөрөнгө оруулалтыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд эдийн засаг, хөгжлийн сайд Л.Гантөмөрт гадна цахилгаан хангамжийн зураг төсөв боловсруулах хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр албан бичиг хүргүүлсэн. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлээгүй байна. Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв-ын 60 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлын хүрээнд Хот байгуулалт, Хотын стандартын газрын 2026 оны зураг төсвийн төлөвлөгөөнд тусгуулсан.	85%
			НБМҮТП	НТ	2023	-	Цэвэрлэх байгууламж, ариутгах татуурга барих ажлын гүйцэтгэл	хувь	50	2,663.00		
	НХТЖҮЧ-4.3.3		НБМҮТП	НТ	2023	-	Гадна цахилгаан хангамжийн зураг төсөв хийх ажлын явц	хувь	100	110		
			НБМҮТП	НТ	2023	-	Бөөний болон жижиглэн худалдааны төвийн төлөвлөлтийг /ХЕТ/ боловсруулах ажлын явц	хувь	100	210		
230	НХТЖҮЧ-4.3.3	Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн Ерөнхий цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих	БНҮТП	НТ	2023	-	Ажлын гүйцэтгэл	хувь	50	4,955.80	Паркийн цахилгаан хангамжийн хүрээнд 110/35/10кВ-ын 2х16МВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын хүрээнд нийт төсөв 9,911.6 сая төгрөг бөгөөд Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 50% буюу 4,955.8 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 1,048.9 сая төгрөг тусгагдаж дараах шатанд ажил явагдаж байна. 1.Цахилгаан хангамжийн 110/35/10кВ-ын 2х16мВА чадалтай үндсэн дэд станц барих ажлын 1,048.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын эрхийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/430 дугаар захирамжаар Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлсэн. 2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нээгдэж оролцогч 3 байгууллагууд шаардлага хангаагүй тул Багануур үйлдвэрлэл технологийн паркийн дэд станцын ажил, 110/35/10кВ-ын НХААГ/20250101634/02/01 урилгын дугаартай тендерийг 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдөр хүртэл дахин зарласан.	85%
231		Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг барих	БНҮТП,НХОГ	НТ	2023	-	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	60	1,740.00	1.Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн захиргаа, нэгдсэн үйлчилгээний төвийг худалдан авах 700.0 сая, засвар хийж ашиглалтад оруулах 2,329.0 сая, нийт 3,029.0 сая төгрөгийн төсөвтэй ажил юм. Нийслэлийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөөнд 60% буюу 1,740.0 сая тусгагдсан боловч Нийслэлийн 2025 оны төсөвт 700.0 сая төгрөг тусгагдсан. Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2025 оны төсвийн жилд хэрэгжүүлэхээр тусгагдсан “Захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилга худалдан авах ажлыг НХОГ-т 2025 оны 02 дугар сарын 06-ны 36 дугаар албан бичгээр хүсэлтээ уламжилсан боловч төсвийн тодотголоор дахин хэлэлцэгдэж хасагдсан тул уг арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон. 2.Нийслэлийн Засаг даргын 2019 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн А/619 дүгээр захирамжаар Паркийн “захиргаа, нэгдсэн үйлчилгээний төв”-ийн барилгын зураг төслийн 35.0 сая төгрөгийн санхүүжилт шийдвэрлэгдэж “Нутаг консалтинг” ХХК нь зураг төслийг гүйцэтгэж 2020 онд хүлээлгэн өгсөн. Тухайн барилгыг барихад шаардлагатай 2,454.2 сая төгрөгийг нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар бэлтгэж зураг төслийн төсөв шинэчлэх хүсэлтийг 2025 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 135 дугаар албан бичгээр “Нутаг консалтинг” ХХК-д хүргүүлсэн. “Нутаг консалтинг” ХХК нь 3.0 сая төгрөгөөр төсөв шинэчлэх санал ирүүлсэн тул 2025 оны 09 дүгээр сарын 24-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний хэрэгжилтийн дагуу “Барилга хөгжлийн төв”-ийн 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 2009/2025 дугаартай магадлалын дүгнэлт гаргуулан хүлээлгэн өгсөн. Нийт төсөвт өртөг 6,026,262,161 төгрөг болж шинэчлэгдсэн. Энэхүү төсвийн 50 хувийг Нийслэлийн 2026 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгуулахаар ажиллаж байна.	85%
232	НХТЖҮЧ-4.3.3	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	ЭЭАҮП	УТ	2023	-	Үндсэн цахилгаан хангамжийн дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	14,800.00	ЭЭАҮПаркийн “Дулааны цахилгаан станц болон Цэвэрлэх байгууламж”-ийг барьж байгуулах ажилд нийт 225 тэрбум төгрөг шаардлагатайгаас 2025 онд эхний санхүүжилт болох 30 тэрбум төгрөгийг нийслэлийн төсөвт суулгуулсан. Уг ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 08 дугаар сарын 26-ны өдөр “Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн Дулааны цахилгаан станц, бохир ус цэвэрлэх байгууламжийн ажил гүйцэтгэх (EPC+F) гэрээг байгуулаад байна. Гэрээний нөхцөлийн дагуу гүйцэтгэгч компаниас 30 тэрбум төгрөгийн урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргуулсан ба зураг төсөл боловсруулах ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна. Мөн Эрчим хүчний барилга байгууламж барих тусгай зөвшөөрөл авах хүрээнд ДЦСтанцын байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ба уг ажлын явц 90 хувьтай үргэлжилж байна. Түүнчлэн инженерийн шугам сүлжээ, бусад дэд бүтцийн бүтээн байгуулалттай холбоотой дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: 1. БНСУ-ын хөрөнгө оруулалтаар “Смарт энержи платформ” нэгдэлтэй хамтран “10мВт-ын нарны эрчим хүч үйлдвэрлэх төсөл” хэрэгжүүлэхээр ТЭЗҮ-ийг боловсруулах ажил 2025 оны 07 дугаар сард эхлээд байна. 2. Үерийн хамгаалалтын барилга байгууламжийн ажлын зургийн дагуу төсөв шинэчлэх ажлыг Усны Эрчим ХХК-иар гүйцэтгүүлэн Хот байгуулалт, Барилга орон сууцжуулалтын яамны дэргэдэх Барилгын хөгжлийн төвөөр магадлуулж, 2094/2025 дугаартай магадлалын нэгдсэн дүгнэлтийг гаргуулсан. 3. Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн Баруун бүсэд 2*630кВа хаалттай дэд өртөө, гадна цахилгаан хангамж байгуулах ажлыг бүрэн дуусган, улсын комисс ажиллуулах бэлтгэл ажлыг хангаж байна. 4. Баруун бүсийн Хамгаалалтын бүс байгуулах (3228м урттай) бүтээн байгуулалтын ажлуудын гүйцэтгэл 80 хувьтай үргэлжилж байна. 5. 2017 онд боловсруулагдсан тус паркийн Технологийн ус хангамжийн зургийг үндэслэн төсвийг шинэчлэх ажил 50%-ийн гүйцэтгэлтэй. 6. 2025 онд шинээр боловсруулж байгаа "Унд ахуйн ус хангамжийн зураг төсөл" болон "Гадна холбоо дохиоллын ажлын зураг төсөл"-ийн гүйцэтгэл 80%-ийн гүйцэтгэлтэй үргэлжилж байна.	90%
	НХТЖҮЧ-4.3.3		ЭЭАҮП	ТХХТ	2023	-	Дулаан, уурааар хангах "Дулааны станц"-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	97,400.00		
	НХТЖҮЧ-4.3.3		ЭЭАҮП	НТ	2023	-	Цэвэрлэх байгууламж /үйлдвэрийн болон ахуйн бохир усны/-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	108,400.00		

	НХТЖҮЧ-4.3.3	Эмээлт эко аж үйлдвэрийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	ЭЭАҮП	НТ	2023	-	Гадна авто зам (Таван толгойн гүүрнээс Эмээлтийн авто зам хүртэл)-ын барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	30	35,000.00	Эмээлтээс Шувуун фабрик хүртэлх 12.5 км гадна авто замыг барьж байгуулах зураг төсвийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/1249 дугаар захирамжаар шинэчлэн боловсруулж 2026 оны нийслэлийн төсвт тусгуулсан.	
	НХТЖҮЧ-4.3.3		ЭЭАҮП	НТ	2023	-	Үерээс хамгаалах барилга, байгууламжийн угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	30	30,600.00	Үерийн байгууламжийн төсвийг 2025 онд тарифын өөрчлөлтийг тусгаж Барилгын хөгжлийн төвийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 2094/2025 дугаар магадлалын дүгнэлтээр баталгаажуулсан.	
233	НХТЖҮЧ-4.3.3	Багахангайн үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг үргэлжлүүлэх	БХҮТП	НТ	2023	-	Хүнд үйлдвэрлэлийн бүсийн хөгжлийн төлөвлөгөө зураг төсөл боловсруулах ажлын гүйцэтгэл	хувь	100	90	Паркийн Хүнд үйлдвэрлэлийн бүсийн Хөгжлийн төлөвлөгөөний зураг төсөл боловсруулах 90.0 сая төгрөгийн санхүүжилт Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/769 дүгээр захирамжаар шийдвэрлэгдэж, тендер зарлагдсан. 2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр "Аж үйлдвэрийн паркийн технологи дамжуулах төв" ТББ шалгарч, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай гэрээ байгуулсан. 50%	93%
			БХҮТП	НТ	2023	-	Цахилгаан хангамж 35/10 кВ-ын 2х8МВА дэд станцын барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	50	4,379.30	Паркийн Цахилгаан хангамжийн 35/10 кВ-ын 4.7 км 2 хэлхээт 1.8 тэрбумын төсөвтэй ЦДАШ-ын бүтээн байгуулалтын ажил хийгдэж дууссан бөгөөд 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн хөрөнгө оруулалтын газраас хүлээн авсан. Мөн цахилгаан хангамжийн 35/10 кВ-ын 2х8МВА чадалтай дэд станцыг барих ажлын 8.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Нийслэлийн 2026 оны төсвт тусгуулах саналыг 2025.11.05-ны өдрийн 147 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргад хүргүүлээд байна. 100%	
3.3 Үйлдвэрлэл инновац												
Салбарын үр дүн : Бойжуулж, хөгжүүлсэн гарааны бизнес эрхлэгчдийг нэмэгдүүлнэ.												
234	НХТЖҮЧ-4.2.2	Гарааны бизнесийг дэмжих инновацын төв байгуулах	НБИГ	ГТ	2023	-	Ажлын гүйцэтгэл	тоо	50	6,912.00	БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар “Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв” байгуулах асуудлаар хамтран ажиллах, санал солилцох 9 удаагийн уулзалтыг зохион байгуулсан. -НЗД-ын нэгдүгээр орлогч дарга, НБИГ-ын дарга, БНСУ-аас төслийг хэрэгжүүлэхээр ирсэн төлөөлөгчид, БНСУ-ын ЭСЯ-ны нэгдүгээр нарийн бичгийн дарга Куаг Хан Сул нарыг хүлээн авч уулзсан. Уулзалтаар БНСУ-аас Монгол Улсад буцалтгүй тусламжийн хүрээнд урт болон дунд хугацаанд нийт 58 төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд нэн тэргүүнд “Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв” байгуулах төслийг хэрэгжүүлэхээр болж Нийслэлийн Засаг даргын А/258 дугаар захирамж гарсан. -“Улаанбаатар хот дахь гарааны бизнесийг дэмжих төв” байгуулах төслийг хэрэгжүүлэх зөвшөөрлөө авсан. Төслийн бэлтгэл ажлын хүрээнд шаардлагатай баримт бичгүүдийг боловсруулан хүргүүлж, холбогдох мэдээллээр ханган ажиллаж байна. Үр дүн: БНСУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2026-2028 онд “Инновацын төв” байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	85%
235	НХТЖҮЧ-4.2.1	Инновацын соёлыг бий болгох, түгээх арга хэмжээг зохион байгуулах	НБИГ	НТ	2023	12	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	4	200	Инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 6 арга хэмжээ зохион байгуулж, 10 контент, 29 постер бэлтгэн нийтэд хүргэн ажилласан. Тухайлбал: 1.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан “Хөгжлийн харандаа” инновацын үзэсгэлэн арга хэмжээ; 2.“MICS-2024” хөтөлбөрийн хаалтын арга хэмжээ; 3.“Монгол - Японы олон улсын Бизнес Инновацын форум - 2025” арга хэмжээ; 4.МУ-ын Ерөнхийлөгчийн Тамгын газар болон нийслэлийн Засаг даргын Тамгын газар хамтран бэлтгэж буй "Инновацын эзэд" 2025 уралдаант нэвтрүүлэг; 5.“Global Youth Entrepreneurship Challenge” буюу “Олон улсын өсвөрийн энтрепренеруудийн уралдаан”; 6.“Хиймэл оюун ухаанд суурилсан анимейшн дүр"-ийг бий болгож, түүгээрээ дамжуулан газрын үйл ажиллагаа болон Улаанбаатар хотын бүтээн байгуулалтын ажлыг олон нийтэд сурталчлан таниулах, инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэхтэй холбоотой ажил, үйлчилгээг үзүүлэх зэрэг арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. 7.Инновацын соёлыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор цуврал контент, сургалт арга хэмжээ зохион байгуулахаар тус төвд Медиа центр, чөлөөт уулзалт, студийн буланг тохижуулан ашиглалтад оруулсан. 8.Баянхошуу бизнес инкубатор сургалт, үйлдвэрлэлийн төвд хүүхэд, залуучуудад технологийн үйлчилгээг үзүүлэх, соёлын хүртээмжийг бий болгох зорилгоор AR/VR танхимыг тохижуулан ашиглалтад оруулсан. 9.Баянхошуу бизнес инкубатор, сургалт үйлдвэрлэлийн төвийн фейсбүүк пейж хуудсанд шинжлэх ухаанд үндэслэсэн “Хүн төрөлхтнийг хамгийн их өөрчилсөн 30 инновац” сэдэвт мэдээ мэдээллийг цувралаар бэлтгэн нийт 29 постер оруулан ажилласан. 10.Инновац болон хотын соёлыг түгээх зорилтод ажлын хүрээнд нийгэмд нөлөөлөгч залуусаар 5 контент бэлтгэн сошиалаар нийтэд түгээсэн. 5.“21-р зууны шилдэг 5 стартап бизнес” цуврал видео контентыг бэлтгэн фейсбүүк пейж хуудсанд байршуулсан.	100%

236	НХТЖҮЧ-4.2.1	Гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулан, хөгжүүлж бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, зөвлөх үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулах	НБИГ	НТ	2023	32	Зохион байгуулсан эвент арга хэмжээ	тоо	50	200	Инновацын төвүүдэд бойжиж буй гарааны бизнес эрхлэгчдэд 94 удаагийн сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулсан. Үүнд: 1.Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан “Бизнесээ хэрхэн өргөжүүлэх вэ“ цахим маркетингийг хэрхэн оновчтой зөв хийж хандалтаа өсгөж, харилцагч татах”, “Бизнес эрхэлж борлуулалтын сүлжээгээ өргөжүүлэх боломжууд”, “Бизнесээ эхлүүлэх, хэрхэн зөв бүртгүүлэх вэ”, “Цахим хэрэглээг бизнесийн үйл ажиллагаандаа амжилттай хэрэглэх нь”, “Банкны зээлийн бүтээгдэхүүн танилцуулах”, “Рийл хийж сурах нь” гэх мэт 44 удаагийн сургалт арга хэмжээг зохион байгуулж 2200 иргэн, аж ахуйн нэгж хамрагдаад байна. 2.Германы хамтын ажиллагааны GIZ нийгэмлэг, Худалдаа хөгжлийн банкны хамтран “Жижиг, дунд бизнес эрхлэгчдийг чадавхжуулах хөтөлбөр 2025” арга хэмжээний хүрээнд гарааны компаниудын бизнес хөгжүүлэлт, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүгийн төлөвлөлт, зах зээлийн судалгаа болон маркетингийн стратеги гэсэн 4 сэдвээр 15 удаагийн сургалт зохион байгуулсан. 3.“Баянгол дүүргийн насан туршийн суралцахуйн төв”-тэй хамтран гарааны болон жижиг, дунд бизнес эрхлэгч залуучуудад бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг ур чадвар олгох нийт 12 удаагийн сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж, нийт 126 гарааны бизнес эрхлэгчид, иргэд, аж ахуйн нэгжүүд хамрагдсан. 4.“Гааль, татварын хөнгөлөлтийн талаарх мэдээлэл”, “Архив албан хэрэг хөтлөлтийн шинэчилсэн журмын ойлголт, албан хэрэг хөтлөлтийн өдөр тутмын хэрэглээний стандарт” сэдэвт 2 удаагийн сургалтыг зохион байгуулж 10 стартап компанийн төлөөлөгчид хамруулсан.	100%
			НБИГ	-	2023	1,500	Эвент арга хэмжээнд хамрагдсан хүн	тоо	5,000	-	Гарааны болон жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд зориулан бизнесээ тэлэх, эрчимжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар олгох сургалт, зөвлөх үйлчилгээг зохион байгуулж нийт 2364 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулсан.	
237	НХТЖҮЧ-4.2.1	Гадаад, дотоодын инновацын экспо, үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулах	НБИГ	НТ	2023	2	Зохион байгуулсан экспо, үзэсгэлэн арга хэмжээ	тоо	3	600	Гадаад, дотоодын инновацын экспо, үзэсгэлэн 5 удаагийн арга хэмжээ зохион байгуулж ажилласан. Үүнд: 1. “Амар байна уу-2025” үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Тус үзэсгэлэнд нийслэл, хөдөө орон нутгийн нийт 1200 гаруй жижиг, дунд бизнес эрхлэгчид оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ олон нийтэд сурталчлан таниулсан. 2.“Олон улсын жижиг, дунд үйлдвэрлэлийн өдөр-2025” арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд инновацын төвд бойжигч 2 иргэнийг хамруулсан. 3.ЖАЙКА-гийн Монгол дахь төлөөлөгчийн газартай хамтран “MICS-2024” хөтөлбөрийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр “Ашигласан HEV/EV батарейг дахин ашиглах/дахин боловсруулах технологийг хөгжүүлэх, ноу-хау солилцох” төсөлд Худалдаа хөгжлийн банкнаас 10,000,000 төгрөгийн дэмжлэг олгосон. 4.“Хөгжлийн харандаа” инновацын үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулсан. Тус үзэсгэлэн арга хэмжээний үеэр 2 төрөлт И-Спортын тэмцээн зохион байгуулж шилдэг багууд болон шилдэг тоглогчдыг шалгаруулсан. Тэмцээний тоглолтуудыг нийт 5 сувгаар 6 удаа шууд дамжуулж, мэдээллийг 20,000 гаруй хүнд хүргэсэн. Энэ жилийн хувьд “Цуглуулгын үзэсгэлэн” арга хэмжээг зохион байгуулснаар илүү онцлогтой байсан бөгөөд AR, VR технологи, 3D шоу, шидэт толь зэрэг үзүүлбэрүүдийг хүүхэд багачуудад танилцуулсан. 5. ЖАЙКА олон улсын байгууллагатай хамтран “Монгол-Японы олон улсын бизнес инновацын форум-2025” арга хэмжээг 2 дахь жилдээ зохион байгуулсан. Форумд Монгол улсаас 400, Япон улсын 150 гаруй зочид төлөөлөгч, бизнес эрхлэгчид оролцож, Монгол-Япон хоёр орны хоорондын шинэ бизнесийн боломж, бизнесийн өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал болон цаашдын хөгжлийн талаар илтгэл, панел хэлэлцүүлэг болон нэтворкинг үйл ажиллагааг зохион байгуулсан.	100%
238	НХТЖҮЧ-4.2.4	Нийслэлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд шинэ санаа, шилдэг инновацын төслийг сонгон шалгаруулах	НБИГ	НТ	2023	10	Олон нийтийн оролцоотой гаргасан шийдэл, төсөл	тоо	1	70	Нийслэл хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, хотын хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулсан. Үүнд: 1.Хүнсний эрүүл ахуйн тулгамдсан асуудлуудыг бодит өгөгдөлд суурилан салбарын мэргэшсэн залуусаар шилдэг инновацын шинэлэг шийдлийг гаргах хакатон тэмцээнийг 3 сэдвийн хүрээнд 1 сарын турш 3 үе шаттайгаар зохион байгуулсан. Тус хакатон тэмцээнд нийт 27 баг бүртгүүлсэн бөгөөд шалгарсан 3 багт тус бүр 3 сая төгрөгийн грант олгосон. 2.Байгууллагын албан хаагчдын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, хотын тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд оролцоог нэмэгдүүлэх зорилготой төслийн уралдаан зохион байгуулж 3 төслийг шалгаруулсан.	100%
239	НХТЖҮЧ-4.2.3	Бизнесийн орчны судалгааг боловсруулах	НБИГ, МҮХАҮТ	НТ	2023	20	Боловсруулсан судалгаа	тоо	1	200	Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа гарааны компаниудын бизнесийн орчныг судлах, тулгарч буй асуудлыг тодорхойлох, цаашид хөгжлийг дэмжих зорилготой “Бизнесийн орчны судалгаа”-г Санхүү, Эдийн засгийн Их сургуулийн Зах зээлийн судалгааны хүрээлэнгийн судлаачдын баттай хамтран хийсэн. Судалгааны үр дүнг танилцуулан, материалыг ном хэлбэрээр хэвлүүлэн олон нийтэд хүргэсэн. Гарааны бизнесийн орчны өнөөгийн нөхцөл байдлыг нарийвчлан тогтоож, цаашид анхаарч ажиллах стратеги, зөвлөмжийг боловсруулсан судалгааны үр дүнгийн тайлангийн ном хэвлэгдсэн.	100%
240	НХТЖҮЧ-4.1.4	Ургамлын үр тариалж, нутагшуулах судалгааны ажил хийх	НБИГ	НТ	2023	-	Судалгааны ажлын явц	хувь	100	85	Ургамал газар тариалангийн хүрээлэнгийн доктор Т.Атарсайхантай холбогдон Жунцао ургамлын тариалалтын 1 дүгээр үеийн судалгаан дээр үндэслэн, 2 дугаар үеийн туршилтын тариалалтыг Говийн бүсийн аймагт хийхээр тохиролцон Бүгд Найрамдах Хятад ард улсаас Жунцао ургамлын ургамал зүйн судалгаа болон тус ургамлыг тариалах үр, суулгац зэргийг авахаар хүсэлт явуулсан боловч хариу ирээгүй тул түр хугацаанд хэрэгжих боломжгүй болсон.	50%
241	НХТЖҮЧ-4.3	Монгол, Японы хамтарсан Ай Ти Консерциум төслийг хэрэгжүүлэх	НБИГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	70	“Ай Ти Консерциум“ байгуулах санамж бичгийн хүрээнд Монгол, Япон 2 улсад төлөөлөх ТББ-ыг байгуулсан. Токио хотод 2 удаагийн эвент арга хэмжээ, зохион байгуулсан бөгөөд нийт 60 гаруй технологийн чиглэлийн компаниудад мэдээлэл хүргэсэн байна. Япон улсын Токио хотын Шинагава дүүргийн удирдлагууд, цахиурын хөндийн "Готанда валлэй" ТББ-ын гүйцэтгэх захиралтай 3 удаагийн уулзалт хийж хамтран ажиллах талаар санал солилцсон. Япон улсын технологийн 5 компани айлчилж ICT tour хийхээр болсон бөгөөд тус арга хэмжээг зохион байгуулах бэлтгэлийг хангасан. “Зууны мэдээ” сонины “Leaderships forum” буланд Ай-Ти консорциумын үйл ажиллагааны талаар мэдээлэл нийтэлж олон нийтэд хүргэн ажилласан.	100%
3.4 Дөрвөн улирлын аялал жуулчлал												
Салбарын үр дүн: Нийслэлээс зохион байгуулж буй олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнд 70,000 жуулчныг хамруулна.												
242	НХТЖҮЧ-4.3.1	Аялал жуулчлалын мэдээлэл сурталчилгааны төвийг нэмэгдүүлж, үйл ажиллагааг үргэлжлүүлэх	НАЖГ	НТ	2023	7	Шинээр байгуулсан мэдээлэл сурталчилгааны төв	тоо	1	194	Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг үе шаттайгаар нэмэгдүүлэх ажлын хүрээнд жуулчид хамгийн ихээр зорчдог байршлын судалгааг гаргасан. Чингэлтэй дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэр Жуулчны гудамжийг тохижуулах төсөл, арга хэмжээтэй уялдуулан Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр тухайн байршилд байгуулахаар холбогдох байгууллагуудад санал хүргүүлэн шийдвэрлүүлж, бэлтгэл ханган ажиллаж байна. 0%	70%
			НАЖГ	НТ	2023	100	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	190	Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, Төв шуудан, “Чингис хаан” олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон “Тэрэлж Монгол олле”, “Хонхор тосгон Монгол олле”, “Сөүлийн гудамж Монгол олле” зэрэг нийт 7 байршилд тогтмол болон улирлын чанартай ажиллуулж, гадаад, дотоодын нийт 17,208 хүнд мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч үйлчилгээг үзүүллээ. 100%	

243	НХТЖҮЧ-4.3.1,	Аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр нийтийг хамарсан олон улсын шинж чанартай томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулах	НАЖГ	НТ	2023	14	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	10	1,520.00	Монгол Улсын Засгийн газраас 2023-2028 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран 17 арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: 1.“Улаанбаатар өвлийн наадам” 2.“Улаанбаатарын өвлийн явган алхалтын фестиваль” 3.“Мөсөн замын авто машины уралдаан” 4.“Монгол үндэстэн угсаатан дээлтэй жагсаал” 5.“Бүргэдийн баяр” 6.“Нарны баяр” 7."Нийслэлийн аварга шалгаруулах нээлттэй Монгол адуучин” тэмцээн, 8.“Юби фүүд фестиваль-Үзбек улсын хоолны өдөрлөг, 9.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийн "Magic dream" парад, 10."Талын салхи" олон улсын мото фестиваль, 11."Бурхан багшийн дүйчин өдөр", 12.“Нийслэл Улаанбаатар хотын иргэдийн өдөр -Хүрээ цам даншиг наадам”, 13."Плэйтайм" олон улсын хөгжмийн наадам, 14."Дээлтэй Монгол" наадам, 15.“Бэсрэг даншиг наадам”, 16."Улаанбаатар олон улсын явган алхалтын фестиваль”, 17."Хийморь" олон улсын морьт харвааны тэмцээн. 100%	100%
			НАЖГ	-	2023	50,000	Оролцсон жуулчид	тоо	70,000	-	Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор зохион байгуулсан арга хэмжээнүүдийг гадаад, дотоодын нийт 288,836 хүн үзэж сонирхов. 100%	
244		"Нэг жуулчин-нэг мод” жуулчны төглийн тохижилтын ажлыг үргэлжлүүлэх	НАЖГ	НТ	2023	-	Тохижилтын ажлын явц	хувь	100	100	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Монголын Аялал жуулчлалын холбоо “Цолмон трэйвел” ХХК-тай хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд “Жуулчин төгөл” байгуулах ажлыг 2022 онд эхлүүлж төслийн талбайд 27 төрлийн 1116 мод, бут сөөг тарьж суулгасан. Монголын Аялал жуулчлалын холбооны гишүүн 30 гаруй байгууллагатай хамтран 2025 оны 10 дугаар сарын 04-ний өдөр мод тарих ажлыг зохион байгуулж, шинэс, гацуур, хус зэрэг 5 төрлийн 320 гаруй мод тарьж суулгав.	100%
245		Улаанбаатар хотын тойрон аяллын "Сити тур" төслийг үргэлжлүүлэх	НЗДТГ-НБХ, НАЖГ	НТ	2023	-	Нийслэлийн төсөвт орлого төвлөрүүлэх ажлын хэрэгжилт	хувь	100	62	"Сити тур" төслөөс 2025 оны төсөвт 35,000,000 (гучин таван сая) төгрөгийн орлого төвлөрүүлэхээр тусгасан. Сити тур төсөлд ашиглагдаж байгаа автобусанд эвдрэл гарсан, замын хөдөлгөөний ачаалал их, ажиллах хүчний хүрэлцээгүй байдал, улирлын хамаарал зэргээс шалтгаалан төлөвлөсөн орлогыг бүрдүүлэх боломжгүй болсон тул төвлөрүүлэх орлогыг 8,521,440 төгрөг болгож, бүрэн төвлөрүүлсэн.	100%
246	НХТЖҮЧ-4.3.1, НЗДҮАХ-3.4.1.2.	Өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх замаар аялал жуулчлалын	НАЖГ	НТ	2023	15	Бүтээгдэхүүн, үйлчилгээ	тоо	20	20	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, өвлийн улиралд жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “Go Winter - Өвлийн хямдралтай аян”-ыг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа 4 салбарын 82 аж ахуйн нэгж, байгууллага 100 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 10-50 хувь хүртэл хөнгөлөлттэй үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүллээ.	100%
			НАЖГ	-	2023	68	Хамрагдах байгууллага	тоо	80	-		
247	НХТЖҮЧ-4.3.1	Бэлхийн амны Хүннүгийн язгуартны цогцолбор/музей зураг төсөв боловсруулж, цахилгаанаар хангах	НАЖГ	НТ	2023	-	Зураг төсөв	тоо	2	200	Нийслэлийн Засаг даргын 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн “Эрх шилжүүлэх тухай” А/253 дугаар захирамжаар төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаат зохион байгуулах эрхийг Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газарт шилжүүлж, Бэлхийн амны Хүннүгийн язгуартны цогцолборын музейн зураг төсөв боловсруулах ажил 160,000,000 (нэг зуун жаран сая)-ын худалдан авах ажиллагаат зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагаар “Аркосис” ХХК шалгарч зургийг гүйцэтгүүлж батлуулав. Нийслэлийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/717 дугаар захирамжаар Бэлхийн амны Хүннүгийн язгуартны цогцолборын цахилгааны эх үүсвэр, тохижилтын ажлын 40,000,000 (дөчин сая) худалдан авах ажиллагаат зохион байгуулж, гүйцэтгэгч байгууллагаар “Филипс гэрэлтүүлэг” ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж, хүлээн авах Ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ажилласан.	100%
248	НЗДҮАХ-3.4.1.3.	Жуулчдын зорин очих аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх	НАЖГ	НТ	2023	1	Шинээр нэвтрүүлсэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн	тоо	2	200	Улаанбаатар хот болон хот орчимд эко аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг бий болгох, жуулчдын зорин очих газар болон маршрутын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Эко Улаанбаатар 360 хөтөч” гарын авлага, цахим мэдээллийн хөтөч бүтээх ажлын хүрээнд ногоон бүсэд 11 төрлийн аяллын бүтээгдэхүүний төрлүүдийг бий болгож, 20 аяллын зам маршрутыг шинээр тогтоож, Богд уул, Зүрх уул, Чингэлтэй хайрхан, Тэрэлжийн зам харгуйг тэмдэгжүүлэх ажил хийгдэж байна.	100%
249	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.2.1.	Улаанбаатар хотын танилцуулгыг шинэчлэн хэвлүүлэх	НАЖГ	НТ	2023	18,500	Сэтгүүл, цахим сэтгүүл, газрын зураг, хөтөч ном	тоо	25,000	150	Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр ашиглах Улаанбаатар сэтгүүл (Англи, Герман, Япон, Солонгос, Орос, Хятад хэл дээр), Улаанбаатар хотын хөтөч ном (Guide book), жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг (City map) зэрэг 8 төрлийн 27,450 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж Монгол Улсад суугаа гадаад улсуудын Элчин сайдын яамд, консулын газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, зөвлөгөөн, эвент арга хэмжээнүүдэд тарааж Улаанбаатар хотыг сурталчлан ажилласан.	100%
250		Улаанбаатар хотын аялал жуулчлалыг иргэд, олон нийт, жуулчдад түгээн сурталчлах	НАЖГ	НТ	2023	2	Гэрээ байгуулсан хэвлэл мэдээллийн байгууллага	тоо	7	60	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулан зохион байгуулсан үзэсгэлэн, эвент арга хэмжээнүүдийн талаар MYOHPT, UBS, TV5, Eagle, TB9, C1, SBN, Монгол ТВ зэрэг 10 телевиз, News.mn, Gogo.mn, Zarig.mn, Eguur.mn, Ikom.mn зэрэг 25 сайт, Өдрийн сонин, Өнөөдөр, Монголын мэдээ зэрэг 5 сонин нийт хэвлэл мэдээллийн 42 байгууллагаар 23 удаагийн ярилцлага, нэвтрүүлэг, 50 гаруй мэдээ мэдээллийг түгээж, мөн “Дэлхийн Монголчуудын MGL” радиогийн Дөрвөн зүгийн шуугиан, Өдөр тутмын мэдээ, Пин пост буланд 11 эвент, арга хэмжээний талаар цуврал мэдээ мэдээлэл нийтлүүлж үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан. 100%	100%
			НАЖГ	-	2023	1,800.00	Сурталчилгааны контент, мэдээ, мэдээлэлд хандсан хүн	тоо	2,000.00	-	Байгууллагын цахим хуудас болон бусад олон нийтийн цахим сүлжээнд давхардсан тоогоор 1488 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 3,219,009 хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан. Тухайлбал: 1.www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 178 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 10,870, 2.www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 81 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 41, 564 3.https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 911 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 37,208 хандалтын тоо 3,136,805 4.https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 280 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 416, хандалтын тоо 18,247 5.https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA цахим хуудсанд 38 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 517, хандалтын тоо 11,523 байна. 100%	
251		Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах	НАЖГ	НТ	2023	-	Эй Ар, Ви Ар (AR, VR) технологиор бүтээсэн аялал жуулчлалын сурталчилгаа	тоо	2	100	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд мета куэст 3S төрлийн 11 ширхэг Ви Ар (VR) төхөөрөмжийг худалдан авч, 8 арга хэмжээ, 13 үзвэр, үйлчилгээний газар, 6 дурсгалт газар нийт 27 бүтээгдэхүүн үйлчилгээнд VR 360 зураг авалт хийж, Web AR 3D модель контент хийсэн.	100%

252		Жуулчдад зориулсан гар утасны аппликейшн хөгжүүлэх	НАЖГ	НТ	2023	-	Ажлын гүйцэтгэл	тоо	100	50	Гадаад, дотоодын иргэд, жуулчид аялал жуулчлалын байгууллагуудын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэг дороос авах боломжийг бүрдүүлэх, төлбөр тооцооны ухаалаг систем, үзвэр үйлчилгээ, байршуулах хэрэгсэл, хоол үйлчилгээ, нийтийн тээвэр болон такси үйлчилгээг нэг дороос худалдан авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Visit.ub мобайл аппликейшн" болон www.visitub.com веб цахим системийн UI, UX дизайныг бүтээх, хөгжүүлэх ажлыг "Эрксис монголиа" ХХК, "Эн Эм Эм Эй ХХК, "Премиум капитал трейдэрс" ХХК-аар гүйцэтгүүлж, ажил сүүлийн шатанд явагдаж байна.	90%
253		Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах	НАЖГ, НЗДТГ-ГХХАГ	НТ	2023	6	Оролцсон олон улсын үзэсгэлэн	тоо	4	400	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд олон улсын 9 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож Улаанбаатар хотыг сурталчилсан. Үүнд ХБНГУ-ын Берлин хотноо 2025 оны 03 дугаар сарын 04-06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "ITB Berlin" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНХАУ-ын Засаг Захиргааны онцгой бус болох Хонгконг хотноо 2025 оны 04 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн аялал жуулчлалын хотуудын холбооны (WTCF) ээлжит чуулга уулзалт арга хэмжээ, БНХАУ-ын Бээжин хотноо 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөс 26-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "COTTM-2025" (China Outbound Travel & Tourism Market) олон улсын үзэсгэлэн, Улаанбаатар хотноо 2025 оны 05 сарын 16-18-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатар травэл экспо 2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНСУ-ын Сөүл хотноо 2025 оны 06 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "SITF 2025-Seoul International Travel Fair" олон улсын үзэсгэлэн, БНСУ-ын Бусан хотноо 2025 оны 10 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Дэлхийн Хотуудын Аялал Жуулчлалын дээд хэмжээний уулзалт", Япон улсын Токио хотноо 2025 оны 09 дүгээр сарын 25-29-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Tourism Expo Japan -2025" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, БНСУ-ын Жэжү мужад 2025 оны 11-р сарын 06-08-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "Жэжү Олле" явган алхалтын фестиваль, БНХАУ-ын Ханиань мужийн Саньяа хотноо 2025 оны 11 дүгээр сарын 18-21-ний өдрүүдэд зохион байгууладсан Ази, номхон далайн аялал жуулчлалын холбооноос зохион байгуулсан арга хэмжээнд оролцлоо.	100%
			НАЖГ, ТББ	НТ	2023	2	Сошиал орчинд нөлөө бүхий инфлюнсэрээр сурталчилсан сурталчилгаа	тоо	4	130	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах зорилгоор "Бүргэдийн баяр-2025" арга хэмжээний үеэр Аяллын тойрог нэвтрүүлэг, "УБ фүүд фестиваль-Узбек улсын хоолны өдөрлөг" арга хэмжээний үеэр сошиал орчинд нөлөө бүхий 2 инфлюнсэрээр, Унгар Улсын Будапешт хотноо 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатарын соёлын өдрүүд" арга хэмжээг Унгар улсын 5 инфлүнсерээр дамжуулан цахим орчинд контент бэлтгэн 2,250,000 хүнд хүргэсэн.	
	НХТЖҮЧ-4.3.1 НЗДҮАХ-3.4.2.1.	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах	НАЖГ, НЗДТГ-ГХХАГ	НТ	2023	-	Найрамдалт харилцаат хотуудад зохион байгуулах арга хэмжээ	тоо	2	250	1.Унгар Улсын Будапешт хотноо "Улаанбаатарын соёлын өдрүүд" арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 10,11-ний өдрүүдэд зохион байгууллаа."Улаанбаатар хотын соёлын өдрүүд" арга хэмжээний хүрээнд "Go Mongolia" үндэсний аялал жуулчлалын брэндийг сурталчлах өдөрлөг, "Монгол үндэсний хоолны өдөрлөг", "Морьт харвааны үзүүлбэр", "Монгол Унгарын түүхийн жимээр" гэрэл зургийн үзэсгэлэн, баримтат кино, хүндэтгэлийн урлагийн тоглолт болон жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, гар урчуудын үзэсгэлэн худалдааг зохион байгуулав. "Go Mongolia" үндэсний аялал жуулчлалын брэндийг сурталчлах өдөрлөгт Аялал жуулчлалын мэргэжлийн холбооны Европ зах зээлийн салбар холбооны 8 тур оператор компани оролцож аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчилж, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчид, гар урчуудын үзэсгэлэн худалдаанд 9 дүүргийн 21 аж ахуйн нэгж, иргэн 2130 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож, Улаанбаатар театрын уран бүтээлчид үндэсний урлагийн тоглолтоо зохион байгуулж, Монгол үндэсний хоол, ундааг сурталчлан "Улаанбаатар хотын соёлын өдрүүд" арга хэмжээг нийт 10,000 гаруй хүн үзэж сонирхов. 2.Монгол, Хятад, Орос гурван улсын "Түмэн газрын цайны зам" соёл, аялал жуулчлалын сурталчилгааны арга хэмжээ БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хотод 2025 оны 8 дугаар сарын 25-27-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, цайны замын холбооны гишүүн 100 гаруй муж, аймаг, хотуудын төлөөллүүд, аялал жуулчлалын бизнес эрхлэгч холбоод оролцов. Монгол Улсаас Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Нийслэлийн Аялал жуулчлалын газар, 8 байгууллага, соёл, урлагийн төлөөлөл оролцож үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа. 100%	100%
			НАЖГ, НЗДТГ-ГХХАГ	НТ	2023	3	Улаанбаатар хотод зохион байгуулсан найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл урлагийн арга хэмжээ	тоо	4	150	Найрамдалт харилцаат 4 хотуудын арга хэмжээг Улаанбаатар хотноо зохион байгууллаа. Үүнд: Монгол, Франц хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойн хүрээнд "Франц хотхон" соёл, аялал жуулчлалын арга хэмжээг 2025 оны 04 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд Жанжин Д.Сүхбаатарын талбайд Япон, Монгол хоёр улсын найрсаг харилцааг бэхжүүлэх, Монголын залууст Япон улсын түүх, соёлыг таниулах, сурталчлах зорилготой "Japan Festival in Mongolia-2025" арга хэмжээг 2025 оны 08 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Жанжин Д.Сүхбааатрын талбайд, Монгол, БНСУ хоёр улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 35 жилийн ойг тохиолдуулан "Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд" (Korea Week) арга хэмжээг 2025 оны 09 дүгээр сарын 06,07-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд, БНХАУ-ын ӨМӨЗО, ОХУ-ын Эрхүү хот, Улаанбаатар хотын аялал жуулчлалын байгуллагуудын уулзалт, арга хэмжээг 2025 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр "Чингисийн хүрээ" аялал жуулчлалын цогцолборт зохион байгууллаа. 100%	
			НАЖГ, НЗДТГ-ГХХАГ	-	2023	-	Зохион байгуулалтад оролцох олон улсын залуучуудын АСПАК чуулган	тоо	1	-	Ази, Номхон далайн бүсийн "Аспак-2025" чуулга уулзалтад оролцох гадаад улсаас оролцох зочид төлөөлөгчдийг байршуулах зочид буудлын судалгааг зохион байгуулах Ажлын хэсэгт хүргүүлсэн. "Аспак-2025" чуулга уулзалт 2025 оны 06 дугаар сарын 12-15-ны өдрүүдэд зохион байгуулагдаж дэлхийн 70 орчим улсын 5000 орчим төлөөлөгч оролцсон. 100%	
254		Оюутан цагдаа хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	НАЖГ, НЦУГ	НТ (ГХУСАЗНСЗ)	2023	90	Оюутан цагдаа	тоо	90	270	Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран "Оюутан цагдаа-2025 арга хэмжээг 2025 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс 08 дугаар сарын 10-ны өдрийн хооронд хэрэгжүүлээ. Жуулчид ихээр зорчдог гудамж талбай, олон нийтийн газруудад 62 оюутныг өдөр бүр ээлжээр эргүүлийн 32 чиглэлд ажиллуулж аюулгүй ажиллагааны зааварчилгаа, зөвлөмжийг өгч, ажлын үр дүн, сахилга ёс зүйд тогтмол хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр ханган хамтран ажиллаж, оюутан цагдаа нараас ажиллах хугацаандаа Цагдаагийн байгууллагын 102 тусгай дугаарт гэмт хэргийн 4, зөрчлийн шинжтэй 18 дуудлага мэдээлэл өгч, дотоодын 11,860 иргэнд туслалцаа үзүүлэн, гадаадын 6,380 иргэнд хэлмэрчилж, 2 төрлийн 5,800 ширхэг гарын авлага, зурагт хуудас, зөвлөмж, сэрэмжлүүлэг тараан, олон нийтийг хамарсан арга хэмжээнүүдийн үеэр 380 хүүхдэд эцэг эхийн утасны дугаар бүхий бугуйвч зүүж, эцэг эх, асран хамгаалагчаасаа төөрсөн 93 бага насны хүүхдийг ар гэрт нь хүлээлгэн өгсөн. Оюутан цагдаа хөтөлбөр бүрэн хэрэгжиж үр дүнд хүрсэн ба санхүүжилтээс шалтгаалан оюутан цагдаагийн тоонд өөрчлөлт орсон байна.	100%
255		"Зочид буудал, дэн буудал, амралтын газар тавигдах ерөнхий шаардлага (MNS 4588:2008, MNS 6043:2019, MNS 6043:2019) стандартын үзлэг зохион байгуулах	НАЖГ	НТ	2023	243	Тухайн жилд хамрагдах байгууллага	тоо	600	30	Улаанбаатар хотод зочин байршуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, дэн буудал, жуулчны бааз, амралтын газруудад нэгдсэн үзлэг шалгалтыг 2025 оны 3 дугаар улиралд зохион байгуулахаар удирдамж боловсруулан төсвийн тооцоолол гаргаж Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар албан даалгаврын хүрээнд үзлэг шалгалтын төсөв гаргах боломжгүй тухай чиглэл өгөгдсөн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.	0%

256		Аялал жуулчлалын салбарын ажилтнуудын ур чадварыг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах чиглэлээр олон улсын туршлагыг судлах, экспертийг урьж төрөлжсөн сургалтуудыг зохион байгуулах	НАЖГ	НТ	2023	Танхим, цахим хосолсон 2,769	Сургалтад хамрагдах аялал жуулчлалын салбарын ажилтнууд	тоо	450	150	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор холбогдох сургалтуудыг зохион байгуулахаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргад танилцуулсан боловч Төрийн хэмнэлтийн тухай хууль, Монгол Улсын Ерөнхий Сайдын 2025 оны "Төрийн албаны сахилга, дэг журам, хариуцлагыг чангатгах тухай" 03 дугаар албан даалгаврын хүрээнд сургалтын үйл ажиллагааны төсөв гаргах боломжгүй тухай чиглэл өгөгдсөн тул арга хэмжээ зохион байгуулагдаагүй болно.	0%
3.5 Хүнс, хөдөө аж ахуй												
Салбарын үр дүн: Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын сүлжээг хөгжүүлж, хотын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодоос хангана.												
257	НХТЖҮЧ-4.5.2 НЗДҮАХ-3.3.1.4.	Нийслэлийн хүн амын хаврын махны хангамж, үнийг тогтвортой байлгах зорилгоор мах бэлтгэн нөөцлөх, худалдан борлуулах ажлыг зохион байгуулах	УБЗАА, НХХААГ, НМЭГ, НЭМГ, Дүүргүүд	НТ	2023	6,337	Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ	тонн	6,500	7,993.70	2025 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бүрдүүлэх аж ахуйн нэгжийн сонгон шалгаруулалтад 10 аж ахуйн нэгж шалгаран нийт 8380 тн мах бэлтгэн нөөцөлсөн. Худалдан борлуулалт 85 хувийн гүйцэтгэлтэй буюу 7123 тн мах худалдан борлуулсан. 2026 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан махны нөөц бэлтгэх 15 аж ахуйн нэгж сонгон шалгаруулалтад тэнцсэнээс 9 аж ахуйн нэгж 5016,5 тн мах бэлтгэн нийлүүлэхээр "Мах бэлтгэх гэрээ" байгуулан бэлтгэл ажилдаа орон ажиллаж байна. Үйлдвэрийн аргаар бэлтгэсэн махны хэмжээ 2025 оны 11 дүгээр сард 26.9 мян.тн байна.	100%
258	МУХТЖҮЧ-8.3.6 НХТЖҮЧ-4.5.1	Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	НХХААГ	НТ	2023	9,416.40	Хураан авсан ургацын хэмжээ	тонн	10,500.00	29	Энэ онд төмс, хүнсний ногоо 585.6 га, малын тэжээл 831.7 га, хамгаалалттай хөрсөнд 54.7 га, жимс, жимсгэнэ 202.1 га, нийт 1686.1 га талбайд тариалж, 9984.1 тн ургац авахаар төлөвлөсөн. Үүнээс 1523,03 га талбайд тариалалт хийж 11690 тн ургац хураан авахаар урьдчилсан баланс гарсан. Ургац хураалт төмс 71 га талбайгаас 782,5 тн, хүнсний ногоо 251,04 га талбайгаас 3788,3 тн, хамгаалагдсан хөрс 50,6га талбайгаас 3667 тн, малын тэжээл 738 га талбайгаас 2494 тн, жимс жимсгэнэ 294 га талбайгаас 377тн, нийт 11108.8 тн ургац хураан авсан.	100%
259	НХТЖҮЧ-4.5.1	Үйлдвэрийн аргаар боловсруулсан сүүний хэмжээг нэмэгдүүлж, түүхий эдийн нөөц ашиглалтыг сайжруулах	НХХААГ	НТ	2023	53.5	Боловсруулсан сүүний хэмжээ	сая литр	55	2.5	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 130-р тогтоолоор баталсан "Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох" журмын хүрээнд: 2024-2025 оны өвлийн улиралд 2218 фермер эрхлэгч, 6,3 сая литр сүү бэлтгэн нийлүүлж 6,3 тэрбум төгрөгийн урамшуулал олгосон. 2025 оны 11 дүгээр сарын байдлаар шлагаруулалтад 13 аж ахуйн нэгж тэнцэн, 2025 оны 11 дүгээр сарын 01-ээс 2026 оны 03 дугаар сарын 01-ний хугацаанд сүүний нийлүүлэлт хийгдэнэ. Үйлдвэрийн аргаар боловсруулсан шингэн сүүний хэмжээ 2024 оны байдлаар 59.9 сая.л байсан бол 2025 оны 10 дугаар сарын байдлаар 49.2 сая.л байна. Улаанбаатар хотын хүн амын боловсруулсан сүүний хангамж 35.7хувь байна.	100%
308	НХТЖҮЧ-6.1.	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх	НБОГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	180	Улсын Онцгой комиссын 2025 оны 01 дүгээр албан даалгавар, Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн сайдын А/112 дугаар тушаал, Нийслэлийн Онцгой комиссын 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Нийслэлийн Байгаль орчны газрын даргын "Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай" 2025 оны А/28 дугаар тушаал гарч, 03 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн Нийслэлийн Байгаль орчны газар, Нийслэлийн Онцгой байдлын газар, Нийслэлийн Цагдаагийн удирдах газруудын хамтарсан хөдөлгөөнт эргүүлийн бүрэлдэхүүн Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй, Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн ногоон бүсийн 5 чиглэлд өдөр бүр 5 тээврийн хэрэгслээр 24 албан хаагч хяналт тавьж хэрэгжилтийг хангуулах ажлыг гүйцэтгэв. Хуурайшилт өндөртэй үе буюу нийт 135 өдрийн турш мэдээлэл солилцон ажиллах хариуцлагатай жижүүрийн үүрэг гүйцэтгэх 49 албан хаагч, ногоон бүсэд өдөр бүр тогтмол хяналт шалгалтын ажлыг зохион байгуулах 33 байгаль хамгаалагч, нэмэлтээр 60 урамшуулалт эргүүлүүдийг үүрэгжүүлэн ажилласан. 2025 онд нийслэлийн хэмжээнд 279 шар өвсний түймэр, ой, хээрийн 3 түймэр бүртгэгдсэнээс 45 тохиолдлыг хөдөлгөөнт эргүүлийн бие бүрэлдэхүүн Нийслэлийн Онцгой байдлын газрын гал унтраах ангитай хамтран унтраасан. Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээллийг өдөр тутмын хэвлэл мэдээлийн хэрэгслээр 5, цахим орчинд 21 удаа нийтэд хүргээд байна. Цахим орчинд нийтэлсэн мэдээллийг нийт 131,249 хүн үзсэн байна. Ойн түймэр тархах нөхцөлийг бууруулах зорилгоор 2025 онд Сүхбаатар дүүргийн 19-р хорооны нутаг дэвсгэр Их Баян, Төв аймгийн Батсүмбэр сумтай хиллэх заагт баруунаас зүүн тийш чиглэсэн 1.5 км урттай 40 метрийн өргөнтэй ойн түймрээс сэргийлэх зурвасыг сэргээх ажлыг ойн мэргэжлийн байгууллага "Сайхан санаа" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн.	100%
309		Доройтсон ойг нөхөн сэргээж, ойжуулах ажлыг зохион байгуулах	НБОГ	НТ	2023	15	Ойжуулсан талбай	га	20	540	Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэр Дээндийн амны ойн сангийн 28 га талбайд ойжуулалт, нөхөн сэргээлт хийх ажлыг сонгон шалгаруулах 2025 оны А/76 дугаар тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр "Хөвчийн бүргэд" ХКК шалгарч, НБОГ/20250101001 дугаартай гэрээ байгуулан 28 га талбайг ойжуулан 36,400 ширхэг 2-3 насны шинэсний тарьц тарьж, 2200 урташ метр хамгаалалтын хашаа барьсан. Газрын даргын 2025 оны А/111 дугаартай гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсэг гэрээнд зааснаар тайланг хүлээн авч, 10 дугаар сарын 20-ны өдөр тарьсан модны амьдралтын хувийг 93 хувьтай байгааг тогтоон, акт үйлдэн хүлээн авсан.	100%
310		Байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх	НБОГ	НТ	2023	-	Байгалийн сэргэн ургалтыг дэмжсэн талбай	га	26	24.6	Байгалийн сэргэн ургалтыг дэмжих арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах А/41 дугаартай тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр "Ойн хайгуул" ХКК шалгарч, гэрээ байгуулан Баянзүрх дүүргийн 33 дугаар хороо, Шар хоолойн аманд 67 га талбайд 46,900 ширхэг 2-3 насны шинэсний тарьцаар ойжуулах, шан татах ажлыг хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн Байгаль орчны газрын даргын 2025 оны А/110 дугаартай гүйцэтгэлийг хүлээн авах Ажлын хэсэг гэрээнд заасны дагуу 10 дугаар сарын 20-ны өдөр амьдралтын хувийг тооцон, акт үйлдэн хүлээн авав.	100%
311		Ойн хортон шавжийн тархалтын судалгаа, мониторинг хийх	НБОГ	НТ	2023	80,000.00	Судалгаанд хамрагдсан талбай	га	80,000.00	20	Нийслэлийн ногоон бүсэд ойн хөнөөлт шавж, өвчний голомтолсон тэмцлийн ажил гүйцэтгэх шаардлагатай талбайн хэмжээг тогтоох судалгааны ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр "Нямын өндөр" ХХК ойн мэргэжлийн байгууллага шалгарч, 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр гэрээ байгуулан ойн хөнөөлт шавж, өвчний судалгааны ажлыг Нийслэлийн ногоон бүсийн ойгоор бүрхэгдсэн 80,000 га талбайд хийж гүйцэтгэсэн.	100%

312		Ойн хортон, хөнөөлт шавжтай тэмцэх ажлыг зохион байгуулах	НБОГ	НТ	2023	8,199.00	Тэмцлийн ажил хийсэн талбай	га	6,000.00	438	Нийслэлийн ногоон бүсэд тархсан ойн хөнөөлт шавж, өвчний тэмцлийн ажлыг үүргийн шүршигч багаж ашиглан, микробиологийн аргаар 6793 га талбайд зохион байгуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Гүйцэтгэгчээр ойн мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй "Хатант форест" ХХК шалгарч, ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан. Нийслэлийн Байгаль орчны газрын даргын 2025 оны А/99 дугаартай тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг 10 дугаар сарын 20-ны өдөр гүйцэтгэлийг хянаж, ирүүлсэн тайланд дүн шинжилгээ хийж, судалгааны тайланд дурьдсан үр дүн 81 хувьтай байгааг тооцон, акт үйлдэн хүлээн авсан.	100%
313		"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлж, тарьц суулгацын нөөцийг бүрдүүлэх, мод үржүүлгийн газруудын хүчин чадлыг нэмэгдүүлэх	НБОГ	НТ	2023	595.5	Таригдсан мод	мян. ш	600	10	Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2025 оны "Тэрбум мод тарих үндэсний өдөр зарлах тухай" 44 дүгээр зарлиг, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны “Тэрбум мод үндэсний хөдөлгөөн” 178 дугаар зарлиг, Засгийн газрын 2021 оны “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 350 дугаар тогтоолын дагуу уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг бууруулах, цөлжилтийг сааруулах, ой, усны нөөцийг хамгаалж нэмэгдүүлэх, экосистемийн тэнцвэрт байдлыг хангах, мод тарих, арчлан ургуулах соёлыг түгээн дэлгэрүүлэх, олон нийтэд сурталчлан таниулах арга хэмжээний хүрээнд 2025 онд нийслэлийн хэмжээнд 7 байршилд мод тарих хавар, намрын аяныг нэгдсэн журмаар зохион байгуулж, төрийн байгууллагын болон иргэдийн төлөөлөл нийт 37996 хүн оролцож 693,855 ширхэг мод тарьсан. Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2025 оны байдлаар нийслэлийн хэмжээнд өссөн дүнгээр 4,063,474 ширхэг мод тариад байна. 100%	100%
			УБЗАА, НБОГ, Дүүргүүд	НТ	2023	12	Ургуулсан тарьц, суулгац	сая. ш	36	2,500.00	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьц суулгацын нөөц бүрдүүлэх зорилгоор шинэс модны үр 7кг, 1500 ширхэг шинэс модны тарьц худалдан авах БОГ2025/69 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгэлийн хэрэгжилтийг хангуулах хүлээн авсан. 2025 оны хаврын байдлаар нийслэлийн хэмжээнд 7.1 сая ширхэг тарьц суулгацын нөөцтэй байв. “Ногоон хот-Иргэний оролцоо” мод тарих аяныг хавар, намар 2 удаа зохион байгуулж, нийт 131419 ширхэг мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлсэн. Үүнд: 1.Хязгаарлагдмал хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх чиглэлээр гэр хорооллын бүсэд нийт 61053 мод, бут сөөг, тарьсан. 2.Дүүргийн нийтийн ээмшлийн ногоон байгууламжийн нөхөн тарилтын ажлын хүрээнд нийт 10 байршилд гоёл чимэглэлийн 54480 ширхэг мод, сөөг тарьсан. 3.Тусгай хэрэгцээний ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд дүүргийн 14 дүгээр хороо Айцын амны ойжуулалтын талбайд нийслэл, дүүргийн 59 хэлтэс албадын 680 албан хаагч 2022-2024 онд байгуулсан 12.3 га талбайд усалгаа, арчилгаа хийж, нэмэлтээр болон нөхөн тарилтаар 8800, 13-р хороо, Агропаркийн талбайн салхины хамгаалалтын зурваст 4567, Засгийн газрын харьяа агентлагууд, төрийн захиргааны төв байгууллагууд 180, Богдхан уулын дархан цаазат газрын Түргэний ам, 136 га талбайд ойжуулалтын ажлын хүрээнд 2639, нийт 16186 ширхэг мод, бут, сөөг тарьсан байна.	100%
314		Жижиг гол, горхины эх, татмыг ойжуулах замаар усны нөөцийг хамгаалах, нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах	НБОГ	НТ	2023	4.4	Голын татмын ойжуулсан талбай	га	4.4	88.2	Баянзүрх дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвгэр Дээндийн аманд жижиг гол, горхины эх, татмыг ойжуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг зохион байгуулсан. Тус ажлын гүйцэтгэгчээр “Шилмүүст модны төгөл” ХКК шалгарч, НБОГ/20250201008 дугаартай гэрээ байгуулан уг ажлыг 4,4 га талбайд гүйцэтгэж, 5,280 ширхэг 3-4 насны навчит модны суулгац тарьж, 840 уртааш метр хамгаалалтын хашаа барьсан. Нийслэлийн Байгаль орчны газрын даргын 2025 оны А/109 дугаар тушаалаар байгуулагдсан гүйцэтгэлийг хүлээн авах Ажлын хэсэг 10 дугаар сард тарьсан модны амьдралт 81 хувьтай байгааг тогтоон, акт үйлдэж уг ажлын гүйцэтгэлийг хүлээн авсан.	100%
315	НХТЖҮЧ-6.3.	Булгийн эхийг тохижуулж хамгаалах	НБОГ	НТ	2023	22	Тохижуулж, хамгаалсан булаг	тоо	26	100	2025 онд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр Баянзүрх дүүргийн 20-р хорооны Дээндийн амны “Дээд булаг”, 33-р хорооны “Баяндөхөмийн булаг”, “Шивэртийн амны булаг”, 11 дүгээр хорооны “Сахарын рашаан”, аж ахуйн нэгж байгууллагын хөрөнгөөр дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд Баянзүрх дүүргийн 33-р хорооны Шар хоолойн "Хавчуугийн булаг", Хан-Уул дүүргийн 14-р хорооны "Гавьжийн шанд", Түргэний гол дагуу "Хар үзүүрийн булаг", 12-р хорооны "Биогийн булаг", "Булгатайн булаг"-ийн эхийг, нийт 9 булгийн эхийг хашиж хамгаалсан.	100%
316		Гадаргын ус хуримтлуулах хөв цөөрмийн зураг төсөв хийх	НБОГ	НТ	2023	1	Боловсруулж батлуулсан зураг төсөв	тоо	4	300	Нийслэлийн нутаг дэвсгэрт Баянзүрх дүүргийн 20-р хороо Дээндийн аманд 1, Хан-Уул дүүргийн 14-р хороо Түргэний гол дагуу 1, Налайх дүүргийн 1-р хорооны Энгэр шандад 1, Сонгинохайрхан дүүргийн 21-р хороо Мухарын аманд 1, Нарийн гол дагуу 2, нийт 6 хөв цөөрөм (усан сан) байгуулах ажлын зураг төсөв боловсруулах ажлыг хийлгэсэн.	100%
317		Улаанбаатар хотын газар доорх усны органик бохирдлын зөвгдлийн загварын судалгаа хийх	НБОГ	НТ	2023	-	Судалгааны тайлан	тоо	1	383.4	Улаанбаатар хотын газар доорх усны органик бохирдлын зөвгдлийн загварын судалгаа хийх ажлыг Нийслэлийн Хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгуулсан боловч санхүүжилт нь батлагдаагүй болно.	0%
318		Хамгаалалтын бүс тогтоогоогүй гол, горхи, булаг, шанд, рашаан, нуур, тойромд усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоох судалгааны ажил хийх.	НБОГ	НТ	2023	-	Судалгааны тайлан	тоо	1	100	Хамгаалалтын бүс тогтоогоогүй гол, горхи, булаг, шанд, рашаан, нуур, тойромд усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс тогтоох судалгааны ажил хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан. Гүйцэтгэгчээр "Дижитал мэппинг" ХХК шалгарч, НБОГ/20250201015 дугаартай ажил гүйцэтгүүлэх гэрээг байгуулсан. Гэрээт ажлыг гүйцэтгүүлж байна.	85%
319		Уул уурхайн олборлолтын улмаас эвдэгдсэн газрын нөхөн сэргээлт хийх	НБОГ	НТ	2024	40	Нөхөн сэргээлт хийх талбайн хэмжээ	га	40	600	Налайх дүүргийн 3 дугаар хорооны нутаг дэвсгэрт 20 га талбайд Нийслэлийн төсвийн хөрөнгөөр “Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх” ажлын даалгаврыг боловсруулж, Газрын даргын 2025 оны А/21 дүгээр тушаалаар байгуулагдсан үнэлгээний хороонд хүргүүлсэн. Уг ажлын даалгаврын дагуу зарлагдсан нээлттэй сонгон шалгаруулалтад “Эм Ди Юу” ХХК нь 296.3 сая төгрөгөөр уг ажлыг гүйцэтгэхээр шалгарч, ажил гүйцэтгэх НБОГ/20250101013 дугаартай гэрээ байгуулан гэрээнд заасны дагуу гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэлийг томилогдсон Ажлын хэсэгт акт үйлдэн хүлээлгэж өгсөн. Ажлын даалгаврын дагуу 20 га талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлтийг хийсэн бөгөөд 2 га талбайд навчит мод тарьж, модны ургалтад шаардлагатай усалгааны зориулалттай худаг гаргаж Налайх дүүргийн 3 дугаар хороонд хүлээлгэн өгөөд байна.	100%
320	НХТЖҮЧ-6.2.11,	Геологи, уул уурхай, авто замын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон, орхигдсон газруудын судалгаа хийх, хохирлыг тогтоох	НБОГ	НТ	2023	-	Судалгаа хийх талбайн хэмжээ	га	500	150	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны тогтоолоор төсөв батлагдаагүй хасагдсан тул хэрэгжүүлэх боломжгүй байна.	0%
321		Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага хотын стандартын хэрэгжилтийг хангуулах	ХБХСГ, УБЗАА, ХТГ	НТ	2023	-	Хяналт тавьсан байгууллага	тоо	30	30	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 25/05 дугаар тогтоолоор Хот төлөвлөлт, хот байгуулалт бүлгийн UCS0302B:2025 "Оршуулгын газрын орчны эрүүл, аюулгүй байдлын ерөнхий шаардлага" хотын стандартыг батлуулж, 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдүүлэхээр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба болон нийслэлийн 9 дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 01/301 дугаартай "Хотын стандартын хэрэгжилтийг хангуулан хамтран ажиллах тухай" албан бичиг, Буяны зан үйлийн холбоо ТТБ-д 03 дугаар сарын 25-ны өдрийн 01/314 тоот албан бичгээр хотын стандартыг тус тус хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/370 захирамжийн хэрэгжилтийг хангуулах Ажлын хэсэгт “Оршуулгын үйл ажиллагаа эрхлэх, зохион байгуулах, зөвшөөрөлтэй оршуулгын газар болон зөвшөөрөлгүй газар оршуулсан шарилыг шилжүүлэх" журмын хэрэгжилтийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, оршуулгын үйл ажиллагаа эрхлэгч 30 аж ахуй нэгж, байгууллагад батлагдсан хотын стандартыг танилцуулсан. Мөн оршуулгын үйлчилгээ эрхлэгч нарт 2025 оны 05 дугаар сарын 29-ний өдөр хотын стандартын танилцуулга сургалтыг зохион байгуулан ажиллалаа.	100%

322	НХТЖҮЧ 5.3.3	Агаарын чанарын стандарт шинэчлэн боловсруулж, батлуулах	НАОБТГ, ХБХСГ, НБОГ,	НТ	2023	-	Батлагдсан хотын стандарт	тоо	1	50	Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартыг шинэчлэх ажлын хүрээнд Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн агаар бохирдуулах түгээмэл тархалттай бохирдуулах бодисын агууламжид өөрчлөлт оруулах саналыг боловсруулан 2025 оны 06 дугаар сарын 03-ны өдөр Стандарт хэмжилзүйн газрын Байгаль орчны стандартчлалын техникийн хороогоор хэлэлцүүлсэн. Стандарт хэмжилзүйн газрын даргын 2025 оны 06 дугаар сарын 19-ны Б/20 дугаар тушаалаар Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2016 стандартыг хүчингүй болгож Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585:2025 стандартыг шинэчлэн баталсан.	100%
323		Орон сууцны хороолол дахь ногоон байгууламж хотын стандартын төсөл боловсруулж, батлуулах	ХБХСГ	НТ	2023	-	Батлагдсан хотын стандарт	тоо	1	50	Хот байгуулалт, хотын стандартын газрын даргаар 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр “Орон сууцны хороолол дахь ногоон байгууламж” хотын стандартын ажлын даалгаврыг батлуулсан. (2025 оны төсөвт тусгуулахаар саналаа хүргүүлсэн боловч хөрөнгө тусгагдаагүй.)	0%
ТАВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО												
5.1 Цахим засаглал												
Салбарын үр дүн: Иргэдийн оролцоог хангасан, авилгаас ангид, үр нөлөөтэй, цахимжсан, хариуцлагатай, мэргэшсэн тогтвортой засаглалыг төлөвшүүлнэ.												
324	НХТЖҮЧ-5.3.2	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх	НЗДТГ- ТЗУГ	-	2024	НҮНТ-ийн үйл ажиллагааны тур журам	Батлагдсан үйлчилгээний стандартын хэрэгжилт	хувь	100	-	Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагаанд үйлчилгээний стандартыг нэвтрүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд: 1.Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн салбарууд нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйлчилгээ авахад зориулсан налуу зам, авто зогсоол, тэргэнцэртэй бөгөөд Баянгол, Мишээл салбарт харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан харааны шил, таягыг шинээр байршуулж, 6 салбарт барель үсэгтэй Төрийн үйлчилгээний жагсаалтыг товхимол хэлбэрээр хэвлүүлэн ашиглаж байна. 2.Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төв болон нийслэлийн 9 дүүрэг бусад нутгийн захиргааны байгууллагаас үйлчилгээ авч буй иргэн, хуулийн этгээдээс үйлчилгээний чанар, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн үнэлгээг авч хэвшсэн бөгөөд үнэлгээнд тулгуурлан тухай бүр үйлчилгээ үзүүлэх орчин нөхцөл, үйлчилгээний шат дамжлага, хүнд суртлыг бууруулах, иргэдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн цахимжуулах үйлчилгээний судалгааг гарган холбогдох байгууллагад хүргүүлэх зэрэг ажлыг зохион байгуулан ажилласан. 3.Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 84 дүгээр тушаалаар баталсан “Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны журам”, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/01 дүгээр захирамжийн 1 дүгээр хавсралтаар баталсан “Нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн үйл ажиллагааны тур журам”, Төрийн албаны үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага MNS 7068:2025, Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 6984:2022, МУЗГ-ын 2023 оны 100 дугаар тогтоолоор 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам" зэрэг журам, стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, операторын горимоор үйлчилгээг үзүүлэх ерөнхий шаардлага, стандартыг ханган ажиллаж байна.	100%
325		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг цахимжуулж, цахим үйлчилгээний нэгдсэн портал “E-Mongolia”-д холбох	НЗДТГ- ТЗУГ, НЗДТГ- МТГ	-	2024	110	Хур системд нэвтэрсэн үйлчилгээний тоо	тоо	22	-	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд үзүүлж буй үйлчилгээг цахимжуулах зорилгоор “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем” дээр үзүүлж буй 134 үйлчилгээг “И-Монгол академи” УТҮГ-ын систем "e-business.mn" төрийн нэгдсэн систем рүү шилжүүлэхээр хамтарсан ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган хамтран ажиллаж байна. Онлайн бизнес төв”-ийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн үндсэн систем дээр явагдаж байгаа процессыг “И-Монгол академи“ УТҮГ-аас судалж систем хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд иргэн, хуулийн этгээдийн шийдвэрлэлтийн процессыг судалж, илүү хялбарчлах арга хэмжээг боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	100%
326	ШСБ-6.1	Онлайн бизнес төвийн үйлчилгээ эрхлэх бүртгэлийн системийг хөгжүүлэх	НЗДТГ- МТГ, УБЗАА	НТ	2023	134	Цахимжуулсан төрийн үйлчилгээ	тоо	174	200	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн хуралдаанаар зөвшөөрлийн “Хур” системийг ашиглан, “И-Монгол”-ын "e-business.mn" системд нэгтгэх арга хэмжээг 2025 оны 05 дугаар сарын 1-ний өдрийн дотор багтаан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. Иймд “Онлайн бизнес төв”-ийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн систем” дээр үзүүлж буй 134 үйлчилгээг “И-Монгол академи” УТҮГ-ын систем И-бизнес төрийн нэгдсэн систем рүү шилжүүлэхээр хамтарсан ажлын төлөвлөгөө гарган төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган хамтран ажиллаж байна. Онлайн бизнес төв”-ийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн үндсэн систем дээр явагдаж байгаа процессыг “И-Монгол академи“ УТҮГ-аас судалж систем хөгжүүлэлтийн ажлыг гүйцэтгэж байгаа бөгөөд иргэн, хуулийн этгээдийн шийдвэрлэлтийн процессыг судалж, илүү хялбарчлах арга хэмжээг боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.	77%
5.2 Орон нутгийн засаглалын бие даасан байдал												
327		Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэлийг бууруулах, гэр хорооллыг орон сууцжуулах тухай хуульд заасан журам, шийдвэрийг боловсруулж, батлуулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах	НЗДТГ -ХТГЭЗГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	20	Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/332 дугаар захирамжаар Нийслэлийн нутаг дэвсгэрт ачаа, түгээлт, хүргэлтийн үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулах, дэмжлэг үзүүлэх журмыг баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 7202 дугаартай бүртгэгдсэн.	100%

328	НХТЖҮЧ-5.1.2	Хууль, эрх зүйн шинэчлэлийг үргэлжлүүлэх эрх зүйн сургалт, сурталчилгаа, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулах	НЗДТГ -ХТГЭЗГ	НТ	2023	2	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	4	140	1."Иргэдэд хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх өдөрлөг"-ийг сар бүрийн 3 дахь долоо хоногийн Лхагва гарагт тусгай дугаарын утсаар болон нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан нийт 10 удаа зохион байгуулсан. Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, иргэдэд анхан шатны хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх "Хуульчийн Про боно өдөр 2025" өдөрлөгийг Монголын Хуульчдын холбоотой хамтран 2025 оны 05 дугаар сарын 01-ны нийслэлийн хэмжээнд зохион байгуулж 1836 иргэнд хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн. 2.Ерөнхий боловсролын 8-11 дүгээр ангийн сурагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр Нийслэлийн нийт 72 сургуулийн 7906 сурагчид сургалт зохион байгуулсан. Азийн 13 дахь Про боно чуулга уулзалтыг Монголын Хуульчдын холбоотой хамтран 2025 оны 10 дугаар сарын 01–06-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, 29 орны 250 орчим хуульч, хуулийн фирмүүд, судлаач, төрийн болон иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл оролцож, туршлага, санаачлагаа хуваалцсан. Нийслэлийн прокурорын газрын хяналтын харьяа Нийслэлийн байгууллагын нийт 190 эрх бүхий албан тушаалтанд зөрчлийн бүртгэл мэдээллийн нэгдсэн системийн сургалтыг зохион байгуулсан. 3.Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн, Дүүргүүдийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн мэргэжилтнүүдэд Захиргааны шийдвэр ба хүний эрх, Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа,үйлчилгээ эрхлэх нийтлэг журмыг шинэчлэсэнтэй холбогдуулан 2025 оны 03 дугаар сарын 25-ны өдөр сургалт зохион байгуулсан. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын хууль, эрх зүйн асуудал хариуцсан 40 мэргэжилтнүүдийн дунд Үндсэн хуулийн асуулт хариултын тэмцээн зохион байгуулсан.	100%
329		Олон улсын санхүүгийн төвийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, хязгаар, эрх зүйн үндсийг тогтоох чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран санал боловсруулах	НЗДТГ -ХТГЭЗГ, НЗДТГ-СХОГ	-	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	-	Олон улсын санхүүгийн төвийн удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны хүрээ, хязгаар, эрх зүйн үндсийг тогтоох чиглэлээр холбогдох байгууллагатай хамтран санал боловсруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	85%
330		Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэгжүүлж, нэгжийн удирдлагаас хотын удирдлагад чиг үүргийг шилжүүлэх ажлыг зохион байгуулах	НЗДТГ -ХТГЭЗГ, НЗДТГ-ТЗУГ, НЗДТГ-НБТГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	200	Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1309 дүгээр захирамжаар байгуулагдсан (14 хот, 3 дагуул хот, 42 хорооллыг байгуулах шилжилтийн үйл ажиллагааг нийслэлийн нутаг дэвсгэрт зохион байгуулах чиг үүрэг бүхий) Ажлын хэсэгт Нийслэлийн агентлагуудаас 14 хот, 3 дагуул хот, 42 хорооллын төлөвлөлттэй уялдуулан бүтэц орон тоо, чиг үүргийн хуваарилалт, төсвийн урьдчилсан тооцооллыг гаргуулж, бүтэц, орон тооны саналыг боловсруулсан. Бүтэц, орон тоог аль болох орон тоо нэмэгдүүлэхгүй, одоо байгаа бүтэц, орон тоогоо оновчтой хуваарилах зарчимд суурилсан. Одоо байгаа бүтэц, орон тоо нь 16,892, нэмэгдүүлэх орон тоо 3728,14 хот, 3 дагуул хот, 42 хороолтой уялдуулан төлөвлөсөн орон тоо 20,620. Бүтэц, орон тооны хувьд Нийслэлийн Эрүүл мэндийн газар 700 буюу 8.3 хувь, Нийслэлийн Биеийн тамир, спортын газар 630 буюу 31.4 хувь, Нийслэлийн Нийтлэг үйлчилгээний газар 238 буюу 47.7 хувь, Нийслэл дэх Улсын бүртгэлийн газар 205 буюу 48.8 хувь, Нийслэлийн Боловсролын газар 129 буюу 186.9 хувиар тус тус нэмэгдүүлэх санал ирүүлсэн байна. Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газар 23 буюу 18.7 хувь, Хот байгуулалт, хотын стандартын газар 40 буюу 31.2 хувиар тус тус бүтэц, орон тоог бууруулах санал ирүүлсэн байна. Нийслэлийн 14 хот, 3 дагуул хот, 42 хорооллын төлөвлөлттэй уялдуулан гаргасан бүтэц, орон тооны өөрчлөлтийн саналыг 25 агентлаг, 9 дүүрэг нийт 34 байгууллага ирүүлснээс 17 буюу 50.0 хувь нь бүтэц, орон тоог нэмэгдүүлэх, 15 буюу 44.1 хувь нь одоогийн бүтэц орон тоогоор ажиллах, 2 буюу 5.9 хувь нь бүтэц, орон тоог бууруулах санал ирүүлсэн байна. Иймд Нийслэл Улаанбаатарын 14 хот, 3 дагуул хот, 42 хорооллын төлөвлөлтийн дагуу чиг үүргийн давхардлыг нэгтгэх, төрийн үйлчилгээг цахимжуулж, албан хаагчийн ачаалыг багасгах зэргээр одоогийн бүтэц, орон тоогоо оновчтой хуваарилж ажиллах боломжтой байна. Чиг үүргийн хуваарилалтын хувьд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд хотын чиг үүргийг тогтоосон байх бөгөөд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1-т заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын чиг үүргийг шилжүүлэх асуудлыг УИХ-ын 2024 оны 72 дугаар тогтоолоор шийдвэрлэсэн байна.	100%
331		Нийслэл хотын эдийн засгийн тусгай бүсүүдийг хөгжүүлж, үйл ажиллагааг нь тогтворжуулах.	ХБХСГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	200	Засгийн газрын 2024 оны 220 дугаар тогтоолоор Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 9000 га-д хүлэмж, хүнс, нарийн ногооны агуулах, үйлдвэрлэлийн чиглэлээр Агросити эдийн засгийн тусгай бүс, Налайх дүүргийн 3, 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт тээвэр логистик, барилгын материалын үйлдвэрлэлийн чиглэлээр Налуу-Ухаа эдийн засгийн тусгай бүс байгуулахаар баталсан. Тус ажлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1306 дугаар захирамжаар "Эдийн засгийн тусгай бүсийн үйл ажиллагааг зохион байгуулах" үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан тусгай бүсийн үйл ажиллагааг зохион байгуулалтаар ханган ажилласан. Ажлын хэсгийн хүрээнд боловсруулагдсан Эдийн засгийн тусгай бүсийн Захирагчийн ажлын албыг байгуулах, Захирагч томилох, Бүтэц, орон тооны хязгаар батлах тухай захирамжийн төслийг Нийслэлийн Засаг даргын Зөвлөлийн 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01 дүгээр хурал болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/117, А/118, Б/23, Б/24 дугаартай захирамжуудаар тус тус батлуулсан. Захирачийн ажлын алба байгуулагдан үйл ажиллагаагаа зохион байгуулан ажиллаж байна. Мөн "Тусгай бүсэд үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулах, татварын бус дэмжлэг үзүүлэх журам"-ын төсөл боловсруулж Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2025 оны 25/122 дугаар тогтоолоор батлуулсан.	100%

332		Шинэ Зуунмод хотын хөгжлийн корпорацыг байгуулж, Нийслэлийн дагуул Шинэ Зуунмод хотын бүтээн байгуулалтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулах	ХБХСГ	-	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	-	Засгийн газрын 2024 оны 114 дүгээр тогтоолоор Хүннү хотын хөгжлийн корпорац байгуулах тухай, Хөгжлийн корпорацын дүрмийн төсөл, Хүннү хотын хөгжлийн корпорацын төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах журмын төсөл баталсан. 2024 онд “Хүннү хотын эрх зүйн байдлын тухай” хуулийг баталж, мөн өдөр “Хот байгуулах тухай” Улсын Их хурлын 2024 оны 76 дугаар тогтоолоор “Хүннү хот”-ыг байгуулж, 31501.3га хотын эдэлбэр газрыг тогтоосон. Хүннү хотын эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулж, 2025.01.24-ний өдрөөс Хүннү хот болгон өөрчилж, 2025.02.15-ны өдрөөс мөрдөж эхэлсэн. **Дулаан хангамж:** Хүннү хотын эхний ээлжийн 120 Гкал/ц хүчин чадалтай дулааны станц (350 т/б) болон 2 өргөлтийн насос станц, 10 ус дулаан дамжуулах төв (32.6 т/б), 15 км дулааны гол шугамыг (70,5 т/б) барьж байгуулахаар төлөвлөсөн. Одоогийн байдлаар тус бүр 29мВт хүчин чадалтай 5 зуух бүхий дулааны станц, өргөлтийн насос, ус дулаан дамжуулах төв, дулааны гол шугамын (нийт 453,1 т/б) ажлын зураг төслийг боловсруулж экспертизийн магадлал, баталгаажуулалтад оруулсан. **Цэвэрлэх байгууламж:** Хүннү болон Зуунмод хотуудын дунд 20000 м3/хоног хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг төлөвлөсөн бөгөөд эхний ээлжийн 3000м3/хоног хүчин чадалтай (34.8 т/б) цэвэрлэх байгууламжийн ажлын зураг төслийг Наран рашаан ХХК боловсруулж, экспертизийн магадлал, баталгаажуулалтад оруулсан. **Ариутгах татуурга:** Нийт 22.6 км урттай ариутгах татуургын гол шугам сүлжээний /21.5 т/б/ ажлын зураг төслийг 2022 онд Наран рашаан ХХК-д боловсруулж, 2023 онд экспертизийн магадлал, баталгаажуулалтад хамруулсан. Одоогийн байдлаар тус шугам сүлжээний барилга угсралтын ажлыг хийж гүйцэтгэх зорилгоор Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны төсвийн багцад суулгахаар ажиллаж байна. **Үерийн хамгаалалтын шугам сүлжээ:** Үерийн хамгаалалтын 4 багц 26.9км (нийт 50т/б) шугам барихаар төлөвлөгдсөнөөс одоогийн байдлаар 2 багц 11,1км (17,6 т/б) шугамын ажил хийгдэж ажлын гүйцэтгэл 65 хувийн гүйцэтгэлтэй байна. Үерийн хамгаалалтын 2 багц 15.8км (32.4 т/б) шугамын ажлыг Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайдын 2025 оны төсвийн багцад суулгахаар ажиллаж байна. **Ус хангамж:** Хүннү хотын эхний ээлжийн ус хангамжийн 24км урт шугам сүлжээ, 5 гүний худаг, 1 насос станц, 2х2000м3 усан сангийн (20т/б) угсралтын ажлууд 2023 оноос эхлэн хийгдэж байгаа бөгөөд 62 хувийн гүйцэтгэлтэй байна. **Цахилгаан хангамж:** Хүннү хотын эхний ээлжийн цахилгаан хангамжийн ажлын хүрээнд 220кВ-ын 1, 110кВ-ын 1, 35кВ-ын 1 буюу нийт 3 дэд станц, нийт 102км урт бүхий цахилгаан дамжуулах агаарын шугамын (120т/б) угсралтын ажлыг 2022 оноос эхэлсэн бөгөөд гүйцэтгэл нь 50 хувьтай хэрэгжиж байна.	85%
333		Хотын шилжилт хөдөлгөөний төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах	НЗДТГ- ТЗУГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	20	Шилжилт хөдөлгөөний төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа, статистик мэдээ, өгөгдөл боловсруулах ажил хийгдэж байна. Өнөөдрийн байдлаар НҮБ-ын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын “Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй шилжилт хөдөлгөөнийг зохицуулах нь” төслийн хүрээнд "Уур амьсгалын өөрчлөлт ба шилжилт хөдөлгөөн судалгаа"-ны хүрээнд анхдагч болон хоёрдогч эх сурвалжаас цуглуулсан дата, мэдээлэл дээр хамтран ажиллаж, анхдагч эх сурвалжаас цуглуулсан дата, мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хоёрдогч эх сурвалжийн дата, мэдээллээр баяжуулан баталгаажуулж, нэгдсэн санал, зөвлөмжийг боловсруулах ажил хийгдэж, судалгааны тайлан гарсан. Мөн ХЭЗК-ийн захиалгаар хийгдсэн Нийслэл дэх шилжилт хөдөлгөөн, шилжин суурьшигчдад тулгамдсан хүний эрхийн асуудал судалгаанд дэмжлэг өгч ажилласан бөгөөд дээрх 2 судалгааны үр дүнгээс Нийслэлийн хүн амын шилжих хөдөлгөөнд хамаарал бүхий бодлогын баримт бичигт, тухайлбал, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичигт Улаанбаатар хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөнийг төвлөрлийг саарруулах талаарх дагуул, хаяа хот, тосгодыг хөгжүүлэх зэрэг бодлогын зорилтуудад тусгалаа олсон байна. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд дэлгэрэнгүй дурджээ. Тус бичиг баримтад нийт 17 дагуул, хаяа хот, тосгон, сууринг чиглэл бүрээр хөгжүүлж, нийслэлийн хүн амын өсөлтийг тооцож, тэдгээр дагуул, хаяа хотуудад хэрхэн суурьшуулах талаар дэлгэрэнгүй тусгасан байгаа. Тодруулбал, Улаанбаатар хотын нутаг дэвсгэр 532.04 мян га, хүн ам нийт 2.2 сая, Улаанбаатар хотод 1.6 сая, дагуул, хаяа хотуудад нийт 600 мянган хүн байхаар төлөвлөжээ. Улаанбаатар хотын 2040 он хүртэлх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг боловсруулаад 2025 онд УИХ-аар хэлэлцүүлэхээр өргөн барьсан боловч тус ерөнхий төлөвлөгөө УИХ хараахан хэлэлцэн баталж амжаагүй байна. Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний төслийг дахин үнэлж, УИХ-аар батлуулбал тус төлөвлөгөөнд ирэх 20 жилийн хугацаанд Нийслэл хотыг чиглэсэн дотоод шилжих хөдөлгөөнийг дагуул, хаяа хот, тосгон, суурингуудад шингээх талаар судалгаа, шинжилгээтэй арга хэмжээний төлөвлөгөө үндсэндээ туссан байгаа.	100%
334		Улаанбаатар хот “20 минутын хот” үзэл баримтлалын дагуу Улаанбаатар хотын дэд төвүүдийн захиргаа, засаглалын тогтолцоог тодорхойлох, салбар хоорондын хамтын ажиллагааг дэмжих, зохион байгуулах	НЗДТГ-ТЗУГ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	100	Орчин үеийн хот төлөвлөлт, хөгжлийн чиг хандлага нь иргэдийн амьдралын чанарыг сайжруулах, байгаль орчныг хамгаалах, нийгмийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна. "20 минутын хот" гэдэг нь иргэд өөрийн оршин суугаа газраасаа 20 минутын дотор алхах, дугуй унах, нийтийн тээврээр зорчих замаар бүх төрлийн нийгмийн суурь үйлчилгээг авах боломжийг бүрдүүлэхийг зорьж буй хот төлөвлөлтийн үзэл баримтлалд нийцүүлэн нийслэл болон хот, хороллын удирдлан удирдлагын тогтолцооны нийслэлийн дэргэдэх хөгжлийн болон дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлэх үндсэн корпорацууд тэдгээрийн үйл ажиллагаа, уялдаа холбоог тодорхойлсон. 20 минутын хот-чиг үүрэг ба удирдлагын тогтолцоо (үзэл баримтлал, эрх зүйн үндэс ба одоогийн чиг үүрэг, шинэ удирдлагын загварын үндсэн зарчим, Чиг үүргийн дахин хуваарилалт, байгууллагын бүтэц, хэрэгжүүлэгч нэгжүүд) Мөн нийслэлийн хэмжээнд метро, орон сууц, зам, эрчим хүч, хий, худалдаа-үйлдвэрлэл зэрэг салбарын корпораци, агентлагууд-аар дамжуулан хөгжлийн болон дэд бүтцийн томоохон төслүүдийг хэрэгжүүлэх загварыг боловсуулж санал боловсруулсан.	85%
335	НХТЖҮЧ-5.1.2	Нийслэлийн өмчит харьяа байгууллагуудад чиг үүргийн шинжилгээ хийж, үр ашгийг нэмэгдүүлж, менежментийн реформ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох	НЗДТГ-ТЗУГ	НТ	2024	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	100	Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актад заасны дагуу төрийн байгууллагууд нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн, хариуцлагатай, ил тод, үр дүнтэй засаглалыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хүрээнд төрийн байгууллагуудын гүйцэтгэлийг зөвхөн гадаад хяналт, шалгалтын аргаар бус, дотоод үнэлгээ, өөрийн шинжилгээ, сайжруулалтад суурилсан соёл төлөвшүүлэх нь орчин үеийн засаглалын шинэчлэлийн гол хандлага болж байна. Засаглалын шинэчлэлийн хүрээнд төрийн байгууллагуудын удирдлагын тогтолцоо, гүйцэтгэлийн чанар, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний хүртээмж, хариуцлагын тогтолцоог боловсронгуй болгох шаардлага өмнө нь хэзээ ч байгаагүй хэмжээнд тулгарч буйг олон улсын болон үндэсний судалгааны дүн харуулж байна. Үүний тод илрэл бол иргэдийн төрд итгэх итгэлийн түвшин буурсан, төрийн үйлчилгээний чанарт тавих олон нийтийн хүлээлт нэмэгдсэн, хүнд суртал, ил тод бус байдалтай холбоотой шүүмжлэл нэмэгдэж буй явдал юм. Иймд энэхүү нөхцөл байдлыг өөрчлөх, төрийн байгууллагын системийн уялдаг бэхжүүлэх, өөрчлөлт шинэчлэлийг дэмжих бодит суурь үнэлгээг бий болгох, засаглалын реформ хэрэгжүүлэх бодлогын баримт бичиг боловсруулах, байгууллагуудын стратеги төлөвлөгөөнд тусгаж хэрэгжилтийг хангах зорилгоор Нийслэлийн нутгийн захиргааны 76 байгууллагуудын засаглалын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох үнэлгээ хийж засаглалын реформ хэрэгжүүлэх "Тогтвортой хөгжилт түшиглэсэн засаглалын шинэчлэлийн хүрээг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газар болон Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөнд засаглалын бодлогын ажил "Тогтвортой хөгжилд түшиглэсэн засаглалын шинэчлэлийн бодлого" стратегийн зорилтын хүрээнд бүрэн тусгаж ажиллалаа. Стратеги төлөвлөгөөний хүрээнд "Тогтвортой хөгжилд түшиглэсэн засаглалын шинэчлэлийн бодлого" -ийг хэрэгжүүлэх чиглэлээр нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд төлөвлөгөөндөө тусган, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%

336	5.1.2	Нийслэлийн зарим чиг үүрэг, ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх	НЗДТГ- ТЗУГ	-	2023	3	Хувийн хэвшилд шилжүүлсэн үйлчилгээ	тоо	24	-	Засгийн газрын 2022 оны 340 дугээр “Хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд нийслэлийн 9 дүүргийн хэмжээнд хот тохижилт, нийтийн аж ахуйн 7 чиглэлийн ажил үйлчилгээг сонгон шалгаруулалтын үндсэн дээр нийт 85 хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудад шилжүүлсэн байна. Үүнд: Баянзүрх-33, Баянгол дүүрэг-20, Сонгинохайрхан дүүрэг-32. Мөн дээрх ажлын хүрээнд Налайх, Хан-Уул, Багахангай, Сүхбаатар , Чингэлтэй, Багануур дүүргүүд хот тохижилт, нийтийн аж ахуйн зарим ажил үйлчилгээг хувийн хэвшил, төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх чиглэлээр ажлын хэсэг байгуулах, тооцоо судалгаа, сонгон шалгаруулт хийх ажлыг зохион байгуулж байна.	100%
337		MNS ISO 9001 - чанарын менежментийн тогтолцооны стандартыг баталгаажуулж гэрчилгээ авах	НЗДТГ- ТЗУГ	НТ	2022	-	Стандартыг нэвтрүүлсэн байгууллага	тоо	21	160	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн “Нийслэлийн хэмжээнд засаглалын үзүүлэлтийг тооцох, чанарын удирдлагын тогтолцооны MNS 180 9001:2016 стандартын баталгаажуулах ажлыг зохион байгуулах тухай” А/1041 дүгээр захирамжаар эрх шилжсэн НХААГ/20240103580 дугаартай "Нийслэлийн нутгийн захиргааны зарим байгууллагуудад MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулалт хийлгэх нээлттэй тендер зарлаж, “ЭС ЭФ СИ ЭС” ХХК (Багц 2,4), Менежмент ба ур чадварын хүрээлэн (5) шалгарч, улмаар 10 байгууллага олон улсын чанарын менежментийн тогтолцооны MNS ISO 9001:2016 стандартын гэрчилгээ авлаа. Тус нээлттэй тендэрийн хүрээнд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас 2025 оны 01 дүгээр сард “Гэрээ байгуулах тухай” 03/198, 03/199 дугаар албан бичиг ирүүлснийг үндэслэн Менежмент ба ур чадварын хүрээлэн ТББ (1,3) -тай гэрээ байгуулж, MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцооны стандартын дотоод аудит болон баталгаажуулах ажлыг эхлүүлж, нийт 21 (үүнээс 3 - байгууллага татан буугдсан) байгууллага баталгаажилтын гэрчилгээ авч бусад нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд MNS ISO 9001:2016 чанарын менежментийн тогтолцоо нэвтрүүлэх бэлтгэл ажлыг хангаж байна.	100%
338		Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дагуу нийслэлийн хэмжээнд засаглалын үзүүлэлтийг тооцох	НЗДТГ-ТЗУГ	НТ	2022	-	Аргачлалын баримт бичиг	тоо	1	50	Нийслэлийн Засаг даргын 2024 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/1041 дүгээр захирамжаар эрх шилжсэн НХААГ/20240103581 дугаартай "Дэлхийн банкны засаглалын үзүүлэлтийн дагуу нийслэлийн хэмжээнд засаглалын үзүүлэлтийг (тохируулан) тооцох аргачлалыг боловсруулах, үзүүлэлтийг тооцох үнэлгээ хийх" нээлттэй тендер зарлаж, “Статистик дэвшил” НҮТББ шалгарч, зөвлөх үйлчилгээний гэрээ (гэрээт ажил 2025 оны 04 дүгээр сард дуусан) байгуулан засаглалын үзүүлэлт тооцох аргачлалыг боловсруулсан бөгөөд тус аргачлалын хүрээнд Нийслэл хотын 2024 оны засаглалын төлөв байдлын үнэлгээ (суурь үнэлгээ) 3.5 (0-5 балл) байна. Тус аргачлалын дагуу нийслэлийн засаглалын төлөв байдлыг үнэлгээг жил бүр хийж харьцуулсан мэдээлэл бэлтгэх талаар тусгасны дагуу 2025 оны нийслэлийн засаглалын төлөв байдлын үнэлгээ хийх бэлтгэл ажлыг хангаж байна.	100%
339	НХТЖҮЧ-5.1.2	Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх	НЗДТГ-ХНХХ	НТ	2023	-	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	80	Нийслэлйн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хороо 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар "Ёс зүйн дэд хороо"-ны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөөг баталсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Ёс зүйн хорооны гишүүн, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн багш М.Цэрэнбат (Ph.D)-тай хамтран 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдөр "Төрийн албан хаагчийн ёс зүй" сэдэвт сургалтад нийт 100 гаруй албан хаагчийг хамруулсан. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооноос 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр НЗДТГ-ын нийт албан хаагч нарт зориулж Монгол Улсын төрийн шагналт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, Академич, МУИС-ийн Эмерит профессор, Япон Улсын Нагояагийн их сургуулийн хүндэт доктор С.Нарангэрэл нь "Хүмүүн байхын учир ёс суртахуунд нь оршвой" сэдэвт сургалтыг орсон.	90%
340		Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	НЗДТГ-ХНХХ	НТ	2023	6	Зохион байгуулсан арга хэмжээ	тоо	7	120	"1.НИТХ-аас 2025 оныг Авлигын эсрэг жил болгон зарласантай холбоотойгоор Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас “УЛААНБААТАР МАРАФОН-2025” олон улсын гүйлтийн өдөр Жанжин Д.Сүхбаатарын нэрэмжит талбайд Авлигатай тэмцэх газартай хамтран олон нийтэд авлигын нийгмийн хор аюулыг ухуулан таниулах, тэдэнд авлигыг үл тэвчих ёс суртахуун төлөвшүүлэх, уг ажиллагаанд тэднийг татан оролцуулах, Авлигатай тэмцэх газрын үйл ажиллагааг сурталчлан таниулах, зөвлөгөө мэдээлэл өгөх зорилгоор “ИРГЭН ТӨВТЭЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ӨДӨРЛӨГ”-ийг 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулсан. 2.“Бүсчилсэн хөгжил-төрийн албаны манлайлал” нийслэлийн зөвлөгөөний хүрээнд зохион байгуулсан нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 300 сурагчдад зориулсан “Төрийн алба-Бидний ирээдүй, Өнөөдрийг маргаашийн бахархал болгоё” арга хэмжээг Нийслэлийн Онцгой байдлын газрын хурлын танхимд 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулсан. 3.Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр иргэдэд хүүхэд багачуудад зориулан “ИРГЭН ТӨВТЭЙ СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ ӨДӨРЛӨГ"" зохион байгуулсан. 4.Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдийн дунд “Шударга зан Бидний гоёо” рийл бичлэгийн уралдааныг зарлан, нийгэмд эерэг үлгэрлэл үзүүлсан шударга ёсны агуулга бүхий 8 бүтээлийг 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдөр шалгаруулахаар ажиллаж байна. 5.Авлигын эсрэг олон улсын өдрийг угтан “Нийслэлийн төсөв асуудал, шийдэл: Иргэдийн хяналт” сэдэвт хэлэлцүүлгийг Нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нар, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагууд, эрдэмтэн судлаач, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулан 2025 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн АТГ-тай хамтран зохион байгуулахаар ажиллаж байна. Үр дүн: Авлига ашиг сонирхлын зөрчил болон ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор нийт 5 арга хэмжээг зохион байгуулж, 3500 гаруй иргэнийг хамруулсан байна."	100%
341		Нийслэлийн төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтын тогтолцоог бэхжүүлж, ур чадвар, идэвх санаачилгыг нэмэгдүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулах	НЗДТГ-ХНХХ	НТ	2023	9,451	Сургалтад хамрагдсан албан хаагчид	тоо	9,500	635.4	1. Тайлант хугацаанд 24 төрлийн нийт 103 удаагийн 422 цагийн сургалтад ННЗБ-ын 65 байгууллагын 2474 албан хаагчийг хамруулсан. Сэтгэл ханамжийн дундаж үнэлгээ-91.8 хувь. 2. ННЗБ-уудын албан хаагчдын идэвх, хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор 4 төрлийн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна. Үүнд: -Мэтгэлцээний тэмцээнд 18 байгууллагын 54, -"Ахмадын туршлага-Байгууллагын хөгжилд" хэлэлцүүлэгт 18 байгууллагын 65 албан хаагч тус тус хамрагдсан. Зөвлөн чиглүүлэх хөтөлбөрт шинээр томилогдсон 71 албан хаагчийг бүртгэн "Чадварлаг ажилтан-Хотын ирээдүй" 16 цагийн сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Нийслэлийн 9 дүүрэг, 21 аймгийн ЗДТГ-уудаас сайн туршлага илрүүлэх зорилгоор "Бүтээмж ба инновац" хөтөлбөрийг хэрэгжүүлж, хариуцах албан хаагчдад холбогдох мэдээллийг хүргэн ажиллаж байна.	100%
342		Сургалтын агуулга, хөтөлбөр боловсруулах, шинэчлэх, материаллаг орчныг сайжруулах, цахим сургалтын системийг хөгжүүлэх	НЗДТГ-ХНХХ	НТ	2023	43	Агуулга, хөтөлбөрийн тоо	тоо	47	427	1. “Улаанбаатар хотын хөгжлийн чиг хандлага, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн танилцуулга” сэдэвт 4 цагийн сургалтын агуулгыг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Нийт 8 сургалтад 9 байгууллагын 32 албан хаагчийг хамруулсан. Сэтгэл ханамжийн үнэлгээ 92.29 хувь байна. 2. ННЗБ-уудын Хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудад зориулсан сургалтын агуулга боловсруулалт хийгдэж байна. 3. 3 төрлийн шинэ сургалтын агуулгыг боловсруулан сургалтыг 5 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.	85%

343	МУХТЖҮЧ-5.4.4.	Мэдээлэл технологийн нарийн мэргэшсэн өндөр ур чадвар бүхий хүний нөөцийг бүрдүүлж, дэвшилтэт техник технологид суурилсан цахим шилжилт хийж нийслэлээс иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах	НЗДТГ-МТГ	НТ	2023	1	Нарийн мэргэжлээр мэргэшсэн албан хаагчид	тоо	8	590.7	1.Нийслэлийн Мэдээ, мэдээллийн https://www.ulaanbaatar.mn/ цахим хуудаст НЗДТГ-ын Хууль, эрхзүйн хэлтсээс ирүүлсэн хуулийн төслүүдийн холбогдох мэдээллийн хамт вэб хуудасны “Санал асуулга цэс” болон баннерын буланд цаг тухай бүрд байршуулж, иргэд олон нийтээс санал авч хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. 2.Нийслэлийн цахим үйлчилгээний http://eservice.ulaanbaatar.mn/-ээр иргэд олон нийтээс өргөдөл гомдол санал хүсэлтийн хэвийн үйл ажиллагаанд байнга хяналт тавин ажиллаж байна. 3.“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дотоод удирдлагын UB ERP” системийг өдөр тутмын хэвийн ажиллагаар хангах, шаардлагатай нэмэлт хөгжүүлэлт, тоног төхөөрөмжүүдийн техникийн туслалцаа дэмжлэг үзүүлж, мэргэжил арга зүйгээр хангаж ажиллаж байна. 4.“Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн https://service.ulaanbaatar.mn/ систем өдөр тутам иргэдээс ирдэг 10-15 дуудлагыг цаг хугацаанд нь шуурхай шийдвэрлэж, мэргэжил арга зүйн зөвлөгөөг өгөн ажиллаж байна. 5.Иргэний санал дэвшүүлэх Vote.ulaanbaatar.mn системээр иргэд олон нийтээс санал авахад хэвийн үйл ажиллагаанд хяналт тавьж, Нийслэлийн хэмжээнд иргэд олон нийтээс авах санал асуулгыг зохион байгуулан ажиллаж байна. 6.Нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь Мэдээллийн технологийн газартай бөгөөд Мэдээлэл технологийн нарийн мэргэжлийн инженер мэргэжилтэй 14 албан хаагчтайгаас ажиллаж байгаагаас Төрийн захиргааны ангиланд 11 албан хаагч, Төрийн үйлчилгээний ангиланд 9 албан хаагч ажиллаж байна. Үүнээс мэдээллийн технологийн нарийн мэргэшсэн өндөр ур чадвар бүхий 2 инженер Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 213 дугаар тогтоолын дагуу итгэлцүүр цалинтай ажиллаж байна.	100%
344	НХТЖҮЧ-4.6.1	Төрийн албаны хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын албан хаагчдыг олон улсын хурал, үзэсгэлэн, туршлага судлах аялалд тогтмол хамруулах	НЗДТГ- ГХХАГ, НЗДТГ - ТЗУГ, НЗДТГ-ННХХ	НТ	2023	100	Хамрагдсан албан хаагчид	тоо	105	750	2025 онд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч болон Тамгын газрын даргын 153 удаагийн захирамж, тушаалыг боловсруулж батлуулсан байна. Үүнд: Нийслэлийн Засаг даргын 88 удаагийн Захирамжаар 226 гаруй албан хаагч; Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 33 удаагийн тушаалаар 89 гаруй албан хаагч (23 албан хаагч харьяа газар), нийт 335 албан хаагч гадаадад албан томилолтоор ажилласан байна. Үүнээс нийт 112 гаруй албан хаагч олон улсын сургалт, семинарт хамрагдаж, 226 гаруй албан хаагч олон улсын хурал, чуулга уулзалтад оролцож, гадаадын улс, хотуудын туршлагаас судлав. Түүнчлэн гадаад томилолтоос гадна зочид, төлөөлөгчид хүлээн авсан, арга хэмжээ зохион байгуулсан захирамж, тушаалыг батлуулсан байна. Үүнд: -Хөрөнгө гаргах тухай – 23; -Хөдөлмөрийн гэрээний хугацаа сунгах тухай – 2; -Ажилд томилох тухай – 2 -Арга хэмжээ зохион байгуулах тухай – 3 -Ажлын хэсэг байгуулах тухай – 1 -Төлөөлөгчөөр ажиллуулах тухай – 1	100%
345		Улаанбаатар хоттой ах дүүгийн болон найрамдалт харилцаат хотуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа, төрийн албан хаагчдыг чадавхжуулах сургалтад хамруулах	НЗДТГ- ГХХАГ	НТ	2023	55	Хамрагдсан албан хаагчид	тоо	65	600	2025 оны жилийн эцсийн байдлаар Улаанбаатар хоттой ах дүүгийн болон найрамдалт харилцаат хотуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг өргөжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны хүрээнд: 1. ОХУ-ын Бүгд Найрамдах Буриад Улсын Тэргүүн Цыденов Алексей Самбуевич тэргүүтэй албаны төлөөлөгчдийг (34 хүн) 2025 оны 03 дугаар сарын 19-20-н өдрүүдэд Улаанбаатар хотод хүлээн авахыг ажлыг зохион байгуулав. 2. Монгол Улс, Унгар Улс хооронд дипломат харилцаа тогтоосны түүхт 75 жилийн ойн хүрээнд “Улаанбаатарын соёлын өдрүүд” арга хэмжээг 2025 оны 0 дугаар 09-ний өдрөөс 10-ны өдөр Будапешт хотод зохион байгуулав. 3. БНСУ-ын Үүнчонь хотоос 2025 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 30-ны өдөр зохион байгуулсан Хүүхдийн гар зургийн 3 дахь удаагийн олон улсы уралдаанд Монгол Хүүхдийн ордон, Урлан бүтээх төвийн 50 гаруй бүтээлийг хүргүүлж хамтран ажиллав. 4. Европын Холбооноос Монгол Улсад суугаа Төлөөлөгчийн газар, тус холбооны Монгол Улсад суугаа ЭСЯ-тай хамтран 2025 оны 05 дугаар сарын 17-ны өдө Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд “Европын өдөр” арга хэмжээг амжилттай зохион байгуулав. 5.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар 2025 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөс 30-ны өдөр БНХАУ-ын Бээжин хотноо ажиллаж, тус хотын дарга Ин Юнтай уулзлаа. 6.Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Х.Нямбаатар БНСУ-ын Гёнсаннам-до аймгийн Захирагч Пак Ван Сү тэргүүтэй 30 гаруй төлөөлөгчдийг 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр хүлээн авч уулзаж, нийслэлд хэрэгжих 24 мега төслийг танилцуулж, цаашид хамтарч ажиллах боломжийн талаар санал солилцов. 7.Нийслэлийн Засаг даргын нийгмийн салбар, ногоон хөгжил болон агаар, орчны бохирдлын асуудал хариуцсан орлогч А.Амартүвшин 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр Шанхай хотын орлогч дарга бөгөөд Нийгмийг аюулаас хамгаалах товчооны дарга Жан Яхун тэргүүтэй 6 хүний бүрэлдэхүүнтэй төлөөлөгчдийг Улаанбаатар хотноо хүлээн авч уулзаж, талууд хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурав.	100%
346	НХТЖҮЧ 5.3.2, 5.3.3	Улсын бүртгэлийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх	НУБГ	НТ	2022	3	Байгуулсан бүртгэлийн цэг	тоо	2	350	Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үйлчүүлэгчдийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх зорилгоор нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвийн шинэ салбарыг ХУД-ийн 23 дугаар хороонд байрлах “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын цогцолбор барилга”-ын “Б” блокын нэгдүгээр давхарт 413.42 м.кв талбайд 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдрөөс эхлэн үйл ажиллагаа явуулсан. Тус салбарын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхээр Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн үйлчилгээг 2025 оны 06 дугаар сарын 16-ны өдрөөс нэвтрүүлсэн бөгөөд нийт 51 төрлийн 66,225 бүртгэлийн үйлчилгээг хүн, хуулийн этгээдэд үзүүллээ.	50%
347	НХТЖҮЧ 5.3.2.3	Архивын барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэх	НАГ	НТ	2022	25	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	6,455.80	Архивын зориулалтын барилгыг 2020 онд 1.3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр эхлүүлж, барилгын суурийн цутгалт, дулааны холболт, цахилгааны дэд өртөөний байгууламж, холболтын ажлыг бүрэн хийж дуусгасан. Цар тахалтай холбоотойгоор Нийслэлийн төсвөөс дахин санхүүжилт хийгдээгүй тул цаашид барилгыг үргэлжлүүлэх боломжгүй 5 жил өнжсөн. 2. Улмаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас 2024 онд Сүхбаатар дүүрэг дэх архивын барилгын газар нь “Загвар гэр хороллын төсөл”-тэй давхардсан, хөрсний ус, цэвдэг ихтэй тул архивын зориулалтын барилга барихад тохиромжгүй гэсэн шалтгаанаар байршлыг өөрчлөх шийдвэр гаргасан. Нийслэлийн 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд Архивын барилга барих газрын шинэ байршлыг Хан-Уул дүүргийн 21 дүгээр хорооны нутаг дэвсгэрт 5000 м.кв газар олгохоор тусгаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн зөлжит бус II дугаар чуулганаар хэлэлцэж баталсан. Гэвч Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас шинээр олгох газрын байршилд давхцал үүссэн тул барилгын газрын асуудал шийдвэрлэгдээгүй байна. Иймд тус арга хэмжээний биелэлтийг Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.6. дахь хэсэгт заасан “Давагдашгүй хүчин зүйлийн улмаас бодлогын баримт бичгийн хэрэгжих хугацааг сунгасан бол биелэлтийг гүйцэтгэлд тулгуурлан тооцно” заалтын дагуу үнэллээ.	30%
348		Багануур дүүрэгт архивын барилга шинээр барих зураг төсөв боловсруулах	БНДЗДТГ	НТ	2023	-	Зураг төсөв боловсруулах ажлын явц	хувь	100	250	Багануур дүүргийн Засаг даргын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн “Эзэмшил газрын байршил өөрчлөх тухай” А/138 дугаар захирамжаар архивын газрын байршлыг өөрчлөн тогтоосон. Төрийн архивын барилгын зураг төслийн төсвийг 88,490,000 төгрөгөөр 2025 оны дүүргийн тодотголд тусгуулж батлуулаад байна.	50%
349	НХТЖҮЧ 5.3.2.5	Үндэсний төв архиваас хуулбарлан авсан Нийслэл Хүрээний түүхэнд холбогдох 1911-1924 оны үндэсний бичиг дээр үйлдэгдсэн холбогдох баримтыг хөрвүүлэх	НАГ	НТ	2023	-	Хөрвүүлэг хийгдсэн баримт, хуудас	тоо	827 баримт 5542 хуудас	36	Үндэсний төв Архивд хадгалагдаж буй Нийслэл Хүрээний түүхэнд холбогдох үндэсний бичиг дээр үйлдэгдсэн 1911-1924 оны 888 баримт, 5542 хуудас баримтыг хуулбарлан авсан. Үүнээс "Нийслэл Хүрээний түүхэнд холбогдох баримт бичгийн эмхэтгэл" 1, 2 дугаар боть ном гаргах ажлын хүрээнд 654 баримтын 4820 хуудсыг кирилл бичигт хөрвүүлсэн.	85%

350	НХТЖҮЧ 5.3.2.4	Нийслэл хотын түүхэнд холбогдох архивын баримтаар цуврал нийтлэл гаргах	НАГ	-	2023	59	Гаргасан нийтлэл	тоо	59	-	Их хотын баримтат өв “Ub weekly” нийтлэл гаргах ажлын хүрээнд нийтээр тэмдэглэх баяр ёслолын өдөр болон Улаанбаатар хотын түүхэнд холбогдох 18 хөмрөгийн 24 дансны 181 баримтыг судалж 2025 онд 59 удаа нийтлэл гаргах төлөвлөгөө боловсруулж 7 хоног бүрийн пүрэв гариг бүрд байгууллагын цахим хуудсанд нийтэлж, олон нийтэд сурталчилсан.□	100%
351	НХТЖҮЧ 5.3.2.4	Төрийн архивын сан хөмрөгийг нөхөн баяжуулах	НАГ	-	2023	50	Хүлээн авсан байгууллага	тоо	7	-	Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын 2025 оны 1-3 дугаар хурлаар нийт 24 байгууллагын данс бүртгэл, жагсаалтыг хэлэлцүүлэн батлуулж 15 байгууллагын 19,190 хадгаламжийн нэгжийг хүлээн авсан. Үүнд: -Цаасан суурьт 18,288 хадгаламжийн нэгж -Тусгай төрлийн 902 хадгаламжийн нэгж	100%
352	НХТЖҮЧ 5.3.2.5	Архивын цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг үргэлжлүүлэх	НАГ	НТ	2023	43.1	Цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын эзлэх хувь	хувь	52.5	124	Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж буй лавлагаа мэдээллийн эрэлт ихтэй 12,516,850 хуудас баримтаас 6,571,346 хуудас баримт буюу 52.5 хувийг цахимжуулсан. Цахимжуулалтын үр дүнд тус газраас архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээ үзүүлэх дундаж хугацаа 3 хоногоос 60 минут хүрч буурсан байна.	100%
353	ЗГ-ын 2020 оны 96 дугаар тогтоол	Нийслэлийн нутгийн захиргааны 130 байгууллагын албан хэргийг кирилл болон үндэсний хос бичгээр хөтлөх үйл ажиллагаанд хяналт тавих	НАГ	-	2023	-	Хяналт тавьсан байгууллага	тоо	130	-	1.Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Нийслэлийн нутгийн захиргааны 138 байгууллагад “Албан бичгийг хос бичгээр хөтлөх тухай” зөвлөмжийг 2025 оны 01/65 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2.Нийслэлийн нутгийн захиргааны 647 байгууллагын 1,358 албан хаагчид “Албан хэргийг хос бичгээр хөтлөх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх” сургалтыг 63 удаа зохион байгуулсан. 3.Нийслэлийн нутгийн захиргааны 1,143 байгууллагын үндэсний бичгийн 9 нэр төрлийн 3,001 хэвлэмэл хуудасны эхийг хянан баталгаажуулж, 669,530 ширхэг хэвлэмэл хуудсыг хэвлүүлэх зөвшөөрөл олгож, хэвлэсэн. 4.Нийслэлийн хэмжээнд нийт 958 байгууллага албан хэргээ хос бичгээр хөтөлж байна. Үүнд: - Нутгийн захиргааны 144 байгууллага - Дүүргийн харьяа 814 байгууллага	100%
354	НХТЖҮЧ-4.1.4	Нийслэлийн хот байгуулалтын салбарын тулгамдсан асуудлыг богино хугацаанд шийдвэрлэх төлөвлөлтийн шийдлийг мэргэжлийн холбоодтой хамтран боловсруулах	НЗДТГ-ДБХБХ	НТ	2023	-	Хамтарч ажиллах мэргэжлийн холбоод	тоо	10	500	354. Хот байгуулалтын салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хүрээнд холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран ажиллахаар төлөвлөсөн боловч төсөв батлагдаагүй улмаас тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан.	0%
355	МУХТЖҮЧ-2.5.6, 9.3.3 НХТЖҮЧ-6.2.3, 9.14.1	Ус хангамж, ариутгах татуургын мастер төлөвлөгөө боловсруулах	НЗДТГ-ДБХБХ	НТ	2023	-	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц	хувь	100	1,000.00	Нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 65 дугаар тогтоолоор "Хотын инженерийн бэлтгэл арга хэмжээний мастер төлөвлөгөө" батлагдсан. Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, уур амьсгалын тэсвэртэй байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Дэлхийн банктай хамтран “Улаанбаатар хотын үерийн эрсдэлийг бууруулах, бохир усны шугам сүлжээний шинэчлэлийн төсөл”, мөн Туул, Сэлбэ голын тохижилт, үерийн хамгаалалтын барилга байгууламж, усан сан барих төслийн техник эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулах, байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээний баримт бичиг боловсруулахаар ажиллаж байна.	100%
356		Орон сууц, нийтийн аж ахуйн салбарын мастер төлөвлөгөө боловсруулах	НЗДТГ-ДБХБХ	НТ	2023	-	Төлөвлөгөө боловсруулах ажлын явц	хувь	100	1,000.00	Орон сууц, нийтийн аж ахуйн инженерийн шугам сүлжээ, барилга байгууламжийг өргөтгөн шинэчлэх, дэвшилтэт техник, тоног төхөөрөмж суурилуулах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, ашиглалтын түвшнийг сайжруулах ажлын хүрээнд Ус хангамжийн Баруун эх үүсвэрийн төслийн хэрэгжилт 2025 оны 06 дугаар сарын байдлаар 88 хувийн хэрэгжилттэй байна. Төслийн хүрээнд Доод эх үүсвэрийн ус гүн цэвэршүүлэх байгууламжийн бүтээн байгуулалт 98.3, Биокомбинат, Шувуун фабрик орчмын гүний 30 худаг, 55 км ус дамжуулах шугам сүлжээний суурилуулалт 81.8% байгаа бөгөөд тоног төхөөрөмж, туршилт тохируулгын ажилд Ус сувгийн удирдах газар ОНӨААТҮГ-ын инженер, техникийн ажилтнууд томилогдон дадлагажин ажиллаж байна.	90%
357	НХТЖҮЧ-5 3.1	Нийслэлийн хөгжлийн дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн боловсруулалтад экспертийн үнэлгээ хийлгэх	НЗДТГ-ТЗУГ	НТ	2023	-	Үнэлгээ хийлгэсэн баримт	тоо	1	60	Нийслэлийн хөгжлийн дунд, богино хугацааны төлөвлөлтийн баримт бичгийн чанар, засаглалын зарчимд нийцлийг үнэлэх зорилгоор экспертийн үнэлгээний аргачлал боловсруулан хэрэглэсэн. Үнэлгээний гол үр дүнг нэгтгэн дүгнэхэд, нийслэлийн хөгжлийн дунд хугацааны бодлогын баримт бичигт стратегийн зорилт, тэргүүлэх чиглэл нь харьцангуй тодорхой, үндэсний болон нийслэлийн хөгжлийн бодлоготой уялдаа дундаас дээш түвшинд үнэлэгдсэн бол богино хугацааны баримт бичигт хэрэгжилтийн арга хэмжээ, хариуцах байгууллага, хугацаа, төсөв, санхүүжилтийн уялдаа нь тодорхой боловч эдгээрийг дунд хугацааны стратегийн зорилт, үзэл баримтлалтай холбох логик гинж сул байгаа нь ажиглагдав. Экспертүүдийн үнэлгээгээр хууль эрх зүйн үндэслэл, эрх хэмжээ, батлах журам, хэрэгжүүлэгч байгууллагын хуваарилалт зэрэг чиглэлүүд харьцангуй сайн, зарим салбарын баримт бичигт техникийн болон салбарын үзүүлэлтүүд нэлээд тодорхой томьёологдсон байсан бол нөгөө талаар зорилго, зорилт, арга хэмжээ, үр дүн, үзүүлэлтийн уялдаа бүхий логик загвар бүх баримт бичигт жигд бүрдээгүй, зарим зорилтод хэмжихүйц үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин тодорхой бус, хяналт-шинжилгээ, үнэлгээний хэсэгт аргачлал, давтамж, хариуцах нэгжийн үүрэг тодорхой бус, иргэд, ТББ, хувийн хэвшлийн оролцоо, олон нийтийн хэлэлцүүлгийн үйл явцыг тайлбарласан нотолгоо дутмаг, хэрэгжилтийн эрсдэл, түүнийг бууруулах арга хэмжээ, хувилбарт шийдэл сул тусгагдсан нь сайжруулах шаардлагатай чиглэлээр болсон байна. Үнэлгээний дүн, экспертүүдийн хэлэлцүүлгийн үр дүнд тулгуурлан дараах чиглэлийн зөвлөмжийг гаргасан. Нэгдүгээрт, бодлогын бүх баримт бичигт зорилго–зорилт–үр дүн–үзүүлэлт–гол арга хэмжээ–эрсдэлийн логик гинж бүхий загварыг нэг мөр стандартчлан хэрэглэх, уг загварыг журамчлан төлөвлөлтийн үйл явцад заавал мөрдөх нь зүйтэй. Хоёрдугаарт, хэрэглэж буй үзүүлэлтүүдийг SMART зарчмаар нарийвчлан тодорхойлж, бүр үзүүлэлт бүрт суурь түвшин, зорилтот түвшин, мэдээллийн эх сурвалж, хэмжих давтамжийг тодорхой зааж, нийслэлийн засаглалын индекс болон олон улсын хамааралтай чанарын үзүүлэлттэй уялдуулах шаардлагатай. Гуравдугаарт, бодлогын баримт бичгийг боловсруулах явцад оролцсон талуудын (иргэд, хувийн хэвшил, ТББ, мэргэжлийн холбоод г.м) оролцоо, хэлэлцүүлгийн үр дүнг тайлбарласан хэсгийг тогтмол тусгаж, оролцоо сул байгаа салбар, зорилтот бүлгийн хувьд нэмэлт арга хэмжээ төлөвлөн, оролцоог тусгай үзүүлэлтээр хянах шаардлагатай. Дөрөвдүгээрт, хэрэгжилтийн гол эрсдэлүүдийг тогтмол таньж, эрсдэл–хариу арга хэмжээний хүснэгт бүхий эрсдэлийн удирдлагын хэсгийг стандартчлан оруулах, мөн нийслэлийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, төсвийн дунд хугацааны хүрээтэй бодлогын зорилт, арга хэмжээг илүү тодорхой уялдуулах замаар хөрөнгө оруулалтын эрэмбэ, сонголтын шалгуурыг ил тод, логик үндэслэлтэй болгох нь гол зорилт болж байна.	100%
358		"Нийслэлийн 2025-2028 оны стратеги төлөвлөгөө" боловсруулах	НЗДТГ-ТЗУГ	-	2023	-	баримт бичиг боловсруулах ажлын явц	хувь	100	-	Монгол Улсын Үндсэн хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн актад заасны дагуу төрийн байгууллагууд нь нийтийн ашиг сонирхолд нийцсэн, хариуцлагатай, ил тод, үр дүнтэй засаглалыг хэрэгжүүлэх үүрэгтэй. Энэ хүрээнд төрийн байгууллагуудын гүйцэтгэлийг зөвхөн гадаад хяналт, шалгалтын аргаар бус, дотоод үнэлгээ, өөрийн шинжилгээ, сайжруулалтад суурилсан соёл төлөвшүүлэх нь орчин үеийн засаглалын шинэчлэлийн гол хандлага болж байна. Нийслэлийн нутгийн захиргааны 76 байгууллагуудын засаглалын өнөөгийн төлөв байдлыг тодорхойлох үнэлгээ хийж тус үр дүнд тулгуурлан Нийслэлийн Засаг даргын Тамгын газар боловсруулж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын стратеги төлөвлөгөө боловсруулалтад хяналт тавьж ажиллав.	100%

359	НХТЖҮЧ-5 3.1	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд экспертийн үнэлгээг шинэчилж хийлгэх	НЗДТГ-ТЗУГ	НТ	2022	-	Үнэлгээ хийлгэх ажлын явц	хувь	100	50	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд экспертийн түвшний чанарын үнэлгээ хийсэн бөгөөд үр дүнг нэгтгэн дүгнэхэд, төлөвлөгөөнд туссан байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг оновчлох, үйл ажиллагааны процесс, журам, стандартуудыг шинэчлэх, цахим үйлчилгээ, мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэхтэй холбоотой зорилтууд харьцангуй сайн үнэлэгдсэн бол нөгөө талаар гүйцэтгэлийн үзүүлэлтүүдийг институцийн болон хотын хөгжлийн өндөр түвшний зорилттой уялдуулах, хариуцлагын гинжин хэлхээ, дотоод хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог бэхжүүлэх, албан хаагчдын гүйцэтгэлийг бодит өгөгдөлд тулгуурлан үнэлж, урамшууллын бодлоготой холбох чиглэлүүд сул үр дүн гарсан. Мөн стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх явцад иргэд, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог системтэйгээр хангах, хэрэгжилтийн явц ба үр дүнгийн талаарх тайлагнал, олон нийттэй харилцах байдлыг тогтмол, ойлгомжтой хэлбэрээр сайжруулах шаардлагатай гэж экспертүүд үзсэн бөгөөд цаашид стратеги төлөвлөгөөг дараагийн мөчлөгт шинэчлэхдээ дээрх ололт, сул талын дүн шинжилгээнд үндэслэн зорилт, үзүүлэлт, хэрэгжилтийн механизмыг нарийвчлан сайжруулахыг шаардлагатайг зөвлөсөн.	100%
360	НХТЖҮЧ 5.2	Нийслэлийн хүн ам, өрхийн анхан шатны бүртгэлийн "Хүн ам, өрхийн мэдээллийн сан"-гийн чанарыг сайжруулах зорилгоор сургалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгөх	НСГ	УТ	2023	171	Сургалт зохион байгуулсан хороо	тоо	204	10	Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилт, өрх, хүн амын үзүүлэлтүүдийн нөхөлт, мэдээллийн чанар, үнэн бодит байдлыг сайжруулах тал дээр онцгой анхаарч, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, 204 хорооны ажлын албатай хамтран дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн чанарыг сайжруулж, ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгоор 9 дүүргийн статистикийн хэлтэстэй хамтран ХАӨМС-гийн баяжилт, ашиглалтын талаарх сургалтыг ажлын байранд болон цахим хэлбэрээр тогтмол зохион байгуулсан. Мөн дүүргийн хүн ам, нийгмийн салбар хариуцсан мэргэжилтнүүд болон хороодын зохион байгуулагч нарт шаардлагатай тохиолдолд тухай бүрт нь утсаар болон цахимаар холбогдон заавар зөвлөмж өгч ажиллав. ХАӨМС-гийн программ хангамж 2025 онд шинэчлэгдэж буйтай холбогдуулан нийслэлийн 9 дүүргийн 204 хорооны Засаг дарга, зохион байгуулагч нарт дадлагажуулах сургалт зохион байгуулаа.	100%
361		Нийслэлд "Мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллого"-ыг зохион байгуулж, хяналт, мониторинг явуулах, үр дүнг боловсруулж, танилцуулах	НСГ	УТ	2023	1	Зохион байгуулсан тооллого	тоо	1	14.7	Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолд заасны дагуу Улсын хэмжээнд Мал тэжээвэр, амьтдын тооллогыг жил бүрийн 12 дугаар сарын 07-ноос 17-ны өдрийн хооронд зохион байгуулж өмчийн бүх төрлийн мал, тэжээвэр амьтдыг тооллогод хамруулдаг. 2025 онд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн “Тооллого явуулах тухай” А/1667 дугаар захирамжид батлагдсан төсөв, удирдамжийн дагуу бэлтгэл ажлыг хангаж, Үндэсний статистикийн хорооны даргын 11 дүгээр сарын 24-ны өдрийн 01/853 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу хуулийн хүрээнд амжилттай зохион байгууллаа. Мал тооллогын мэдээлэл цуглуулалтын ажил улс орон даяар 12 дугаар сарын 17-ны өдрийн 20 цагт дуусаж, нийслэлийн хэмжээнд 9 дүүргийн, 25 хороонд нийт 25 маршрут 73 чиглэлд төлөвлөгөө маршрут гарган, 282 мэдээлэл цуглуулагч тоологч ажилласан. Тооллогын үр дүнгээр 2025 онд 5595 малтай өрхийн 415227 толгой мал, 76 ААНБ-ын 8365 толгой мал тоологдож, малын мэдээллийг 2025 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор мал тооллогын программд шивэлтийг бүрэн хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн хэмжээнд 423592 толгой мал тоологдсон нь өмнөх оноос 10743 толгой малаар буюу 2.6 хувиар өссөн дүнтэй байна.	100%
362		Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын мэдээлэл, технологийн программ хангамжийн чадавх, хүртээмжийг нэмэгдүүлэх	НЗДТГ-МТГ	НТ	2023	-	Лиценз ашиглалтын түвшин	хувь	50	661.7	1.Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 70 албан хаагчдын албан хэрэгцээний компьютерт "Miscrosoft 365 хорт вирусны эсрэг программ"-ыг суулгаж, тус программын хэрэглээний талаар зөвлөмж мэдээллийг өгч ажиллаж байна. 2.Нийслэлийн харьяа байгууллагуудад ашиглах цахим хурлын системийг нэвтрүүлсэн ба Нийслэлийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн болон бусад нэгжүүдийн цахим хурлыг мэдээллийн аюулгүй байдал хангасан цахим системээр нэвтрүүлэн хэвийн ажиллагааг ханган ажиллаж байна.	100%
363		Нийслэлийн мэдээлэл, харилцаа холбооны дэд бүтцийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангах	НЗДТГ-МТГ	НТ	2023	-	Нэг жилд эзлэх тасалдлын түвшин	хувь	15	864.7	1.Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх Хангарди ордны 1 давхарт байрлаж байсан нийслэлийн Дата төвийг нийслэлийн Засаг захиргааны 5 дугаар байранд нүүлгэн шилжүүлэх ажлыг 2025 оны 01 дүгээр сараас эхлэн зохион байгуулж, 2025 оны 03 дугаар сард бүрэн ашиглалтанд оруулсан. Хуучин Дата төвийн тоног төхөөрөмжийг бүрэн шинэчилж, физик серверүүдийн хэвийн ажиллагаанд алдагдуулалгүйгээр виртуал серверт шилжүүлсэн. Шинээр байгуулсан нийслэлийн нэгдсэн Дата төвд зориулалт бүхий 8 рак, 30 физик сервер, 193 виртуал сервер, хадгалах төхөөрөмж, 130 систем, 278 цахим хуудасны мэдээлэл байрладаг бөгөөд тэдгээрийн хэвийн найдвартай байгын горимоор тасралтгүй ажиллагааг ханган ажиллаж байна. 2.Нийслэлийн Нутгийн захиргааны байгууллагуудын цогцолбор А, Б байрны сүлжээний аюулгүй, хэвийн ажиллагааг сайжруулах зорилгоор үндсэн кор салаалагч төхөөрөмжүүдийг сольж холбогдох тохиргоонуудыг хийж сүлжээний хэвийн ажиллагааг хангаж ажилласан. Б байрны давхаруудад байрлах 45 свичүүдийг тохиргоо хийж нэгдсэн сүлжээнд холбосон. А байрны давхаруудын салаалагч төхөөрөмжүүдийг бүрэн сольж тохиргоонуудыг хийж үйл ажиллагаа тасалдалгүй, хэвийн ажиллагаанд орсон.	100%
5.3 Ил тод байдал, хяналт												
Салбарын үр дүн: Нийслэл дэх төрийн хяналт шалгалтын тогтолцоог сайжруулах хөтөлбөр боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавьж,												
хяналт шалгалтын ажлын үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.												
364	НХТЖҮЧ-5.1.1	Шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, санхүүгийн ил тод байдлыг хангуулж, нутгийн захиргааны байгууллагуудад сургалт зохион байгуулах	НДАА	-	2023	100	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	-	Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 5.3-д тусгагдсан арга хэмжээний биелэлтийг улирал бүр гаргаж Сангийн яам болон Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь тайлагнаж ажилласан. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн 34, орон нутгийн өмчит үйлдвэрийн 39, төсөл, хөтөлбөр 5 нийт 78 байгууллагын шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилтэд 2025 оны 11 дүгээр сарын 30-ны байдлаар хяналт тавихад нийт 12,276 мэдээлэл оруулах ёстойгоос мэдээллийг хугацаанд нь байршуулсан 11,945 (97.3%), хугацаа хоцроож мэдээлсэн 331 (2.7%) мэдээллийн цэс байна. Нийслэлийн Дотоод аудитын албаны Аудит, хяналт шалгалтын 2025 оны төлөвлөгөө болон Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2025 онд баталсан 12 дугаар удирдамжийн дагуу хамрах хүрээний нийт 78 байгууллагын 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэлх Шилэн дансны мэдээлэлд аудит, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Тус шалгалтын хүрээнд 134,226,467.8 мянган төгрөгийн 664 тушаал, 21 байгууллагын 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, 11 байгууллагын 47 тендерийн мэдээлэл, 220,071,227.8 мянган төгрөгийн 7,931 орлого, зарлагын гүйлгээ, нийт 352,297,695.6 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд нөхөн байршуулах ажлыг зохион байгуулж, холбогдох зөвлөгөө мэдээллийг тухай бүр нь өгч ажиллаж, хэрэгжилтийг 100% болгосон. Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа нийт 78 байгууллагаас 56 байгууллагын нягтлан бодогч, шилэн данс хариуцсан албан хаагч нарт “Шилэн дансны хууль тогтоомжийн хэрэгжилт, анхаарах зүйлс” сэдэвт сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр цахимаар зохион байгуулсан. Сургалтын ирц 71%-тай байсан ба шилэн дансны хуулийн хэрэгжилт, аудит, хяналт шалгалтын үр дүн, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөгөө, мэдээлэл хүргэлээ.	100%
365		Хотын хөгжлийн индекс тооцох үзүүлэлтийн анхдагч мэдээллийн чанарыг сайжруулах	БСШТ	НТ	2023	48	Индексийн судалгаа	тоо	66	1,900.00	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 1.2.10 дахь хэсэгт “Хотын хөгжлийн индексийн суурь анхдагч мэдээллийн боловсруулалтыг сайжруулж, хэрэглээнд нэвтрүүлнэ” заалтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хяналт шалгалтын шалгуур үзүүлэлтэд хотын хөгжлийн индексийн суурь түвшинг оруулав. Нийслэлийн харьяа байгууллагуудын удирдлагуудтай хийсэн хариуцлагын гэрээний 2.1.14. дахь заалтад Нийслэлийн Засаг даргын 2023 оны А/1024 дугаар захирамжаар батлагдсан хотын хөгжлийн индексийн 86 үзүүлэлтээс өөрийн байгууллагын чиг үүрэгт хамаарах үзүүлэлтийг үйл ажиллагааны төлөвлөгөөнд уялдуулах заалт тусгагдсан ба дээрх заалтын хүрээнд хотын хөгжлийн индексийн үзүүлэлтүүдийн суурь тоон мэдээллийн чанарыг сайжруулах зорилгоор хэд хэдэн чиглэлийн суурь судалгаг эхлүүлэн хэрэгжүүлэв. Агаарын бохирдлын индекст ашиглах суурь өгөгдлийг бүрдүүлэх хүрээнд шахмал түлшний борлуулалтын цэг, өрхийн байршил, агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого, өрхийн сууц, халаалтын нөхцөл зэрэг мэдээллийг холбогдох байгууллагуудаас албан бичгээр авч, сонгосон хороодод газар дээрх судалгаа, асуумж, ажиглалт хийсэн. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хүний нөөцийн судалгаа, төрийн үйлчилгээ, боловсрол, соёлын хүртээмжийн индексэд зориулсан суурь судалгаа, анхдагч мэдээлэл боловсруулах ажлыг зохион байгуулсан. Эдгээр судалгааны үр дүнд индексийн суурь мэдээллийн найдвартай байдал, орон зайн харьцуулалтын боломжийг нэмэгдүүлэх суурь бааз бүрдүүлж байна.	100%

366		Хотын хөгжлийн индексийг тооцож, холбогдох арга хэмжээг зохион байгуулах	НЗДТГ-ТЗУГ	НТ	2022	100	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	500	Хотын хөгжлийн индекс 2024 оны урьдчилсан гүйцэтгэлийн дүнгээр Хотын хөгжлийн ерөнхий индекс 0.5054 болж, өмнөх оноос 0.0032 пунктээр өссөн нь нийслэлийн хөгжлийн түвшин тогтвортой, бага зэргийн сайжралттай байгааг харуулж байна. “Хүрээлэн буй орчин” бүлгийн индекс 0.5140 болж 0.0033 пунктээр өссөн нь нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэнтэй; “Дэд бүтэц” бүлгийн индекс 0.4825 болж 0.0002 пунктээр өссөн нь хатуу хучилттай зам талбай, сайжруулсан ариун цэврийн байгууламж, төвлөрсөн дулаан, цахилгаан, нийтийн эзэмшлийн зам талбайн гэрэлтүүлгийн хүртээмж өссөнтэй холбоотой байна. “Амьжиргааны зохистой түвшин” 0.6920 болж 0.0386 пунктээр, “Эрүүл мэнд” 0.6507 болж 0.0573 пунктээр тус тус өссөн нь хөдөлмөр эрхлэлтийн түвшин дээшилж, халдварт өвчний тархалт буурч байгааг илтгэж байна. Харин “Боловсрол” бүлгийн индекс 0.5467 болж 0.0282 пунктээр, “Хувь хүний аюулгүй байдал” 0.2729 болж 0.0192 пунктээр тус тус буурсан нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургуулийн хамран сургалт, эзлэжийн коэффициент буурсан, гэмт хэргийн түвшин нэмэгдсэнтэй холбоотойгоор боловсрол, аюулгүй байдлын чиглэлд эрсдэл, сорилт хэвээр байгааг харуулж байна. Ийнхүү 2024 онд ХХИ ерөнхий индекс өссөн ч боловсрол, хүний аюулгүй байдлын үзүүлэлтүүдэд бодлогын онцгой анхаарал шаардлагатай хэвээр байна.	100%
367	НХТЖҮЧ-5.1, 5.2	Улсын /ахлах/ байцаагчдыг мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөр баталж, хэрэгжүүлэх	НХШГ	НТ	2023	-	Хөтөлбөрийн хэрэгжилт	Хувь	100	100	Нийслэлийн хэмжээнд барилга, дэд бүтцийн салбарын төрийн хяналтын улсын (ахлах) байцаагчдын чадавх, мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор тус газрын 42 улсын байцаагчийн мэргэшлийн сургалтын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, холбогдох яам, мэргэжлийн холбоод болон сургалтын байгууллагуудын судалгаанд үндэслэн мэргэшүүлэх багц сургалтын хөтөлбөрийг боловсруулж, 2025 оны 03 дугаар сарын 10-ны өдөр газрын даргаар батлуулсан. Хөтөлбөрийн хүрээнд батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу дараах сургалтуудад улсын (ахлах) байцаагчдыг хамруулав. Үүнд: 1) Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын хяналтын чиглэлийн сургалт: 2025 оны 02 дугаар сарын 10-нд цахимаар, 13–14-нд танхимаар зохион байгуулагдаж Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн 18 байцаагч, албан хаагч хамрагдав. 2) “Барилгын эрчим хүчний үр ашиг” сургалт (RePaRe төсөл, GIZ/ГОУХАН): 2025 оны 03 дугаар сарын 15, 16, 22, 23-нд зохион байгуулагдаж нийт 26 албан хаагч хамрагдсан. 3) Нийслэлийн Прокурорын газартай хамтарсан сургалт: “Зөрчлийн тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудал” сэдвээр 2025 оны 03 дугаар сарын 27-нд зохион байгуулагдаж, 30 албан хаагч хамрагдав. 4) “Барилгын эрчим хүчний хэмнэлтийн үр ашиг” 32 цагийн сургалт (RePaRe төсөл, МБЗТСХ): 2025 оны 03 дугаар сарын 15-23-нд зохион байгуулагдаж, 28 байцаагч, албан хаагч мэргэжил дээшлүүлж, 3 багц цагийн гэрчилгээ авсан. 5) Угсармал бетон хийцлэлтэй танилцах дадлага сургалт: 2025 оны 09 дүгээр сарын 18-нд “Эн Си Ди Прекон” ХХК-тай хамтран Каса да Винчи болон Гарден сити хаус төслийн талбайд зохион байгуулж, НХШГ-ын улсын (ахлах) байцаагчид оролцов.	100%
5.4 Амар тайван аюулгүй нийгэм												
Салбарын үр дүн: Иргэдийг гамшгаас цаг алдалгүй авран хамгаалах, батлан хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх												
цагдаагийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх ажлуудыг зохион байгуулна.												
368		Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэрт шинээр хоёрдугаар зэрэглэлийн гал түймэр унтраах, аврах анги байгуулах	НОБГ	НТ	2023	-	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	30	2,000.00	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны МН/231 тоот тогтоолоор Гал түймэр унтраах, аврах 82 дугаар анги байгуулах шийдвэрийн дагуу Сонгинохайрхан дүүргийн 21 дүгээр хороо, Жаргалант тосгонд Гал түймэр унтраах, аврах анги байгуулахаар нийслэлийн Газар зохион байгуулалт албанд кадастрын дагуу газар олгох хүсэлтийг 2025 оны 03 дугаар сарын 12-ны өдөр хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/420 дугаар захирамжаар батлагдсан. Тус ангийн барилгын Архитектур төлөвлөлтийн даалгавар 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр батлагдсан бөгөөд Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер зарлан гүйцэтгэгчээр “Эй Эс Эс инженеринг” ХХК шалгарч, 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулсан. Гал түймэр унтраах, аврах ангийн холболтын зургийг боловсруулахад шаардлагатай 120.0 сая төгрөгийн зардлыг Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/1392 дугаар захирамжаар шийдвэрлэн, гүйцэтгэгч "Батсүндэрлэ" ХХК-тай 2025 оны 02 дугаар сарын 20-ны өдөр гэрээ байгуулж, холболтын зургийг Барилга хөгжлийн төвөөр хянуулан, барилга угсралтын ажлын гүйцэтгэл 10 хувьтай байна.	90%
369	МУХТЖҮЧ 7.3.3	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт шинээр гал түймэр унтраах, аврах ангийн барилгыг ашиглалтад оруулах	НОБГ, ЧДЗДТГ	-	2023	30	Барилга угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	-	Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн 43 дугаар тогтоолоор дүүргийн 21 дүгээр хороонд дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр Гал түймэр унтраах, аврах анги байгуулахаар зураг төсвийг шийдвэрлэн 2024 онд 1 тэрбум төгрөг, нэмэлт төсвийн тодотголоор 1 тэрбумыг нэмж нийт 2 тэрбум төгрөгийн өртөгөөр барилгын ажлыг эхлүүлсэн. Чингэлтэй дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор 3,2 тэрбум төгрөгийг төсөвт суулгаж, 2024-2025 он дамжин санхүүжих нийт төсөвт өртөг 5,2 тэрбум төгрөг төсөвлөснөөс Гал түймэр унтраах, аврах 86 дугаар ангийн урдуур үерийн далан шуудуу барих ажилд 250 сая төгрөгийг төсөвлөн, 4 тэрбум 900 сая төгрөгийг ангийн бүтээн байгуулалтад зарцуулахаар “Дуутын нуруу” ХХК-тай хамтран ажиллаж, барилгыг 2025 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр хүлээн авсан.	100%
370	НХТЖҮЧ-7.4.1	Баянзүрх дүүрэгт гал түймэр унтраах, аврах анги шинээр байгуулах газрын асуудлыг шийдвэрлэж, холболтын зураг боловсруулж бэлтгэл хангах	НОБГ, БЗДЗДТГ	НТ (ГЭБНЗ)	2024	-	Холболтын зураг боловсруулах ажлын явц	хувь	100	50	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны Гал түймэр унтраах, аврах 83 дугаар анги байгуулах 163 дугаар тогтоолын хүрээнд Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/420 дугаар захирамжаар Баянзүрх дүүргийн 21 дүгээр хороо, Ганцын задгайд газар эзэмших эрхийн гэрчилгээ, 2025/00-368 дугаартай Архитектур төлөвлөлтийн даалгавар 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр гарсан. Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас тендер зарлаж, 3 хуулийн этгээд оролцсоноос "Би Рич Трейд" ХХК шалгарч 05 дугаар сарын 16-ны өдөр гэрээ байгуулж, барилгын шав тавих арга хэмжээг зохион байгуулсан. Тус Гал түймэр унтраах, аврах ангийн барилгын ажил эхлээгүй бөгөөд барилгын холболтын зураг Барилга хөгжлийн төвөөр хянагдаж дуусаагүй байгаа бөгөөд барилга угсралтын ажил 2026 онд эхэлнэ.	90%
371		Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх, гал түймэр унтраах автомашины хангалтыг нэмэгдүүлэх	НОБГ	НТ	2023	92	Тусгай зориулалтын автомашин	тоо	94	520	Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхээр ой, хээрийн түймэр унтраах тусгай зориулалтын 2 ширхэг автомашиныг нийслэлийн 2025 оны төсөвт 750 сая төгрөгийг тусгуулахаар санал оруулсан боловч дэмжигдээгүй. Сонгинохайрхан дүүргийн Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөс 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар тус дүүргийн Онцгой байдлын хэлтэст шаардлагатай бага оврын ачааны автомашин, туулах чадвар сайтай Танк-300, хүн зөөврийн Тоёота Вокси, Хьюндай Старекс, ирсэн Давхар кабинтай портер маркийн шуурхай албаны автомашинуудыг худалдан авахаар тус дүүргийн худалдан авах ажиллагааны газраас тендер зарлан гүйцэтгэгч байгууллагуудтай гэрээ байгуулж, автомашиныг хүлээн авсан.	100%
372		Онцгой байдлын байгууллагын гамшигтай тэмцэх, гал түймэр унтраах, аврах, эрэн хайх, ажиллагааны техник, багаж хэрэгслийн хангалтыг нэмэгдүүлэх	НОБГ	НТ	2023	66	Техник хэрэгслийн хангалт	хувь	70	300	Нийслэлийн 2025 оны төсөвт онцгой байдлын байгууллагад эрэн хайх аврах, гал түймэр унтраах үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлд 992.2 сая төгрөг батлагдсан бөгөөд Нийслэлийн Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн А/107 дугаар захирамжаар худалдан авах ажиллагааны эрх шилжиж, гүйцэтгэгчээр “Хайтек интернэйшнл” ХХК шалгаран, 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдөр гэрээ байгуулсан. Гэрээний дагуу батерейт хөрөө 7, тасдагч 7, молдок 2, хорт хий мэдрэгч драгер 6, батарей ажиллагаатай тасдагч 3, батарей ажиллагаатай тэлэгч 3, аврах ажиллагаа болон гал түймэр дээр ашиглаж болох олон үйлдэлт шанзны багаж 50, универсал олс 450, лазер хэмжигч 16, хөдөлгөөнт хурдны интернэт төхөөрөмж 13, тоон гар станц 45, тоон суурин станц 29, холбооны дахин дамжуулах бааз станц 6, утасгүй өндөр хурдны суулжэний төхөөрөмж 26 ширхэг, нийт 870,961,612 төгрөгийн үнэ бүхий 14 төрлийн 663 ширхэг багаж хэрэгслийг 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч бүтцийн нэгжүүдэд хуваарийн дагуу олгосон.	100%

373		Нийслэлийн гамшгаас хамгаалах албадын аюулт үзэгдэл, ослын үед ажиллах бэлтгэл, бэлэн байдлыг хангахад шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хамгаалах хувцас хэрэгслээр хангах	НОБГ, ННЗБ	НТ	2023	-	Машин механизм, тоног төхөөрөмж, хэрэгсэл	тоо	108	25,894.40	Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрсдэлтийг бууруулах, чадавхыг бэхжүүлэх ажлын хүрээнд Нийслэлийн 2025 онд төсөвт Газар хөдлөлтийн эрсдэлийг бууруулах хүрээнд ашиглалтын шаардлага хангахгүй барилга байгууламжийг буулгаж, дахин төлөвлөх, инженерийн шугам сүлжээний ажилд 7.998.900.000 төгрөг, үерийн эрсдэлийг бууруулах хүрээнд үерийн хамгаалалтын барилга байгууламж, ус зайлуулах шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх, засварлах ажилд 57.881.000.000 төгрөг, Онцгой байдлын байгууллагын чадавхыг бэхжүүлэх хүрээнд эрэн хайх, аврах ажиллагаа, холбоо, зарлан мэдээллийн тоног төхөөрөмж, техник хэрэгсэлд 992.200.000 сая төгрөг, Баянзүрх, Сонгинохайрхан дүүргэт шинээр гал түймэр унтраах, аврах анги байгуулахад 3,960.000.000, төгрөг, Сүхбаатар дүүргийн гал түймэр унтраах, аврах 74 дүгээр анги хүртэлх авто замын ажилд 462.500.000 төгрөг зэрэг нийт 75,294.600.000 төгрөгийн төсөл, арга хэмжээ тусгагдсан нь нийслэлийн төсвийн зарлагын 1.26 хувь болж байна. Энэ нь Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан төрийн байгууллага тухай жилийн төсвийн 1-ээс доошгүй хувийг гамшгаас хамгаалах арга хэмжээнд тусгаж хэрэгжүүлнэ гэсэн заалт хангагдаж байна. Хан-Уул дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс 29.0 сая төгрөгөөр Онцгой байдлын хэлтсийн гал түймэр унтраах, аврах ангиудад: 1. Лайв төхөөрөмж-1, 2. Зөөврийн чанга яригч-1, 3. Нисэгчгүй нисэх төхөөрөмж-3, нийт 3 төрлийн 5 тоног, хэрэгслийг худалдан авч, 2025 оны 06 дугаар сарын 06-нд хүлээлгэн өгсөн. Гамшгийн эрсдэлийг бууруулах орон нутгийн зөвлөлөөс ой хээрийн түймрийн үед ашиглах зориулалт бүхий 15 ширхэг рло, 6 ширхэг үлээгч аппаратыг хүлээлгэн өгсөн. Мөн дүүргийн төсвийн 60 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Онцгой байдлын хэлтэст шаардлагтай гал унтраах, эрэн хайх 6 нэр төрлийн 53 ширхэг тоног төхөөрөмж нийлүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 3 удаа зохион байгуулахад аж ахуй нэгж материал ирүүлээгүй, худалдан авах ажиллагааны шатанд байна.	100%
374	НХТЖҮЧ-7.4.1	Батлан хамгаалах хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг иргэдийн оролцоонд тулгуурлан сурталчлах	НЗДТГ-ЦШ	-	2022	12,000	Арга хэмжээнд оролцсон иргэд	тоо	20,000	-	Батлан хамгаалах хууль тогтоомжийг байгууллага аж ахуйн нэгж, иргэдэд сурталчлах ажлыг олон талт хэлбэрээр явуулж, нийслэлийн их, дээд, ерөнхий боловсролын сургуулиуд болон төр хувийн хэвшлийн 161 байгууллагад явуулж нийт 30 гаруй мянган иргэнийг хамруулсан байна. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний үйл ажиллагаа, Цэргийн гэрээт алба, хугацаат албыг сурталчлах зорилгоор дүрс бичлэг “видео контент”-уудыг бэлтгэн гаргаж нийслэлийн иргэд, Ерөнхий боловсролын сургуулиуд, телевиз, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж 350 гаруй мянган иргэн хандсан үзүүлэлттэй байна.	100%
375		Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгж, Орон нутгийн цэргийн отрядын бэлэн байдал, бэлтгэлжилтийг хангах	НЗДТГ-ЦШ	-	2022	30	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	70	-	Нийслэлийн Засаг даргын 2025 оны мн/06 дугаар захирамж, Батлан хамгаалахын сайдын 2025 оны “Орон нутгийн хамгаалалтад дэмжлэг үзүүлэх” тухай А/63 дугаар тушаалыг тус тус үндэслэн Баянгол дүүргийн Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн иргэдтэй хээрийн дадлага, сургалтыг Зэвсэгт хүчний 311 дүгээр ангитай, Хан-Уул дүүргийн Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн иргэдтэй хээрийн дадлага, сургалтыг Зэвсэгт хүчний 326 дугаар ангийн материаллаг баазыг тушиглэн Зэвсэгт хүчний Жанжин штабын сургалтын хөдөлгөөнт бүлэг болон төрийн цэргийн байгууллагуудтай хамтран 2025 оны 05 дугаар сарын 19-ний өдрөөс 27-ны өдрүүдэд зохион байгууллаа. Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн ОНХ-ын удирдлагын бүлгийн бүрэлдэхүүнтэй 2025 оны 10 дугаар сард дадлага, сургалт явууллаа. Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газартай дайчилгаатай болон орон нутгийн хамгаалалтын нэгдсэн сургуулийг 3 үе шаттайгаар 2025 оны 09 дүгээр сарын 08-ны өдрөөс 21-ний өдрүүдэд Налайх дүүргийн нутаг дэвсгэрт Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн хээрийн байрлалын сургалтын материаллаг баазыг тушиглэн ЗХЖШ-тай хамтран зохион байгуулсан.	100%
376		Иргэн цэргийн харьцааг бэхжүүлэх, өсвөр үе, хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил олгох үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, боловсролын бүх шатанд цэрэг-эх оронч хүмүүжил олгох сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, тусгай анги танхим байгуулах	НЗДТГ-ЦШ	НТ	2022	16,000	Арга хэмжээнд оролцсон сурагчид	тоо	20,000	200	1.Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах”, “Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх”, “Цэрэг-эх оронч үзэл хүмүүжил олгох” нөлөөллийн ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчидтай “Монгол хүн байхын учир” сэдвээр уулзалт ярилцлага, “Монгол цэрэг” гар зураг, “Эх оронч үзэл-Үндэсний бахархал” эссэ бичлэгийн уралдаан зэрэг нийт 12 төрлийн үйл ажиллагааг зохион байгуулж 130 гаруй сургуулийн 6800 гаруй сурагчдыг хамруулсан. 2.“Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдад “Бид эх орны ирээдүй” хөтөлбөрийг хэрэгжүүлэн “Эх орон”, “Цэргийн алба хаах хэлбэрүүд”-ээр сургалт, өдөрлөгийн үйл ажиллагааг зохион байгуулан явуулж нийт 90 гаруй сургуулийн 30 гаруй мянган хүүхдийг хамруулсан. 3.Бид эх орны ирээдүй хөтөлбөрт улсын 136 сургуулийн 296 бүлэг, хувийн хэвшлийн 19 сургуулийн 46 бүлэг, нийт 155 сургуулийн 342 бүлгийн 9200 сурагчдыг хамруулан оролцуулсан. 4.“Эх оронч” суралцагч арга хэмжээг Нийслэлийн 9 дүүргийн 20 гаруй Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагч, багш эцэг, эхийн төлөөллийг оролцуулж 4 ээлжээр зохион байгуулж 1200 хүүхэд хамруулж уг үйл ажиллагааг зохион байгуулсан. 5.Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл” цогцолбор тэмцээнийг 2 үе шаттайгаар зохион байгууллаа. Нэгдүгээр шатны тоглолтыг Монгол цэргийн өдөр Зэвсэгт хүчний 104 жил, нийслэлийн Цэргийн штабын 100 жилийн ойн хүрээнд 2025 оны 3, 4 дүгээр сард дүүргүүдийн Засаг даргын Тамгын газраас ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд зохион байгуулж, 96 сургуулийн 1400 гаруй ахлах ангийн сурагчид хурд хүч, тэсвэр хатуужил, авхаалж самбаагаа сорин өрсөлдөө. Хоёрдугаар шатны тэмцээнийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит улсын аварга шалгаруулах цэрэг-спортын “Дөл-2025” цогцолбор тэмцээн 06 дугаар сарын 05-07-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвийг тушиглэн амжилттай явагдаж өндөрлөлөө.	100%
377	НХТЖҮЧ-7.3.2	Нийслэлд аюулгүй ногоон бүсийг өргөжүүлж, гэмт хэрэг, зөрчил ихэсэр үйлдэгддэг гудамж, зам талбай, эмзэг цэгүүдийг камержуулах, ухаалаг системийг нэвтрүүлэх, удирдлагын төвд холбох	НЦУГ	ТХХТ	2023	2,335	Камержуулсан цэг, ногоон бүс	тоо	2,525	46,113.40	Нийслэлийн 31 хорооны гудамж талбай, олон нийтийн газарт шинээр **299** теле камерыг, аж ахуйн нэгж байгуллагын гадна орчинд шинээр **661** теле камерыг тус тус суурилуулж, дэд төвд холбосон. Мөн авто замын 176 уулзвар, гарцад **2525** ширхэг автомашины улсын дугаар таних, зөрчил илрүүлэх ухаалах программ хангамжид суурилсан теле камерыг суурилуулж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. “Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд суурилуулсан болон аж ахуй нэгж, байгууллагын гадна орчны теле камерыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа теле камерын стандартад нийцүүлэх, мэдээлэл холбоо, сүлжээний үйлчилгээ үзүүлэгч байгууллагын дэд бүтцийг ашиглан “Теле камерын хяналтын дэд төв”-д холбох ажлын хүрээнд Баянгол-349, Баянзүрх-301, Сонгинохайрхан-132, Сүхбаатар-270, Хан-Уул-242, Чингэлтэй-2532, Багануур-113, Багахангай-68, Налайх-246 **нийт-4253 ширхэг телекамер холбогдсон байна.**	100%
378	НХТЖҮЧ-7.1.2	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангахад шаардлагатай техник хэрэгслээр хангах	НЦУГ	НТ	2023	25	Техник, хэрэгслийн хангалтын түвшин	хувь	30	937.5	Морьт эргүүлийн үйл ажиллагаанд шаардлагатай тоног төхөөрөмж, бараа материалд шаардлагатай 296.1 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлж, хангалтыг хийсэн. Олон нийтийн цагдаагийн хөдөлмөрийн аюулгүй байдлын хувцас, таних тэмдэг, үнэмлэх, тусгай хэрэгслийн зардалд 571.4 сая төгрөгийн төсвийг шийдвэрлүүлж, **214 олон нийтийн цагдаад 100 хувь хангалт** хийгдсэн. Мөн дүүргийн цагдаагийн газар, хэлтсүүд орон нутгийн санхүүжилтээр иж бүрэн компьютер 84, принтер 50, ширээ 42, сандал 64, баримт бичгийн шүүгээ 15, бичлэг хадгалах төхөөрөмж 3, камер 52, дрон 1, согтуурал хэмжигч төхөөрөмж 4, цахилгаан дугуй 4, чанга яригч 5 зэрэг техник, хэрэгслийн нийт 575.1 сая төгрөгийн төсөв хөрөнгийг шийдвэрлүүлж, **гэмт хэрэгтэй тэмцэх чиг үүрэг бүхий алба хаагчдын 30.1 хувьд хангалт** хийгдсэн.	100%
379	НХТЖҮЧ-7.3.2	Алба хаагчдад ArCGis программын сургалт, зөвлөх үйлчилгээ авах, судалгаа дүн шинжилгээ, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ, шуурхай удирдлага зохицуулалтын чиглэлээр сургах	НЦУГ	УТ	2023	1	Зохион байгуулсан сургалт	тоо	2	100	Тус цагдаагийн удирдах газрын даргын 2025 оны Б/98 дугаар тушаалаар үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, төлөвлөлт, зохион байгуулалтыг оновчтой болгох чиглэлээр “Процессын дахин инженерчлэл” сэдэвт сургалтыг энэ оны 04 дүгээр сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулж, **сургалтад 42 удирдах албан тушаалтныг** хамруулсан. “Дата гэр солюшн” ХХК-тай хамтран зохион байгуулсан “Power BI буюу “Өгөгдөл боловсруулах, дүрслэх программ”, “Dashboard буюу “Өгөгдлийг шинжлэх, дүрслэх, тайлагнах программ” ашиглах **сургалтад 158 алба хаагчийг** хамруулсан.	100%

380	НХТЖҮЧ-7.1.2	Шаардлагатай техник хэрэгслээр тоноглогдсон автомашинаар хангах	НЦУГ	НТ	2023	2	Автомашин	тоо	5	1,000.00	Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 185 сая төгрөгийг шийдвэрлүүлж, "Албан хэрэгцээнд шаардлагатай тээврийн хэрэгсэл худалдан авах тухай" нээлттэй тендер шалгаруулалтыг зохион байгуулж, "Киамоторс Монгол" ХХК-аас 2025 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Киа Карнывал маркийн тусгай тоноглол бүхий **1 автомашиныг** хүлээн авсан. Мөн Налайх дүүргийн цагдаагийн хэлтэс Ниссан патрол Y61 маркийн тусгай тоноглол бүхий **1 автомашин**, Сүхбаатар дүүргийн цагдаагийн газар Т2 ENDURO маркийн кросс загварын тусгай тоноглол бүхий **1 мотоциклыг** тус тус хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.	100%
381	НХТЖҮЧ-7.3.2	Салбарын хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан үүсгэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх	НЦУГ	УТ	2023	20	Үйл ажиллагааны хэрэгжилт	хувь	100	100	“Томотек солюшн" ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан Цагдаагийн байгууллагын **“Удирдлагын нэгдсэн хяналтын систем”**-ийг зохион бүтээх ажлыг 3 үе шаттайгаар хэрэгжүүлэн ажиллаж байна. Нэгдүгээр шатанд “Дуудлага мэдээлэл”, “Өргөдөл, гомдол”, “Эрүүгийн хэрэг”-ийн хяналтын самбарыг зохион бүтээж үйл ажиллагаанд нэвтрүүлсэн. Хоёрдугаар шатанд “Хүний нөөц”, “Тайлан мэдээ”, “Бодлогын баримт бичиг”-ийн хяналтын самбарыг өрөх ажил хийгдэж байна. Гуравдугаар шатанд үүссэн хяналтын самбаруудыг хиймэл оюун ухаантай холбох ажил батлагдсан төлөвлөгөөний дагуу явагдаж байна.	100%
382	НХТЖҮЧ-7.2.3	Түр хамгаалах байрыг ашиглалтад оруулах	НЦУГ	ГЗ	2023	40	Барилгын угсралтын ажлын гүйцэтгэл	хувь	100	8,700.00	Түр хамгаалах байрны барилгын дотор засал, гадна талбай тохижуулах ажлууд хийгдэж байна. **Барилгын ажлын гүйцэтгэл 95 хувьтай.**	91.60%
383	НХТЖҮЧ-7.2.1	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Олон нийтийн цагдаа” арга хэмжээг үргэлжлүүлэх	НЦУГ	НТ (ГХУСАЗНСЗ)	2023	214	Олон нийтийн цагдаагийн сул орон тооны нөхөн хангалт	тоо	214	1,800.00	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 24/35 дугаарт тогтоолоор гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр 2025 онд ажиллах олон нийтийн цагдаагийн тооны дээд хязгаарыг 214 хүртэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин буюу 2.3760.000 төгрөгийн урамшуулал олгуулахаар батлуулсан. Олон нийтийн цагдаагийн 73 орон тоо сул байсныг нөхөх чиглэлээр болзол шалгуурыг хангасан иргэдийг дүүргийн цагдаагийн газар, хэлтсээс судлан тус цагдаагийн удирдах газрын даргын 2025 оны Б/53 дугаар “Олон нийтийн цагдаагаар бэлтгэх иргэдийг сургалт, дадлагад хамруулах тухай” тушаал, Цагдаа, дотоодын цэргийн сургалтын нэгдсэн төвийн даргын баталсан “Үйлдвэрлэлийн дадлага сургалтын удирдамж”-ийн дагуу сургалтад хамруулж, 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн Б/84 дүгээр тушаалаар **73 иргэнийг сул орон тоонд томилж, 214 олон нийтийн цагдаа ажиллаж байна.**	100%
384	НХТЖҮЧ-7.2.2	Сургуулиас гэр, гэрээс сургууль хүртэлх замд хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх	НЦУГ	НТ (ГХУСАЗНСЗ)	2023	151	Хүүхэд хамгаалагч	тоо	153	535	"Хүүхэд хамгаалагч” төслийн хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 154,303,400 төгрөгийг урамшуулалд шийдвэрлүүлж, хүүхдийг гэмт хэрэг, зөрчилд өртөж, хохирохоос урьдчилан сэргийлэх чиглэлээр **хүүхэд хамгаалагчаар 194** иргэн ажиллаж байна. Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран хүүхдийн эрхийг хангах, аюулгүй орчныг бүрдүүлэх, орчны эрсдлээс урьдчилан сэргийлэх зохилгоор 89 удаагийн сургалт зохион байгуулсан.	100%
385	НХТЖҮЧ-7.1.1	Цагдаагийн хэсгийн байрыг шинээр барих, засварлах	НЦУГ	НТ	2023	1	Шинээр барьсан, засварласан барилга	тоо	2	1,500.00	Сүхбаатар дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 02/15 дугаар тогтоолоор 396.0 сая төгрөгийг дүүргийн 2025 оны төсөвт суулгаж, Сүхбаатар дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр Шарга морьтын уулзварт 140м2 талбай бүхий **зуслангийн цагдаагийн хэсгийн байрыг шинээр барьж** ашиглалтад оруулсан. Сүхбаатар дүүргийн 4 дүгээр хороонд байрлах тус цагдаагийн удирдах газрын хоёрдугаар байрны **их засварын ажлыг улсын төсвийн 610.0 сая** төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгэж, Халаасны хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, Ажиллагааны хэлтсийн алба хаагчид байрлан ажиллаж байна.	100%
386	НХТЖҮЧ-5.3.2	Цагдаагийн алба хаагчдыг болзошгүй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулснаар эрүүл мэнд, сэтгэл зүйн хамгаалал бий болж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангах	НЦУГ	УТ	2023	480	Эрүүл мэнд, сэтгэл зүйн эмчилгээнд хамруулсан алба хаагч	тоо	Урьдчилан сэргийлэх үзлэгт 500, хэвтэн эмчлүүлэх 410	65	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчид алба хаагчдын сэтгэл зүйн судалгаа, оношилгооны үр дүн болон удирдлагын зүгээс сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай, стресс, сэтгэл гутрал, нойргүйдэл, ажлаас халшрах хам шинжийн илрэлтэй алба хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, сэтгэл зүйн нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах ажлын талаар танилцуулж, шаардлагатай 65 сая төгрөгийн төсвийг Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/579 дүгээр захирамжаар шийдвэрлүүлсэн. Дээрх ажлын хүрээнд гэрээ байгуулсан Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн Стрессийн шалтгаант мэдрэлийн ядаргааны тасагт 91, Рехамед Гялс нэгдсэн эмнэлэгт 70, Нийслэлийн Аддиктологийн төвд 16, н**ийт 177 алба хаагчийг** хэвтүүлэн эмчлүүлсэн. Тус цагдаагийн удирдах газрын сэтгэл зүйчдийн баг дүүргийн цагдаагийн газар, хэлтэст ажиллаж **3855 алба хаагчдад сэтгэл зүйн** тусламж, үйлчилгээ, зөвлөгөө, сургалтыг зохион байгуулж ажилласан. Нийслэлийн Аддиктологийн төв, “Рехамед Гялс”, “Натур мед”, дүүргийн Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран 4 удаагийн урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулж нийт **1915 алба хаагч, ажилтныг** сайн дурын үндсэн дээр хамруулсан. Мөн “Монгол фарм” ХХК-тай НЦУГ/2025-49 дугаартай гэрээ байгуулан 14.170.000 төгрөгийн дархлаажуулалтын багц, дусал, тариаг худалдан авч, н**ийт 400 алба хаагчид өдрийн эмчилгээ** хийсэн.	100%
												86.0%